

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
2024 оны ... дугаар сарын ... -ний өдрийн
... дугаар албан бичгийн хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаабаатар
хот**

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг 2023 он, 2020-2023 оны байдлаар танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан бөгөөд төлөвлөгөө нь 6 бодлого, 259 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 1087 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө санхүүжилтийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлт болон объектоор буюу гүйцэтгэх ажлаар нь салган томъёолж, 44 арга хэмжээг давхардуулсныг хасаж, 2020-2024 онд нийт 1042 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2023 оны байдлаар **74.2** хувийн /өссөн дүнгээр **73.8 хувь**/ хэрэгжилттэй байна.

Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-т заасан аргачлалаар, тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй тохиолдолд журмын 6.2.2-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн болно.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бодлого тус бүрээр харуулбал:

1. КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого- 87.0 хувь /өссөн дүнгээр- 88.0 хувь/,
2. Хүний хөгжлийн бодлого- 71.7 хувь /өссөн дүнгээр- 70.5 хувь/,
3. Эдийн засгийн бодлого- 71.1 хувь, /өссөн дүнгээр-71.0 хувь/,
4. Засаглалын бодлого-78.4 хувь,/өссөн дүнгээр-77.9 хувь/,
5. Ногоон хөгжлийн бодлого- 76.5,/өссөн дүнгээр-76.1 хувь/,
6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого- 76.9 хувийн /өссөн дүнгээр-77.1 хувь/ хэрэгжилттэй байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан 1008 арга хэмжээнээс 316 буюу 31.3% нь үр дүнтэй, 436 буюу 43.3% нь тодорхой үр дүнд хүрсэн, 200 буюу 19.8% нь эрчимжүүлэх шаардлагатай, 56 буюу 5.6% нь үр дүнгүй хэрэгжсэн байна.

2020-2023 онд хэрэгжүүлэх 1042 арга хэмжээнээс 183 буюу 17.6% нь үр дүнтэй, 628 буюу 60.3% нь тодорхой үр дүнд хүрсэн, 205 буюу 19.7% нь эрчимжүүлэх шаардлагатай, 26 буюу 2.5% нь үр дүнгүй хэрэгжсэн байна.

Хэрэгжилт үр дүнтэй гэж үнэлэгдсэн арга хэмжээг 2020-2023 оны дүнгээр авч үзэхэд, нийт 183 арга хэмжээ байгаагаас Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй

нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын 21, Хүний хөгжлийн бодлогын 44, Эдийн засгийн бодлогын 51, Засаглалын бодлогын 52, Ногоон хөгжлийн бодлогын 6, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 9 арга хэмжээ тус тус байна.

2020-2023 оны дүнгээр хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдсэн буюу хөтөлбөрт тусгагдаад огт ажил хийгдээгүй дараах 26 арга хэмжээ байгаагаас Хүний хөгжлийн бодлогын 8, Эдийн засгийн бодлогын 18 арга хэмжээ байна.

Та бүхэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлантай танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг 2023 он, 2020-2023 оны байдлаар танилцуулж байна.

Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан бөгөөд төлөвлөгөө нь 6 бодлого, 260 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 1087 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө санхүүжилтийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлт болон объектоор буюу гүйцэтгэх ажлаар нь салган томъёолж, 44 арга хэмжээг давхардуулсан байсныг хасан 2020-2024 онд нийт 1042 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

НЭГ.ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд чиглэж байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

ХОЁР.АРГА ЗҮЙ

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг "Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.", Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт "хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, Засгийн газарт танилцуулах" заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор 6 бодлого, 23 чиглэл, 260 зорилтын хүрээнд 1087 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

Уг хөтөлбөрийн арга хэмжээг нэг бүрчлэн хянаж, нийт 1086 арга хэмжээнээс санхүүжилтийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлт, объектоор болон гүйцэтгэх ажлаар нь салгаж давхардуулсан нийт 44 арга хэмжээг хасаж, 1042 арга хэмжээнд дээрх

журмын 6.2.1-т заасан аргачлалаар, тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй тохиолдолд журмын 6.2.2-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д ирүүлсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулж, хяналт-шинжилгээний үндсэн суурь мэдээлэл болгон ашигласан болно.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2023 онд 74.2 хувь, 2020-2023 онд 73.8 хувийн хэрэгжилттэй байна.

Зураг 1.ЗГҮАХ-ийн хэрэгжилт, бодлогоор, хувиар



Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлант он буюу 2023 он, өссөн дүнгээр буюу 2020-2023 оны гүйцэтгэлээр үнэлэв.

3.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилт

Уг хөтөлбөрийн хэрэгжилт 2023 онд 74.2 хувь байгаагаас КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого хамгийн өндөр буюу 87.0 хувь нь, Эдийн засгийн бодлого хамгийн бага буюу 71.1 хувийн хэрэгжилттэй байна (Зураг 1).

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан 1008 арга хэмжээнээс 316 буюу 31.3 хувь нь үр дүнтэй, 436 буюу 43.3 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 200 буюу 19.8 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 56 буюу 5.6 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, бодлогоор, үр дүнгийн ангиллаар, хувиар, 2023 онд

№	Бодлогын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь						Хэрэгжилтийн хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	33	21	4	3	4	0	1	87.0
2	Хүний хөгжлийн бодлого	260	84	46	52	40	18	20	71.7
3	Эдийн засгийн бодлого	366	93	85	86	44	31	27	71.1
4	Засаглалын бодлого	268	94	53	70	29	16	6	78.4
5	Ногоон хөгжлийн бодлого	34	10	12	4	4	2	2	76.5
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	47	14	9	12	12	0	0	76.9
7	Нийт	1008	316	209	227	133	67	56	74.2
8	Дүнд эзлэх хувь	100.0	31.3	20.7	22.5	13.2	6.6	5.6	
9	Үр дүнгийн ангилал		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй			

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого, чиглэл тус бүрийн хэрэгжилтийн хувь, үр дүнтэй болон үр дүнгүй арга хэмжээг дараах байдлаар харуулав. Үүнд:

3.1.1.КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого

Энэ бодлогын хүрээнд 1 чиглэлийн 15 зорилтын 33 арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тус бодлогод "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх 1 чиглэлийг тусгасан бөгөөд 2023 оны хэрэгжилт 87.0 хувь байна.

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 33 арга хэмжээнээс 2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 21 арга хэмжээ байна. Харин 2023 оны гүйцэтгэлээр, огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) 1 арга хэмжээ байна.

3.1.2.Хүний хөгжлийн бодлого

Энэ бодлогын 6 чиглэлийн 55 зорилтын 260 арга хэмжээний хэрэгжилт 71.7 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Хүний хөгжлийн бодлого	260	71.7
2	Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	16	52.5
3	Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	68	82.4
4	Үндэсний бахархал, өв соёл. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.	33	78.0
5	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	47	73.3
6	Шинжлэх ухаан, технологи, инновац. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зарлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.	15	86.0
7	Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	81	60.1

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 260 арга хэмжээнээс 2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 84 арга хэмжээ байна. Харин 2023 оны гүйцэтгэлээр, огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) 20 арга хэмжээ байна.

3.1.3.Эдийн засгийн бодлого

Энэ бодлогын 7 чиглэлийн 81 зорилтын 366 арга хэмжээний хэрэгжилт 71.1 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.Эдийн засгийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Эдийн засгийн бодлого	366	71.1
2	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	18	70.3

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
3	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	61	74.9
4	Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	62	62.4
5	Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.	42	80.0
6	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.	61	83.3
7	Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.	85	61.5
8	Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.	37	71.9

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 366 арга хэмжээнээс 2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 93 арга хэмжээ байна. Харин 2023 оны гүйцэтгэлээр, огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) 27 арга хэмжээ байна.

3.1.4.Засаглалын бодлого

Энэ бодлогын 6 чиглэлийн 70 зорилтын 268 арга хэмжээний хэрэгжилт 78.4 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4.Засаглалын бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Засаглалын бодлого	268	78.4
2	"Цахим Монгол"- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	61	80.7
3	Амар тайван, аюулгүй нийгэм. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	52	76.6
4	Батлан хамгаалах. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.	47	76.0

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
5	Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.	26	80.2
6	Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого. Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.	51	77.3
7	Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.	31	80.3

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 268 арга хэмжээнээс 2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 94 арга хэмжээ байна. Харин 2023 оны гүйцэтгэлээр, огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) 6 арга хэмжээ байна.

3.1.5.Ногоон хөгжлийн бодлого

Энэ бодлогын хүрээнд 1 чиглэлийн 12 зорилтын 34 арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тус бодлогод байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх 1 чиглэлийг тусгасан бөгөөд 2023 оны хэрэгжилт 76.5 хувь байна.

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 34 арга хэмжээнээс 2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 10 арга хэмжээ байна. Харин 2023 оны гүйцэтгэлээр, огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) 2 арга хэмжээ байна.

3.1.6.Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого

Энэ бодлогын 2 чиглэлийн 27 зорилтын 47 арга хэмжээний хэрэгжилт 76.9 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5.Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	47	76.9
2	Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	18	74.4
3	Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.	29	78.4

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 47 арга хэмжээнээс 2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 14 арга хэмжээ байна. Харин 2023 оны гүйцэтгэлээр, огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) арга хэмжээ байхгүй байна.

3.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020-2023 оны хэрэгжилт

Уг хөтөлбөрийн хэрэгжилт 2020-2023 онд 73.8 хувь, КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого хамгийн өндөр буюу 88.0 хувь, Хүний хөгжлийн бодлого хамгийн бага буюу 70.5 хувь байна (Зураг 1).

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1042 арга хэмжээнээс 2020-2023 оны байдлаар, 183 буюу 17.6 хувь нь үр дүнтэй, 628 буюу 60.3 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 205 буюу 19.7 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 26 буюу 2.5 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, бодлогоор, үр дүнгийн ангиллаар, хувиар, 2020-2023 онд

№	Бодлогын нэр	Арга хэмжээ-ний тоо	Хэрэгжилтийн хувь						Хэрэгжилтийн хувь, дунджаар
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	38	21	9	3	4	1	0	88.0
2	Хүний хөгжлийн бодлого	263	44	64	79	50	18	8	70.5
3	Эдийн засгийн бодлого	384	51	133	100	47	35	18	71.0
4	Засаглалын бодлого	275	52	88	96	30	9	0	77.9
5	Ногоон хөгжлийн бодлого	35	6	15	9	2	3	0	76.1
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	47	9	14	18	6	0	0	77.1
7	Нийт	1042	183	323	305	139	66	26	73.8
8	Дүнд эзлэх хувь	100.0	17.6	31.0	29.3	13.3	6.3	2.5	
9	Үр дүнгийн ангилал		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй			

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого, чиглэл тус бүрийн хэрэгжилтийн хувь, үр дүнтэй болон үр дүнгүй арга хэмжээг дараах байдлаар харуулав. Үүнд:

3.2.1.КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого

Энэ бодлогын хүрээнд 1 чиглэлийн 15 зорилтын 38 арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тус бодлогод "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх 1 чиглэлийг тусгасан бөгөөд 2020-2023 оны хэрэгжилт 88.0 хувь байна.

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 38 арга хэмжээнээс 2020-2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 21 арга хэмжээ байна. Үүнд:

1. [1.1.1.1] Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цар тахлын үеийн нэмэгдлийг 2020 оныг дуустал үргэлжлүүлэн олгоно. (СаЯ)
2. [1.1.1.2] Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг 2020 оны 10 дугаар сараас хойш хэсэгчлэн үргэлжлүүлнэ. (СаЯ)
3. [1.1.1.3] Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх арга хэмжээг 2020 оныг дуустал үргэлжлүүлнэ. (2019 оны үйл ажиллагааны орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоогүй жижиг, дунд бизнесийн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлнө.) (СаЯ)
4. [1.1.1.4] Түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод 2020 оныг дуустал татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлэн үзүүлнэ. (2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оныг дуустал 11 сарын хугацаанд түрээсийн төлбөрөө бууруулсан татвар төлөгчид бууруулсан түрээсийн төлбөрийн хэмжээгээр татварын хөнгөлөлт эдлүүлнэ.) (СаЯ)
5. [1.1.1.5] Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ. (ХНХЯ)
6. [1.1.2.1] Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. (СаЯ)
7. [1.1.2.3] Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад шаардлагатай эх үүсвэрийг олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудтай хамтран шийдвэрлэнэ. /110.0 сая ам.доллар/ (СаЯ)
8. [1.1.2.4] Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна. (ЭМЯ)
9. [1.1.2.5] Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ. (ЭМЯ)
10. [1.2.1.6] Хүн амыг коронавирүсийн эсрэг вакцинд хамруулна. (ЭМЯ)
11. [1.1.2.8] Олон улсын байгууллагатай хамтарсан коронавирүст халдвар (COVID-19) судалгааны ажлуудыг эхлүүлэх, үр дүнг хүлээн авна. (ЭМЯ)
12. [1.1.3.6] Шинэ коронавирүсийн халдварыг тодорхойлох оношлуурыг дотооддоо бүтээн, туршиж, хэрэглээнд нэвтрүүлнэ. (ЭМЯ)
13. [1.1.3.7] Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн Молекул биологийн лабораторийн чадавхийг бэхжүүлнэ. (ЭМЯ)
14. [1.1.4.1] Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтыг шинэчлэн боловсруулна. (ЭМЯ)
15. [1.1.4.2] "Ковид-19" халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал,

халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2021 оныг дуустал үргэлжлүүлэн чөлөөлнө. (СаЯ)

- 16.[1.1.7.1] Шилжин ирэгчдийг КОВИД-19-ийн хариу арга хэмжээнд хамруулахад чиглэсэн судалгаа хийх, нутагтаа шилжиж ирсэн хүмүүсийн нөхцөл байдлыг үнэлэх, нийгмийн ажилтнуудад сургалт явуулах, төрийн бус байгууллагуудын үйлчилгээг дэмжих, мэдээллийн кампанит ажил явуулна. (УОК)
- 17.[1.1.7.2] Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктэй тохирч, идэвхтэй хамтран ажиллана. /200.0 сая ам.доллар/ (СаЯ)
- 18.[1.1.8.1] КОВИД-19-ийн улмаас хүнд нөхцөлд байгаа гадаадад гацсан Монголчуудыг татан авах ажиллагаанд олон улсын байгууллагатай хамтран ажиллана. (ГХЯ)
- 19.[1.1.10.1] Засгийн газрын бондын хөрөнгөнөөс ЖДҮХС-д дамжуулан зээлдүүлсэн зээл , МУХС-гийн хөрөнгөөр бүрдүүлсэн улаан буудайн нөөцтэй холбоотойгоор улсын төсөвт төлөх өр төлбөрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас төлж барагдуулна. (ХХААХҮЯ)
- 20.[1.1.10.3] Улсын төсөв, Засгийн газрын дотоод үнэт цаасны эх үүсвэр, гадаад хөнгөлөлттэй зээлээс Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өр авлагыг барагдуулна. (СаЯ)
- 21.[1.1.11.1] Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагчдад сурлагын амжилттай нь уялдуулан Засгийн газрын тэтгэлэг олгоно. (БШУЯ)

Харин 2020-2023 оны гүйцэтгэлээр, хөтөлбөрт тусгагдаад огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) арга хэмжээ байхгүй байна.

3.2.2.Хүний хөгжлийн бодлого

Энэ бодлогын 6 чиглэлийн 55 зорилтын 263 арга хэмжээний хэрэгжилт 70.5 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2020-2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7.Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Хүний хөгжлийн бодлого	263	70.5
2	Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	16	51.7
3	Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	68	77.3
4	Үндэсний бахархал, өв соёл. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.	33	75.8

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
5	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	49	70.2
6	Шинжлэх ухаан, технологи, инновац. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зарлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.	15	76.5
7	Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	82	65.3

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 263 арга хэмжээнээс 2020-2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 44 арга хэмжээ байна. Үүнд:

- [2.1.1.3] "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээ хэрэгжүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.1.5] Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулна. (ЭМЯ)
- [2.1.3.9] Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II"-ийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих /концессын эргэн төлөлт/. (СаЯ, ЭМЯ)
- [2.1.6.2] Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.6.4] Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан /Телемедицин/ ашиглах боломжийг бүрдүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.6.6] Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.6.7] Үзлэгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.6.8] Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.7.5] Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.7.9] Төрөөс болон ЭМД-аас хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, багц, төлбөрийн хэмжээг тогтоох, зардлын тооцооллыг хийнэ. (ЭМЯ, СаЯ)
- [2.1.7.12] Олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлнэ. (ЭМЯ)
- [2.1.8.5] Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллага байгуулна. (ЭМЯ)
- [2.1.8.6] Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ. (ЭМЯ)
- [2.1.9.1] Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлнэ. (ЭМЯ)

- 15.[2.1.9.6] Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ. (ЭМЯ)
- 16.[2.1.9.7] Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ. (ЭМЯ)
- 17.[2.1.13.2] Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ.
- 18.[2.1.13.4] Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг шинэчлэнэ. (ЭМЯ)
- 19.[2.1.14.2] Сумдын эмнэлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. (БХБЯ)
- 20.[2.2.1.1] Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. (БТСУХ)
- 21.[2.2.1.4] Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгоно. (БТСУХ)
- 22.[2.2.2.2] Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна. (БТСУХ)
- 23.[2.3.2.1] Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах насыг 3-5 нас болгон хамран сургалтыг нэмэгдүүлнэ. (БШУЯ)
- 24.[2.3.3.5] Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлнэ. (БШУЯ)
- 25.[2.3.4.2] Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг шинэчилж, сургалтад ашиглах нээлттэй нөөц материал, цахим агуулгыг бий болгоно. (БШУЯ)
- 26.[2.3.4.3] Үндэстний цөөнхийн хүүхдүүд, лам хүүхдүүд болон гадаадад гацсан хүүхдүүдэд таатай орчин бүрдүүлж, шаардлагатай сурах материалаар хангана. (БШУЯ)
- 27.[2.3.4.4] Сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сурах бичгийг зохиох, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ. (БШУЯ)
- 28.[2.3.5.3] Их, дээд сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийн чанарын үнэлгээг сайжруулна. (БШУЯ)
- 29.[2.3.8.5] Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлнэ. (БШУЯ)
- 30.[2.3.10.1] Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлэнэ. (БШУЯ)
- 31.[2.4.1.3] Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахад хөнгөлөлттэй зээл, грант олгоно. (БШУЯ)
- 32.[2.5.4.4] Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас,уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалт бий болгоно. (ХНХЯ)
- 33.[2.5.5.3] Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно. (ХНХЯ)
- 34.[2.5.5.5] Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилж, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. (ХНХЯ)
- 35.[2.5.7.3] "Цалинтай ээж" хөтөлбөрийг үргэлжлүүлж, 3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд ялгаварлалгүй олгоно. (ХНХЯ)

36. [2.5.7.4] Ахмад настны амьжиргааг дэмжиж, орлогын баталгааг хангах зорилгоор "Насны хишиг" тэтгэмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. (ХНХЯ)
37. [2.5.10.2] Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын засаглал, удирдлагыг сайжруулах, багш, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ. (ХНХЯ)
38. [2.5.11.3] Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцах орчин, сургалтын хэрэглэгдэхүүн болон дотуур байрны хүрэлцээ, хангамжийг сайжруулна. (ХНХЯ)
39. [2.6.1.1] "Чингис хаан" хаад, язгууртны шинэ музей. (СоЯ)
40. [2.6.1.9] "Төв Азийн түүх, соёлын голомт" судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын цогцолборыг Орхон-Тамир, Хануй-Хүнүйгийн дурсгалуудыг түшиглэн байгуулна.
41. [2.6.1.10] Байгалийн түүхийн музейг /хуучнаар Лениний музей/-г шинэчлэн засварлана.
42. [2.6.2.5] "Монгол өв ба дэлхий дахин" олон улсын арга хэмжээ. "Монгол өв ба дэлхий дахин" дунд хугацааны бодлогын баримт бичиг батлуулж, хэрэгжүүлнэ.
43. [2.6.2.6] Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээг зохион байгуулна.
44. [2.6.3.6.5] Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчилж, иргэн, сүм хийдийн өмчлөл эзэмшилд байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулна.

Харин 2020-2023 оны гүйцэтгэлээр, хөтөлбөрт тусгагдаад огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) дараах 8 арга хэмжээ байна. Үүнд:

1. [2.1.3.1] Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна. (ЭМЯ)
2. [2.1.3.3] Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна. (ЭМЯ)
3. [2.1.11.2] Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барина. (ЭМЯ)
4. [2.2.2.3] Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгоно. (БТСУХ)
5. [2.2.3.1] Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна. (БТСУХ)
6. [2.2.3.2] Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ. (БТСУХ)
7. [2.2.3.3] Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор байгуулна. (БТСУХ)
8. [2.2.3.4] Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна. (БТСУХ)

3.2.3.Эдийн засгийн бодлого

Энэ бодлогын 7 чиглэлийн 81 зорилтын 384 арга хэмжээний хэрэгжилт 71.0 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2020-2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Эдийн засгийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Эдийн засгийн бодлого	384	71.0
2	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	18	70.2
3	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	61	72.1
4	Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	62	69.1
5	Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.	46	78.1
6	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.	61	83.9
7	Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.	98	60.1
8	Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.	38	71.3

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 384 арга хэмжээнээс 2020-2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 51 арга хэмжээ байна. Үүнд:

- [3.1.9.1] Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т тусгасны дагуу Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлнэ. (СаЯ)
- [3.1.11.1] Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх зорилгоор газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгоно. (СаЯ)
- [3.1.12.6] Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хяналт, зөвшөөрлийн процессыг хялбаршуулах, автоматжуулах программ хангамж хөгжүүлнэ. /69.9 мянган ам.доллар/ (СаЯ)
- [3.1.16.1] Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон мэдээллийн системийн тоог нэмэгдүүлэх, цахим системд бүртгэгдэж буй машин унших боломжтой өгөгдлийн тоог нэмэгдүүлж, нээлттэй өгөгдлийг түгээх, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулж, хиймэл оюун

- ухаанд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлж, холбогдох мэдээллийг иргэд, байгууллага, олон нийтэд ил тод мэдээлнэ. (ТХААГ)
5. [3.1.16.2] Төрийн байгууллагын худалдан авч буй бараа, үйлчилгээнд эрэлт, нийлүүлэлт, дотоодын үйлдвэрлэгчдийн зах зээлийн бүтэц, өрсөлдөөний хэлбэр, хүчин чадалд тогтмол судалгаа зохион байгуулж, ерөнхий гэрээ байгуулан, иргэд, байгууллага, олон нийтэд ил тод мэдээлнэ. (ТХААГ)
 6. [3.1.21.1] Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг болно. (СаЯ)
 7. [3.1.22.1] 2020 оны 4 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 1-ийн өдрийг хүртэл хугацаанд хувийн хэвшилд ажилладаг иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлнө. (СаЯ)
 8. [3.2.2.1] Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана. (УУХҮЯ)
 9. [3.2.2.2] Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна. (УУХҮЯ)
 10. [3.2.5.2] Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө. (УУХҮЯ)
 11. [3.2.8.1.5] Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ. (УУХҮЯ)
 12. [3.2.8.3.2] Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна. (УУХҮЯ)
 13. [3.3.1.3] Хөрсний үржил шимийг сайжруулах, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно. (ХХААХҮЯ)
 14. [3.3.1.5] Өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйнууд байгуулж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортыг бууруулна. (ХХААХҮЯ)
 15. [3.3.3.3] Хүнсний сүлжээнд зохистой дадал, угтвар нөхцөл, удирдлагын тогтолцооны стандартыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (ХХААХҮЯ)
 16. [3.3.3.5] Түүхий сүүний нийлүүлэлтийг сэрүүний улиралд нэмэгдүүлнэ. (ХХААХҮЯ)
 17. [3.3.3.6] Хүнсний ногооны хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулна. (СХЗГ)
 18. [3.3.4.4.1] Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна. (ХХААХҮЯ)
 19. [3.3.4.5] Тариалангийн бүс нутгийг түшиглэн сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйг бий болгоно. (ХХААХҮЯ)
 20. [3.3.4.7] Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор бог малыг шахан бордох төвийг орон нутагт туршина. (ХХААХҮЯ)
 21. [3.3.13.1] Экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд даатгалын үйлчилгээг нэвтрүүлнэ. (ХХААХҮЯ)
 22. [3.3.13.2] Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлнэ. (ХХААХҮЯ)
 23. [3.3.15.2] Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийг санхүүжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. (ХХААХҮЯ)

- 24.[3.4.6.3] Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад аялал жуулчлалын нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох цогц судалгааг хийнэ. (БОАЖЯ)
- 25.[3.5.1.1] Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар нэмэгдүүлэн шинэчилнэ. (ЭХЯ)
- 26.[3.5.1.10] Эрдэнэтийн Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөнө. (ЭХЯ)
- 27.[3.5.1.12] Эгийн голын 315 МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц төслийн байгаль орчинд үзүүлэх олон талт нөлөөллийн судалгааг хийж, дэлхийн өвийн хороонд тайлагнаж зохих шийдвэр гаргуулна. (ЭХЯ)
- 28.[3.5.4.3] Нүүрсний ордуудын метан хийн хангамжийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулна. (ЭХЯ)
- 29.[3.6.1.1.1] Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барина. (ЗТХЯ)
- 30.[3.6.1.4.5] Азийн авто замын сүлжээний АН-4 дугаартай Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто зам, Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто зам, гүүрийг барина
- 31.[3.6.1.8.5] Завхан аймгийн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67км хатуу хучилттай авто замыг барина. (ЗТХЯ)
- 32.[3.6.1.8.6] Говьсүмбэр аймгийн Даланжаргалан сумаас Хэнтий аймгийн Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замыг барина. (ЗТХЯ)
- 33.[3.6.1.8.16] Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн 474.2 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ хийнэ. (ЗТХЯ)
- 34.[3.6.1.8.18] Эрдэнэт-Жаргалант чиглэлийн авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна. (ЗТХЯ)
- 35.[3.6.1.10.3] Ховд аймгийн Дөргөн сумын Чоно харайхын голын 36.8 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
- 36.[3.6.1.10.4] Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Онги голын 54.8 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
- 37.[3.6.1.10.8] Говь-Алтай аймгийн Шарга сумын Эвийн голын 32 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
- 38.[3.6.1.10.9] Хэнтий аймгийн Батширээт сумын Бархын голын 121.36 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
- 39.[3.6.2.1.4] Авто зам засвар арчлалтын байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлнэ. (ЗТХЯ)
- 40.[3.6.4.1.1] Агаарын харилцааны зохицуулалтыг сайжруулж, агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг байгуулна. (ЗТХЯ)
- 41.[3.6.4.1.2] "Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ. (ЗТХЯ)
- 42.[3.6.4.3.3] Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг эхлүүлж, байнгын ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтворжуулсан байна. (ЗТХЯ)
- 43.[3.7.1.1.] Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барина. (БХБЯ)
- 44.[3.7.1.4.] Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна. (БХБЯ)
- 45.[3.7.1.6.] Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барина. (БХБЯ)
- 46.[3.7.3.1] Цахим үйл ажиллагаатай Газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд

байгуулан газрын биржийн үйл ажиллагааны тодорхой хувиар газар хөгжүүлэх санг бүрдүүлнэ.

47. [3.7.4.4] Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулна. (АНЗДТГ)
48. [3.7.9.6] Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
49. [3.7.11.4] "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, цэвэр ус дамжуулах шугам, дагалдах тоног төхөөрөмж, ус цэвэршүүлэх станцыг барьж ашиглалтад оруулна. (БХБЯ)
50. [3.7.11.3] Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.
51. [3.7.14.1.2] "Замын-Үүд" чөлөөт бүсийг нээж байнгын ажиллагаанд оруулна. (ШСАА)

Харин 2020-2023 оны гүйцэтгэлээр, хөтөлбөрт тусгагдаад огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) дараах 18 арга хэмжээ байна. Үүнд:

1. [3.4.1.3] "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл"-ийг Архангай, Өвөрхангай аймагт хэрэгжүүлнэ. (БОАЖЯ)
2. [3.5.5.3] Даланзадгад-Ноён чиглэлийн 220 км 110 кВ-ын ЦДАШ барина. (ЭХЯ)
3. [3.6.1.8.3] Баянхонгор аймгийн төвөөс Шаргалжуут чиглэлийн 54.17 км хатуу хучилттай авто замын төслийг эхлүүлнэ. (ЗТХЯ)
4. [3.6.1.8.4] Завхан аймгийн Донойн нисэх буудлаас Улаагчины хар нуур хүртэлх 74 км хатуу хучилттай авто замыг барина. (ЗТХЯ)
5. [3.6.1.8.9] Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлнэ. (ЗТХЯ)
6. [3.6.1.8.1] Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замыг барина. (ЗТХЯ)
7. [3.6.1.10.2] Завхан аймгийн Ургамал сумын Хүнгүйн голын 72 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
8. [3.6.1.10.5] Хөвсгөл аймгийн Ханх сумын Ханх-Монд чиглэлийн 23 км хатуу хучилттай авто замын Цагаан сайрын 72.85 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
9. [3.6.1.10.6] Завхан аймгийн Улиастай сумын Богд Чигэстэйн голын 290.03 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
10. [3.6.1.10.7] Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэрийн голын 97 у/м төмөр бетон гүүрийг барина. (ЗТХЯ)
11. [3.6.2.2.2] Увс аймгийн Түргэн сумын Түргэний голын 160.8 у/м төмөр бетон гүүр. (ЗТХЯ)
12. [3.6.2.2.3] Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Байдрагийн голын 108 у/м төмөр бетон гүүр. (ЗТХЯ)
13. [3.6.2.2.5] Дорнод аймгийн Хэрлэн сумын Хэрлэн голын төмөр бетон гүүрийн их засвар, 264 у/м. (ЗТХЯ)
14. [3.6.2.2.6] Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөөгийн голын 192 у/м төмөр бетон гүүр. (ЗТХЯ)
15. [3.6.2.2.7] Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны голын 290 у/м төмөр бетон гүүр. (ЗТХЯ)
16. [3.6.2.2.8] Архангай аймгийн Тариат сумын Гичгэнийн голын 90 у/м төмөр бетон гүүр. (ЗТХЯ)

17. [3.6.2.3.4] Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчинд төлбөр авах цэг байгуулна. (ЗТХЯ)
18. [3.6.4.2.6] Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засвар. (ЗТХЯ)

3.2.4.Засаглалын бодлого

Энэ бодлогын 6 чиглэлийн 70 зорилтын 275 арга хэмжээний хэрэгжилт 77.9 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2020-2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 9.Засаглалын бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Засаглалын бодлого	275	77.9
2	"Цахим Монгол"- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	64	77.0
3	Амар тайван, аюулгүй нийгэм. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	55	76.9
4	Батлан хамгаалах. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.	48	77.9
5	Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.	26	78.3
6	Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого. Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.	51	79.6
7	Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.	31	78.9

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 275 арга хэмжээнээс 2020-2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 52 арга хэмжээ байна. Үүнд:

1. [4.1.1.5] "Цахим архив албан хэрэг хөтлөлт" хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлнэ. (ХЗДХЯ)
2. [4.1.1.9] Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ. (ХЗДХЯ)
3. [4.1.1.11] Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар Улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглана. (ХЗДХЯ)
4. [4.1.3.2] Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлнэ. (ЦХХХЯ)

5. [4.1.3.3] Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. (ЦХХХЯ)
6. [4.1.3.6] Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлнэ. (ЗГХЭГ)
7. [4.1.3.7] Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний хамрах хүрээг өргөтгөн аймгийн төвүүдийг төв (Улаанбаатар хот)-тэй холбосон дэд систем, сүлжээг зохион байгуулна. (ТЕГ)
8. [4.1.4.2] Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлсэн цахим систем бий болгоно. (ЦХХХЯ)
9. [4.1.5.12] Үндэсний хиймэл дагуул хөөргөх хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ. (ЦХХХЯ)
10. [4.1.6.1] Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна. (ЦХХХЯ)
11. [4.1.6.4] Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ. (ЗГХЭГ)
12. [4.1.6.6] Цахим шинжилгээний лаборатори байгуулна. (ТЕГ)
13. [4.1.7.2] МХХТ-ийн хэрэглээний өрх болон хувь хүний судалгааг хийнэ. (ЦХХХЯ)
14. [4.1.7.4] Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, контент боловсруулж, түгээнэ. (ЗГХЭГ)
15. [4.1.7.7] Бүх шатны төрийн байгууллагын албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх онлайн сургалтын платформ хөгжүүлж, сургалтын контент боловсруулж, сургалт зохион байгуулна. (ЗГХЭГ)
16. [4.1.8.1] Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ. (ЗГХЭГ)
17. [4.1.8.5] Зөвшөөрлийн нэгдсэн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ. (ЗГХЭГ)
18. [4.1.8.6] Нээлттэй өгөгдлийн порталыг өргөтгөнө. (ЗГХЭГ)
19. [4.2.2.2] "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийнэ. (ЗГХЭГ)
20. [4.2.2.3] Төрийн байгууллагад "цалингийн нэгдсэн систем"-ийг нэвтрүүлнэ. (СаЯ)
21. [4.2.3.1] Зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүлнэ. (ЗГХЭГ)
22. [4.2.4.2] Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна. (ТӨБЗГ)
23. [4.2.7.2] Жендэрийн сургагч багш бэлтгэнэ. (ЖҮХ)
24. [4.2.9.8] Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг бууруулахад олон улсын стандартыг нутагшуулна. (СХЗГ)
25. [4.2.9.9] Бүтээн байгуулалт, мега төсөл болон экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүний стандартыг бий болгоно. (СХЗГ)
26. [4.2.10.2] Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, Барилгын материал үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, Барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох зэрэг төрийн эрхлэх

- зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх болон Барилгын салбарын 3 талт хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангана. (БХБЯ)
- 27.[4.3.1.4] Хилийн салбаруудыг байнгын цахилгааны эх үүсвэрт холбох ажлыг үргэлжлүүлнэ. (ХЗДХЯ)
- 28.[4.3.2.2] Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг криминологи дүн шинжилгээ судалгаанд суурилан явуулж гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах арга хэмжээ авна. (ХЗДХЯ, БШУЯ)
- 29.[4.3.2.8] Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг хотхон хэлбэрээр хөгжих замаар нэмэгдүүлж, сургалтын үйл ажиллагаанд олон улсын чанарын удирдлагын ISO-9001:2015 стандартыг нэвтрүүлнэ. (ХЗДХЯ)
- 30.[4.3.4.1] Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдийг албадан эмчлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. (ХЗДХЯ)
- 31.[4.3.7.1] Криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна. (ХЗДХЯ)
- 32.[4.3.9.2] Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ. (ХЗДХЯ)
- 33.[4.3.18.1] Согтууруулах ундааны эргэлт болон хэрэглээ, архи дан согтууралтаас үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. (ХЗДХЯ)
- 34.[4.4.3.1] Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. (ХЗДХЯ)
- 35.[4.4.4.1] 2050 он хүртэлх Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлж эхлүүлнэ. (ХЗДХЯ)
- 36.[4.4.6.2] Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Патентын тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг боловсронгуй болгох оюуны өмчийн багц хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Оюуны өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах бүтэц, хүний нөөцийг бүрдүүлнэ. (ХЗДХЯ)
- 37.[4.4.7.1] Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг чангатгана. (ХЗДХЯ)
- 38.[4.4.10.5] Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина. (ТӨБЗГ)
- 39.[4.5.1.7] Аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг дэмжих ажлын хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын виз олгох журмыг шинэчлэн батлуулах зэргээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Монгол Улсын виз олгох үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан цахим визийн систем нэвтрүүлэх, мөн виз мэдүүлгийн төвийг хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах зэрэг шинэлэг арга хэлбэрийг бий болгоно. (ГХЯ)
- 40.[4.5.4.1] ОХУ, БНХАУ-тай дээд, өндөр түвшний харилцан айлчлал, хамтын ажиллагааны механизмуудын уулзалтыг тогтмолжуулна. (ГХЯ)

41. [4.5.5.5] БНСУ-тай харилцаагаа өргөжүүлж, "Стратегийн түншлэл"-ийн түвшинд хүргэнэ. (ГХЯ)
42. [4.5.6.1] НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган, Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын чуулган болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Сайд нарын зөвлөлийн уулзалт, АСЕМ-ын Дээд түвшний уулзалт, Гадаад хэргийн сайд нарын уулзалт зэрэг НҮБ, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн байгууллагаас зохион байгуулах хурал, арга хэмжээнд төлөөлөгчдийн үр дүнтэй, идэвхтэй оролцоог хангаснаар өөрийн улсын эрх ашгаа хамгаалж, олон улсад нэр хүндээ улам бататгана. (ГХЯ)
43. [4.5.6.3] "Монгол Улсад НҮБ-аас үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ" хөтөлбөр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сантай хэрэгжүүлж буй Орны хөтөлбөр зэрэг баримт бичгийн хэрэгжилтэд анхаарч, Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана. (ГХЯ)
44. [4.5.6.4] НҮБ-ын мандаттай олон улсын Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлнэ. НҮБ болон олон улсын байгууллагуудын хүрээнд болох томоохон сонгуулиудад Монгол Улс хийгээд Монгол Улсын иргэнийг нэр дэвшүүлснээр олон улсад нэр хүндээ өсгөх, байр сууриа бэхжүүлэх боломж бүрдэнэ. (БХЯ)
45. [4.5.10.1] Монгол Улсын эерэг имижийг бүрдүүлэх, нэр хүндийг өсгөх замаар улс орныхоо язгуур эрх ашгийг хамгаалах, байр суурийг бэхжүүлэхэд зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх зорилготой "Монгол Үндэстний үнэлэмж" арга хэмжээ хэрэгжүүлнэ. (ГХЯ)
46. [4.5.10.2] Хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх "Дэлхийн Монголчууд II" арга хэмжээ /хөтөлбөр/ боловсруулж хэрэгжүүлнэ. (ГХЯ)
47. [4.6.2.2] Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийг 4 жилийн цэргийн сургалтын тогтолцоонд шилжүүлнэ. (БХЯ)
48. [4.6.4.2] Барилга-инженерийн цэргийн ангийг байгуулах бүтээн байгуулалтын ажил. (БХЯ)
49. [4.6.6.2] Олон улсын болон 2 талын хамтарсан сургалт, дадлага, хээрийн сургуулийн тоог нэмэгдүүлнэ. (БХЯ)
50. [4.6.8.3] "Оюутан цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах их, дээд сургуулийн оюутан, МСҮТ-ийн суралцагчдын тоог шат дараатай нэмэгдүүлнэ. (БХЯ)
51. [4.6.9.2] Зэвсэгт хүчний ангиудад цэргийн байр шинээр барьж, одоо ашиглагдаж байгаа байруудыг засварлаж шинэчилнэ. (БХЯ)
52. [4.6.9.6] Цэргийн төв эмнэлгийг орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үргэлжлүүлэн дуусгана. (БХЯ)

Харин 2020-2023 оны гүйцэтгэлээр, хөтөлбөрт тусгагдаад огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) арга хэмжээ байхгүй байна.

3.2.5. Ногоон хөгжлийн бодлого

Энэ бодлогын хүрээнд 1 чиглэлийн 12 зорилтын 35 арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тус бодлогод байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх 1 чиглэлийг тусгасан бөгөөд 2020-2023 оны хэрэгжилт 76.1 хувь байна.

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 35 арга хэмжээнээс 2020-2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 6 арга хэмжээ байна. Үүнд:

1. [5.1.3.1] Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийнэ. (БОАЖЯ)
2. [5.1.3.2] Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтооно.
3. [5.1.4.2] Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. (БХБЯ)
4. [5.1.6.2] Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын дэд бүтэц, материаллаг баазыг сайжруулна. (БОАЖЯ)
5. [5.1.12.6] Барилгын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлж, хэрэгжүүлнэ. (БХБЯ)
6. [5.1.12.7] Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийг нэвтрүүлнэ. (БХБЯ)

Харин 2020-2023 оны гүйцэтгэлээр, хөтөлбөрт тусгагдаад огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) арга хэмжээ байхгүй байна.

3.2.6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого

Энэ бодлогын 2 чиглэлийн 27 зорилтын 47 арга хэмжээний хэрэгжилт 77.1 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг 2020-2023 оны байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 10. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Д/д	Бодлого, чиглэлийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	47	77.1
2	Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	18	74.4
3	Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.	29	78.8

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй 47 арга хэмжээнээс 2020-2023 онд үр дүнтэй (100.0%) хэрэгжсэн 9 арга хэмжээ байна. Үүнд:

1. [6.1.3.5] Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд гэр хорооллын газрын дахин төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж, төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. (НЗДТГ)
2. [6.1.4.1] Нийслэлийн зүүн бүсэд сайжруулсан түлшний үйлдвэрийг барьж байгуулна. (ЭХЯ)
3. [6.1.7.1] Дугуйн замыг хөгжүүлнэ. (НЗДТГ)
4. [6.1.7.2] Сул шороон хөрс бүхий талбайд явган зам, гүйлтийн зам хийнэ. (НЗДТГ)
5. [6.1.9.2] Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн

төвүүдийн хот хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ. (БХБЯ)

6. [6.1.12.1] Богдхан төмөр замын төслийг түшиглэн "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. (ЗТХЯ)
7. [6.1.13.1] Сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих "Сургуулийн автобус" төслийг үргэлжлүүлнэ. (НЗДТГ)
8. [6.2.7.1] Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. (БХБЯ)
9. [6.2.9.1] Бүс нутгийн томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлнэ /5 газар/. (ЭХЯ, БХБЯ)

Харин 2020-2023 оны гүйцэтгэлээр, хөтөлбөрт тусгагдаад огт ажил хийгдээгүй буюу хэрэгжилт үр дүнгүй (0.0%) арга хэмжээ байхгүй байна.

ДӨРӨВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г баталсан. Уг хавсралтад заасан 6 бодлогын 23 зорилтын 155 шалгуур үзүүлэлтийн 2023 оны хүрэх түвшин, хүрсэн түвшинг харьцуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2023 оны хүрсэн түвшний мэдээллийг үндсэн хариуцагч 27 байгууллагаас ирүүлсэн бөгөөд Үндэсний статистикийн хорооны "Статистикийн мэдээллийн нэгдсэн сан - www.1212.mn", болон олон улсын байгууллагаас гаргасан мэдээлэлтэй тулгаж, 2023 оны хүрсэн түвшинг тодорхойлов.

Уг шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь 2023 онд дунджаар 86.5 хувь байна. Ногоон хөгжлийн бодлого болон засаглалын бодлогын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт хамгийн өндөр буюу 90.1-94.1 хувь, нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогынх хамгийн бага буюу 81.7 хувь байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12.Шалгуур үзүүлэлтийн тоо, бодлогоор, хэрэгжилтийн хувиар

№	Бодлогын нэр	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилтийн дундаж хувь
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого*	1	-
2	Хүний хөгжлийн бодлого	44	85.0
3	Эдийн засгийн бодлого	52	85.0
4	Засаглалын бодлого	31	90.1
5	Ногоон хөгжлийн бодлого	14	94.1
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	13	81.7
7	Нийт	155	86.5

Тайлбар: *-Уг бодлогын хүрээнд шалгуур үзүүлэлт, түүний хэмжих нэгж, суурь түвшин, хүрэх түвшинг тодорхойлж батлаагүй болно.

Баталсан нийт 155 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хариуцагч байгууллагаар авч үзвэл, 9 байгууллагын хариуцсан 18 шалгуур үзүүлэлт 2023 онд

100.0 хувийн хэрэгжилттэй байна. Харин УУХҮЯ, ЦХХХЯ, ЭМЯ-ны хариуцсан 25 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт хамгийн бага буюу 66.7-74.0 хувийн хэрэгжилттэй байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13.Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, хариуцагч байгууллагаар

№	Хариуцагч байгууллагын нэр	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилтийн дундаж хувь
1	Засгийн газар	13	89.1
2	ЗГХЭГ	1	100.0
3	Засгийн газар, АТГ	1	78.6
4	Засгийн газар, МБанк	1	57.7
5	Засгийн газар, УОК*	1	-
6	БОАЖЯ	10	91.5
7	БХБЯ	12	94.3
8	БХЯ	5	85.4
9	БШУЯ	13	81.8
10	ГХЯ	6	100.0
11	ЗТХЯ	6	83.8
12	СаЯ	1	100.0
13	СоЯ	8	98.0
14	УУХҮЯ	12	74.0
15	ХЗДХЯ	3	100.0
16	ХНХЯ	5	98.8
17	ХХААХҮЯ	16	85.7
18	ЦХХХЯ	3	66.7
19	ЭМЯ	10	69.1
20	ЭХЯ	6	92.6
21	СаЯ, ТХААГ	1	100.0
22	ХНХЯ, ХЗДХЯ	1	100.0
23	БТСУХ	1	100.0
24	ТЕГ	3	100.0
25	ТӨБЗГ	3	99.7
26	НЗДТГ	12	80.2
27	АНЗДТГ, БОАЖЯ	1	100.0
28	Нийт	155	86.5

Тайлбар: *-Уг бодлогын хүрээнд шалгуур үзүүлэлт, түүний хэмжих нэгж, суурь түвшин, хүрэх түвшинг тодорхойлж батлаагүй болно.

ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө санхүүжилтийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлт болон объектоор буюу гүйцэтгэх ажлаар нь салган томьёолж, 44 арга хэмжээг давхардуулсан байна. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д нийт 49 байгууллага тайлагнасан бөгөөд дундаж үнэлгээгээр хариуцсан арга хэмжээгээ тодорхой үр дүнд хүргэж хэрэгжүүлсэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 10 яам, 5 агентлаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай Шадар сайдын ажлын алба, 6 яам, 3 агентлаг байна.

Тус хөтөлбөрт 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан 1008 арга хэмжээнээс 316 буюу 31.3 хувь үр дүнтэй, 436 буюу 43.3 хувь тодорхой үр дүнд хүрсэн, 200 буюу 19.8 хувь эрчимжүүлэх шаардлагатай, 56 буюу 5.6 хувь үр дүнгүй хэрэгжсэн байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13.ЗГҮАХ-ийн хэрэгжилт, үнэлгээний ангиллаар, хэрэгжилтийн хугацаагаар

Үнэлгээний ангилал		2023		2020-2023	
		Нийт арга хэмжээний тоо	Дүнд эзлэх хувь	Нийт арга хэмжээний тоо	Дүнд эзлэх хувь
Үр дүнтэй	100%	316	31.3	183	17.6
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	209	20.7	323	31.0
	70%	227	22.5	305	29.3
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	133	13.2	139	13.3
	30%	67	6.6	66	6.3
Үр дүнгүй	0%	56	5.6	26	2.5
Нийт		1008	100.0	1042	100.0

Харин тус хөтөлбөрийн нийт 1042 арга хэмжээнээс 2020-2023 оны байдлаар, 183 буюу 17.6 хувь нь үр дүнтэй, 628 буюу 60.3 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 205 буюу 19.7 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 26 буюу 2.5 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна (Хүснэгт 13).

Арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байгаа үндсэн шалтгаан нь төлөвлөлтийг суурь судалгаа, тооцоололгүй хийдэг, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв батлагддаггүй болон тендер шалгаруулалт, гэрээ байгуулах зэрэг зохион байгуулалтын ажлууд удаашралттай явагдаж байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжих шалгуур үзүүлэлтийг арга хэмжээ, зорилт, зорилгын эцсийн зорилгод нийцүүлэн тодорхойлоогүй улмаас хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн илэрхийлэх, хэмжих боломж бүрдэхгүй байна.

Иймд бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийн урьдчилсан судалгааг бүрэн хийж, хэрэгжүүлэх ажлын хүрээг зөв тодорхойлж, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түвшинг оновчтой төлөвлөх, арга хэмжээг үндсэн хариуцагч байгууллага шалгуур үзүүлэлтийн дагуу иж бүрэн, үнэн зөв тайлагнаж, шалтгаан түүний үр дагаврыг тодорхойлж хэвших, мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд төсөвлөлтийг төлөвлөлтийн хугацаатай уялдуулж баталдаг болох шаардлагатай байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, өссөн дүнгээр, 2023 оны байдлаар

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
Нэг	КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО	88.0
1.1	"Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	88.0
1.1.1	Ковид-19 халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	100.0
1.1.2	"Ковид-19" халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	97.8
1.1.3	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.	72.6
1.1.4	"Ковид-19" халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 оныг дуустал үргэлжлүүлэн чөлөөлнө.	100.0
1.1.5	Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.	70.0
1.1.6	Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	90.0
1.1.7	Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, тусалцааг нэмэгдүүлэх чиглэлээр хөгжлийн түнш улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана.	100.0
1.1.8	Гадаад улсад байгаа иргэнээ татан авах ажлыг эрчимжүүлнэ.	100.0
1.1.9	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээ авна.	50.0
1.1.10	Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	75.0
1.1.11	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагчдад сургалтын амжилттай нь уялдуулан 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.	100.0
1.1.12	Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.	72.5
1.1.13	Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	90.0
1.1.14	Боловсролд зориулсан зардлыг урьдчилан нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг зарцуулах, боловсролд дутагдаж байгаа зардлыг шийдвэрлэнэ.	86.7
1.1.15	Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно.	95.0
Хоёр	ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	70.5
2.1	Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	65.3
2.1.1	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	71.4
2.1.2	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ.	18.8
2.1.3	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна.	46.6
2.1.4	Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.	55.0
2.1.5	Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий болгоно.	58.1
2.1.6	"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	88.8
2.1.7	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.	65.2

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
2.1.8	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	70.1
2.1.9	Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	87.1
2.1.10	Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	15.0
2.1.11	Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг үе шаттайгаар байгуулна.	31.7
2.1.12	Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	67.5
2.1.13	Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.	75.8
2.1.14	Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.	80.0
2.2	Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	51.7
2.2.1	Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.	78.0
2.2.2	Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.	35.8
2.2.3	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.	41.3
2.3	Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	76.8
2.3.1	Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2 нас, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	78.2
2.3.2	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	76.0
2.3.3	Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.	83.6
2.3.4	Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.	85.0
2.3.5	Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ.	71.3
2.3.6	Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлнэ.	68.9
2.3.7	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.	37.5
2.3.8	"Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.	76.2
2.3.9	Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ. Үүнд: - 273 цэцэрлэг ашиглалтад оруулах, - 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, - Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх, - Жил бүр нүхэн жорлонтой 100-аас доошгүй цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох.	81.1
2.3.10	Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгоно. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй үндны цэвэр усаар хангана.	79.5
2.3.11	Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.	87.5

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
2.3.12	Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.	73.8
2.3.13	Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхыг дээшлүүлнэ.	73.0
2.3.14	Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.	78.0
2.3.15	Орон нутаг дахь мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.	86.7
2.3.16	Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	70.0
2.4	Шинжлэх ухаан, технологи, инновац. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зарлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.	76.5
2.4.1	Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.	82.5
2.4.2	Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ.	71.5
2.4.3	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эдийн засаг, нийгмийн хөгжилд өгч байгаа үр өгөөжийг шалгуур болгон санхүүжүүлдэг өрсөлдөөнт тогтолцоонд шилжүүлж, нэгдсэн, төрөлжсөн, нээлттэй лабораторийг байгуулан салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	73.4
2.5	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	70.2
2.5.1	Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.	54.7
2.5.2	Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	77.5
2.5.3	Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.	70.0
2.5.4	Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	77.5
2.5.5	Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	81.7
2.5.6	"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.	77.1
2.5.7	Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.	75.6
2.5.8	Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.	57.2
2.5.9	Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	76.7
2.5.10	Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцүүлнэ.	90.0
2.5.11	Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.	80.0
2.5.12	"Хуримтлалтай хүүхэд" арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.	50.0
2.5.13	Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	90.0
2.5.14	Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.	58.3
2.5.15	Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.	62.1

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
2.6	Үндэсний бахархал, өв соёл. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.	75.8
2.6.1	Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна.	72.0
2.6.2	Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ.	78.8
2.6.3	Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	77.1
2.6.4	Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.	86.7
Гурав	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	71.0
3.1	Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.	78.1
3.1.1	Инфляцын зорилтот түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.	90.0
3.1.2	Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	90.0
3.1.3	Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож, эрсдэл даах чадамжтай болгоно.	90.0
3.1.4	Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.	50.0
3.1.5	Санхүүгийн түрээсийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	50.0
3.1.6	Иргэдийг санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх замаар мөнгө хүүлэлтийг таслан зогсооно.	30.0
3.1.7	Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох боломжийг бүрдүүлнэ.	90.0
3.1.8	Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.	70.0
3.1.9	Хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ.	100.0
3.1.10	Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.	90.0
3.1.11	Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ.	100.0
3.1.12	Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.	89.4
3.1.13	Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.	74.8
3.1.14	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно.	81.3
3.1.15	Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.	50.0
3.1.16	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгана.	100.0
3.1.17	Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.	65.0
3.1.18	Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг сайжруулна.	90.0
3.1.19	Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулна.	70.0
3.1.20	Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих "Экспортын баталгааны сан" байгуулж ажиллуулна.	70.0
3.1.21	Нийслэлээс 1000 км-ээс дээш алслагдсан бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд 10 дахин бага буюу 1 хувийн татвар төлөх хуулийн хөнгөлөлтийг үргэлжлүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг санхүү, татварын бодлогоор дэмжиж, бүсийн нэмэгдэл олгоно.	100.0
3.1.22	Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ.	100.0

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
3.2	Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	69.1
3.2.1	Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ:	59.2
3.2.2	Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ:	100.0
3.2.3	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	77.5
3.2.4	Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	80.0
3.2.5	Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.	86.7
3.2.6	Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.	60.8
3.2.7	Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ:	50.4
3.2.8	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг Баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ.	90.0
3.3.1	Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	80.0
3.3.2	Газар тариалан, хөдөө аж ахуйн төв Дархан, Сэлэнгэ бус нутагт агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.	80.0
3.3.3	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	91.1
3.3.4	Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	83.6
3.3.5	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.	70.0
3.3.6	Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	92.2
3.3.7	Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.	83.3
3.3.8	Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.	77.9
3.3.9	Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	88.3
3.3.10	Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	83.1
3.3.11	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно.	96.7
3.3.12	Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	77.3
3.3.13	Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ.	95.0
3.3.14	Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ.	90.0
3.3.15	Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	86.7
3.4	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	70.2
3.4.1	Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий, "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II"-ийг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Увс, Ховд зэрэг аймагт хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.	32.7
3.4.2	Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор"-ын ажлуудыг цогц байдлаар дуусгаж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулна.	81.3
3.4.3	Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ.	50.0
3.4.4	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.	80.0

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
3.4.5	Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ.	90.0
3.4.6	Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	75.0
3.4.7	Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	90.0
3.4.8	"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	80.0
3.4.9	Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.	70.0
3.5	Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.	71.3
3.5.1	Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ:	69.8
3.5.2	Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана.	82.5
3.5.3	Төвлөрсөн хот, сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. /Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дундговь, Говьсүмбэр, Төв, Сүхбаатар, Хэнтий аймагт дулааны станц барина./	84.7
3.5.4	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах инновац, шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.	73.8
3.5.5	Бүс нутгийн эрчим хүчний сүлжээг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийн цахилгаан хангамжийг үе шаттайгаар шийдвэрлэж, ухаалаг систем бий болгоно. /Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина./	51.8
3.5.6	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах ногоон үйлдвэрлэлийн төслүүдийг хэрэгжүүлнэ. /Салхины цахилгаан станцын 15 МВт-ын хоёр, нарны цахилгаан станцын 35 МВт-ын дөрвөн төсөл хэрэгжүүлнэ./	76.2
3.5.7	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх иргэний болон үйлдвэрлэлийн барилга байгууламжийн томоохон төслийн эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хийнэ. /Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ./	71.9
3.6	Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.	60.1
3.6.1	Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ:	64.0
3.6.2	Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналтын механизмыг бүрдүүлэх замаар авто замын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн авто замын санг бие даасан үйл ажиллагаанд шилжүүлнэ:	43.8
3.6.3	Зорилт	69.5
3.6.4	Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна	58.4
3.7	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	72.1
3.7.1	Газрын харилцаа, хот байгуулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтооно.	85.0
3.7.2	"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно.	56.1
3.7.3	Хиймэл оюун ухаан болон блокчейн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан технологид суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	65.3
3.7.4	Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.	84.7
3.7.5	Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.	87.5
3.7.6	Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.	70.0
3.7.7	"Шинэ Зуунмод", "Майдар" шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ.	79.1
3.7.8	Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.	55.0
3.7.9	Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.	55.7
3.7.10	Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулна.	87.5
3.7.11	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.	78.9

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
3.7.12	Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	76.5
3.7.13	Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.	61.3
3.7.14	Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж "Замын-Үүд" чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд оруулна.	92.5
Дөрөв	ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	77.9
4.1	"Цахим Монгол"- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	77.0
4.1.1	Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, "Нэг иргэн-нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.	74.5
4.1.2	Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана.	90.0
4.1.3	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.	87.1
4.1.4	Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	68.3
4.1.5	Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ.	75.1
4.1.6	Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.	81.4
4.1.7	Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, үр чадварыг дээшлүүлнэ.	84.5
4.1.8	Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.	71.7
4.1.9	Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.	63.3
4.1.10	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	96.7
4.2	Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.	78.3
4.2.1	Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	67.5
4.2.2	Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.	91.1
4.2.3	"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд зөвшөөрлийн цахим бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрөөс олгох зөвшөөрлийн тоог цөөлж, олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.	100.0
4.2.4	Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.	82.5
4.2.5	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	76.6
4.2.6	Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.	56.7
4.2.7	Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.	78.5
4.2.8	Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.	70.0
4.2.9	Үндэсний стандартуудыг олон улсын түвшинд нийцүүлж шинэчилнэ.	100.0
4.2.10	Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	71.3
4.2.11	Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	63.3
4.3	Амар тайван, аюулгүй нийгэм. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	76.9
4.3.1	Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглана. Хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хүний нөөцийг нэмэгдүүлнэ. Хилийн анги, салбаруудын автомашины парк шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.	81.8

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
4.3.2	Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	78.9
4.3.3	Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.	76.3
4.3.4	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	82.0
4.3.5	Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	85.0
4.3.6	Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялсныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ.	76.8
4.3.7	Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангана.	73.3
4.3.8	Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	89.4
4.3.9	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	82.5
4.3.10	Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл автомашины камертай байх стандартыг тогтоож, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг үе шаттайгаар хязгаарлах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.	70.0
4.3.11	Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлэх, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна.	35.0
4.3.12	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн системийг хөгжүүлнэ.	74.4
4.3.13	Иргэдийн эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийг өндөр нарийвчлалтай тодорхойлж, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрсдэлд суурилсан хяналтаар чанд мөрдүүлнэ.	70.0
4.3.14	Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна.	43.5
4.3.15	Салбар дунд ашиглах "Агаарын аврах хүчин" байгуулна.	96.7
4.3.16	Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүрээлэн байгаа орчны эрүүл, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хэмжил зүйн эталоныг хөгжүүлнэ.	80.0
4.3.17	Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.	83.3
4.3.18	Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлнэ. Архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.	100.0
4.4	Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.	78.9
4.4.1	Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авна.	80.0
4.4.2	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хууль ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно.	70.0
4.4.3	Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэнэ.	85.0
4.4.4	Эх газрын эрх зүйн бүлийн хэв шинж, философид суурилсан Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн урт хугацааны "Эрх зүйн шинэтгэл II" арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.	100.0
4.4.5	Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	82.5

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
4.4.6	Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулан цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	80.6
4.4.7	Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.	76.0
4.4.8	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.	70.0
4.4.9	Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээлэлээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	74.4
4.4.10	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.	83.3
4.4.11	Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна.	78.3
4.4.12	Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.	70.0
4.5.1	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, цахимаар үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.	82.8
4.5.2	Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.	72.5
4.5.3	Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ.	83.0
4.5.4	Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, хүмүүнлэг зэрэг бүх салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.	58.0
4.5.5	Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.	82.4
4.5.6	Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	85.0
4.5.7	Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, төр, засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	36.7
4.5.8	Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно.	88.3
4.5.9	Дипломат албанд сахилга, хариуцлагыг эрс нэмэгдүүлж, хар тамхи тээвэрлэх болон хууль бус бусад аливаа үйлдлийг таслан зогсооно.	78.9
4.5.10	Монгол Улсын түүх, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ олон улсад сурталчлах, таниулах "Монгол Үндэстний үнэлэмж" арга хэмжээ, хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх "Дэлхийн Монголчууд II" арга хэмжээг төлөвлөн боловсруулж хэрэгжүүлнэ.	100.0
4.6	Батлан хамгаалах. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.	77.9
4.6.1	Хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.	80.0
4.6.2	Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг зэвсэгт хүчнийг бэхжүүлнэ.	75.7
4.6.3	Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	84.8
4.6.4	Зэвсэгт хүчний бүтэцэд барилга-инженерийн, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргийг байгуулна.	82.2
4.6.5	Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангах бодлогыг дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.	79.5
4.6.6	Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, зэвсэгт хүчнийг олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.	86.7
4.6.7	Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.	63.5
4.6.8	"Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ"-ийг хэрэгжүүлж, "Оюутан-цэрэг" сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.	75.6

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
4.6.9	Цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулна.	73.9
Тав	НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	76.1
5.1	Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	76.1
5.1.1	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	67.9
5.1.2	Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	81.7
5.1.3	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, нийслэлийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.	90.0
5.1.4	Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	76.3
5.1.5	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	85.8
5.1.6	Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна.	85.0
5.1.7	Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно.	86.7
5.1.8	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	91.7
5.1.9	Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулна.	76.7
5.1.10	Туул голын сав газраас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохыг таслан зогсоож, нөхөн сэргээлт хийж, усны түвшинг нэмэгдүүлнэ.	60.0
5.1.11	"Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	47.8
5.1.12	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	73.8
Зургаа	НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	77.1
6.1	Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.	78.8
6.1.1	Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн 20 жилээр төлөвлөнө.	80.0
6.1.2	Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад, Дарь-Эх дэд төвүүдийг шинээр байгуулна.	65.8
6.1.3	Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.	78.0
6.1.4	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлогын арга хэмжээний хүрээнд сайжруулсан түлшний 2 дахь үйлдвэрийг байгуулна.	96.7
6.1.5	Нийтийн тээврийн үйлчилгээнд зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан ухаалаг, эко, цахилгаан хөдөлгүүрт дан болон давхар автобус, цахилгаан соронзон болон дүүжин замын тээврийн хэрэгслийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлнэ.	48.2
6.1.6	Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулна.	70.0
6.1.7	Олон улсын стандартад нийцсэн явган хүний болон унадаг дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж барьж байгуулан, тоосжилтыг 50 хувь бууруулна.	100.0
6.1.8	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулна. Туул, Сэлбэ, Дунд голын урсацын тохируулга хийж, голуудын орчинд олон нийтийн соёл, амралтын тохилог орчныг бүрдүүлнэ.	91.7
6.1.9	Хог хаягдлын менежментийг сайжруулж, гэр хорооллын айл өрхийг үнс хадгалах зориулалтын савтай болгож, дахин боловсруулах бүх төрлийн үйлдвэрийг байгуулна.	91.7
6.1.10	Улаанбаатар хотын цэвэр усны шинэ эх үүсвэрийг бий болгож, "Төв цэвэрлэх байгууламж"-ийг шинээр барьж ашиглалтад оруулан, тус цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг дулааны III, IV цахилгаан станцын технологийн хэрэгцээнд ашиглана. Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартад нийцсэн бие даасан цэвэрлэх байгууламж бүхий ноолуурын үйлдвэрүүдээс бусдыг хотоос гаргаж, Ус сувгийн удирдах газрын харьяа урьдчилсан цэвэрлэх байгууламж Харгиаг татан буулгана.	79.2
6.1.11	Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	67.5
6.1.12	Богдхан төмөр замын төслийг түшиглэн "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	100.0
6.1.13	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих "Сургуулийн автобус" төслийг үргэлжлүүлнэ.	100.0

Д/д	Бодлого, чиглэл, зорилтын нэр	Хэрэгжилтийн хувь
6.2	Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	74.4
6.2.1	Төвлөрлийг сааруулах бодлогыг Улаанбаатар хотын удирдлагатай хамтарч үндэсний хэмжээнд цогц байдлаар хэрэгжүүлнэ.	70.0
6.2.2	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	82.2
6.2.3	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу аймгийн төвийн статусын асуудлыг тодорхой болгоно.	50.0
6.2.4	Дархан, Эрдэнэт зэрэг улсын зэрэглэлтэй хот байгуулах болон аймгийн төвүүдийг хот болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	50.0
6.2.5	Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	69.2
6.2.6	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тус сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ.	96.7
6.2.7	Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	81.7
6.2.8	Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	72.2
6.2.9	Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна. Аймгийн төвүүдийн гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна.	100.0
6.2.10	Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	72.9
6.2.11	Хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих замаар сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулна.	63.3
6.2.12	Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.	74.0
6.2.13	Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	71.7
6.2.14	Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	69.3
Хэрэгжилтийн хувь		73.8

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
НЭГ.КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО													
2.1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.													
1	Цар тахлын үеийн хүн, амын эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдэлийг бууруулах, нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлээр шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал						83.1	83.0	87.0				Засгийн газар, Улсын Онцгой Комисс
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО													
2.2.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.													
2	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	90.2	91.2	91.7	92.2	91.0	93.8	99.0	99.8	100.0	100.0	Эрүүл мэндийн яам
3	Эрүүл мэндийн салбарын мэдээллийн нэгдсэн платформд холбогдсон эмнэлгийн хувь	хувь	0	13.6	16.0	22.8	10.4	18.5	20.0	76.5	100.0	87.7	Эрүүл мэндийн яам
4	1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	13.3	12.3	11.8	11.3	11.6	12.4	12.3	94.3	0.0	0.0	Эрүүл мэндийн яам
5	100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцаа	промилль	23	21.4	20.6	19.8	24.9	35.1	26.4	0.0	0.0	0.0	Эрүүл мэндийн яам
6	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	77.4	80.6	82.2	83.8	46.6	55.4	61.9	57.8	67.4	73.9	Эрүүл мэндийн яам
7	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	73.1	77.9	80.3	82.7	82.4	74.8	79.1	100.0	93.2	95.6	Эрүүл мэндийн яам
8	Хорт хавдрын эрт илрүүлгийн хувь	хувь	30	40.0	50.0	60.0	26.0	29.6	33.7	65.0	59.2	56.2	Эрүүл мэндийн яам 2023 он: Урьдчилсан гүйцэтгэл
9	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	38.3	41.6	43.0	44.4	28.6	35.0	37.8	68.8	81.4	85.1	Эрүүл мэндийн яам 2023 он: Урьдчилсан гүйцэтгэл
10	Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь	хувь	98.1	98.5	98.7	98.9	97.0	95.3	96.0	98.5	96.6	97.1	Эрүүл мэндийн яам 2023 он: эхний 11 сарын байдлаар
11	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь	хувь	98.5	98.9	99.1	99.3	95.1	93.7	95.0	96.2	94.6	95.7	Эрүүл мэндийн яам 2023 он: эхний 11 сарын байдлаар
2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.													
12	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)	хувь	53	54.5	56	57.5	-	78.5	68.3	-	100.0	100.0	Биеийн тамир спортын улсын хороо 2021 он:"Ковид-19" цар тахлын улмаас улс орон даяар "Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал", "Бүх нийтийн бэлэн байдал" зарлаж, нийтийг хамарсан арга хэмжээг тодорхой хугацаагаар хориглосон, Мөн хорио цээрийн дэглэмийг мөрдөх шаардлагын улмаас сорилд хамруулах боломжгүй болсон тул 2021 онд иргэдээс бие бялдрын түвшин тогтоох сорил аваагүй болно.
2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.													

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
13	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /3-5 нас/	хувь	86.1	87.3	87.9	88.5	80.0	90.4	92.8	91.6	100.0	100.0	Боловсрол, шинжлэх ухааны яам
14	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	хувь	90.1	93.4	95.0	96.7	91.2	93.3	94.8	97.6	98.2	98.0	Боловсрол, шинжлэх ухааны яам
15	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	94.9	95.2	95.3	95.5	95.0	95.5	95.4	99.8	100.0	99.9	Боловсрол, шинжлэх ухааны яам
16	Дээд боловсролын нийт багшид докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	хувь	30.5	32.0	35.0	40.0	36.1	38.1	46.9	100.0	100.0	100.0	Боловсрол, шинжлэх ухааны яам
17	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	тоо	34.1	31.1	29.6	28.1	31.1	30.5	31.2	100.0	97.0	90.1	Боловсрол, шинжлэх ухааны яам
18	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	31.1 хот-34.6 хөдөө-28.5	29.1, хот-33.2, хөдөө-27.3	28.1, хот-32.5, хөдөө-26.7	27.1, хот-31.8, хөдөө-26.1	29.1	32.5	32.1	100.0	86.5	84.4	Боловсрол, шинжлэх ухааны яам
19	Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр)	тоо	Цэцэрлэг-32.6 ЕБС: хотод-32.8, хөдөө-27	26-32	26-31	26-31	29.0	30.0	30.5	100.0	95.0	93.3	Боловсрол, шинжлэх ухааны яам
20	Ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль)	хувь	76.5	81.1	83.4	85.7	67.8	70.2	72.5	83.6	84.2	84.6	Боловсрол, шинжлэх ухааны яам
2.4. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.													
21	Нэг зуун судлаачид оногдох патентын тоо	тоо	10	11	12	14	20	10	5	100.0	83.3	37.1	Боловсрол, шинжлэх ухааны яам
22	Хэвлүүлсэн нийт бүтээлд гадаадад хэвлүүлсэн бүтээлийн эзлэх хэмжээ (хувиар)	тоо	18.7	20	24	26	18	20	34.5	90.0	83.3	100.0	Боловсрол, шинжлэх ухааны яам
23	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	0.18	0.98	1.38	1.78	0.13	0.11	0.11	13.3	8.0	6.2	Боловсрол, шинжлэх ухааны яам
24	Нэг сая хүнд оногдох эрдэм шинжилгээний өгүүллийн тоо	тоо	50	134	176	218	164	164	151	100.0	93.4	69.2	Боловсрол, шинжлэх ухааны яам
25	Шинэ бүтээлийн гэрчилгээ авсан бүтээлийн тоо	тоо	50	200	275	350	240	403	345	100.0	100.0	100.0	Боловсрол, шинжлэх ухааны яам
2.5. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.													
26	Хүний хөгжлийн үзүүлэлт	индекс	0.74	0.74	0.75	0.75	0.776	0.781		100.0	100.0		Засгийн газар 2023 он: 2024 оны эхний улиралд гарна.
27	Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувь	хувь	71.6	73	74	76							Засгийн газар 2022 он: ҮСХ-Тэгш онуудад тооцдог. 2022 оны судалгааны эцсийн үр дүн 2024 оны 1-р улиралд гарна
28	Ядуурлын түвшин	хувь	28.4		26								Засгийн газар 2022 он: ҮСХ-Тэгш онуудад тооцдог. 2022 оны судалгааны эцсийн үр дүн 2024 оны 1-р улиралд гарна
29	Ажилгүйдлийн түвшин	хувь	10	9.5	9.0	8.5	8.1	6.7	5.2	85.3	74.4	61.2	Засгийн газар 2023 он: 3-р улирлын байдлаар

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
30	Хэрэглээний тэгш бус байдлын үзүүлэлт	нэгж	0.33	0.33	0.33	0.33	0.31	0.34	0.30	93.9	103.0	92.3	Засгийн газар 2023 он: 3-р улирлын байдлаар
31	Төсөвт байгууллагын сарын дундаж цалингийн хэмжээ	сая төгрөг	1090	-	1155.4	1224.7	1140.7	1290.5	1982.1		100.0	100.0	Засгийн газар
32	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	60.5	61.0	61.5	62.0	56.9	58.6	58.9	93.3	95.3	95.0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
33	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	хувь	77.5	80	82.5	85	86.5	99.0	93.3	100.0	100.0	100.0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
34	Төгсөөд шууд ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь (МСҮТ, Политехник коллеж)	хувь	53.5	67.5	68	68.5	74.5	73.8	72.5	100.0	100.0	100.0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
35	Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт	хувь	8	-	6	6	-	29.4	10.0		100.0	100.0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
36	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилж, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх	сая төгрөг	420.0		483	504	-	420.0	550.0		87.0	100.0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
37	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хувь	хувь	68	70	72	75	81.3	64.0	84.0	100.0	88.9	100.0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам
2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.													
38	1,000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо	32	33	34	35	37.3	37.1		100.0	100.0		Соёлын яам 2023 он: Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 19 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу салбарын албан ёсны статистикийг эрхлэн жилд нэг удаа гаргах буюу дараа жил бүрийн 3-р сарын 15-ны өдрийн дотор Үндэсний статистикийн хороонд хүргүүлдэг эрх зүйн зохицуулалттай. Үүнээс шалтгаалан 2023 оны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт гаргах боломжгүй байна.
39	Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	хувь	47.1	49	52	54	28.3	58.9		57.8	100.0		
40	Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	хувь	8.1	10.1	12.1	14.1	4.8	23.7		47.5	100.0		
41	Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн хувь	хувь	21.6	21.8	22.1	22.7	14.2	25.3		65.1	100.0		
42	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	хувь	0.3	0.5	1.3	2.4	0.27	1.09		54.0	83.8		
43	Музейгээс зохион байгуулсан үзэсгэлэнгийн тоо	тоо	48	50	55	60	187	1731		100.0	100.0		
44	Сэргээн засварласан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо	тоо	200	250	500	650	4528	5122		100.0	100.0		
45	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулсан зардал	тоо /сая төгрөг/	30.0	50.0	72.8	115.6	327.5	364.5		100.0	100.0		
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО													
3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.													
46	Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанкинд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлсэн хувь	хувь	30	40	50	60	0	50	60	0.0	100.0	100.0	Сангийн яам
47	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт	хувь	5.2	7.2	4.4	6.5	1.6	5.0	6.9	22.2	100.0	100.0	Засгийн газар 2023 он: 2023 оны 3-р улирлын байдлаар
48	Инфляц	хувь	3.8	7.0	6.0	6.0	7.3	15.2	7.9	95.9	39.5	75.9	Засгийн газар, Монгол банк

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.													
49	Геологийн сэдэвчилсэн судалгааны ажил гүйцэтгэн бүс нутгийн хэтийн төлөвийн үнэлгээ	төслийн тоо	9	16	24	25	17	22	20	100.0	91.7	80.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
50	Геомэдээллийн болон чулуун дээжийн сан, цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээ	төслийн тоо	1	2	3	3	3	3	3	100.0	100.0	100.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
51	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийн ажлын явц	хувь	10	25	60	90	-	7	11		11.7	12.2	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
52	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	18	25.5	26.8	28.1	25.4	23.6	26.8	99.6	88.1	95.4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2023 он: 2023 оны хүрсэн түвшин эцэслэн гараагүй ба 2023 оны III улирлын байдлаар 26.8 хувьтай.
53	Нүүрсний экспортын хэмжээ	сая тонн	20	36	38	40	16.1	31.8	69.6	44.7	83.7	100.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
54	Зэсийн баяжмалын экспорт	мян. тонн	1270	1430	1590	1750	1283	1453	1525	89.7	91.4	87.1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
55	Төмрийн хүдэр, баяжмалын экспорт	сая тонн	8.2	8.9	9.2	9.5	7.1	4.7	5.7	79.8	51.1	60.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
56	Жилд ашиглалтад оруулах уурхай, баяжуулах үйлдвэрийн тоо, өссөн дүнгээр	ш	0	20	40	60	39	73	93	100.0	100.0	100.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
57	Геологийн зураглалын ажил гүйцэтгэн нутаг дэвсгэрийн гүний тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол	төслийн тоо	33	36	37	37	33	35	25	91.7	94.6	67.6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
58	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь	хувь	9.6	9.7	9.8	9.9	8.5	8.6	6.8	87.1	87.9	68.7	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2023 он: 2023 оны 3-р улирлын байдлаар
59	Газрын тос олборлолтын хэмжээ	мянган тонн	400	836.4	834.3	816.2	620.9	347.9	657.1	74.2	41.7	80.5	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
60	Экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахууны хэрэглээ	хувь	13	15	25	35	15.5	23	11	100.0	92.0	31.4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.													
61	Хүнсний ногооны хангамж	хувь	40	55	60	70	60	70	83	100.0	100.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
62	Төмсний хангамж	хувь	100	100	100	100	100	100	100	100.0	100.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
63	Буудайн хангамж	хувь	100	100	100	100	100.0	100	100	100.0	100.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
64	Махны нөөц бүрдүүлсэн хэмжээ	мян. тонн	11	20	20	20	19.3	12.7	9.1	96.3	63.5	45.5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
65	Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ	мян. тонн	59	70	90	120	22.4	16	80.4	32.0	17.8	67.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
66	Сэрүүний улиралд нийлүүлсэн сүү	сая литр	17	20	22	25	19.5	23.2	24.8	97.5	100.0	99.2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
67	Тослог ургамлын дотоодын хангамж, дотоодын үйлдвэрийн хэрэгцээний хангалт	мян тонн	-	48	56	64	12	45.7	50.5	25.0	81.6	78.9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
		хувь	-	50	62	71	30	45.7	56.02	60.0	73.7	78.9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
68	Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж	тоо	131	5	10	15	155	174	189	100.0	100.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
69	Отрын тусгай хэрэгцээний нөөц нутаг	сая.га	3	3.3	3.6	3.9	1.9	3.6	3.9	57.6	100.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
70	Малчин өрхийн дундаж орлогын өсөлт	хувь	1180662 сая төгрөг	10%	10%	10%	7.5%	15.8%	27.0%	75.0	100.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
71	Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан малчин өрх	хувь	-	83.5	87.0	89.0	100.0	90.0	90.2	100.0	100.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
72	Мал, амьтны зоонозын халдварт өвчний голомт, тохиолдлын бууралт	хувь	бруцеллёзын халдварлалтын түвшин 0.26%	0.02	0.02	0.02	0.25	0.10	0.06	8.0	20.0	33.3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
		хувь	галзуугийн 216 голомтод 284 тохиолдол	1	1	2	171 голомт, 266 тохиолдол	94 голомт, 154 тохиолдол	137 голомт, 204 тохиолдол	100.0	100.0	68.6	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
		хувь	боомын 6 голомтод 44 тохиолдол	1	1	2	5 голомт, 14 тохиолдол	14 голомт, 20 тохиолдол	боомын 3 голомт, 66 тохиолдол	100.0	35.7	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
3.4. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.													
73	Брэнд бүтээгдэхүүн	тоо	10	-	20	40	-	0	100		0.0	100.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
3.5. Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.													
74	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал	МВт	1407	1508	1518	1568	1544	1554	1569	100.0	100.0	100.0	Эрчим хүчний яам
75	Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлын эзлэх хувь	хувь	19.3	21	22	22	18	18	19	83.8	82.3	85.9	Эрчим хүчний яам
76	Импортын эрчим хүчний хэмжээ	сая кВт.ц	1715.8	1710	1705	1690	1869	2142	2421	91.5	79.6	69.8	Эрчим хүчний яам
77	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	95	95.1	95.2	95.3	100	99	99	100.0	100.0	100.0	Эрчим хүчний яам
78	Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал	Гкал/ц	2868	2998	3200	3350	3406	3219	3725	100.0	100.0	100.0	Эрчим хүчний яам
79	Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрээс хангах дулааны эрчим хүчний хэмжээ	мян.Гкал	10310.9	10500	10800	11300	10757	11544	11425	100.0	100.0	100.0	Эрчим хүчний яам
3.6. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.													

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
80	Байнгын ашиглалтад оруулах хатуу хучилттай авто замын хүчин чадал	км	480	126.60	623.02	654.15	164.48	292.03	318.92	100.0	46.9	48.8	Зам, тээврийн хөгжлийн яам 2023 он: Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил 91%-тай, Ховд-Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн 18.775 км хатуу хучилттай авто замын ажил 40%-тай, Ховд-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км авто замын барилгын ажил 55%-тай байгаа бөгөөд 2024 онд бүрэн ашиглалтад оруулахаар байна.
81	Байнгын ашиглалтад оруулах гүүрийн нийт хүчин чадал	у/м	350	300.60	323.51	218.36	531.80	414.89	841.87	100.0	100.0	100.0	Зам, тээврийн хөгжлийн яам
82	Логистик төв	тоо	-	-	1	1	-	1	1		100.0	100.0	Зам, тээврийн хөгжлийн яам
83	Ашиглалтад оруулах төмөр замын урт	км	1922	414.6	267	-	601.2	297.2	-	100.0	100.0		Зам, тээврийн хөгжлийн яам
84	Ерөнхий зориулалтын нисэхийн хөөрч буух зурвас байгуулах	тоо	96	30	10	10	59	23	24	100.0	100.0	100.0	Зам, тээврийн хөгжлийн яам
85	Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өссөн дүнгээр	тоо	2	-	1	2	-	-	5		0.0	70.0	Зам, тээврийн хөгжлийн яам 2021 он: Төслийн зардал, үр ашгийн тооцоо алдагдалтай тул "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах боломжгүй. 2022 он: Төслийн зардал, үр ашгийн тооцоо алдагдалтай тул "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах боломжгүй. 2023 он: "Ховд", "Чойбалсан", "Мөрөн", "Гурвансайхан" нисэх буудлуудыг концессын зүйл заалтын жагсаалтад оруулсан боловч концессын уралдаант шалгаруулалт амжилтгүй болж 2024 онд дахин зарлахаар ажиллаж байна.
86	Нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэл хийх автобусны тоо	тоо	1200	530	120	150	0	73	314	0.0	60.8	100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
87	Ашиглалтад оруулах зорчигч тээврийн автобуудал	тоо	10	2	3	3	6	25	23	100.0	100.0	100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.													
88	Салбарын эрэлт, хэрэгцээнд нийцсэн 1:25000 масштабтай байр зүйн зураг	хувь	45	60	70	80	45	45	45	75.0	64.3	56.3	Барилга, хот байгуулалтын яам
89	Хаягийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн хувь	хувь	30	50	70	90	50	90	90	100.0	100.0	100.0	Барилга, хот байгуулалтын яам
90	Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, "Нэг газрын зураг" үйлчилгээний нэвтрүүлэлтийн хувь	хувь	50	60	70	80	60	70	70	100.0	100.0	87.5	Барилга, хот байгуулалтын яам

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
91	Шинээр байгуулагдсан үндсэн нэр төрлийн барилгын материалын үйлдвэр	тоо	3	4	5	7	13	18	25	100.0	100.0	100.0	Барилга, хот байгуулалтын яам
92	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдрах нийт өрхийн эзлэх хувь	хувь	33.3	34	35	36	33.5	34.8	36	98.5	99.4	100.0	Барилга, хот байгуулалтын яам
93	Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо	тоо	6476	14476	22476	30476	13292	20024	35707	91.8	89.1	100.0	Барилга, хот байгуулалтын яам
94	Шинээр баригдсан үерийн далан сувгийн урт	км	432.5	473.3	514.1	554.9	440.5	452.9	485.9	93.1	88.1	87.6	Барилга, хот байгуулалтын яам
ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО													
4.1.Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.													
95	Цахим засаглалын хөгжлийн индекс	хөгжлийн индекс	0.582	0.590	0.600	0.610		0.721			100.0		Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Source: UN E-Government Knowledgebase
96	Иргэний улсын бүртгэлийн дугаар, тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн, бүртгэлжүүлэх	хувь		1	10	20		20.4	43.1		100.0	100.0	Хууль зүй, дотоод хэргийн яам
97	Тусгай хэрэглээний сүлжээний хамрах хүрээг өргөтгөсөн хувь	хувь	20	40	20	20	0	0	36			100.0	Тагнуулын ерөнхий газар
98	Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцсон иргэний тоо	тоо	23000			123000	-	503802	859902			100.0	Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар 2021 он: Санхүүжилт олгогдоогүй тул уг ажлын биелэлт тасарсан. 2022 он: Санхүүжилт олгогдоогүй тул уг ажлын биелэлт тасарсан.
99	Төрийн үйлчилгээний E-Mongolia платформд холбогдох, төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээний тоо	тоо	181	261	341	421	606	806	1130	100.0	100.0	100.0	Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар
100	Шилэн кабелийн сүлжээнд холбох сум суурингийн тоо	тоо	320	8	5	-	1	2	0	12.5	40.0	0.0	Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар 2023 он: Төсвийн асуудал шийдвэрлэгдээгүй
4.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.													
101	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Авлигын хяналт	хувь	39.9	41	42	44		33.02				78.6	Засгийн газар, Авлигатай тэмцэх газар Дэлхийн банкнаас 5 жил тутам гаргадаг. https://www.worldbank.org/en/publication/worldwide-governance-indicators/interactive-data-access
102	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Засгийн газрын үр нөлөө	хувь	45.7	47	49	51		34.91				71.2	
103	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Зохицуулалтын чанар	хувь	54.8	56	58	60		42.45				73.2	
104	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Хуулийн засаглал	хувь	44.7	45	46	48		45.75				99.5	
105	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба хариуцлага	хувь	57.1	58	60	62		56.04				93.4	

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
106	Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, захиран зарцуулалтад хийсэн хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо	хуулийн этгээдийн тоо	26	35	35	35	38	45	35	100.0	100.0	100.0	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
107	Төрийн өмчийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн бууралт	хувь	3 хувь	5 хувь	8 хувь	12 хувь	10	8	12	100.0	100.0	100.0	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
108	Төрийн өмчит компанийн засаглалын дундаж үнэлгээ	хувь	53.9	65.0	70.0	75.0	64.8	69	74.4	99.7	98.6	99.2	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2021-2023 он: Хувьцаа эзэмшигчдийн эрх олон болсон, компанийн засаглалын нэгдсэн удирдлагагүй
4.3.Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.													
109	Даяаршлын үзүүлэлт	индекс	57.0	57	58	59							Засгийн газар
110	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, сургалтад ашигласан байдал	хувь	0	40	20	20	40	20	20	100.0	100.0	100.0	Тагнуулын ерөнхий газар
111	Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлсэн болон эрсдэлийн үнэлгээ боловсруулж, эрсдэлийг бууруулсан хувь хэмжээ	хувь	70	72	74	76	71	72	74	98.6	97.3	97.4	Тагнуулын ерөнхий газар
112	Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (100 000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)	тоо	13.4	9.4	9.2	9	7.1	8.2	9.0	75.5	89.1	100.0	Хууль зүй, дотоод хэргийн яам
4.4.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.													
113	Нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлал	хувь		44.7	51.2	60.7	45.8	7.7	17.3	97.6			Хууль зүй, дотоод хэргийн яам 2022, 2023 он: Үзүүлэлт тооцох аргачлалаас хамаарч тооцох боломжгүй байна.
4.5.Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.													
114	Дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээ	тоо	20	30	21	21	28	29	49	93.3	100.0	100.0	Гадаад харилцааны яам
115	НҮБ, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн түвшинд оролцсон арга хэмжээ, хэрэгжүүлсэн айлчлал	тоо	4	7	4	4	15	14	5	100.0	100.0	100.0	Гадаад харилцааны яам
116	Хоёр талт олон улсын гэрээ	тоо	47	7	8	7	11	12	31	100.0	100.0	100.0	Гадаад харилцааны яам
117	Салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ЗГ хоорондын комиссын хуралдаан, ГХЯ хоорондын зөвлөлдөх уулзалтын тоо	тоо	36	34	33	34	27	27	39	79.4	81.8	100.0	Гадаад харилцааны яам

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
118	Гадаад улстай хэрэгжүүлэх хамтарсан төсөл хөтөлбөрийн тоо	тоо	60	41	34	35	93	74	42	100.0	100.0	100.0	Гадаад харилцааны яам
119	Хилийн чанадаас хуулбарлан буцаан авсан эд өлгийн зүйлс, соёлын өв	тоо	5	40	20		23	30	3	57.5	100.0		Гадаад харилцааны яам
4.6. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.													
120	Дэлхийн энх тайвны үзүүлэлт	индекс	1.8	1.75	1.71	1.67	1.783	1.775	1.765	100.0	100.0	100.0	Засгийн газар
121	Кибер аюулгүй байдлын тоног төхөөрөмжийг шинэчилж, анги, байгууллагын сүлжээний аюулгүй байдал хангагдсан хувь	хувь	5	10	30	40	10	30	40	100.0	100.0	100.0	Батлан хамгаалах яам
122	Тусгай хүчний цэрэг орчин үеийн зэвсэглэл, техник, хэрэгслээр хангагдах хувь	хувь	10	15	20	30	15	20	30	100.0	100.0	100.0	Батлан хамгаалах яам
123	Улсын агаарын хилийн хяналтад технологийн шинэчлэлт хийж, системийн чадавхыг нэмэгдүүлсэн хувь	хувь	4	-	7	13		7	10		100.0	76.9	Батлан хамгаалах яам
124	Зэвсэгт хүчний анги, байгууллагыг холбоо, мэдээллийн суурь сүлжээ, өндөр хурдны өргөн зурвасын тоон техник, технологид шилжүүлсэн хувь	хувь	15	20	30	40	20	30	40	100.0	100.0	100.0	Батлан хамгаалах яам
125	Оюутан цэрэг цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах их, дээд сургуулийн оюутан, МСҮТ-ийн суралцагчдын тоо	тоо	1000	-	500	-		500	1500		100.0		Батлан хамгаалах яам
ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО													
5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.													
126	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	60	55	50	46	44	41	41	100.0	100.0	100.0	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
127	Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	124	115	107	101	89	88	82	100.0	100.0	100.0	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
128	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	20.1	22	23	24	21	21	21	95.5	91.3	87.5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
129	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	48.3	50	51	52	50	50	50	100.0	98.0	96.2	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
130	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	7.9	8	8.2	8.4	8	8.2	8.28	100.0	100.0	98.6	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
131	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	хувь	14	15	17	19	14.8	16.6	17.3	98.7	97.6	91.1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
132	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	82.5	82.6	83	83.5	82	82.1	82.2	99.3	98.9	98.4	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
133	Барилгын салбарын хүлэмжийн хийн бууралт	мян.тн CO2	0.3	0.6	0.9	1.2	0.6	0.9	1.2	100.0	100.0	100.0	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
134	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	7.6	10	15	20	15.7	18.4	20.1	100.0	100.0	100.0	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
135	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	25.6	30	36	42	43.5	43.5	48	100.0	100.0	100.0	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам
136	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	-	2	4	6			6			100.0	Сангийн яам, Худалдан авах ажиллагааны газар
137	Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI	оноо	57.2	57.2	57.2	58	32.2	29.6	Тайлан гараагүй	56.3	51.7		Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2023 он: тайлан гараагүй (АНУ-ын Ейлийн их сургуулиас байгаль орчны гүйцэтгэлийн индекс нь улс орнуудын Засгийн газраас явуулж буй байгаль орчны бодлогын хэрэгжилтийг 11 бүлэгт хамаарах 32 гүйцэтгэлийн шалгуураар 2 жилд нэг удаа дүгнэдэг аргачлал юм. МУ-ын албан ёсны дата мэдээллийг оруулах чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай. Цаашид үндэсний хэмжээнд энэ үзүүлэлтийг гаргадаг болох асуудлаар Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллана.)

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
138	Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь	мян.т CO ₂ -экв.	25,815.30	9.2	10	10.8	Тодорхойг үй	Тодорхойг үй	Тодорхойг үй				Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2021 он."Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг 2021-2025 онд хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор баталсан. Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг цаашид таван жил тутамд шинэчлэн зорилтыг ахиулан тодорхойлж, хэрэгжилтийг тайлагнах үүрэгтэй. Үүний дагуу 2025 онд үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг шинэчилнэ. Үүнтэй холбогдуулан үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн 2021-2023 оны зорилтын хэрэгжилтийг зорилтод түвшин тус бүрээр үнэлэх ажлыг 2024 онд багтаан нэгтгэн дүгнэх ажлыг зохион байгуулж байна. Иймд хүрсэн түвшин, хэрэгжилтийн хувийг он тус бүрээр тодорхойлох боломжгүй байна.
139	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	38	40	42	44	69.2	69.3	69.3	100.0	100.0	100.0	Барилга, хот байгуулалтын яам
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО													
6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.													
140	Бүтээн байгуулалт хийсэн дэд төвийн тоо	хувь		2	-	4	2	4	4	100.0		100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
141	Хотын хөгжлийн үзүүлэлт	индекс	0.504	0.517	0.531	0.544	0.562	0.557	0.459	100.0	104.9	84.4	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
142	Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдсан орон сууц	орон сууцны тоо	9,229	2,475	2,475	5,000	201	2,164	1,313	8.1	87.4	26.3	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 2023 он: Барилгын материалын үнэ нэмэгдсэн
143	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдсан орон сууц	орон сууцны тоо	1,556	300	600	600	266	377	307	88.7	62.8	51.2	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 2023 он: Барилгын материалын үнэ нэмэгдсэн
144	Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын төслөөр баригдсан орон сууцны тоо	орон сууцны тоо	-	-	500	2500		0	0		0.0	0.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 2023 он: Гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил хийгдэж байна

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин			Хэрэгжилтийн хувь			Хариуцах байгууллага/ Хүрсэн түвшингийн талаарх тайлбар
				2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	
145	Сайжруулсан түлшээр хангасан өрхийн тоо	өрхийн тоо	162,469	197,000	187,000	177,000	197,000	206,383	203,683	100.0	100.0	100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
146	Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглолтой шинээр нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн тоо	автобусны тоо	11	80	70	90	10	73	314	12.5	100.0	100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
147	Шинээр нэмж барих дугуйн замын урт	км	58.8	10	18	18	10	20	38	100.0	100.0	100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
148	Цэцэрлэгт хүрээлэнгийн тоо	тоо	18	1	1	1	1	15	13	100.0	100.0	100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
149	Шинээр барьж ашиглалтад оруулсан Улаанбаатар хот болон аймгуудын цэвэрлэх байгууламжийн нэмэгдсэн хүчин чадал	тоо	5	2	3	2	3	12	14	100.0	100.0	100.0	Барилга, хот байгуулалтын яам
6.2.Бус, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.													
150	Орон нутаг дахь шинээр барьж байгуулсан инженерийн шугам сүлжээний нийт урт (жил бүр)	км	100	100	100	150	150.8	232.8	292.8	100.0	100.0	100.0	Барилга, хот байгуулалтын яам
151	"Сумын хөгжил" арга хэмжээнд хамрагдсан сумд	тоо	40	45	63	81	45	63	81	100.0	100.0	100.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
152	Хот, суурин газрын нийтийн халуун усны төвийг шинэчлэх, шинээр барьсан тоо	тоо	634	642	652	662	641	656	662	99.8	100.0	100.0	Барилга, хот байгуулалтын яам



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Улаанбаатар
хот**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
(2023 оны байдлаар)**

Монгол Улсын Их Хурлын ээлжит 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Засгийн газар нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн, Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд оролцсон Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан нам, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналуудад үндэслэн 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлсон.

Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, бүс ба орон нутгийг хөгжүүлэх, өмнөх Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарч, дараах зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүлсэн болно.

**НЭГ.КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО**

1.1."Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.1.“Ковид-19” халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих дараах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ:

1.1.1.1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цар тахлын үеийн нэмэгдлийг 2020 оныг дуустал үргэлжлүүлэн олгоно.

Биелэлт: Цар тахлын үед Иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор 18 хүртэлх насны 1.2 сая хүүхэд бүрд олгож буй мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж сар бүр 100 мянган төгрөг олгосон. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид нийт 2,916.9 (2021 онд 1,455.2 тэрбум төгрөг, 2022 онд 1,461.7) тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

1.1.1.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг 2020 оны 10 дугаар сараас хойш хэсэгчлэн үргэлжлүүлнэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт болон хөнгөлөлтийг гурван үе шаттай хэрэгжүүлсэн байна. Үүнд, 1) 2020 оны 4 дүгээр сарын 1-ээс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл аж ахуйн нэгж даатгуулагчийг шимтгэл төлөхөөс бүрэн чөлөөлж төрөөс нөхөн төлсөн. 2) 2020 оны 10 дугаар сарын 1-ээс 2020 оны 12 дугаар сарын 31-ийг дуустал хугацаанд ажил олгогч болон даатгуулагч (сайн дурын даатгуулагч мөн нэгэн адил) тус бүр 5 хувь шимтгэл төлөх, үлдэх хувийг төрөөс нөхөн төлсөн. 3) 2021 оны 1 дүгээр сарын 1-ээс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл ажил олгогч болон даатгуулагч (сайн дурын даатгуулагч мөн нэгэн адил) тус бүр 8.5 хувь шимтгэл төлөх, үлдэх хувийг төрөөс нөхөн төлөв.

1.1.1.3.Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх арга хэмжээг 2020 оныг дуустал

үргэлжлүүлнэ. (2019 оны үйл ажиллагааны орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоогүй жижиг, дунд бизнесийн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлнө.)

Биелэлт: УИХ-аар 2020 оны төсвийн тодотголд тусгагдсанаар, жилийн 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийг 6 сарын хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлсөн.

1.1.1.4.Түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод 2020 оныг дуустал татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлэн үзүүлнэ. (2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оныг дуустал 11 сарын хугацаанд түрээсийн төлбөрөө бууруулсан татвар төлөгчид бууруулсан түрээсийн төлбөрийн хэмжээгээр татварын хөнгөлөлт эдлүүлнэ.)

Биелэлт: 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн 28.5-д зааснаар төлбөрийн баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлж нийт 7,678 татвар төлөгчийн 3,400.0 сая төгрөгийг чөлөөлсөн. (2020 онд 3,514 татвар төлөгчийн 2,300.0 сая төгрөг, 2021 онд 4,164 татвар төлөгчийн 1,100.0 сая төгрөг)

1.1.1.5.Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: Ажлын байранд Ковид 19 цар тахал гарахаас урьдчилан сэргийлэх асуудлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг БНТУ-ын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн үйлчилгээний яамны харьяа Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий газар, Туркийн Хамтын ажиллагааны зохицуулах агентлагтай хамтран 2020 оны 9 дүгээр сард Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд ажлын байранд авч хэрэгжүүлэх ерөнхий арга хэмжээ, үйлдвэрлэл, үйлчилгээний 18 салбар, чиглэл тус бүрээр ажлын байрыг коронавирүсийн дэгдэлтээс хамгаалахад анхаарах асуудлаар нийт 5 өдрийн 20 цагийн зайн сургалтыг зохион байгуулсан. Мөн “Ажлын байранд Ковид-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх шалгах хуудасны загвар”-ыг батлан хэрэгжүүлсэн.

1.1.2.“Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ:

1.1.2.1.Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн төсвийг нэмэгдүүлж 2021 оны төсөвт 100.0 тэрбум төгрөг батлуулсан.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс шинэ коронавирүсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм, халдваргүйтгэлийн бодис худалдан авах зардалд, тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын байр, хоолны мөнгө, төрийн холбогдох байгууллагуудын

албан хаагчдад урамшуулал, халдварын тусгаарлалтын зардалд нийт 115.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.(2020 онд 50.9 тэрбум, 2021 онд 64.9 тэрбум)

1.1.2.2.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ.

Биелэлт: Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны 67/А/268, А/387/99 дүгээр хамтарсан тушаалуудыг тус тус баталсан.

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, эмнэлгүүдийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, илүү цагийн хөлс, урамшуулал, дэмжлэг олгоход 2021 онд нийт 309.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ПГУ оношлуурын нөөцийн мэдээг өдөр бүр Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын мэдээний санд бүртгэж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд оношлуур 29 гаруй хоног, хувийн хамгаалах хэрэгсэл 44-234 хоног, вирусийн эсрэг эм 56-827 хоног, антибиотик 65-872 хоног, амилуулах тусламж, үйлчилгээний эм 91-357 хоног, дуслын шингэн болон шинж тэмдгийн эсрэг эм 68-260 хоногийн нөөцтэй байсан.

1.1.2.3.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад шаардлагатай эх үүсвэрийг олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудтай хамтран шийдвэрлэнэ. (110.0 сая ам.доллар)

Биелэлт: Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад шаардлагатай эх үүсвэрийг олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудтай хамтран нийт 111.7 сая ам.долларыг шийдвэрлэв. Үүнд:

1. Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсад КОВИД-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл”-ийн 50.7 сая ам.доллар;
2. Монгол Улс, АХБ-тай 19.0 сая ам.долларын Зээлийн хэлэлцээр;
3. Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкттай (АДБХОБ) 21.0 сая ам.долларын Зээлийн хэлэлцээр;
4. Монгол Улс, Япон Улсын Засгийн газартай байгуулсан 21.0 сая ам.долларын буцалтгүй тусламж.

1.1.2.4.Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна.

Биелэлт: 2020 онд Монгол Улсын хэмжээнд дархлаажуулалтад хамрагдвал зохих 6 сартайгаас 13 насны нийт 352924 хүүхэд байсан ба нийт хүүхдийн 96.6 хувь нь буюу 340968 хүүхэд дархлаажуулалтад хамрагдсан. Дархлаажуулалтын хувь нийслэлд 96.2 хувьтай байсан бол орон нутагт 98 хувьтай хамрагдсан байна.

2021 онд нийт 360,600 тун вакциныг томуугийн вакцинжуулалтад хэрэглэх бэлтгэл ажлыг хангасан, нийт төсөв 4.6 тэрбум төгрөгийг зарцуулсан. Дархлаажуулалтыг эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-11 насны 235,678 хүүхдийг 2021 оны байдлаар улирлын томуугийн вакцинд хамруулсан. Энэ нь нийт хамрагдвал зохих хүүхдийн 98.6 хувийг эзэлж байна.

1.1.2.5.Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Коронавируст халдварын голомтод ажилласан Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эмнэлгийн ажилтнуудын цалин, урамшуулал, дэмжлэгт 8.3 тэрбум төгрөг, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 1.2 тэрбум төгрөгийг 2021 онд тус тус олгосон байна. Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод болон гамшгийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтанд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэгийг ХӨСҮТ-ийн 1,596 (давхардсан тоогоор) албан хаагчдад 7 удаагийн шийдвэрээр 2.8 тэрбум төгрөг, ЗӨСҮТ-ийн 249 (давхардсан тоогоор) албан хаагчдад 3 удаагийн шийдвэрээр 415.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

1.1.2.6. Хүн амыг коронавирусийн эсрэг вакцинд хамруулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг 5 төрлийн (АстраЗенека (AZD1222), Пфайзер/БиоНТех BNT162 (Comirnaty), АстраЗенека (COVISHIELD), Спутник-В Гам-КОВИД-Вак, Синофарм CoV (Verocell)-ийн вакцины нийт 8,317,750 хүн/тунг татан авч, нийт хүн амыг 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн вакцинжуулж байна. Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсээр коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины хамралт:

1. Зорилтот бүлэг 1 дүгээр тунгийн хамралт 96.1 хувь, 2 дугаар тунгийн хамралт 91.8 хувь, 3 дугаар тунгийн хамралт 47.9 хувь;
2. Нийт хүн амын 1 дүгээр тунгийн хамралт 69.7 хувь, 2 дугаар тун 66.5 хувь, өссөн дүнгээр 3 дугаар тунд 916,096 хүн хамрагдсан байна. 3 дугаар тун 28.2 хувьтай байв. КОВАКС хөтөлбөрөөс 2021 онд ДЭМБ-ын чанар, аюулгүй байдлыг хангасан 1,329,060 тун вакцин буюу нийт хүн амын 20.24 хувийг хамрах тооны вакцин, тарилгад хэрэглэх 0.3 мл хэмжээтэй өөрөө эвдрэх 900,000 ширхэг тариурыг аюулгүй хайрцгийн хамт тус тус хүлээн авсан байна.

1.1.2.7. Коронавируст халдвар (COVID-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээн авна.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/620 тушаалаар Коронавируст халдвар (COVID-19)-ын судалгааг зохион байгуулах, удирдах ажлын хэсэг, судалгааны тэргүүлэх 10 чиглэлийг боловсруулж, судалгааны ажлын санхүүжилтийг 2021 оны төсвийн тодотголоор 2.4 тэрбум төгрөгийг баталсан. Коронавируст халдварын чиглэлээр ёс зүйн зөвшөөрөл бүхий 13 судалгааны төсөл хэрэгжиж, үр дүнг нь хүлээн авсан. Үүнд:

1. SARS-CoV-2-ын нутгийн омгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, онош, тандалт, сэргийлэлтийн манай орны нөхцөлд тохирсон арга, хэрэгсэл зохион бүтээх;
2. Хүн амын янз бүрийн давхарга, эмзэг бүлгийнхний дотор anti-CoV, anti-SARS-CoV2 IgM, IgG тархалтыг судалж, онош, тандалт, сэргийлэлт ашиглах чиглэлийг тодорхойлох;
3. Манай оронд тохиолдож буй КОВИД-19 халдварын эмнэлзүйн илрэлийг судалж, онцлогийг тодорхойлон эмчлэн илааршуулах оновчтой аргыг боловсруулах;
4. Манай оронд тохиолдож буй улирлын коронавируст халдварын эпидемиологи, эмнэлзүйн онцлогийг судлан тогтоож, сэргийлэх, эмчлэх оновчтой арга замыг тогтоох, вакцин хэрэглэх нас, хүрээ, дэс дарааллыг тогтоож, тохиолдож болох бэрхшээлийг даван туулах аргуудыг тооцоолох;
5. Манай орны нөхцөлд тохирсон, ДЭМБ-ын шаардлагыг хангасан оношлуур, эм,

биобэлдмэл, бусад тоног төхөөрөмж, хэрэглүүр зохион бүтээж үйлдвэрлэн хангах зэрэг судалгааны нийт 40 ажлын үр дүнгийн эмхэтгэл боловсруулж гаргасан.

ХӨСҮТ-д SARS-CoV-2 вирусийн хэв шинж, генийн дарааллыг тогтоох NGS шинжилгээний лаборатори байгуулж, SARS CoV-2 вирусийн генийн дарааллыг тогтоох тандалтыг ДЭМБ-ын стратеги зөвлөмжид тулгуурлан хийж эхлээд байна.

1.1.2.8. Олон улсын байгууллагатай хамтарсан коронавируст халдвар (КОВИД-19) судалгааны ажлуудыг эхлүүлэх, үр дүнг хүлээн авна.

Биелэлт: Монгол Улсад бүртгэгдсэн шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн судалгааг 2021-2022 онд хэрэгжүүлж, судалгааны ажлын эцсийн үр дүнг 2022 оны 11 дүгээр сард хүлээн авч, хэвлүүлсэн. Мөн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагаа, туршлага, сургамж, нийтлэлийг багтаасан тайлбар бүхий фото зургийн цомог болон хоёр боть ном, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг тус бүр 1,500 ширхгийг хэвлүүлэх ажлын хүрээнд ДЭМБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Мөн дээрх бүтээлүүдийн эмхэтгэл болон хянан тохиолдуулах ажлыг гүйцэтгэж байна.

Баримтат киног Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр хийлгэхээр шийдвэрлэсэн ба киноны баг ажиллаж байна.

1.1.3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана:

1.1.3.1. Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.

Биелэлт: Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс дараах байдлаар бүрдүүлж ажилласан байна. Үүнд:

1. АХБ-ны санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан 50,166,400 төгрөгийн үнэ бүхий 3,200 ширхэг моноксифлоксацыныг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгов.
2. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавирусийн халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 1,791,815,400 төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг унтуулгын аппарат болон дагалдах хэрэгслийг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.
3. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 17,008,368 төгрөгийн үнэ бүхий суурилуулах 6 ширхэг эмнэлгийн зориулалт бүхий хөргөгч, 57,036,754 төгрөгийн үнэ бүхий эм болон эмнэлгийн хэрэгсэл, 1,799,583,040 төгрөгийн үнэ бүхий эх, нярайн тусламж үйлчилгээнд ашиглагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.
4. НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 85,950,000 төгрөгийн үнэ бүхий 6,000 ширхэг нэг удаагийн халатыг хүлээн авч нөөцөд авах тухай тушаал гаргасан байна.

1.1.3.2. Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод

тандалтын нэгж байгуулна.

Биелэлт: Дорноговь, Орхон 2 аймагт шинээр Зоонозын өвчин судлалын төв, Сэлэнгэ, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Ховд, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл зэрэг 10 аймгийн хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулахаар тооцоо судалгааг хийсэн. Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод коронавируст халдварын идэвхтэй тандалтын нэгж байгуулсан.

2024 онд Дархан-Уул, Орхон, Булган, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Төв, Говьсүмбэр зэрэг аймагт 33 орон тоо бүхий Зоонозын өвчин судлалын төв, 12 хилийн боомтод тандалтын нэгж байгуулах тухай танилцуулга, шаардагдах тооцоог дахин хийж, барилга байгууламжийн асуудлыг шийдвэрлэхээр нэг маягийн зураг төслийг боловсруулсан.

1.1.3.3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

Биелэлт: Коронавируст халдварын нөхцөл байдлын хэвлэлийн хурлыг (өдөр бүрийн 11:00 цаг) 219 удаа зохион байгуулж, 30 телевиз 50 сайтаар дамжуулсан. Мөн ЭМЯ-ны фейсбүүк хуудсаар шууд дамжуулахад давхардсан тоогоор 33,712,188 хүн хандалт хийж, 19,898 хүн мэдээллийг хуваалцсан байна. Коронавируст халдвараас сэргийлэх 31 төрлийн инфографик, 70 удаагийн мэргэжлийн эмчийн зөвлөмж, 26 видео, шторк, 28 төрлийн зөвлөмж (текст) бэлтгэн Эрүүл мэндийн яамны фейсбүүк хуудсанд байршуулан 22,944,731 иргэдэд мэдээлэл хүргэж, 201,056 гаруй хүн хуваалцсан байна.

1.1.3.4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулна.

Биелэлт: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ)-ийн эзэмшлийн газрын баруун хойд хэсэгт 0.58 га. талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сонсголонгийн замын дагуу газарт онцгой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын байрыг барьж ашиглалтад оруулж, агуулахын тоног төхөөрөмжөөр хангав.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын барилга барихад 6.7 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 1.6 тэрбум төгрөг, нийт 8.3 тэрбум төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна.

Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад шаардлагатай эрүүл мэндийн салбарын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, оношлуурын жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 дүгээр тушаалаар батлуулсан.

1.1.3.5. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна.

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн Х1Х.1.53-Д Өвчтөний хяналт, зохицуулалтын төвийн барилга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)-ын ажил 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр батлагдаж, худалдан авах ажиллагааг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр зарласан бол оролцогч байгууллагууд шаардлага хангаагүй байна. Барилгыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хашаанд барихаар төлөвлөж байна.

"Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ

/Төв, Сэргэлэн сум/ төсөл, арга хэмжээ 13,340.7 сая төгрөгөөр баригдахаар 2024 оны төсөвт батлагдсан.

1.1.3.6. Шинэ коронавирусийн халдварыг тодорхойлох оношлуурыг дотооддоо бүтээн, туршиж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

Биелэлт: Шинэ коронавирусийн SARS-COV-2 вирусийн халдварыг шүлснээс илрүүлэх АШУҮИС-ийн эрдэмтдийн бүтээсэн ПГУ/PCR оношлуурыг 2021 оны 03 дугаар сараас оношилгоонд нэвтрүүлсэн. Коронавируст халдварыг шүлсэнд тодорхойлох 1.3 тэрбум төгрөгийн 200 мянган ширхэг түргэвчилсэн оношлуурыг худалдан авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан ашиглаж байна.

“Чорос онош” ХХК-ийн гаргасан коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх бхПГУ-ын тодорхойлох оношлуур, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн гаргасан шүлсэнд коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх бхПГУ-ын тодорхойлох оношлуурын цомог, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйлдвэрлэсэн дархлаа дэмжих хүний хэвийн иммуноглобулиныг “Үндэсний багц” үүсгэн Ерөнхий гэрээнд оруулах чиглэлийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 2022 онд 5/1108 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус газар дээрх 3 бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээнд оруулах асуудлыг дэмжиж, хэрэгцээ, техникийн тодорхойлолт, босго үнийн саналыг тооцоолон Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2022 оны 04 дүгээр сарын 02/01/703 дугаар албан бичгээр хүсэлтийг уламжилсан. 2022 оны 09 дүгээр сараас шүлсний оношлуурыг хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна (АШУҮИС).

Коронавирусийн халдварыг тодорхойлох оношлуур бүтээсэн 3 баг тус оношлуурыг хязгаарлагдмал хүрээнд хэрэглээнд нэвтрүүлсэн.

Манай улсад КОВИД-19 халдварын тохиолдол эрс багасаж, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэлийн хугацаа дуусаж, эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх бхПГУ-ын тодорхойлох оношлуурын эрэлт хэрэгцээ эрс буурсан нь үндэсний оношлуурын хэрэгцээг багасгасан. Оношлуур бүтээгч аж ахуйн нэгжүүд ТХААГ-ын “Ерөнхий гэрээ байгуулах журам”-д тусгасан шаардлагыг хангасан бол Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (цахим дэлгүүр)-д бүтээгдэхүүнээ байршуулах боломжтой болно.

1.1.3.7. Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн Молекул биологийн лабораторийн чадавхыг бэхжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын хэмжээнд 16 аймаг, 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 5 аймаг дахь БОЭТ-д нийт 33 молекул биологийн лабораторийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын дэмжлэгээр 2021-2023 онд үе шаттай байгуулж, үйл ажиллагаа жигдрэн ажиллаж байна.

Мөн Дархан-Уул, Дорноговь, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн лабораторид РСК аппарат, нуклейн хүчил ялгагч аппаратыг шинээр нэмж суурилуулан, хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.

2022 онд Люксембургийн Их Гүнт Улсын санхүүжилтээр “Цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах” төслийг хэрэгжүүлж, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-11, Өргөө, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт молекул биологийн шинжилгээ хийх иж бүрэн лабораторийг байгуулсан. Төслийн хүрээнд 109,726.76 ам.долларын үнэ бүхий 22 нэр төрлийн молекул биологийн оношилгооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдийг лабораторийн стандарт тавилгын хамт хүлээлгэн өгсөн байна.

1.1.4.“Ковид-19” халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 оныг дуустал үргэлжлүүлэн чөлөөлнө.

1.1.4.1.Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтыг шинэчлэн боловсруулна.

Биелэлт: Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 163/А/603 дугаар хамтарсан тушаалаар цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалтыг шинэчлэн баталсан. Засгийн газрын 2021 оны 274 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар (КОВИД-2019)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, “Ремдесивир” тарилгын уусмалын БТКУС код “3004.90.10”-ыг нэмэлтээр оруулсан. Мөн Засгийн газрын 2021 оны 379 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар (КОВИД-2019)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтад Тоцилизумаб, Касиривимаб, Молнупиравир, Паксловид (PF-07321332) зэрэг эмийг нэмсэн.

1.1.4.2.“Ковид-19” халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2021 оныг дуустал үргэлжлүүлэн чөлөөлнө.

Биелэлт: Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолын 13-т Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор 2021 оныг дуустал хугацаанд импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх шийдвэрийг гаргаж тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

УИХ-аас 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар “Ковид-19” халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2021 оныг дуустал үргэлжлүүлэн чөлөөлсөн.

1.1.5.Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Хөгжлийн банкны үйл ажиллагааг шинэчлэн өөрчилж, экспортын орлогыг нэмэгдүүлэх, эксим банкны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр болов.

Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах тухай хууль 2023 оны 6 дугаар сард батлагдсан. Худалдааны тухай хуулийн төслийн урьдчилсан тандан судалгааны ажлыг эхлүүлсэн байна.

Экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоол батлав, тогтоолын хүрээнд нүүрсний экспортыг бодитоор нэмэгдүүлэх, экспортын дэд бүтцийг цахим болгох чиглэлээр төрийн өмчит компаниудад үүрэг даалгавар өгсөн. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 385 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 6 сарын хугацаатай онцгой дэглэм тогтоогоод байна. Онцгой дэглэм тогтоосноос хойш нүүрс экспортыг 2 дахин, нүүрс тээврийг 4 дахин нэмэгдүүлэн борлуулалтын орлогыг 500 орчим сая ам.доллараар өсгөж “Эрдэнэс Тавантолгой” ХК байгуулагдсанаас хойш хамгийн өндөр түвшинд буюу 1.1 тэрбум ам.долларт хүргэлээ.

1.1.6.Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 38 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайтын орд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, ногоон бүс болгох эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Шуурхай бүлгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдаар ахлуулан байгуулсан.

Улмаар Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй “Ногоон гарц”-ын журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны Улсын комисст хүлээлгэн өгч, улмаар 2021.10.03-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Тавантолгой” ХК-ууд бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээг байгуулсан.

Терминалын үйл ажиллагааг 2021.11.08-ны өдрөөс эхлүүлэн өдөрт 100 тээврийн хэрэгслээр экспорт хийж эхэлсэн боловч 2021.12.15-ны өдрөөс зогссон байна.

Шивээхүрэн боомтод 11.6 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Монголын алт (МАК)” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Жавхлант орд” ХХК, “Цагаан өвөлжөө” ХХК “Сан транс” ХХК-иуд гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 орчим хувьтай, бараа бүтээгдэхүүнийг татан авч суурилуулах ажил хүлээгдэж байна.

Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Ногоон гарц” түр журам бүрэн хэрэгжсэн. 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 67,259.5 мян.тн нүүрс, 1,482.6 мян.тн зэсийн баяжмал, 5,437.1 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 147.6 мян.тн цайрын баяжмал, 1047.6 мян.тн хайлуур жоншны баяжмал экспортолсон. Алт олборлолт 17.0 тонн, нүүрсний экспортын гүйцэтгэл 134.5%, алт олборлолт 82.0%, зэсийн баяжмал 102.0%, төмрийн хүдэр, баяжмал 64.6%, цайрын баяжмал 147.6%, хайлуур жоншны баяжмал 261.9%-ийн гүйцэтгэлтэй байна.

1.1.7.Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, туслалцааг нэмэгдүүлэх чиглэлээр хөгжлийн түнш улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана.

1.1.7.1.Шилжин ирэгчдийг КОВИД-19-ийн хариу арга хэмжээнд хамруулахад чиглэсэн судалгаа хийх, нутагтаа шилжиж ирсэн хүмүүсийн нөхцөл байдлыг үнэлэх, нийгмийн

ажилтнуудад сургалт явуулах, төрийн бус байгууллагуудын үйлчилгээг дэмжих, мэдээллийн кампанит ажил явуулна.

Биелэлт: Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед стандартын мэдээллээр дэмжлэг үзүүлэх зорилгоор Стандарт, хэмжил зүйн газраас дараах багц стандартуудыг бүрэн эхээр нь үнэ төлбөргүйгээр www.estandard.gov.mn цахим хуудастаа нээлттэй мэдээлсэн.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалахад стандартын мэдээллээр дэмжлэг үзүүлэх зорилгоор Стандарт, хэмжил зүйн газраас 18 стандартуудыг баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

1.1.7.2.Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктэй тохирч, идэвхтэй хамтран ажиллана. /200.0 сая ам.доллар/

Биелэлт: АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл”-ийн хүрээнд улсын төсвөөс олгосон хүүхдийн мөнгөний нөхөн санхүүжилтэд 2020 онд 60.7 тэрбум, 2021 онд 119.5 тэрбум, 2022 онд 82.6 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

1.1.8.Гадаад улсад байгаа иргэнээ татан авах ажлыг эрчимжүүлнэ.

1.1.8.1.КОВИД-19-ийн улмаас хүнд нөхцөлд байгаа гадаадад гацсан Монголчуудыг татан авах ажиллагаанд олон улсын байгууллагатай хамтран ажиллана.

Биелэлт: Эх орондоо ирэх хүсэлтэй иргэдээ гадаадаас бүрэн татан авч, 2021 оны 6 дугаар сарын 1-ээс эхлэн агаарын хилээ нээж, тусгай үүргийн нислэгийг ердийн нислэгт шилжүүлсэн. Цар тахал эхэлсэн хугацаанаас хойш буюу 2020.02.01-2021.05.31-ний хооронд агаарын замаар 183 нислэг үйлдэж 29,543, Монгол-Хятадын боомтоор 4,301, Монгол-Оросын боомтоор 2,516, нийт 36,360 Монгол иргэдээ эх оронд нь ирүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дэлхийн 91 улсаас агаарын замаар 106 удаагийн нислэг үйлдэж 20,582, Монгол Улс-БНХАУ-ын боомтоор 4,210, Монгол Улс-ОХУ-ын боомтоор 2,392, нийт 27,184 Монгол Улсын иргэнээ зохион байгуулалттайгаар татан авсан байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар хилийн чанадад байгаа “Монгол Улсын иргэдэд туслах сан”-аас 56 өргөдөл, хүсэлтэд 188.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. Тус санд УОК-оос төвлөрүүлсэн 300 сая төгрөгөөс энэ онд 280 иргэнд тусгаарлах байрны зардал болон санхүүгийн бусад дэмжлэг үзүүлэхэд нийт 120.2 сая төгрөгийн тусламжийг (нислэгийн тийз, тусгаарлалтын зардал, бичиг баримтын төлбөр зэрэг) үзүүлсэн байна.

1.1.9.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээг авна.

1.1.9.1.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээг авна.

Биелэлт: Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах чиглэлийн дагуу 2021 онд ЭМДЕГ-ын арилжааны банканд байршуулсан 333.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлсэн. Тухайлбал, Худалдаа хөгжлийн банкнаас 120.0 тэрбум төгрөг, Хас банкнаас 20.0 тэрбум төгрөг, Хаан банкнаас 92.0 тэрбум төгрөг, Төрийн банкнаас 27.0 тэрбум төгрөг, Капитал банкнаас 10.0 тэрбум төгрөг, Голомт банкнаас 40.0 тэрбум төгрөг, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас 24.8 тэрбум төгрөгийг Прокурорын байгууллагуудын барьцаа хөрөнгийн 13 дансны 726.4 сая төгрөгийг, тус тус төвлөрүүлсэн.

Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны А122/А-172 дугаар тушаалаар “Засгийн газрын болон төсвийн байгууллагын банканд нээх, хаах, тайлагнах журам” батлуулсан.

Засгийн газрын болон төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийг эрсдэлд оруулахгүй байх үүднээс тус журамд Монголбанкнаас тогтоосон банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын зохистой харьцаа, заавал байлгах нөөцийн шаардлагын үзүүлэлтийг сүүлийн 6 сар тасралтгүй хангасан байх, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг сүүлийн 6 сар тасралтгүй хангасан байх, засаглалын үнэлгээгээр 65 ба түүнээс дээш онооны үнэлгээтэй байх, банканд байршиж буй Монгол Улсын Засгийн газрын болон төсвийн байгууллагын банк дах өглөг, харилцах, хадгаламжийн дансны нийт мөнгөн хөрөнгө нь тухайн улирлын банкны нийт активын 30 хувиас хэтрэхгүй байх зарчмыг баримтална гэсэн зохицуулалтуудыг шинээр оруулж өгсөн.

1.1.10. Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлнэ.

1.1.10.1. Засгийн газрын бондын хөрөнгөнөөс ЖДҮХС-д дамжуулан зээлдүүлсэн зээл, МУХС-гийн хөрөнгөөр бүрдүүлсэн улаан буудайн нөөцтэй холбоотойгоор улсын төсөвт төлөх өр төлбөрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас төлж барагдуулна.

Биелэлт: Засгийн газрын бондын хөрөнгөнөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 14.5 тэрбум төгрөгийг 2022 онд бүрэн төлж барагдуулсан бөгөөд тооцоо нийлж баталгаажуулан Сангийн яамтай гэрээг дүгнэн хэрэгжилтийг бүрэн хангасан.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бүрдүүлсэн улаан буудайн нөөцтэй холбоотойгоор улсын төсөвт төлөх өр төлбөрийн зээлийн эргэн төлөлтөд 2023 онд 3.6 тэрбум төгрөгийг төлж үндсэн төлбөр бүрэн барагдаж дууссан. Үндсэн төлбөр барагдуулж дууссантай холбогдуулан тус зээлийг төлөхөд үүссэн алданги 4.3 тэрбум төгрөгийг чөлөөлөх Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 269 дүгээр тогтоол гарснаар өр төлбөр бүрэн барагдаж дууссан бөгөөд Сангийн яамтай тооцоо нийлсэн.

1.1.10.2. Сангийн яамны эзэмшиж байгаа давуу эрхийн ипотекийн зээлээр баталгаажсан бондыг Монголбанк болон бусад санхүүгийн байгууллагад хямдруулан эсвэл нэрлэсэн үнээр худалдаж, Засгийн газрын санхүүгийн эх үүсвэр, нөөцийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө буюу авлагаас Сангийн яамны хяналтад байдаг хөрөнгө болох төсвийн эх үүсвэрээр ОССК болон Төрийн банкаар дамжуулан олгогдсон орон сууцны зээл, ипотекийн

зээлээр баталгаажсан бонд зэрэг урт хугацаатай зээлийн хөрөнгүүдээс тодорхой хувийг нь буюу бүхлээр нь хөрөнгө байршиж байгаа банкнуудад хямдруулан зарах замаар эх үүсвэр төвлөрүүлэх боломжийг судалсан.

Энэ ажлын хүрээнд 2021 оны эхний үлдэгдлийн тооцоонд тулгуурлан, хямдралын хувь хэмжээ, саналыг тооцооллыг бэлтгэн удирдлагад танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын 2021 оны батлагдсан төсөвт тусгагдсан ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс олгосон эх үүсвэрийн зээл, ипотекийн зээлээр баталгаажсан бондыг Монголбанк, Төрийн банканд худалдах хүсэлтийг "Актив хөрөнгө худалдах тухай" Сангийн сайдын 2021 оны 8-2/660, 8-2/559 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Засгийн газраас орон сууцны хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлсэн эх үүсвэрийн Төрийн банк дахь чөлөөт үлдэгдлийг буцаан төвлөрүүлэхээр ажилласны үр дүнд Сангийн яамны Төрийн банкнаас авах нийт зээлийн авлага 54.3 тэрбум төгрөг, Төрийн банкны зээлдэгчдээс авах авлага 39.3 тэрбум төгрөгийн зөрүү болох 15.0 тэрбум төгрөгийн чөлөөт үлдэгдлийг Төрийн банкаар төлүүлэхээр тохиролцож, бүрэн төвлөрүүлсэн болно.

1.1.10.3. Улсын төсөв, Засгийн газрын дотоод үнэт цаасны эх үүсвэр, гадаад хөнгөлөлттэй зээлээс Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өр авлагыг барагдуулна.

Биелэлт: Төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэй Засгийн газрын тусгай сан, компани, банк, санхүүгийн байгууллагуудад олгогдсон Засгийн газрын бүх төрлийн авлагыг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 2021 онд Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 2.8 тэрбум, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаа 12 тэрбум төгрөгийг төлүүлж, хугацаа хэтэрсэн авлагын дүнг буурууллаа.

1.1.10.4. Анод, Зоос банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлнэ.

Биелэлт: Анод банкны эрх хүлээн авагчийн 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 715 дугаар албан бичгээр тус банк дахь эрх хүлээн авах үйл ажиллагаа дуусгавар болж Анод банк ХК-аас авлагатай этгээдийн өр төлбөрийг бүрэн барагдуулахад банкны актив хөрөнгө хүрэлцэхгүй байгаа тул нэхэмжлэлийн шаардлагыг хангах боломжгүй тухай мэдэгдсэн. Мөн эрх хүлээн авагч татан буугдсан тул Анод ХК-аас авах авлагыг нэхэмжлэх боломжгүй болсон.

Монголбанкны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, энэхүү асуудлын талаар санал солилцсон. Монголбанкнаас тавьсан саналын дагуу Анод болон Зоос банкнуудаас авах Засгийн газрын авлагыг шүүхээр шийдвэрлүүлж, авлагыг хаалгах талаар ажиллаж байна.

1.1.11. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагчдад сургалтын амжилттай нь уялдуулан 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.

1.1.11.1. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагчдад сурлагын амжилттай нь уялдуулан Засгийн газрын тэтгэлэг олгоно.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн "Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай" 13 дугаар тогтоолыг баталж, дараах өөрчлөлтийг нэмсэн. Үүнд: Засгийн газрын 2014 оны "Журам, чиглэл шинэчлэн батлах тухай" 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам"-ын "4.1.9-д "Төрийн өмчийн дээд

боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь; суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд 100 хувь” хөнгөлнө гэж шийдвэрлэсэн. Журамд заасан шаардлага хангасан 843 оюутанд сурлагын амжилттай нь уялдуулан 625.1 сая төгрөгийн тэтгэлэг олгосон бол 2021 онд 1417 оюутанд 1.8 тэрбум төгрөг, 2022 онд 2480 оюутанд 3.1 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

1.1.12.Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.

1.1.12.1.Сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, цахим хичээлийн сан бүрдүүлэн сонголттой хувилбарыг бий болгоно.

Биелэлт: Үндэсний хэмжээнд цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх, түүгээр дамжуулан бүх нийтэд зориулсан цахим контент боловсруулах, сургалтад ашиглах зорилгоор MEDLE.mn платформыг 2021 оны 6 дугаар сараас эхлэн хөгжүүлж байна. Энэ платформд 1-12 дугаар ангийн 419 хичээл байршиж, 1.0 сая иргэн хандсан статистик гарсан байна. Танхимын сургалт зайн, цахим хэлбэрт шилжсэн 2 жилийн хугацаанд боловсрол, сургалтын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим баримтлан 5,756 теле хичээл, 104 интерактив хичээл, 2,775 цахим хичээл, 50 цахим контент, радио болон аудио 30 хичээлийг тус тус бэлтгэн тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор дохионы хэл, тува, казах хэлний орчуулгатайгаар телевиз, радиогоор дамжуулан хүргэх ажлыг телевизүүдийн холбоо, хувийн хэвшил болон олон улсын байгууллага (Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан)-тай хамтран зохион байгууллаа. Цар тахлын үед төгсөх ангийн сурагчдад зориулсан онлайн сургалтын талбарыг үүсгэн цахим хичээлийг улсын хэмжээнд X-X11 ангид хичээл зааж байгаа шилдэг 602 багш удирдаж, хот, хөдөөгийн сургуулийн ахлах ангийн 30.1 мянган сурагч онлайн хичээлд хамрагдсан байна. Цахим контент бэлтгэх, цахим хичээлийн санг бүрдүүлэх, баяжуулах, сургалтад мэдээллийн технологийг бүрэн ашиглах, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын бэлэн байдлыг хангах зорилгоор улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын 45 сургуульд цахим контент бүтээх бичил студи байгуулсан.

2022 онд Medle.mn цахим санд 2590 контентыг нэмж байршуулсан бөгөөд 5196 контент боловсруулалт, хяналтын шатанд байна. Тус платформд 147 цахим сурах бичиг, 4140 теле хичээл, 6-12 дугаар ангийн математик, физик, хими, биологийн хичээлд ашиглах 805 виртуал лаборатори, эрүүл мэнд, замын хөдөлгөөний чиглэлээр 152 контент, суралцагчдад зориулсан цахим хичээл, контент боловсруулах арга зүйн зөвлөмж, насан туршийн боловсрол, цахим ур чадварын 413 контент, хоцрогдол нөхөх арга зүйн зөвлөмжийг бүх ангийн бүх хичээлээр байршуулан багш нар хичээл сургалтын үйл ажиллагаандаа татаж аван ашиглаж байна.

1.1.13.Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.1.13.1.Боловсролын болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, дүрэм журмыг шинэчлэн боловсруулна.

Биелэлт: Боловсролын ерөнхий хуульд боловсрол эзэмших сургалт нь танхимын, танхимын бус, холимог хэлбэртэй байх, танхимын бус сургалтад зайны болон цахим,

холимог сургалт нь танхимын болон танхимын бус сургалтыг хослуулсан байх, боловсролын хөтөлбөр, агуулгыг цахим хэлбэрт шилжүүлж хөгжүүлэх зэрэг боловсролын цахим шилжилттэй холбоотой заалтуудыг тусгаж 2023 оны 7 сараас мөрдөж эхэлсэн байна.

Тус хуульд багш нь “сургалтад харилцаа холбоо, мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад платформыг ашиглах” үүрэг хүлээхээр эрх зүйн зохицуулалт орсон. Боловсролын ерөнхий хуульд боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан, түүний мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой шинэ бүлгийг тусган батлуулсан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/84 дүгээр тушаалаар Монгол Улсын боловсролын салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсэг КОВИД-19 цар тахлын хүрээнд боловсролын салбарын суурь үйлчилгээг дэмжих, НҮБ-ын нэгдсэн төслийн хүрээнд ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр Боловсролын салбар дахь Мэдээлэл, харилцаа холбооны технологийн бодлогын тойм шинжилгээг хийх ажлыг амжилттай зохион байгуулж, тайланг эцсийн байдлаар боловсруулж, хэвлүүлсэн.

Ажлын хэсэг дээрх тойм шинжилгээний зөвлөмжид үндэслэн Монгол Улсын боловсролын салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны технологийн цахим шилжилтийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний төслийг 6 зорилт, 7 бүлэгтэй боловсруулж БШУС-ын 2022 оны А/488 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1.14.Боловсролд зориулсан зардлыг урьдчилан нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг зарцуулах, боловсролд дутагдаж байгаа зардлыг шийдвэрлэнэ.

1.1.14.1.Боловсролд зориулсан зардлыг нэн тэргүүнд тавьж нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг дайчлах замаар боловсролд дутагдаж буй зардлыг шийдвэрлэнэ.

Биелэлт: Орон нутгийн төсвөөс боловсролын салбарын үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 2022 оны 1-4 дүгээр сард 55.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. 2022 онд Төрийн үйлчилгээний албан хаагчдын дутагдалтай цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт сургуульд 3743.6 сая төгрөг, цэцэрлэгт 962.8 сая төгрөг нэмэлтээр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. “Цэцэрлэгийн зориулалтаар ашиглах болон ерөнхий боловсролын сургуулийн гурван ээлжээр хичээллэдэг сургуулийг хоёр ээлжид шилжүүлэх” ажлын хүрээнд Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 152 байрыг түрээсэлж ашиглахаар шийдвэрлэж, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн засаг дарга нь орон нутгийн төсвийн хөрөнгөнөөс сургууль цэцэрлэгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, зөөлөн эдлэл болон бусад зардалд нийт 1386.0 сая төгрөг шийдвэрлэлээ.

Одоогийн байдлаар Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Дархан-Уул, Хөвсгөл, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн төсвийн хөрөнгөөр боловсролын байгууллагуудад компьютер тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, байр ашиглалтын түрээс, урсгал засварын 8965.2 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн байна.

1.1.15.Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно.

1.1.15.1. Эрүүл мэндийн судалгаанд үндэслэн багш, суралцагчийн хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн зохицуулалт хийнэ.

Биелэлт: 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 1а/3371 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтран баталсан “Боловсролын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах” удирдамжийг баталсан. Тус удирдамжийн дагуу боловсролын байгууллагын багш, ажилтныг багц үзлэгт хамруулах ажлыг 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 9 дүгээр сарын 31-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 34,073 багш, цэцэрлэгийн 28,070 багш, ажилтан 100 хувь хамрагдсан байна.

Хичээлийн жил эхлэхтэй уялдуулан багш нарыг вакцинжуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид ковидын эсрэг дархлаажуулалтын 1 дүгээр тунд 95.1 хувь, 2 дугаар тунд 94.7 хувь, 3 дугаар тунд 58.9 хувьтай хамрагдаад байна.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Эрүүл мэнд.

2.1.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

2.1.1.1. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/195 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс тус арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, Сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар 5 зорилтын хүрээнд 77 заалт бүхий “Эрүүл идэвхтэй амьдрал” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. төлөвлөгөөний хэрэгжилт 2022 онд 38.4, 2023 онд 42.1 хувьтай байна.

“Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7005:2023 стандарт батлагдаж, хэрэгжиж эхэлсэн. “Эерэг хандлага-Эрүүл оюутан” уриатай оюутны эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд цуврал 21 төрлийн инфографик шинээр боловсруулан олон нийтийн сүлжээнд 2-3 удаагийн давтамжтайгаар байршуулан олон нийтэд түгээсэн байна.

2.1.1.2. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар 8 зорилт, 166 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлуулсан.

Улсын хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар 29 төрлийн 37,648 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 108.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 278,183 тохиолдлоор буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 817.3-аар буурсан байна. Харин салхинцэцэг, гар, хөл, амны өвчин, улаан эсэргэнэ өмнөх оноос 2.9-өөс 22.5 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

2023-2024 онд улирлын томуугийн эсрэг вакцинаар зорилтот бүлгийн хүн амыг дархлаажуулахад шаардлагатай 300 000 хүн тун 4 цэнт вакциныг НҮБ-ын Хүүхдийн санд захиалан хүлээн авч, улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулсан. Вакцины хамралтын мэдээг 30 (21 аймаг, 9 дүүрэг) байгууллагаас ирүүлсэн ба хамралтын хувь 91.7 байгаагаас орон нутагт 97.5, нийслэлд 86.1 байна. Энэ нь зорилтот түвшний 88.6 хувьд хүрсэн байна.

2.1.1.3. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээ.

Биелэлт: “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 35.8 хувьтай байна.

2.1.1.4. “Хавдрын эсрэг” арга хэмжээ.

Биелэлт: “Хавдрын эсрэг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 6 зорилт, 61 үйл ажиллагааг шалгуур үзүүлэлтийн хамт Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар, “Хүүхдийн хорт хавдартай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээ, хяналтыг сайжруулах 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг А/201 дугаар тушаалаар тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Улсын хэмжээнд эрт илрүүлэг үзлэгт 1,274,408 хүн хамрагдсан нь хүн амын 37.8 хувийг эзэлж байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 658,763 буюу 51.7 хувь нь 0-17 насны хүүхэд, 615,645 буюу 48.3 хувь нь 18-аас дээш насныхан байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18-60 насны хүн амаас 548,935 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс хортой болон хоргүй хавдрын 5,583 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 18-30 насанд 68 тохиолдол буюу 1.2 хувь, 31-45 насанд 2,312 тохиолдол буюу 41.4 хувь, 46-60 насанд 3,203 тохиолдол буюу 57.4 хувийг эзэлж байна. 31-45 насныхны дунд элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн 1.5 хувь, хөхний өмөн 1.4 хувь, ходоодны өмөн 1.4 хувийг эзэлж байна. 46-60 насанд ходоодны өмөн 3.1 хувь, элэг ба элгэн дэх цэсний өмөн 3.0 хувь, хөхний өмөн 1.2 хувийг эзэлж байна. 61-ээс дээш насанд хортой болон хоргүй хавдрын 1,859 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн 8.6 хувь, ходоодны өмөн 6.6 хувь, улаан хоолойн өмөн 3.2 хувийг тус тус эзэлж байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 243,253 (27.3%) хүн хамрагдсанаас 68 тохиолдолд хорт хавдар оношлогдсон бол хөхний хорт хавдрын илрүүлэгд улсын хэмжээнд нийт 366,918 эмэгтэй (35.9%) хамрагдаж, үүнээс 1,341 эмэгтэй эмнэлзүйн шинжилгээгээр эерэг гарч, 10 хүнд хөхний өмөн тус тус оношлогдсон байна.

2.1.1.5. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар тушаалаар 2022-2024 онд

“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 зорилт 34 үйл ажиллагаатай баталсан бөгөөд хэрэгжилт 42.4 хувьтай байна. Улсын хэмжээнд вируст гепатитын өвчлөл 10000 хүн амд 0.7 хувь байна.

Эрүүл мэндийн сайдын 2023 онд А/250 дугаар тушаалаар өнчин эмийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, элэгний Д вирусийн эсрэг Булевиртид (Хепклюдекс) эмийг Эрүүл мэндийн сайдын “Өнчин эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тушаалд нэмж батлуулсан байна.

Гепатитын Дельта вирусийн оношилгоо, эмчилгээ, хяналтад тулгамдсан асуудлыг судалж шийдвэрлэх, гарцыг тодорхойлох ажлын хэсгийг байгуулан, үр нөлөөний үнэлгээг ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ, УНТЭ, УХТЭ, ХСҮТ, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Дорнод БОЭТ-д 4-6 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийсэн байна.

2.1.1.6. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан бөгөөд төлөвлөгөө нь 4 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 онд 50.3 хувь, 2023 онд 39.2 хувьтай тус тус хэрэгжсэн нь зорилтот түвшний 78.4 хувьд хүрсэн байна.

“Суурьшлын бүсийн харшил төрүүлэгч тоост ургамлыг зүлэгт талбай хэмжээнд арчлан ногоон байгууламжид ашиглах арга, сул шороон хөрсийг зүлэгжүүлэх ба нөхөн зүлэгжүүлэх технологийн туршилт, ургамлын тоосны харшил өвчний шалтгаан тархалт, оношилгоо эмчилгээ, харшлаас сэргийлэх аргачилсан заавар зөвлөмж” төслийг Эрүүл мэндийг дэмжих сангаас 24.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн байна. Энэхүү төслийн хүрээнд Алтай, баруун, говийн бүсийн аймгуудын дэд ажлын хэсэг, тус аймгуудын арьс, харшлын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг 2023 оны 09-10 дугаар сард Баянхонгор, Өмнөговь аймагт зохион байгуулж, Өвөрхангай (Хайрхандулаан, Нарийнтээл сум), Баянхонгор (Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал сум), Говь-Алтай аймаг, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр зэрэг 7 аймгийн 46 байгууллагын 134 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.

2.1.1.7. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ.

Биелэлт: “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр 4 зорилт, 46 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулан ажиллаж байгаа бөгөөд, төлөвлөгөөний хэрэгжилт 43.0 хувьтай байна. Одоогоор улсын хэмжээнд улсын 22 эрүүл мэндийн байгууллагад урологи, андрологийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаагаас нийслэлд 11, аймагт 11 тус тус ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/449 дүгээр тушаалаар “Эрэгтэйчүүдийн кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам”-ыг баталж, тус кабинетыг өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн тусламж, үйлчилгээний бүтцийн нэгж байхаар заасан байна.

2.1.2. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ.

2.1.2.1. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашгийн судалгаа хийнэ.

Биелэлт: “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашгийн судалгаа хийх ажлын хүрээд ДЭМБ-тай 3 удаа уулзалт зохион байгуулсан. Мөн Булган, Орхон аймаг,

Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт вируст гепатитын эмнэлгийн тусламж, үйлчилгээний үр нөлөөллийн судалгаа, үнэлгээг зохион байгуулсан. Судалгааны хүрээнд цуглуулсан тоо баримтад дүн шинжилгээ хийгдэж байна. Одоогоор “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашгийн судалгаа хийгээгүй байна.

2.1.2.2.Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан гепатитын В, С, Д вирусийн халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.

2.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна:

2.1.3.1. Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна.

Биелэлт: Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь Улаанбаатар хот Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд 60.2*30 м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай, шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байхаар төлөвлөгдсөн. Тус төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдсан бөгөөд 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 3.3.2.2. “Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилга барих” гэж 60,000.00 сая төгрөг тусгагдсан. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв төсөл арга хэмжээнд 2024-2026 онд 140.0 тэрбум төгрөг, үүнээс 2024 онд 42.0 тэрбум төгрөг төсөвлөж, УИХ-д өргөн барьж, хэлэлцэгдэн 2024 оны төсөв батлагдсан.

2.1.3.2. Зүрх судасны төв байгуулна.

Биелэлт: Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Зүрх судасны төв байгуулах” төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн хүрээнд хийж магадлалаар баталгаажуулсан байна. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Монгол Улсын 2024 оны төсөвт Зүрх, судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээ төсөл арга хэмжээнд 2,252.1 сая төгрөг батлагдсан.

2.1.3.3. Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна.

Биелэлт: Сүрьеэгийн эмнэлгийн барилга нь нийт 5 блок бүхий 120 ортой цогцолбор барилга, байгууламж бөгөөд Баянзүрх дүүрэг, Чулуутын амны 1.5 га газарт төлөвлөгдсөн. 2019 онд зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл батлагдсан ба Барилгын хөгжлийн төвийн Магадлалын ерөнхий дүгнэлтээр 19 тэрбум төгрөгөөр батлагдсан. 2019 оны Монгол Улсын Төсвийн тухай хуульд Эрүүл мэндийн сайдын багцад Сүрьеэгийн эмнэлгийн барилга /Улаанбаатар/ төсөл, арга хэмжээ нь төсөвт өртөг 10 тэрбум төгрөгөөр батлагдан худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас гаргасан зөвлөмжид оролцогч компаниуд шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаснаар барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдаж чадаагүй байна. Нийслэлийн анхан шатны шүүхээс гомдлыг шалгаж шүүхийн шийдвэрийн дагуу дахин үнэлгээ хийгдэж байна.

2.1.3.4. Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.

Биелэлт: Барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн. 2022 онд Үндэсний аудитын газраас дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээнүүдэд чиглэсэн аудит хийх төлөвлөгөөнд уг барилгын ажлыг тусгуулсан болно. Геронтологийн төвийн барилгын ажлын явц 46.0 хувьтай байна.

2.1.3.5. Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулна.

Биелэлт: ГССҮТ-ийн харьяа Түлэнхийн төвийн барилга бүрэн ашиглалтад орж, 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр нээлтээ хийж, ашиглалтад орсон. “Түлэнхийн төвийн тоног төхөөрөмж” нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зарласан.

2.1.3.6. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна.

Биелэлт: Халдварт өвчин судлалын үндэсний төвийн салбар II барих зураг төслийн ажил хийгдэж дууссан. Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн гэрчилгээг олгосон. Төсөвт өртөг урьдчилсан байдлаар 313 тэрбум төгрөгөөр батлагдсан ч Барилгын хөгжлийн төвийн магадлалаар хянагдсаны дараа төсөвт өртөг 277.0 тэрбум төгрөг болж баталгаажсан байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн боловч УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам сүлжээ төсөл арга хэмжээнд 13,340.7 сая төгрөг УИХ-д өргөн баригдаж, батлагдсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2.1.3.7. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна.

Биелэлт: Хавдар судлалын үндэсний төвийн салбар II барилгын зураг төсвийн ажил 80 хувьтай үргэлжилж байна. Төвийн салбар Баянзүрх дүүргийн Чулуутын аманд 10 га газарт баригдахаар шийдвэрлэгдсэн.

2.1.3.8. Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина.

Биелэлт: Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлгийн барилгын зураг төслийн ажил хийгдэж байна. Уг эмнэлгийн барилгыг барихаар олгогдсон 7,000 м² газарт эмнэлгийн барилга багтахгүй байгаа тул газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж, мөн зураг төсвийн ажил хүлээгдэж байна. “Нийслэлийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-нд тусгуулсан. Газар чөлөөлөлтийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд урьдчилсан байдлаар 28 нэгж талбарын газар чөлөөлөхөд 4 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтэй шаардагдах тооцоолол хийгдсэн байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд “Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих” 25.0 тэрбум төгрөг тусгагдсан.

2.1.3.9. Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II"-ийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих (концессын эргэн төлөлт)

Биелэлт: Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II"-ийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих (концессын эргэн төлөлт) коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэдийг эмчилж байгаатай холбоотой Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн төсвийг нэмэгдүүлэн нийт 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-д эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай нийт 30 орчим нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2021 оны улсын төсөвт 30.7 тэрбум төгрөг ЭНЭҮТ-II концессын эргэн төлөлт хийхээр баталсан. 2021 оны III улирлын байдлаар концессын эргэн төлөлт бүрэн олгогдсон байна.

2.1.3.10. Гадаадын зээл, тусламжийн хүрээнд эрүүл мэндийн салбарт цөмийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Олон улсын Атомын энергийн агентлаг (ОУАЭА)-ийн Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан Техникийн хамтын ажиллагааны хүрээнд Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-д "Шугаман хурдасгуурт суурилсан стереотактик туяа эмчилгээний аргыг нэвтрүүлж, түгээмэл тохиолддог хорт хавдрын эмчилгээний чанарыг сайжруулах нь" MON6021 төслийг хэрэгжүүлснээр өвчтөний амьсгалын хөдөлгөөнийг барих төхөөрөмж "Abches", өвчтөний амьсгалын хөдөлгөөнийг хянах 2 ширхэг камер, цацрагийн хяналтын дозиметрийн багаж, туяа эмчилгээний төлөвлөлт хийх сервер, шугаман хурдасгуурт аппаратын амьсгал хянах нэмэлт төхөөрөмж "Breath hold monitoring device" 2 ширхэг зэрэг нийт 385 мянган еврогийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүд, дүрслэлийн төхөөрөмж (Onboard Imaging), мөн 1 тэрбум 752 сая төгрөгийн Компьютер Томографын аппаратыг хүлээн авснаар компьютер томографгүйн улмаас зогсоод байсан 3D дотуур туяа эмчилгээг эхлүүлж 950 хүнд, оношилгоогоор 467 хүнд үйлчилж туяа эмчилгээнд орох хүмүүсийн хүлээгдэл хоёр дахин бууруулсан.

"GMP стандартын дагуу Технеций-99m эмнэлгийн изотоп үйлдвэрлэх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх" MON1009 үндэсний төслөөр МУИС-ийн Цөмийн физикийн судалгааны төвд эмнэлгийн изотоп гарган авах генератораас изотоп саах радиохимийн лабораторид нийтдээ 483 сая төгрөгийн үнэтэй урвалж хадгалах хөргөгч, хөлдөөгч, урвалж нийлэгжүүлэх ламинар урсгалтай татах шүүгээ, олон горимт үүрэнцэр уншигч, лабораторийн жижиг хэрэглэгдэхүүн зэргийг худалдан авч тохижилт хийгдсэн бөгөөд тус лабораторид цаашид туяа эмчилгээ, цацрагийн эмчилгээний эмнэлгүүдэд ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, дадлагажуулах, сургалт явуулах, Монгол Улсад генераторыг үйлдвэрлэх судалгаа хийгдэнэ.

2.1.3.11. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Сумын эрүүл мэндийн төвийн 10, 15, 22 ортой, нэгдсэн эмнэлгийн 100 ортой барилга, 30 ортой сүрьеэгийн барилга, Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг төслүүд хийгдэж батлагдсан.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаалаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт (улсын хэмжээнд)-ын хүрээнд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-ыг баталснаар хот, хөдөөд хийгдэх бүтээн байгуулалтуудын 19 зураг төслийг боловсруулж, батлуулсан байна.

2.1.4.Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ:

2.1.4.1.Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын тушаалаар яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын 1,549.8 сая төгрөгийн санхүүжилтээр хийж, орон нутагт шаардлагатай 19 цэгт яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийг хуваарилсан байгаа ч хийгдээгүй байна.

2.1.4.2.Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/504, А/540, А/766 дугаар тушаалаар УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ зэрэг 7 эрүүл мэндийн байгууллагад амьсгалын аппарат, яаралтай тусламжийн иж бүрдэл, унтуулгын аппарат, өвчтөний монитор, эрчимт эмчилгээний ор зэргийг хуваарилж, яаралтай тусламжийн чадавхыг бэхжүүлсэн.

Алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглах туулах чадвар өндөртэй түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг болон лавлагаа шатлалын Халдварт өвчин судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын гуравдугаар төв эмнэлгүүдэд нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгосон байна. Мөн 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр түргэн тусламжийн УАЗ-фургон автомашин, “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн коронавируст халдвар КОВИД-19-ыг эмчлэх, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 8 ширхэг иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашиныг тус тус хүлээлгэн өгсөн байна.

Мөн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Энэрэл эмнэлэг, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Төв аймгийн Эрдэнэ сум, Сүхбаатар аймгийн Асгат, Дарьганга, Мөнххаан, Эрдэнэцагаан сум зэрэг 9 эрүүл мэндийн байгууллагад нийт 910.8 сая төгрөгийн өртөгтэй хүчилтөрөгчийн аппаратыг хуваарилжээ.

2.1.4.3.Яаралтай тусламж үйлчилгээнд агаарын үйлчилгээг /нисдэг тэрэг/ нэвтрүүлнэ.

Биелэлт: АХБ-ны санхүүжилттэй Эрүүл мэндийн салбарын хөгжил-6 төслийн хүрээнд үндэсний түргэн тусламжийн тогтолцоог бэхжүүлэхэд агаарын түргэн тусламж нэвтрүүлэх арга хэмжээ тусгагдаж төслийн 1 дэх үе шат буюу 2025 онд агаарын яаралтай тусламж, үйлчилгээ (нисдэг тэрэг) нэвтрүүлэхээр ажиллаж байна. Олон улсын зөвлөх компанийн үйл ажиллагааны хүрээнд нисдэг тэргийг түргэн тусламж, үйлчилгээнд ашиглах хэрэгцээ шаардлагын судалгаа хийгдсэн бөгөөд ГССҮТ, ЭХЭМҮТ-д нисдэг тэрэг буух талбайг байгуулсан.

АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийг 3 үе шаттай хийхээр судалгааны ажил хийгдэж байна.

Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээнд ОБЕГ, хувийн хэвшлийн байгууллагатай иргэд хувиараа хамтран ажиллаж, нисдэг тэргээр тусламж, үйлчилгээ авч байна.

2.1.4.4.Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.

Биелэлт: Яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 21 аймагт эмнэлгийн бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. 2021 онд Баян-Өлгий аймгийн 5 сум, Өмнөговь аймгийн 11 сум нийт 16 суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 724 сая төсөвт өртөг бүхий түргэн тусламжийн автомашин, мөн НҮБ-ийн Хүүхдийн сангаас 221.0 сая төгрөгийн санхүүжилтээр 5 аймгийн 9 сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн тоногдсон эмнэлгийн автомашин хүлээлгэн өгсөн байна.

Алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглагдах туулах чадвартай түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг болон лавлагаа шатлалын Халдварт өвчин судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг зэрэг 50 эрүүл мэндийн байгууллагад нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгосон.

Улсын хэмжээнд 79 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон нь нийт 150 эрүүл мэндийн мэндийн байгууллагын 52.7 хувийг хангасан дүнтэй байна.

2.1.5.Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий болгоно.

2.1.5.1.Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих төв байгуулна.

Биелэлт: “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг 15 аймаг, нийслэлийн 5 дүүргийн Эрүүл мэндийн төв (Баянзүрх, Багануур, Сонгинохайрхан), төрөлжсөн мэргэшлийн 3 эмнэлэг (УГТЭ, УХТЭ, УНТЭ)-т байгуулж нийт 2.4 тэрбум төгрөгийн өртөгтэй, 20 гаруй төрлийн иж бүрэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслээр хангасан.

Эрүүл мэндийг дэмжих төвийн засварыг Увс, Завхан Булган, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Баян-Өлгий, Хөвсгөл, Сэлэнгэ зэрэг 9 аймагт 11.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулан 100 хувийн гүйцэтгэлтэй хийсэн байна.

2023 оны төсвийн тодотголд сум дундын нэгдсэн эмнэлгүүдэд Эрүүл мэндийг дэмжих төв нэмж байгуулах төсвийн саналыг хүргүүлсэн боловч 2024 оны төсөвт батлагдаагүй болно.

2.1.5.2.Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлуулна.

Биелэлт:Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/736 дугаар тушаалаар байгуулсан. 2022 онд Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай үндэслэл, танилцуулга, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авч нэгтгэн 2023 оны 10 дугаар сард УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлуулсан байна.

Хуулийн нэмэлтээр А вирус гепатит, пневмококкийн халдвар, хүний папиллома вирусийн эсрэг вакцинжуулалтыг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолд шинээр нэмсэн.Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлуулахаар тогтоолын төслийг боловсруулж, яамдаас санал нэгтгэж байна.

2.1.5.3. Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрүүл мэндийг дэмжих сангаас 78 төслийг сонгон шалгаруулж, нийт 4,763,632,883 төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилгоор Засгийн газар “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай” 321 дүгээр тогтоолыг баталсан, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар батлуулахаар ажиллаж байна.

2.1.5.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулж батлуулна.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/171 дүгээр тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн удирдамжийг батлуулсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан саналуудыг тусган сайжруулж 2023 оны 12 дугаар сард УИХ-ын нэгдсэн хуралдааны эхний хэлэлцүүлгээр хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороо руу шилжүүлсэн. 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт оруулсан.

2.1.5.5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчилнэ.

Биелэлт: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, холбогдох дүрэм, журмын төслийн хэлэлцүүлэг уулзалтыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Завхан, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Ховд зэрэг 10 аймгийн төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Мөн Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг боловсруулсан. Төв аймгийн нийтийн эрүүл мэндийн төвтэй газар дээр нь очиж танилцан ажлын хэсгийн 4 удаагийн хурлыг зохион байгуулж, санал солилцсон стандарт батлагдаагүй байна.

2.1.5.6. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Биелэлт: Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/86, А/52 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг 2023 оны 4 дүгээр сард шинэчлэн Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдаар хамтран батлуулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу яамдаас санал авч нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд хүргүүлээд байна.

2.1.5.7.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.

Биелэлт: Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах шаардлагатай эдийн засгийн тооцооллыг хийж байна. Нийслэлийн 8 дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулахад шаардлагатай хүний нөөц, гарах зардал, бүтэц зохион байгуулалтын тооцооллыг хийхэд нийт 21.9 тэрбум төгрөгийн төсөв, хүний нөөцийн хувьд 594 ажилтан шаардлагатай гэсэн тооцоо гарсан.

2.1.6.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.

2.1.6.1.Салбарын түвшинд мэдээллийн технологийн сүлжээний дэд бүтцийг бий болгоно.

Биелэлт: 2021-2022 онд Эрүүл мэндийн салбарын "VPN" хамгаалагдсан мэдээллийн сүлжээний дэд бүтцийг Мобиком, Юнител зэрэг байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн хөгжлийн төвд байгуулж, нийт 48 эрүүл мэндийн байгууллагыг шилэн кабелийн VPN сүлжээний дэд бүтцэд холбон, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2 дугаар байранд төв зангилааг байршуулсан.

Цаашид анхан шатны эрүүл мэндийн 535, лавлагаа шатлалын 48, хувийн хэвшлийн 68 эрүүл мэндийн байгууллагыг цахим технологи ашиглан холбон Монгол Улсын хэмжээнд нэгдсэн нэг мэдээний санг үүсгэх, аль байгууллагаар үйлчлүүлэхээс үл хамаарч мэдээллээ нэг хэлээр солилцдог болох, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн платформ хөгжүүлэх гол суурийг тавиад байна.

2.1.6.2.Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформыг Дэлхийн банкны “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Мэдээлэл солилцооны платформын анхны туршилтыг УГТЭ, Увс аймгийн нэгдсэн эмнэлэг хооронд амжилттай туршсан.

Мөн Дэлхийн банкны санхүүжилтээр "Цахим эрүүл мэнд" төслийн туслан гүйцэтгэгч “Аксис системс” ХХК-тай хамтран нийт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд ашиглаж байгаа програм хангамжид (хувийн эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг Медсофт И-клиник, Вингс, Гиганет, Карте зэрэг систем) хадгалагдаж буй иргэний эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэсэн. Мөн Үндэсний дата төвд сервер тоног төхөөрөмжүүд байршуулан ЭМДЕГ-тай гэрээ бүхий лавлагаа шатлалын болон анхан шатны эмнэлэг, 50 гаруй хувийн эмнэлэг зэрэг эрүүл мэндийн байгууллагуудыг НІЕР системд холбож, нийт эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны платформыг нэвтрүүлсэн.

2.1.6.3.Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн дүрс архивлан хадгалах тоног төхөөрөмж EZO дэлгэцээр тоноглогдсон workstation, программ хангамжийн хуваарилалтыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар УНТЭ, УГТЭ, ГССҮТ, Хөвсгөл, Увс аймгийн нэгдсэн эмнэлэг, Үндэсний дата төвд хуваарилан суурилуулж үйл ажиллагааг жигдрүүлсэн.

Үндэсний Дата төвд суурилуулагдсан төвлөрсөн PACS системд бүх шатны эрүүл

мэндийн байгууллагуудыг холбох ажлыг 2022-2023 онд шат дараалалтай хийж байна. 2023 онд оношилгоо, эмчилгээний дүрс архивлан хадгалах, солилцох системийг боловсруулж хэрэгжүүлэх, PACS системийг E-health программ хангамжид холбон нэмэлт хөгжүүлэлт хийсэн.

ЭХЭМҮТ, СЭМҮТ, ГССҮТ, ХӨСҮТ, ХСҮТ, УНТЭ, нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх зэрэг 4 дүүргийн Эрүүл мэндийн төв, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Дорнод, Орхон, Өвөрхангай, Ховд аймаг дахь 4 БОЭТ, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Завхан, Төв, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Увс, Хөвсгөл зэрэг 13 аймгийн нэгдсэн эмнэлэг, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Ховд аймгийн Булган сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэг, нийт 31 эрүүл мэндийн байгууллагад нэмэлтээр PACS системд E-health программ хангамжаар дамжуулан холбогдсон ба дүрс архивлан хадгалах системийг ашиглаж байна.

2.1.6.4. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт: Алсын зайн анагаах ухаан (Телемедицин)-ы тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийг түшиглэн 16 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, нийслэлийн 2 дүүргийн эмнэлэгт тус тус суурилуулсан.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрхний төвд зүрх судасны өвчлөлийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд телемедициний МН кардио програм хангамжийг хувийн хэвшлийн эрүүл мэндийн 4 байгууллага, анхан шатлалын 212 эрүүл мэндийн байгууллага, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ болон нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн яамны харьяа 4 байгууллага, нийт 250 байгууллага холбогдон зүрх судасны чиглэлээр эмнэлзүйн хэлэлцүүлэг, зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд ашиглаж байна.

МН кардио программын хэрэглээний сургалтын бичлэгийг cardiocenter.telemedicine.mn цахим хуудсанд нөхөж үзэх боломжтойгоор байршуулж байна. Мөн ЭХЭМҮТ-д Эх, нярайн тусламжид зайн оношилгооны дэмжлэг үзүүлэхээр 21 аймаг, амаржих газруудад IP camera, IP phone тогтолцооны тоног төхөөрөмжүүдийг тус тус суурилуулж зайн зөвлөгөө 2,588, зайн сургалт 42, зайн хурал 48 хийжээ.

2.1.6.5. Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна.

Биелэлт: Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн мэдээлэл, технологийн төв байгуулах үндэслэл, төсөл, бүтэц орон тоо, төсвийн төлөвлөгөө, дүрэм, Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны танилцуулга боловсруулж, яамдаас санал авсан боловч Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 283 дугаар тогтоолоор үндэсний хэмжээнд нэгдсэн “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газар” байгуулахаар болсон тул ажил зогссон.

2.1.6.6. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

Биелэлт: АХБ-ны “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах” төслийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн нэгдсэн сан байгуулсан. Нийслэлийн эрүүл мэндийн газраас олгодог тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулж, E-Mongolia системд хуулийн этгээдийн хандах хэсгийг бүрэн оруулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн программыг хөгжүүлэх, нийлүүлэх гэрээг “Аксис системс” ХХК-тай байгуулж хөгжүүлэлт

бүрэн хийгдэж дууссан.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх хүсэлт, шийдвэрлэлт, олгох, сунгах зэрэг ажлууд цахимжсан, нийт 6,122 байгууллагуудын мэдээллийн шинэчлэлийг хийж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2.1.6.7. Үзлэгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд зэрэг 6 аймагт 1800-0119 тусгай утсаар үзлэгийн цаг авах үйлчилгээ бүрэн нэвтэрсэн. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээр дамжуулан 21 аймаг, 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, ЭМЯ-ны харьяа 18 эмнэлэг болон нийслэлийн 136 өрхийн эрүүл мэндийн төвийн цагийг онлайнаар захиалах үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бүрэн ашиглалтад оруулсан.

2.1.6.8. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ.

Биелэлт: 2021 нийт 63 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологийн 28 нэр төрлийн 1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг олгосноор мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлж байгаатай холбогдуулан хүний нөөцийг чадавхжуулах цахим сургалтууд зохион байгуулагдсан байна.

2022 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн дэмжлэгтэйгээр аймаг, нийслэлийн 23 ЭМАШТҮ үзүүлэгч байгууллага эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь" арга хэмжээнд хамрагдаж тайлант оны эцсээр 56 анхан шатны эрүүл мэндийн байгууллага мобайл технологийг өргөжүүлэх арга хэмжээнд хамрагдаж мобайл тоног төхөөрөмжийн багцыг хүлээн авсан.

Улсын хэмжээнд сумдын эрүүл мэндийн төвийн 82% буюу 272, өрхийн эрүүл мэндийн төвийн 42% буюу 88, нийт 360 Эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.

2.1.7.1. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын хурлаар “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах тухай” 02 дугаар тогтоол батлагдсан. Эрсдэлийн санг эрүүл мэндийн сангийн 2021 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсан бол Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 08 дугаар тогтоолоор санхүүжилтийн хуваарийг, 09 дүгээр тогтоолоор "Эрсдэлийн сангийн хөрөнгийг Төрийн санд байршуулах, зарцуулах журам"-ыг, 10 дугаар тогтоолоор эрсдэлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан байна.

2023 оны жилийн эцэст Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийг 1,603.4 тэрбум төгрөгөөр төсөвлөж, эрсдэлийн санг 40.0 тэрбум төгрөгөөр баталсан. Энэ нь даатгалын санхүүжилтийн ердөө 2.5 хувийг эзэлж байгаа бөгөөд зорилтот түвшний 31.2 хувьд хүрсэн байна. Тусламж үйлчилгээнд 40.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна

2.1.7.2. Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад Улсын төсөв (ЭМДС)-гаас амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтад тэнцсэн 196 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай 3 жил буюу 2022-2025 оны хугацаатай даатгалын гэрээг 2022 оны 09 дүгээр сард байгуулсан байна. 2023 оны 12 сарын байдлаар 221.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээтэй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна.

2.1.7.3. Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-гаас санхүүжүүлнэ.

Биелэлт: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, АХБ хамтран “Олон нийтэд түшиглэсэн ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний шинэлэг тогтолцоо, үйлчилгээг хөгжүүлэх нь” техник туслалцааны ТА9928 төслийг хэрэгжүүлж байна. “Урт хугацааны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн өнөөгийн байдал” сэдвээр зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Геронтологийн үндэсний төв, АХБ-ны ТА- 9341 төслийн баг оролцож, БНСУ-д туршлага судалсан.

2.1.7.4. Эмнэлгийн хагас бие даасан байдлыг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлнэ.

Биелэлт: УНТЭ, УГТЭ, АӨСҮТ, Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 9 байгууллагад ТУЗ байгуулагдан ажиллаж байна. УНТЭ, УГТЭ, АӨСҮТ-ийн хамт олны болон олон нийтийн төлөөлөл, АӨСҮТ-ийн ТББ, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийн зарим гишүүдийн хугацаа дууссантай холбоотойгоор шинээр нэр дэвшүүлэх хурал, сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулж, шинэ гишүүдийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/161, А/251, А/372 дугаар тушаалаар тус тус батламжилсан.

2.1.7.5. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлнэ.

Биелэлт: Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 328 сумын Эрүүл мэндийн төв, лавлагаа шатлалын 64 эрүүл мэндийн байгууллагад гүйцэтгэлд суурилсан санхүүжилт бүрэн нэвтэрсэн.

2.1.7.6. Санхүүжилтийн гүйцэтгэл, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд байгууллагын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж байна.

2.1.7.7. Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ.

Биелэлт: 2016-2021 оны Эрүүл мэндийн үндэсний тооцооллыг “Эрүүл мэндийн тооцооны систем-2011” стандартын дагуу улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, хувийн

даатгал, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, гадаадад эмчлүүлэгчдийн зардал, ТББ болон хандивлагчдын зардлын мэдээлэлд үндэслэн боловсруулсан. Тооцооллын үр дүнд үндэслэн 3 үндсэн бүлэг, олон улсад харьцуулах 23 үзүүлэлт, хэмжээс хоорондын хамаарлыг харуулах 30 хавсралт хүснэгттэйгээр нэгдсэн тооцоолол, үр дүнгийн тайланг боловсруулан дүн шинжилгээ хийсэн. Тооцооллын үр дүнг Эрүүл мэндийн үндэсний тооцооны зохицуулах зөвлөлийн хурлаар 2023 оны 12 дугаар сард багтаан хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

2.1.7.8.ЭМДЕГ-ын бүтцийг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхижуулна.

Биелэлт: Хүний нөөцийг чадавхжуулахаар төлөвлөгөөт сургалтад хамруулж, албан хаагчдыг тогтмол чадавхжуулж байна.

2.1.7.9.Төрөөс болон ЭМД-аас хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, багц, төлбөрийн хэмжээг тогтоох, зардлын тооцооллыг хийнэ.

Биелэлт: “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт”-ыг шинэчлэн баталж, мөрдөж байна. Улсын төсвөөс санхүүжүүлж байсан халдварт өвчин, хавдар, жирэмслэлт, төрөлт, нярайн эмгэг, сэтгэцийн өвчин, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, түргэн тусламж, хөнгөвчлөх, сэргээн засах эмчилгээ нь ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолоор батлагдсан 563 оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад багтсан ба хамтын төлбөргүй байхаар зохицуулагдсан.

2.1.7.10.Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулна.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын цахим системд лавлагаа шатлалын 334, анхан шатны 530 гаруй эмнэлэг,1,600 гаруй эмийн сан, нийт 2,264 гаруй эрүүл мэндийн байгууллага холбогдон иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээлэл солилцон ажиллаж байна. Сумын эрүүл мэндийн төв, зарим өрхийн эрүүл мэндийн төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүд 60-аас дээш насны иргэдийн хөнгөлөлттэй эмийн жор бичихэд хурууны хээ шаардахгүй байх хөгжүүлэлтийг хийж, чирэгдлийг бууруулсан.

2.1.7.11.Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-гийн орлогыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын "Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2023 оны хувь хэмжээ тогтоох тухай" 2022 оны 500 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь, Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.12-т заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 5500 (таван мянга таван зуун) төгрөгөөр, мөн хуулийн 4.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа

ялтны эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 11000 (арван нэгэн мянган) төгрөг байхаар тогтоосон.

2.1.7.12.Олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлнэ.

Биелэлт: Олон улсын эмнэлзүйн цахим UpToDate платформыг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтний хэрэглээний түвшин сар бүр нэмэгдэж байна. 2023 оны 11 сарын байдлаар тус платформын хэрэглэгчдийн тоо 58,754 байгаа нь өмнөх 10 сартай харьцуулахад 19.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цахим платформын хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг, UpToDate цахим платформын Монгол Улсыг хариуцсан мэргэжилтэн хамтран 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр цахим сургалт зохион байгуулж, нийслэл болон орон нутгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 300 гаруй эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.

2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.

2.1.8.1.Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлнэ.

Биелэлт: Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, АХБ-ны “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах” төслийн хүрээнд Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэлийг эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн нэгдсэн сан байгуулах ажилтай хамтатган хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, гадаадын эмийн үйлдвэрийн төлөөлөгчийн газрууд www.licemed.mohs.mn домэйн хаягаар, иргэд, олон нийт www.druginfo.mohs.mn домэйн хаягаар хандан ашигладаг ба нээлттэй мэдээлэл бүрэн байршсан.

Тус системд эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээлэл, эм, эмийн түүхий эд, био идэвхт бодис, оношлуурын бүртгэлийн мэдээлэл, импорт, экспортын лиценз олгох үйл ажиллагаа, ханган нийлүүлэх байгууллага, үйлдвэрийн тайлан, эмийн гаж нөлөөний мэдээллийг бүрэн агуулдаг. Мөн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бүх эмийн сан эмийн үнийн хөнгөлөлт олгох www.health.gov.mn цахим системийг хөгжүүлж бүрэн ашиглалтад оруулсан.

Эмийн чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой эмийн мэдээллийг цахимаар авах, хянах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Үндэсний ДАТА төв, И-Монгол академитай хамтран Licemed программын үндсэн өгөгдлийн сан болон программ ажиллах 2 ширхэг Dell gold серверийг Үндэсний ДАТА төвд байршуулсан. E-Mongolia системээр дамжуулан аж ахуйн нэгж, байгууллагууд биологийн идэвхт бүтээгдэхүүн, импортын эм, үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийг бүртгэх, сунгах, өөрчлөх, зохицуулах үйл ажиллагааг тус системд оруулж цахимжуулсан. Биологийн идэвхт бүтээгдэхүүн, импортын эм, үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийг бүртгэх, сунгах, өөрчлөх, зохицуулах зэрэг 21 үйл ажиллагаанд E-Mongolia болон E-Business платформуор 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 11,185 үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд дамжуулсан байна.

2.1.8.2.Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийнэ.

Биелэлт: Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 20/A/95 дугаар хамтарсан тушаалаар Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын өнөөгийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг Эрүүл мэндийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газрын төлөөллийг оролцуулсан байгуулсан. Хяналт шалгалт, үнэлгээнд нийт 223 эмийн сан, 109 эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, 19 эмийн үйлдвэр, 12 аймгийн нэгдсэн эмнэлэг, 5 аймаг дахь БОЭТ хамрагдсан. Хяналт шалгалт, үнэлгээгээр эмийн үнэ хэлцлийн үнээс эцсийн хэрэглэгчид хүрэхдээ дунджаар 1.1 дахин нэмэгдсэн байгааг тогтоосон. Үнэлгээнд хамрагдсан эмийн 80 хувьд ханган нийлүүлэх байгууллагууд өртөг үнэ дээр 30 хүртэл хувь нэмж борлуулсан бол 20 хувьд бөөний үнийн нэмэгдэл 30-аас дээш хувь нэмэгдэлтэй байна.

Засгийн газрын 2023 оны 30 дугаар хуралдаанд Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын өнөөгийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг Эрүүл мэндийн сайд танилцуулсан. Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

2.1.8.3.Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2022 оны A/450 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна, хэрэгжилт 75.6 хувьтай байна. Энэ нь зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагад тавигдах ерөнхий шаардлага, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд мэргэжлийн зэрэг олгох журам, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх ажлууд хийгдэж байна. Эрүүл мэндийн сайдын 2023 оны A/67 дугаар тушаалаар “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам” батлуулан хэрэгжүүлж байна.

Эм шинжлэх лабораторийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, сэлбэх, шинэчлэх шаардлагатай аппарат, тоног төхөөрөмжийн судалгааг гаргахад нэн шаардлагатай 118 багаж тоног төхөөрөмж, 199 нэрийн стандарт бодис, сэлбэг хэрэгсэлд 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Вакцин, био бэлдмэлд цувралын зөвшөөрөл олгох ажлын хүрээнд Монгол Улсад бүртгэлтэй нийт 21 нэр төрлийн бүтээгдэхүүний бүртгэлийн материалд судалгаа хийж, лабораторийн шинжилгээнд хамрагдах үзүүлэлтийн судалгааг гаргаж “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” MNS/ISO IES 17025-2018 стандартын шаардлагын дагуу үнэлгээг хийн, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн холбогдох байгууллагад хүргүүлсэн.

2.1.8.4.Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Нян судлалын антибиотик мэдрэг чанарын шинжилгээнд дүн шинжилгээ хийж, нянгийн тэсвэржилтийн тандалтын дэлхийн сүлжээ (WHONET GLASS)-д орох, мэдээллийг цуглуулах, эргэн мэдээлэх үйл ажиллагааг хэвшүүлэх зорилгоор WHONET-ийн программд 20 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, 7 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 19 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн 4 лаборатори зэрэг нийт 50 эрүүл мэндийн байгууллагын нян судлалын лабораторийг холбосон.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Няан судлалын лабораторитой хамтран WHONET программ дээр ажиллах 21 аймгийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулсан байна.

Улсын хэмжээнд WHONET үндэсний сүлжээг өргөжүүлснээр эрүүл мэндийн байгууллагууд нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн бөгөөд сар бүр дүн шинжилгээ хийх асуудлаар цахим сургалт тогтмол хийгдэж байна.

2.1.8.5.Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллага байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаарыг (80) баталсан.

Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын 28, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лабораторийн 24, нийт 52 албан хаагчийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт орон тоо, цалингийн сан, холбогдох зардлын хамт 2021 оноор тасалбар болгон шилжүүлэх арга хэмжээ авахыг Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд нарт даалгасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тоог 132 болгон нэмэгдүүлсэн.

2.1.8.6.Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

Биелэлт: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд коронавируст халдварын цар тахлын үед эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг төрөөс бодлогоор дэмжиж ажилласан. Монгол Улсын хэмжээнд 38 үйлдвэр эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж, 24 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна

Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/222 дугаар тушаалаар Эрүүл мэндийн салбарт 2023-2026 онд хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийг баталсан. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын судалгаагаар 2023 онд зах зээлд гаргахаар 20.1 тэрбум төгрөгийн 17,565,984 ширхэг эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэсэн тооцоо байна.Энэ нь эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд 21 хувийг эзэлж байна. Энэ нь 2023 оны зорилтот түвшинд хүрсэн үзүүлэлттэй байна.

2.1.8.7.Био бэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.

Биелэлт: 2010 оноос үйл ажиллагаа нь зогсоод байсан “Био бэлдмэлийн үйлдвэр”-ийн үйл ажиллагааг сэргэсэн. Био бэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын 144 дүгээр тогтоолоор 284.0 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын багцаас 3 тэрбум төгрөг тус тус төсөвлөгдсөн.

ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ зэрэг эрүүл мэндийн байгууллагуудад тэжээлт орчныг тасралтгүй үйлдвэрлэж, тусламж, үйлчилгээнд ашиглаж байна. ЗӨСҮТ-ийн био үйлдвэрлэлийн лаборатори нь нянгийн шалтгаант халдварт өвчин болох тарваган тахал, боом, холер, хулгана тахал, бруцеллез, хуурмаг сүрьеэ, листериоз, төрөл бүрийн мөөгөнцрийн халдварт өвчний оношилгоонд ашиглагдах 33 нэр төрлийн үндсэн, 10 нэр төрлийн хадгалах, тээвэрлэх, 97 нэр төрлийн сонгомол, 188 нэр төрлийн ялган оношлох микробиологийн тэжээлт орчин үйлдвэрлэж байна. ЗӨСҮТ-д 182 нэр төрлийн 1457.4 литр микробиологийн тэжээлт орчин үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

НЭМҮТ-д Симмонсын орчин, хатуу шээгийн орчин, шээгтэй шингэн орчин, хатуу, шингэн Сабуро орчин, пептонт ус, тиогликолаттай орчин, мах пептонт агар, мах пептоны шөл тэжээлт орчныг үйлдвэрлэж байна.

2023 онд шинэ бүтээгдэхүүний туршилт үйлдвэрлэлийг явуулж, “Шиллэг эд” био бэлдмэл 25 тун/шил, микробиологийн шинжилгээнд хэрэглэгддэг 12 нэр төрлийн тэжээлт орчин 6 литр, гэдэсний бүлгийн бактерийг хурдавчилсан аргаар илрүүлэх 3 төрлийн орчин 1.5 литр, гиалуроны хүчлээр баяжуулсан тараг бүтээгдэхүүн 34 литр, шар сүүгээр баяжуулсан зутан 7 литр, гар халдваргүйжүүлэгч 1 литр тус тус гарган авсан байна.

2.1.8.8.Эмийн аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори байгуулна.

Биелэлт: 2024 онд хэрэгжихээр ЗГҮАХ-т тусгагдсан.

2.1.8.9.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.

Биелэлт:Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагаа 2021 оноос эхэлж нийт 73 эрүүл мэндийн байгууллагын 13 нэр төрлийн 873 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд 88.8 хувь эмнэлгийн тоног төхөөрөмж шалгалт тохируулгад тэнцсэн байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан буюу www.heps.hdc.gov.mn цахим программд төрийн өмчийн болон хувийн хэвшлийн 588 эрүүл мэндийн байгууллагын 1,181 хэрэглэгч, 31,163 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн байна.

Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд Польш Улсын Storalczyk Mirosław Technologia Pozarnicza компанитай МОН/2021-005-0723 дугаартай гэрээ байгуулсан боловч гэрээний дагуу 2 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний автомашин (явуулын лаборатори) нийлүүлэх хугацаа хойшилсон.

Эхний ээлжид гэрээний дагуу нийлүүлэгдэх түргэн тусламжийн 12 автомашиныг ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан ТИР ачааны автомашинд хоёр хоёроор ачиж 6 удаагийн татан авалтаар 12 автомашин Монгол Улсад орж ирээд гаалийн түр горимоор бүрдүүлэлт хийж, “Бридж” ХХК-ийн гаалийн баталгаат агуулахад хадгалж байна.

2.1.9. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.

2.1.9.1.Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлнэ.

Биелэлт: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг 2021-2022 онд Орхон, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Ховд зэрэг 5 аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгосон. 2022-2023 оны хичээлийн жилд сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий Бүсийн оношилгоо, эмчилгээний 5 төвд Ерөнхий мэргэшил судлал, үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад нийт 12 резидент эмчийг сургаж байна.

Эрчимт эмчилгээний сувилахуй, Яаралтай тусламжийн сувилахуйн төрөлжсөн мэргэшлийн сургалтыг Орхон БОЭТ-д зохион байгуулж, сургалтын төрөл, чиглэлийг нэмэгдүүлж байна.

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2023 оны хурлаар Булган, Хөвсгөл, Сонгинохайрхан, Баянгол, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг зэрэг 7 байгууллагад Ерөнхий мэргэшил

судлалаар сургалт эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2.1.9.2. Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг гадаадад урт хугацааны сургалтад хамруулна.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаараар “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл, 2023 оны А/103 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн ажилтны 2023-2024 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал”-ийг тус тус баталсан.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нэгдсэн лабораторийн албаны вирус судлалын лабораторийн тасгийн 2 их эмч, 1 био-анагаах судлаач нар Япон Улсад “SARS COVID” бүрэн генийн дарааллыг тодорхойлох, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Хүүхдийн гэмтэл согогийн тасгийн 1 их эмч Турк Улсад хүүхдийн гэмтлийн мэргэжлээр, БНСУ, БНТУ-д ЕСМО эмчилгээ 3, бөөр үргэлжлэн орлуулах эмчилгээ 1, нойр булчирхай шилжүүлэн суулгах 1, глауком 1, мэдрэлийн мэс заслаар 2, нийт 8 эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжил дээшлүүлэх сургалтад, Улсын гуравдугаар төв эмнэлгээс Япон Улсад уушги судлалаар 1, БНСУ-д Мэдрэл судлал чиглэлээр 1 эмч, нийт 2 эмч тус тус гадаад улсад суралцаж байна. Мөн Австрали Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Сиднейн их сургуульд хүүхдийн эмчийн 1 жилийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт ЭХЭМҮТ-ийн 50 эмч цахимаар суралцаж байна. Энэ нь зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Үүдэл эсийн технологи, нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс засал чиглэлээр урт хугацааны сургалтад хамрагдах захиалга авсан.

2.1.9.3. Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/484 дүгээр тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд 2022-2023 нийт 22 чиглэлээр 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллан суралцаж төгссөн байна.

Ажиллан суралцах хүрээнд ХСҮТ-ийн Хими эмчилгээний тасагт нийслэлийн 9 дүүргийн 13 эрүүл мэндийн байгууллага тус бүрээс 1 (13 хүн), 9 аймгаас тус бүр 2 эмийн мэргэжилтэн, нийт 31 мэргэжилтнийг богино хугацааны сургалтад хамруулсан байна. Мөн оношилгооны дурангийн сувилахуйн 1, мэс заслын сувилахуйн 3, нярайн сувилахуйн 9, эх барих 4, хавдрын бүртгэл судлал 1, үйл онош зүйн 3, эрчимт эмчилгээний сувилахуй 1, нийт 22 сувилагч тусгай мэргэжилтэн мэргэжил дээшлүүлэх сургалтад ажиллан суралцаж байна.

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ЭСҮТ, Өргөө, Амгалан амаржих газар, Цэргийн төв эмнэлэг зэрэг сургалт эрхлэх 8 байгууллагын 27 эмч дурангийн онош зүй, бөөр шилжүүлэн суулгасны дараах хяналт, яаралтай тусламж, зүрх, тархины судас, хэвлий, эмэгтэйчүүдийн хэт авиа оношилгоо, эмэгтэйчүүдийн мэс засал, дурангийн мэс засал, хөнгөвчлөх эмчилгээ, чих, хамар, хоолойн мэс засал, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг судлал зэрэг 12 чиглэлээр ажиллан суралцаж байна. Улсын хэмжээнд нийт 132 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллан суралцаж нь зорилтот түвшинд хүрсэн байна.

2.1.9.4. Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг цалин урамшуулалтай уялдуулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг сайжруулах, эмнэлгийн өрсөлдөх чадварыг

дээшлүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн доод хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/77 дугаар тушаалаар Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, ажилтны ажлын гүйцэтгэл, бүтээмжийн урамшуулал, өнөөгийн байдалд судалгаа хийх, боловсронгуй болгох, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран байгуулж, салбарын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ангилал, дундаж цалин хөлсний тооцоо судалгааг сум, аймаг, нийслэл, харьяа байгууллагуудын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдээр гаргаж УИХ-ын НББСШУБХ-нд мэдээлэл хийсэн байна.

2.1.9.5. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 193 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийг хүрээнд “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент: КОВИД-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO/PAS 45005:2021” стандартыг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нийт 117,674 ажилтныг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд жил болгоны 08 дугаар сарыг Эрүүл мэндийн ажилчдын нийгмийн хамгааллыг дэмжих сар болгон ажилладаг байна. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн ажилчдын цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоож, эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдын цалинг дунджаар 10-25 хувиар нэмэгдүүлсэн байна.

УНТЭ 33 эмч, ажилтанд орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж урьдчилгаа 30 сая хүртэлх төгрөг олгосон, ажилчдынхаа үндсэн цалинг 40 хувиар нэмэгдүүлсэн байна.

Мөн Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, эрүүл мэндийн ажилтнуудын нийгмийн баталгааны суурь судалгаа зэрэг сэдвүүдээр АШУҮИС-ийн НЭМС-ийн судлаач багш нараар судалгаа хийлгэсэн. Судалгаагаар эрүүл мэндийн ажилтнуудын 2 хүн тутмын 1 нь өөрийн эрүүл мэндийг дундаас доогуур үнэлсэн нь тэдний амьдралын чанар муу байгааг илтгэж байна. Тухайлбал:эрүүл мэндийн ажилтнуудын бодит орлого хангалтгүй, судалгаанд хамрагдсан 655 эрүүл мэндийн ажилтнуудын 89.2 хувь нь ямар нэгэн зээлтэй, 11 хувь нь өрх толгойлсон, 44.1 хувь нь бага насны хүүхэдтэй, 46.9 хувь нь галлагаатай сууц, 18.7 хувь нь бусдын өмчлөлийн болон түрээсийн байранд амьдардаг гэх судалгаа гарсан байна.

Судалгаанаас гарсан санал дүгнэлтэд үндэслэн бодлогын түвшинд эрүүл мэндийн ажилтнуудын бодит орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийг дэмжих, эрүүл, аюулгүй ажиллах орчин бүрдүүлэх, ажлын байран дахь сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлүүдийг тусган эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааны цогц хөтөлбөрийн төслийг боловсруулахаар ажиллаж байна.

2.1.9.6.Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.

Биелэлт: Япон Улсын ЖАЙКА хамтын ажиллагааны байгууллагын “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн хүрээнд сувилахуйн чадамжийг тодорхойлж, 120 сувилагчийг сувилахуйн, 70 эх баригчийг эмнэл зүйн сургагч багшаар тус тус бэлтгэсэн. Мөн Япон Улсад 16 эх баригч, сувилагч туршлага судлах

сургалтад хамрагдсан байна.

2.1.9.7. Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл”, 2023 оны А/103 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн ажилтны 2023-2024 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал (190.0 сая төгрөг)”, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2023 оны А/38 дугаар тушаалаар Эрүүл мэндийн ажилтныг 2023 онд төгсөлтийн дараах гадаад сургалтад хамруулах төлөвлөгөөг тус тус баталж, тэргүүлэх чиглэлийн дагуу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, амаржих газраас 2022-2026 онд гадаад улсад урт, богино хугацаанд эмнэлгийн мэргэжилтнийг суралцуулах сургалтын захиалгыг авсан болно.

Тайлант хугацаанд 369 хүнийг богино хугацааны гадаад сургалтад хамруулсан байна. Үүнд: 2021 онд ЭМХТ, УНТЭ, ЦССҮТ, Өргөө амаржих газрын удирдах албан хаагч, эмч 10 хүн 7 хоногийн сургалтад, 2022 онд 27 эмнэлгийн 32 эмнэлгийн мэргэжилтэн 14-60 хоногийн сургалтад, 2023 онд 327 эмнэлгийн мэргэжилтэн (улсын төсөв болон Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр АХБ-аар дамжин хэрэгжиж буй МОН-9218 төслийн санхүүжилтээр 2023 оны сургалтад 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, өрх, сумын ЭМТ, нийслэлийн 9 дүүргийн ЭМТ, 3 дүүргийн нэгдсэн эмнэлэг, өрхийн ЭМТ, нийслэлийн ЭМГ-ын харьяа 7 байгууллага, ЭМЯ-ны харьяа 18 байгууллагын төлөөлөл бүхий 200 сувилагч, эх баригчийг БНСУ-ын Сүнчонхян их сургуулийн Сөүл Бүчон эмнэлэг болон БНХАУ-ын Бээжин, Хөх хот дахь хавдрын эмнэлэгт 8 Хөдөөгийн багт ажилладаг 18 аймгийн 84 бага эмчийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод) богино хугацааны гадаад сургалтад тус тус хамруулав.

2.1.10. Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.1.10.1. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулна.

Биелэлт: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулга, хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг боловсруулан бүх яамдаас санал авч холбогдох саналыг тусган эцэслэсэн бөгөөд хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

2.1.11. Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг үе шаттайгаар байгуулна.

2.1.11.1. Барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг бүрдүүлнэ.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (БОЭТ)-ийн барилгын ажлын явц 30-80 хувийн гүйцэтгэлтэй (Ховд аймгийн БОЭТ-ийн барилгын ажлын зураг төслийг боловсруулсан ч санхүүжилт шийдвэрлэгдээгүй,

11.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дорнод аймгийн Хүүхдийн эмнэлгийн барилга угсралтын ажил 80.0 хувь, Өвөрхангай аймгийн Хархорин суманд 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын ажил 70.0 хувьтай) байна.

2021 онд Өмнөговь, Орхон, Ховд, Дорнод, Өвөрхангай зэрэг 5 аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 6.9 тэрбум төгрөгийн 64 зүслэгтэй компьютер томографийн аппарат, 8.9 тэрбум төгрөгийн ангиографийн тоног төхөөрөмж ханган нийлүүлсэн.

2.1.11.2.Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барина.

Биелэлт: АХБ-ны хөнгөлөлттэй зээл “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд үе шатын хүрээнд “Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл” (Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөл)-ийн зураг төсвийг боловсруулж, хүлээлгэн өгсөн бөгөөд “Интернэйшлл медикал центр” олон улсын зөвлөх фирм нь хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн нөхцөл байдлын үнэлгээ, шинэ өргөтгөлийн төлөвлөлт хийсэн.

2.1.12.Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

2.1.12.1.Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажил хийнэ.

Биелэлт: Барилга байгууламжийн шилжих 86 төсөл, арга хэмжээний 146.7 тэрбум төгрөгөөс 101.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон (Эрүүл мэндийн сайдын багцаас эрх шилжээгүй 61 төсөл, арга хэмжээний 119.2 тэрбум төгрөгөөс 82.3 тэрбум төгрөг). Нийт барилгын барилга угсралтын ажил 77.0 хувьтай байна. Үүнээс эхний 12 сарын байдлаар:

- 33 төсөл, арга хэмжээ ашиглалтад орсон (100.0 хувь);
- 11 төсөл, арга хэмжээ улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангаж байгаа бөгөөд барилга угсралтын ажил 90 хувиас дээш;
- 21 төсөл, арга хэмжээ барилга угсралтын ажил 70-89%;
- 14 төсөл, арга хэмжээ барилга угсралтын ажил 40-69%;
- 6 төсөл, арга хэмжээ барилга угсралтын ажил 20-39%-ийн гүйцэтгэлтэй.
- 1 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаа хийгдэж байна.

2.1.12.2.Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлнэ.

Биелэлт: Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй орон нутаг болон нийслэлийн 12 байгууллагад хөндлөнгийн аудит хийж зөвлөмж хүргүүлэн ажилласан болно. Мөн сонгогдсон сумын ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ хийх, төлөвлөгөөний төслийг боловсруулах, ус хангагч байгууллагын ажилчдад ДЭМБ-ын санхүүгийн дэмжлэгээр Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний 10 модулийн дагуу талбарын сургалт МХЕГ, АШУҮИС, Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, НЭМҮТ-тэй зохион байгуулж, Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулсан.

2.1.12.3.Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилгыг шинэчилнэ.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр санхүүжиж байгаа “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд өрх, сумын эрүүл мэндийн төвийн шилжих барилга байгууламж 45/2+3+36+4/, шинээр барих 38/3+35/, өргөтгөх 25 буюу давхардсан тоогоор нийт 108 сум, өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барилга угсралтын ажлын явц дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- ашиглалтад орсон 29 (2022-25, 2023-4)
- барилга угсралтын ажил 40-89 хувьтай үргэлжилж байгаа 4;
- өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ЛСТ барих газрын тооцоолол хийснийг үндэслэн бүх төвийн газрын кадаструудыг шинэчилж, нийслэлийн засаг даргын захирамж, бүх барилгын архитектурын төлөвлөлтийн А даалгаврууд гарсан;
- барилгын иж бүрэн зураг төсөв, магадлал хийж, нийслэлийн Ерөнхий архитектор (БЗД 17 дугаар хорооны ӨЭМТ) батлуулж, тендерийн бичиг баримтыг боловсруулж эхэлсэн;
- Иж бүрэн зургийг хийж дууссан (ЧД 19 дүгээр хорооны ӨЭМТ)

Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 03 дугаар тушаалаар БНБД 31-22-21 Эмнэлгийн барилгын норм, дүрмийг батлуулан, 2022 оноос хойш Монгол Улсын төсвийн тухай хуульд тусгагдсан Сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн зураг төслүүдийн төлөвлөлтөд мөрдөн ажиллаж байна.

2.1.12.4. Сум, өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн стандарт боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тушаалаар Эмнэлгийн барилгын норм, дүрмийг баталсан. Шинээр баригдаж байгаа болон шилжих сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилга нь энэхүү дүрмийн дагуу баригдаж байна. Үүнд:

- 2021 оны шинээр баригдах 21, шилжих 41 барилга;
- 2022 оны шинээр баригдах 35, шилжих 45 барилга;
- 2023 оны шинээр баригдах 21, шилжих 86 барилга;

2.1.12.5. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын агаарын чанарын дэд бүтцийг сайжруулна.

Биелэлт: Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтарсан 3308.000 ам.долларын санхүүжилт болон орон нутгийн төсвөөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Говь-Алтай, Баянхонгор Өмнөговь аймаг аймгуудад “Эх, хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын нөлөөг бууруулах нь” төслийн хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд:

- 2 өрхийн эрүүл мэндийн төвд агаар сэлгэлтийн механик систем байрлуулах;
- НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилттэй 22 сая төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг ЭМЯ-нд хүлээн авч, 10 өрхийн эрүүл мэндийн төвд агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг суурилуулах;
- НҮБ-ын Хүүхдийн сангаас 21 аймгийн төв, нийслэлийн 9 дүүрэг, зарим суурин газруудад гадаад орчны агаарын чанарыг хэмжих жижиг оврын 28.4 сая төгрөгийн үнэ бүхий 33 төхөөрөмжийг худалдан авч Цаг уур, орчны шинжилгээний газарт хүлээлгэн өгсөн.
- Монгол гэрийн дулаалга, халаалтын багц буюу ЧИП-ыг төсөл хэрэгжүүлэгч Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, 3 аймгийн орон нутгийн 12 үйлдвэрлэгч 100 ажилтантайгаар уг багцыг чанарын шаардлага хангах хэмжээнд үйлдвэрлэж 3

- аймгийн 90-100 өрх болон Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 100 өрх, 2 цэцэрлэгт чип суурилуулсан;
- Монгол гэрийн дулаалга, халаалтын багцыг Баянхонгор аймагт 150 сая төгрөгийн үнэ бүхий 110 ширхэг, Өмнөговь аймагт 150 сая төгрөгийн үнэ бүхий 59 ширхэг, Говь-Алтай аймагт 46.6 сая төгрөгийн үнэ бүхий 62 ширхгийг хуваарилсан;
- Баянхонгор аймгийн агаарын чанарын хяналтын харуулын мэдээллийг үндэсний мэдээллийн системтэй холбох ажлыг Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран хэрэгжүүлж байна.

2.1.12.6. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 169 дүгээр тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд тус яам эрүүл мэндийн байгууллагын барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулж, тайлант онуудад Эрүүл мэндийн яаманд CD хэлбэрээр хүргүүлсэн.

Эрүүл мэндийн төв, хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газраар батлуулан 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн бөгөөд дээрх жагсаалтад заасан зураг төслүүд:

- 2021 онд хэрэгжүүлэх Эрүүл мэндийн байгууллагын нэг маягийн 6 төрлийн батлагдсан нэг маягийн зураг төсөл (10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 100 ортой аймгийн нэгдсэн эмнэлэг Эрүүл мэндийн төвийн моргийн барилга, Эрүүл мэндийн төвийн эмчийн байрны барилга, 30, 100 ортой сүрьеэгийн эмнэлэг;
- 2022 онд “сумын хөгжил” дэд бүтцийн төсөл арга хэмжээний “Эрүүл мэндийн төвийн барилгын зураг төслийг 1 аймгийн 3 суманд (Төв аймгийн Батсүмбэр, Угтаал, Жаргалант) зориулан магадлалын дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэж өгсөн. Мөн Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулсан;
- 2023 онд “сумын хөгжил” дэд бүтцийн төсөл арга хэмжээний зураг төслийг 5 аймгийн 9 суманд (Завхан аймгийн Тэс, Цэцэн-Уул, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл аймгуудын Баяндэлгэр, Мянгад, Рашаант, Цагаан-Уул, Увс аймаг Давст, Түргэн, Наранбулаг);
- Эрүүл мэндийн төвийн барилгын нэг маягийн зураг төслийг Төв, Увс аймгуудын нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн, 2 аймгийн 2 суманд (Дорноговь аймгийн Эрдэнэ-12 ор, Булган аймгийн Дашинчилэн-15 ор) зориулан магадлалын дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэж өгсөн. Мөн Сумын төвийн гэр хорооллын инженерийн дэд бүтцийн зураг төслийг Увс аймаг Давст, Түргэн, Наранбулаг сумдад, Завхан аймгийн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн улсын чанартай авто замаас Идэр сум хүртэлх 12 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөл /Төв/-ийг боловсруулан 1280/2023 дугаар магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан.

2.1.13. Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.

2.1.13.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ.

Биелэлт: “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм” болон “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/212, 2023.08.10-ны өдрийн А/283 дугаар тушаалуудаар тус тус баталж, 2023 оны тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан тусламж, үйлчилгээний жагсаалтад тусламж, үйлчилгээний хүрээ тус бүрээр гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг тодорхой болгосон. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан хүрээнд нийцүүлэн тусламж, үйлчилгээний болон үйлдлийн жагсаалт, тусламж, үйлчилгээ үзүүлэх хэлбэр, насны бүлэг, давтамжийг өвчний олон улсын 10 дугаар ангиллаар коджуулан эрт илрүүлгийн товллол, нас, хугацаатай нийцүүлсэн.

АХБ-ны “Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-6”-ийн “Ядуу эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвийн өнөөгийн байдлын үнэлгээг 154 өрхийн эрүүл мэндийн төвд хийсэн байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нөөцийг үр ашигтай зарцуулах, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор хэвтээ (ӨЭМТ хооронд) болон босоо (ӨЭМТ, лавлагаа шатлал хооронд) интеграцлалын хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрүүдийг сонгон нэвтрүүлэхээр АХБ-ны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд нийслэлийн өрхийн эрүүл мэндийн зарим төвд хэрэгжүүлж байна.

2.1.13.2. Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ.

Биелэлт: “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, арга, журам”-ыг ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн журмыг шинэчилж ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор, ЭМДҮЗ-ын 13 дугаар тогтоолоор “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үлгэрчилсэн гэрээ, гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг, 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г тус тус батлан хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн анхан шатлалын байгууллага болох өрх, сумын Эрүүл мэндийн төвд гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлсэн буюу сар бүр 80 хувийн урьдчилгаа санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 20 хувийг хянаж олгохоор зохицуулсан бөгөөд ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолын дагуу 328 өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийг гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд бүрэн шилжүүлж, 2022 онд 497.4 (225.2+272.4) тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлсэн.

2.1.13.3. Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журам” батлагдсан.

Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, сэтгэл ханамжийн үнэлгээг хөндлөнгийн байгууллага АШУҮИС гүйцэтгэсэн бол АХБ-ны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний

өнөөгийн байдалд түргэвчилсэн үнэлгээг "Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хөгжил" зөвлөх багаар 2022 онд гүйцэтгүүлсэн байна. Судалгааны үр дүн:

- Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин ирэгсдийн урсгал хурдацтай нэмэгдсээр байгаа нь эрүүл мэндийн байгууллагуудын ачааллыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хүний нөөцийн, тоног төхөөрөмжийн хангамж, санхүүжилтийн бэрхшээл хүндрэлийг ихэсгэж байна;
- Лаборатори, оношилгоо шинжилгээ дутагдалтай, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хангалтгүй, хүний нөөцийн чадавх сул, хувийн хэвшил нь зохицуулалт муутай болон чанарын хяналт сул;
- Санхүүжилт хомс, байшин барилга, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хангалтгүй зэргээс шалтгаалан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ нь хөдөө орон нутагт багагүй бэрхшээлтэй тулгарч байна;
- Тусламж үйлчилгээний нэгдмэл загвар болон цахимжуулалт хөгжөөгүйгээс анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний уялдаа холбоо муу, салангид байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтын тогтолцоо бүрэн хөгжөөгүй, хувийн хэвшлийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна зэрэг гарчээ.

2.1.13.4. Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг шинэчилнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 04 дүгээр тогтоол, ЭМДҮЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоолыг нэгтгэж "Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх журам"-ыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор батлуулж, 04 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлсэн. Шинэчилсэн журмын дагуу нэг иргэнд ногдох нормативт зардлыг 2 дахин нэмэгдүүлж санхүүжилтийг олгож байна.

"Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх төлбөрийн арга, санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлуулж, 2023 оны 07 дугаар сарын 01-ээс хэрэгжүүлж эхэлсэн. Энэ шинэчилсэн тогтоолын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн сарын хуваарийг шинэчлэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/100 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. 2023 оны 12 сарын байдлаар 218 өрхийн эрүүл мэндийн төвд нэг иргэнээр тооцох санхүүжилт 118.1 тэрбум төгрөг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 17.2 тэрбум төгрөг, нийт 135.3 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн байна.

2.1.14. Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.

2.1.14.1. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалт (2022 онд 360.0 сая төгрөг) болон гадаадын зээл, тусламжийн (2022 онд 423.0 сая төгрөг) санхүүжилт буюу нийт 24.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй эрүүл мэндийн анхан шатны байгууллагыг (3 аймгийн 15 сум) үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгохоор төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

- БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА), НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн хүрээнд 3 аймгийн 11 сум, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 3 аймгийн 4 сум, нийт 3 аймгийн (Баянхонгор, Говь-Алтай, Завхан) 15 сумын эрүүл мэндийн төвд нүхэн жорлон ба сайжруулсан ариун цэврийн байгууламжийн санхүүжилтийг батлуулсан;
- 3 аймгийн 4 сумын (Баянхонгор аймгийн Заг, Говь-Алтай аймгийн Бугат, Хөхморьт, Завхан аймагт Цагаанчулуут) ариун цэврийн өрөөний өргөтгөл хийж, ариун цэврийн байгууламжийн сайжруулсан болон контейнер ашигласан ариун цэврийн байгууламж байгуулсан;
- Ус, ариун цэврийн байгууламжийн түргэвчилсэн үнэлгээний асуумжаар ЭМЯ, НЭМҮТ, МХЕГ хамтран 21 аймгийн 358 сумын Эрүүл мэндийн төвөөс 2022 онд авсан судалгааны дүнгээр “ЭМТ-ийн 76.5% нь нүхэн жорлон тогтмол ашигладаг, 13.1% нь хааяа ашигладаг, 2.0% огт ашигладаггүй бол 8.4% нь гадна нүхэн жорлонгүй байсан. Бүсээр харахад баруун бүсийн сумын ЭМТ хамгийн их буюу 89.2%, зүүн бүс 78.6%, хангайн бүс 78.1%, төвийн бүс 60 хувьд нүхэн жорлон тогтмол ашигладаг” гэж гарсан байна.
- Улаанбаатар хотод 5 өрхийн эрүүл мэндийн төв, орон нутагт 55 сумын эрүүл мэндийн төвийн хөрөнгө оруулалтыг 2023 оны улсын төсөв тусгаснаас 65% буюу 4 өрхийн эрүүл мэндийн төв, 33 сумын эрүүл мэндийн төв орчин үеийн ариун цэврийн байгууламжтайгаар ашиглалтад орж, үлдсэн нь 2024 онд ашиглалтад орохоор хүлээгдэж байна.

2.1.14.2. Сумдын эмнэлгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны А/174 тушаалаар “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээ”-ний хүрээнд сумдын эмнэлгийн ариун цэврийн байгууламжийг хоногт 6м³, 12м³ бохир ус цэвэрлэх бага хүч чадлын цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зураг төслийг боловсруулсан бөгөөд эрүүл мэндийн сайдын багцад нийт 24 тэрбум, үүнээс 2022 онд 3.0 тэрбум төгрөгийн санхүүжүүлэхээр батлагдсан.

Мөн газар хөдлөлийн 7, 8, 9 балл, гадна агаарын тооцооны хасах хэмд(-30°С, -35°С, -40°С)-д нийцүүлэн 6, өөр тэнхлэг бүхий (4х6м, 3.6х2.4м) хэмжээтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүний ариун цэврийн өрөө, 1 тн усны нөөцийн савтай, зоорьгүй, ± 0.00 түвшнээс дээш 1 давхар байрны нэг маягийн ажлын зураг төсөл батлуулсан.

Биеийн тамир, спорт

2.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.

2.2.1.1. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Эртэч, илүүдэл жингүй Монгол” хөтөлбөрийн хүрээнд иргэдийг насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн цахим гүйлт”, “Дасгал хөдөлгөөнөө хийцгээе”, “Цахим гимнастрада”, “Иргэдийн наадам-21”, “Өртөөт марафон” “Үнэгүй фитнес” арга хэмжээг төрийн болон төрийн бус 70 гаруй байгууллагатай хамтран зохион байгуулсан арга хэмжээнд 99,791 иргэн хамрагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигаар “Хүн амын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-д 21 аймаг, 9 дүүргийн 3-64 насны 347237 иргэн буюу хүн амын 10.1 хувийг хамруулж, 3-5, 6-8, 9-11, 12-17, 15-64 гэсэн насны ангиллаар хүний бие бялдрын таван чанараар (хурд, хүч, уян хатан, тэсвэр, авхаалж самбаа) MNS 5538:2005 стандартын дагуу авч А, В, С, D, F дүгнэхэд сорилд хамрагдсан иргэдийн 78.5% нь А, В, С хангалттай үнэлгээтэй гарсан бөгөөд энэ мэдээллийг “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын цахим сан бий болгох ажил бэлтгэл шатны гүйцэтгэлтэй байна.

БТСУХ-оос “Иргэдийн бие бялдрын ерөнхий хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох судалгааг 2023 онд 7471 хүнээс асуулга, антропометрийн хэмжилт аргаар 4 үе шаттай зохион байгуулсан бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн иргэнд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Мөн иргэдийн бие бялдарт тохирсон дасгал хөдөлгөөний жишиг хөтөлбөр боловсруулах ажлыг “БТСЧАЗН” төрийн бус байгууллага гүйцэтгэж байна.

2.2.1.2. Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлнэ.

Биелэлт: Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дадал олгох насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд сумдад орон тооны арга зүйчдийг үе шаттай нэмэгдүүлж байгаа бөгөөд 2021 онд 60, 2022 онд 63, 2023 оны байдлаар төвийн бүсэд 25, хангайн бүсэд 43, баруун бүсэд 40, зүүн бүсэд 20, нийслэлд 9, нийт 132 арга зүйч ажиллаж байна

2.2.1.3. Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2021 онд биеийн тамир спортын салбарын цахим сангийн сервер, тоног төхөөрөмжийг Үндэсний Дата төвд байршуулснаар салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийн хөгжүүлэлт хийх нөхцөл бүрдсэн буюу sport.gov.mn болон харьяа 31 байгууллага, статистикийн дэд систем болон үндсэн админ сpanel эрхийн нийт 34 домэйн хаягийг үүсгэн үндсэн сервер рүү холболт хийж, харьяа 31 байгууллага болон 15 холбоодод мэдээллийн цахим санд нэвтрэх эрх үүссэн. Салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн бүрдүүлэлт, ашиглалтын ажил хийгдэн олон талт хэрэглэгчдийн сургалт, нэвтрүүлэлтийг үе шаттай зохион байгуулж спортын цол зэргийн мэдээллийг цахим санд байршуулсан байна.

Нэгдсэн цахим сангийн хүрээнд техник хангамжийг бүрдүүлэн, төр ба төрийн бус байгууллагуудын ашиглагдаж байгаа мэдээллийн санг нэгтгэн спортын тэмцээн, наадмын систем, спортын цол, зэргийн систем, статистикийн дэд систем, сорилын систем, үндэсний шигшээ багийн дэд системийн хөгжүүлэлтийг тус тус хийж нэгдсэн байдлаар зохион байгуулан мэдээллийн сангийн үйл ажиллагааны хөгжүүлэлт хийгдэж байна. Спортын цол, зэргийн лавлагааг төрийн мэдээллийн нэгдсэн emongolia порталд холбох хэд хэдэн үе шат бүхий арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Үүнд:

- Спортын цолны системийг салбарын мэдээллийн нэгдсэн цахим санд нэгтгэх ажлыг зохион байгуулах ажлыг БТСУХ-ны даргын 2023 оны “Спортын цолны системийг салбарын мэдээллийн нэгдсэн цахим санд нэгтгэх тухай” А/11 дүгээр тушаалаар шийдвэрлэснээр нийт цолтой тамирчин болон шүүгчдийн мэдээллийг хуучин цолны системээс 2012 оноос хойш бий болсон 22299 хүний мэдээллийг салбарын нэгдсэн цахим санд шилжүүлэв;
- Спортын цол олгох үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлан хэрэгжих хүртэл хугацаанд шинэ системд үйлчилгээг олгохдоо хуучин эрх зүйн орчны хүрээнд спортын цолны үйлчилгээг хүргэхээр системийн засвар үйлчилгээг хийн тохируулах ажлыг зохион байгуулсан;
- ЦХХХЯ-тай “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”, “Танилт, нэвтрэлтийн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”, “Мэдэгдэл хүргэх систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г 2023 онд тус тус байгуулснаар дээрх системд холбогдох зохицуулалт, мэдээллийг Үндэсний дата төвд хүргүүлж хамтран ажиллаж холболтыг хийсэн болно.

2.2.1.4. Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгоно.

Биелэлт: Үндэсний болон залуучуудын шигшээ багийн цалин, орон тоог баталж спортын 25 төрөлд давхардсан тоогоор 488 хүнтэй (дасгалжуулагч 103, эмч 4, 381 тамирчин) гэрээ байгуулан ажлын байраар (цалин НДШ-ын зардал) хангаж байна. Төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, тайлант хугацаанд 173 холбоо, клуб, 120 төрийн бус байгууллагаар болон иргэдээр дамжуулан нийт 3,600 орчим түр ажлын байр бий болгон ажилласан байна. Үүнд:

- Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд сонгогдоогүй даам, туялзуур сэлэм, усан спортын төрлөөр 4 холбоодтой гэрээ байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн;
- 2022 онд иргэдийн дунд дасгалаар дархлааг дэмжих, зөв дадал хэвшилтэй иргэдийг бий болгох зорилгоор эрүүл зөв хооллолт, үндэсний наадгай, иог, цахим гүйлт, алхалт, дугуй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэр бүлийн орчинд дэмжих арга хэмжээг зохион байгуулж гүйцэтгүүлэхээр 33 төрийн бус байгууллагатай хамтран ажилласан;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан "Эрүүл Монгол хүн" өдөрлөгийг Баянхонгор аймагт хөл бөмбөгийн "Грассрүүтс" сургалт, хөл бөмбөгийн фестиваль, сагсан бөмбөгийн 3х3 сонирхогчдын тэмцээн, идэвхтэй хөдөлгөөний флэш мобил, сумын арга зүйч нарийн сургалтыг “Эерэг амьдрал Эрүүл нийгэм” нийгэмд үйлчлэх ТББ, хөл бөмбөг болон сагсан бөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулахад 6 хүнийг түр ажлын байраар хангаж хамтарч ажилласан;
- МҮСН, МОСН, МБАТН-аар шигшээ тэмцээнийг зохион байгуулах спортын төрлийн 63 холбоодтой ажил гүйцэтгүүлэх 67 гэрээгээр 1.2 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж;
- 2023 онд төрийн зарим чиг үүргийг 79 удаагийн спортын ажил, үйлчилгээ, тэмцээн, наадмыг 4.7 тэрбум төгрөгөөр шүүгчид, албаны ажилтны ажлын түр байр бий болгож,
- “Олимп, паралимпын наадамд бэлтгэн оролцуулахад улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ”-ний дагуу нийт 157 арга хэмжээнд зориулж 8.3 тэрбум төгрөг;
- Фитнес, иог, бүжиг, дартс, граунд гольф, софт волейбол, алхалтын клуб, граунд гольф, хөл бөмбөг, хөнгөн атлетикийн, уулын, дугуйн, бэрхшээлтэй иргэдийн

нэгдсэн төв, ТББ, Ахмадын хороо гэх мэт 23 төрлийн төрийн бус байгууллага, холбоо, клубүүдтэй хамтран ажиллав.

2.2.1.5. Үндэсний шигшээ багийн залгамж халааг сайжруулах, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх Залуучуудын шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Залуучуудын шигшээ багийг 2022 оны А/71, 2023 оны А/39 дүгээр тушаалуудаар тодорхой 48 орон тоотой (2021 онд 3 дасгалжуулагч, 15 тамирчин, 2022 онд 15 тамирчин, 2023 онд спортын 3 төрөлд 15 тамирчин) баталж төсвөөс цалин, тэмцээн уралдаан бэлтгэл сургалтын зардал санхүүжилтийг хариуцан ажиллаж байна. 2023 онд жүдо, чөлөөт, боксын төрөлд залуучуудын шигшээ баг байгуулж олон улсын болон улсын тэмцээнд оролцуулахад 53.03 тэрбум төгрөг зарцуулсан.

2.2.2. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.

2.2.2.1. Бөх, сурын харваа, шагайн харваа, морин болон тэмээн пөлогийн спортын төв байгуулах, үндэсний багтай болно.

Биелэлт: Үндэсний спортын төвд 8 үндэсний спортын задгай талбайг байгуулахаар төлөвлөж холбоодоос зураг төслийн даалгаварт тусгуулах талбайн стандарт хэмжээ, ерөнхий төлөвлөлтийн зургийн талаарх мэдээлэл ирүүлсэн ч ковид-19 цар тахлын улмаас хойшилсон, 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт шинэ төсөл, арга хэмжээ тусгахгүй гэсэн шийдвэртэй холбоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй болсон тул үндэсний спортын холбоодтой хамтран хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна

2.2.2.2. Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна.

Биелэлт: Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу “Монголын Оюутаны спортын наадам”-ыг 2 жил тутам зохион байгуулах хэдий ч Засгийн газрын 2021 оны 268 дугаар “Спортын наадмыг хойшлуулах тухай” тогтоолоор “Монголын бүх ард түмний спортын XV наадам”-ыг 2022 онд гэж тогтсоны дагуу тайлант хугацаанд дараах наадмууд зохион байгуулсан. Үүнд:

- 2022 онд Монголын оюутны спортын V наадам эхний хагас жилд спортын 10 төрлөөр 29 их, дээд сургуул 4500 тамирчин хамрагдаж амжилтаараа медаль хүртсэн 459 тамирчин, дасгалжуулагч холбогдох журмын дагуу 176.4 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон.
- Монголын үндэсний спортын наадмыг 4 жил тутамд нэг удаа зохион байгуулан шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 2,648 тамирчид 53 багц, 561 медалийн төлөө өрсөлдөхөд Монголын үндэсний спортын хороотой байгуулсан гэрээгээр 349.5 сая төгрөгийн зардал гаргаж медаль авсан 294 тамирчин, дасгалжуулагчдад 117.6 сая төгрөгийн шагнал олгоно.
- “Монголын бүх ард түмний спортын XV зуны спортын наадам”-ыг цар тахлын улмаас 2022 онд олимпын спортын 18 төрөл, оюуны спортын 2 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 6 төрөл, нийт 26 спортын төрөлд 4,500 гаруй тамирчид оролцож, 1,198 медалийн төлөө өрсөлдөхөд 1.2 тэрбум төгрөгийн мөнгөн шагнал олгосон;

- Биeийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2020-2024 онд мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Иргэдийн спортын наадмыг 2023 онд спорт явган аялал, орс таталт, сагсан бөмбөг, волейбол, софт волейбол, хийн дасгал, аэробик, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр 5 үе шаттай зохион байгуулахад 5 аймаг, 9 дүүргийн 171 хорооны 93 мянган иргэн оролцсон.

2.2.2.3. Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгоно.

Биелэлт: Үндэсний спортын брэнд наадмын үзэл баримтлал, зохион байгуулах хорооны бүрэлдэхүүн, соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, өв тээгчийг алдаршуулах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний уламжлалт спортын төрөл, тоглоом, наадгайг гадаад дотоодын аялал жуулчдад сурталчлах, шинээр хөгжиж буй үндэсний уламжлалт өв төрлүүдийг олон таниулах зорилгоор Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад Монголын Үндэсний спортын хороотой гэрээ байгуулан ажиллаж 21 аймаг, 9 дүүргийн 721 тамирчин, дотоодын үзэгч 3,440, гадаадын жуулчид, зочид 485 үзэгчид үзэж сонирхсон.

Үндэсний спортын тоглоом наадгайн төрөл болох шагайгаар тоглох спорт тоглоомыг түлхүү зохион байгуулах шийдвэрийг НҮБ-ын ЮНЕСКО-гийн Уламжлалт спорт, тоглоом наадгайн олон улсын зөвлөлөөс гаргуулахаар ажиллаж, үндэсний шагайн харваа, мөсөн сур спортын 2 төрлөөс ажлын даалгаварт тусгуулах санал авч олон улсын брэнд наадмыг зохион байгуулах хөтөлбөрийн төслийг боловсруулж байна.

2.2.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.

2.2.3.1. Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна.

Биелэлт: Засгийн газрын 2019 оны 315 дугаартай "Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 3 дахь заалтад "Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэнгийн төслийн иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулах, богино хугацаанд барьж байгуулан ашиглалтад оруулах асуудлыг хариуцан зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг 2020 оноос эхлэн улс, орон нутгийн төсөвт тусгаж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид" тусгайлан даалгасан хэдий ч Нийслэлийн засаг даргын тамгын газраас тус цэнгэлдэх хүрээлэнгийн газрын асуудлыг бүрэн шийдвэрлээгүй тул ТЭЗҮ боловсруулах боломжгүй байна.

2.2.3.2. Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 онд БНХАУ-д хийсэн албан айлчлалын хэлэлцэх асуудлын жагсаалтад спортын төв ордныг БНХАУ-ын буцалтгүй тусламжаар шинэчлэн барих асуудлыг оруулах хүсэлтийг хүргүүлсэн ч санхүүжилт шийдвэрлэгдээгүй болно. "Спортын төв ордны дахин төлөвлөлт хийх" зураг төслийн "Спортын төв ордны дахин төлөвлөлт хийх" загвар зураг, биет загвар" бүтээлийг сонгон шалгаруулах шагналын сан 30,000,000 төгрөг уралдааныг 3 дахь удаагаа зарлахаар (ажлын даалгавар шинэчлэн) бэлтгэж байна.

2.2.3.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор байгуулна.

Биелэлт: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор” барих ажлыг 2016 онд БНХАУ-ын Худалдааны яамны сайдын айлчлалын үеэр хэлэлцэн Монгол Улсын Гадаад хэргийн сайд, БНХАУ-ын Худалдааны яамны сайд нарын түвшинд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 20.4 сая ам.долларын төсөвт өртөгтэй барихаар үзэглэсэн бөгөөд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор” барих газрыг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/112 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 10 га газрын эзэмших эрхийн гэрчилгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 15 жилийн хугацаатай олгож, БНХАУ-ын талаас судалгааны баг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2.12-д санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтын 25 дугаарт төслийн нийт санхүүжилт 54.7 тэрбум төгрөгөөр батлагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны БНХАУ-д хийсэн айлчлалаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэний спорт цогцолборын төслийг цуцлан Хүүхэд, залуучуудын спорт цогцолборын төслийг хэрэгжүүлэхээр тохиролцож, Монгол Улсын Шадар сайдын БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр Хүүхэд, залуучуудын спорт цогцолбор буюу президент цогцолборт нэмэлтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх зорилгоор хэдэн спортын төрлийг нэмж оруулах талаар санал солилцож байна.

2.2.3.4.Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна.

Биелэлт: Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ гэрээ байгуулж ажил хийгдэж байгаа боловч ажлын гүйцэтгэлтэй уялдуулж санхүүжих дүнг бууруулж, Барилга угсралтын ажил Б блокийн каркас угсралтын ажил дууссан. В блокийн зоорины давхар 1-4 давхрын каркасны ажил гүйцэтгэсэн. 2021 онд 218.07 сая төгрөг гүйцэтгэлээр санхүүжсэн ба 2022 онд ажил хийгдээгүй. 2023 онд төсөвт тусгагдаагүй царцсан. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа дууссан. Гэрээ сунгах эсэх, цуцлах мэдэгдэл хүргүүлэхээр бэлтгэж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.

2.2.3.5.Нийслэлийн болон Налайх, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна.

Биелэлт: Нийслэлийн болон 4 дүүргийн спортын цогцолборын ажлын явц дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Баянгол дүүрэг, 700 суудалтай спорт цогцолборын санхүүжилт 401.5 сая төгрөг, 2022 ашиглалтад оруулсан;
- Налайх дүүрэг, 700 суудалтай спорт цогцолборын санхүүжилт 1.3 тэрбум төгрөг, барилга угсралтын ажил 97 хувийн гүйцэтгэлтэй;
- Баянзүрх дүүргийн спорт цогцолборын санхүүжилт 1.2 тэрбум төгрөг, барилга угсралтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Гадна тохижилтын ажлууд хийгдэж, бассейны тоног төхөөрөмжийн;
- Сүхбаатар дүүрэг, 1000 суудалтай спорт цогцолборын олгосон санхүүжилт 218

сая төгрөг, барилга угсралтын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй буюу Б блокийн каркас угсралтын ажил дууссан, В блокийн зоорины давхар 1-4 давхрын каркасны ажил гүйцэтгэсэн бөгөөд 2023 онд гэрээний хугацаа дууссан тул гэрээ цуцлах мэдэгдэл хүргүүлсэн;

2.2.3.6. Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар аймагт шинээр спортын цогцолбор барина.

Биелэлт: 3 аймгийн спортын цогцолборын ажлын явц дараах гүйцэтгэлтэй байна.

Үүнд:

- Сүхбаатар аймаг, Баруун-Урт сумын спорт цогцолборын барилга угсралтын ажил 80 хувьтай буюу дээврийн төмөр угсралтын ажил хийгдэж, дээврийн дүүргэлтийн ажил, дотор заслын ажлууд хийгдэж байна;
- Дундговь аймаг, Сайнцагаан сумын усан бассейн бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажил 40 хувьтай буюу 4.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон, хучилт, багана, дам нуруу, шалны төмөр бетоны ажил хийгдэж байна;
- 2022 оны 03 дугаар сард Спорт цогцолборын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/ барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Их Модун” ХХК-тай гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

2.2.3.7. Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв байгуулна.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны “Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Буянт-Ухаа спортын ордныг “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ААТҮГ-т нэгтгэх зохион байгуулалтын ажил хийгдэж байна. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар “Буянт-Ухаа” спортын ордонд 30 орчим тэрбум төгрөгийн хөрөнгөөр гадна, дотор иж бүрэн засвар, барилгын дэд бүтцийг шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд улсын комисс ажиллаж байна.

2.2.3.8. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны А/169 дүгээр тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталдаг бөгөөд жагсаалтад заасан сум болон аймгийн төвд баригдах спортын заал, усан бассейн бүхий спорт цогцолборыг нэг маягийн зураг төсөл Барилгын хөгжлийн төвөөр батлуулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- 2019 оноос эхлэн он дамжин хэрэгжиж байгаа спорт заалны 48 барилгаас 2023 онд 22 спорт заал бүрэн ашиглалтад оруулсан;
- Сумын төвийн усан бассейн бүхий спорт цогцолборын 2 барилгын 2014 онд батлагдсан нэг маягийн зургийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулахаар холбогдох судалгааг хийж байна.
- 2024 онд 18.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 7.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 8 спорт заалны барилга хэрэгжихээр туссан бөгөөд 50 хувийг нэг маягийн зургаар хэрэгжүүлэхээр байна.

Боловсрол

2.3. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.

2.3.1.Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2 нас, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.3.1.1.Яслийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.5-д "Гурав хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсролын, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.", Засгийн газрын "Яслийн үйлчилгээг зохион байгуулах зарим арга хэмжээний тухай" 2020 оны 223 дугаар тогтоол, БШУС, ЭМС, ХНХС-ын 2022 оны хамтарсан тушаалаар "Нялх балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр", 2023 оны хамтарсан тушаалаар "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)", "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө" тус тус батлуулан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд хоёр хүртэлх насны 138,264 хүүхэд байгаагаас 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2 хүртэлх насны 2763 хүүхэд буюу 2% нь цэцэрлэгийн 111 бүлэгт хамрагдаж байна. Үүнээс: төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа 244 хүүхдийн хувьсах болон хоолны зардлыг төрөөс, хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа 2519 хүүхдийн хувьсах болон хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагч нар бүрэн хариуцаж байна. Яслийн бүлгийн хамрагдалтыг тайлант хугацаанд 2538, 48, 2907, 2763 хүүхэд хамрагдсан байна.

2.3.1.2.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газар үе шаттайгаар хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчид болон эцэг эх асран хамгаалагчид 0-3 хүртэлх насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд зориулсан "Нялх балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр", засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоолоор "Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох" журам, 2022 оны 218 дугаар тогтоолоор "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай", ХНХС-ын 2022 оны А/38 тоот тушаалаар "Хүүхэд харагч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр", 2022 оны А/151 дугаар "Журам батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралтаар "Хүүхэд харах үйлчилгээний шалгуур болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам" шинэчлэн баталсан.

"Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль"-д нэмэлт өөрчлөлтөөр хүүхэд харах үйлчилгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чиг үүрэгт шилжүүлсэн бөгөөд үүргийн биелэлт:

- 2021 онд 2818 хүүхдэд зайнаас хөгжлийг дэмжих үйлчилгээ;
- 2022 онд хүүхэд харах үйлчилгээний зардалд 1894 хүүхэд (106 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд) 2.1 тэрбум төгрөгөөр батлуулж, 16 аймаг, 7 дүүрэгт 176 хүүхэд харах төвд 470 хүүхэд харагч ажиллаж, хамрагдсан нийт хүүхдийн дундаж 2200 байна. Засгийн газрын 2022 оны "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 218 дугаар тогтоолын хэрэгжилт БШУС, ХНХС-ын 2022 оны А/145, А/261 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан ажлын хэсэг нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж багатай Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт

хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, 2-3 настай 2000 хүүхдийг нэмж авахаар шийдвэрлэн шинээр 320 хүүхэд харагч 5 өдрийн сургалтад хамруулж бэлтгэсэн;

- 2022-2023 оны хичээлийн жилд улсын хэмжээнд төрийн болон төрийн бус өмчийн ясли, цэцэрлэгт нийт яслийн насны 2988 хүүхэд хамруулсан байна.

2.3.2. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

2.3.2.1. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах насыг 3-5 нас болгон хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулахаар хуульчилж эрх зүйн орчныг бүрдүүлсэн. (БЕХ 40.2.2, СӨБЕБТХ.4.3) бөгөөд тайлант хугацааны хэрэгжилт:

- 2021-2022 оны хичээлийн жилд "КОВИД-19" цар тахлын онцгой нөхцөл байдлын улмаас халдварын тархалтаас сэргийлэх дэглэмийг баримтлан 4-5 настай хүүхдийг танхим, 3 настай хүүхдийг зайны сургалтад хамруулсан. Нийт 1453 цэцэрлэгт 182,189 (80%) хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Үүнээс 3 настай 47,551 (61.9%), 4 настай 63,623 (86.2%), 5 настай 71,015 (91.2%) тус тус хамрагдсан;
- 3-5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор дараах "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт зохион байгуулах журам"-ыг 2022 онд батлан хөдөөгийн сум болон тосгоны цэцэрлэгт хувилбарт сургалтын үндсэн багш ажиллуулж, 2022-2023 оны хичээлийн жилд хувилбарт сургалтад 15,533 хүүхэд хамрагдсан. "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тухай" 2022 оны 218 дугаар тогтоолын хүрээнд цэцэрлэгийн зориулалтаар байр түрээслэх, хувийн өмчийн цэцэрлэгийн сул орон тоонд хүүхэд элсүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага дэргэдээ цэцэрлэг байгуулах санаачилгыг дэмжих, орчин үеийн шинэ дэвшилтэт технологи ашиглан гэр цэцэрлэг байгуулах, ачаалал өндөртэй хороодын хувийн өмчийн цэцэрлэгт хувьсах зардлыг хоёр дахин нэмэгдүүлж өгөх, хоолны зардал олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нийслэлийн 3-5 насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 92.4 хувьд хүрлээ. Дээрх цогц арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд 3-5 насны 206,150 хүүхэд буюу 90.4% нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулсан;
- Улсын хэмжээнд 3-5 насны 230,536 хүүхэд байгаа ба 2023-2024 оны хичээлийн жилд 213,869 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, хамран сургалт 92.7 хувьд хүрсэн бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 6 аймагт хүртээмжийг нэмэгдүүлэх талаар зөвлөмж, чиглэл хүргүүлж, зөвлөн туслах ажлыг үе шаттай зохион байгуулав. (Баян-Өлгий, Булган, Дундговь, Дорноговь, Сэлэнгэ, Хөвсгөл аймгууд 70 гаруй хувь хамрагдалтай байсан бол 2023-2024 оны хичээлийн жилд 3-10 хувиар нэмэгдэж, 3-5 нас хамран сургалт 92.7 хувь, 5 настай хамран сургалт 94.8 хувьтай)

2.3.2.2. Сургуулийн өмнөх боловсролд 5 настай хүүхдийг бүрэн хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг жил бүр хийнэ.

Биелэлт: Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулахаар хуульчилж эрх зүйн орчныг бүрдүүлсэн. (БЕХ 40.2.2, СӨБЕБТХ.4.3)

- Улсын хэмжээний таван настай хүүхдийн мөшгөх судалгааг хийж, судалгааг үндэслэн төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд улсын хэмжээнд 5 настай 77,115 хүүхэд байгаагаас 2023-2024 оны хичээлийн жилд 73,085 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 94.8 хувьд хүрч, өмнөх хичээлийн жилээс 1.3 хувиар нэмэгдсэн. Энэхүү үзүүлэлт нь сургуульд бэлтгэгдсэн байдлыг 1.3 хувиар өсгөсөн үр дүнтэй байна.
- БШУС-ын 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журмын дагуу сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг 3 дахь жилдээ зохион байгуулсан:
- 2021 онд 23,462, 2022 онд 59,382, 2023 онд 71,824 сурагч тус тус хамруулсан. Тус үнэлгээнд 2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийн нэгдүгээр ангид элсэн суралцаж буй бүх хүүхдийг хамруулсны үр дүн хамрагдалт 2021 онд 60.7 хувь, 2022 онд 72.9 хувь болж 12.2 хувиар нэмэгдсэн бол 2023 онд 70.2 хувь болж 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Үнэлгээний ерөнхий үр дүн, нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаанд үндэслэн нарийвчилсан шинжилгээ хийж, цаашид үнэлгээний даалгавар, арга зүй, хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн чадварыг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулав.

2.3.2.3. Малчин болон алслагдсан хязгаар бүсэд амьдарч буй өрхийн 3-5 насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж, хөгжлийг дэмжинэ.

Биелэлт: Улсын хэмжээнд малчин өрхийн 47,221 хүүхэд байгаагаас 2023-2024 оны хичээлийн жилд 34,888 (73.8%) хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, өмнөх жилээс 2.6 хувиар өссөн. Мөн малчин өрхийн 2-5 хүртэлх насны хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт сүүлийн 3 жил тогтмол нэмэгдэж байна. (2020-2021 оны хичээлийн жилд 17,141, 2021-2022 оны хичээлийн жилд 30,102, 2022-2023 онд 33,650 хүүхэд хамрагдсан)

Цэцэрлэгийн сургалтын болон гал тогооны зориулалтай 699.7 сая төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн 54 хос (сургалт болон гал тогооны зориулалттай) гэр цэцэрлэгийг сумын 54 цэцэрлэгт нийлүүлсэн болно. Гэр цэцэрлэг хуваарилах, цэцэрлэгийг сонгохдоо өнгөрсөн хичээлийн жилд хувилбарт сургалтын хүүхдүүд хамгийн олон хамрагдаж байгаа, одоо ашиглаж байгаа "Гэр цэцэрлэг"-ийн ашиглалтын хугацаа, нүүдлийн бүлэг ажиллуулдаг сумын цэцэрлэгүүдийн судалгаанд үндэслэн олгосноор малчин өрхийн хүүхдүүд гэрт ойр "Нүүдлийн бүлэг"-т буюу хилийн заставд байгаа 2-5 хүртэлх насны хүүхдүүд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсрол эзэмших нөхцөл боломж бүрдүүлсэн.

2.3.2.4. Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулж, тэдэнд боловсрол, эрүүл мэнд, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлнэ.

Биелэлт: Улсын хэмжээнд цогц дэмжлэг шаардлагатай 2-5 хүртэлх насны 9,328 хүүхдээс 2023-2024 оны хичээлийн жилд боловсролыг дэмжих үйлчилгээнд 98.2% буюу 9163 хүүхдийг хамруулсан бөгөөд үүнээс хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн 2,055 хүүхдийг 24 цагийн үйл ажиллагаатай 32 цэцэрлэгийн 72 бүлэгт хамруулсан байна. 24 цагийн үйл ажиллагаатай бүлэгт тайлант хугацаанд буюу 2020-2021 оны хичээлийн жилд 2,226, 2021-2022 оны хичээлийн жилд 1,496, 2022-2023 оны хичээлийн жилд 2,038 хүүхэд тус тус хамруулав.

2023.11.30-ны өдрийн А/508 дугаар тушаалаар батлагдсан "Цэцэрлэгийн

үлгэрчилсэн дүрэм“-д 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэг, бүлгийн хүүхдийн бүртгэл, элсэлтийг зохион байгуулах, сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хүүхэд хамгааллын асуудлыг зохицуулснаар тус цэцэрлэг, бүлгийн сургалтын чанарт ахиц гарч, зайлшгүй хамгаалал, дэмжлэг шаардлагатай хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах эрх зүйн орчин бүрдэж байна.

Мөн 24 цагийн бүлэгтэй цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сан МУБИС-ын багш нар хамтран багш, ажилтнуудад зориулсан "Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих зөвлөмж, гарын авлага, "Эцэг эхтэй харилцах дэвтэр", эцэг эх асран хамгаалагчдад зориулсан цахим зөвлөмж боловсруулан, тэдэнд зориулсан сургалтыг үе шаттай зохион байгуулан үйлчилгээний чанарыг сайжруулах, хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга зүйгээр хангаж ажиллав. "24 цагийн цэцэрлэгийн хүүхдэд ээлтэй байдал" судалгааны үр дүнд үндэслэсэн 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн багш, ажилтнуудад сургалт зохион байгууллаа. Ингэснээр 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэг нь "Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээний аргачлал"-ын дагуу өөрийн үнэлгээ хийж, үнэлгээнд суурилсан хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

2.3.2.5.Цэцэрлэгийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж, цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулна.

Биелэлт: Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, суралцах чадамжид суурилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хүрээнд дараах ажлуудыг хийсэн:

- "Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах түр журам" БШУС-ын 2021 оны А/214, "Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулахад мөрдөх журам" 2022 оны А/274 дүгээр тушаалаар тус тус баталснаар цэцэрлэгийн багшийн ажлын ачааллыг бууруулах, өөрийгөө хөгжүүлэх, гэр бүл, эрүүл мэнддээ цаг гаргах, хөдөлмөрийн тухай хуульд заасан ажлын 8 цагаар ажиллах, багшийн өөрийн хүсэлтэд тулгуурлан ээлжийн багш ажиллуулах эрхзүйн орчин бүрдсэн бөгөөд хэрэгжилт нь Орхон аймаг, Төмөр замын цэцэрлэгт 2022-2023 оны хичээлийн жилд 47, 2023-2024 оны хичээлийн жилд 44 багш байна;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж буй 331 багшийг мэргэжүүлэх сургалтад хамруулсан;
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр 4952 багш, удирдах ажилтныг сургалтад хамруулан мэргэшүүлсэн (Японы Тоёо их сургууль, НҮБ-ын Хүүхдийн сан, Жайка Старт 2 төслийн дэмжлэг);
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, ажилтанд зориулсан "Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй" гарын авлагыг боловсруулан хэвлүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа 320 багшид хүргүүлсэн;
- Сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулж, 2023 оны хичээлийн жилээс "Тэгш хамруулах боловсрол" (сонгон судлах) хичээлийг 3 кр, Багшийн туслах бэлтгэх хөтөлбөрт "Тусгай хэрэгцээт боловсрол"-оор 1 кредитийн агуулгыг судлуулахаар тусгасан;
- ЖАЙКА Олон улсын байгууллагын "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл" II шатны Зорилт II-ын хүрээнд Төв аймгийн "Унагалдайн андууд", Нийслэлийн Хан-Уул дүүргийн 12-р цэцэрлэгт "Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах үйлчилгээний загвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар"-ыг боловсруулан туршилтаар хэрэгжүүлж байгаа бөгөөд бэлтгэгдсэн багш нарын

хариуцсан бүлэгт 904 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

2.3.2.6.Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

Биелэлт: 0-5 насны хүүхдийг эрүүл өсгөн бойжуулах, эрхийг хамгаалах, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн цогц хөгжлийг дэмжихэд тэдний нас, хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээг үзүүлж, хүүхэд аюулгүй, ээлтэй гэр бүл, нийгмийн орчинд өсөж, хөгжих боломжийг бүрдүүлэх зорилготой “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр” баримт бичгийн төслийг 2020 онд боловсруулж, “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)”, “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г БШУС, ЭМС, ХНХС-ын 2023 оны А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалаар баталсан.

“Бага насны хүүхдийн цогц хөгжил” арга хэмжээний баримт бичгийн төслийг боловсруулахтай холбогдуулан НҮБ-ын Зүүн ази, Номхон далайн бүсийн зөвлөхийг Монгол Улсад урьж ажиллуулан, Монгол Улсад бага насны хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудыг нэгтгэн “Бага насны хүүхдийн цогц хөгжил, боловсролын сүлжээ” (ECED Network Mongolia)-г байгуулж, 4 удаагийн хэлэлцүүлэг зөвлөгөөн болон Үндэсний сүлжээ байгууллагууд БШУЯ, БЕГ, ХНХЯ, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран “Бага насны хүүхдийн хөгжилд эцэг, эх асран хамгаалагчдын оролцоо, дэмжлэг” сэдэвт сургалт хэлэлцүүлгийг 2023 онд зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллагын 48 оролцогч хамрагдсан.

2.3.3.Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.

2.3.3.1.Суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийнэ.

Биелэлт: Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний гол үзүүлэлт нь суралцагчийн мэдлэг, чадварын ахиц, үр дүн байх тул ахиц өөрчлөлтийг үнэлэх суралцагчийн гүйцэтгэл, асуулга, судалгааг цахимаар зохион байгуулж, үндэсний хэмжээнд нэгдсэн арга зүйгээр дүн шинжилгээг тогтмол хийж хэвшсэн.

2021 онд “Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA-2022” туршилтаар, 2022 онд бага ангийн суралцагчдын ахицын үнэлгээнд 21 аймаг, 9 дүүргийн 641 ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн 244480 суралцагч (давхардсан тоо), 2023 онд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээг багшийн болон байгууллагын үнэлгээний бүрэлдэхүүнд оруулан, бичгийн шалгалтаар үнэлж байна. Гүйцэтгэлийн үнэлгээг 2023 онд ерөнхий боловсролын 681 сургууль, 28382 багш, 912 мянган суралцагчийг хамруулан зохион байгуулав.

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээ буюу суралцагчийн мэдлэг, чадварын даалгаврын гүйцэтгэл 2022 онд 51.1 хувь, 2023 онд 53.5 хувь болж 2.4 хувиар өссөн ба тусгай сургууль, цэцэрлэг, багшийн ажлын гүйцэтгэлийг ердийн сургууль, цэцэрлэгийн адил шалгуур, үзүүлэлтээр үнэлж дүгнэсэн. Суралцагчийн үнэлгээний үр дүнд хөндлөнгийн хяналт хийхэд зориулсан цахим үнэлгээний системийг Боловсролын үнэлгээний төв дээр бүрдүүлж ашиглалтад орууллаа. Энэхүү системээр монгол хэл, суралцагчийн математикийн хичээлийн улирал, жилийн эцсийн үнэлгээний бодитой байдлыг төрийн байгууллага болон эцэг эх, асран хамгаалагч хөндлөнгөөс хянах боломжийг бүрдүүлсэн.

2.3.3.2.Бага, дунд боловсролын чанарыг үнэлэх судалгааг жил бүр зохион байгуулж, хариу арга хэмжээ авна.

Биелэлт: “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээг сонгогдсон сургуулиуд дээр зохион байгуулсан. Чанарын үнэлгээний судалгаанд чадвар үнэлэх үнэлгээний даалгавар, хичээл ажиглалтын хуудас, орчны ажиглалтын хуудас, асуулга, ярилцлага зэрэг аргыг ашиглан зохион байгуулсан. Үүнд:

- VI, X, XII ангийн суралцагчид, МБСБ-ын 2,3-р курсийн суралцагчдаас түүврийн аргаар сонгож, бага боловсролын түвшнийг үнэлэхээр VI ангид суралцагчдын 12%, суурь боловсролын түвшнийг үнэлэхээр X ангид суралцагчдын 13.5%, бүрэн дунд боловсролын түвшнийг үнэлэхээр XII ангид суралцагчдын 14.7%, МБСБ-ын 2,3-р курсийн 19.7 хувийг хамруулсан.
- Чанарын судалгаанаас гадна сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээг багшийн болон байгууллагын үнэлгээний бүрэлдэхүүнд оруулан, бичгийн шалгалтаар үнэлэхдээ цаасан болон нийслэлийн 7 дүүргийн 47 сургуулийн 12 дугаар ангийн 2380 суралцагчийн шалгалтыг таблет ашиглан зохион байгуулсан.
- Боловсролын чанарын үнэлгээний нэгдсэн дүнгээр 37 хувьтай үнэлэгдсэн, цаашид бага, дунд боловсролын чанарын үнэлгээг 3 жил тутамд зохион байгуулж байхаар Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу 2023-2024 оны хичээлийн жилийн боловсролын чанарын үнэлгээний хугацаа хойшилсон.
- “COVID-19” цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан боловсролын чанарын үнэлгээг суралцагчдын хоцрогдлыг тодорхойлох зорилго бүхий “оношлох болон сургуульд суурилсан үнэлгээ” хэлбэрээр 10 судлагдахууны давхардсан тоогоор 73 ангийн, сургуульд суурилсан үнэлгээний 135 ангийн ерөнхий болон дэлгэрэнгүй блюпринтийг боловсруулж 219 даалгавар зохиогч, эксперт нарт даалгавар зохиох арга зүйн сургалт зохион байгуулсан бөгөөд үр дүнгийн тайланг 10 судлагдахууны 1-12 ангийн 64 өгөгдлийн санд SPSS, Testan, MS Excel программ ашиглан боловсруулалт хийж, асуулга судалгаатай холбон шинээр 128 өгөгдлийн сан үүсгэсэн.

2.3.3.3.Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын (PISA) үнэлгээнд хамрагдана.

Биелэлт: Монгол улс 2020 оноос дэлхийн эдийн засгийн байгууллага (OECD)-аас зохион байгуулдаг “PISA-2022” олон улсын үнэлгээнд оролцохоор бэлтгэл хангаж, 2022 онд анх удаа PISA олон улсын үнэлгээнд хамрагдлаа. “Сурлагын амжилтын олон улсын үнэлгээ PISA-2022”-нд дэлхийн 81 орны хагас сая гаруй 15-16 насны сурагчдын 7276 нь Монгол Улсын 7-12 дугаар ангийн сурагчид байв. Олон улсын PISA үнэлгээний Монгол Улсын зарим үр дүнгээс дурдвал:

- 81 орноос математикийн чиглэлээр 425 оноо авч, 47 дугаарт;
- Амьдралын сэтгэл ханамж буюу сургууль, сурах үйлдээ хандах хандлагын хувьд монгол сурагчдын түвшин 7.2 буюу OECD-ийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй;
- Монголын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал сайтай суралцагчдын математик чадвар боломж тааруу суралцагчдаас 94 оноогоор илүү;

“PISA-2022”-нд хамрагдсанаар: өөрийн орны боловсролын чанар, үр дүнгээ дэлхийн улс орнуудтай харьцуулан боловсролын тогтолцооны давуу, сул талыг харьцуулан дүгнэж, хүний нөөц болон байгууллагын хөгжлийг дэмжих, сургалтын чанарыг ахиулах бодлого боловсруулахад үндэслэл болохуйц стандарт үзүүлэлт, баримт мэдээлэлтэй болсон үр

дүнтэй байна. Үнэлгээний үр дүнг нэгтгэх асуудлаар OECD байгууллагад 2023 оны 5-9 дүгээр сарыг дуустал Монгол Улсаас 2 шинжээчийг ажиллуулж, үнэлгээний мэдээлэл боловсруулах ажилд оролцсон. “PISA-2022” олон улсын үнэлгээний байгууллагын дүрмийн дагуу боловсролын байгууллагууд, судлаачид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад тус үнэлгээний зорилго, ач холбогдол, үнэлгээний зохион байгуулалтын талаар танилцуулах сургалтыг зохион байгууллаа.

2.3.3.4.Их, дээд сургуульд элсэх шалгалтыг сургалтын хөтөлбөрт суурилан зохион байгуулж, ахлах ангийн сургалтын зарим агуулгыг их, дээд сургуулийн багц цаг (кредит)-д тооцуулах зохицуулалтыг бий болгоно.

Биелэлт: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/540, 2023 оны ЭЕШ-ын журам батлах тухай” Боловсролын үнэлгээний төвийн захирлын А/10 дугаар тушаалын хүрээнд 2022 оноос их дээд сургуульд элсэгчдээс авах ЭЕШ-ыг жилд 2 удаа (6, 12-р сар) зохион байгуулж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг шинээр боловсруулан ахлах ангийн судлагдахууны хөтөлбөр нь кредитийн мэдээлэл, дүйцүүлэх, хөрвүүлэх аргачлалыг багтаасан байхаар тусгасан. Боловсролын багц хуульд “Ахлах ангийн сургалтын хөтөлбөр нь заавал судлах болон сонгон судлах хэлбэртэй байна”, “Ахлах сургууль нь сургалтын хөтөлбөрийн онцлогоос хамааран төрөлжиж болно”, “Ерөнхий боловсролын сургуулийн бүтцэд ахлах сургууль байх ба бүсийн болон аймаг сум дундын байж болно”, “сургуулийн бүтцийг тогтооход хөгжлийн бодлого төлөвлөлт, хүн амын нягтаршил, газарзүйн байршил зэрэг хүчин зүйлийг харгалзана” гэж заасны дагуу ахлах сургуулийг хөгжүүлэх хувилбарыг судалж, нийслэлийн 1, орон нутгийн 1, их дээд сургуулийн харьяа 1, мэргэжлийн боловсролын сурталтын байгууллагын дэргэд 1, нийт 4 сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд төрөлжсөн ахлах сургуулийн хувилбарыг туршихаар БШУС-ын 2023 оны А/456 дугаар тушаалаар шийдвэрлэсэн. 2023 онд олон улсын шалгалтын үнэлгээг Монгол Улсын элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэх хүсэлт гаргасан 1,302 шалгуулагчийн 5 хичээлийн 2097 шалгалтын үнэлгээг дүйцүүлэн тооцов.

2.3.3.5.Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам", олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлж Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-д ЕБС-ийн сурагчдын дунд олон улс (математик, биологи, газар зүй, физик, мэдээлэл зүй, хими, Менделеевийн олон улсын химийн олимпиад)-ын болон тивийн (Азийн физикийн олимпиад, Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл зүйн олимпиад) хэмжээнд зохион байгуулагддаг олимпиадад амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулахаар тус тус тусгасан бөгөөд эдгээрийн хэрэгжилт нь:

- Олон улсын олимпиадаас медаль хүртсэн сурагчид дэлхийн тэргүүлэх 100-д багтдаг их, дээд сургуульд элсэх эрх авснаар “Ерөнхийлөгчийн илгээлт 2100” тэтгэлэгт хамрагдах боломжтой болсон;
- 2021 онд олон улсад зохион байгуулагдсан математик, хими, биологи, физик, мэдээлэл зүйн олимпиадад оролцож амжилт үзүүлсэн 15 хүүхдэд энэхүү сангаас 25.0 сая төгрөгийн урамшуулал олгосон;

- 2022 онд улсын олимпиадад Биологи, Математик, Хими, Мэдээлэл зүй, Физик хичээлээр оролцох 13 багш, 23 сурагч нийт 36 хүний 236.9 сая төгрөгийн төсөв баталж, 23 суралцагчдад мөнгөн урамшуулал олгосон;
- 2023 онд олон улсын олимпиадаас медаль хүртсэн сурагчид болон сурагчдаа амжилттай бэлтгэсэн олимпиадыг зохион байгуулах хороодод Монгол Улсын Ерөнхийлөгч нэрэмжит шагналыг олгосон (олон улсын олимпиадаас алтан медаль авсан сурагчид 11 сая, мөнгөн медаль авсан сурагчид 7 сая, хүрэл медаль авсан сурагчид 4 сая, тусгай байр эзэлсэн сурагчийг 1 сая төгрөгөөр, сурагчдаа амжилттай бэлтгэсэн Монголын олимпиад зохион байгуулах хороо тус бүрийг 10 сая төгрөг)

2.3.3.6.Ерөнхий боловсрол дахь эцэг эхийн үүрэг, оролцоог сайжруулна.

Биелэлт: Ерөнхий боловсрол дахь эцэг эхийн үүрэг, оролцоог сайжруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль болон Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, оролцоог (i) боловсролын чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах (ii) сурах бичиг зохиох (iii) төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал (iv) суралцагчийн хөгжил, хамгаалал, төлөвшил, аюулгүй байдлыг хангахад тус тус эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг авах, хамтран ажиллах талаар тусгав;
- Сургуулийн үйл ажиллагаа болон багшийн ажлыг үнэлэх, дүгнэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн оролцоотой үнэлэх зохицуулалтын хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилд 715,421 эцэг эх, асран хамгаалагч үнэлгээнд оролцсон байна;
- Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүй, хөгжил, төлөвшил, хамгааллын талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг хэлэлцэх зорилгоор хамтдаа хамгаалъя уриан дор "Боловсрол ба эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоо" цахим зөвлөгөөн 2023 онд зохион байгуулсан;
- БШУС-ын 2022 оны А/463 дугаар тушаалаар "Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд баримтлах заавар"-ын дагуу төрийн өмчийн 600 гаруй сургууль эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой орчны эрсдэлийн үнэлгээ хийсэн;
- Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлж буй ерөнхий боловсролын 30 сургууль дээр цогц арга хэмжээг хэрэгжүүлсний дүнд 30 сайн туршлага бий болгож, түгээн дэлгэрүүллээ. 6. Эцэг эхийн, хүүхэдтэй ажиллах арга, хандлагын ялгаатай байдлыг арилгах, бүтээлч оролцоог нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагааг давхардсан тоогоор 240 мянга орчим эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүргэж ажиллалаа.

2.3.4.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.

2.3.4.1.Боловсролын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, үзэл баримтлал

боловсруулан түүнийг сургалтын хөтөлбөрт тусгана.

Биелэлт: Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд “Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” боловсруулах зохицуулалт шинээр нэмэгдсэн (10.1-д “Сургалтын хөтөлбөр үзэл баримтлалтай байх бөгөөд уг үзэл баримтлалыг Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Боловсролын үндэсний зөвлөл хэлэлцэж, Засгийн газар батална) бөгөөд энэ чиглэлд хийсэн ажил:

- 2023 онд сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, түүнд монгол хүүхдийн дүр төрх, монгол хүүхдийг хүмүүжүүлж төлөвшүүлэх монголын соёл, зан заншил, үндэсний өв уламжлал, нэгдмэл үнэт зүйлс, эх түүхийн агуулгыг тусгахдаа боловсролын бодлого боловсруулагчид, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, судлаачид, эцэг эх, олон нийтийн төлөөлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох удирдах ажилтан, зөвлөх зэрэг 1200 гаруй хүнд танилцуулж, хэлэлцүүлэг хийсэн;
- Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын одоо хүчин төгөлдөр мөрдөж буй I-XII ангийн 65 багц сургалтын хөтөлбөр, 33 нэр төрлийн 174 сурах бичигт 2022-2023 онд хийсэн шинжилгээний үр дүнгээр сургалтын хөтөлбөрийг 2024 оноос эхлэн сайжруулахаар төлөвлөв.

2.3.4.2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг шинэчилж, сургалтад ашиглах нээлттэй нөөц материал, цахим агуулгыг бий болгоно.

Биелэлт: Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлагыг БШУС-ын 2022 оны А/375 дугаар тушаалаар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын 2022 оны "Сургалтын хэрэглэгдэхүүний жишиг жагсаалт батлах тухай" А/70 дугаар тушаалаар жишиг жагсаалт баталснаар улсын хэмжээнд сургалтын хэрэглэгдэхүүний судалгааг нарийвчлан гаргаж цаашдын хангалтыг дээрх шаардлагад нийцүүлэн хийхээр ажиллаж байна.

Medle.mn сургалтын платформд суурилан 2023-2024 оны хичээлийн жилд ахлах ангийн сонгон судлах хичээлийг 476 сургуулийн 15,615 сурагч (10 дугаар ангийн 9,003, 11 дүгээр ангийн 6,612) сонгон суралцаж, 282 багш 10 дугаар ангийн 571 бүлэг, 11 дүгээр ангийн 453 бүлгийг удирдан цахимаар хичээллэж байна. 2023 оны байдлаар "Medle" цахим контентын санд ээлжит хичээл 8,553, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршуулан хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Польшийн "Learnetic" боловсролын технологийн компанитай хамтран бага ангийн 33 сурах бичгийг интерактив хэлбэрт шилжүүлснээр ЕБС-ийн бүх сурах бичиг цахим, интерактив хэлбэрт бүрэн орж, сурах бичиг, контентын динамик системийг бий болгосон. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн 138 нэрийн сурах бичгийн 6000 гаруй алдааг засан сайжруулсан.

Засаж сайжруулсан 1-5 дугаар ангийн 32 нэрийн 659.0 мянга, 6-12 дугаар ангийн 100 нэрийн 816.8 мянган сурах бичгийг улсын төсөв болон түрээсийн эргэлтийн сангийн хөрөнгөөр хэвлэж, ЕБС-ийн суралцагчдад хүргэснээр сурах бичгийн хангалт бага ангид 100 хувь, дунд ахлах ангид 85.0 хувь, цахим сурах бичгээр 100% хангах боллоо. “ЕБС-ийн сургалтын үйл ажиллагаанд ашиглах сурах бичгийн эхийг ашиглан хэвлэн борлуулах” сонгон шалгаруулалтад "Эй плас" ХХК шалгарч 2023 оны 11 дүгээр сараас эхлэн худалдах сурах бичгийн захиалгыг цахимаар авч сургууль бүрд хүргэлт хийж байна. Мөн ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн болон техникийн боловсролын суралцагчдаас онлайнар захиалга авч 600 гаруй багц сурах бичгийг хэвлэн нийлүүлсэн.

2.3.4.3. Үндэстний цөөнхийн хүүхдүүд, лам хүүхдүүд болон гадаадад гацсан хүүхдүүдэд таатай орчин бүрдүүлж, шаардлагатай сурах материалаар хангана.

Биелэлт: Үндэстний цөөнхийн хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Боловсролын судалгааны үндэстний хүрээлэнгээс боловсруулсан I-V ангийн Тува хэлний 1500 ширхэг гарын авлага, казах хэлээр V ангийн 2500 ширхэг математикийн сурах бичгийг тус тус хэвлэн Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад хүргэсэн.
- Гадаадад үйл ажиллагаа явуулж буй сургууль болон сургалтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2023 оны хэвлэлтээс Унгарын ЭСЯ-д I-V ангийн 28 ширхэг, Солонгос дахь Монгол сургуульд I-V ангийн 130 ширхэг, Швед дэх монгол хүүхдүүд суралцдаг сургалтын төвд I-V ангийн 100 орчим сурах бичгийг тус тус нийлүүллээ. Мөн Англи, АНУ, Бельги, Ирланд, Канад зэрэг 20 оронд 60 гаруй монгол хэл, соёлын сургалтын төв ажилладаг бөгөөд сургалтын төвүүдэд шаардлагатай сурах бичгийг нийлүүлж байна.
- Боловсролын судалгааны үндэстний хүрээлэнгээс “Агуулга болон хэлийг интеграцчлан суралцахуй” зөвлөмжийг хэвлэн хос хэлээр хичээл заадаг ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтнуудад түгээж, зөвлөмжийн сургагч багшаар 34 багш бэлтгэн орон нутгийн 6 сургуулийн 176 багшид арга зүйг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол-Казах, Казах-Монгол, "Монгол-Тува, Тува-Монгол" зэрэг 8 төрлийн толь бичгийг хэвлүүлэн хос хэлний сургалтад хамрагдаж байгаа үндэстний цөөнхийн багш, суралцагчдад хүргүүлсэн. Баян-Өлгий аймгийн зорилтот 6 сургуулийн 12-р ангийн сурагчдад монгол хэл бичгийн сургалт зохион байгуулж 255 суралцагч, 54 багшийг хамруулсан.
- Хийдэд шавилан сууж буй лам хүүхдүүдийг орон нутгийн насан туршийн боловсрол төвөөр дамжуулан дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулан суурь болон бүрэн дунд боловсрол олгож байна.

2.3.4.4. Сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сурах бичгийг зохиох, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Сургалтын хөтөлбөрийн дагуу сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын сурах бичиг, багшийн ном бусад гарын авлагыг боловсруулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлын хүрээнд хийсэн ажлууд:

- 2021 онд 2021-2022 оны хичээлийн жилд ашиглах 2.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 61 нэрийн сурах бичиг болон багшийн журнал, анги удирдсан багшийн дэвтэр, тусгай хэрэгцээт боловсролын 11 нэрийн сурах бичгийг нөхөн хангалтаар улсын төсвийн хөрөнгөөр хэвлэн түгээж сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн;
- Суралцагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөх, боловсролыг тэгш хүртээмжтэй болгох, суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахимаар суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор medle.mn буюу боловсролын цахим сургалтын платформыг 2021 оноос үүсгэж хөгжүүлж, тус платформд 147 цахим сурах бичиг, 4,140 теле хичээл, 6-12 дугаар ангийн математик, физик, хими, биологийн хичээлд ашиглах 805 виртуал лаборатори, эрүүл мэнд, замын хөдөлгөөний чиглэлээр 152 контент, суралцагчдад зориулсан 85 Microsoft 365 цахим хичээл, контент боловсруулах арга зүйн зөвлөмж байршуулаад байна.
- 2022-2023 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан I-V ангийн суралцагчдад 1.2 сая ширхэг сурах бичгийг 3.7 тэрбум төгрөгөөр, VI-

XII ангийн суралцагчдад түрээсээр ашиглуулах 1.0 сая ширхэг сурах бичгийг 3.7 тэрбум төгрөг, нийт 2.2 сая ширхэг сурах бичгийг 7.5 тэрбум төгрөгийн зардлаар тус тус хэвлүүлэн түгээсэн;

- Боловсролын судалгааны хүрээлэнгээс 2023 онд 1-12 дугаар ангийн 138 төрлийн сурах бичгийн 6000 гаруй алдааг засаж сайжруулан хэвлэх тендер зарлан 1-5 дугаар ангийн 32 нэрийн 659.0 мянган сурах бичгийг улсын төсвийн 1,589.0 сая төгрөг, 6-12 дугаар ангийн 100 нэрийн 816.8 мянган ширхэг сурах бичгийг 2,285.0 сая төгрөгийн түрээсийн эргэлтийн сангийн хөрөнгөөр хэвлэж ЕБС-ийн суралцагчдад хүргэсэн;
- БШУС-ын 2023 оны А/01 дүгээр тушаалаар 2023 оныг “Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил” болгон зарлаж нийслэлийн 46, орон нутгийн 84, нийт 130 сургуульд зөвлөн туслах ажлыг зохион байгуулсны үр дүнд “Сургуулийн менежментийн зөвлөмж”-ийг боловсруулан өмчийн бүх хэлбэрийн 871 сургуульд хүргэсэн;
- ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн цагчилсан төлөвлөлт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн цуврал зөвлөмжүүдийг Боловсролын ерөнхий газрын цахим хуудсанд нээлттэй байршуулснаар багш нар ээлжит хичээлээ бэлтгэхэд дэмжлэг болж байна. “Бага боловсролын чанарын шинэчлэл төслөөс “2-5 дугаар ангийн монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж”, “Агуулга болон хэлийг интеграцчлан суралцахуй” зэрэг нийт 5 төрлийн зөвлөмжийг хэвлэн багш нарт хүргэсэн. 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 435 сургуульд 15.9 тэрбум төгрөг, төслийн хөрөнгө оруулалтаар 33 сургуульд 3.7 тэрбум төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

2.3.4.5.Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулна.

Биелэлт: Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах чиглэлээр хийсэн ажил:

- АХБ-ны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн санхүүжилтээр 2021 онд Монгол хэл бичгийн хөтөлбөрт шинжилгээ хийж, Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах чиглэлээр нийслэлийн 1240 монгол хэл, бичгийн багшид “Kahoot” программ заасан. Багш нарын боловсруулсан 176 цахим болон видео хичээлд арга зүйн зөвлөгөө өгч, сайжруулалтыг хийж, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 200 сургууль монгол бичгийн кабинетыг шинэчлэн байгуулах, сайжруулах зэргээр сургалтын орчныг бүрдүүлсэн байна. Энэ хичээлийн жилд 2390 багш нийт 8227 цахим хичээл, 15502 цахим хэрэглэгдэхүүн, 5315 контентыг боловсруулж, эх хэлний сургалтад ашигласан. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөөс авсан монгол хэл бичгийн шалгалтад 33138 шалгуулагч хамрагдлаа.
- 2023 онд баталсан “Боловсролын ерөнхий хууль”-ийн 6.1-д “Монгол Улсад боловсрол эзэмшүүлэх сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна”, гадаад хэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа сургалтын байгууллага нь суралцагчид монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийг заавал монгол хэлээр эзэмшүүлнэ”, 14.4-т “монголын түүх, монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшилийг сургалтын хөтөлбөрт заавал тусгаж, сургалтын байгууллага өмчийн

- хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ” гэж тусган эрх зүйн орчныг бүрдүүлсэн;
- Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс "Хүүхдийн академик үгийн сангийн нөөцийг тогтоон, түвшинд хуваах судалгаа"-г хийж, насан хүрэгчдийг монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бие даан суралцахад зориулж, гар утасны “Үндэсний бичиг” аппликейшнийг турших ажлыг эхлүүлсэн;
- Ерөнхий боловсролын сургуулийн Монгол хэл, уран зохиолын 2816 багшид мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт болон сонголтот модуль сургалт зохион байгуулсан;
- Монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөрт заасан агуулгын хүрээнд зохиосон монгол хэлний сурах бичгийг 1-12 дугаар ангид, монгол бичиг, уран зохиолын сурах бичиг 6-12 дугаар ангид, сургалтын Medle.mn цахим платформд ерөнхий боловсрол сургуулийн 1-12 ангийн монгол хэл, 6-12 ангийн үндэсний бичгийн хичээлийн сурах бичгийг цахимаар байршуулан, багш суралцагчдад нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлснээр 2023 оны байдлаар монгол хэлний 264 ээлжит хичээл, үндэсний бичгийн 343 ээлжит хичээлийг байршуулж, хичээл сургалтад ашиглаж байна;
- Баян-Өлгий аймгийн бага боловсролын Монгол хэл II, III, IV ангийн гарын авлага, Монгол хэл II, IV ангийн дасгал ажлын дэвтэр тус тус хэвлүүлж, сургалтад хэрэглэж байна.

2.3.4.6. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгоно.

Биелэлт: Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох чиглэлээр дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах чадамж, ялгаатай хэрэгцээг харгалзан тусгай сургуулийн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, 2020 оны А/37, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр”, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөн орон зайн баримжаа олгох хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг тус тус боловсруулж, 2021 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/309, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл”-ийг 2021 оны А/325, 2022 оны А/311 дүгээр тушаалыг тус тус баталсан.
- 2022-2023 оны хичээлийн жилд харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжих зорилгоор харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэрэгслийн зардал авах 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоонд шилжүүлж, “Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд монгол хэлний хичээлийг хос хэлний арга зүйгээр заах арга зүйн зөвлөмж боловсруулах, монгол дохионы хэлний анхан, ахисан шатны хөтөлбөр боловсруулан 140.6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн. Мөн “Виртуал дохионы хэлний хэлмэрч” аппликейшн бүтээн сургалтад ашиглаж байна
- Харааны бэрхшээлтэй суралцагчийн I-V ангийн “Орон зай, хөдөлгөөний чиг баримжаа”, “Ахуйн баримжаа” сургалтын жишиг хөтөлбөр, сонсголын бэрхшээлтэй суралцагчийн “Дохионы хэл I-V анги” сургалтын жишиг хөтөлбөр, танхимын сургалтад тогтмол хамрагдаж чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх явуулын багшийн Монгол хэл, Нийгэм ахуйн баримжаа хичээлийн жишиг хөтөлбөрийг тус тус боловсруулан сургалтад хэрэглэж байна.
- 2023 онд явуулын багшийн Математик, Дүрслэх урлаг технологи хичээлийн

сургалтын жишиг хөтөлбөр, суралцахуйн удирдамж, "сонсголгүй хүүхдэд монгол хэл заах арга зүйн зөвлөмж", "Ялгаатай хэрэгцээтэй (Хараа, сонсгол, оюун ухааны бэрхшээлтэй) сурагчдад бэлгийн боловсрол олгох арга зүйн зөвлөмж, эрүүл мэндийн багш нарт зориулсан арга зүйн удирдамжийг тус тус боловсруулж түгээсэн.

- I-V ангийн ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулан 2500 ширхэг "Дүрслэх урлаг"-ийн сурах бичгийг хэвлэн аймаг, дүүргийн боловсролын газарт түгээн сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.

2.3.4.7. Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт: Олон улсын туршлагыг судлан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Үндэстний цөөнхийн асуудлаар Дээд комиссар болон Боловсрол шинжлэх ухааны сайд нар "Монгол Улсын олон хэлт, олон соёлт боловсролыг хөгжүүлэх тухай хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулан ажиллаж байна. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Үндэстний цөөнхийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын зүгээс хэрэгжүүлж буй Төв Азийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн хамтран ажиллаж байна.

Үндэстний цөөнх иргэн түүх, ёс заншил, өв соёлыг хадгалж үлдэх, эх хэлээрээ суралцах эрхийг хангах зорилгоор Хөвсгөл аймгийн Тува иргэдийн хүүхдэд зориулсан "Тува хэлний сургалтын жишиг хөтөлбөр", бага боловсролыг эх хэлээр эзэмшиж байгаа Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 2-5 дугаар ангийн сурагчдад зориулсан "Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийг тус тус Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/338, А/339 дугаар тушаалаар баталсан бөгөөд энэ хүрээнд:

- Үндэстний цөөнх хүүхдүүдийн (казах, тува) сургалтын чанарыг дээшлүүлэх, тэдний төрийн (монгол) хэл болон эх хэлний үгийн нөөцийг нэмэгдүүлэх, хос хэлээр суралцахад сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах 8 төрлийн сургалтын толь бичгийг сайжруулан 17,100 ширхэг түгээсэн, "Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд зориулсан багшийн гарын авлага боловсруулж, хэвлүүлэн, Баян-Өлгий аймагт хүргүүлэн сургалтад ашиглаж эхэлсэн.
- Тува хэлээр сургалт явуулдаг сургуулийн бага ангийн сурагчийн 1-5 дугаар ангид судлах Тува хэлний гарын авлага 2013-2018 онд хэвлэгдсэн ба 2023 онд агуулга, арга зүйн сайжруулалтыг анх удаа хийсэн бөгөөд Хөвсгөл аймгийн Цагаан нуур суманд амьдарч буй эх хэлээрээ суралцахгүй байгаа цаатан хүүхдүүдэд зориулан тува хэлний анхан шатны гарын авлагыг шинэчлэн сайжруулж, 300ш хүргэсэн. Мөн цаатан иргэдийн боловсролыг дэмжих зорилгоор их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөр элсэгчдэд Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийг төгссөн бакалаврын хөтөлбөрт сурч байгаа цаатан иргэдийн 13 суралцагчдад 17.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгосон байна.
- Medle.mn цахим сургуулийг байгуулж, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан 13500 гаруй цахим хичээл, контентыг нээлттэй тавьж, багш, суралцагч, иргэдийн суралцах боломжийг бүрдүүлсэн. Энэ хичээлийн жилд олон улсын жишигт нийцсэн, цахим системд суурилсан "Eduten" математикийн хөтөлбөр, Pearson English англи хэлний хөтөлбөрийг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

2.3.4.8. Гадаад улсад монгол сургууль, насан туршийн сургалтын төвийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бий болгож, дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: 2023 онд баталсан Боловсролын ерөнхий хуулийн 14.6-д Гадаад улсад монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, боловсрол нөхөн эзэмших сургалт зохион байгуулах, монгол хүний хөгжлийг дэмжих зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг байгуулж болно, 38.9-д Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна гэж тусгасан.

Иргэдийн насан туршдаа суралцахуй, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор <https://medle.mn/tele/21> сайтад бага боловсролын түвшинд монгол хэл, математик, иргэний боловсрол гэсэн судлагдахуунаар 12, суурь боловсролын түвшинд монгол хэл, математик, иргэний боловсрол судлагдахуунаар 12, иргэдийн боловсролд зориулан гэр бүлийн боловсрол, мэдээлэл, харилцаа холбоо технологи, эрх зүй, амьдрах ухаан, эрүүл мэнд, соёл, гоо зүй, санхүүгийн боловсрол, Тогтвортой хөгжлийн боловсрол гэсэн 7 чиглэлээр 229 теле хичээлийг байршуулан түгээн дэлгэрүүлж байна. Гадаадад үйл ажиллагаа явуулж буй сургууль болон сургалтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2023 оны хэвлэлтээс Унгарын ЭСЯ-д I-V ангийн 28 ширхэг, Солонгос дахь Монгол сургуульд I-V ангийн 130 ширхэг, Швед дэх монгол хүүхдүүд суралцдаг сургалтын төвд I-V ангийн 100 орчим сурах бичгийг тус тус нийлүүллээ

“Насан туршдаа суралцахуйн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох судалгаа, шинжилгээ хийж, санал боловсруулах ажлын хэсгийг БШУС-ын 2021 оны А/245 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. Ажлын хэсгээс гадаад улсад насан туршийн боловсролын төв байгуулах, төв байгуулахад тавих нийтлэг шаардлага, тусгай зөвшөөрөл хэрхэн олгох зэрэг чиглэлээр Хилийн чанад дахь Монголчуудын холбоо ТББ-аар уламжлан санал авч байгаа бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Гадаад харилцааны сайд, Соёлын сайдын 2021 оны А/304,47, 173 дугаар хамтарсан тушаалаар “Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат иргэдийн хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншлын боловсрол олгох ажлыг бодлого, зохицуулалтаар хангах байнгын ажиллагаатай салбар дундын комисс” байгуулагдан ажиллаж байна.

2.3.4.9. Өсвөр насны бүх хүүхдэд нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварт суралцахад туслах хичээлээс гадуурх чанартай үйл ажиллагаанд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэгт “Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.”, “Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллах бөгөөд сэтгэл зүйч нь суралцагчийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх, ганцаарчилсан болон бүлгээр сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ” гэж тус тус тусгасан, мөн Боловсрол, шинжлэх ухааны сайд “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг 2020 оны А/199, “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг 2022 оны А/288 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан, цахим системд байршуулсан бөгөөд энэ чиглэлээр хийсэн ажил:

- Ковид-19 халдварт цар тахлын үед ЕБС-ийн 12 дугаар ангийн суралцагчдад шалгалтын өмнөх стресс менежмент, сэтгэл зүйн бэлтгэлд дэмжлэг үзүүлэх,

зөвлөгөө өгөх “Чатбокс” үйлчилгээнд давхардсан тоогоор нийт 248 хүн холбогдсоны 96.3 хувь нь төгсөх ангийн хүүхэд бүрдүүлсэн.

- Ерөнхий боловсролын сургуульд 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн сэтгэл зүйчийг ажиллуулж, сэтгэл зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн 62 иргэнийг 12 багц цагийн мэргэшүүлэх сургалтад хамруулж, сургуулийн сэтгэл зүйчээр давтан бэлтгэсэн бөгөөд 201 сургууль (төрийн өмчийн 99, төрийн өмчийн сургуульд 102) сэтгэл зүйч ажиллаж байна. Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй төслийн зохион байгуулсан сургалтад төслийн 5 аймгийн 25 сумын 14-25 насны 2097 хүүхэд залуучууд хамрагдаж, сургалтын хүрээнд тэтгэлэгт хөтөлбөр зарлагдсан. Тэтгэлэгт хөтөлбөрт 32 багийн 151 хүүхэд оролцож 5 баг шалгарсны 4 нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас бүрдсэн баг байна.
- 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 859 сургуульд 746,405 суралцагч суралцаж байгаагаас давхардсан тоогоор 979,628 суралцагч хичээлээс гадуурх сургалтын ажилд хамрагдсан байгаа бөгөөд сургууль дээр зохион байгуулагдаж буй хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа, секц, дугуйланд 418,240 суралцагч буюу 54% нь хамрагдаж байна.
- Түүнчлэн 2023-2024 оны хичээлийн жилд “After school” хөтөлбөрийг эхлүүлж, 24,546 суралцагч цахимаар хамрагдах боломжийг бүрдүүлснээр хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны хамрагдалт 57%-д хүрэв. Уг хөтөлбөрт IX-XII ангийн суралцагчид нийгэм-сэтгэлзүй, хувь хүний ур чадвар, дэлхийн иргэний боловсрол, шинжлэх ухааны болон бусад хичээлүүдээс сонголтоо хийх боломжийг нэмэгдүүлээ

2.3.5. Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ.

2.3.5.1. Судалгаанд суурилсан үндэсний их сургуулийн эрх зүйн орчныг бий болгож, судалгааны их сургуулийг хөгжүүлж эхэлнэ.

Биелэлт: 2023 онд батлагдсан Дээд боловсролын тухай хуульд судалгааны их сургуулийг тодорхойлон (4.1.4-д "Судалгааны их сургууль" гэж ... сургалтын байгууллага" гэж тодорхойлон, 7.8 заалтад "... Улсын Их Хурал хуулиар байгуулна) зохицуулалтыг бүрдүүлсэн. Мөн шинэчлэн батлагдсан Дээд боловсролын тухай хуулиар салбарын сайд төрийн өмчит их, дээд сургуулийн удирдлагын томилгооны зохицуулалтыг шинэчилсэн бөгөөд их, дээд сургуулийн захиралтай гүйцэтгэлийн гэрээ байгуулах, гэрээг дүгнэх, сургалтын төлбөрийг төрөөс хараат бусаар тогтоохыг сургуулийн өөрийн удирдлагад шилжүүлсэн.

АХБ-ны 30 сая ам.долларын зээлээр 2022 оноос хэрэгжих Судалгааны их сургууль хөгжүүлэх төслийн дизайн батлан тавигдах шаардлага, шалгуурын төслийг Казахстан, ОХУ, БНХАУ, Япон, АНУ зэрэг улсын жишиг, туршлагыг судалсан боловсруулсан.

2.3.5.2. Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, нэн хэрэгцээтэй хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа, мэдээлэлд үндэслэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэнэ.

Биелэлт: Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийг Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолын 1-р хавсралтаар МУ-ыг хөгжүүлэхэд шаардлагатай дээд

боловсролын тэргүүлэх мэргэжлийн 83 чиглэлийг, 2-р хавсралтаар дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн 38 чиглэлийг баталсан. Европын холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд хөгжүүлсэн “Дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны систем”-ийн нээлтийг ХНХЯ, БШУЯ хамтран 2022.06.27-нд хийсэн. Уг систем нь ХНХ-ын салбарын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, халамжийн системүүд болон Боловсролын салбарын мэдээллийн системүүд хооронд интеграци хийсэн. Одоогоор системд 2021, 2022 онд МБСБ төгссөн 17,640, Их, дээд сургууль төгссөн 58,343 төгсөгчийн мэдээлэл орж тооцоолол хийгдсэн байна.

2.3.5.3. Их, дээд сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийн чанарын үнэлгээг сайжруулна.

Биелэлт: Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ хийх, их, дээд сургуулиудын эрэмбийг тогтоох зорилгоор дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг тогтоох арга зүйг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" А/240 дугаар тушаалаар баталж, 2023 онд сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээг хийж, дүнг олон нийтэд танилцуулсан. Үнэлгээнд 61 их дээд сургууль хамрагдсан.

Их, дээд сургуулийн хөтөлбөрийн чанарыг сайжруулахаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

- "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр/, индекс"-ийг олон улсын хөтөлбөр, стандартын чиг хандлагад нийцүүлэн шинэчилж БШУС-ын 2022 оны А/160 тоот "Босго оноо тогтоох тухай" тушаалаар төр, хувийн сургуулиудын босго оноог ижил байхаар их сургуульд 480, дээд сургуульд 440, коллежид 400, орон нутгийн их, дээд сургуульд 410 байхаар тогтоосон.
- Боловсролын чанарын үнэлгээний мэргэжилтнийг ахисан түвшний сургалтаар бэлтгэх зорилгоор Боловсролын үнэлгээний төв, МУБИС, ОХУ-ын Эдийн засгийн дээд сургуультай ахисан түвшний хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.
- Гадаад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгааг хийсэн. Сургалтын хөтөлбөр судлалаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн.

2.3.5.4. Судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент, венч сан) эх үүсвэрийг бий болгоно.

Биелэлт: Улсын хэмжээнд их сургуулийн нэг эндоумент сан байгуулагдсан бөгөөд анхны эндоумент санг МУИС 2022 онд байгуулж, тус сангаас 2022 онд судалгаа, шинжилгээний 8 ажлын санхүүжилтэд 32.3 сая төгрөг, 2023 онд 24 төсөлд 530.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон. УИХ-аар шинэчлэн батлагдсан Дээд боловсролын тухай хуулийн 32.4 дэх заалтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын эндоументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам"-ыг батлах эрх эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгосон бөгөөд журмын төслөөр санал авч байна.

2.3.5.5. Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх механизмыг боловсронгуй болгож, үр дүнг шинээр төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагааны гол шалгуур болгох замаар төслийн санхүүжилтийн уян хатан, өрсөлдөөнт тогтолцоог бий

болгоно.

Биелэлт: Судалгааны ажлын үр дүнг байгууллагын болон эрдэм шинжилгээний ажилтны ажлын үнэлгээ, санхүүжилтийн үндсэн шалгуур болгох зорилгоор дараах ажлууд хийсэн. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" 409 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам", "Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн жагсаалт", "Жагсаалт батлах тухай" А/51 дүгээр тушаалаар баталсан. Нийт 26 эрдэм шинжилгээний байгууллагын 99 судалгааны үндсэн чиглэл, хамрах хүрээний 322 сэдвийн жагсаалт багтсан бөгөөд энэ хүрээнд "Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд олгох санхүүжилтийн хэмжээг тооцох, хуваарилах аргачлал"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Аргачлал батлах тухай" А/120 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Судалгааны үндсэн чиглэлүүдийг санхүүжүүлэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Зардлын хуваарилалт батлах тухай" А/11 дүгээр тушаалын "Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний 2023 оны төсвийн зардлын хуваарилалт"-д 900 сая төгрөг олгохоор тусгагдсан;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн "Журам батлах тухай" А/394 дүгээр тушаалаар "Эрдэм шинжилгээний ажилтныг аттестатчилах журам"-ыг батлуулсан. Тус журмаар Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Эрдэм шинжилгээний дэд ажилтан, Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтны хийж гүйцэтгэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын шалгуур үзүүлэлтийг өөр өөр байхаар тогтоосон;
- Тайлант хугацаанд 2021 онд 361 төсөлд 5.8 тэрбум төгрөг, 2022 онд 79 төсөлд 1.4 тэрбум төгрөг олгосон байна.

2.3.5.6. Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгож, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулна.

Биелэлт: 2023 онд баталсан Дээд боловсролын тухай хуулийн 32.2.2-д "улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал"-ыг Дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дэмжлэг үзүүлнэ гэж туссан, мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/141 дүгээр тушаалаар "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл сонгон шалгаруулж, урамшуулах журам"-ыг шинэчлэн баталсан. Журмаар эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн шагналыг "Эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл", "Эрдэм шинжилгээний шилдэг ном" гэсэн 2 төрөлд тодорхой стандарт, шалгуур, шаардлагыг баримтлан шалгаруулж, тус бүр 10 сая төгрөгийн мөнгөн урамшуулдаг.

2021 онд эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд 9 эрдэмтэнд 90 сая төгрөгийн урамшуулал, 2022 онд эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд 60.0 сая төгрөг, инновацын санаачилгыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "МОН ИКС ПРАЙЗ" хөтөлбөрт 1000 гаруй иргэн хамрагдаж, 251 төслийн санал ирүүлсний 9 багт 180.0 сая төгрөгийн урамшуулал олгосон.

2.3.6. Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын

амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлнэ.

2.3.6.1."Боловсролын зээлийн сан"-г орлогын олон талт эх үүсвэр бүхий "Боловсролын хөгжлийн сан" болгож оюутныг дэмжсэн үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам", Боловсрол, шинжлэх ухааны сайдын Үүний дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 онын "Боловсролын зээлийн сангийн бүтэц шинэчлэн батлах тухай" 2021 оны А/353, "Боловсролын зээлийн сангийн бүтэц шинэчлэн батлах тухай" 2022 оны 6 дугаар сарын 22-ний тушаалаар Боловсролын зээлийн сангийн бүтцийг 5 хэлтэс, 32 ажилтан үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна.

2.3.6.2.Засгийн газрын тэтгэлэг, зээлээр гадаадад дээд боловсрол эзэмшигчдийг мэргэжлээр нь хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан томилон ажиллуулах зохицуулалт хийнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам", 3 дугаар хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам" батлуулсан.

Эдгээр журмаар тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагч, Боловсролын зээлийн сан, тэтгэлэгт хамрагдсан иргэний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг дарга нар гуравласан гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллах болон тэтгэлэгт хамрагдсан иргэн сургуулиа төгссөний дараа гэрээний дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид 5-аас доошгүй жил ажиллана гэж зохицуулсан

Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургуульд Засгийн газрын гэрээ хэлэлцээрийн хүрээнд суралцаж байгаа 97, бакалаврын зэргийн сургалтад суралцаж байгаа 111, магистр болон докторын сургалтад суралцаж байгаа 37, нийт 245 оюутантай гэрээ байгуулж 20.9 тэрбум төгрөгийн сургалтын зээл, тэтгэлгийг 2021 онд олгосон байна.

2.3.6.3.Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр амжилттай суралцагчдыг дэмжих "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам" батлуулсан. Журамд дотоодын их, дээд сургуулийн 50 хүртэлх суралцагчид 10 хүртэлх сая төгрөг, 50 хүртэлх суралцагчийг дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахаар зохицуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэгт 2022 онд 75, 2023 онд 125 иргэнийг шалгаруулж тэтгэлэг олгосон.

2.3.7.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.

2.3.7.1.Бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хийнэ. (Дархан, Сэлэнгэ, Орхон, Багануур, Дорнод, Ховд, Завхан)

Биелэлт: Засгийн газрын 2021 оны "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 321

дүгээр тогтоолын хүрээнд 4 байршилд их дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхээр шийдвэрлэсэн. (Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх, Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр ШУТИС-ийн харьяа сургуулийг шинээр байгуулах, Орхон аймаг дахь ШУТИС-ийн харьяа "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх, Хөшгийн хөндийд дижитал их сургуулийн сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлсэн хэв шинжтэй дээд боловсролын сургалтын байгууллагыг шинээр байгуулах)

Энэ тогтоолын хүрээнд нэг ТЭЗҮ, нэг ерөнхий төлөвлөгөөг 2023 онд хүлээн авсан, нэг цогцолборын ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах ажлын санхүүжилтийг "Эрдэнэт үйлдвэр", Дархан болон Ховд аймаг дахь "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ын газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Дорнод аймаг дахь "Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв"-ийн Ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, эхний ээлжийн барилгажилтын зургийг хийж гүйцэтгэсэн ба Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймгууд дахь "Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор"-ын Ерөнхий төлөвлөгөөний загвар, ТЭЗҮ-ийн ажлын даалгавруудын төслийг хийж гүйцэтгэлээ. 2021, 2022, 2023 оны улсын төсөвт бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт тусгагдаагүй.

2.3.8."Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.

2.3.8.1.Багш мэргэжлийн стандартыг батлуулж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2023 онд батлуулсан Боловсролын ерөнхий хуулийн 12 зүйлийн 17 заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 7 заалт, Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох зохицуулалтыг шинэчилсэн болон "Чадварлаг багш" арга хэмжээний хөтөлбөр /2021-2024/-ийг 2021 оны А/07, "Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих журам"-ыг 2022 оны 170, Багшийн цалингийн хэмжээг шинэчлэн 2022 оны БШУС-ын А/122 дугаар тушаалуудаар багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

ЕБС-ийн багшийн ачааллын судалгааг явуулж, судалгаанд үндэслэн багшийн мэргэжлийн стандартыг батлуулахаар ажиллаж байна. Мөн судалгааны үр дүнг үндэслэн 2023 онд норм нормативыг шинэчилж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн олон хувилбарт, уян хатан үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн.

- "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажил мэргэжлийн стандарт"-ыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 3 дугаар тогтоолоор батлуулсан
- Аймаг, нийслэлийн БСУГ, Засаг даргын тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган Английн Засгийн газрын дэмжлэгтэйгээр Глобал Грөүф институттэй хамтран нийт төрийн өмчийн 669 ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер болох 1000 сургалтын байгууллагын удирдах ажилтан, багшийг "Дэлхийн түвшний менежер" хөтөлбөрт 2021 онд хамруулсан
- Багш ажлын байран дээр бие даан болон хамтран суралцах замаар тасралтгүй хөгждөг байх концепцид тулгуурлан "ментор багшийг бэлтгэх сургалтад 30

зөвлөх багшийг хамруулж бэлтгэсэн.

2.3.8.2. Багш мэргэжлээр их, дээд сургуульд суралцагчдад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 264 дүгээр тогтоолын “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 3.2.3, 4.2.4-д заасны дагуу багш мэргэжлээр суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх хүрээнд 2021 онд төрийн өмчийн дээд боловсролын 6 сургалтын байгууллагад багш мэргэжлээр суралцаж байгаа 1443 оюутанд 1.2 тэрбум төгрөг, 2023 оны эхний хагас жилд 24 их, дээд сургуулийн 792 багш мэргэжлээр суралцагчид 0.9 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, багшийн дутагдлыг нөхөх зорилгоор багш бэлтгэдэг их дээд сургуулийн төгсөх ангийн 237 оюутны суралцах академик цагийн хичээлийг 2022 онд бүрэн олгож, багшаар ажиллангаа дадлага хийж төгсгөн шинэчилсэн хөдөлмөрийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2023 оны “Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 326 дугаар тогтоолоор Багш бэлтгэх, багшийн тасралтгүй хөгжих боломж, нийгмийн баталгааг хангах хүрээнд авах арга хэмжээг тодорхойлсон.

2.3.8.3. Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан ур чадвар, улирлын үр дүнгийн урамшууллыг бий болгоно.

Биелэлт: Боловсролын салбарын бодлого, эрх зүй, төсвийн шинэчлэлийн судалгааг 2021 оноос эхлүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганаар 2022 оны төсвийн тухай хуулийг батлахтай хамтатган цэцэрлэг, сургуульд үр дүнд суурилсан төсвийн шинэчлэлийг нэвтрүүлж, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн тогтоож, төсвийн шинэчлэлийг “Хүртээмжээс чанарт” зорилгын хүрээнд боловсролын чанарыг хэмжиж, гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог цахим шилжилттэй хослуулан хэрэгжүүлсэн байна. Төсвийн шинэчлэлийн хүрээнд боловсролын засаглалыг бэхжүүлж, сургууль, цэцэрлэгт төсвийн тодорхой эрх мэдлийг шилжүүлэх замаар хагас бие даасан тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд сургалтын байгууллага болон багш, ажилтны цалин, хөлсний бүтцийг шинэчилж, “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал” хэсэгт Засгийн газрын 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 252, 2023 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ын дагуу багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2 дахь жилдээ зохион байгуулж үр дүнг тооцон, холбогдох урамшууллыг олгосон байна. (2022 онд 5,937 багш 5.9 тэрбум төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн 12,296 багш нийт 31.3 тэрбум төгрөг, 2023 оны 9-12 дугаар сард 12,307 багш 16.7 тэрбум төгрөг, цэцэрлэгийн 6,450 багш 3.1 тэрбум төгрөг). 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр цэцэрлэгийн багш нарын 50.6 хувь, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 51.7 хувьд нь тус тус албан тушаалын үндсэн цалингийн 10-25 хувийн урамшуулалд хамрагдаж байна.

2.3.8.4. Багш мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх нөхцөлийг сайжруулна.

Биелэлт: 2023 онд баталсан Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйл "Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо" хэсэгт багш бүрийг мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтыг цахим, танхим, хосолсон хэлбэрээр зохион байгуулах, багш өөрийн хөгжих хэрэгцээндээ тулгуурлан мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх эрхзүйн нөхцөлийг бүрдүүлсэн. Боловсролын төсвийн шинэчлэлийн хүрээнд Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол, БШУС-ын 2022 оны "Заавар батлах тухай" тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардлын бүрэлдэхүүнд "багшийн хөгжлийн зардал"-ыг тусган, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

АХБ-ны "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-тэй хамтран цахим сургалтын платформыг өргөжүүлэн хөгжүүлэх, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд 2021 оны 10-11 дүгээр сард СӨБ, ЕБС-ийн 110 багшид "Онлайн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. БМДИ-ийн захирлын 2021 оны 02 сарын 10-ны өдрийн А/04 дугаар тушаалаар "ДБ-ын багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих журам"-ыг боловсруулан батлуулсан.

Энэ хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилд цахим-танхим-цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулан 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй 8791 багш, ажилтан хамруулж, багш бүрд цахим сургалт явуулах, цахим агуулга бэлтгэх чиглэлээр мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах, мэдлэг, чадвар эзэмшүүлэх 14 модуль сургалт зохион байгуулж, 16400 багш хамрагдаж амжилттай суралцан батламж авсан. Багш, ажилтны цахим, онлайн орчинд мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, сургалт зохион байгуулах ур чадварыг сайжруулах, багшийг цахим сургалт явуулах, цахим агуулга бэлтгэхэд "Ухаалаг анги" танхимыг бий болгож, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан. Үүнд багш бүр цахимаар суралцах боломжийг бүрдүүлж, компьютержуулсан, бүх сургуулийг интернэтэд холбосон.

2.3.8.5. Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлнэ.

Биелэлт: 2020-2023 онд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах мэдлэг, чадвар, арга зүй эзэмшүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, 8603 багшийг давтан сургаж, чадавхжуулсан байна. Мөн ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан "Хүүхэд бүрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх нь" гарын авлага, "Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангид суралцаж буй ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийн сайн туршлага", "Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй" гарын авлага боловсруулж, хэвлүүлэн түгээсэн.

АХБ-ны санхүүжилттэй G9208MON "Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл"-ийн хүрээнд "Тэгш хамран сургах боловсролын соёл, бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх нь" сургагч багш бэлтгэх вакум сургалтаар 36 багш бэлтгэгдэж, 463 багшид түгээн дэлгэрүүлсэн. Тэдгээр багш нарт "Тэгш хамруулсан сургалтыг хэрэгжүүлэх" гарын авлага, 6 төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн 14 видео хичээл, сургагч багшийн түгээн дэлгэрүүлэх сургалтын 9 модулийг өгч, улмаар сургагч багш нар тэгш хамран сургах боловсролын соёл, бодлого, үйл ажиллагааг хөгжүүлэх сургалтаар 437 багш, 46 захирал, эрхлэгчийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж чадавхжуулсан. Боловсролын дэлхийн түншлэл Олон улсын байгууллага, Жайка, Японы хүүхдийг ивээх сангийн санхүүжилттэй Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих EQUAI төслийн тэгш хамран сургах боловсрол бүрэлдэхүүний хүрээнд ердийн сургуулийн багш нарыг тэгш хамран сургах боловсролын

арга зүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэглээ болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний чиглэлээр Архангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс аймгуудад 160 удирдах ажилтан, 3012 багшийг сургалтад хамруулсан байна. "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах төсөл"-ийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, Өмнөговь аймгийн БШУГ-ын тэгш хамруулах боловсролын 45 мэргэжилтний сургалт, тэгш хамран сургах боловсролын соёл, бодлого, үйл ажиллагааг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулан 400 багш, 20 удирдах ажилтны сургалт, брайл бичиг, технологийн сургалтаар 10 багш, дохионы хэлний сургалтаар 11 багшийг тус тус чадавхжуулсан.

БШУС-ын 2022 оны "Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай" А/160 дугаар тушаалын нэгдүгээр төрөлжсөн чиглэлд багш, тусгай хэрэгцээт боловсрол /011428/бакалавр, магистр/011429/-ын түвшинд орсон бөгөөд Багш, тусгай хэрэгцээт боловсролоор 68 оюутан, Тусгай хэрэгцээт боловсролоор 7 оюутан суралцаж, ОХУ-ын Буриадын багшийн дээд сургуулиас хөрвөх сургалтаар хэл засалч мэргэжлээр 45 багш төгссөн. Мөн 2022-2023 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдээс АШУҮИС-ийн Сувилахуйн сургуульд хөдөлгөөн засалчаар 7, хөдөлмөр засалчаар 12, нийт 19 хүн сурч байна

2.3.8.6. Сургуулиудын эрүүл мэндийн боловсролын хичээлд суурилан амьдралын ур чадварыг сайжруулна. (багш нарт зориулсан сургалт, сургалтын материал боловсруулалт)

Биелэлт: Ерөнхий боловсролын сургуулийн "Эрүүл мэнд" хичээлийн хөтөлбөрийг салбарын сайдын 2019 оны А/492 дугаар тушаалаар батлан 3-12 дугаар ангид 7 хоног тус бүр 2 цагаар хэрэгжүүлж, НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр Эрүүл мэндийн лаборатори кабинетыг Багшийн хөгжлийн ордонд 2020 онд байгуулан эрүүл мэндийн багшийн хөгжлийг дэмжих "Эрүүл мэндийн багш нарт зориулсан зайн сургалтын модуль" боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд эрүүл мэндийн хичээл зааж буй багш нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.

НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр "Эрүүл мэндийн боловсрол, түүний дотор жендерийн агуулгыг багш нарт хүргэх, үндэсний чадавхыг бэхжүүлэх" сургалтыг 9-11 дүгээр сард 2 үе шаттай зохион байгуулж нийслэл, орон нутгийн нийт 28 мэргэжилтэн, 21 аймаг, 8 дүүргийн 32 сургагч багшийг бэлтгэсэн. Эдгээр сургагч багш нар ерөнхий боловсролын сургуулиудын эрүүл мэндийн багш нарт "Жендерт суурилсан хүчирхийлэлгүй орчин" сэдвээр сургалт зохион байгуулсан. Эрүүл мэндийн боловсролын багш нар сургалтад хамрагдсанаар хөтөлбөрийн хэрэгжилт сайжирч, эрүүл зөв дадал хэвшилтэй иргэн бий болох, амьдралын ур чадвараа сайжруулахад эерэг нөлөөлөл үзүүлж байна. 2023 онд АШУҮИС-ийн харьяа Монгол-Японы эмнэлэгт түшиглэн "Багшийн эрүүл мэндийг дэмжих төв"-өөс боловсролын салбарын багш, ажилтан 3 дугаар шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, цэцэрлэг, сургуулийн эмч нарыг чадавхжуулах үйл ажиллагааны хүрээнд нийт 1079 байгууллагын 1206 эмч, багш, удирдах ажилтны сургалт, 2023-2024 оны хичээлийн жилд анги удирдсан болон эрүүл мэндийн багш нарт зориулсан "хүүхдийн дархлаанд цахим хэрэгсэл нөлөөлөх нь" сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.

БШУЯ, ЭМЯ хамтран 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элсэн суралцаж буй 54,758 суралцагчдын дунд эрт илрүүлэг, үзлэг, оношилгоог сургуульд суурилан харьяа өрхийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан. Мөн 2022-2023 оны хичээлийн жилд БШУЯ, ЭМЯ хамтран Эрүүл мэндийн хичээлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнг удирдлагуудад танилцуулж, эрүүл мэндийн багш нарыг тусгайлан давтан сургалтад хамруулах саналыг гаргаж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгахаар шийдвэрлэсэн.

2.3.8.7.Багшийн хөдөлмөрийн онцлог, нөхцөлд үнэлгээ хийж, тэтгэвэр тогтоох насанд өөрчлөлт оруулах боломжийг судална.

Биелэлт: Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багшийн өндөр насны тэтгэвэрт гарах настай холбогдох харилцааг боловсролын салбарын хууль тогтоомжоор зохицуулах боломжгүй болохыг УИХ-ын холбогдох Байнгын хорооноос ажлын хэсэгт чиглэл өгч, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн "Ажил мэргэжлийн стандарт" боловсруулах ажлын хүрээнд багшийн ажлын чиг үүрэгт 2022-2023 онд хийсэн шинжилгээгээр багшийн ачаалал нь "багшийн хөдөлмөрийн нөхцөл "хэвийн" гэж тогтоогдсон тул багшийн албан тушаалд ажиллаж байгаа иргэний өндөр насны тэтгэвэр тогтоох насанд өөрчлөлт оруулах үндэслэл одоогоор байхгүй гэж тогтоогдсон.

Тэтгэвэр тогтоох насыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-аар болон Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн "13.9.Боловсролын болон хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас бусад чиг үүргийг багшаар гүйцэтгүүлэхийг хориглоно" гэж заасан нь багш нарын хичээл, сургалтаас бус ачааллыг бууруулах эрх зүйн үндэслэл болсон.

2.3.9.Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ.

2.3.9.1.Газар зүйн мэдээллийн системд суурилж боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөдөг болно.

Биелэлт: БШУЯ 2022 оны 3 дугаар сараас АХБ-ны "Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-ийн санхүүжилтээр "Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн оновчлол"-ын систем боловсруулах ажлыг эхлүүлж, 2023 оны 5 дугаар сард системийг хүлээн авсан.

Энэ систем нь боловсролын салбарын сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалтын оновчтой төлөвлөлт, байршил, хамран сургах тойрог болон кластерийн тооцоололд одоо байгаа сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн мэдээлэл, хүн амын өсөлтийн дунд хугацааны төсөөлөл, шинээр баригдаж буй барилга, байгууламжийн мэдээлэл, сургалтын байгууллагын мэдээлэл, суралцагчийн хаягийн мэдээлэл, өрхийн хаягийн сангийн мэдээлэл, Монгол Улсын 0-18 насны хүүхдийн байршлын мэдээлэл, 2022 оны хүн амын тооллого, нийслэлийн болон хөдөө орон нутгийн авто зам, явган хүний замын маршрут гэсэн үзүүлэлтийг ашигласан болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, 2024 оны төсвийн хязгаарын санал, 2023, 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг газар зүйн мэдээллийн системийн шинжилгээг хийж, саналыг боловсруулж, БШУС-ын 2023 оны 1а/1540, 2023 оны 1а/2609, 2023 оны 1а/3765 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлуулж ажиллав.

2.3.9.2.Цэцэрлэг, сургуулийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон төсөв, гадаадын зээл тусламжаар 200 сургууль, 273 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон АХБ, АНУ, БНХАУ, Япон зэрэг улсын зээл тусламжийн санхүүжилтээр 2020-2023 онд ерөнхий боловсролын 84 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 157 байгууллага, дотуур байр 9, ерөнхий боловсролын спорт заал 3 тус тус ашиглалтад орж хүүхдийн тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлж ажиллав.

Засгийн газрын 2023 оны "Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 290 дугаар тогтоолыг батлуулж, хэрэгжилтийг эрчимжүүлж ажилласны үр дүнд 2023 оны байдлаар 70-дээш хувийн гүйцэтгэлтэй ерөнхий боловсролын сургуулийн барилгын 97 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна.

2.3.9.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээ авна.

Биелэлт: Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл арга хэмжээг 4 ээлжээр зохион байгуулж ажилласны үр дүнд нийт 62 цэцэрлэг, 106 сургууль, 82 дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар сольж ашиглалтад оруулав.

Улсын хэмжээнд 1,638.4 сая төгрөгийн санхүүжилттэй зураг төслийн ажил 71.4 хувь, 38,790.81 сая төгрөгийн санхүүжилттэй барилга угсралтын ажил 48 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, 2024 оны эхний хагас жил бүрэн дуусгахаар ажиллаж байна.

2.3.9.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/177 дугаар тушаалаар, "Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам" 2020 оны А/184 дүгээр тушаалаар тус тус батлагдаж хэрэгжсэн.

Хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай цэцэрлэг нийслэлд төрийн өмчийн 3, аймгийн төвд хувийн хэвшлийн цэцэрлэг ажиллаж байгаа бөгөөд тусгай болон ердийн цэцэрлэгт цэцэрлэгт жилд дунджаар 1,204 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 5,606 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тус тус боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр "Боловсролын чанарын шинэчлэл" төсөлд 63 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн төвийн 21 сургуульд "Хүүхэд хөгжлийн танхим", Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургуулиуд дээр эрүүл мэндийн танхим нээж, "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-өөр нийслэлийн 25 цэцэрлэгт 125 сая төгрөгийн тохируулгат хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнээр тохижуулж, "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төслийн "Тэгш хамран сургах боловсрол", "Сургуулийн үдийн хоол" бүрэлдэхүүн хэсэгт нийт 12 аймгийн 113 сургуулийг хамруулсан. Мөн "Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл" /G9208/-ийн хүрээнд нийслэлд 1, орон нутгаас 3 цэцэрлэг сонгон, Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах сургалтын орчны загвар бий болгох, цэцэрлэгийн удирдах ажилтан,

багш нарыг чадваржуулах модуль сургалтуудыг зохион байгуулсан.

2.3.9.5.Тусгай цэцэрлэг, сургуулийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангана.

Биелэлт: Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургууль (320 суудал бүхий), цэцэрлэгийн тус бүр 4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилгын зураг төслийг улсын төсвийн хөрөнгөөр (100 сая төгрөг) батлуулсан бөгөөд 1 сургуулийн барилга газар чөлөөлөх шатанд, 2 цэцэрлэгийн барилга угсралтын ажил 50 хувьтай хэрэгжиж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад 2021-2023 онд "Тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах нийт 900 сая төгрөгийн төсөв батлагдсаныг тус тус хуваарилан худалдан авах ажиллагааг зарлан гэрээ байгуулан тусгай хэрэгцээт цэцэрлэгт 51 нэр төрлийн, сургуульд 38 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээн авч хуваарийн дагуу түгээлт хийж ажилласан.

2.3.9.6.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллийн төв байгуулна.

Биелэлт: Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэгт "Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна." тусгасан болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/200 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны чиглэл, "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхимд тавигдах шаардлага", 2022 оны А/288 дугаар тушаалаар "ЕБС-ийн хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зөвлөмжийг тус тус баталснаар суралцагчдыг сонголтот хөтөлбөрөөр, сайн дурын үндсэн дээр хамрагдах боломжийг бүрдүүлсэн.

Суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг Боловсролын үнэлгээний төвийг түшиглэн цахим хэлбэрээр (www.myfuture.mn) хүргэж, аймаг, дүүрэгт насан туршийн боловсролын төвд "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхим"-ийг 574.2 сая төгрөг, Боловсрол, соёл урлагийн газар, хэлтсүүдэд 175.8 сая төгрөг, БМДИ-д 50.3 сая төгрөг буюу АХБ-ны санхүүжилтээр нийт 800.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулсан байна.

Боловсролын ерөнхий газрын Насан туршийн боловсролын хэлтэс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа "Ажил мэргэжил судлалын үндэсний төв"-тэй хамтран аймаг, дүүргийн насан туршийн боловсролын төвүүдийн "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхим"-д ажиллах багшийг чадавхжуулах болон МСҮТ, политехникийн 79 байгууллагын нийгмийн ажилтныг хамруулсан нийт 363 удаагийн сургалт, үйл ажиллагаанд давхардсан тоогоор 985,982 суралцагч, иргэн хамрагдсан байна.

2.3.9.7.Барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Боловсрол, шинжлэх ухааны яам сургууль, цэцэрлэг, дотуур байр, тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэг, спорт заалны барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг улсын төсвийн хөрөнгөөр хийлгэх захиалгыг Барилга, хот байгуулалтын яаманд өгсөн.

Барилга, хот байгуулалтын яам БШУЯ-тай хамтарч нийт 30 нэг маягийн зураг төсөв боловсруулж, магадлал хийлгэж ажилласан байна.

2.3.10.Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгоно. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.

2.3.10.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлнэ.

Биелэлт: "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7005:2023 үндэсний стандартыг боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн С/20 дугаар тушаалаар баталсан.

Энэ стандартыг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн дэмжлэгтэйгээр 200 хуудас зөвлөмжийн төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн бөгөөд зөвлөмжийг хөндлөнгийн редакцын багт шилжүүлээд байна. Стандартыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх бөгөөд шинээр батлагдсан стандартыг сурталчлан таниулах сургалтыг аймаг, нийслэл, орон нутгийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд 2 удаа зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах чиглэлээр улсын төсвийн санхүүжилт болон гадаадын буцалтгүй зээл тусламжаар 35 сургуулийн хоолны газрыг зориулалтын дагуу засварлан, 354 сургуульд 888 нэр төрлийн 1.4 тэрбум төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан байна. Төрийн өмчийн 688 сургуулийн 416 сургууль буюу 60.4 хувь нь стандартын шаардлагад нийцсэн хоол үйлдвэрлэлийн орчныг бүрдүүлсэн байна.

2.3.10.2.Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгоно.

Биелэлт: Засгийн газрын "Үдийн хоолны норматив тогтоох тухай" 2021 оны 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн нэг сурагчид ногдох үдийн хоолны зардлын нормативыг хүн амын зохистой хооллолтын талаарх зөвлөмжид заасан хэмжээ, инфляцын түвшинтэй уялдуулан 1500 төгрөг байхаар тогтоосон бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн 378,034 сурагч үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа буюу нийт сургуулийн 99 хувь буюу үдийн хоолоор үйлчилж, 12 сургууль (нийслэлд 8, Хөвсгөл, Өвөрхангай аймагт 4) бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байна

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар дунд ангийн сурагчдын үдийн хоолны үйлчилгээнд шилжих хугацааг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдэх хүртэл үе шаттайгаар эхлүүлэхээр шийдвэрлэсэн буюу УИХ-ын “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2019 оны тогтоолын 2 дахь заалтыг УИХ-ын 2022 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж, “дунд, ахлах ангийн суралцагчдыг зохих бэлтгэл хангасны үндсэн дээр үдийн хоолны үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах” гэж зааснаар дунд, ахлах ангийн суралцагчийн үдийн хоолны үйлчилгээнд хамрагдах хугацаа хойшилсонтой холбоотойгоор үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын шийдэл, үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөөг шинэчлэх судалгаа, тооцоолол, төслийг боловсруулж байна.

2.3.10.3.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дээр стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт: 2021 онд 596 сургуульд 5393 ширхэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж шаардлагатай байсан бол 2023 оны байдлаар 172 сургуульд 262 ширхэг ус цэвэршүүлэгч

төхөөрөмж нийлүүлснээр 397 сургуульд 5028 ус цэвэршүүлэгч төхөөрөмж шаардлагатай байна. 2023 оны статистикийн урьдчилсан мэдээгээр баллонтой 3674, шугамд холбогдсон 2047 нийт 5721 ус цэвэршүүлэгч төхөөрөмж ерөнхий боловсролын сургуульд байна.

Төрийн өмчийн 688 сургуулийн 57.7 хувь нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр бүрэн хангагдаад байна.

2.3.10.4.Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2 дахин нэмэгдүүлж, төр, эцэг эх, асран хамгаалагч хамтран хариуцах зарчмаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын "Норматив батлах тухай" А/166, А/559, 222 дугаар хамтарсан тушаалаар "Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт", "Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-г баталсан.

Дээрх нормативын дагуу сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хоолны зардлыг хуваалцах боломжийн судалгаагаар эцэг эх, асран хамгаалагчдын 56% нь хоолны зардал өгөх, 76% нь өдөрт 1000-1500 төгрөг өгөх боломжтой гэсэн дүн болон шаардлагад үндэслэн "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай (нэг өдрийн хоолны зардлыг 4000 төгрөг, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг, цэцэрлэгийн бүлгийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 5100 төгрөг болгон улсын төсвийн санхүүжүүлэх хувь хэмжээ, эцэг эх, асран хамгаалагчийн хариуцах хувь хэмжээг тогтоосон) асуудлыг засгийн газрын 2023 оны 31 дүгээр тэмдэглэлээр хойшлуулсан.

Орон нутгаас Өмнөговь аймгийн Засаг даргын 2023 оны "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэмэгдэл" олгох тухай А/101 захирамжаар цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 3712 төгрөгөөр тогтоож, тус аймгийн 31 цэцэрлэгт 6617 хүүхэд хамрагдаж байна.

2.3.10.5.Боловсролын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, лабораторийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын 2021, 2022, 2023 оны төсвийн тухай хуулийн хавсралтын холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж тайлант хугацаанд БШУС-ын тушаал (2021 оны А/03 дугаар тушаалаар 9.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ, 2022 оны А/23, 2023 оны А/14 тоот тушаалаар 41-н багц төсөл, арга хэмжээ)-ыг үндэслэсэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалуудаар байгуулсан ажлын хэсэг техникийн тодорхойлолтыг боловсруулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

"Боловсролын чанарын шинэчлэл" төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор 8 аймгийн (Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий) төвийн сургуульд 265.2 сая төгрөгийн өртөгтэй ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл бүхий "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим" байгуулсан бөгөөд Японы "Хүүхдийг ивээх сан"-гийн "Хүүхэд бүрийг тэгш хамран сургах нь" төслөөс 16 сургуульд 5 Насан туршийн боловсролын төвд 41 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна.

Улсын хэмжээнд 134 сургуулийг нийт 888 нэр төрлийн 1.4 тэрбум төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан бөгөөд нийт 1.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, сургалтын бусад хэрэглэгдэхүүн бүхий 15 цэцэрлэг, 11 сургуулийн өргөтгөл шинээр ашиглалтад оруулсан. 11 аймгийн (Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл, Архангай, Баян-Өлгий) Засаг даргын тамгын газар орон нутгийн төсвийн хөрөнгөөр боловсролын байгууллагуудад

компьютер тоног төхөөрөмж, зөөлөн эдлэлийн зардалд 8965.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн, багш нарыг компьютержүүлэх ажлыг хэд хэдэн аймаг санаачлан зохион байгуулж, шинээр ашиглалтад орсон 24 цэцэрлэгт 759.0 сая төгрөгийн 29 нэр төрлийн тоног төхөөрөмж олгосон байна.

2023 онд шинээр ашиглалтад орж байгаа 18 сургууль, 6 дотуур байр, 5 спорт заалны барилгад, нөхөн хангалтад нийт 435 сургуульд 17.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, шинээр ашиглалтад орсон 29 цэцэрлэг, 2 цогцолбор нийт нөхөн хангалтыг 430 цэцэрлэгт 6.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж тус тус олгосон. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 146 сургуульд 488.6 сая төгрөгийн 155 ширхэг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хэрэгслийг нийлүүлж, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулсан. Ингэснээр Төрийн өмчийн 688 сургуулийн 416 сургууль буюу 60.4% нь стандартын шаардлагад нийцсэн хоол үйлдвэрлэлийн орчныг бүрдүүлсэн байна.

2.3.11. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

2.3.11.1. Урлаг, биеийн тамирын хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсгээр сургууль, цэцэрлэгийг хангана.

Биелэлт: 2021 оны Улсын төсвийн “Боловсрол, шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмж” багцаас Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/03 дугаар тушаалаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад “Морин хуур” хөгжим худалдан авах” төсөвт өртөг 540.0 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуульд “Морин хуур” хөгжим худалдан авах төсөвт өртөг 645.0 сая төгрөг, “Ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд техник хэрэгсэл худалдан авах” төсөвт өртөг 350.0 сая төгрөгийг тус тус баталж, 2022 онд Боловсролын ерөнхий газар сургууль, цэцэрлэгүүдийг тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсгээр хангасан бол 2023 онд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэгцээнд 587.6 сая төгрөгийн төгөлдөр хуурын худалдан авалт хийн 38 сургуульд, биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүн 503.8 сая төгрөгөөр 9 нэр төрлийн 1000 ширхэг тоног төхөөрөмж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 339.6 сая төгрөгөөр 5 нэр төрлийн 254 ширхэг техник, хэрэгсэл, биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүн 271.4 сая төгрөгөөр 26 нэр төрлийн 18.343 ширхэг тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж түгээсэн байна.

2.3.12. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.

2.3.12.1. Бүх насны иргэд насан туршдаа суралцах боломжийг дэмжих, тэдний бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгож өргөжүүлнэ.

Биелэлт: 2023 онд баталсан Боловсролын ерөнхий хуулийн 3.1.7-д насан туршийн суралцахуйн ойлголтыг, 3.1.9-д албан бус боловсрол, 3.1.10-д “амьдралын орчинд суралцахуй” гэж хүний ажил, амьдрал, нийгмийн орчинд бие даан чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг хэлнэ гэж тусгасан болон “Боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр”-ийг Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2021 оны А/88 дугаар тушаалаар эрх зүйн орчныг шинэчилсэн бөгөөд үүнтэй холбогдуулан иргэдийн суралцахуйн хэрэгцээний судалгааг хийж, үр дүнг нэгтгэн бэлэн болголоо.

“Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах бодлого 2023-2030” бодлогын

баримт бичгийн төсөл боловсруулсан бөгөөд 2021 онд батлагдсан хөтөлбөртэй нийцүүлэн “Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журам”-ыг хэлэлцүүлсэн.

Иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих зорилгоор /medle.mn/tele/21 сайтад бага, суурь, боловсролын түвшинд 3, 3 судлагдахуунаар тус бүр 12, иргэдийн боловсролд зориулан 8 чиглэлээр 229 теле хичээлийг байршуулан түгээсэн байна. Насан туршийн боловсролын эрх зүйн орчны хэрэгжилтийг хангахад чиглэсэн холбогдох судалгаа, бүртгэлийн 4 маягыг боловсруулан холбогдох сургалт мэдээллийг 2023 онд зохион байгуулж, аймаг нийслэлийн Насан туршийн суралцахуйн төвийн сургалтын захирал, менежер, БШУГ-ын мэргэжилтэн 86 удирдах ажилтан хамрагдав. “Албан бус боловсролын Амьдрах ухааны хөтөлбөр”-ийн сургалтад хөдөлмөрийн насны 208, төрийн албан хаагч 81, хөгжлийн бэрхшээлтэй 8, БЕГ-ын НТБХ мэргэжилгүй 64, ажилгүй 80 иргэн хамрагдаж, 95 иргэнд чадамжийн гэрчилгээ олгов. БШУС-ын 2018 оны А/168 тоот тушаалаар батлагдсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролыг дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-ын дагуу ерөнхий боловсролын зохион ангийн агуулгын бие даан эзэмшсэн бага боловсролд 7, суурь боловсролд 42, бүрэн дунд боловсролд 5, бүгд 84 иргэн үнэлгээ, баталгаажилт хийлгэн боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж байна. Тэдгээрийн 11 нь насанд хүрэгчид байна

2.3.12.2.Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгож, цахим хичээлийн сан бүрдүүлнэ.

Биелэлт: Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч бие даан суралцах, мэдлэг чадвараа бататгах үйлийг дэмжих, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын тасралтгүй байдлыг хангах, багш хичээл, сургалтыг зайнаас зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ сурах үйлийг дэмжихэд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий MEDLE.MN сургалтын нэгдсэн платформыг 2021 онд боловсруулсан бөгөөд дараах үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд:

- Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2021 оны “Ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэх тухай” А/237, 2022 оны “Журам батлах тухай” А/123 (ерөнхий боловсролын сургуулийн контентын санг бүрдүүлэх), 2022 оны “Аргачлал шинэчлэн батлах тухай” А/384 (ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн контент сонгон шалгаруулах) тушаалуудаар тус тус батлагдсан;
- 21 аймгийн Боловсролын газар, ерөнхий боловсролын 45 лаборатори сургуульд “Контент боловсруулах лаборатори” байгуулах зардлыг шийдвэрлэсэн бөгөөд Medle” контентын санд ээлжит хичээл 9,027, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, Интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршсан байна. Мөн БШУЯ Польшийн “Learnetic” боловсролын технологийн компанитай хамтран ЕБС-ийн бага ангийн 33 сурах бичгийн бүх дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт бүрэн шилжүүлж дууссан;
- Нийт ахлах ангийн сонгон судлах хичээлийн сонголтыг боловсролын салбарын мэдээллийн системийн суралцагчийн удирдлагын системээр дамжуулан 83,740 сурагч хичээл сонголт хийсэн бөгөөд сургуульд бүлэг бүрдээгүйгээс 475 сургуулийн 10, 11-р ангийн 15,539 сурагч цахим сургуульд суралцаж байгаа бол 282 багш 1,024 бүлэг удирдан хичээл зааж байна;

2.3.12.3.Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж,

багшийг мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах ажлыг үе шаттай зохион байгуулна.

Биелэлт: АХБ-ны санхүүжилтээр "Багш" платформыг нэвтрүүл бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн багш нар гүйцэтгэлийн үнэлгээний дүн, өөрийн хэрэгцээндээ суурилан модуль сургалтад цахимаар хамрагдаж байна. Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих "Модуль сургалт"-д мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах, мэдлэг, чадвар эзэмшүүлэх 14 модуль сургалт зохион байгуулж 16400 багш хамрагдсан.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн онлайн сургалтын талбар болох MOODLE системд суурилсан "Багшийн цахим кампус"-г мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын 181 онлайн курс, STEM боловсролын сургалтын 4, "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалтын 18, "Анги удирдсан багшаар дамжуулж, эцэг эхийн боловсролыг дэмжих нь" арга зүйн зөвлөмжийн 4, "24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн бүлгийн багшийг чадавхжуулах" сургалтын 5, "Цахим ба танхим хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх сургалт"-ын Google Classroom дээрх 21-н курс нийт 322 онлайн курс үүсгэж, зорилтот бүлэг тус бүрд онлайн сургалтыг зохион байгуулсан. Мэргэжил дээшлүүлэх сургалт нь "Боловсролын бодлого чиглэл", "Мэдээлэл, харилцаа холбооны технологи", "Хувь хүний хөгжил", "Мэргэжлийн онол арга зүй" гэсэн 4 ерөнхий агуулгын хүрээнд нийт 96 цагийн цахим болон бие даалт, вебинар хэлэлцүүлэг гэсэн хосолсон арга хэлбэрээр зохион байгуулагдаж, оролцогчид нь 8 багц цагийн агуулгыг онлайнгаар судалсан

2023-2024 онд Medle.mn цахим платформд багш, ажилтны цахим, онлайн орчинд сургалт зохион байгуулах ур чадварыг сайжруулах 16 модуль сургалт зохион байгуулах багш нарын бүртгэлийг сонгон шалгаруулах зарчмаар зохион байгуулж, нийт 8,554 хичээлийг давхардсан тоогоор 870 багш боловсруулж, хичээлийн контентын санд байршуулсан байна. (2021 онд цахим хичээл шалгарсан 44 багш 453 хичээл, 2022 онд 470 багш 4,467 хичээл, 2023 онд 356 багш, 3,643 хичээл)

2.3.12.4. Боловсролын салбарт мэдээллийн системийн инновацыг нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт: БШУС-ын 2021 оны "Мэдээлэл солилцох арга хэмжээний тухай" А/403 дугаар тушаалаар боловсролын салбарын мэдээллийн системийн мэдээллийн бодит байдлыг хангах, нэгж байгууллагын ажлын ачааллыг бууруулах зорилгоор боловсрол, сургалтын байгууллагын өөрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагын хөгжүүлсэн сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын системийг Боловсролын салбарын мэдээллийн системтэй сервисээр холбох боломжийг бүрдүүлсэн бөгөөд СӨБ-ийн түвшинд 1, ЕБС-ийн түвшинд 15, Дээд боловсролын түвшинд 26, Орон зайн мэдээллийн системийн түвшинд 2, Боловсролын үнэлгээний төвд зориулж 5 сервисийг developer.esis.edu.mn системд байршуулж ДБУМС-ийн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөр, хичээлийн жил, улирал, суралцагч, сургалтын агуулга, багш, улирлын дүн, хөтөлбөрийн дүн, санхүүгийн дэмжлэг, суралцагчийн санхүү, эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр модулийн сервисээр мэдээлэл солилцож эхэлснээр их, дээд сургууль төгссөн эсэх тухай лавлагааны сангийн баяжуулалтыг хийж, Үндэсний дата төвд байрлах сервисээр дамжуулан Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia системээр дамжуулан лавлагааг цахим хэлбэрээр олгож эхэлсэн. Нэгдсэн сүлжээний өргөтгөлийн ажлын хүрээнд өнгөрсөн хугацаанд шинээр ашиглалтад орсон, сүлжээний дэд бүтэц очоогүй орон нутгийн болон шилэн кабель нь гэмтэж, тасарсан нийт 291 ерөнхий боловсролын сургуульд шилэн кабель татах, засварлах ажлыг зохион байгуулж дуусгаснаар бүх төрийн өмчийн ЕБС-ийн сүлжээний дэд бүтэц хэвийн ажиллагаатай болсон. Дээд боловсролын баримт бичгийг блокчэйн технологиор

баталгаажуулах системийн хөгжүүлэлтийг БМТТ, Корекс ХХК-тай хамтран хийсэн Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг Тагнуулын ерөнхий газрын МАБГ-аар хийлгэсэн.

БШУС-ын 2022 оны “Шаардлага батлах тухай” А/111 дүгээр тушаалаар “Боловсрол сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага /LMS, SMS”, А/370 дугаар тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системд тавих шаардлага”-ыг тус тус баталж, 5 аж, ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулснаар дээрх системүүдийг цэцэрлэг, сургууль сонголттойгоор боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. Нийт 381 сургууль SMS, LMS-ийг, 21 цэцэрлэг, сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд Боловсролын салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцож байна.

2.3.12.5. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт мэдээллийн системийн инновацыг нэвтрүүлнэ.

Биелэлт: АХБ-ны санхүүжилтээр Шинжлэх ухааны салбарын албан ёсны статистикийн мэдээг онлайн хэлбэрээр цуглуулж, нэгтгэн, цахим порталд байршуулах нээлттэй шинжлэх ухааны цахим порталыг хөгжүүлэх MON TA-9375 төслийг Инфокон ХХК хэрэгжүүлж, судалгааны төслийн модуль, төслийн уралдаан сонгон шалгаруулалт зарлах модуль, төслийн санал илгээх модуль, ЭШ, Судалгааны грант зарлал, ЭШ, Судалгааны байгууллагуудын жагсаалт, нийтлэл хуваалцах систем, Бүтээлийн хуулбар илрүүлэгч, Эшлэлийн бүртгэл, Бодлогын баримт бичигт санал авах модуль, шинжлэх ухааны хурлын систем, шинжлэх ухааны сургалтын эх үүсвэрийн бүртгэл зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Шинжлэх ухаан, инновацын салбарын мэдээллийн нэгдсэн системийн бизнес шинжилгээ, систем архитектурыг боловсруулах чиг үүрэг бүхий хувь зөвлөх 6 сарын хугацаатай ажиллаж, системийн бизнесийн шинжилгээг хийж, системийн бүтцийн зургийг боловсруулж, эцсийн тайланг хүлээлгэж өгсөн. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт мэдээллийн системийн инновацыг нэвтрүүлэхээр салбарын мэдээллийн системүүдийн нэгтгэл ба хөгжүүлэлтийн чиглэлээр судалгааг хийсэн.

“Судлаачийн мэдээллийн сан” системийн хөгжүүлэлтийг “Гөү смарт” ХХК-аар гүйцэтгүүлж, судлаачдын нэгдсэн бүртгэлийг үүсгэн шинжээч сонгох, төслийн анхан шатны саналыг хүлээн авч, бүртгэх, төсөлд үнэлгээ хийх шинжээчийг түлхүүр үгийг илэрцээр томилох зэрэг хөгжүүлэлтийг хийсэн. Тус нэгдсэн мэдээллийн санд III улирлын байдлаар 920 судлаач бүртгүүлсэн байсан бол жилийн эцсийн байдлаар 1526 судлаач бүртгүүлсэн өссөн дүнтэй байна. Тус www.project.stf.gov.mn цахим мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан 2023 онд нийт 186 төслийн саналыг цахимаар хүлээн авч, шалгаруулаад байна. Ингэснээр, төсөл болон судлаачдын мэдээллийн нэгдсэн сан үүсч, төсөл бүртгэх, сэдвийн давхардал шалгах, шинжээчийг сонгох, шинжээчээр төсөл уншуулах бүх үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн.

2.3.12.6. Салбарын үйлчилгээг цахимжуулан иргэд, байгууллагад хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод хүргэнэ.

Биелэлт: АХБ-ны Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд "Багшийн хөгжил" платформ bagsh.edu.mn домэйн хаяг дээр байршуулсан.

Боловсролын салбарт суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дээд боловсролын сургалтын байгууллага төгссөн дипломын лавлагаа, боловсролын сургалтын байгууллагад

суралцаж байгаа тухай тодорхойлолт болон ерөнхий боловсролын сургуулийн улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар, ЭЕШ-ын дүн оноо лавлагаа гэсэн 6 төрлийн лавлагааг болон ХУР систем дээр багш, оюутны сервис, E-Mongolia систем дэх цахим үнэмлэхээр төрөөс үзүүлж буй тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулал, автобусны карт, төлбөрийн НӨАТ-ын буцаан олголт, багшийн үнэмлэхийн лавлагаа зэрэг үйлчилгээг тус тус олгож байна.

Мөн E-Mongolia системээр СӨБ, ЕБС-ийн 2023-20234 оны хичээлийн элсэлтийг зохион байгуулж, И-Монгол академи болон ГТСМТ төвтэй хамтран Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1. дүгээр зүйлийн 7 дугаарт заасан БШУЯ-ны олгох зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэв.

2022-2023 оны хичээлийн жилд багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим ба танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, нийт 7,914 багшийг хамруулан, сургалтын батламжийг ebatlammj.agency.edu.mn системээр цахим хэлбэрээр олгоод байна. бөгөөд боловсролын баримт бичгийн лавлагаа нь 1000 төгрөгийн үнэтэй байсныг 02 дугаар сараас үнэ төлбөргүй олгодог болгосон.

Боловсролын салбарын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг гүйцэтгэж, Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тусгай зөвшөөрөл олгох, сунгах хүсэлтийг журмын дагуу иргэн, аж ахуйн нэгжээс 2021 оны 2 дугаар сарын 15-аас 3 дугаар сарын 12-ны хооронд Боловсролын мэдээллийн технологийн төвийн www.license.edu.mn системээр дамжуулан цахимаар хүлээн авсан. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia.mn системд тусгай зөвшөөрлийн системийн тухай мэдээллийг байршуулж иргэн, аж ахуйн нэгжүүд цахим үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэв.

2.3.12.7. Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийг байгуулж, чадавхыг бэхжүүлнэ.

Биелэлт: Мэдээллийн технологийн чиглэлээр үйлчилгээ болон колл центрийн үйлчилгээ үзүүлэх аутсорсингийн нэгдсэн төвийг ШУТИС МХТС-ын дэргэд 10 давхар барилга, мэргэжлийн боловсон хүчинтэй 2023 онд байгуулах гэрээтэй ч “Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв”-ийн барилга угсралтын ажил 50 хувь (каркас төмөр угсрах)ийн гүйцэтгэлтэй.

Сургалтын 16 хөтөлбөрийн жагсаалтыг баталсан болон 2022 онд 10 онлайн сургалтад ШУТИС-ийн МХТС-ийн сургалтын төвд 386 суралцагч, БНЭУ-д зохион байгуулсан Data Analytics, Cyber Security сэдвээр 45 хоногийн танхимын сургалтаар нийт 15 хүн (ШУТИС-МХТС-ийн мэргэжлийн 13 багш, БМТТ-ийн 2 инженер) тус тус хамрагдлаа.

2.3.12.8. Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэнэ.

Биелэлт: Засгийн газрын 2023 оны “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах” 115 дугаар тогтоолоор дээд боловсролын тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл, баталсан бөгөөд түүнд тэргүүлэх чиглэлд мэдээллийн технологи, Программ хангамжийн инженерчлэл, эрэлттэй мэргэжилд Программ хангамж, IoT (Зүйлсийн интернэт) технологи гэсэн мэргэжлүүд багтсан. БШУС-ын 2021 оны “Шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай” А/174 дүгээр тушаалаар ШУТИС-д Мультимедиа технологи, өгөгдлийн сан, хиймэл оюун ухаан, IoT технологи, робот ба хиймэл оюун ухаан, Ухаалаг сүлжээ гэсэн мэргэжил шинээр нээж 2021-2022 хичээлийн жилд элсэлт авч, мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн. БШУС-ын 2022 оны А/160 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн батлахдаа энэ чиглэлийн 13 мэргэжлийг тусгасан.

Мэдээлэл харилцаа холбоо технологийн салбарын чиглэлээр 2021-2023 онд давхардсан тоогоор 18,670 оюутан 24 нарийвчилсан хөтөлбөрөөр суралцаж байна. БНЭУ-н санхүүжилтээр хэрэгжиж буй Мэдээллийн технологи, аутсорсингийн төслийн 2-р багц нь мэдээлэл харилцаа холбоо технологийн инженер, оюутан залуус, багш нарын чадавхыг бэхжүүлэх 16 хөтөлбөрөөр онлайн сургалтаар 15, 2023 онд онлайн сургалтыг ШУТИС дээр зохион байгуулж, 400 суралцагч болон БНЭУ-д 2022 онд Data Analytics, Cyber Security сэдвээр, 2023 онд Training on CCNP Level Certification, Virtualization using VMWare сэдвээр тус тус 45 хоногийн танхимын сургалтад ШУТИС-ийн багш, Боловсролын мэдээлэл технологийн төвийн инженер нийт 30 хүн сургалтад хамрагдлаа.

2.3.12.9.Цахим бичвэр, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

Биелэлт: Иргэдийн насан туршдаа суралцахуй, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор <https://medle.mn/tele/21> сайтад бага боловсролын түвшинд монгол хэл, математик, иргэний боловсрол гэсэн судлагдахуунаар 12, суурь боловсролын түвшинд монгол хэл, математик, иргэний боловсрол судлагдахуунаар 12, иргэдийн боловсролд зориулан гэр бүлийн боловсрол, мэдээлэл, харилцаа холбоо технологийн боловсрол, эрх зүйн боловсрол, амьдрах ухааны боловсрол, эрүүл мэндийн боловсрол, соёл, гоо зүйн боловсрол, санхүүгийн боловсрол, Санхүүгийн боловсрол, Тогтвортой хөгжлийн боловсрол чиглэлээр 229 теле хичээлийг байршуулан түгээн дэлгэрүүлж байна.

Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын 859 сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын 78 байгууллагын хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаагаар “Цахим хэрэглээ”, “Цахим орчны хүүхэд хамгаалал”, “Цахим дээрхлээс сэргийлье”, “Цахим орчинд таван дүрмийг хэвшүүлцгээе” “Цахим ухаалаг хэрэглээ” зэрэг сургалт, танилцуулга хийж, 39 мянган суралцагчийг хамруулсан. БШУЯ “Мета” компанийн FARO Foundation ТББ-аас хэрэгжүүлж буй “We Think Digital - Бид цахим иргэд” төсөлтэй 2021 оноос хамтран ажиллаж байна.

Энэхүү төслийн хүрээнд цахим аюулгүй байдал, хувийн нууцлалаа хангах, эерэг харилцаа, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх болон хуурамч, ташаа мэдээллийг хэрхэн таних вэ зэрэг агуулгаар найман загвар хичээлийг монгол хэлнээ орчуулж, үнэ төлбөргүй түгээсэн.

Цахим орчин дахь мэдээллийн урсгалд аюулгүй байдлаа хамгаалах, мэдлэг мэдээлэлтэй иргэнийг төлөвшүүлэхэд тасралтгүй сургах чадвар бүхий ерөнхий боловсролын сургуулийн 1,000 гаруй багш, 170 орчим нийгмийн ажилтан, 40 сургагч багшийг сургагч багшаар бэлтгэсэн.

Сургагч багш нар ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвүүдээр дамжуулан хувь хүний хөгжил, амьдрах ухаан, цахим орчны зүй зохистой хэрэглээний чиглэлээрх сургалтад 10,000 гаруй суралцагч, иргэдийг хамруулсан байна.

2.3.12.10.Цахим агуулга, цахим хичээл боловсруулан насан туршийн боловсролыг бүх хэлбэрээр дэмжинэ.

Биелэлт: АХБ-ны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл”ийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах цахим сурах

бичигт тавих шаардлага, сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, ээлжит хичээлийн цахим контентод тавих шаардлагыг тус тус боловсруулан яамны удирдлагуудад танилцуулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Цахим сурах бичиг, ерөнхий боловсролын сургалтад ашиглах сургалтын нээлттэй материалд тавих шаардлага батлах тухай" А/193 дугаар тушаалаар батлуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч болон насан туршийн боловсрол эзэмшигч бие даан суралцах, мэдлэг чадвараа бататгах үйлийг дэмжих, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын тасралтгүй байдлыг хангах, багш хичээл, сургалтыг зайнаас зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ сурах үйлийг дэмжихэд дэмжлэг үзүүлэх, суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багш нарын бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах боломжтой MEDLE.MN сургалтын нэгдсэн платформыг боловсруулсан бөгөөд контентын санд дээрх ээлжит хичээлээс гадна ЕБС-ийн 147 цахим сурах бичиг, 4140 теле хичээл, 230 интерактив контент, 805 виртуал лаборатори, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршийн боловсрол, цахим ур чадварын 413 контент тус тус байршсан бөгөөд багш, суралцагчид, эцэг эхчүүд ашиглаж байна.

2.3.12.11.Багш бүрийг компьютержуулж, "Ухаалаг сургууль", "Ухаалаг анги" төсөл хэрэгжүүлнэ.

Биелэлт: УИХ-н Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2020 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 01 дүгээр тогтоолд бүх шатны боловсролын байгууллагад цахим сургалтын эрх зүйн орчин бүрдүүлэх, боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэхээр тусгасан бөгөөд Монгол Улсын төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим орчныг бүрдүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, багшийн үндсэн үйл ажиллагааг дэмжих, ажлын байрандаа суралцах, зайн сургалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлууд хийсэн байна. Үүнд:

БНХАУ-н буцалтгүй тусламжийн хөрөнгөөр (10 сая доллар) ерөнхий боловсролын сургуулийн интернэтийн гадаад, дотоод сүлжээний орчин бүрдүүлэх асуудал шийдвэрлэсэн;

Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээнд төрийн өмчийн бүх сургуулиудад компьютер тоног төхөөрөмж, "Цахим танхим"-ын тоног төхөөрөмж, "Суурин болон зөөврийн компьютер, олон үйлдэлт принтер", "Ухаалаг анги" төслийг хэрэгжүүлж байна;

сургалтын зориулалтаар ашиглах Багшийн дата багц, LMS, SMS системийн үйлчилгээ, суурин болон зөөврийн компьютер, Таблет, Ухаалаг самбар, Утасгүй сүлжээний орчин бүрдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг төрийн худалдан авах үйл ажиллагааны цахим дэлгүүр (www.tender.gov.mn/mn/e-shop/)-т байршуулсан. Сургалтын байгууллага хувьсах зардлаараа өөрийн хэрэгцээнд нийцүүлэн сургалтын зориулалтаар ашиглах компьютер тоног төхөөрөмж худалдан авах, цахим анги танхим байгуулах, дотоод сүлжээний орчин бүрдүүлэх, багш бүрд компьютер олгох, багшийн дата хэрэглээ, LMS, SMS системийг авч ашиглах бүрэн боломжтой болсон.

2.3.13.Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхыг дээшлүүлнэ.

2.3.13.1.Боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгож, Багшийн хөгжлийн институт, Боловсролын судалгааны хүрээлэн, Боловсролын чанарын үнэлгээний төв, Насанд туршийн боловсролын хөгжлийн төвийг

шинэчлэн зохион байгуулна.

Биелэлт: Боловсролын багц хуулиар боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын хэрэгжүүлэх суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлын чиглэлийг тодорхой зааж өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 407 дугаар тогтоолоор Боловсролын хүрээлэнг “Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн”, “ЗГ-ын агентлаг байгуулах тухай” 403 дугаар тогтоолоор Боловсролын ерөнхий газар байгуулагдаж, эдгээр байгууллагын бүтэц, дүрэм болон Боловсролын үнэлгээний төвийн чиг үүргийг өргөжүүлж, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/21 дүгээр тушаалаар шинэчилсэн.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлд "Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн болон үнэлгээний байгууллага", "Насан туршдаа суралцахуйг дэмжих байгууллага"-ыг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн хөгжүүлэх хэм хэмжээний зохицуулалтыг тус тус тусгасан.

Боловсролын мэргэжлийн байгууллагын чиг үүргийг оновчтой болгосноор боловсролын судалгааны хүрээ өргөжсөн; үнэлгээний байгууллага зөвхөн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн үнэлгээнд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан бол боловсролын бүх түвшний суралцагч, багш, байгууллагын үнэлгээний асуудлыг цогцоор нь авч үзэх шийдэл, арга хэмжээ хэрэгжүүлдэг болсон зэрэг үр дүн гарч байна.

2.3.14. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.

2.3.14.1. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: УИХ-д өргөн мэдүүлсэн “Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд “Судалгааны их сургуулийн санхүүжилт” гэсэн 4 дүгээр бүлгийг санхүүжилтийн эх үүсвэр, санхүүгийн дэмжлэг, хөрөнгийн удирдлага гэсэн 3 зүйлтэй байхаар боловсруулсан.

Төрийн өмчийн их, дээд сургуулийн судалгааны зардалд Шинжлэх ухаан, технологийн сангаас төслийн санхүүжилтэд 1,447 тэрбум төгрөг (ШУТИС-ийн 18, МУИС-ийн 32, ХААИС-ийн 15, АШУУИС-ийн 9) олгосон бол Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээл (7.5 тэрбум иен) болон Монгол Улсын төсвийн санхүүжилт (615 сая иен)-ээр хэрэгжиж байгаа "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн хүрээнд МУИС болон ШУТИС-ийн сургалтын тоног, төхөөрөмж, лабораторийг шинэчлэх, хүртээмжийг сайжруулсан 9.4 сая ам.долларын үнэ бүхий 253 нэр төрийн 409 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Төслийн хүрээнд ШУТИС, МУИС-ийн 10, 10 судалгааны багийг шалгаруулан 384 багш, судлаачид Япон Улсын 40 гаруй их сургууль, хүрээлэнгийн 170 судлаачидтай хамтран Монгол Улсад нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж байгаа бөгөөд хамтарсан судалгааны багуудын судалгааны ажлын үр дүнд өссөн дүнгээр Олон Улсын сэтгүүлд 335 өгүүлэл, дотоодын сэтгүүлд 267 өгүүлэл хэвлүүлж, 37 бүтээлийг оюуны өмчийг бүртгүүлж, гарааны 3 компани үйл ажиллагаа явуулж байна

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, сургалт, судалгааны ажлыг дэмжих зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компани байгалийн ухаан, инженер технологийн чиглэлээр суралцаж буй нийт 68.0 сая төгрөгийн (8 докторантад 6.0 сая, 5 магистрантад 4.0 сая төгрөг) тэтгэлэг, их сургуулийн төгсөх ангийн судлаач оюутнуудын дунд 5.0 сая төгрөгийн шагналын сан бүхий төслийн уралдаан зарлан хэрэгжүүлсэн. Төрийн өмчийн их, дээд

сургуулиудын судалгааны болон бусад зардалд хийсэн шинжилгээгээр 21 сургууль судалгаанд улсын төсвөөс 1.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, олон улсын төсөл, хөтөлбөрийн шугамаар 8.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургалт, лабораторийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч, ахисан түвшний болон зэргийн бус хөтөлбөрт 130 багш, судлаачдыг хамруулсан байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 222 дугаар тушаалаар баталсан "Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацын тэтгэлгийг олгох журам"-ын дагуу төсөл хэрэгжүүлэгч 9 докторант нарт дараах грантыг олгосон.

2.3.15. Орон нутаг дахь мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.

2.3.15.1. Орон нутаг дахь их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.

Биелэлт: 2023 онд батлуулсан Дээд боловсролын тухай төслийн 18.1.4 “Орон нутагт ажиллах дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарт орон сууцны дэмжлэг үзүүлэх”, 17.2.1-д "орон нутаг дахь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 5 жил тутамд нэг удаа олгох", Боловсролын ерөнхий хуулийн 13.3.1-д "хөдөлмөрийн онцлогийг харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын ... багш, багшийн туслах, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт олгох", Дээд боловсролын тухай хуулийн асуудлыг тухайн сургалтын байгууллагын дотоод журмаар тусгасан болон Засгийн газрын “Их, дээд сургуулийг сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 321 дугаар тогтоолд орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд ажиллаж байгаа багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан бол зохих тэтгэмж олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулдаг байх зохицуулалт бий болгох асуудлыг судлан, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахаар зохицуулсан байна.

Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 347 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-д 5.1.3-д "Оюутны хөгжлийн зээлийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуульд бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцагчийн сургалтын төлбөрийн 50 хүртэлх хувийг зээлээр олгоно", 5.1.4-д "Оюутны хөгжлийн зээлийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуульд суралцагчдад энэ журмын 5.1.1-д заасан тэргүүлэх болон эрэлттэй мэргэжил харгалзахгүй олгоно" 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 3.2.2, 34.1 дэх заалтын дагуу орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд суралцах оюутнуудад сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, зээл олгох асуудал нь 2023-2024 оны хичээлийн жилд шинээр элссэн болон үргэлжлүүлэн суралцаж буй 770 суралцагчдад 668.5 сая төгрөгийн тэтгэлэг олгосон. (Дорноговь, Дархан-Уул, Говь-Алтай дахь дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцаж байгаа 691 оюутанд 608 сая төгрөг, Дорнод, Архангай, Ховд, Баян-Өлгий аймаг дахь дээд боловсролын сургалтын байгууллагад багш мэргэжлээр суралцаж байгаа 81 оюутанд 60.5 сая төгрөг)

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Өмнөговь аймгийн Засаг даргатай 2021 онд

байгуулсан гэрээгээр "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль"-д 2022-2023 оны хичээлийн жилд элсэн суралцагчдын нэгдүгээр улирлын сургалтын төлбөрийн 50 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс зарцуулах зөвшөөрөл олгосон.

2.3.16. Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.3.16.1. Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2023 оны "Төрийн өмчийн зарим их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 307-р тогтоолоор их сургуулийн харьяа төрөлжсөн сургалттай 3 ахлах сургуулийг шинээр, 12 ахлах сургуулийг Боловсролын багц хуулиудад нийцүүлэн өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн.

Олон улсын хөтөлбөрөөр /Кембрижийн/ хичээллэж байгаа төрийн болон хувийн өмчийн 22 сургууль байгаа бөгөөд "Cambridge Assessment International Education" байгууллагаас Cambridge, AP, IB хөтөлбөрөөр сургалт явуулахаар ерөнхий боловсролын 11 сургууль эрх авсан бөгөөд ерөнхий боловсролыг зарим сургуулиудад кембрижийн хөтөлбөр туршилтыг БШУС-ын 2023 оны "Туршилт зохион байгуулах тухай" А/456 дугаар тушаалаар (нийслэлийн 32, 157, Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургууль болон Төв аймаг дахь Политехник коллежид) туршилтыг эхлүүлсэн.

БШУС-ын 2023 оны "Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" А/240 дугаар тушаалаар батлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлт, сургалтын хөтөлбөрийн болон тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их, дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шалгуурын дагуу гадаад, дотоодын чанарын үнэлгээний мэргэжлийн байгууллагууд тогтоож, 2023 онд нийт 61 их, дээд сургуулийн эрэмбийг нийтэд танилцуулсан

Шинжлэх ухаан, технологи, инновац.

2.4.Шинжлэх ухаан, технологи, инновац. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.

2.4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.

2.4.1.1. Салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлнэ.

Биелэлт: Эрдэм шинжилгээний байгууллагын чадавхыг бэхжүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох зорилгоор төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн жагсаалтыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Жагсаалт батлах тухай" А/51 дүгээр тушаалаар 26 эрдэм шинжилгээний байгууллагын 99 судалгааны үндсэн чиглэл, хамрах хүрээний 322

сэдвийн жагсаалтыг баталсан. Улсын төсвийн байгууллагуудын эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардал нь ДНБ-д эзлэх хувь 0.11, төр, хувийн хэвшлийн байгууллагын түншлэлийн хүрээн дэх ДНБ-д эзлэх хувь ойролцоогоор 0.18 байна.

БШУЯ-аас шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэхэд чиглэсэн шинэчлэлийн 6 зорилтын хүрээнд Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэл /30 ЭШХ, төв/-ийг тогтоож, "ШУТС-аас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам", "Эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам"-ыг 2022 онд батлууллаа.

Шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлэхэд суурь судалгааны үргэлжлэн хэрэгжиж буй 115 төслийн 1.9 тэрбум төгрөг, шинээр хэрэгжиж буй 64 төслийн 811 сая, суурь хавсарга судалгааны 18 грант төсөлд 113 сая төгрөг, гадаадтай хамтарсан 32 төслийн 285.1 сая төгрөг, үргэлжлэн хэрэгжиж буй улсын захиалгат 54 төслийн 1.3 тэрбум төгрөг, шинээр хэрэгжиж буй 28 төслийн 687 сая төгрөг, инновацын 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацын 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон бөгөөд 94 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шинжлэх ухаан, инновацын нэгдсэн цогцолборын барилгын ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж, 2023 онд дуусгахаар төлөвлөсөн ч 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.4.1.2. Шинжлэх ухаан, технологи, инновацын хамтын ажиллагааг эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэл, зохицуулалтыг хийж, татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.

Биелэлт: Инновацын тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т "Гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална" гэж заасантай холбогдуулан СЗХ-ны 2021 оны 348 дугаар тогтоолоор "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-ын 1.5, 1.6, 2.4.6, 2.5.10, 3.4, 3.5, 3.6, 3.7, 4.2, 4.5, 4.5.1, 4.5.2 гэсэн заалтуудыг шинээр тусган гарааны компани биржийн бус зах зээлд олон нийтэд хувьцаагаа санал болгох зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтийг баталсан.

2022 онд Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулсан. Гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны асуудлыг хөндөхдөө шинжлэх ухаан, технологи, инновацын хамтын ажиллагааг эдийн засгийн хөшүүргээр дэмжих, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хамтарсан дэмжлэгийг бүрдүүлэх, хамтын түншлэлд суурилсан судалгаа хөгжүүлэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой эрх зүйн зохицуулалт бүхий заалт тусгасан.

Шинжлэх ухаан, технологи, инновацын хамтын ажиллагааг татвар, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих ажлын хүрээнд Засгийн газрын 2023 оны 39 дугаар тогтоолын хавсралтаар "Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам"-ыг батлуулсан бөгөөд Технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид татварын дэмжлэг үзүүлэх журам Инновацын төсөл хэрэгжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт олгох журмын төслийг боловсруулсан.

2.4.1.3. Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахад

хөнгөлөлттэй зээл, грант олгоно.

Биелэлт: Эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг татварын бодлого болон эдийн засгийн хөшүүргээр дэмжих зорилгоор Засгийн газрын 2023 оны 39 дугаар тогтоолоор "Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам", 2022 оны 497 дугаар тогтоолоор "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг батлуулан тус тус хэрэгжүүлж байна

Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор БШУС-ын А/422 дүгээр тушаалаар 2 инновацын төсөлд, залуу судлаачдын "Эрдэм хакатон"-ны шилдэг 5 төсөлд, Нийгмийн инновацын санаачилгыг дэмжих "Мон Икс" хөтөлбөрийн шилдэг 9 төсөлд тус тус дэмжлэг үзүүлж грант олгосон. Инновацын тэргүүлэх чиглэлийн хүрээнд технологийн туршилт, зүгшрүүлэлтийн 40 төсөлд 2 тэрбум төгрөг (2021 онд 15 төсөлд 247.8 сая төрөг, инновацын 16 төсөлд 341.2 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүллээ 2022 онд 350 сая төгрөг, 2023 онд 794 сая төгрөг) олгосон

ШУА-ийн Биологийн хүрээлэн, ХӨСҮТ, МУИС-ийн эрдэмтдийн багийн хамтарсан Sars-Cov2 вирусийн халдварын эсрэг бие үүсэж, дархлаа тогтсон эсэхийг богино хугацаанд илрүүлэх оношлуурын цомгийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг төрөөс 180 сая төгрөгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

2.4.1.4.Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, дэвшилтэт технологийг нутагшуулахад чиглэсэн санаачилга, хөрөнгө оруулалт, бүтээлч үйл ажиллагааг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт:Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дараах дэмжлэг үзүүлсэн. Үүнд: Инновацын тэргүүлэх салбар чиглэлийн хүрээнд БШУС-ын А/269 дугаар тушаал ДТҮЭХ-ийн барилгын дулаан алдагдлыг бууруулах технологийн шийдэл бүхий "Хавсарга судалгааны төсөл"-д 199.3 сая төгрөг, ковидын нөхцөл байдлыг даван туулахад монгол эрдэмтдийн санаачилсан, хамтран нутагшуулсан технологийн туршилт зүгшрүүлэлтийн болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор БШУС-ын А/334 дүгээр тушаалаар "Эмнэлзүйн туршилт судалгаа"-д 154 сая төгрөгийн судалгааны дэмжлэг тус тус үзүүлсэн.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг үндэслэн эрдэм шинжилгээ, судалгааны 5 төсөлт ажилд 821.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлснээр судалгааны үр дүн үйлдвэрлэлд амжилттай нэвтэрсэн

БШУЯ-ны харьяа Шинжлэх ухаан, технологийн сан нь 3 улсын шинжлэх ухаан, судалгааны сантай хамтран 23 төслийг (Тайвань улсын Үндэсний шинжлэх ухаан, технологийн зөвлөлтэй 6 төсөл, БНХАУ-ын Байгалийн шинжлэх ухааны сантай 6 төсөл, Беларусын Бүгд Найрамдах суурь судалгааны сантай 11), хэрэгжүүлж байгаа болон ковидын улмаас зогссон ОХУ-тай хамтран хэрэгжүүлж байсан хамтарсан төслүүдийг 2024 оноос эхлэн сэргээхээр болсон.

Шинжлэх ухаан, технологи, инновацын шийдэлтэй гарааны бизнесүүдийг дэмжсэн, экосистем, мэдээлэл технологийг хөгжүүлдэг гарааны бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгох Гарааны бизнесийг дэмжих санг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК ХХК-ийн дэргэд байгуулан Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авахаар ажиллаж байна.

Эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, дэвшилтэт технологийг нутагшуулахад чиглэсэн санаачилга, хөрөнгө оруулалт, бүтээлч үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Эрдэм хакатон 2023" тэмцээнийг зохион байгуулж 5 төсөлд ("Артемис", "Эко хөнгөн бетон", "Метаког", "Экора Грийн гоулд", "Амин хүнс") грант олгосон.

2.4.1.5. Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, инновацын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

Биелэлт: Инновацын тэргүүлэх чиглэлийн судалгаа хөгжүүлэлтийн эрх зүйн зохицуулалт сайжирсан. (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль шинэчлэлээр Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолын хавсралтын 47-д заасны дагуу "Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр", "Инновацыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх заавар"-ыг БШУС-ын 2021 оны А/76 дугаар тушаал, Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлах зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн бүрэлдэхүүнийг БШУС, УУХҮС-ын 2023 оны А/235, А/200 дугаар хамтарсан тушаалаар тус тус шинэчлэн баталсан.)

"Ухаалаг засаг төсөл"-ийн хүрээнд инновацын дэд төслийг зарлах, сонгон шалгаруулах, бойжуулах, инновацын грант олгох, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох арга хэмжээг зохицуулахад мөрдөх "Инновацыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх заавар"-ыг баталж, инновацын 16 дэд төсөлд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Үүний зэрэгцээ судалгаа хөгжүүлэлтийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор инновацын 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацын 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжилтийг хангасан.

"Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/347 дугаар тушаалаар 6 төсөлд инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх грант олгосон.

Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлах зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн шийдвэрээр Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургууль (Геологи, уул уурхайн сургууль, Уул уурхайн сургууль, Механик тээврийн сургууль) Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг 3 жилийн хугацаатай тус тус олголоо.

2.4.1.6. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, эрдэм, шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлнэ.

Биелэлт: ШУА-тай 6 зорилт бүхий "Чадварлаг эрдэмтэн хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2023 оны "Төрийн өмчийн их сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 306 дугаар тогтоолын 5 дахь заалтад "шинжлэх ухаан, технологи, инновацын өндөр мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, үндэсний чадавхыг бэхжүүлэх" талаар тусган батлуулсан.

2.4.2. Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж,

олон улсын стандартад нийцүүлнэ.

2.4.2.1.Шинжлэх ухааны паркийн эрх зүйн орчныг бүрдүүлж, парк байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

Биелэлт: Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/177 дугаар тушаалаар Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах ажлын хэсгийг байгуулж урьдач нөхцөл байдлын судалгаа болон эдийн засаг, үр нөлөөний судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, шинжлэх ухааны паркийн хөрөнгө оруулалтын тооцоо, техник, ТЭЗҮ зэргийг боловсруулсан. Шинжлэх ухааны паркийн ТЭЗҮ боловсруулахад шаардагдах санхүүжилтийг Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 оны 5 жилийн үндсэн чиглэлийн хавсралтаар баталсан арга хэмжээний зүйл заалтыг үндэс болгон тооцож, саналыг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. БШУЯ-ны баталсан “Сургалт-Эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ын ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврын хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 506.4 га газарт хийгдэх Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолборын ерөнхий төлөвлөгөөний 65 га газарт Шинжлэх ухаан, технологийн бүс хэлбэрээр Шинжлэх ухааны парк, шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийн кластеруудийн дэд бүтцийг цогцоор тусгуулахаар судалж байна. НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурал (UNCTAD)-тай хамтран “Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан шинжлэх ухаан, технологи, инновацын парк Монгол Улсын бодлогын орчин, практик чадавхыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

2.4.2.2.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолборыг олон улсын стандартад нийцүүлж, нээлттэй, салбарын дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах замаар эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн судалгааны нэгдмэл байдлыг хангана.

Биелэлт: “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 4.8 га талбайд баригдах ба 74,300 м.кв ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэх 94.0 тэрбум төгрөгийн нийт төсөвтэй, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50.0 хувьтай байна.

2.4.2.3.Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барина.

Биелэлт: Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэг үйлчилгээ, судалгаа, сургалтын цогцолборын зураг, ТЭЗҮ нь 2021 онд боловсруулагдаж БХТ-ийн магадлангаар орсон. Нийт барилгын төсөв 25.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр баригдахаар төлөвлөгдсөн. Барилгын хөгжлийн төвийн Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан. Тус барилгын ажлыг 27.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйг болж өөрчлөгдсөн ба 2023 оны улсын төсөвт санал хүргүүлсэн, батлаагүй.

2.4.2.4.Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан судалгааны үндэсний төвүүдийг байгуулж, хөрөнгө, нөөцийг төвлөрүүлнэ.

Биелэлт: Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан судалгааны үндэсний төвийг байгуулах ажлын хүрээнд Шинжлэх ухааны академи болон төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэн тэдгээрийн материаллаг бааз, хүний нөөцөд түшиглэн төрийн өмчийн их сургуультай хамтарсан ахисан түвшний дээд боловсролын сургалтын байгууллага байгуулахыг судлах талаар 2023 оны 306 дугаар тогтоолоор батлуулсан.

2.4.3.Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эдийн засаг, нийгмийн хөгжилд өгч байгаа үр

өгөөжийг шалгуур болгон санхүүжүүлдэг өрсөлдөөнт тогтолцоонд шилжүүлж, нэгдсэн, төрөлжсөн, нээлттэй лабораторийг байгуулан салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

2.4.3.1. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад технологийн инкубатор, технологи дамжуулах төв байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

Биелэлт: БНХАУ-тай хамтран “Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт”, “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслүүдийг хэрэгжүүлж байна. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын дэргэд нийт 25 гарааны компани байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Шинжлэх ухааны академийн дэргэд “Технологийн инкубатор” ХХК биотехнологи, микробиологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, технологийн хөгжүүлэлт хийж байна. МУИС, ШУТИС, АШУҮИС, ХААИС-ийн дэргэд Инновац, технологи дамжуулах төвүүд байгуулагдан, үйл ажиллагаа нь тогтмолжсон. Эдгээр төвүүд нь багш, судлаачид, оюутан, зохион бүтээгчдийн ноу-хау, судалгааны үр дүнг оюуны өмчийн эрхийн хамгаалалтаар баталгаажуулан эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Инновацын тухай хуулийн 16.4.1-д заасны дагуу Засгийн газрын 2023 оны 39 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам”-д заасан шаардлагыг хангасан 5 хамтын оффис, 2 технологи дамжуулах төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан.

2.4.3.2. Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

Биелэлт: Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг Шинжлэх ухааны хүрээлэнгийн цогцолборт байгуулж байна. Лабораторийн 3 барилгын гадна фасад, дээвэр, цонх, аваарын шат, дотор өрлөг шавар, цахилгаан шат, сангийн болон салхивчны системийн ажил бүрэн дууссан. Гадна цахилгааны ажлыг дуусаж улсын комисст хүлээн авсан. Гадна дулаан болон цэвэр, бохирын шугамын ажлыг 90 хувьтай байна.

2.4.3.3. Монгол судлалыг олон улсын болон бүс нутгийн хүрээнд өргөжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, бэхжүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол судлалын үндэсний зөвлөлийн жил бүр тогтсон хугацаанд хуралдаж Монгол судлалын үндэсний зөвлөлийн төлөвлөгөө тухайн жилийн зардлыг батлах, өмнөх оны үйл ажиллагаанд хяналт хийх зэрэг ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж байна. Үүнээс Монгол судлалын үндэсний зөвлөл, Олон улсын Монгол судлалын холбооны үйл ажиллагааг дэмжих, монгол судлалыг сурталчлах, гадаад дахь монгол судлалын төвүүдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2023 онд 12 арга хэмжээ тусгагдсан. Монгол судлалыг сурталчлах хүрээнд Олон Улсын Монголч эрдэмтний XII их хурлыг зохион байгуулсан.

2.4.3.4. Шинжлэх ухаан, технологи, инновацын статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.

Биелэлт: Шинжлэх ухаан технологийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг үндэсний хэмжээнд боловсруулан, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны А/69 дугаар тушаалаар батлуулан улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна. Шинжлэх ухаан технологийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн боловсруулж, Үндэсний статистикийн

хорооны даргын 2020 оны А/71 болон А/72 тоот тушаал болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/215 тоот тушаалаар тус тус батлуулан мөрдөж байна. Шинжлэх ухаан технологийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан. ҮСХ-ноос 2021 онд зохион байгуулсан “Аж ахуйн нэгжийн долоо дахь удаагийн тооллого”-оор дамжуулан БШУЯ-аас анх удаа аж ахуйн нэгжийн инновац, судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг үндэсний хэмжээнд цуглуулж, үр дүнг нийтэд түгээсэн. Тухайн арга хэмжээний үр дүнд шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын статистикийн мэдээллийн үзүүлэлтийн хүрээг нэмэгдүүлж, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын бодлого, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх цогц мэдээлэл бүхий их өгөгдлийн санг бий болгосон. Мөн олон улсын аргачлалын дагуу анх удаа үндэсний хэмжээнд хувийн хэвшлийн байгууллагуудын судалгаа шинжилгээний ажилд зарцуулж буй зардлын талаарх мэдээллийг цуглуулах тогтолцоог бий болгосон. Захиргааны 10, албан ёсны 11 маягтын 900 гаруй үзүүлэлтээр жил бүр шинжлэх ухаан инновацын статистик мэдээллийг тооцон гаргаж байна.

2.4.3.5. Шинжлэх ухааны мэдлэг, инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, танин мэдэхүйн агуулга бүхий контент бүтээх ажлыг дэмжих замаар шинжлэх ухаанч соёлыг төлөвшүүлнэ.

Биелэлт: Инновацын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, шинэлэг санаа, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Монголын инновацын 7 хоног” арга хэмжээг жил бүр төрийн байгууллага, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. “Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацыг нутагшуулъя” түгээн дэлгэрүүлэх аяныг 2022 оны 2-8 дугаар саруудад Өмнөговь, Орхон, Хөвсгөл, Дархан аймагт амжилттай зохион байгуулсан. Аяны зохион байгуулалтын хүрээнд аймаг тус бүрд шинжлэх ухааны салбарын 80 гаруй эрдэмтэн, мэргэжилтнүүд очиж ажиллан, инновацын 200 гаруй бүтээгдэхүүнийг танилцуулж, нийт 6,000 гаруй иргэнд салбарын тухай мэдээллийг түгээн дэлгэрүүлсэн.

Улсын хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж буй инновацын гарааны бизнесүүдийг дэмжих, хурдасгах, бүс нутагт хамтран ажиллахыг дэмжих зорилготой “Нийгмийн инновацын 7 хоног” арга хэмжээг цахим болон танхимаар “Кайт Монгол” ХХК-тай хамтран зохин байгуулсан. 2022 оны Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан “Шинэ сэргэлтийн бодлого дахь шинжлэх ухааны оролцоо” бодлогын хэлэлцүүлгийг 500 хүнд танхимаар, 4000 гаруй хүнд цахимаар зохион байгууллаа. Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/260 дугаар тушаалын дагуу иргэд, олон нийтийн нийгмийн инновацын санаачилгыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх “МОН ИКС” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд 518 иргэн бүртгүүлж, 151 төслийн санал ирсэн бөгөөд хөтөлбөрийн сургалт, менторинг, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээнүүд болон 2 шатны сонгон шалгаруулалтыг явуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

2.5. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.

2.5.1. Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд

шилжинэ.

2.5.1.1.Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжсэнээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, хуримтлал үүсгэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх зэрэг томоохон өөрчлөлтийг хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

2.5.1.2.Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: ХНХЯ нь иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, уг суурь тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн судалгаа, бусад орны суурь тэтгэвэр олгож буй туршлага зэргийг судлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд иргэн бүрд суурь тэтгэвэр олгохоор хуулийн төслийг боловсруулж намын бүлэг, төрийн болон төрийн бус байгууллагаар хэлэлцүүлэхэд нийгмийн халамжийн тэтгэвэр нь суурь тэтгэвэр тул хасах саналыг ирүүлсэнээр хуулийн төслөөс хассан болно. Харин тэтгэвэр авагч нас барсан бол Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэр бүлээ бүртгүүлсэн, 20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр, эсхүл нөхрийн тэтгэврийн хэмжээг нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн 20 хувиар нэмэгдүүлэхээр хуулийн зохицуулалтыг нэмж тусгаж батлуулсан.

2.5.1.3.Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улмаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан 10 аймаг, нийслэлд ахмадууд, залуучууд, сайн дураар даатгуулагчид, үйлдвэрчний эвлэлийн шат шатны байгууллага, ажил ологчдын төлөөлөл, худалдаа аж үйлдвэрийн танхим, хуульчдын холбоо зэрэг газруудаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг зохион байгуулсан.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин баталсан. Энэ дагуу Ажлын дэд хэсгийн гишүүд хуулийн төслийн санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. Улсын Их Хурлын D parliament цахим хуудсанд хандан 21 дэмжсэн санал, зарим холбогдох хуулийн заалтуудад өөрчлөн найруулах 22 саналыг тус тус ирүүлсэн бөгөөд 17,560 дэмжсэн санал өгсөн байна. УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийгмийн бодлогын байнгын хорооны дэд ажлын хэсэг 12 удаа хуралдсан. Мөн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг хэлэлцсэн.

2.5.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.2.1. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчны хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг тус тус 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар баталсан. Шинэчлэн батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх” харилцааг тусгасан. Тэтгэврийн нөөц санг даатгуулагчийн төлөх шимтгэлийн 2 хувь, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу улсын төсөвт шилжүүлсэн орлого, улсын төсвөөс олгох бусад орлогоос бүрдүүлэхээр хуульчилсан. Тухайлбал, 2024 оноос эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2.0 хувийн шимтгэлийн орлогыг хуримтлал болгох арга хэмжээ үе шаттай хэрэгжиж эхлэх бөгөөд 2024 онд 380 орчим тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг мөнгөжүүлэх, энэхүү эх үүсвэрээр тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн татаасыг нэмэгдүүлэн батлуулсан. Ингэснээр даатгуулагч боловсрол, эрүүл мэнд, орон сууцны ипотека зарцуулах боломжийг тухайлсан хуулиар зохицуулахаар тусгасан.

2.5.3. Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.

2.5.3.1. Хуримтлалын нэгдсэн сан бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/64 дүгээр тушаалаар Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж хуулийн төслийг боловсруулах чиглэлээр ажлын хэсгийн хурал 3 удаа, хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах, хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2023 оны 06 сарын 07-ны өдөр байгуулсан. Тус гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Монгол Улсын онцлогт нийцсэн Хуримтлалын тогтолцоог бий болгох Хуримтлалын нэгдсэн сангийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэрийн хамт боловсруулсан. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Хуримтлалын нэгдсэн сангийн орлого, зарлагын хэтийн төлөвийг тооцох актуар тооцооллыг хийж байна.

2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2.5.4.1. Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ.

Биелэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2011 онд шинэчлэн найруулснаас хойш 2015 онд Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай болон

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181, 88 дугаар конвенцыг Монгол Улсын Их Хурал соёрхон баталж, нэгдэн орсон. Улмаар конвенцын үзэл санаа, зүйл заалтыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

2.5.4.2. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний уян хатан зохицуулалт бий болгож, бүтээн байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2018 оны 259 дугаар тогтоолын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний зөвшөөрөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2020 онд эхлүүлж, цахим системийн хөгжүүлэлт хийгдэн, ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор ezuvshuurul.mn цахим хаягт төвлөрүүлэн бүрэн ашиглалтад оруулан ажиллаж байна. Цахим шилжилттэй холбогдуулан шаардагдах дүрэм журмыг батлуулж, иргэд, аж ахуйн нэгжээс цахим системээр дамжуулан бичиг баримтыг хүлээн авч шийдвэрлэж байна. Мөн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний мэдээллийн сан үүсгэн, холбогдох мэдээ, мэдээллийг цаг алдахгүй цахим системд байршуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна."Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох журам"-ын 3.3, 3.4, 3.5, 3.6-д заасан үйлчилгээг 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ezuvshuurul.mn системээр дамжуулан цахим хэлбэрээр үзүүлж байна.

"Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох" үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, ezuvshuurul.mn/out цахим систем хөгжүүлэн бүрэн ашиглалтад оруулаад байна. Уг системд 68 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй бөгөөд 2287 зуучлуулагч иргэн бүртгэлтэй байна. Ezuvshuurul.mn цахим систем нь ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой үйлчилгээг үзүүлэхээс гадна БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн Солонгос хэлний шалгалтын бүртгэлтэй холбоотой мэдээллийг цахимаар хүргэн ажиллах юм. Улсын Их Хурлаар 2001 онд батлагдсан "Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль"-ийг шинэчлэн найруулж "Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай" хууль нэрээр Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

2.5.4.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалттай уялдуулна.

Биелэлт: Боловсролын салбарт хэрэгжүүлж болох гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцооны схем, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, түүнийг үнэлэх үнэлгээний зааварчилгааны төслийг боловсруулж Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

2.5.4.4. Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалт бий болгоно.

Биелэлт: Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажилтныг ажлын бүтэн бус цагаар ажиллуулах, гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн онцлог харилцааг зохицуулсан заалтуудыг тусган, УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг эцэслэн баталсан. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар олон нийтэд сурталчлах арга хэмжээний төлөвлөгөөг ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжүүлж байна.

2.5.5.Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

2.5.5.1.Төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг урьд нь мөрдөж байсан цалингийн сүлжээний хамгийн өндөр буюу 5 дугаар шатлалаар тогтоосон. Үр дүнд нь төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин дунджаар 8.5 орчим хувиар нэмэгдсэн. Засгийн газрын 2022 оны 193 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах болон ТЗ-5 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг, төрийн захиргааны албан тушаалын АА-9 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүгчийн туслах болон АА-10 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоосон. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөвт төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх замаар цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан тогтоодог болох, төрийн албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хувь хэмжээгээр нэмэгдүүлэх дараах арга хэмжээ тусгагдсан. Үүнд: Төрийн албаны цалингийн олон шатлал, зэрэглэлийг цэгцлэн үндсэн цалинг шатлалгүй болгож, төрийн захиргааны 15 зэрэглэлийг 10 болгоно, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлнэ, орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах хүрээнд орон нутгийн нэмэгдэл олгох ба улсын төсвөөс 20 хувийн нэмэгдлийг олгоно. Энэ хэмжээг 100 хүртэл хувьд хүргэх эрхийг орон нутагт нь олгоно. Нийт төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дээшлүүлэх хүрээнд тэдний ажилласан жил бүрийг үнэлж, нэмэгдэл олгодог болно.

2.5.5.2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2023 оны 239 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 550.0 мянган төгрөгт, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр баталсан.

Дээрх арга хэмжээний хүрээнд нийт 486.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, 555.0 мянган төгрөг байсан дундаж тэтгэвэр 685.6 мянган төгрөгт хүрч 2016 оны дундаж тэтгэврийн хэмжээтэй харьцуулахад 2.2 дахин нэмэгдсэн. Мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталсан.

2.5.5.3.Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно.

Биелэлт: Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх ажлын хүрээнд дундаж цалин болон хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөд үндэслэн 2022 он суурьтай тэтгэвэр

бодох цалингийн итгэлцүүрийн хувилбарыг боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолоор баталсан. Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 07/1826 тоот албан бичиг хүргүүлж, хэрэгжилтийг зохицуулан ажилласан. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 485.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 683.2 мянган төгрөгт хүрсэн.

2.5.5.4.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бүсүүдийн хүн амын амьжиргааны түвшний дундажтай тэнцүү болгож нэмэгдүүлнэ.

Биелэлт: Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор "Тогтоолд өөрчлөлд оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн баталгааг хангах боломж бүрдсэн. Нэмж шаардагдах 109.5 тэрбум хөрөнгийг 2023 оны халамжийн сангийн төсөвт тусгасан. Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн батлуулсан. Мөн Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоов. Үүнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр 288 мянгаас 325 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 288 мянгаас 325 мянган төгрөг, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж 84.5 мянгаас 275 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэний тэтгэмж 123.1 мянгаас 275 мянган төгрөг, нэмэгдлийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 12.3%, 2020 оноос хойш нэмэгдээгүй байсан асаргааны тэтгэмжийн хэмжээ 2.2-3.2 дахин нэмэгдэв. 2023 онд Хүн амын амьжиргааны түвшин бүсүүдийн дундаж 282,880 төгрөг байгаа ба тэтгэврийн хэмжээ 7 сараас нэмэгдсэнээр амьжиргааны дундаж түвшнээс 12.9 хувиар илүү болсон. Мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталсан.

2.5.5.5.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилж, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 10 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 3,273 төгрөг 80 мөнгө буюу сард 550.0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоосон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ийнхүү нэмэгдүүлснээр бага цалинтай хэсгийн орлого 2023 онд 31 хувиар нэмэгдсэн.

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 3,929 төгрөг буюу сард 660.0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоогоод байна.

2.5.6.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.

2.5.6.1.Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолыг үндэслэн хэрэгжүүлж байгаа “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг хөгжүүлж байна. Нийгмийн халамжийн 68 төрлийн үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрт шилжүүллээ. Ингэснээр иргэд <https://e-mongolia.mn/services/citizen/sector/all>, <https://www.ehalamj.mn/> цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин “ТҮЦ” машин, <https://ebarimt.mn/> аппликейшн ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргаж, үйлчилгээг бүрэн авах боломжтой боллоо. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах ажилд тусгайлан зардал гараагүй болно.

2.5.6.2.Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ.

Биелэлт: Тэтгэврийн дэвтрийг бүрэн цахимжуулж 2021 оноос эхлэн тэтгэврийн цаасан дэвтэр олгохгүй, үүний оронд тэтгэвэр тогтоолтын хуудсыг цахимаар эсвэл цаасаар авах боломжтой болсон. Түүнчлэн “Эмнэлгийн хуудас олгох, хянах процессын зураглал, тайлбар, ажлын төлөвлөгөө”-г батлуулж, программд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулсан. 1990-2000 оны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн төлөлтийн мэдээллийг ND LAV программд холбов түүнчлэн 1995-2019 оны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн мэдээллийг ND LAV программ, нийгмийн даатгал аппликейшнд 2021 оны 05 дугаар сард бүрэн холбов. Нийгмийн даатгалын 34-н төрлийн үйлчилгээний 24-н үйлчилгээг нь цахимжуулан E-Mongolia системд 12 үйлчилгээг холбосон. Үлдсэн үйлчилгээг 2024 он хүртэл үе шаттайгаар цахимжуулах ажлыг зохион байгуулна.

2.5.6.3.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлнэ.

Биелэлт: ХНХЯ-аас хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад оруулсан. Тус платформ нь 3 дэд систем, 13 модулиас бүрдсэн. Систем нь “ХУР”, “ДАН” зэрэг төрийн бусад мэдээллийн системтэй холбогдож, хэрэглэгч бүрийн хэрэгцээнд тохируулан хөгжүүлж, хүндрэл бэрхшээлийг технологийн шийдлээр оновчтой шийдвэрлэхээр зорьсон болно.

2.5.6.4.Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Үйлчлүүлэгч төвтэй аргачлал”-ыг нэвтрүүлж, цахимжуулна.

Биелэлт: Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Цахим Монгол” арга хэмжээ, Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон хөдөлмөрийн хувийн биржүүд хөдөлмөр зуучлалын үйлчилгээг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн www.ejob.gov.mn вэбсайтаар дамжуулан иргэдэд түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэж байна. Уг цахим системд ажил хайгч иргэн хандсанаар өөрийн хөдөлмөр эрхлэх боломжийн үнэлгээг хийлгүүлэх, үүнд тулгуурлан ажил хөдөлмөр эрхлэх төлөвлөгөөгөө боловсруулах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө авах, холбогдох шаардлагатай дэмжлэг, туслалцааг цахимаар үнэ төлбөргүй авахаас гадна өөрийн ур чадвар, ажил, мэргэжилд нийцсэн ажлын байрны захиалгын дэлгэрэнгүй

мэдээллийг хүлээн авч ажилд зуучлагдах боломжтой болно. Нөгөө талаас ажил олгогч сул чөлөөтэй ажлын байрандаа өөрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажилтныг зуучлуулан авах боломжтой программ юм.

2.5.6.5. Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулна.

Биелэлт: Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний зөвшөөрөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2020 онд эхлүүлж, цахим системийн хөгжүүлэлт хийгдэн, ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор ezuvshuurul.mn цахим хаягт төвлөрүүлэн бүрэн ашиглалтад оруулан ажиллаж байна. Цахим шилжилттэй холбогдуулан шаардагдах дүрэм журмыг батлуулж, иргэд, аж ахуйн нэгжээс цахим системээр дамжуулан бичиг баримтыг хүлээн авч шийдвэрлэж байна. Мөн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний мэдээллийн сан үүсгэн, холбогдох мэдээ, мэдээллийг цаг алдахгүй цахим системд байршуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.

2.5.7. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ.

2.5.7.1. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгох, давхардлыг арилгаж халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай зорилтот бүлэгт тэтгэвэр, тэтгэмжийг чиглүүлэх үндсэн зарчмыг баримтлан Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийг боловсруулсан. Нөгөө талаар нийгмийн халамж болон хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг ялгаж, салгах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ. Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийн хүрээнд халамжийн хөтөлбөрүүдийг амьжиргаа багатай зорилтот хэсэгт чиглүүлэх, амьжиргааны түвшинтэй уялдуулах, өрх, иргэнийг чадавхжуулах, бие даан амьдралаа аваад явах чадвар дадлыг бий болгох, ажлын байранд бэлтгэх халамжаас хөдөлмөрт чиглүүлэх бодлогын шинэчлэлийг хийж Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой хуулийн төсөлд яамдаас дахин санал авч, хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

2.5.7.2. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэх зорилгоор өрхийн амьжиргааны түвшинг төрийн байгууллагын мэдээллийн санд үндэслэн тодорхойлдог байхаар аргачлалыг шинэчлэн, нэвтрүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын 2023 оны төсвийг УИХ-аар хэлэлцэж, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан. Уг төсөвт хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91 хувьд олгохоор шийдвэрлэсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар захирамжаар “Төрийн байгууллагын мэдээллийн санг ашиглан хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг тодорхойлох” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж холбогдох тооцоо, судалгааг хийж ажиллаж байна. Үүний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/189 дугаар тушаалаар “Төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион

байгуулах, програм хангамж хөгжүүлэх” ЦХХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг, “Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төсөл боловсруулах” Үндэсний статистикийн хорооны даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг тус тус байгуулсан. Ажлын хэсэг шаардлагатай 150 гаруй үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, хүснэгтийн талбарыг боловсруулсан. Үзүүлэлтийн өгөгдөл болох үндэсний статистикийн хороо өрхийн нийгэм, эдийн засгийн 2018, 2020 оны судалгааны 32 мянган өрх-иргэний мэдээллийг CD-нд буулгаж, төрийн байгууллагуудын нууцын ажилтнуудаар дамжуулан 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр бүх байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Нийт төрийн 14 байгууллагын мэдээллийг Үндэсний статистикийн хороонд гаргаж өгсөн.

2.5.7.3.“Цалинтай ээж” хөтөлбөрийг үргэлжлүүлж, 3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд ялгаварлалгүй олгоно.

Биелэлт: Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Дээрх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журмыг баталсан. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид нийт 181,030 иргэн хамрагдаж 71.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2.5.7.4.Ахмад настны амьжиргааг дэмжиж, орлогын баталгааг хангах зорилгоор “Насны хишиг” тэтгэмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт: Ахмад настны тухай хуульд заасны дагуу Насны хишиг тэтгэмжийг 2017 оноос эхлэн жилд 2 удаа 65 ба түүнээс дээш настай ахмадуудад олгосон. Насны хишиг тэтгэмж нь ахмад настнуудын эрүүл насжих, тэдний орлогын баталгааг бууруулахгүй байхад чиглэсэн томоохон дэмжлэг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 65 ба түүнээс дээш настай 176,906 ахмад настанд 26.6 тэрбум төгрөгийн насны хишиг тэтгэмжийг олгоод байна.

2.5.8.Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.

2.5.8.1.Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг батлуулан гэр бүлийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг бий болгох, шинэ төрлийн үйлчилгээг бий болгож нэвтрүүлнэ.

Биелэлт: Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг 2023.11.01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн олонх буюу 85.7 хувь нь дэмжиж, нэгдсэн хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэсэн. УИХ-ын чуулганы 11 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн 58 хувь нь дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн. Гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээний стандартын төслийг боловсруулж,

батлуулахаар ажиллаж байна.

2.5.8.2. Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих асуудлаарх эрх зүйн орчныг шинэчилж, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

Биелэлт: Хүүхэд хамгааллын тухай болон Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг 2020 онд хийсэн. Тус үнэлгээг үндэслэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулан Хүүхэд хамгааллын тухай хуулийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар дахин шинэчлэн батлуулсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдан боловсруулсан хуулийн төслийг Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

2.5.8.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийг төрийн бус байгууллагад 4 удаа хэлэлцүүлээд байгаа бөгөөд холбогдох БХБЯ, ЗТХЯ, ЦХХХЯ, Нийслэлийн ЗДТГ зэрэг төрийн байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн явцад гарсан санал, зөвлөмжийг хуулийн төсөлд тусган ажиллалаа. Хуулийн төсөл нь 6 бүлэг, 21 зүйлтэй бөгөөд нийтийн тээврийн хүртээмж, барилга байгууламж, авто зам, замын байгууламжийн хүртээмж, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж, үйлчилгээний хүртээмж гэсэн 4 төрлийн хүртээмжийн асуудлыг зохицуулах юм.

2.5.8.4. Хүн амын амьдралын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн Хүний амын хөгжлийн зорилтот хөтөлбөр, хүүхэд, залуучууд, ахмад настан, удмын сан, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” нь Засгийн газрын 2019 оны 389 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2020-2023 онд хэрэгжиж байна. Уг хөтөлбөр нь 4 зорилтын хүрээнд нийт 58 арга хэмжээг 75 шалгуур үзүүлэлтийн дагуу 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг холбогдох байгууллагууд төлөвлөгөөндөө тусган 2021 оны эхний хагас жилд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд 90 орчим хувьтай хэрэгжиж байна.

2.5.8.5. Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлнэ.

Биелэлт: ХНХЯ, АХБ хамтран “Олон нийтэд түшиглэсэн ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний шинэлэг тогтолцоо, үйлчилгээг хөгжүүлэх нь” техник туслалцааны ТА9928 төслийг хэрэгжүүлж байна. Уг төсөл нь эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтолцоонд суурилан хэрэгжих Идэвхтэй насжилтыг дэмжих төв (ИНДТ) байгуулах, Кейс менежментийг нэвтрүүлэх, урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар туршиж, үр дүнг тооцох 3 үндсэн зорилттой. Урт хугацааны тусламж, үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх хүрээнд АХБ-ны дэмжлэгтэйгээр олон нийтийн оролцоонд түшиглэн ахмад настанд урт хугацаанд үзүүлэх тусламж, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Техникийн туслалцааны (KSTA 9928) туршилтын төслийг 2022 онд хэрэгжүүлж, сонгосон 3 байршилд орон нутгийн удирдлага болон хамтран ажиллагч талуудын оролцоог бүрэн хангаж уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулж, тусламж үйлчилгээний цогц загварыг 3 төвд эхлүүлж орон

нутгийн нийт ахмадын 20 орчим хувийг хамруулав. Энэхүү төслийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/127, А/333 дугаар хамтарсан тушаалаар “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 53.3 хувийн хэрэгжилттэй байна.

2.5.8.6. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлнэ.

Биелэлт: Нийгмийн ажлын нийтлэг стандарт”, “Гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага” стандарт болон “Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг стандарт”-ын төслийг тус тус боловсруулж, Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартын техникийн хорооны 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэж, Стандарт, хэмжил зүйн газар батлав. Түүнчлэн “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам” болон “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 209 дүгээр тушаалаар батлуулсан.”Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/190, А/280 дугаар хамтарсан тушаалаар батлуулан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 5,600-д бүртгүүлсэн.

2022 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээг 77,967 хүүхдэд, урьдчилан сэргийлэх үйлчилгээг 318,900 хүүхдэд үзүүлсэн байна. Үүнд: а) 14,207 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн (харьяаллаар нь авч үзвэл: орон нутагт 10,842, нийслэлд 3,365) байна. б) Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын дагуу 3,625 хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээ, 18,843 хүүхдэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, 131906 хүүхдэд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлсэн байна. Энэ нь Улсын хэмжээнд нийт 34 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр насанд хүрсэн 1299 хүчирхийллийн хохирогч, 2,699 хүүхэд үйлчлүүлсэн. Нийт үйлчилгээ авсан хүүхдийн 116 нь 2-оос дээш удаа түр хамгаалах байранд ирсэн байна. Гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 1,757, асрамж, халамжийн үйлчилгээнд 82, дэмжих, холбон зуучлах үйлчилгээг 860 хүүхдэд үзүүлж, аюулгүй байдлыг ханган ажилласан.

2.5.8.7. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад нийт 12 төвийн санхүүжилтийн асуудлыг тусгуулан шийдвэрлүүлсэн. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийг дэмжих чиглэлээр шинээр 5, шилжих 12 барилга байгууламж барихаар 24.6 тэрбум төгрөгийг тусган батлуулсан. Хүн амын бүлэгт чиглэсэн төвүүдээр дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд: Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 5 сум (Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Номгон, Булган)-д ажиллаж, амьдрах ухааны сургалт, сонирхлын клуб, зөвлөлийг ажиллуулах, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ, тусламж,

гэр бүлийн зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээнд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг хамруулдаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 450 мянга гаруй залуучууд буюу нийт залуучуудын 45 хувьд хөгжлийн үйлчилгээг хүргэсэн. Мөн Ховд аймгийн Манхан сум, Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Завхан аймгийн Их-Уул суманд Залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулаад байна.

2.5.8.8. Хүүхдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөгжлийн үйлчилгээг хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

Биелэлт: “Найрамдал-2 цогцолбор”-ын барилгын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг ХНХЯ болон БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар хамтран баталсан. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны багцад барилгын зураг төсөл боловсруулах 1.1 тэрбум төгрөг тусгагдаж, тус яам зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зураг төслийн ажлын 50 хувийн гүйцэтгэлтэй, гэрээний дагуу 2022 оны 6 дугаар сард хүлээн авна. Найрамдал-2 зуслангийн 60 га газрыг 5 жилийн хугацаатай ХНХЯ эзэмших эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/122 тоот тушаалаар баталсан. Шаардагдах 10.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг МУ-н төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгуулсан. Найрамдал-2 цогцолбор (Хөвсгөл, Хатгал сум)-ын төсөл арга хэмжээний Өвлийн байрны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр зарлаж, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Тендерт оролцох сонирхсон этгээд тендер ирүүлээгүй үндэслэлээр хүчингүй болсон. Түүнчлэн Улсын хэмжээнд 2022 онд 38 хүүхдийн зуслан үйл ажиллагаа явуулж, 34042 хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулсан байна. 2022 оны А/854 тоот захирамжийн дагуу нийслэлийн ногоон бүсийн хүүхдийн зусланд зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуслангийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж 350 хүүхдийг амраасны 60 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран хамгаалагчийн хамт хүүхдийн Анар зусланд хөгжлийн хөтөлбөрт хамруулж, нийт 21 сая төгрөгийг зарцуулсан. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт 2022 онд нийт 154.6 сая төгрөгийн дэмжлэг 17 зусланд үзүүлсэн.

2.5.8.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.

Биелэлт: АХБ-ны санхүүжилтээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Ховд, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Дундговь, Дорнод зэрэг 6 аймагт олон улсын стандартад нийцсэн, түгээмэл загвар бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барихаар батлуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/159 дүгээр тушаалаар баталж, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Ховд аймгийн ХБХТ-ийн барилгыг 2022 онд хүлээн авсан. Төвийн үйл ажиллагааг 2023 оны 9 дүгээр сараас эхлэн үзүүлж, 10 дугаар сарын байдлаар 2053 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд үзлэг, сургалт мэдээлэл, эмчилгээ, зөвлөгөөний үйлчилгээ үзүүлсэн байна. Архангай аймагт баригдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улаанбаатар хотод байгуулагдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын угсралтын ажлыг 2022 оноос “Би энд Би” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, барилга угсралтын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.5.9. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.5.9.1. Орлого багатай өрхийн гишүүдэд мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ.

Биелэлт: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 8,091 иргэн хамрагдаж 557.2 сая төгрөг зарцуулж 5,747 иргэн ажлын байраар хангагдсан байна. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр 4,022 иргэн хамрагдаж, 233 иргэн ажлын байраар хангагдаж, 244.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 11,112 иргэн хамрагдаж, 1,224 иргэн ажлын байраар хангагдаж, 601.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.5.9.2. Хүн амын бүлгүүд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэх болон бусад үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангахад хөтөлбөрийн зорилго оршино. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийг 2021 оны 11 сарын байдлаар өссөн нийт 4,022 иргэн хамрагдаж, 233 иргэн ажлын байраар хангагдаж, 244.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцэст 9,156 иргэн хамрагдаж, 732 иргэн ажлын байраар хангагдаж, 487.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Түүнчлэн ажилгүй болон нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай 50,000 иргэнд профайлинг буюу хөдөлмөр эрхлэх ур чадварыг үнэлэх ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр тэдний онцлог хэрэгцээг тодорхойлж тохирсон ажил, үйлчилгээг санал болгож, ажлын байраар хангах боломж бүрдэх юм.

2.5.10. Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцүүлнэ.

2.5.10.1. Үндэсний мэргэшлийн хүрээг бүрдүүлэх бодлогын баримт бичгийг шинэчлэх, ажил мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгон, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн мөрдүүлнэ.

Биелэлт: “Мэргэжлийн боловсрол сургалтын агуулга, стандарт, арга зүйн бичиг баримтыг шинэчлэн боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 04 сард А/47 дугаар тушаалаар байгуулан, ажиллаж байна. Судалгааны ажлын хүрээнд Филиппин, Сингапур, Австрали, ХБНГУ-ын мэргэжлийн агуулга стандартыг судалж Монгол Улсад мөрдөгдөж байгаа “Ажил мэргэжлийн лавлах”, “MNS 6541:2015, Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага” стандартын агуулга, давхцалыг нэгтгэн “Ажил мэргэжлийн стандарт”-ын загвар, боловсруулах аргачлалыг Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээлэл арга зүйн төв болон Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэргэдэх ажил мэргэжлийн сургалт бүсийн төв, германы олон улсын хамтын нийгэмлэг төсөлтэй хамтран боловсруулсан. Олон улсад мэргэжлийн боловсрол сургалтын салбарт ашиглагдаж буй загвар стандартад нийцүүлэн давхцалыг арилгах замаар “Ажил мэргэжлийн стандарт”-ыг шинэчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 103.2.3-д “Хөдөлмөр нийгмийн

түншлэлийн гурван талт үндэсний хороо"-оор батлуулах заалтыг үндэслэн тогтоолын төслийг боловсруулсан.

Шинэчилсэн загварыг туршин 2 мэргэжлийн “Ажил мэргэжлийн стандарт”-ын боловсруулалтад арга зүйн зөвлөгөө өгч “Хөргөлтийн тоног төхөөрөмжийн техникч”, “Агааржуулалтын (эйркон) тоног төхөөрөмжийн техникч” мэргэжлийн стандартыг боловсруулсан.Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт 2022-2023 оны хичээлийн жилд нийтдээ 210 хөтөлбөрөөр хичээл сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тухайн хөтөлбөрийн агуулга нь шинжлэх ухаан, техник, технологийн хөгжил дэвшлийг дагаж 2-3 жил тутам байнга өөрчлөгдөж байгаа тул Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.2.3 дэх хэсгийг үндэслэн “Ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлалыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн үндэсний хорооны 2022 оны 04 дугаар тогтоолоор батлуулсан. Ажил мэргэжлийн стандартын загварт нийцүүлэн МАОЭНХ-ны дэргэдэх Ажил мэргэжлийн ур чадварын төвтэй хамтран эдийн засгийн 6 салбарын 19 мэргэжлийн стандартыг боловсруулж сургалтын агуулгад тусган хөтөлбөрийн боловсруулалтыг мэргэжлийн багш нар хамтран гүйцэтгэж сургалтад нэвтрүүлсэн.

Боловсролын Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөс 2023 оны 02 дугаар сард хийсэн Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын удирдлагуудад хийсэн хэлэлцүүлгээр цаашид байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг өөрчлөх санал гарсны дагуу “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага”-ын төслийг боловсруулан цахим системд оруулж удирдах ажилтнуудаас санал авсан. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч нь хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны шаардлагад нийцсэн чадамж эзэмшиж байгаа эсэхийг тогтоож, мэргэжлийн боловсрол, сургалтын талаар баримтлах бодлогын зөвлөмж боловсруулах зорилгоор Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг зохион байгуулж, дүнг нэгтгэж, холбогдох зөвлөмжийг гаргасан.

2.5.10.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын засаглал, удирдлагыг сайжруулах, багш, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ.

Биелэлт: Түншлэлд суурилсан техникийн ба мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд хэрэгжүүлсэн “Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын суралцахуйн удирдлагын U-TVET”, “TAMS” зэрэг системийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/284 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг хүлээн авсан. Мөн “Дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны систем”, “www.edu-track.gov.mn систем”-ийг тус тус гүйцэтгэгчээс Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны хамтарсан “Ажлын хэсэг байгуулах тухай” А/292, А/104 тоот тушаалаар байгуулагдан ажлын хэсэг хүлээн авсан. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 7 дахь заалтад “Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх” асуудал Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудалд шилжиж ирсэнтэй холбоотойгоор ХНХЯ-аас хөгжүүлж, нэвтрүүлсэн “Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн систем /mergejil.mn/”-ийг БШУЯ-нд хүлээн авч БМТТ-өөс шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийж www.tvets.edu.mn болгосон. Энэ онд Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн системийг ДБУМС-д суурилан шинээр хөгжүүлэн одоо ажиллаж буй системийг Төрийн мэдээллийн солилцооны ХУР системээр дамжуулан боловсролын сургалтын байгууллагад давхар бүртгэлийг хянах боломжтой болгосон. Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын 2022-2023, 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг тус системээр авч байна. Энэхүү арга хэмжээний үр дүнд

багш ажилтнуудыг давтан сургах, суралцагчийн давхардлыг хянаж, тэтгэлэг олгох, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгааг цахимаар хийх боломжийг бүрдүүлсэн ба мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын бүртгэл мэдээлэл 100 хувь цахимд шилжсэн.

2.5.11. Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.

2.5.11.1. Салбар дундын дадлагын баазыг байгуулна.

Биелэлт: Салбар дундын дадлагын баазыг Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн чадамжийн төв хэлбэрээр хөгжүүлэхээр нийт 10 төвийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн. Чадамжийн төвүүдийг ГОУХАН-ийн түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт төсөл, АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагааг өргөжүүлсэн. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг УИХ-ын 2023 оны 07 дугаар сард шинэчлэн батлуулсан. Уг хуульд чадамжийн төвийн эрх зүйн орчныг тусгасан. Чадамжийн төвүүдийн сайн туршлага, тогтвортой үйл ажиллагааг дэмжих мэдлэг туршлагаа хуваалцах төлөвлөлтийн семинарыг 2023 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 306 дугаар тогтоолоор их сургуулийг сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх, шатлан суралцах тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Политехник коллежийн харьяанд Хөдөө аж ахуй, газар тариалангийн дундын дадлагын бааз, Дархан-Уул аймаг дахь Политехник коллежийн харьяанд Техник, технологийн дундын дадлагын бааз ажиллуулахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд 20223-2024 оны хичээлийн жилээс холбогдох ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.

2.5.11.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг “НОГООН ХӨГЖИЛ”-ийн үзэл баримтлалд тулгуурлан санхүүгийн олон эх үүсвэртэй болгож салбарын хэрэгцээнд нийцүүлэн төрөлжсөн салбар дундын үйлдвэрлэл, дадлагын баазыг байгуулж, шинэ хотхоныг бий болгоно.

Биелэлт: Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ ухаалаг, цогцолбор хотхоныг ногоон хөгжлийн үзэл баримтлал тулгуурлаан бүтээн байгуулахад шаардагдах урьдчилсан тооцоо, судалгааг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/54 дугаар тушаалаар байгуулагдан ажилласан. Энэ хүрээнд шинэ хотхон байгуулах ажлыг сургалт, үйлдвэрлэлийн түншлэл, эрэлтэд суурилан сургалтын чанарыг дээшлүүлж өндөр ур чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хөтөлбөрийн давхцалыг арилгаж шатлан суралцах боломжийг бүрдүүлэхээр Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Технологийн дээд сургуулийг Өмнөговь Политехник коллежтой Орхон аймагт Эрдэнэт технологийн дээд сургуулийг мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагатай кластер хэлбэрээр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Технологийн дээд сургуулийг байгуулан, 2022-2023 оны хичээлийн жилд 120 оюутантайгаар сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн. Өмнөговь аймаг дахь дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 3000 оюутны хүчин чадал бүхий “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулахаар “Оюу толгой” ХХК-тай хөрөнгө оруулалтын санамж бичгийг байгуулсан.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн ГОУХАН-ийн түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт төсөл 7, АХБ-ны

Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн дэмжлэгтэйгээр 2 чадамжийн төв нийт салбарт 9 чадамжийн төв байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр чадамжийн төв нь сургалтын байгууллагууд хамтран туршлага солилцох, багш, аж ахуйн нэгж байгууллагын ажилтныг чадавхжуулах, иргэний өмнөх мэдлэг ур чадварын үнэлэх, мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулах бааз болох, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэшлийн V, VI түвшний сургалтыг зохион байгуулах зэрэг зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

2.5.11.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцах орчин, сургалтын хэрэглэгдэхүүн болон дотуур байрны хүрэлцээ, хангамжийг сайжруулна.

Биелэлт: Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол сургалтын 20 гаруй байгууллага сургалтын орчныг сайжруулах, ая тухтай орчин бүрдүүлэх хүрээнд суралцагчдын дотуур байрны гадна болон дотоод иж бүрэн болон хэсэгчилсэн засвар тохижилт үйлчилгээг өөрийн орлого, улсын төсөв, иргэд олон нийтийн хандив тусламж, хамтран ажилладаг ажил олгогчдын туслалцаа дэмжлэгтэйгээр 150.0 гаруй сая төгрөгийн өртгөөр хийсэн. Мөн олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилт, дэмжлэгээр 913.5 сая төгрөгийн санхүүжилтээр 10 сургалтын байгууллага дотуур байрны засвар, хөрөнгө оруулалт, цэвэр усны асуудлыг шийдвэрлэж суралцагчдыг ая тухтай амьдрах орчин нөхцөлөөр хангасан. Сургуулийн шинэ барилгын болон дотуур байрын зураг төсвийн зардлыг орон нутгийн төр болон төрийн бус байгууллага, хамтран ажилладаг аж ахуйн нэгж байгууллагын оролцоотой 5 сургуулийн 7 зураг, төсөв хийлгэхэд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

Дорнод Политехник коллежийн багш хөгжлийн төв, контент хөгжүүлэх танхимын засвар үйлчилгээ, Чадамжийн төвүүдэд ХАБЭА-н чадавхжуулах үйлчилгээ үзүүлэх төсөл хэрэгжүүлэх түгээн дэлгэрүүлэх, сургалт, үйлчилгээний зардалд нийт 116.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Дорнод Политехник коллежийн дээврийн их засварыг 2022 онд 297.0 сая төгрөгөөр “Дорнын Оч” ХХК амжилттай гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгсөн. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын салбарын сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өөрийн орлого бүрдүүлэх нөхцөлийг дэмжих хүрээнд тоног төхөөрөмжийн нөхөн олголтын “Гагнуур, Оёдол, Хоол үйлдвэрлэл, Мужаан” гэх 4 багцын худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Мужаан мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа 15, Гагнуурчин мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа 17, Оёдолчин мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа 21, Хоол үйлдвэрлэл мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа 6 сургалтын байгууллагад 778 тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.

“Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд Чадамжийн төвүүдийг дэмжиж Барилгын ПК-д Эрчим хүчний өндөр үр ашигтай Насос /үр ашигтай Насос МАХО-D40/0.5-16/-ыг нийлүүлсэн. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймаг дахь Улаангом политехник коллежийн дотуур байрын барилгыг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ашиглалтад хүлээн авсан. Тус дотуур байр 300 суралцагчийн хүчин чадалтай бөгөөд Монгол улсын 2019 оны төсөвт анх 4.3 тэрбум төгрөгөөр тусгагдаж байсан бөгөөд 2023 онд 6.8 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр “Амарсанаа” ХХК гүйцэтгэж барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.

2.5.11.4. Олон улсын мэргэжлийн тэмцээн, уралдаанд оролцох, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: “Мэргэжлийн болон Техникийн боловсролыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр 2016-2021”-ийн 5 дугаар зорилтыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/182 дугаар тушаалаар “Монгол ур чадвар” тэмцээнийг

зохион байгуулах журмыг баталсан. Энэхүү журам нь “Монгол ур чадвар” тэмцээнийг зохион байгуулах, шилдгийг шалгаруулах, “Дэлхийн ур чадвар” тэмцээнд оролцогчийг сонгох үйл ажиллагааг зохицуулах зорилготой. Журмыг хэрэгжүүлснээр Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдын мэргэжлийн ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн холбоод, ажил олгогчид, сургалтын байгууллагын хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдэж тэмцээнийг зохион байгуулагчид, Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд, оролцогчид болон шүүгч нар дагаж мөрдөхөөр 7 зүйл 45 заалттай. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарын нэр хүндийг олон нийтэд таниулах, суралцагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, олон улсын жишигт нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх зорилго бүхий “Монгол ур чадвар” тэмцээнийг 2 жил тутамд зохион байгуулж байна.

Энэ удаагийн “Монгол ур чадвар-2023” тэмцээн мужаан, барилгын өрөг угсрагч, сантехникч, тогооч, цахилгаанчин, гагнуурчин, CNC токарь, график дизайн зэрэг 8 мэргэжлийн хүрээнд гурван үе шаттайгаар явуулсан. Нэгдүгээр шатанд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 138 суралцагч, 103 багш, хоёрдугаар шатанд 41 суралцагч, гуравдугаар шатанд 16 суралцагч өрсөлдөж 8 суралцагч үндэсний хэмжээний ялагчаар шалгарсан. Эдгээр шалгарсан 8 суралцагчаас 7 суралцагч дэлхийн ур чадварын стандартыг хангасан тул Франц улсын Леон хотод 2024 онд болох “Дэлхийн ур чадвар”-ын 47 дахь тэмцээнд оролцохоор бэлтгэл хангаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/198 дугаар тушаалаар “Монгол ур чадвар” тэмцээн зохион байгуулах журмыг баталсан. Тухайн журамд шинээр батлагдсан Боловсролын багц хуультай уялдуулан өөрчлөлт оруулахаар төсөл боловсруулан холбогдох нэгжүүдээс санал авч байна. Журмын төсөлд дэлхийн ур чадварын тэмцээнд оролцох оролцогчийг сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагаа болон шалгарсан оролцогчийг олон улсын тэмцээнд бэлтгэх, оролцуулах, урамшуулах зэрэг зохицуулалтыг тусгасан.

2.5.12. “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.

2.5.12.1. Хүүхэд бүрд хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгоно.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг 2021 оны 11 сард баталж, Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд мөнгөн хуримтлал үүсгэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлж эхлэв. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ыг баталсан.

2.5.13. Тусгай хэрэгцээ (байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл)-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.5.13.1. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг

төрөөс төлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс бүрэн хариуцахаар эрх зүйн орчин бүрдээд байна. Энэхүү заалтын хэрэгжилт 2024 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхлэх тул Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд хуулийн хэрэгжилтийг хангуулахаар 11.4 мянган хүний шимтгэлд 10.4 тэрбум төгрөгийг тусгуулсан болно.

2.5.14. Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.

2.5.14.1. Эдийн засгийн загварчлалд суурилсан бүтээн байгуулалт, салбар дундын зохицуулалтыг бий болгож, тогтолцоог хөгжүүлнэ.

Биелэлт: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт загварыг хөгжүүлсэн зөвлөх багтай хамтран ажиллан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик тоон мэдээлэл болон загварын тооцооллын нарийвчлалыг сайжруулахаар ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг хөгжүүлэх жишиг ажлын даалгаврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/103 дугаар тушаалаар батлан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.

2.5.14.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдэд олгох жижиг зээлийн хэмжээг нэмэгдүүлж, хугацааг уртасган хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 340 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.

Хүн амын төвлөрлийг бууруулах, орон нутагт ажлын байр бий болгох, хадгалахыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна. Үүний дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өөрийн эх үүсвэрээс 20.0 тэрбум төгрөгийн бага хүүтэй, жижиг зээлийг 2023 оны 2 дугаар сараас эхлэн олгож байна. Уг зээлийг аймаг, орон нутагт жилийн 4.4 хувийн хүүтэй Төрийн банкаар, Улаанбаатар хотод жилийн 8.5-8.8 хувийн хүүтэй Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкнуудаар дамжуулан олгож байна. 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 897 иргэн, 109 аж, ахуйн нэгж байгууллагад 20.9 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгож 1954 ажлын байрыг бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна. Тус зээлийг олгох хүрээнд 2023 оны төсвийн төлөвлөлтийг хийхдээ 1 зээлдэгчид 12.0 орчим сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн ч зээл хүсэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан бодит дэмжлэг үзүүлэх үүднээс 1 иргэнд ойролцоогоор 20.0 орчим сая төгрөгийг олгосон. Энэ нь тухайн зээл авсан иргэд төслөө бодитой үнэлүүлж, илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал

нөлөө үзүүлсэн болно. Мөн бид анх удаа орон нутагт хамгийн бага хувийн хүүтэй зээлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон бөгөөд энэ нь тухайн зээлд хамрагдсан иргэдэд илүү боломжийг бий болгож, тооноос илүү чанарт шилжсэн үр дүнг үзүүлсэн.

2.5.14.3.Зорилтот бүлгийн иргэдийн хувиараа аж ахуй, гарааны бизнес эрхлэхийг дэмжих зорилгоор хүүгүй, барьцаагүй, эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг болон бусад шинэ арга дэмжлэгийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Биелэлт: Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 2022 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр нийт 9,095 иргэн хамрагдаж 18.3 тэрбум төгрөг зарцуулж 3,764 ажлын байр бий болсон байна. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2,032 иргэн хамрагдаж, 2,263 ажлын байр бий болж, 13.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 702 өрхийн 1704 иргэн хамрагдаж, 1,452 ажлын байр бий болж, 3в8 тэрбум төгрөгийг зарцуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр харуулбал 3,163 иргэн хамрагдаж 6.9 тэрбум төгрөгийг зарцуулж 1031 ажлын байр бий болсон байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 48 иргэн хамрагдаж, 108.5 сая төгрөгийг зарцуулж 16 иргэн ажилд зуучлагдсан байна. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 868 иргэн хамрагдаж, 905 ажлын байр бий болж, 4.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2.5.15.Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.

2.5.15.1.Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх эрхзүйн үндсийг бүрдүүлнэ.

Биелэлт: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцоо, судалгаа бусад баримт бичгийн хамт боловсруулсан. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлд Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх зүйл, заалтыг тусгасан.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын намрын чуулганы 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар эцэслэн батлав.

2.5.15.2.Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж ажиллах, тэдний ур чадварыг нутагшуулахыг бодлогоор дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад хөдөлмөр зуучлалын бирж байгуулна.

Биелэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн 2019-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.2-д тусгасан Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, E-job платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг энэ оны байдлаар 10 удаа, системийн дизайн хөгжүүлэлтэд санал өгөх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний процессын зураглалыг шинэчлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг 6 удаа, шаардлагатай бусад уулзалт хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулж, систем хөгжүүлэлтэд бүртгэл мэдээллийг хэрхэн сайжруулах талаар саналыг тусгасан. E-job платформыг нэвтрүүлэх ажил 2022 оны 11 дүгээр сард дуусаад байна. Мөн эх орондоо

эргэн ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Хөдөлмөрийн яармагийг энэ оны сүүлийн хагас жилд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Үндэсний бахархал, өв соёл

2.6.Үндэсний бахархал, өв соёл. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.

2.6.1.Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна.

2.6.1.1.“Чингис хаан” хаад, язгууртны шинэ музей

Биелэлт: Үндэсний их өв соёл, төрт ёс, түүхэн уламжлал, ёс заншил, үндэсний үнэт зүйлсээ эрхэмлэн хамгаалах, сурталчлан таниулах зорилгоор “Чингис хаан” хаадын музейн бүтээн байгуулалтыг улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлж 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр ашиглалтад хүлээн авч, 11 дүгээр 09-ний өдөр нээлтээ хийсэн. Музейн барилга нь хүчин чадлын хувьд 2,500 м.кв талбай бүхий 9 давхар барилга бөгөөд нийт талбайн 60 хувийг музейн үзмэр, үзүүлэг эзлэх бөгөөд үндсэн гурван хэсэг 15 байнгын үзмэрийн танхимтай, шинээр 160 ажлын байр бий болно. Музейн үзүүлэг, дэглэлтийг 15 танхимд нийт 6,033 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл дэглэхээр батлагдсан.Үүнээс 5,927 ширхэг буюу нийт үзмэрийн 98.2 хувийг нь дотоодын эх үүсвэрээс, 106 ширхэг буюу 1.8 хувийг нь гадаадын музей, номын сан, архив зэрэг байгууллагын эх үүсвэрээс бүрдүүлэх бөгөөд одоогийн байдлаар 27 байгууллагаас 5,742 үзмэр шилжүүлэх, 8757 үзмэр авах тооцоог хийж баталгаажуулж, 111 дэсийн 160 ширхэг үзмэрийг бүртгэж хүлээн авсан.Музейн сан хөмрөгийг баяжуулах чиглэлээр Австри, ХБНГУ, ОХУ, Польш, Их Британи, Япон улсад хадгалагдаж байгаа монголын түүхэнд холбогдох 9 ховор үзмэрийн А хуулбарыг хүлээн авч, музейн сан хөмрөгт шилжүүлсэн. Япон улсаас 3 үзмэрийг хуулбарлах ажлын гэрээг байгуулж, ажлыг эхлүүлээд байна.”Чингис хаан” музей нь Монголчуудын төрт ёсны түүхэн уламжлалд холбогдох үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, судалж, сурталчлах соёл, боловсрол, шинжлэх ухааны цогц бүтээн байгуулалт бөгөөд дэлхийн жишигт нийцсэн стандарт орчин бүрдэж, олон улсын арга хэмжээ, хурал, үзэсгэлэн зохион байгуулах боломж нээгдэн цаашид дэлхийн Чингис судлалын төв болох зорилт тавин ажиллаж байна.

2.6.1.2.Байгалийн түүхийн шинэ музей

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд музейн бүтээн байгуулалтад 25.0 тэрбум төгрөг батлагдсан. Төслийн ажил үргэлжилж байна. Байгалийн түүхийн музейн шинэ барилга нь байгалийн түүхэнд холбогдох үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, судалж, сурталчлах соёл, боловсрол, шинжлэх ухааны цогц музей байхаар төлөвлөгдсөн бөгөөд 47,733 м.кв талбай бүхий, шинээр 240 ажлын байр бий болох юм. Засгийн газраас музейн стандартын шаардлагад бүрэн нийцсэн, Азид томоохонд тооцогдох орчин цагийн Байгалийн түүхийн музейн барилгын ажлыг Их тэнгэрийн аманд 6.6 га газарт 39,000 ам. метр талбай бүхий байршилд гүйцэтгэхээр төлөвлөсөн. 2023 онд 6 удаа тендер зарласны эцэст “Содон номин констракшн” ХХК шалгаран 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн БСШУСЯ/202001211 дугаар 130.6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдаж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Буулгалтын ажил, Б блокийн газар шорооны ажил, төмөрбетон аяган суурийн ажил, гадна бохирын шугамын ажлыг 100 хувь, гадна цахилгааны ажлыг 20 хувь

тус тус гүйцэтгэсэн. Барилга угсралтын ажил 40 хувьтай үргэлжилж байна.

2.6.1.3. Үндэсний номын сангийн шинэ барилга

Биелэлт: Сүхбаатар дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэр 0.3 га газарт баригдаж байгаа Үндэсний номын сангийн шинэ барилга нь хүчин чадлын хувьд 9948.2 м.кв талбай бүхий орчин үеийн стандарт шаардлага хангасан төрөлжсөн 16 уншлагын танхим, технологийн дэвшилд суурилсан цахим сан хөмрөг, хурал, үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулах танхим бүхий 450 хүний суудалтай. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 2,081.8 сая төгрөгөөр тусган батлуулсан. 2022 онд ашиглалтад бүрэн оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Барилгын ажлын явц 90 хувьтай үргэлжилж байна.

2.6.1.4. Үндэсний урлагийн их театрын шинэ барилга

Биелэлт: Сүхбаатар дүүргийн 9,11 дүгээр хороо, 5.5 га газрын байршилд Үндэсний урлагийн их театрын барилга барихаар төлөвлөсөн бөгөөд Үндэсний урлагийн их театрын шинэ барилга ашиглалтад орсноор үндэсний болон сонгодог урлагийг хөгжүүлэх, шинэ түвшинд гаргах, олон улсын хэмжээний уралдаан тэмцээнийг эх орондоо зохион байгуулах боломжийг бүрдүүлэх бөгөөд 49.5 мянган м.кв талбай бүхий, 2500 хүний багтаамжтай их танхим, 1500 хүний багтаамжтай дуулалт жүжгийн танхим, 800 суудал бүхий хөгжмийн танхимтай, шинээр 400 ажлын байр бий болно. Нийслэлийн засаг даргын эзэмших эрх олгох тухай 2020 оны А/635 дугаар захирамжаар 5.5 га газарт Үндэсний урлагийн их театрт эзэмшүүлсэн. УСУГ-аас цэвэр бохир ус, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-аас холбооны техникийн нөхцөлүүд авч, ЭХЯ-аас цахилгаан дулааны техникийн нөхцөлүүдийн бэлтгэл ажил хангагдсан. 2022 онд БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яамнаас 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр төслийн ТЭЗҮ-ийг ирүүлэх тухай албан тоот ирүүлсэн. Үүний дагуу Соёлын сайд 89.8 сая төгрөг баталж, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

2.6.1.5. Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лаборатори

Биелэлт: Монголын Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лабораторийн барилгыг Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, Монгол Улсын Аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Төв аймгийн Зуунмод хотын шинэ суурьшлын бүсэд хотын шинэ төв болох “Атарчдын талбай”-н баруун өмнөд хэсэгт 2.4 га газарт байгуулах бөгөөд музейн барилга 8200 м.кв орчим талбайтай, гадна талаар гэрэлт хөшөө, хүн чулуун хөшөө, буган хөшөө зэрэг археологийн дурсгалууд, угсаатны зарим эд зүйлсийг бодитоор болон хуулбар байдлаар дүрсэлсэн үзүүллэг бүхий цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын орчинтой цогцолбор байхаар төлөвлөсөн. Музей нь археологи ба угсаатны үзүүллэгийн 2 хэсгээс бүрдэх бөгөөд үзүүллэгийн талбайн археологийн 6 танхим, угсаатны 5 танхимд байнгын үзүүллэг дэглэх ба түр үзэсгэлэн зохион байгуулах том, жижиг 2 танхимтай байна. Төслийн барилгын ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр эхлүүлж, шав тавих ёслол болсон. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тус төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 22.4 тэрбум төгрөг, санхүүжих дүн 5.7 тэрбум төгрөгийг баталсан. Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолоор барилгын материалын үнийн өсөлт МЭД-р 4.5 тэрбум төгрөгөөр баталгаажсан. Тус төсөл арга хэмжээний СОЯ/20210311+1 дугаар 4.5 тэрбум төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж нийт 22.2 тэрбум төгрөгөөр байгуулагдсан. Барилга угсралтын ажил 70 хувьтай үргэлжилж байна.

2.6.1.6. “Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”

Биелэлт: Хөвсгөл нуурын байгаль экологи, соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, судалж, сурталчлах цогц музей байгуулах зорилтын хүрээнд Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”-ийг байгуулахаар төлөвлөсөн. 2021 онд төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг бэлэн болгосон. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 10 дугаар тушаалын жагсаалтад “Хөвсгөл нуурыг түшиглэсэн Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”-ийн зураг төслийг хэрэгжүүлэх 120.0 сая төгрөг батлагдсан. Соёлын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд дээрх төсөл арга хэмжээний зураг төсөв боловсруулах 250.0 сая төгрөгийн санхүүжилт 2023 онд шийдэгдээгүй.

2.6.1.7. Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/23 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театрын цогцолборын зориулалттай 15 жилийн хугацаатай 11000 м.кв газрын асуудлыг шийдвэрлэсэн. Цогцолбор нь 600 хүний суудалтай их, 150 хүний суудалтай бага, орчин үеийн техник, технологи бүхий 5D танхим, хүүхдийн энтертайнмент төв, хүүхэлдэйн музейн танхим, хүүхдийн амралт чөлөөт цагийн танхим бүхий дөрвөн давхар цогцолбор байхаар төлөвлөгдсөн. Цогцолборын загвар зураг төслийг “Гангоо архитектурис” ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. Хүүхэд, залуучуудын оюуны хөгжлийг дэмжих, гоо зүйн боловсрол олгох, хүүхэд, залуучууд дэлхийн театр, урлагийн хөгжлөөс суралцах, үндэсний урлагаа уламжлан хөгжүүлэх, уран сайхны бусад урсгал чиглэлийг танин, мэдэх нөхцөл бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн “Хүүхэд, залуучуудын театр байгуулах тухай” 158 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордны барилгыг Хүүхэд, залуучуудын театрын зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зохион байгуулж, Соёлын яам болон “Скайлайн дизайн” ХХК-ийн хооронд СОЯ/202212033 дугаар 1.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдсан, зураг төсөв хийгдсэн, 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XIV.4.3-т “Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театрын цогцолбор барилгын зураг төсөв (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг)” тусгагдсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт Соёлын яаманд тендер зарлагдаж, “Скайлайн дизайн” ХХК гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. “Хүүхдийн номын сан хүүхэлдэйн театр барих зураг төсвийг 2022-2023 оны Улсын төсөвт 1.1 тэрбум төгрөгөөр баталж, Соёлын яам “Скай лайн” ХХК-тай гэрээ байгуулж, БХТ-өөр тус төслийн зураг төсөв баталгаажуулсан. Хүүхдийн номын сангийн барилгын МЕД нь 19.9 тэрбум төгрөгөөр, Хүүхэлдэйн театрын барилга 29.2 тэрбум төгрөгөөр, Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театрын гадна шугам сүлжээ 5.0 тэрбум төгрөгөөр нийт 54.1 тэрбум төгрөгөөр баталгаажсан.

2.6.1.8. Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төв, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.6.1.8.1. Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төв, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Төв, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Дархан-Уул, Өмнөговь, Дундговь аймгуудад улсын төсвийн санхүүжилтээр соёлын барилга, байгууламж барихаар төлөвлөсөн. Үүнд: Дархан-Уул аймгийн Музей, номын сангийн цогцолборын интерьерийн зураг төслийг 2023 онд 174.18 сая төгрөгөөр хийлгэж, эскиз зураг батлагдаж байна. Дархан-Уул аймгийн музей номын сангийн барилга угсралтын ажил 70 хувьтай, Өмнөговь аймгийн номын сангийн барилга 80 хувьтай хэрэгжиж байна. Дундговь, Эрдэнэдалай суманд 400 суудалтай соёлын төвийн барилга, соёлын заал, 45 суудалтай номын сангийн барилгыг 2021 онд байнгын ашиглалтад оруулсан.

Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 57 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан. 2020 онд 22, 2021 онд 10, 2022 онд 11, 2023 онд 13 соёлын төвийг ашиглалтад орсон. Нийслэлд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Багануур, Багахангай, Налайх, Сонгинохайрхан зэрэг 4 дүүрэгт соёлын ордон барих ажил хэрэгжиж байна. Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 158 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа “Дүүргийн соёлын ордны барилга”-ыг “Хүүхэд залуучуудын театр”-т шилжүүлэхийг үүрэг болгосон. Хүүхэд, залуучуудын театрын барилгын ажил 95 хувьтай, дотоод интерьер засал хийгдэж байна.

2.6.1.9. “Төв Азийн түүх, соёлын голомт” судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын цогцолборыг Орхон-Тамир, Хануй-Хүнүйгийн дурсгалуудыг түшиглэн байгуулна.

Биелэлт: Төв азийн түүх, соёлын биет болон биет бус өвийг судлах, хамгаалах, сурталчлах чиглэлээр “Төв Азийн түүх, соёлын голомт” судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын цогцолборыг Орхон-Тамир, Хануй-Хүнүйгийн дурсгалуудыг түшиглэн байгуулахаар төлөвлөсөн. Уг цогцолборын төсөл амжилттай хэрэгжсэнээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг түшиглэсэн ил музейтэй болох, аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинээр 150 ажлын байр бий болно. “Орхон-Тамир, Хануй-Хүнүй голын сав газар хадгалагдан үлдсэн түүхийн олон үеийн дурсгалт газруудыг түшиглэн “Төв Азийн түүх, соёлын голомт” судалгаа, сурталчилгаа, мэдээллийн цогцолбор байгуулах зорилтыг дэвшүүлсний дагуу Орхон-Тамир, Хануй-Хүнүй голын сав газар орших түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн өндөр ач холбогдолтой 10 гаруй томоохон археологийн дурсгалыг сонгож, соёл мэдээллийн төвийн сүлжээ байгуулахаар төлөвлөн, бүтээн байгуулалтын ажлыг Архангай аймгийн Өлзийт сумын нутагт орших “Харганын дөрвөлжин” хэмээх газраас илрүүлсэн хүннүгийн шаньюйн орд өргөө, нийслэл Луут хотын туурийг түшиглэн эхлүүлсэн.

2022 онд Хотын туурийг тойруулан 300x250 метрийн хамгаалалтын хашаа барьснаас гадна дурсгалт газрыг зорин ирэх ард иргэд, зочид гийчдэд дурсгалын талаарх үнэн зөв, цэгцтэй мэдээллийг өгөх, археологийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг сурталчлан таниулах зэргээр тав тухтай орчинд олон талын үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн “Соёл, мэдээллийн төв”-ийн барилгыг барьж байгуулаад байна. Тус барилгын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ББАОКД-2022/08 дугаар Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарч барилгыг бүрэн хүлээн авсан. “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар “Төв Азийн түүх соёлын өлгий Орхон, Тамир, Хануй, Хүнүйн соёлын өвийг судлах, сурталчлах мэдээллийн төв төсөл, арга хэмжээнд 400.0 сая төгрөг батлагдсан. Соёлын яам нь “Их шовх” ХХК-тай 398.2 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж, тус барилгын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн ББАОКД-2022/08 дугаар Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарч барилгыг бүрэн хүлээн авсан.

2.6.1.10. Байгалийн түүхийн музейг (хуучнаар Лениний музей)-г шинэчлэн засварлана.

Биелэлт: “Соёлын сайдын 2022 оны А/288 тушаалаар Байгалийн түүхийн музейг шинэчлэн засварлах ажилд 280.0 сая төгрөг батлагдаж, 1-3 давхрын засаж, шинээр үзүүлэлэг дэглэлтийн 4 танхим байгуулж, засварын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж дууссан. Эдийн засгийн хөгжлийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” А/16 дугаар тушаалаар Байгалийн түүхийн музейг шинэчлэн засварлах ажлын зураг төслийн төсөв 250.0 сая төгрөг батлагдсан ба тус ажлын гүйцэтгэл 70 хувийн хэрэгжилттэй байна.

2.6.1.11.Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр 2021 онд “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журам”, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ”, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар, үйл ажиллагааны журам” боловсруулсан. Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийг хэрэгжүүлж Улсын хэмжээнд хүчитгэх шаардлагатай барилга байгууламжийн судалгааг гаргасан. Улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан нийт 354 барилга, архитектурын дурсгал байгаагаас нийслэлийн хэмжээнд түүх соёлын дурсгалт Богд хааны ордон музей, Чойжин дагинын ордон музей, Улсын драмын эрдмийн театр, Дуурь бүжгийн эрдмийн театр нийт 4 барилга байгууламжийг паспортжуулсан. Улсын төсвийн хөрөнгөөр “Үндэсний дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг хүчитгэн засварлах ажлын зураг төсөл (Улаанбаатар)”, “Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейн сэргээн засвар, их засварын зураг төсөв (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг)”, “Улсын төв номын сангийн барилгын хүчитгэл, их засварын зураг төсөв (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг)”, “Богд хааны ордон, музейн сэргээн засвар”, “Чойжин ламын сүм музейн сэргээн засвар (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг)” төслүүд хэрэгжиж дуусаад байна. Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 2-р үе шатны ажлыг эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 10 барилга байгууламжийг сонгон 5 барилгын хүчитгэлийн зураг төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, уг барилгын норм, дүрмийг шинэчлэн боловсруулах техникийн даалгаврыг боловсруулаад байна.

2.6.2.Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.6.2.1.“Цахим соёл” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Соёлын салбарын мэдээллийн технологийн дунд хугацааны бодлогын баримт бичиг “Цахим соёл” арга хэмжээний төслийг боловсруулан Соёлын сайдын 2022 оны А/91 тоот тушаалаар батлуулсан. Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээллийн санд RICH 3.0 программ хангамжид нийт Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамрагдсан. Уг Rich программд бүртгэсэн өвийн бүртгэлийг шууд шинэ системд хөрвүүлэх боломжтойгоор программчлахаар ажлын даалгаварт тусгасан тул одоо ашиглагдаж байгаа программд өвийн бүртгэлийг бүртгэх ажил амжилттай хийгдэж байна. Одоогийн байдлаар төрийн

болон орон нутгийн өмчийн өвийн цахим бүртгэл 100 хувьтай байна. Түүнчлэн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг дэмжсэн олон нийтийн сүлжээ болох Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн Creativehub.mn системийн хөгжүүлэлтийг дуусгаж, нээлтийн арга хэмжээг 2023 оны 11-р сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Одоогоор 149 байгууллага, 436 уран бүтээлчийн 573 уран бүтээлийг оруулаад байна. Мөн номын сангийн бүртгэл мэдээллийн систем болон Соёлын өвийн бүртгэл мэдээллийн систем хөгжүүлэлтийг тус тус дуусгаад байна. Соёлын биет бус өвийн дэд системд үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээллийг хөрвүүлэн оруулж, өв тус бүрийн бүртгэлийн талбараас “GLAM” системээр дамжуулан олон нийтэд хүргэх мэдээллийн талбаруудыг нарийвчлан гаргасан.

2.6.2.2. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээ.

Биелэлт: “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилт 16 арга хэмжээтэйгээр 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Соёлын сайдын 1/152, Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/195, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/57, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/40 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу шинэчлэн батлуулсан стандарт 1, сургалтын агуулга хөтөлбөр 2, албан даалгавар 1, үндэсний сургагч багш бэлтгэх сургалт 4 сургагч багш 354 бэлтгэгдсэн, олон улсын форум 1, олон улсын фестиваль 1, нийгмийн соён гэгээрлийг дээшлүүлэх “Соёлын сэргэлт-2023” нэгдсэн цогц арга хэмжээ 1, “Хамтаар амьдрах соёл” аян, нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх сошиал нөлөөллийн аян-10, “Цахим орчинд хүний эрхийг хамгаалъя-Залилагчид боломж бүү олго”, Соёлын давлагаа аян, музейн боловсролын 56, бусад 70 гаруй соёлын боловсролын албан бус хөтөлбөр, сургалт дугуйлан 2,300 гаруй хичээллэсэн, цахим сургалт 10, бага насны хүүхдийн интерактив контент 30, нүүдлийн соёлын боловсрол олгох зуны зуслан 6 ажиллаж 200 гаруй хүүхэд хамрагдсан. Хөгжмийн боловсролын 307 багш мэргэжил дээшлүүлж, ЕБС-ийн суралцагчдын 54% буюу 418,240 суралцагч урлаг, спортын чиглэлээр сургалтад, After school аппликейшнаар 24,546 суралцагч хамрагдсан. “Хамтаар амьдрах соёл” аяны хүрээнд “Нийгмийн соёл, төлөвшлийн төлөө” фэйсбүүк цахим хуудасны үүсгэн хөгжүүлж, цахим хуудас лайк 18 мянга, дагагч 20 мянга, хандалт 1.3 саяд хүрч нэмэгдсэн. Нийт 234 пост, нийтлэл, ярилцлага 34, сошиал пост 250, постер 500, видео материал ТВ 6, боловсрол 9, богино 30, хүүхдэд зориулсан 4 зохиол, 3 төрлийн стикер, 256 ширхэг дизайнерын бүтээл, сошиал уралдаан, олимпиад 2, автобус, ТВ, FM радио, өдөр тутмын сонин, сайтуудаар түгээсэн. Түгээлт давхардсан тоогоор нийт 2.8 сая хүнд, “Цахим орчинд хүний эрхийг хамгаалъя-Залилагчид боломж бүү олго” аяны хүрээнд 20.1 сая хүнд хүрч, 86.4 хувь дэмжиж, цахим орчинд 25.5 сая хандалт авсан.

2.6.2.3. “Сонгодог урлаг-III” дунд хугацааны бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Сонгодог урлаг III” арга хэмжээний төлөвлөгөөг Соёлын сайдын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/77 дугаар тушаалаар 2021-2023 онд хэрэгжүүлэхээр шинэчлэн баталсан. Уг арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор нийт 23 төсөл арга хэмжээнд 100.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, үндэсний болон олон улсын 9 уралдаан наадам, 4 сургалт, 7 олон улсын хамтарсан болон аялан тоглолт арга хэмжээ, хүүхдэд зориулсан 3, уран бүтээлчдийн 5 тоглолт арга хэмжээ, 2 зорилтот бүлэгт зориулсан төсөл арга хэмжээг дэмжин нийт 870 гаруй уран бүтээлчийг хамруулан бодлого зохицуулалтаар ханган ажилласан.

2.6.2.4. “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээ; /”Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” дунд

хугацааны бодлогын баримт бичиг батлуулж, хэрэгжүүлнэ./

Биелэлт: Соёлын тухай хуулийн 34.1 дэх хэсэг, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээ болох дунд хугацааны бодлогын баримт бичиг батлуулж, хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 316 дугаар тогтоолоор “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээ”-г батлуулсан. Соёлын бүтээлч үйлдвэрлэл арга хэмжээг 1 дүгээр үе шатыг бүрэн хэрэгжүүлж.”Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум-2022” болж форумд соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах 12 салбар, 90 гаруй чиглэлийн 400 гаруй төлөөлөл оролцож, хэлэлцүүлгээс гарсан саналыг үндэслэн форумын нэгдсэн зөвлөмж гаргасан. Соёлын яамнаас 2023 онд Соёлын бүтээлч үйлдвэрлэл II арга хэмжээний гүйцэтгэлийн хоёрдугаар үе шатанд Хуулийн 6 бүлэг, 30 зүйлтэй хуулийн төсөл боловсруулсан бөгөөд холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаас саналыг авч нэгтгэн 2023 оны 4 дүгээр сарын 05-нд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хуулийг УИХ-д өргөн барьсан.

2.6.2.5. “Монгол өв ба дэлхий дахин” олон улсын арга хэмжээ. “Монгол өв ба дэлхий дахин” дунд хугацааны бодлогын баримт бичиг батлуулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Монголын соёлын төв”-ийг үе шаттай байгуулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг тандан судлах, эдийн засгийн тооцооллыг боловсруулах зардлыг Соёлын сайдын 2021 оны А/266 дугаартай тушаалаар баталж, ажлын даалгаврыг боловсруулж Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав. Тус тандан судалгааны тайланг боловсруулах гэрээг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнтэй байгуулсан. “Монгол өв ба дэлхий дахин” дунд хугацааны бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын урьдчилсан судалгааг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн гүйцэтгүүлж, тайланг хүлээн авч, төслийг боловсруулсан.

2.6.2.6. Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээг зохион байгуулна.

Биелэлт: Саудын Арабын Хаант Улсад 2023 оны 09 дүгээр сарын 10-25-ны өдрүүдэд хуралдсан Дэлхийн өвийн хорооны 45 дугаар ээлжит чуулганаар “Буган чулуун хөшөө, хүрлийн үеийн холбогдох дурсгалууд” өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн. Чуулганы үеэр Соёлын сайд ЮНЕСКО-ийн Соёлын асуудал эрхэлсэн дэд захирал Эрнесто Оттонитой уулзаж Дэлхийн баримтат өвийн үнэт дурсгалыг хадгалан хамгаалах зорилготой ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Ази, Номхон далайн /MOWCAP/ 10-р чуулганыг Монгол Улсад зохион байгуулахаар болсон. Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр “Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн их наадмыг олон улсын хэмжээнд өргөжүүлэн “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль болгон 2023 оны 8 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Налайх дүүргийн “Тайж хайрхан”-ы бэлд зохион байгууллаа. Тус фестивальд аймаг, нийслэлийн 1000 гаруй өвлөн уламжлагч, нүүдлийн соёл иргэншил бүхий гадаад улс орны төлөөлөл Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргизстан Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Саха Улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Тува Улс, Бүгд Найрамдах Турк Улс, ЮНЕСКО болон олон улсын байгууллагын өвлөн уламжлагч, зочид төлөөлөгчид хуран чуулсан. Уг фестивалийг БНСУ-ын “KBS” телевиз, АНУ-ын “CNN”, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын “Мир” телевиз болон БНХАУ-ын Синьхуа агентлаг зэрэг гадаадын 15 хэвлэл мэдээллийн байгууллага фестивалийг

сурвалжлан дэлхий нийтэд хүргэв. Мөн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан 1000 гаруй контент бүтээгчдийг нэгтгэсэн “Nas Summit-2023” чуулга уулзалт арга хэмжээний оролцогч, контент бүтээгчид Нүүдэлчин фестивалиар зочилж, контент бүтээж цахим орчинд түгээн сурталчилсан. МҮОНРТ 3 өдрийн туршид 13 цагийн шууд нэвтрүүлэг, аймаг нийслэлийн 22 отог тус бүрээр нэвтрүүлэг, сурвалжлаг, Үндэсний хүрээ, Соёлын өвийн өртөө болон өвлөн уламжлагчдыг оролцуулсан мэдээ мэдээлэл, сурвалжилгыг бэлтгэн түгээсэн.

2.6.2.7. Соёлын өвийг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн болон соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлнэ.

Биелэлт: Дэлхийн өвийн хорооны 44 дүгээр чуулган 2021 оны 07 дугаар сарын 16-31-ний өдрийн хооронд БНХАУ-ын Фужоу хотоос цахимаар хуралдаж Монгол Улсаас нэр дэвшүүлсэн өвийн номинацийг уг чуулганаар хэлэлцэж, нэмэлт бичвэр бичих, зөвлөмж бүхий 44 СОМ 8В.14 тоот шийдвэрийг батлав. 44 СОМ 8В.14 тоот шийдвэрийг англи хэлнээс монгол хэл рүү орчуулж, шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Гадаад харилцааны дэд сайд бөгөөд Дэлхийн өвийн үндэсний хорооны даргаар батлуулав. Цаашлаад Дэлхийн өвийн хорооны 45 дугаар ээлжит чуулган Саудын Арабын Хаант Улсад хуралдаж, Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүрэл зэвсгийн үеийн нүүдэлчдийн бүтээсэн гайхамшигт дурсгал болох Буган чулуун хөшөөг “Буган чулуун хөшөө, хүрлийн үеийн дурсгалууд” нэрээр Дэлхийн өвд бүртгүүлээ. “Халхын Цогт хун тайжийн хадны бичээс”-ийг Дэлхийн дурсамж хөтөлбөрийн “Олон Улсын баримтат өв”-ийн жагсаалтад бүртгэгдлээ. Соёлын сайдын 2022 оны А/206 дугаар тушаалын дагуу “Монгол нүүдлийн зан үйл” өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлэх номинацийн материал болон баримтат киног бэлтгэж, Соёлын биет бус өвийн Мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулан, санал, дүгнэлтийг авч, Соёлын сайдын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1/682 дугаар албан бичгээр ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах конвенцын Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн.

2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

2.6.3.1. Монгол хэл, бичиг, соёлыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх “Монголын соёлын төв”-ийг их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудыг түшиглэн байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Соёлын яам, Бүгд Найрамдах Турк Улсын Соёл, аялал жуулчлалын яамд хоорондын “Соёлын салбарт хамтран ажиллах тухай” Харилцан ойлголцлын санамж бичигт “Оролцогч тус бүр өөрийн орны соёлын төвийг нөгөө улсад байгуулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллана, Соёлын төвийг байгуулах асуудлыг Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын тусгайлсан хэлэлцээр байгуулах замаар шийдвэрлэнэ” гэж тусган оруулсан бөгөөд цаашид судалгаан дээр үндэслэн “Монголын соёлын төв”-ийг байгуулах чиглэлээр ажиллаж байна. Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэд Монголын соёл, мэдээллийн төвийг байгуулан үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр нээсэн. Соёлын яамнаас арга зүйн мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан.

Гадаадын 11 улсын 25 хотод нийт 44 монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төв ажиллаж байна. Дэлхийд тархсан монгол өвийг хамгаалах зорилтын хүрээнд “Монголын нууц товчоо”-г болгар, румын, грек, вьетнам хэлээр гаргав. Карлын Их сургуулиас 2000

оноос хойш эрхлэн гаргаж буй монгол судлалын “Mongolica Pragensia” эрдэм шинжилгээний сэтгүүл, Монгол, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойн хүрээнд Конгрессын номын сангийн гар бичмэлийн тасагт хадгалагдаж буй Дилова хутагтын захидлыг англи, кирилл, монгол бичгээр, ЮНЕСКО-ийн “World Heritage Review” сэтгүүлийн “Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг баталсны 50 жилийн ой”-д зориулсан дугаарт, Берлиний Mein viertel сэтгүүлийн 2022 оны тусгай дугаарт монголын тухай нийтлэл гаргав. “Google Arts and Culture Platform”-д монголын ЮНЕСКО-д бүртгэгдсэн өвийн 5 газрыг сурталчлав. Бээжинд “Монголын соёл, мэдээллийн төв”-ийн барилгын ажлыг 2022 оны 4 дүгээр сард эхлүүлж, 10 дугаар сард дуусган хүлээн авч, нээлтийн арга хэмжээний үеэр Монголын соёлын өдрүүдийг зохион байгуулав.

2.6.3.2. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ.

Биелэлт: ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр соёл, урлагийн мэргэжлээр 34 оюутан элсэн суралцаж байна. Тайваны Боловсролын яамнаас 2023 онд зохион байгуулсан Хятад хэлний тэтгэлэгт хөтөлбөрт Соёлын яамны харьяа Чингис хааны өв, соёл судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан нэр дэвшиж шалгарсан. Соёлын салбарын албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, чадавхжуулах 6 сургалтыг зохион байгуулан 370 гаруй албан хаагчдыг хамруулсан. Баримтат өвийг “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Олон Улсын болон бүс нутгийн жагсаалтад нэр дэвшүүлэх үйл явц, түүний ач холбогдол” хүний нөөцийн чадавх бэхжүүлэх” сургалтыг баримтат өвийн сан хөмрөгтэй төрийн 9, төрийн бус 3 байгууллагын 37 ажилтан, албан хаагчдад зохион байгуулсан. Соёлын өвийн үндэсний төв соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр Япон улсын Осака, Нара, Киото хотын урлаг дизайны их сургуулийн судлаач багш мэргэжилтнүүдтэй хамтран 2023 оны 8 дугаар сарын 14-24-ний өдрүүдэд онол, дадлагын сургалт зохион байгууллаа. БНСУ-ын Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн “Соёлын түншлэл” хөтөлбөр, “Соёлын салбарын албан хаагч болон соёлын мэргэжилтнийг дадлагажуулах сургалт” хөтөлбөрт 09 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд БНСУ-д яамны 3 албан хаагч мэргэжил дээшлүүллээ. Соёлын яам болон соёл, урлагийн байгууллага, бусад холбогдох байгууллагуудын 10 гаруй сургалт зохион байгуулагдаж, 250 гаруй албан хаагчдыг мэргэжлийг дээшлүүлж, сургалтад хамрууллаа.

2.6.3.3.1. Үндэсний кино урлагийг дэмжинэ.

Биелэлт: Кино урлагийг дэмжих тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдсан. Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкийг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журмыг Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 132 дугаар тогтоолоор батлагдсан. Кино урлагийн үндэсний зөвлөлөөс кино урлаг дэмжих сангийн төслийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 09 дүгээр сарын 21-ээс 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл 2 үе шаттай олон нийтэд нээлттэй зарласан. Соёлын сайдын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/78 тушаалаар дараах 11 төсөл, арга хэмжээг Эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүжүүлэхээр шийдвэрлэгдсэн. Кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын дэргэд “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг 2022 он 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд шинэ байгууламжийн зураг төслийг хийж гүйцэтгэхээр “Урбанвижн” ХХК шалгарч гүйцэтгэж байна. Нийт хийж гүйцэтгэх ажлын хүрээнд “Олон талт арга хэмжээний танхим”-ын барилга баригдах ба одоо байгаа Монгол кино үйлдвэрлэлийн төв байрын засвар шинэтгэл, тус

үйлдвэрийн газрын агуулах, мужаан цехийн барилгын засвар шинэтгэл болон гадна зам, талбайн тохижилтыг хийх зураг, төсвийг боловсруулах чиглэлээр гэрээнд тусгагдан 295.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлж байна. Үр дүнд Монгол уран бүтээл “ТРИО” уран сайхны кино 2022 оны 10 сард болсон 38 дахь удаагийн Варшавын олон улсын кино наадамд урилгаар оролцлоо. Мөн Варшав, Таллин, Тайланд, АУН-ын болон Улаанбаатар зэрэг олон улсын 7 кино наадмаас шагнал хүртсэн. Швейцарын Женев хот дахь НҮБ-ын байранд 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Трио киног гаргасан. Мөн Каннын кино наадмын 2023 оны “Un Certain Regard” төрөлд “Баавгай болохсон” кино 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр албан ёсоор нэр дэвшсэн.

2.6.3.3.2. Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

Биелэлт: Соёлын яамнаас соёлын бүтээлч үйлдвэрлэлийг салбаруудтай илүү харилцан уялдуулах шаардлагын үүднээс Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 чиглэлийг тодорхойлсон. Соёлын сайдын 2021 оны А/119 дугаар “Соёл, урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай” тушаалын дагуу сонгон шалгаруулалтад санхүүжилт хүссэн 737 төсөл, арга хэмжээ оролцсоноос 42 төсөл шалгарч, 1.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Соёлын сайдын 2022 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/264 дугаар тушаалаар “Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, санхүүжилт батлах тухай” тушаалаар нийт 34 төсөлд 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. Соёл урлагийн дэмжих сангаас Соёлын сайдын 2021 оны А/119 дүгээр тушаалаар нийт 42 төсөлд 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Уг санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд соёлын өвийг сэргээх, хадгалах, хамгаалах, урлагийн төрөл бүрийн бүтээл туурвих, орчин үеийн хөгжилд нийцүүлэн соёл, урлагийг хөгжүүлэх цахим программ, контент, нэвтрүүлгийг бүтээсэн, эрдэм шинжилгээний хурал, уралдаан тэмцээн, сургалтыг олон удаа зохион байгуулсан. 2023 онд Монгол Улсын олон улс дахь мэдээлэл, сурталчилгааны Үндэсний хороо байгуулагдаж Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх төлөвлөгөө /5 чиглэлийн 50 арга хэмжээг хэрэгжүүлж Монгол улсад зочлох жил болгон зарлаж, бодлого төлөвлөлттэй стратеги төлөвлөгөөний дагуу чиг үүргийн яамд харилцан уялдаатай ажилласан ба үүний үр дүнд олон улс дахь Монгол улсын нэр хүнд өсөж 2024 онд аялахад таатай улсуудын жагсаалтад орсон.

2.6.3.4. Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг буй болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

Биелэлт: “Соёл, урлагийн менежментийн чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт бүсчилсэн уулзалтыг зохион байгуулж 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн орон нутагт ажиллаж, 4 бүсчлэлээр 21 аймгийн 412 байгууллагын 800 гаруй соёлын ажилтнуудтай уулзалт хийлээ. Уулзалтын үр дүнд Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 зорилт, Засгийн газрын 2021 оны 168, 2020 оны 217 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, шинээр батлагдсан 3 хуулийг сурталчлан таниулав. Соёлын сайдын 2021 оны А/122 дугаар тушаалаар Үндэсний их найрал хөгжмийн шинэчилсэн хөг (бүтэц)-ийн судалгааг Соёл, урлагийн их сургууль болон Шинжлэх ухааны технологийн их

сургуулийн эрдэмтэн, судлаачдын багаар гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан. Засгийн газрын 2023 оны “Хөрөнгө гаргах тухай” 116 дугаар тогтоолын дагуу Улсын Филармонийн симфони найрал хөгжмийн чавхдаст, нумт, утсан хөгжмийн зэмсэг, дижитал концертын танхимын техник хэрэгсэл, дууны төхөөрөмж зэрэг 1326 тоо ширхэг бүхий хөгжмийн зэмсэг, хөгжмийн зэмсгийн дагалдах хэрэгсэл, концертын танхимын тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийг бүрэн шинэчиллээ. Гавьяат жүжигчин, дуурийн дуучин Ч.Бадрал Бүгд Найрамдах Итали Улсын Буссето хотод 2022 оны 6 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд зохиогдсон “Бердианы дуу хоолой” Олон улсын дуурийн дуулаачдын уралдаанд амжилттай оролцсон. Олон улсад өрсөлдөх “Хотулун гүнж” түүхэн уран сайхны киног Берлиний ОУ-ын кино наадам болон “НордАрт 2022”, “Венецийн биенналь 2022”, “Каннын кино наадам”-д 70 уран бүтээлчийн 100 гаруй уран бүтээлд дэмжлэг үзүүлсэн. Монгол Улсын Ардын жүжигчин А.Энхтайвангийн нэрэмжит мэргэжлийн дуучдын олон улсын анхдугаар уралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан.

2.6.3.5. Соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмыг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэнэ.

Биелэлт: Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд соёлын төв, музей, театр, номын сан зэрэг соёл урлагийг нийгмийг соён гэгээрүүлэх, залуус, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд аймаг, нийслэлд нийтдээ 77 төсөлд 349.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан. Үүнээс 2023 оны байдлаар ашиглалтад орсон 47 төсөл арга хэмжээ байна. Түүнчлэн, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад соёлын салбарт хэрэгжүүлэхээр барилга байгууламжийн 63 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Соёл, урлагийн газартай байхаар бүтцийг, “Улаанбаатар чуулгын үйл ажиллагааг өргөжүүлж, театрын статустай болгох асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж “Улаанбаатар театр” нэртэй болж, 11 дүгээр сарын 08-ны өдрийн 148 дугаар тогтоолоор “Улаанбаатар театр” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан.

Соёлын сайдын 2021 оны А/86 дугаар тушаалаар байгуулагдсан “Соёлын төв, Соёлын ордны стандартын төслийг боловсруулах ажлын хэсэг” стандартын төслийг боловсруулан, сум, дүүргийн Соёлын төв, Соёлын ордонд мөрдөгдөх стандартын төслийг батлуулахаар Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн.

2.6.3.6.1. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийг судлах, сурвалжлан олох журам”-ын төслийг шинэчлэн боловсруулсан. “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д багтсан 102 өвлөн уламжлагч (2022 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 76 өвлөн уламжлагч амьд сэрүүн байна)-ийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах арга хэмжээг ЭМЯ-аас хэрэгжүүлж байгаа “урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо” арга хэмжээнд улсын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар хамруулж байна. Тайлант хугацаанд өссөн дүнгээр 72 нь буюу 94.7 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан. Засгийн газрын 2018 оны 354 дугаар тогтоолын дагуу Соёлын сайдын 2021 оны А/05 дугаар тушаалаар байгуулагдсан “Соёлын биет бус өвийн

мэргэжлийн зөвлөл” 2021 оны 02 дугаар сард хуралдаж, 2020 оны шилдэг өвлөн уламжлагчаар Увс аймгийн Малчин сумын ихэлч, бийч Ж.Хумбааг шалгаруулсан. Шалгарсан өвлөн уламжлагчид 30.5 сая төгрөгийн мөнгөн шагналыг олгосон. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг дэмжих хүрээнд Өвөрхангай аймгийн Уянга сумын “Уянга” хийцийн гэр урлаач С.Батмөнхтэй гэрээ байгуулж, 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Засгийн газрын 2018 оны 354 дугаар тогтоолын дагуу 2022 оны шилдэг өвлөн уламжлагчаар Ховд аймгийн Чандмань сумын иргэн Дашдоржийн Цэрэндаваа шалгарч Соёлын сайдын 2023 оны А/23 дугаар тушаалаар 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.”Морьт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн”, “Монгол тууль” өвийг АНУ болон Унгар Улсад сурталчлах, Говь-Алтай аймагт “Монгол Жангар” өвийг сурталчлах, өвлөн уламжлагчдыг алдаршуулах, Дундговь аймагт зохион байгуулагдсан “Уяхан замба тивийн наран” уртын дууны наадам, Төв, Булган аймагт зохион байгуулагдсан “Айрагны баяр”, Монгол шагайн харваа өвийг сурталчлах, шагайн харвааны өвлөн уламжлагчдад нийт 450.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

2.6.3.6.2. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулна.

Биелэлт: Засгийн газрын 2020 оны 13, 2021 оны 179 дугаар тогтоолоор улсын хэмжээнд улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталсан. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, 45.2, 58.5 дугаар зүйлд заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг Соёлын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний 4.1-д тусган иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж байна. 21 аймаг, нийслэлийн газар нутагт орших улсын хамгаалалтын зэрэглэлд орсон нийт 197 дурсгалыг 100 хувь иргэн, хуулийн этгээдээр хамгаалуулж байна.

2.6.3.6.3. Соёлын өвийг хамгаалах олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.

Биелэлт: Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийн тухай ЮНИДРУА-ийн конвенцод нэгдэн орох хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг 2022 онд зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлсэн. Конвенцын орчуулгыг 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр ГХЯ-аар баталгаажуулсан. Хуулийн төслийн баримт бичгийн бүрдлийг хангуулан 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. 2021 оны 11 дүгээр сарын 9-25-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод зохион байгуулагдсан ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын ээлжит 41 дүгээр чуулган, Нүүдлийн Соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн Ерөнхий чуулган, Дэлхийн өвийн конвенцын Оролцогч талуудын Ерөнхий ассамблейн 23 дугаар чуулганд оролцох ажлыг Соёлын өвийн газартай хамтран зохион байгуулж тус чуулганд оролцсон. Соёлын сайд Бодлогын ерөнхий хэлэлцүүлэгт оролцож, хэлсэн үгэндээ Хулгайлсан болон хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийн тухай 1995 оны ЮНИДРУА-гийн конвенцыг соёрхон батлуулахаар танилцуулсан.

2.6.3.6.4. Чойжин ламын сүмийн цогцолбор зэрэг түүхэн дурсгалт, барилга архитектурын дурсгалыг сэргээн засварлаж, хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөлийг сайжруулна.

Биелэлт: Чойжин ламын сүмийн цогцолборын Ядмын сүмийг сэргээн засварлах ажлыг АНУ-ын элчин сайдын нэрэмжит соёлын өвийг хамгаалах сангийн 269.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Энэржин” ХХК гүйцэтгэж, дээврийн ажлыг бүрэн дуусгасан

бөгөөд сэргээн засварлах ажлын гүйцэтгэл 90 хувьтай. Үлдсэн сүмүүдийн сэргээн засварлах зорилгоор МУ-ын 2022 оны улсын төсөвт 1,723.5 сая төгрөг баталсан. Засварын ажил 40 хувьтай хэрэгжиж байна. Тус музейн гадна тохижилтын ажлыг Соёлын өвийн үндэсний төв болон “Преспектив шийдэл” ХХК-ийн хооронд 5 дугаар сарын 22-ны өдрийн №23-01-26 дугаар гэрээг 287.6 сая төгрөгөөр гэрээ байгуулж, 11 дүгээр сарын 15-ны өдөр комиссын акт баталгаажсан.

2.6.3.6.5. Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчилж, иргэн, сүм хийдийн өмчлөл эзэмшилд байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулна.

Биелэлт: “Монгол улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг таньж тогтоох шалгуур үзүүлэлтийн чиглэлээр соёлын баримтат өвийг нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэх арга зүйн сургалтыг 21 аймаг, 9 дүүргийн мэргэжилтнүүдэд зохион байгуулсан. 2023 онд нийт 3200 баримтат өвийг Монгол Улсын баримтат өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн жагсаалтад бүртгэсэн.

2.6.3.7. Хууль сахиулах байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх нэгж байгуулж, чадавхыг бэхжүүлнэ.

Биелэлт: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/315, 2022 оны А/205 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд “Түүх соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх тасаг”-ийг 5 орон тоотой байгуулан, цол цалингийн зэрэглэлийг баталж, алба хаагчийг томилсон. Мөн Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан 1 эрдэм шинжилгээний хурал, 3 уулзалт зөвлөгөөн, 3 сургалтад давхардсан тоогоор 116 алба хаагчийг хамруулсан. Алба хаагчдыг сургалт, зөвлөгөөнд хамруулснаар тэдний соёлын өвийг хамгаалах мэдлэг ойлголт, онцлог, ялгаа, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой болсон.

Цагдаагийн Ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны III хэлтэст соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх нэгж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газарт соёлын хяналтын нэгжүүд 6 болон 3 албан хаагчийн орон тоотойгоор 2022 онд байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас тухайн нэгжүүдтэй байнгын хамтын ажиллагаа тогтоож, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Түүнчлэн тусгай чиг үүргийн байгууллагуудын төвийн болон орон нутгийн албан хаагчдын соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээрх чадавхжуулах сургалтыг “Соёлын өвийн хамгаалал”, “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үндэсний сүлжээг бэхжүүлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, Соёл урлагийн газартай хамтран “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний анхдугаар зөвлөгөөн”-ийг 2022 оны 11 дүгээр сарын 10, 11-ний өдөр зохион байгуулсан.

Соёлын яамны захиалгаар “Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийг 2023 онд хүлээн авах бэлтгэл хангаж байна. Уг системийг хүлээн авсны дараа шаардлагатай техник, хэрэгслийг тодорхойлж, цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох ажлыг үе шаттай зохион байгуулна.

2.6.4. Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх

чиглэлээр хөгжүүлнэ.

2.6.4.1.Хэвлэл мэдээллийн салбарын үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллагын оролцоо, нөлөөлөл” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтаар “Хүний хөгжилд соёлын үзүүлэх нөлөө”, “Бүх нийтийн соёлын боловсролд сэтгүүлчдийн оролцоо”, “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөө”, “Нийгмийн соён гэгээрэл ба сэтгүүл зүй”, “Сэтгүүлч-нийгмийн сэтгэл зүйч” сэдвийн хүрээнд илтгэлүүд хэлэлцүүлж, санал солилцсон.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, иргэдийг соён гэгээрүүлэх 22 нэвтрүүлэг, контентыг өргөн нэвтрүүлгийн 10 гаран телевизээр, 36 нэвтрүүлэг, контентыг орон нутгийн телевизээр нэвтрүүлж түгээсэн. МҮОНРТ-тэй хамтран “Соёлын хүртээмж” сэдэвт телевизийн хэлэлцүүлэг шууд нэвтрүүлгийг иргэд, олон нийтэд бэлтгэн хүргэсэн. Нэвтрүүлэгт Соёлын дэд сайд М.Батбаяр, Соёлын яамны холбогдох бодлогын газрууд болон харьяа байгууллагуудын дарга нар, сэтгүүлч, соёл судлаачдын төлөөлөл оролцож аймаг, нийслэл, орон нутгийн соёлын төв, музей, театр урлагийн байгууллагын соёлын хүртээмж болон тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцсэн. Ховд аймгийн Соёл урлагийн газар болон соёл урлагийн байгууллагууд үндэсний агуулгатай 11 нэвтрүүлэг бүтээж орон нутгийн телевиз болон байгууллагын фейсбүүк хуудсаар түгээсэн. Хөвсгөл аймгийн Соёл урлагийн газар орон нутгийн телевизүүдтэй хамтран соёлын өвийг сурталчлан таниулах агуулгатай 9 нэвтрүүлэг бэлтгэн телевиз, цахим хуудсаар түгээсэн. Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газар Дербес ТВ-тэй хамтран соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах зорилгоор хөрөг нэвтрүүлэг бүтээж фейсбүүк хуудсаар олон нийтэд түгээсэн. “Монгол хэл бичиг соёл судлалын олон улсын академи” ТББ, “Билэг” фильмтэй хамтран “Баатарлаг тууль”-ийн тухай кино-контент нэвтрүүлэг хийсэн.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Санхүү, төсвийн зохицуулалт.

3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

3.1.1.Инфляцын зорилтот түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

3.1.1.1.Инфляцын зорилтот түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газар Монголбанктай хамтран Короновируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эсрэг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байгаа ба Нөөцийн махны борлуулалтын хяналтыг сайжруулах, түгээлтийг хүртээмжтэй байдлаар зохион байгуулах чиглэлээр тус хөтөлбөрийн хүрээнд 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож байгаа бол Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 341 дүгээр тогтоолоор 2021 оны намрын ургацаас гурил, тэжээлийн үйлдвэрт улаанбуудай, дотоодын үйлдвэрт тосны ургамал худалдан авахад зориулан 150.0

тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор болсон. 2021 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр нийт албан нөөц 4.2 тэрбум ам.долларт хүрч, импортын 7.7 сарын нөөцийг хангахаар байгаа нь олон улсын жишигт түвшнийг бүрэн хангаж байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас богино, дунд хугацаанд экспортоос олох валютын бодит орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулан, батлуулсан. Тогтоолд тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжсэнээр ашигт малтмалын борлуулалтын үйл ажиллагаа ил тод болж, баялгийг олон улсын үнээр худалдаалах боломж бүрдэх, олборлолтоос экспорт хүртэлх бүх үе шатанд цахим төлбөрийн баримтын бүртгэл хийгдэж, ашигт малтмалын шинжилгээний дүгнэлт, гаалийн бүрдүүлэлтийг автоматаар гүйцэтгэх тогтолцоо нэвтрэх, богино хугацаанд валютын улсын нөөцийг бодитоор нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

3.1.2. Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

3.1.2.1. Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: Цар тахлын хүндрэлээс шалтгаалж эдийн засгийн өсөлт саарсан 2020-2021 онуудад төсвийг тэлэх, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэх, албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, иргэд аж ахуйн нэгжүүдийн хэрэглээний зардлыг төрөөс хариуцах зэрэг мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлсэн. Харин 2022 оноос эхлэн эдийн засгийн өсөлт хурдсаж байгаатай холбогдуулан инфляцын өсөлтийг сааруулах болон төсвийн тэнцлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2023 онд төсвийн хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлэн, гүйцэтгэлтэй уялдуулсан цалингийн шинэчлэл болон эхлүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг эцэслэх, эдийн засгийн өсөлтийг хурдасгах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

3.1.3. Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож, эрсдэл даах чадамжтай болгоно.

3.1.3.1. Банкны тухай хууль, Төвбанкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль зэрэг хууль, тогтоомж холбогдох журамд өөрчлөлт оруулна.

Биелэлт: Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, зохистой хөгжлийг дэмжих, харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах зорилгоор Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын 2021 оны 5 дугаар сарын 21-ны өдрийн хаврын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Арилжааны банкнуудыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээс өмнө Монголбанкнаас эдгээр банкнуудад активын чанарын үнэлгээг хийх шаардлага тавигдсаны дагуу банкнуудын IPO хийх хугацааг нэг жилээр буюу 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгах зохицуулалтыг УИХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан.

3.1.4. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.

3.1.4.1. Санхүүгийн түрээсийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна."

Биелэлт:Хуулийн төслийг 2024 онд өргөн мэдүүлэхээр хойшлуулж, шаардлагатай судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

3.1.5. Санхүүгийн түрээсийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.5.1. Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн орчныг сайжруулна.

Биелэлт:Хуулийн төслийг 2024 онд өргөн мэдүүлэхээр хойшлуулж, шаардлагатай судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

3.1.6. Иргэдийг санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх замаар мөнгө хүүлэлтийг таслан зогсооно.

3.1.6.1. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулна.

Биелэлт:"Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль"-ийн төслийг эцэслэн боловсруулан, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдлийг ханган 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/990 дүгээр албан бичгээр хууль санаачлагч болох Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан байна. Иймээс энэ заалтыг Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах саналтай байна.

3.1.7. Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох боломжийг бүрдүүлнэ.

3.1.7.1. Сүүлийн үеийн дэвшилтэт технологи дээр тулгуурласан, хөрөнгийн зах зээл дээр ашиглагдах цахим арилжааны дэд бүтцийг нэвтрүүлж, иргэд, хуулийн этгээдэд арилжаанд орох замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт:Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд блокчэйн технологи ашигласан шинэ системийг нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэгч байгууллага болон төлбөр тооцоо гүйцэтгэгч, үнэт цаас хадгалагч байгууллагуудтай хамтран гүйцэтгэж системийг эхний байдлаар бэлэн болгосон. Улмаар 2020 оны 6 дугаар сараас арилжааны туршилтуудыг хийж эхэлсэн бөгөөд 2020 оны 12 дугаар сар хүртэл сар бүр 2-оос доошгүй удаа арилжааны туршилтыг хийж гүйцэтгэсэн. Bonds.mn цахим системээр дамжуулан арилжаа эрхлэх хүрээнд Төрийн банк болон Хаан банкны зүгээс системийн холболтыг хийгээд байгаа бөгөөд Цар тахлын үеэр үүсээд буй хөл хорионоос шалтгаалаад иргэд, байгууллага арилжааны банк дахь салбарт Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд оролцох данс болон Харилцагч, Банк, Сангийн яам хооронд байгуулах гэрээг үзэглэх боломжгүй болсон тул Хаан банк, Худалдаа хөгжлийн банкны "Гялс банк" болон "Интернэт банк" үйлчилгээнүүдийг ашиглан Харилцагчдын арилжааны банканд биеэр очиж гэрээ

байгуулалгүйгээр Засгийн газрын дотоод үнэт цаасанд bonds.mn системээр нэвтрэх боломжийн талаар судалж, энэ талаар Хаан банкны Хөрөнгө зохицуулалтын газартай 2023 оны 12 дугаар сарын 4-ний өдөр санал солилцсон бөгөөд тус асуудлыг Хаан банкны зүгээс гэрээгээр зохицуулах боломжийг судалж хариу мэдэгдэхээр тохиролцсон.

3.1.8.Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.

3.1.8.1.Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.

Биелэлт:"Чанаргүй активыг бууруулах стратеги"-ийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар баталж, 2020 оны жилийн эцсээр тус хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө дуусгавар болсон. Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 24 арга хэмжээний 22 арга хэмжээг бүрэн биелсэн бөгөөд хэрэгжилтийн ерөнхий дүн 98 хувьтай гарсан. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийн УИХ-д ХЗДХЯ-аас өргөн мэдүүлсэн, чуулгын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах асуудлыг ХЗДХЯ-аас хариуцан ажиллаж байна. Иймээс энэ арга хэмжээг Сангийн яамны хариуцан биелүүлэх арга хэмжээнээс хасуулах саналыг дахин хүргүүлж байна.

3.1.9.Хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ.

3.1.9.1.Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т тусгасны дагуу Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлнэ.

Биелэлт:Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 102 дугаар тогтоолын дагуу олон улсын санхүүгийн зах зээлд жилийн 5.125 хувийн купонтой 5.5 жилийн хугацаатай 600.0 сая ам.долларын Номад бондыг 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр арилжаалж, 2021 оны 4 дүгээр сард төлөх Мазаалай бонд, 2022 оны 12 дугаар сард төлөх Чингис бондуудын тодорхой хэсгийг буцаан худалдан авсан. Дэлхий даяар тархаад буй Ковид-19 цар тахлын нөлөө Монгол Улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж буй энэ цаг үед Засгийн газар нь 2021 онд эргэн төлөгдөх 10.875 хувийн хүүтэй Мазаалай бондыг 5.125 хувийн бага хүүтэй шинэ бондоор сольж, жил бүр Засгийн газрын гадаад бондын хүүгийн зардлаас 26.7 сая ам.долларыг хэмнэх боломжтой болсон. Түүнчлэн Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2022-2023 онд эргэн төлөгдөх "Гэрэгэ" бондын 16.3 сая ам.доллар, "Чингис" бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.8 сая ам долларын Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаг үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгөөр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт гаргасан. Мөн "Засгийн газрын зүгээс 2023 онд 2 удаагийн өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлсэн. 2023 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр Сенчири-2 үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргаж 2023 онд төлөгдөх нөхцөлтэй Гэрэгэ бондын үндсэн төлбөрөөс 435.2 сая ам.доллар, 2024 онд төлөгдөх нөхцөлтэй Хуралдай бондын үндсэн төлбөрөөс 207.5 сая ам.долларыг дахин санхүүжүүлсэн. Бондыг 5 жилийн

хугацаатай (2028 онд төлөгдөх), 8.65 хувийн хүүтэйгээр гаргасан болно. 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Сенчири-3 үнэт цаасыг гаргаж 2024 онд төлөгдөх нөхцөлтэй Хуралдай бондын үндсэн төлбөрөөс 350 сая ам.долларыг дахин санхүүжүүлсэн. Бондыг 5.5 жилийн хугацаатай, 7.875 хувийн хүүтэйгээр гаргасан болно. Түүнчлэн, 2022 онд Чингис бондын үлдэгдэл төлбөр болох 136.8 сая ам.доллар, 2023 онд Гэрэгэ бондын үлдэгдэл төлбөр 82.0 сая ам.долларыг төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүй хэмжээгээр төсвийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулсан болно."

3.1.10.Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

3.1.10.1.Барааны борлуулалтын шат дамжлага бүрийг бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан бүртгэж иргэд гар утасны "и-баримт" аппликейшн ашиглан тамхи, согтууруулах ундаа зэрэг онцгой албан татвартай бүх төрлийн бараа, эмийн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар зэрэгт хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт:Бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан хувь хүн, хуулийн этгээдийн гаалийн импорт,экспортын мэдүүлэг болон цахим төлбөрийн баримтаар хэвлэсэн баримтын мэдээлэл бүртгэдэг болсон. Худалдан авалт борлуулалтын шат дамжлагад хяналт тавих, барааны үлдэгдэл тооцох боломжтой болсон бөгөөд ОАТ тэмдэгтийн захиалга бүрэн автоматажсан. ЭМЯ эм эмэн бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийг ГЕГ-ийн гаалийн бүрдүүлэлтэд ашиглаж цахимаар мэдээлэл лавлах боломжтой болсон. ЭМЯ тусгай зөвшөөрөлд эм, эмэн бүтээгдэхүүнд баркодоор бүртгэдэг болсон. ЭМЯ шаардлагатай мэдээллийг боловсруулан дамжуулах боломжтой болсон. ТЕГ Бараа бүртгэлийн нэгдсэн системийг ашиглан Гаалийн мэдүүлгийн мэдээллийг цаг алдалгүй сервисээр дамжуулан солилцдог болсон. ББНС-д цугласан боловсруулсан дата ашиглан Эрсдэлийн шалгуур үзүүлэлт болгон ашиглаж байна. ОАТ тэмдэгтийн захиалга, Татвар төлөгч хүсэлтээ гаргах ТЕГ баталгаажуулалтын процессоор дамжин хэвлэх үйлдвэр лүү илгээгдэж хэвлэлтээс гарах процесс цахим болсон. Татвар төлөгч "и-баримт" аппликейшн ашиглан онцгой албан татвартай бүтээгдэхүүнд наасан QR кодтой тэмдэгтийг уншуулснаар гарал үүсэл, үйлдвэрлэсэн огноо, импортолсон огноо, ААН-ийн мэдээлэл шалгаж, хяналт тавих боломжтой болсон. Бараа бүртгэлийн нэгдсэн системд эм, эмэн бүтээгдэхүүний нэгжийн үнэ, ширхгийн үнэ тооцож тодорхойлдог болсон. Барааны борлуулалтын шат дамжлага бүрийг бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан бүртгэж иргэд гар утасны "И-баримт" аппликейшн ашиглан тамхи, согтууруулах ундааны гарал үүсэл, чанар зэрэгт хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. Бараа, бүтээгдэхүүн, ашигт малтмалыг үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импортын үе шат бүрээр мэдээллийн нэгдсэн санд бүртгэх журмыг ТЕГ, ГЕГ-тай хамтран боловсруулан Сангийн сайдын 2023 оны А/89 дүгээр тушаалаар батлуулсан. Уг журмаар дотоодод үйлдвэрлэх, борлуулах, экспортлох, импортлох бараа бүтээгдэхүүнийг олон улсын стандарт хангасан GS1-13 кодоор кодлон Бараа бүртгэлийн нэгдсэн системд бүртгэх, уг кодыг ашиглан цахим төлбөрийн баримт үйлдэх, тухайн барааг үйлдвэрлэгч борлуулагч борлуулалтын гэрээ болон дагалдах бусад мэдээлэлд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 33.4-т заасан мэдээллийн нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг зохицуулсан.

3.1.11.Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ.

3.1.11.1.Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх зорилгоор газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгоно.

Биелэлт:Татвар төлөгчийн бүртгэл, татварын тайлан, татварын төлөлт зэрэг татварын албаны үйл ажиллагаа нь бүрэн цахимжсан. Түүнчлэн, 2020 оны 1 дүгээр сараас эхлэн газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгосон байна. "И-баримт" аппликейшн ашиглан үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, малын тоо толгойн албан татвар, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газрын төлбөр, галт зэвсгийн албан татварын нэхэмжлэхийг цахимаар хүргүүлж, төлөх боломжийг бүрдүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Түүнчлэн иргэд НӨАТ-ын буцаан олголтын урамшууллын дүнгээс албан татвар төлөх боломжийг бүрдүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн.

3.1.12.Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.

3.1.12.1.Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй төрийн албан хаагчийн мэдээлэлд суурилсан Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлнэ. Салбаруудын орон тоонд хяналт тавьж, давхардсан болон илүүдэл орон тоог илрүүлэх замаар орон тоог дахин хуваарилах, бууруулах зэргээр цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгож, зардлын өсөлтийг тогтворжуулна.

Биелэлт:Сангийн яам төсвийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газруудын орон тоо, цалин хөлсний зардлын хуваарилалтад хяналт тавих, төсвийн үр ашиг, сахилга батыг сайжруулах зорилгоор ТАЦНС-ийн функциональ шаардлага болон бизнес процесс боловсруулах, турших программ хангамж хөгжүүлэх ажлыг ГТСМТТ улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран гүйцэтгэж, албан хаагчдын цалин хөлсийг системээр тооцоолон, албан хаагчдын арилжааны банкны нэрийн дансанд гүйлгээ илгээж байна. ТАЦНС-ийг улс орон даяар үе шаттайгаар нэвтрүүлэх Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 163 дугаар тогтоол батлагдсан. Тогтоолын хэрэгжилтийг хангаж 2020 оны 9 дүгээр сараас үе шаттайгаар нийт 4,375 байгууллагын нягтлан бодогч, дарга нар хэрэглэгчээр бүртгүүлэн нэвтэрч цалин хөлс бодож эхэлсэн нь 100 хувийн гүйцэтгэлтэй байна. ТАЦНС, Төрийн сангийн удирдлагын цахим систем, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн хэрэглэгчдийн гүйлгээний цахим баталгаажуулалтыг Эрхийн бүртгэлийн сангаар дамжуулан хийдэг болсноор нэг ажил үүргийг давтан хийдэг байдлыг хялбаршуулж мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах бололцоо бүрдлээ.Сангийн сайдын 2021 оны 109 тоот тушаалаар баталсан "Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн үйл ажиллагааны заавар"-ын дагуу Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтнүүд, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарын төсвийн мэргэжилтнүүд, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга болон ТЕЗ-ын ерөнхий нягтлан бодогч нарыг ТАЦНС-д хэрэглэгчээр холбох ажил бүрэн хийгдсэн. Ингэснээр харьяа байгууллагуудын орон тоо, цалин хөлсний мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой болсон.

3.1.12.2.Төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS системийг хөгжүүлж хөрөнгө оруулалтын талаарх цогц мэдээллийг олон нийтэд хүргэнэ.

Биелэлт:Төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS системийг Fiscal системтэй холбосноор гүйцэтгэгчид цахим системээр дамжуулан санхүүжилтийг шууд олгох ажил амжилттай хийгдэж, гүйцэтгэлийн санхүүжилтийг гүйцэтгэгчийн дансанд шууд шилжүүлдэг боллоо. Хуучин гүйлгээний процесс дунджаар ажлын 7-14 хоног байсан бол шинэ гүйлгээний процесс 20-30 минут болсон. ТЕЗ, байгууллага, гүйцэтгэгч тал санхүүжилтийн явцын талаар бүрэн мэдээлэлтэй болсон. Цахим систем нь иргэд, олон нийт болон системийг ашиглагч байгууллагуудад зориулсан "www.publicinvestment.gov.mn" веб сайт, "Public Investment" гар утасны аппликейшнаас гадна 9 дэд систем бүхий төсвийн хөрөнгө оруулалтын НЭГДСЭН удирдлагын систем болоод байна. Цахим систем нь "Төслийн амьдралын мөчлөгийн хүрээ"-н дэх аливаа үйл ажиллагааг удирдлагаар хангах, хяналт хийх, үр ашгийг тооцоолох өндөр ач холбогдолтой.

3.1.12.3.Төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, концесс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төслүүдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

Биелэлт: АХБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа "ТСУИТҮАБТ төсөл"-ийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, концесс орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлж, Монгол улсын хэмжээнд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төслүүдийн өнөөгийн байдал болон хөрөнгө оруулалтыг оновчтой удирдах олон улсын туршлагыг судлан технологийн дэвшлийг ашиглах замаар улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн цогц мэдээллийн системийн архитектур шийдэл болон холбогдох программ хангамжийг боловсруулах ажлын даалгаврыг 2021 онд батлуулсан.

Тус системийг 2022 онд ашиглалтад оруулж, туршилт тохируулга, хөгжүүлэлтийг хийж, холбогдох мэдээллийг мэдээллийн санд нэгдсэн загварын дагуу оруулж холбон, тест сервер дээр бүртгэж, 19 аймагт сүүлийн 10 жил орон нутгийн төсвөөс хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг оруулж нэгтгэсэн.

Мөн системд шинээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй болон төлөвлөж буй төслүүдийн мэдээллийг оруулах, улмаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй нэгтгэн харах, төлөвлөхтэй холбогдуулан системд орон нутгийн төсвийн дэд систем үүсгэж, төсөл бүртгэх, төлөвлөх хэсгийн хөгжүүлэлтийг хийсэн. Системийн хэвийн, тогтвортой ажиллагааг хангах хүрээнд Төрийн сангийн газраас гүйлгээ хийхийн өмнө дахин баталгаажуулж байхаар харилцан тохиролцож холбогдох туршилтуудыг хийж баталгаажуулсан.

Системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, ашиглахтай холбоотойгоор төрийн сангийн мэргэжилтнүүд, яам, агентлаг, нийслэл, бүх дүүрэг, аймгийн төсвийн хөрөнгө оруулалт, гүйцэтгэл хэрэгжилт хариуцсан албан хаагчдад болон бүх захиалагч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч нарт зориулсан сургалтыг шат дараатай зохион байгуулсан.

2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг бүртгэх, ИТХ-д танилцуулах, батлах, төслүүдийг ОН коджуулах, батлагдсан төслүүдийн хавсралтыг цахим системээс татаж авах хөгжүүлэлтийг хийсэн.

3.1.12.4.Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тайлан бүртгэл, хяналтын системийн нэгдсэн дэд бүтцийг бий болгоно.

Биелэлт: АХБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа "Төсөв, санхүүгийн удирдлагын ил

тод, үр ашигтай байдал төсөл"-ийн хүрээнд Сангийн яамны дэргэд Мэдээллийн нэгдсэн төвийг барьж ашиглалтад оруулсан. Төслийн зөвлөхүүд модуль боловсруулж, төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тайлан бүртгэл, хяналтын системийн нэгдсэн дэд бүтэцтэй болгох ажлыг хийж байна. Хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн систем бүрдүүлэх талаар системийн зөвлөхийн баг PIMIS системийг худалдан авах ажиллагааны системтэй холбосноор тухайн төсөл, арга хэмжээний тендерийн явц болон оролцогчийн талаарх мэдээллийг авах, мөн Монголбанкны системтэй холбож захиалагч болон гүйцэтгэгчийн дансны мэдээллийг шалгах боломжтой болсон. Төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн системийн хүрээнд боловсруулах 9 модулиас Бодлогын модулийн хөгжүүлэлтийг хийж, энэхүү модулийг PIMIS системтэй холбох ажлыг бүрэн хийж дууссан. Төлөвлөлтийн модуль дээр Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төвийн зураг төслийн магадлалын нэгдсэн систем болон Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын e-gazag.gov.mn цахим системтэй холбогдсон бөгөөд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөлтөд амжилттай ашиглан Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн 2024 оны төсвийн тухай хуульд тусгах барилга, байгууламжийн саналыг үнэлсэн.

3.1.12.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож төсөл, арга хэмжээний үр ашиг, хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулна.

Биелэлт: Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжүүлэх, хянахад Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, мөн Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлал”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2022 оны 12 дугаар сард УИХ-аар хэлэлцэж баталсан бөгөөд энэхүү хуульд тусгагдсан холбогдох журам, зааврын төслийг боловсруулж байна. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг шинэчлэн батлав.

3.1.12.6. Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хяналт, зөвшөөрлийн процессыг хялбаршуулах, автоматжуулах программ хангамж хөгжүүлнэ. /69.9 мянган ам.доллар/

Биелэлт: Засгийн газрын гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл, зарцуулалт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүсэлтийг хянах, хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлагыг сайжруулах, хэрэгжилтийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийг бүрэн ашиглах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, төсөлд оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан /odamis.mof.gov.mn/ цахим системийг 2020 оны 12 дугаар сард нэвтрүүлж, 2021 оны эхний хагас жилд сайжруулалт зүгшрүүлэлтийг хийж бүрэн ашиглалтад оруулсан. Тус хугацаанд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хяналт, зөвшөөрлийн процессыг хялбаршуулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, түргэн хугацаанд шийдвэрлэж ажиллах боломжийг сайжруулсан.

3.1.13.Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.

3.1.13.1.Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулж, Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хамт эцэслэн боловсруулсан. УИХ-ын 2023 оны 76 дугаар тогтоолоор баталсан УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэх асуудлын 37 дугаарт Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэхээр тусгагдсан.

3.1.13.2.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зөвлөх үйлчилгээний баг боловсруулж, хуулийн төслийг танилцуулж, нийт 10 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал авч, шаардлагатай санал, өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг эцсийн байдлаар боловсруулж байна.

3.1.13.3.Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээ (үндэсний хөтөлбөр) боловсруулна.

Биелэлт: Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11-т “Бусад хууль тогтоомжид заасан “төрөөс баримтлах бодлого” гэснийг энэ хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд, “үндэсний хөтөлбөр” гэснийг энэ хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно” гэж заасны дагуу Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд Өрсөлдөөний чиглэлээр хэрэгжүүлэх 3 арга хэмжээг тусгаад байна.

3.1.13.4.Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Биелэлт: НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг эхлүүлж, хуулийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Богд судалгааны хүрээлэн шалгарч, холбогдох судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулж, Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн үзэл баримтлал, хуулийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг танилцуулсан. НҮБ-ын Хүүхдийн сан болон НҮБ-ын Хүүхдийн сангийн Ази номхон далайн орнуудын төслийн удирдагчтай уулзалт хийж, Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бусад улс орнуудын Зар сурталчилгааны тухай хуультай нийцүүлэхэд санал боловсруулж өгөхөөр болсон. Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангасан.

3.1.13.5.Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бүтцийг бий болгож, хүн амын хүнсний болон аюулгүй байдалд сөрөг нөлөөт зар сурталчилгааг таслан зогсоох, хязгаарлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлнэ.

Биелэлт: Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хэрэгжилтийг хариуцан ажиллах нэгжийг бий болгох зохицуулалтыг тусгасан бөгөөд хууль батлагдсаны дараа хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна. Зар сурталчилгааны хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил дутагдал гаргасан аж ахуйн нэгж, иргэнд холбогдох хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

3.1.13.6."Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр III" боловсруулна.

Биелэлт: Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх нэг арга хэмжээг Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд тусган боловсруулсан.

3.1.13.7."Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий "Үндэсний зөвлөл"-ийн үйл ажиллагааг өргөжүүлж зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбар дундын бодлогын удирдамжаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус үндэсний хороо байгуулж ажиллуулна. /Засгийн газрын тогтоолоор/

Биелэлт: Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.11-т "Бусад хууль тогтоомжид заасан "төрөөс баримтлах бодлого" гэснийг энэ хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд, "үндэсний хөтөлбөр" гэснийг энэ хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно" гэж заасны дагуу салбарын хөтөлбөр тусгайлан батлахгүй байх эрх зүй бий болсонтой холбоотойгоор хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий "Үндэсний зөвлөл"-ийг байгуулж ажиллах боломжгүй болсон.

3.1.13.8.Зах зээл дэх хэт төвлөрлийг сааруулах, монопол, давамгай байдлаа урвуугаар ашиглахын эсрэг бодлогын арга хэмжээ авна.

Биелэлт: Зах зээлийн судалгааны хүрээнд 2021 онд зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох зах зээлийн судалгаа хийх ажлын хүрээнд нийт 7 зах зээлд 19 аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоосон. Мөн 2021 онд ноос, ноолуур цахилгаан тамхи, Монгол Улсын хот хоорондын шуудан үйлчилгээ /дайвар ачаа/, газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд бодлогын судалгаа хийсэн.

Засгийн газрын 2010 оны "Зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох" журмыг үндэслэн Дорноговь аймаг дахь Хонгорын-Овоо өртөөний дагнасан хэрэглээний салбар төмөр зам эзэмшигчийн зах зээлийн судалгааг хийж, тус зах зээлд "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийг зүй ёсны монопол байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоосон. Ингэснээр үнэ тарифт хяналт тавих нөхцөл бүрдсэн мөн тус зах зээлд төмөр замын суурь бүтцийг ашиглан тээврийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуй эрхлэгч нэгээр нэмэгдсэн.

3.1.14.Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно.

3.1.14.1.Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг сайжруулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газраас цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг ханган бэхжүүлэх, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын хэрэгжилтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилго бүхий “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг батлуулсан. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг эрчимжүүлэх хүрээнд 6 зорилтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Тус зорилтыг хэрэгжүүлж, эрчимжүүлэхээр яамд тус тусын чиглэлээр төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанд сар бүр танилцуулан ажиллаж байна.

Засгийн газрын 2022 оны "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ашигт малтмалын экспортын гэрээний бүртгэлийг цахимжуулах, тээврийн зохион байгуулалтыг сайжруулах, уул уурхайн биржийн тогтолцоонд шилжих, нүүрсний экспортын худалдааны нөхцөлийг уурхайн ам нөхцөлөөс хил хүртэл худалдах нөхцөлд шилжүүлэх, төрийн өмчит компаниудын экспортын валютын орлогыг гадаад валютын нөөцөд төвлөрүүлэх бодлогыг уул уурхайн салбарт хэрэгжүүлж байна. Тогтоолын хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар тухай бүр хэлэлцүүлж, нийт 54 арга хэмжээ бүхий 14 тэмдэглэлийг гаргуулсан. “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 233 дугаар тогтоолыг баталсан.

3.1.14.2. Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Хөгжлийн зорилтот хөтөлбөр, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон бусад холбогдох баримт бичгүүдийг боловсруулна.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод үндэслэн дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хөгжлийн зорилтот хөтөлбөр (ХЗХ) -ийн төслийг боловсруулсан. “Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр” -тэй уялдуулж, үндэсний хэмжээний зорилго, зорилт, түүний хүрэх түвшин, хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. “Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтаар “Хөгжлийн зорилтот хөтөлбөр” Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогыг, 2 дугаар хавсралтаар Үндэсний болон салбарын үр дүнгийн хяналт -шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг, 3 дугаар хавсралтаар Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг боловсруулсан. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний төслийг холбогдох тооцоолол, саналын товьёг, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын хуралдааны шийдвэрийн төсөл, үзэл баримтлалын төслийн хамт боловсруулж, эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас саналыг авснаар 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/241 дугаар албан бичгээр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад хүргүүлсэн.

3.1.14.3. Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн төслийг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар эцэслэн баталсан. Тус хууль батлагдсантай холбогдуулан Улсын Их

Хурлын 2022 оны 77 дугаар тогтоол гарч, тус тогтоолын 2-т “Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын 1.3-т Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд гэсэн жагсаалтын 17-д заасан “Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгыг дэмжих тухай” гэснийг, мөн жагсаалтын 25-д заасан “Концессын тухай /Шинэчилсэн найруулга/” гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэж заасан буюу Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгыг дэмжих тухай хуулийг боловсруулах заалтыг хүчингүй болгосон.

3.1.14.4.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/17 дугаар тушаалаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төсөлд 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн олон нийтээс санал авч, 2 удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ хугацаанд олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 695 саналыг ирүүлсэн. Нийт ирүүлсэн саналын 60 хувийг тусган Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

3.1.14.5.Хил гаалийн шалган нэвтрүүлэх цогцолборын барилгын ажлыг хийлгэнэ.

Биелэлт: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Замын-үүд” чөлөөт бүсэд гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн цогцолбор барьж байгуулах бөгөөд зөвлөх компани зураг төсөл боловсруулах шатанд явагдаж байна.

3.1.14.6.Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн Загварыг (INFF) нэвтрүүлнэ.

Биелэлт: Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн хүрээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилго бүхий Ажлын хэсгийн хүрээнд 4 дэд Ажлын хэсэг байгуулагдан, Монгол Улсын хөгжлийн бодлогыг санхүүжүүлж буй эх үүсвэрүүдэд үнэлгээ хийв. Түүнчлэн Монгол Улсад байгаа санхүүжилтийн боломж, эх үүсвэрүүдийг хэрхэн оновчтой болгох санал дүгнэлт боловсруулж, үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх стратегийн төслийг боловсруулан төр, хувийн хэвшил, судлаачдаар хэлэлцүүлж тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн Загварыг (INFF) нэвтрүүлэх замын зураглал хийж, “Монголын тогтвортой санхүүгийн форум 2021”-т танилцуулсан.

3.1.15.Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.

3.1.15.1.Даатгалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Даатгалын

тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай зэрэг хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулна.

Биелэлт: Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн тандан судалгаа, үзэл баримтлалын төслүүдийг боловсруулж, хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2021 оны 12 дугаар сард баталсан.

Хуулийн төслүүдийн үзэл баримтлал, төслүүдэд даатгалын салбарын оролцогч байгууллагууд, мөн олон нийтээс албан бичгээр болон цахим хэлбэрээр ирсэн 414 орчим саналуудыг хэлэлцэж, ирсэн саналуудын хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагууд, төлөөллүүдтэй удаа дараагийн 2 талын уулзалтыг хийсэн.

Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдэд яамдаас ирүүлсэн саналыг СЗХ-той хамтарсан ажлын хэсгийн хамт судлан холбогдох зүйл, заалтуудад тусгасан. Зөвшөөрлийн тухай болон Хууль тогтоомжийн тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж бэлтгэн сүүлийн хувилбарыг нийт салбарын оролцогчдод 2023.12.22-ны өдөр танилцуулж хэлэлцүүлэг хийсэн бөгөөд зарим саналуудыг тусгах ажил хийгдэж байна.

3.1.16.Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгана.

3.1.16.1.Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон мэдээллийн системийн тоог нэмэгдүүлэх, цахим системд бүртгэгдэж буй машин унших боломжтой өгөгдлийн тоог нэмэгдүүлж, нээлттэй өгөгдлийг түгээх, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулж, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлж, холбогдох мэдээллийг иргэд, байгууллага, олон нийтэд ил тод мэдээлнэ.

Биелэлт: Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан тендер оролцогчдын дараах мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтыг “Худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn/-д бодит цагийн горимд авах боломжийг бүрдүүлсэн.

Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон мэдээллийн системийн тоог нэмэгдүүлэх, цахим системд бүртгэгдэж буй машин унших боломжтой өгөгдлийн тоог нэмэгдүүлж, нээлттэй өгөгдлийг түгээх, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулж, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх хүрээнд 12 төрлийн лавлагааг Худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан холбогдох төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сангаас шалгаж, тендер шалгаруулалтын үнэлгээнд ашиглаж байна.

3.1.16.2.Төрийн байгууллагын худалдан авч буй бараа, үйлчилгээнд эрэлт, нийлүүлэлт, дотоодын үйлдвэрлэгчдийн зах зээлийн бүтэц, өрсөлдөөний хэлбэр, хүчин чадалд тогтмол судалгаа зохион байгуулж, ерөнхий гэрээ байгуулан, иргэд, байгууллага, олон нийтэд ил тод мэдээлнэ.

Биелэлт: ТХААГ/202209019 дугаартай “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Үдийн хоол” үйлдвэрлэлд шаардагдах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээгээр худалдан авах” тендер шалгаруулалтын нарийн бичгээр ажиллаж, уг тендер шалгаруулалтын 5 удаа зохион байгуулсны үр дүнд 2023 онд 41 хүнсний бүтээгдэхүүн худалдан авах 68 ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт бүртгэсэн.

ТХААГ/202207018 дугаартай “Сургууль, цэцэрлэгийн ширээ сандал, тавилга хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авах” тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын 3.9-д заасныг үндэслэн журмын 3.10, 3.11-т тус тус заасны дагуу зохион байгуулж 2 тендер оролцогчтой 9 бараанд 16 ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт тендер санал болгосон бүтээгдэхүүнийг байршуулсан. ТХААГ/202302002 дугаартай “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд гишүүнээр ажилласан. Уг тендер шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулсны үр дүнд 34 эмийг худалдан авах ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт байршуулсан. ТХААГ/202304099 дугаартай “Зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авах” тендер шалгаруулалтын нарийн бичгээр ажилласан бөгөөд тус тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж 50 эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт байршуулсан.

3.1.17.Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.

3.1.17.1."Замын-Үүд" чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн системийн ажлыг суурилуулж, дуусгана.

Биелэлт: Улсын төсвийн 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Замын-үүд" чөлөөт бүсийн "Харуул хамгаалалтын нэгдсэн систем"-ийг барьж байгуулах ажлыг Хил хамгаалах ерөнхий газар гүйцэтгэсэн.

3.1.17.2.Бүсийн болон аймаг, сумын доторх цахилгаан хангамжийг өргөтгөнө. /Сэлэнгэ, Алтанбулаг/ /Батлагдсан зураг төсөвтэй/

Биелэлт: "Алтанбулаг" чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл /Сэлэнгэ, Алтанбулаг сум/-ийн барилга угсралтын ажлын гэрээг "Улаанбаатар Электромонтаж" ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан. 2023 оны Төсвийн тухай хуулийн дагуу 2023 онд санхүүжих дүн 3,193.77 сая төгрөг батлагдаж, санхүүжилтийг 100% олгосон болно. 2023 оны гүйцэтгэлийн хувь 100%, нийт гүйцэтгэлийн хувь өссөн дүнгээр 30 хувьтай байна.

3.1.17.3."Алтанбулаг" чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбоно.

Биелэлт: Алтанбулаг чөлөөт бүсийг "Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох" ажлын санхүүгийн эх үүсвэр Улсын нэгдсэн төсөвт тусгагдахаар байсан ч санхүүжилт тавигдаагүйн улмаас төсөл хэрэгжээгүй байна. Төсөл хэрэгжээгүйн улмаас төслийн төсөвт өртөг нэмэгдэж 553 сая төгрөг болж өссөн.

3.1.17.4.Хил гаалийн шалган нэвтрүүлэх цогцолборын барилгын ажлыг хийлгэнэ.

Биелэлт: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Замын-үүд” чөлөөт бүсэд гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн цогцолбор барьж байгуулах бөгөөд зөвлөх компани зураг төсөл боловсруулах шатанд явагдаж байна.

3.1.17.5.Худалдаа, тээвэр ложистик, гаалийн хяналтын талбай барьж байгуулна.

Биелэлт: Алтанбулаг тээвэр, логистикийн төвийн барилгын ажил болон шаардлагатай санхүүжилтийн төлөвлөгөөг гаргах Чөлөөт бүсийг түшиглэн тээвэр логистикийн төв байгуулах бодлогын хүрээнд БНСУ-ын “Мэдлэг хуваалцах хөтөлбөр (KSP)-өөр дамжуулан Алтанбулаг тээвэр, логистикийн төвийг хөгжүүлэх ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг зохион байгуулсан. Үүний дагуу тээвэр логистикийн төвийг олон улсын хуурай боомт болгон хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, хүлээгдэж буй үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, Алтанбулаг тээвэр логистикийн төвийг байгуулахад шаардагдах нийт төсвийг тогтоож, эдийн засгийн үр ашигтай байдалд дүн шинжилгээ хийсэн.

Улмаар “Алтанбулаг тээвэр логистикийн төв” төслийн 1-р шатны төслийн эдийн засгийн шинжилгээний үр дүнг гаргаж ирүүлэхэд NPV буюу өртөг, өгөөжийн шинжилгээ нь - 5.258.955 ам.доллар буюу эдийн засгийн үндэслэл баталгаажуулах болох нь тогтоогдсон тул төслийн үйл ажиллагаа зогссон.

3.1.17.6.Цахилгаан хангамжийг нэмэгдүүлнэ (Цахилгаан шугам, сүлжээ шинээр татах)

Биелэлт: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Замын-үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн аж ахуйн нэгжид хүргэх цахилгааны салбар шугам сүлжээний ажил хийгдэх бөгөөд зөвлөх компани зураг төсөл боловсруулах шатанд явагдаж байна. Алтанбулаг чөлөөт бүс 3.8 км 6кВ-ын цахилгаан хангамжийн түр шугам 2610 кВа -ын хүчин чадалтай цахилгаан шугам сүлжээ хийгдсэн.

3.1.17.7.Цэвэр бохир усны байгууламжийн, ерөнхий шугамын зураг төсөв, бүтээн байгуулалтын ажил.

Биелэлт: "Алтанбулаг" чөлөөт бүсийн цэвэр усны зураг төсөв ажлын "Оргил төсөл" ХХК 2010 онд 2,871,298,200 төгрөгийн зураг төсөв батлагдсаны дагуу чөлөөт бүсийн цэвэр усан хангамжийн эх үүсвэр болох Буурын голын хөндийн гүний 7 худгаас хоногт 6300 м.куб цэвэр усаар хангах хүчин чадал бүхий инженерийн байгууламжийг 2010 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд бүсийн доторх цэвэр усны шугам сүлжээ нь 5.6 км, усан сан нь 800 м.куб, 50 м.куб усан сан, өргөлтийн насос станц "Комфорт импекс" ХХК хийж гүйцэтгэсэн. Алтанбулаг" чөлөөт бүсийн цэвэр усны зураг төсөв ажлын "Зэт Эй Ди" ХХК 2012-2013 онд 8,023,000,000 төгрөгийн зураг төсөв батлагдсаны дагуу бүсийн доторх бохир усны шугам сүлжээ нь 11 км, Сүхбаатар сум - Алтанбулаг чөлөөт бүс хүртэлх 25 км бохир усны шугам сүлжээ, бохир усны насос станц нь хоногт 5700 м.куб бохир усны Сүхбаатар сумын цэвэрлэх байгууламжид нийлүүлэх хүчин чадалтай 12ш өргөлтийн насос станц бөгөөд 372 ширхэг үзлэгийн худагтай инженерийн байгууламжтай. Сүхбаатар сум -Алтанбулаг чөлөөт бүс хүртэлх насос станцын 6кВа-н цахилгаан дамжуулах агаарын шугам 19.8км. 100кВа-н 10 ширхэг, 50кВа-н 2ширхэг, 12 ширхэг трансформатор бүхий дэд станцын ажлын "Комфорт импекс" ХХК хийж гүйцэтгэсэн.

3.1.17.8.Бүсийн төлөрсөн уурын зуухны зураг төсөв, нэгдсэн халаалтын шугамын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажил.

Биелэлт: “Замын-Үүд” чөлөөт бүсэд тус ажил төлөвлөгдөөгүй бөгөөд “Замын-үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 2011-2017 оны хооронд 90 мВт хүчин чадалтай дулааны станц барьж байгуулсан.

3.1.18.Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн

боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг сайжруулна.

3.1.18.1.Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж сайжруулна.

Биелэлт: "Алтанбулаг", "Замын-Үүд боомтын шугам сүлжээ /Дорноговь, Замын-Үүд сум/" төсөлд 2020 онд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. 2021 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын багцад "Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төсөл, хилийн боомтын дэд бүтцийн хүрээнд хийгдэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээнд 5.0 тэрбум төгрөг батлагдаж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2020 онд улсын төсвөөс "Гаалийн боомтуудыг шилэн кабельд холбох /Улсын хэмжээнд/" төсөлд 3.0 тэрбум төгрөг олгосон бөгөөд 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 2.5 тэрбум төгрөг батлагдаж 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар батлагдсан санхүүжилтийг бүрэн олгосон.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Боршоо, Шивээхүрэн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор боомтын бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна. Мөн ОХУ-тай хиллэдэг 3, БНХАУ-тай хиллэдэг 7 буюу нийт 10 боомтыг шинээр өргөтгөн шинэчлэхээр төлөвлөсөнтэй холбогдуулан гаалийн байгууллагаас зураг төслийн компаниудтай хамтран ажиллаж, тухайн боомтуудад баригдах барилга байгууламж болон байрлуулах гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн тоо, байрлалыг тогтоосон. Хилийн боомтоор нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, мөн хилийн хяналтын албан хаагч нарын оролцоог багасгах зорилгоор автозамын хилийн боомтуудад орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулахаар төлөвлөсөн. Үүнд: Рентген: 5-12 км цагийн хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэлд ачсан барааг шалгах эхний ИСБ-А рентгенийг Шивээхүрэн боомтод суурилуулсан бөгөөд дараагийн рентгенийг Боршоо боомтод суурилуулахаар төлөвлөн 2022 оны 9 дүгээр сард үйлдвэрлэгч компанийн мэргэжилтнүүд байршлыг тодорхойлсон. Байршил тодорхойлсон мэдээллийг үндэслэн ОХУ-ын үйлдвэрлэгч компани экспортын бичиг баримтаа бүрдүүлсний дараа ачилт хийгдэнэ; Ухаалаг гарцын систем: Гашуунсухайт боомтын ойролцоо байгуулагдсан чингэлэг терминал гаалийн хяналтын бүсэд ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор улсын хилээр орох, гарах чиглэлд тус бүр 1 буюу нийт 2 эгнээ замд ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг сайжруулахаар ажиллаж байна.Түүнчлэн хилийн боомтын шинэчлэл төслийн хүрээнд гаалийн нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад болон дотоод эх үүсвэрээс тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийхэд 120.0 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөж, 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаж, барьцаа хөрөнгийн данснаас 5 тэрбум төгрөг чөлөөлсөн.

3.1.19.Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулна.

3.1.19.1."Замын-Үүд" чөлөөт бүсэд гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулна.

Биелэлт: Замын-Үүд” чөлөөт бүсэд хөрөнгө оруулах аж ахуйн нэгжүүдийг найдвартай эрчим хүчээр хангах ажлын хүрээнд “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдсэн цахилгаан дамжуулах 16 ш 10/0.4 кВт-ын дэд өртөөний 0.4 кВт талын тоноглол угсрах, шалны засварын ажлыг Эрчим хүчний яамны захиалгаар “Улаанбаатар электро монтаж” ХХК гүйцэтгэсэн. Тус ажлын гүйцэтгэл бүрэн дуусаж Эрчим хүчний үндэсний төв болон БЗӨБЦТС ТӨК-аас 2022.12.22-нд техникийн комисс ажилласан. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 280 дугаар тогтоолоор Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан зохицуулах зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг; Гадаад харилцааны сайдын 2022 оны А/69 дүгээр тушаалаар Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг тус тус баталж хятадын талд дипломат шугамаар мэдэгдэн анхдугаар хуралдааныг товлон хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

“2023 БНХАУ-ын Олон улсын эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын Эрээн хот чуулга уулзалт ба үзэсгэлэн худалдаа”, “Монгол-Хятадын Экспо”-д тус тус оролцож, арга хэмжээний үеэр чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлан танилцуулга хийж, холбогдох албаны төлөөллүүдтэй уулзалт хийсэн.

ОХУ-ын Буриад улсын Эдийн засгийн сайдыг “Замын-Үүд” чөлөөт бүсэд хүлээн авч, чөлөөт бүсийн хөгжлийн бодлого хууль эрх зүйн орчин, дэд бүтцийн талаарх мэдээллийг хийв. БНХАУ-ын ӨМӨЗО-ний Эрээн хотод зохион байгуулагдсан “2023 БНХАУ-ын Олон улсын эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын Эрээн хот чуулга уулзалт ба үзэсгэлэн худалдаа”, мөн Хөх хотод зохион байгуулагдсан “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээний үеэр болсон Монгол, Хятадын “Замын-Үүд Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хоёр талын хамтарсан дугуй ширээний уулзалтыг зохион байгуулсан.

”Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 280 дугаар тогтоолоор, Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг Гадаад харилцааны сайдын 2022 оны А/69 дүгээр тушаалаар тус тус батлуулсан. Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдааныг товлон хуралдуулах талаар Гадаад харилцааны яам дипломат шугамаар санал хүргүүлсэн.

3.1.20. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна.

3.1.20.1. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна.

Биелэлт: “Экспортын баталгааны сан” байгуулах боломжийн талаарх судалгааг Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих төсөл” болон Европын Холбооны санхүүжилттэй “StepEcoLab төсөл”-тэй хамтран хийхээр төлөвлөн ажиллаж байна. Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих төсөл”-өөс жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг сайжруулах, санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор Түншлэлийн хөтөлбөр-ийг ЖДҮГ-тай хамтран хэрэгжүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тус хөтөлбөрт хамрагдахаар нийт 43.1 тэрбум төгрөгийн 203 хүсэлт ирүүлснээс 20.2 тэрбум төгрөгийн 100 өргөдөл төслийн иж бүрдлийн шаардлагыг хангасан. Үүнээс ЖДҮГ-т нарийвчилсан судалгаанд хамруулахаар нийт 51 төсөл ирүүлснээс үнэлгээний хорооны хуралд 50 төслийг хэлэлцүүлж, хурлын шийдвэрээр 8.2 тэрбум төгрөгийн 38 төсөл дэмжигдэж, 37 төсөлтэй түншлэлийн гэрээ байгуулаад байна.

Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Экспортыг дэмжих

төслийн хүрээнд "Үндэсний давхар даатгал" ХК-тай хамтран Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн. Даатгуулагчид үүсэх эрсдэлээс хамгаалж Үндэсний Давхар Даатгал ХК, Олон улсын давхар даатгагч SCOR групп хооронд байгуулсан экспортын худалдааны зээлийн хувь тэнцүүлсэн давхар даатгалын гэрээ болон "Бодь даатгал" ХК, "Миг даатгал" ХХК-тай байгуулсан давхар даатгалын мастер гэрээний хугацааг тус тус 2022.10.01-ний өдрөөс 1 жилийн хугацаатайгаар сунгасан.

Ноолуур бэлтгэлд зориулан 2023 онд олгох хөнгөлөлттэй зээлтэй холбогдуулан зээлийн барьцаа хөрөнгийн дутагдалтай үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор экспортын гэрээг "Экспортын зээлийн даатгал"-д даатгуулан арилжааны банканд барьцаа хөрөнгөд тооцуулж санхүүжилтийг нэмэгдүүлэх эхний жишиг загварыг "Ханбогд кашемир" ХХК дээр гаргахаар шийдвэрлэн, 2023.01.17-ны өдөр "Үндэсний давхар даатгал" ХК, "Ханбогд кашемир" ХХК хооронд "Мэдээллийг задруулахгүй байх гэрээ" (NDA)-г байгуулж харилцагчдыг судлан, судалгааны ажлыг дуусгасан. Экспортын зээлийн даатгалын гэрээний төслийг боловсруулан, албажуулахад бэлэн болоод байна.

УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол, ЗГ-ын 2023 оны "Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоолын хүрээнд олгох "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл"-ийг арилжааны 10 банкаар дамжуулан олгохоор 2023.03.30-ны өдөр талууд гэрээнд гарын үсэг зурж албажуулсантай холбогдуулан "Үндэсний давхар даатгал" ХК-ийн төлөөллүүдтэй санал солилцох уулзалтыг 2023.03.30-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар тус зээлүүдэд Монголбанк болон арилжааны банкнуудаас тавьж буй нөхцөл, саналыг танилцуулж, бараа материалын хөрөнгийн болон экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнтэй уялдуулан зээлийн барьцаа хөрөнгийн дутагдалтай зээлдэгч иргэн, ААН-д дэмжлэг үзүүлэх боломжийн талаар харилцан санал солилцсон. Ерөнхий гэрээний дагуу хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, хоршоодод эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг 5-6 хувийн хүүтэйгээр, 3-5 жилийн хугацаатай Мал аж ахуйн үйлдвэрлэлд 132.3 тэрбум төгрөг, Газар тариалангийн үйлдвэрлэлд 342.6 тэрбум төгрөг, Хүнсний боловсруулах, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжихэд 507.1 тэрбум төгрөгийн нийт 982.0 тэрбум төгрөгийн зээлийг банкны эх үүсвэрээс олгож байна.

3.1.21. Нийслэлээс 1000 км-ээс дээш алслагдсан бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд 10 дахин бага буюу 1 хувийн татвар төлөх хуулийн хөнгөлөлтийг үргэлжлүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг санхүү, татварын бодлогоор дэмжиж, бүсийн нэмэгдэл олгоно.

3.1.21.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг болно.

Биелэлт: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг болсон. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт бизнесийн үйл ажиллагаа эрхлэх явдлыг дэмжиж төвлөрлийг сааруулах зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-аар 2022 оны 4 дүгээр сард батлуулсан болно. Энэ хуулийн хүрээнд олон төрлийн татварын дэмжлэгийг энэ оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн эдлүүлж байна. Үүнд:

- 2023 оноос хойш хэрэгжих дулаан, цахилгааны төслүүдийг борлуулалт хийж эхэлснээс хойш гурван жил 90 хувь, дараагийн гурван жил 50 хувиар тус тус орлогын

- татвараас хөнгөлнө;
- Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж үйлдвэр, агуулахаа орон нутагт нүүлгэсэн тохиолдолд нүүлгэн, шилжүүлэлтийн зардлыг 50 хувиар нэмэгдүүлэн тооцож татвар ногдох орлогоос хасна;
- Орон нутагт барьж байгуулсан барилга байгууламжийн элэгдэл тооцох хугацаа одоо 25 жил байгааг өөрийн сонголтоор 15 жилийн дотор түргэн хугацаанд элэгдүүлэн тооцож зардлаа хурдан нөхөх боломжтой болсон;
- Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж тухайн орон нутгаас ажил хайгч иргэнийг ажилд авсан тохиолдолд тухайн аж ахуйн нэгж тухай иргэнд олгосон цалингийн зардлыг 20 хувиар нэмэгдүүлэн татвар ногдох орлогоос хасаж тооцно.

3.1.22. Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

3.1.22.1. 2020 оны 4 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 1-ийн өдрийг хүртэл хугацаанд хувийн хэвшилд ажилладаг иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлнө.

Биелэлт: Монгол Улсын Их хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх тухай хуулийн хүрээнд 2020 оны 4 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд хувийн хэвшилд ажилладаг иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлсөн байна.

Уул уурхай, хүнд үйлдвэр

3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.

3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.

3.2.1.1. Оюу Толгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2022 онд далд уурхайн бүтээн байгуулалтыг 73 хувьд хүргэнэ гэж тусгасан. 2023 оны 12-р сарын 20-ний байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 92.1%, налуу амны туузан дамжуургын угсралтын ажлын гүйцэтгэл 84.3 хувь, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл 33.6 хувь, агааржуулалтын 3-р босоо амны нэвтрэлт 865 метрт, агааржуулалтын 4-р босоо амны нэвтрэлт 959 метрт тус тус хүрээд байна. Далд уурхайгаас хүдэр олборлолтын ажил явагдаж байна.

Цаашид налуу амны дэд бүтцийн угсралтын ажил, агааржуулалтын босоо амнууд

болон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулснаар далд уурхайгаас хүдэр гаргах хүчин чадал төслийн хүчин чадалдаа хүрнэ. 2023 оны 11 сарын байдлаар далд уурхайн бүтээн байгуулалтад нийт 5,961 сая ам.долларыг зарцуулсан бөгөөд 2023 онд 497 сая ам.долларыг зарцуулаад байна.

3.2.1.2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 50%, Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжийн /Өөрөө нунтаглах хэсгийн хүдэр боловсруулах 4-р шинэ шугам, Хам баяжуулалтын 12 сая тн/жил хүчин чадалтай 5-р секцийг шинэчлэх/ төслүүд 100% хийгдэж, одоо Баяжуулах үйлдвэрт 4 төсөл хэрэгжиж байна. Засварын механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ болон инженерийн зураг төслийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлж хүлээн авсан. Уг төслийн хүрээнд одоогийн цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл, Механик цехийн өргөтгөл шинэчлэл, шинэ Цутгуурын цех байгуулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж, ажлын гүйцэтгэл 37%-тай байна.

3.2.1.2.1. Мөчлөгт урсгалт тээврийн технологи

Биелэлт: Төслийн ажлыг 2020 оны 05 дугаар сард байгуулсан “түлхүүр гардуулах” нөхцөлтэй гэрээний дагуу ХБНГУ-ын “ЗВТЕС Aufbereitung ssysteme GmbH” ХХК-ийн гүйцэтгэж байна. Гэрээний үнэ 40.7 сая ам.доллар, гэрээний хугацаа 2021 оны 11 дугаар сарын 28-нд дуусахаар гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компанийн зүгээс цар тахал, хил хаагдсан болон тээвэр логистикийн хүндрэлтэй асуудал зэргээс төслийн ажил графикт хугацаанаасаа ихээхэн хоцорсон тул гэрээний хугацааг сунгах, мөн Орос-Украины дайн, Европ дахь эрчим хүчний хямрал, инфляц зэрэг хүчин зүйлийн улмаас үнэ өссөн гэсэн үндэслэлээр гэрээний үнийг 48 хувиар нэмэгдүүлж, 59.7 сая ам.доллар болгох хүсэлтийг удаа дараа тавьсан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зүгээс төслийн үнийн дүнг их хэмжээгээр нэмэгдүүлэх гүйцэтгэгчийн санал бодитой эсэхэд хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлтийг тендерт шалгарсан олон улсын аудитын “Кей Пи Эм Жи Аудит” ХХК-аар гаргуулсан. “Кей Пи Эм Жи Аудит” ХХК-ийн дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэгч компанитай хэлцэл хийж, гэрээний хугацааг сунгаж, гэрээний үнийг 52.67 сая ам.доллороор тохиролцон, 2023 оны 07 дугаар сарын 21-нд гэрээний нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Мөн 2024 оны 07 дугаар сарын 20-ыг хүртэл хийгдэх ажлын календарчилсан төлөвлөгөөг баталсан. Төслийн ажил гэрээний нэмэлт, өөрчлөлт, календарчилсан төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Уурхайн мөргөцгийг тулах түшиц ханын угсралтын ажил, суурийн цутгалтын ажил хийгдэж 2057 м³ М250 маркийн бетон зурмагийн ажил хийгдсэн. Ирсэн тоног төхөөрөмжүүдийн ангилан ялгаж, угсралтад бэлдэж байна. 2023 онд 11.97 тэрбум төгрөг, нийт төслийн хугацаанд 832.26 тэрбум төгрөг буюу 55.7 хувийн санхүүжилт хийгдээд байна. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 50 хувьд хүрсэн.

3.2.1.2.2. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Биелэлт: Төслийн ажлыг 2020 оны 05 дугаар сард байгуулсан “түлхүүр гардуулах” нөхцөлтэй гэрээний дагуу “Монголиан Инвестмент Корпорэйшн” ХХК гүйцэтгэж байна. Гэрээний үнэ 10.2 тэрбум төгрөг, гэрээний хугацаа 2022 оны 04 дугаар сарын 30-нд байсан.

Цар тахлын халдварын дэгдэлтээс шалтгаалан давагдашгүй хүчин зүйл үүссэн, БНХАУ-ын хил хаагдсан, тээвэрлэлт саатсан, материалын үнэ өссөн зэргээс шалтгаалан хугацаа их алдсан гэх үндэслэлээр гүйцэтгэгч компанийн тавьсан удаа дараагийн хүсэлтийн дагуу төслийн ашиглалтад оруулах хугацааг 2023 оны 06 дугаар сарын 30-н хүртэл сунгасан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ажлын хэсэг уг төслийн ажилд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэж, зохих арга хэмжээ аван ажиллаж байгаа боловч гүйцэтгэгч компаниас шалтгаалан ажил удаашралтай явагдаж байна. 2023 оны 12 дугаар сарын 20-ний байдлаар барилгын ажил үндсэндээ дууссан гэж гүйцэтгэгч компани мэдэгдсэн тул Улсын комисс томилж ажиллуулж байна. Үйлдвэрийн технологийн схемийн усан туршилтыг хийж, технологийн процессын үйлдвэрлэлийн туршилт хийх, ажид залгах, удирдах программ хангамж хүлээгдэж байна. 2023 онд 1.221 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, нийт төслийн хугацаанд 12.31 тэрбум төгрөг буюу 121% төлбөр хийсэн байна.

3.2.1.2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл

Биелэлт: Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх ажлын нарийвчилсан инженерийн тооцоо, зураг төсөл боловсруулах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу лабораторийн туршилт, тоног төхөөрөмжийн сонголт, инженерчлэл, инженер геологийн судалгаа, БОННУ зэрэг ажлууд хийгдсэн. Зураг төсөл боловсруулах ажлын 85 хувийг гүйцэтгэсэн. Хөвүүлэн баяжуулах хэсгийн өргөтгөл шинэчлэлийн хүрээнд 2022 онд хам баяжуулалтын 5-р секцийг шинэчилсэн бөгөөд 2023-2024 онуудад баяжуулалтын 2, 3-р секцийг шинэчлэх төслийн хүрээнд тендер шалгаруулалт зохион байгуулж гэрээ байгуулсан. Инженерийн тооцоо, тоног төхөөрөмжийн сонголт хийгдэж үйлдвэрлэл эхэлсэн. Ажлын зураг төсөл хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 40%. Өөрөө нунтаглах хэсгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх (2.0сая.тн/жил-ээр). 2023 оны 01 дугаар сард тээрэм суурилуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалт зохион байгуулж, гэрээ байгуулсан. 2023.09.28-ны байдлаар зураг төсөл хийгдсэн, үндсэн тоног төхөөрөмж болон цахилгаан хөдөлгүүр, давтамжийн хувиргагчийн үйлдвэрлэл 85%. Үндсэн тоног төхөөрөмж болох тээрэм түүний иж бүрдлүүдийн үйлдвэрлэл дуусаж, хяналтын угсралт хийгдсэн. Тус үйлдвэрээс 2 мэргэжилтэн хүлээж авахаар ажиллаж байна, төслийн гүйцэтгэл 37.5%. Хүдэр бутлах, нунтаглах хэсгийн өргөтгөл, шинэчлэл төслийн ТЭЗҮ, инженерийн тооцоо зураг төсөл боловсруулах ажлын гэрээ байгуулсан. ТЭЗҮ боловсруулж “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн 2023.02.15-ны өдрийн №33 тоот шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг хэлэлцэж хүлээн авсан бөгөөд үйлдвэрийн газрын Техникийн зөвлөлөөр дэмжигдсэн. УУХҮЯ-ны сайдын тушаалаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шинжээчид томилогдон ТЭЗҮ-ийг хянаж, бүртгэсэн. Инженер геологийн судалгаа, БОННУ зэрэг ажлууд хийгдсэн. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил 70% гүйцэтгэлтэй байна. Нийт төсөвт өртгөг 1.6284 их наяд төгрөг буюу 2022 оны эцэст гүйцэтгэл 13.34 тэрбум төгрөг, 2023 оны санхүүжилтийн гүйцэтгэл 80.242 тэрбум төгрөг, нийт санхүүжилт 93.582 тэрбум төгрөг байна.

3.2.1.2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл

Биелэлт: Засвар, механикийн заводын 2018-2031 оны өргөтгөл шинэчлэлийн урьдчилсан ТЭЗҮ 2020 онд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр батлагдсан. Засвар, механикийн заводыг (2020-2024 он) үндэсний машин үйлдвэрийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил дуусаж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Цутгуурын цехийн Илчийн боловсруулалтын хэсэг, Механик цехийн барилга байгууламжийн өргөтгөлийн ажлын зураг төсөл боловсруулах ажил “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэнд хийгдэж байна. Цутгуурын цехийн Илчийн

боловсруулалтын хэсгийн өргөтгөл шинэчлэлийн зураг төсөл боловсруулах ажил 50%-тай. Ажлын явц гэрээнд заасан график төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.

3.2.1.3.Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна.

Биелэлт: Төсөл хэрэгжүүлэгч Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж өнгөрсөн онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна. Бүтээн байгуулалтын ажил 69%-тай байна. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төслийн талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2024 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Үндсэн болон туслах тоног, материалын тээврийг хийж байна. Мөн туслах тоног төхөөрөмжийн захиалга, үйлдвэрлэл хэвийн үргэлжилж байна. 2023 онд 242.46 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмжийн худалдан авалт, төслийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан.

3.2.1.4.1."Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл

Биелэлт: Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50 хувьд хүрсэн. 2020 онд JBIC-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 29.8 тэрбум төгрөгийн 12 тоног төхөөрөмж шинэчлэлт хийгдсэн. 2021 онд 2-р шатны техникийн шинэчлэлд шаардлагатай 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэх ёстой боловч өнөөдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй байна.

3.2.1.4.2.Шивээ-овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалт.

Биелэлт: Засгийн газрын 2018 оны 132-р тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд эрчим хүчний нүүрс олборлогч “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн зардал бууруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, уурхайн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангуулахад техникийн шинэчлэл хийх түүнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Эрдэнэс Монгол ХХК, Японы олон улсын хамтын ажиллагааны банкны экспортын зээлийн шугамаар шийдвэрлэсэн.

Дээрх JBIC төслийн хүрээнд 2 комацу PC1250 гидро экскаватор, 5 комацу HD465 технологийн автомашин нийлүүлэгдэж нийт 14.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2020-2022 оны төлөвлөгөөт хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг биелүүлэх, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж өвөлжилтийг давахад бодитой хувь нэмэр оруулсан. 2021 онд “Шивээ-Овоо” ХК JBIC төслийн хүрээнд 14.8 тэрбум төгрөгийн зээлийн гэрээгээр Комацу HD465 технологийн автомашин 5, Комацу PC-1250 гидро экскаватор 2 ширхэг нийлүүлэгдэж, эдгээр техникүүдийн төлбөрт 6.6 тэрбум төгрөгийг төлж, одоогийн байдлаар үлдэгдэл төлбөр 8.2 тэрбум төгрөг байна. 2022 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар “Барловорлд Монголиа” ХХК-аас 7.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн гэрээтэй нийлүүлсэн CAT777E 2 ширхэг технологийн автомашины төлбөрт 6.4 тэрбум төгрөг төлж, үлдэгдэл төлбөр 1.5 тэрбум төгрөг байна. Дээрх техникүүдийг уулын үйлдвэрлэлд ашиглаж эхэлснээр технологийн автомашины шинэчлэл 70%-ийн биелэлттэй байна.

3.2.1.5. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.

Биелэлт: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн №48 тогтоолоор Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор “Асгатын төслийн нэгж”-ийг байгуулсан. Асгат төслийн нэгжийн бүрэлдэхүүн 2023 оны 08 дугаар сарын 01-ээс ажлаа эхэлсэн байна. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны төсөвт Асгатын мөнгөний ордын ашиглах ордыг олборлох боломжийг судлах, олон улсын (JORC) стандартаар хайгуулын ажлыг хийх, бусад холбогдох үйл ажиллагааны санхүүжилтэд нийт 11,090,452,828 төгрөг тусгасан. Үүнд:

- Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- Асгатын ордын уурхайн амнуудыг нээх ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.

3.2.1.5.1. Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалт.

Биелэлт: Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК нь 3/15 (Mon)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Туршилт судалгааны ажилд ирүүлсэн дээж нь ордыг төлөөлөхгүй байна гэж дахин дээж авах ажлыг эхлүүлээд байна. Цаашид далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийхэд уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. Цар тахалтай холбоотой төсөв танах Засгийн газрын чиглэлийн дагуу цуцлагдсан.

3.2.1.5.2. Асгатын мөнгөний ордын зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт.

Биелэлт: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж "Стийл Айрон" ХХК шалгарч нөөцийн категорийг өнөөгийн нөөцийн ангилалд нийцүүлэх ажил хийгдсэн. Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт 60%-д хүрсэн. Ордын хэмжээнд 5000 га талбайд М1:2000 гадаргын бүрэн зураглал хийх, тусгай зөвшөөрлийн хил хязгаар тогтоох шав тэмдэг тавих ажил цар тахалтай холбоотой төсөв танах Засгийн газрын чиглэлийн дагуу цуцлагдсан.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны төсөвт Асгатын мөнгөний ордын ашиглах ордыг олборлох боломжийг судлах, олон улсын (JORC) стандартаар хайгуулын ажлыг хийх, бусад холбогдох үйл ажиллагааны санхүүжилтэд нийт 11,090,452,828 төгрөг тусгасан.

Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /JORC/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан боловсруулж батлуулах ажлын нээлт 2023 оны 12 дугаар сарын 13-нд хийгдсэн. Тухайн тендерт 3-н компани материал ирүүлсэн боловч тендерийн шаардлага хангаагүй учир уг тендерийг ТХААГ-аас дахин зарлах шийдвэр гарсан.

3.2.1.5.3. Асгатын мөнгөний ордын нэмэлт хайгуулын ажлын хөрөнгө оруулалт.

Биелэлт: “Эрдэнэс Монгол” ХХК нь Асгатын мөнгөний ордод олон улсын нөөц баялгийн (JORC) ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт судалгааны ажил хийж, ордын нөөцийг баталгаажуулахаар 2023 оны төсөвт 9,182.0 сая төгрөг тусгасан.

Ордын бэлтгэл ажлын хүрээнд “Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах”, “Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх”, “Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн ажлууд”-ыг ТХААГ-аар зохион байгуулагдаж, тус тендерүүдэд шалгарсан гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна.

3.2.1.5.4. Асгатын мөнгөний ордын дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалт.

Биелэлт: Өмнөх судалгааны ажлын явцад хийгдсэн Хэвтээ ам-1, Хэвтээ ам-1а, Хэвтээ ам-2, Хэвтээ ам-3, Хэвтээ ам-4, Хэвтээ ам-5-дыг ашиглах боломжийг хангах, нарийвчилсан хайгуулын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дараах тендерүүдийг зарлаж, гэрээ байгуулсан. Үүнд:

- ЭМГЛ/202306084 дугаартай “Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах” тендерийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- ЭМГЛ/202306085 дугаартай “Асгатын ордын уурхайн хэвтээ ам нээх” тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулах тухай зөвлөмж ТХААГ-аас 2023.11.29-нд ирсэн. Ажил гүйцэтгэгч компанитай байгуулахаар ажиллаж байна.
- ЭМГЛ/202306088 дугаартай “Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын гурван хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- ЭМГЛ/202306087 дугаартай “Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн зөвлөх” үйлчилгээний ажилд шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- “Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /JORC/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан боловсруулж батлуулах” ажлын даалгавар боловсруулан батлуулсан ажлын даалгавраа ТХААГ-т хүргүүлсэн. Tender.gov.mn нээлттэй зарлагдаж 2023 оны 12 дугаар сарын 13-нд нээсэн боловч тендерийн шаардлага хангасан оролцогч шалгараагүй тул дахин зарлахаар төлөвлөөд байна.

3.2.1.6. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.

Биелэлт: Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн бүтээн байгуулалтын гүйцэтгэл 63.51%-тай явж байгаа ба 510.44 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Уулын зарим техник, тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч байгаа ба конвейерийн системийн ТЭЗҮ-ийг батлуулсан, түлхүүр гардуулах нөхцөлтэй тендер шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 83.84%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн гүйцэтгэл 92%-д хүрсэн.

3.2.1.6.1.Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт.

Биелэлт: Жилд 12 сая.м3 уулын цулын ажил гүйцэтгэх хүчин чадал бүхий 2 ширхэг Liebherr R9200 экскаватор, 2 ширхэг Liebherr R9100 экскаватор, 13 ширхэг 130 тонны даацтай Belaz 75135 авто самосвалтай хослон ажиллаж байна. Гэрээний дагуу 2023 оны 12 дугаар сард 5ш бульдозер, 9ш авто самосвал, 3ш экскаватор, 2ш авто грейдер хүлээн авсан байна. Төслийн ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн.

3.2.1.6.2.Конвейерийн системийн хөрөнгө оруулалт.

Биелэлт: Конвейерийн системийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн тус төслийн нүүрс тээврийн конвейерийн системийн худалдан авалтын үйл ажиллагааг нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцтай уялдуулан түлхүүр гардуулах нөхцөлтэй зохион байгуулахаар ажиллаж байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-д конвейерийн ТЭЗҮ-ийг танилцуулсан. Эхний ээлжид нүүрс тээврийн конвейерийн системийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерийн ажлын даалгаврыг боловсруулж, тендер зарлахаар ажиллаж байна. Нийт ажлын гүйцэтгэл 15%-тай.

3.2.1.6.3. Нүүрс баяжуулах үйлдвэр

Биелэлт: Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “Чайна металлуржикал инженеринг компани” /СМЕС/ боловсруулж, 2021 онд ЭБМЗ-ийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай 113 дугаар тогтоол батлагдсан бөгөөд уг тогтоолд Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг ТЭЗҮ-ийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг УУХҮС болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-д даалгасан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс “Чайна металлуржикал инженеринг” компанитай байгуулсан гэрээний дагуу 2 дугаар шатны ажил болох нүүрс баяжуулах үйлдвэрийн FEED буюу урьдчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 8 дугаар сард дуусган хүлээж авсан.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн барилгын материалын татан авалтыг 2022 оны 10 дугаар сард хийж, суурь судалгааны ажлуудыг бүрэн дуусгасан. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн захиалгыг хийж, үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд анхдагч нүүрс хадгалах агуулахын суурийн цутгалтын ажил явагдаж байна. Нийт ажлын гүйцэтгэл 20%-тай байна.

3.2.1.6.4.Ачилтын нэгдсэн төв байгуулах.

Биелэлт: Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн батлагдсан ТЭЗҮ-д 2023 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэгчээс давагдашгүй хүчин зүйл учирсан шалтгаанаар төслийг 2024 оны 1 дүгээр улиралд хэрэгжүүлж дуусгахаар хойшлогдоод байна. Ачилтын нэгдсэн төв байгуулах төслийн гүйцэтгэл 84.34%-тай байна. Төслийн ихэнх овор хэмжээ томтой, голлох төхөөрөмжүүд угсрагдаж дуусаж байна. Төслийн нийт санхүүжилтэд 254 тэрбум төгрөгийг олгоод байна.

3.2.1.6.5.Усан хангамж шийдвэрлэх.

Биелэлт: "Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой" гүний усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг боловсруулж, Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулсан. Загийн усны ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч түншлэлүүдтэй гэрээ байгуулан ажлыг 2022 оны 3 дугаар сараас эхлүүлсэн. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-тай захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр байгуулан ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар:

- Гүний худгийн өрөмдлөгийн ажил 100%,
- Гүний худгийн барилга угсралтын ажил 95%,
- 4 салбар ус цуглуулах шугамын барилга угсралтын ажил 100%,
- 2 ш 1500 м3 багтаамжтай усан санг барилга угсралт, доторлох, дулаалах, буцаан булах ажил 100%,
- Зөөлөн ширмэн хоолой болон хуванцар хос хоолой угсрах, хийн тест хийх, буцаан булах, Үзлэгийн худгийн хаалт арматур угсрах зэрэг ус дамжуулах гол шугам хоолойн барилга угсралтын ажил 100%

3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

3.2.2.1.Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана.

Биелэлт: Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэх ажил бүрэн хэрэгжсэн. 2023 оны 03 дугаар улиралд Баяжуулах-2 үйлдвэрийг ашиглалтад оруулсан ба одоогийн байдлаар бүрэн хүчин чадлаар ажиллаж байна. Баяжуулах-2 үйлдвэр ашиглалтад орсноор жилд 600 мян.тн хүдэр боловсруулж, борлуулалтын орлого ойролцоогоор 65 хувиар өссөн. Баяжмал дахь мөнгөний агуулга 11,099-12,300 гр/тн байгаа ба борлуулалтын өмнөх гэрээнүүдийн үнэлгээний хувь 4-5 шатлалтай, 1 тн баяжмалын үнэ 5,200-6,000\$ орчим үнэлгээтэй байсан бол 2024 оноос борлуулалтын үнэлгээний хувийг 2 шатлал руу шилжүүлж, борлуулалтын үнийг 15 хувиар өсгөж, 1 тн баяжмалын үнэ 7,500-8,000\$ орчмоор борлуулах гэрээ хийгдсэн.

Түүнчлэн "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023.10.11-ний өдрийн хурлын 03 дугаар, "Эрдэнэс алт ресурс" ХХК хувьцаа эзэмшигчдийн 2023.10.11-ний өдрийн 08 дугаар тогтоолоор "Компани нэгтгэх гэрээ"-ний төслийг баталж, "Эрдэнэс алт ресурс" ХХК, "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн хооронд компани нэгтгэх гэрээг байгуулсан. Гэрээ байгуулснаас хойш "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн тусгай зөвшөөрлүүд, баримт бичиг, эд хөрөнгө болон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг "Эрдэнэс алт ресурс" ХХК-д шилжүүлсэн.

3.2.2.2.Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна.

Биелэлт: Далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННУ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгал орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг боловсруулан батлуулсан. Цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан.

Зүүн цагаан дэлийн далд уурхайн 2 налуу амыг холбож, бэлтгэл ажлыг бүрэн гүйцэтгэн 2022 оны 09-р сарын 28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн.

Уурхайн 1140 м түвшинд тээвэрлэлтийн налуу малталт болон агааржуулалтын босоо малталт болон түр усан сан, насосын камерын нэвтрэлтийн ажлууд явагдаж байна.

Далд усыг гадагшлуулах зорилгоор ЦНС-105 маркийн 2 ш насосыг бүрэн суурилуулж ус соруулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Ажилчдын амрах 54 хүний кемпийн эхний барилга байгууламжийн ажил бүрэн баригдаж дууссан. Хоёрдох кемпийн барилга байгууламж 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны эхний 12 дугаар сарын 10-ны байдлаар 857.2 тууш метр өрөмдөж 7813.1 м3 уулын цулыг нурааж оны эхнээс 110%-ийн гүйцэтгэлтэй байна. Уурхайн нэвтрэлтийн ажлын гүйцэтгэл 2021 оноос одоог хүртэл төлөвлөгөөт графикийн дагуу 100% гүйцэтгэлтэй байна. Ингэснээр жоншны хүдэр олборлолтыг 2025 оноос эхлүүлэх ажил төлөвлөгөөт хуваарийн гүйцэтгэгдэж байна. Төслийн биелэлт 100%.

3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.

3.2.3.1.1: 50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулна.

Биелэлт: Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн “Хулд уул-50”, “Түдэвтэй уул-50”, “Дэвийн хонгор уул-50”, “Асгат уул-50” төслүүдийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2023 оны 04 дүгээр сарын 10, 11, 14-ний өдрүүдэд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 13,150.3 км² талбай буюу 0.84%, нийтдээ 43.94%-ийг хамруулсан. Энэ ажлын үр дүнд зэсийн 3, хар тугалга-цайр 1, марганц 1, лити 1, төмрийн 6, жонш 1, гантиг 1, өнгөлгөөний чулуу 3, элс, шавар, хайрганы 3, кварцын 1 нийт 21 илрэл, 144 эрдэсэжсэн цэг, 134 геохимийн сарнилын хүрээ, 129 шлихийн сарнилын хүрээг тогтоож, мөнгө 3,085 кг, зэс 216,496 тн, цайр 23,629 тн, сурьма 19,500 тн, вольфрам 12,500 тн, молибден 13,800 тн, никель 8,700 тн, хар тугалга 16996 тн, хүнцэл 647,700 тн, төмөр 5,825,516 тн, манган 53,398 тн, өнгөлгөөний чулуу 30,000 куб.м, шавар 4,628,000 сая.тн таамаг нөөцийг тогтоож, Р зэрэглэлээр үнэлгээг өгсөн.

3.2.3.2.1: 25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулна.

Биелэлт: Үндэсний геологийн албанаас 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажил гүйцэтгэх чиглэл, агуулга, бүтцийн талаар ҮГА-ны холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй санал солилцсон. Чех улсын геологийн албаны болон ОХУ-ын геологийн салбарт ашиглаж байгаа зураглалын ажлын заавартай танилцаж судалж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2024-2028 онд Хархорин-25, Майдар-25, Чойбалсан-25, Налайх-25 төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний төсөлд санал боловсруулсан. Тухайн төслүүдийн талбайн хэмжээнд өмнө гүйцэтгэсэн геологийн бүх төрлийн судалгааны ажлын үр дүн болон бусад холбогдох мэдээлэлтэй танилцаж, судалж байна.

3.2.3.3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна.

Биелэлт: Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1 хувийг хамарсан К хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайлантай танилцан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2022 оны А/03 дугаар тушаалаар хүлээн авсан. Ингэснээр нутаг дэвсгэрийн 14.1 хувийг 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийн нэгтгэлд хамруулсан бол L хавтгайн хэмжээнд

хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаснаар нутаг дэвсгэрийн 60 хувийг судалгаанд хамруулсан бөгөөд L хавтгайн үр дүнгийн суурин боловсруулалтын ажил үргэлжлэн хийгдэж байна. Харин M хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн.

Монгол орны "M" хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийн 2023 оны төсвийг УУХҮС-ын А/21 дүгээр тушаалаар 456.4 сая төгрөгийн ажлыг баталсан. Төслийн хэмжээнд 2023 онд гүйцэтгэсэн ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр "Хээрийн материал хүлээн авах ажлын хэсэг" хянан хүлээж авсан. Үүний үр дүнд Монгол орны нутаг дэвсгэрийн M хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаж, эцсийн үр дүнгийн тайланг Монголын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянагдаж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Монгол орны "L" хавтгайн хэмжээнд хийгдсэн Улсын геологийн 1:200000-ны масштабтай иж бүрдэл зургийг нэгтгэх ажлын үр дүнд "L" эгнээний нийт 160, нэгтгэснээр 152 хавтгайн "УГЗ-200" иж бүрдлийн геологийн, ашигт малтмалын, дөрөвдөгчийн геологийн, экологи-геологийн, баримт материалын шинэчилсэн зургуудыг зохиож, тоон мэдээлэлд оруулж, мэдээллийн санг шинэчилсэн. Төслийн үр дүнгийн тайланг Монголын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянагдаж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

3.2.3.4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулна.

Биелэлт: Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны 2022 оны хээрийн шалгах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан. Ховд-2020 төслийн 2022 оны хээрийн ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.

2020-2021 онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66 хувийг агаарын геофизикийн хэмжилтийн ажилд хамруулсан.

2022 онд агаарын соронзон болон спектрометрийн өндөр эрчимжилтэй гажлуудыг 14 талбайд шалгах газрын геофизикийн хэмжилтийн ажлыг төлөвлөн, геологийн маршрут, соронзон орон ба цацраг идэвхжилийн судалгааг төлөвлөсөн хэмжээнд хийсэн. Мөн петрофизикийн дээжүүд авч лабораторид шинжлүүлэхээр өгсөн ба ингэснээр төслийн хээрийн судалгааны ажил дуусгавар болсон.

3.2.3.5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулна.

Биелэлт: 2009-2011 онд Монгол Улс, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км² талбайг буюу 32.1 хувийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нутаг дэвсгэрийн үлдсэн хэсэгт уг судалгааны ажилд 100% хамруулахаар хэрэгжүүлж эхэлсэн. 2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км² буюу 67.9 хувьд хээрийн судалгаагаар хамруулан холбогдох дээжлэлтийг авч дууссан.

2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнгээр боловсруулах тайлангийн суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын шийдвэрээр баталгаажуулсан. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын анхдагч баримт, материалыг 2022.11.11-нд хүлээн авсан.

3.2.3.6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил

хийнэ.

Биелэлт: 2022 онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан, Ховд хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геоэкологи-2019, ДА геоэкологи-2020, ХО геоэкологи-2021 болон Хангай, Хөвсгөл, Хэнтийн районы халуун рашааны геотермийн Гүний хагарал-1 нэртэй төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын шийдвэрээр баталгаажуулсан. 2022 онд Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ХО геоэкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн хээрийн судалгааны ажилд 8-р сард шуурхай хяналтыг хийсэн. Үндэсний геологийн албатай хамтран ДА геоэкологи-2020, ХО геоэкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг баталгаажуулан хүлээн авах ажлыг 2022.11-р сард багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн 2022.11.22-ны өдрийн байдлаар ХО геоэкологи-2021 хүлээн авч, ДА геоэкологи-2020 төслийн материалыг хүлээн авахаар Дархан хотод комисс томилогдон ажиллаж байна.

3.2.3.7.Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ.

Биелэлт: Монгол орны нутаг дэвсгэрийг хамарсан металлогений зураг зохиох Мета-2014 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн УУХҮС-ын 2021 оны А/225 дугаар тушаалаар хүлээн авсан.

Мезо-Кайнозой-2021 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй 2021.07.07-ны өдрийн 21 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. Гео орчин-2021 төслийн тендер 2 удаа амжилтгүй болсон тул 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2022 оны УУХҮС-ын төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулан шийдвэрлэсэн.

2022 онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагенийн судалгааны Мезо-Кайнозой-2021 болон шинээр хэрэгжүүлэх, Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтцын судалгааны Геоорчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийг төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн дэд сайд баталсан. Мезо-Кайнозой-2021 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Геоорчин-2022, БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг зохион байгуулан хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулан судалгааны ажлыг 8-р сараас эхлүүлсэн. Дээрх 4 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлыг хүлээн авч, баталгаажуулах ажлыг зохион байгуулсан.

3.2.3.8.Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ.

Биелэлт: Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан төслийн 4-р үе шатны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2021.06.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Тус зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын А/217 дугаар тушаалаар төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан Хамтарсан төслийн 5-р үе

шатны ажлын 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж хээрийн болон суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын материалыг УГА-тай хамтран 2022.11.15-нд хүлээн авсан.

Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ ба БНКазУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн V үе шат хэрэгжиж байна. Төсөлд хамтран оролцогч улсууд геологийн бүх төрлийн мэдээллийг нэгтгэж буй нь шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой ажил юм. Төслөөр Алтайн нурууны үргэлжлэл Говийн Алтайн уулсын хэмжээнд судалгааны ажил гүйцэтгэж, геологи болон холбогдох зургуудыг зохиосон. Мөн төслийн талбайн хэмжээнд 252 тодорхойлолт бүхий үнэмлэхүй насны санг бүрдүүлсэн байна. Төслийн ажлын үр дүнгийн тайлан болон хавсралт зургуудыг зохиосон. ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хийж байна.

3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.

3.2.4.1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.

Биелэлт: Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Геологийн баримт-1-2022” төслийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.

Төслөөр Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн санг Илрэл-3,538, Худаг-4,575, Цооног-5,217, Шлихийн хүрээ-2,705, Өрөмдсөн цооног-400, Эрдэсэжсэн цэг-155 нийт 5,880 ширхэг мэдээллээр баяжуулсан. Давхарга зүйн сан-707, Горизонт-61, Интрузив чулуулгийн сан-3,362, Эффузив чулуулгийн сан-360, Палеонтологийн олдворын дэд сан-3,567, Үнэмлэхүй насны сан-1,119,314 мета дата оруулсан. Үүний үр дүнд нийт 9,400 мэдээллээр нэгдсэн санг баяжуулсан.

3.2.4.2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.

Биелэлт: Геологийн судалгааны ажлын үр дүнд цугларсан чулуун дээж болон Геологийн баримтын төв архивд цаасан байдлаар хадгалагдаж байгаа баримтыг цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. “Цахим архив-1-2022”, “Чулуун дээжийн сан-1-2022” төслийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2023 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2023.02.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын шийдвэрээр баталсан.

Төслийн хүрээнд ордын чулуун дээжийн мэдээлэл оруулах ажлын хүрээнд 250 ордын дээж бүртгээд байна. Чулуун дээжийн фото зураг авах ажлын хүрээнд дээжийн-3243 фото зураг авч 2950 дээжийн зураг засварлаж бичвэр мэдээлэл оруулаад байна.

Шлифийн 7544 ширхэг зураг, аншлифийн 1301 ширхэг зураг, тайлангийн хавсралт материалаас 6166 лабораторийн үр дүнгийн хариуг сканер хийн оруулсан.

Геологийн төрөл бүрийн тайлан цахимжуулах ажлын хүрээнд 519 тайлан, боть 1261 ширхэг буюу 144930 хуудас, 12378 ширхэг хавсралт зураг цахимжуулсан. Цахим архивыг баяжуулах ажлын хүрээнд eDOC архивын программд 608 тайлангийн 1006 хадгаламжийн нэгж, 743 ширхэг цаасан суурьт баримт цахимжуулсан. 1006 хадгаламжийн нэгжийг нүүр, гарчиг, агуулгын түвшинд хайх ОПС-ийн программд холбоход бэлтгэн ашиглалтын хувь үүсгэсэн.

3.2.5.Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.

3.2.5.1.Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.

Биелэлт: Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2020 оны А/322 дугаар тушаалаар баталсан. Төслийн 2021 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг 2021.03.29-ний өдөр хэлэлцсэн ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2021.05.20-ны өдрийн А/137 дугаар тушаалаар батлан суурин судалгааны ажлыг эхлүүлсэн.

Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлын үр дүнг цар тахлын нөлөөнөөс шалтгаалан 2021 онд хүлээн авах боломжгүй технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021, ӨТТЭ-2-2022 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан.

3.2.5.2.Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.

Биелэлт: Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын эрэл үнэлгээний “ЭҮ-2-2021”, “ЭҮ-3-2021”, “ЭҮ-4-2022” болон Монгол орны алтны металлогени /1:500000-ны масштаб/, өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны “Мета-алт-500” төслийг тус тус хэрэгжүүлж байна. Төслүүдийн 2023 оны төсөл төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 14, 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын тушаалаар баталсан.

“ЭҮ-1-2020” төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Энэ төслийн ажлын үр дүнд 3 талбайн хэмжээнд алт, алт-мөнгө ба зэс, ховор металлын дан болон хам хүдэржилт бүхий 7 илрэлийг тогтоон хэтийн төлөвийг үнэлсэн байна.

Монгол орны баруун, баруун өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийг тогтоох “БӨМ-Алт-2019” төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023.04.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Энэхүү ажлын үр дүнд өмнө тогтоогдсон шороон болон үндсэн ордуудыг судлан үнэлгээ өгснөөс гадна хэтийн төлөв бүхий 13 алтны хүдрийн талбайг ялган хэтийн төлөвийн үнэлгээ өгсөн байна. Төслөөр баруун болон баруун өмнөд Монголын 557.9 мян.км² талбайд судалгаа хийж, хэтийн төлөв бүхий 9 бүсийн хэмжээнд 365.3 тн алтны баялгийг үнэлсэн байна. Төслийн үр дүнд баруун Монголд дарагдмал алтны шороон орд байх хэтийн төлөвтэй болохыг тогтоосон байна.

3.2.5.3.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө.

Биелэлт: УУХҮС-ын 2018 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам”-ын дагуу 2021 онд СШ-48-аас СШ-57 дугаартай 10 багц талбайг зарлаж 109 тусгай зөвшөөрөл олгон улсын төсөвт 16 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 29.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.

Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2023.01.06-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу УУХҮС-ын 2023 оны А/48 дугаар тушаалаар Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журмыг, А/49 дүгээр тушаалаар Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг

тус тус баталсан. Холбогдох хууль, журамд заасны дагуу www.tender.gov.mn платформ-оор сонгон шалгаруулалтыг нийтэд зарлан цахимаар үнэлж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд 2.3 сая га талбайг хамарсан 450 талбайд сонгон шалгаруулалтыг зарласны үр дүнд 1,06 сая га талбай бүхий 209 тусгай зөвшөөрөл олгосон. Үүний үр дүнд улсын төсөвт 47.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэв.

Сонгон шалгаруулалтын талбайн хэмжээг 8.6 сая га талбайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газрын 2023 оны 268 дугаар тогтоолоор баталгаажуулсан.

3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.

3.2.6.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгоно.

Биелэлт: УУХҮС-ын 2022.10.27-ны өдрийн А-273 дугаар тушаалаар холбогдох мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагууд оролцсон хэлэлцүүлэх зохион байгуулах, танилцуулах, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах, холбогдох яамдаас санал авах, Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулан ажиллаж байна.

Ажлын хэсгийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг тайланг эцэслэн боловсруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн бичвэрийг эцэслэн боловсруулж, хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 171 иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1315 орчим саналыг хянаж, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хувилбарыг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.7-д заасан тусгасан болон тусгаагүй саналыг товьёг, төслөөр шинээр бий болгож байгаа баяжуулах, технологийн аудит, маркшейдер, зураг төслийн эрхэд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу Зөвшөөрлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулахаар холбогдох судалгаа танилцуулгыг бэлтгээд байна. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаас хэлэлцүүлэхээр 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналд тайлбар, тодруулга бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.

3.2.6.2. Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно.

Биелэлт: Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг бий болгох талаар саналыг Ажлын хэсэгт хүргүүлсэн. Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөл болон төрийн өмчит аж ахуйн тооцоот газрын дүрмийн төслийг боловсруулах зэрэг бэлтгэж ажлыг хангасан.

3.2.6.3. Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна.

Биелэлт: Засгийн газрын ээлжит 2022 оны 8 сарын 03-ны өдрийн хуралдаанаас

хэлэлцүүлж, Ашигт малтмал, газрын тосны газрын орон нутаг дахь төлөөлөгчийн газрууд бий болсон ба АМГТГ-ын орон тооны хязгаар 150 байсныг 185 хүнтэй болгосон талаар 295 дугаар тогтоол баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах ажлыг зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор тусгаад байна.

3.2.6.4. Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна.

Биелэлт: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 2021 оны ажиллах хүчний мэдээлэл, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тухайн төслийн техник, технологийн шаардлагаас хамаарсан шаардлагатай мэргэжлийн инженер, техникийн гадаад ажиллах хүчний мэдээлэл болон геологийн салбарын ажил мэргэжлийн ангиллыг багцалж, мэргэжлийн нэр, нэршил, ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэх үүрэг, хууль эрх зүйн болон нийгэм эдийн засгийн үндэслэл бүхий тайлбар санал, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудын нэг болох Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-д бэлтгэгддэг Байгалийн нөөц, технологийн магистр /Master in Resources and Technology/-ын хөтөлбөрт тохирох хөтөлбөрийн нэр, индексийг жагсаалтад бүртгүүлэх хүсэлт зэргийг холбогдох яамдад хүргүүлсэн.

Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай инженер, техникийн ажиллагсдыг бэлтгэх ажлын хүрээнд ШУТИС, МУИС-тай хамтран сургалтын төлөвлөгөөг боловсруулж ШУТИС-ийн “Хөтөлбөрийн дэд хороо”, “Хөтөлбөрийн ерөнхий хороо”-оор хэлэлцүүлэн Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлд оруулаад байна. Мөн “Газрын тосны инженерчлэл” бакалаврын хөтөлбөрт БШУС-ын 2022.05.09-ний өдрийн А/160-р тушаалаар 072407 тоот индекс авсан. Энэхүү хөтөлбөрийг 2022-2025 онуудад хэрэгжүүлэх бөгөөд 2022-2023 онд инженерийн чиглэлээр элссэн оюутнуудыг 4 жилээр, инженерийн чиглэлээр сурч байгаа 2-р дамжааны оюутнуудыг 2.5 жилээр, инженерийн суурьтай төгсөгчдийг 2 жилээр сургах бөгөөд 2022 оны 9 сараас элсэлт авахаар төлөвлөсөн.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль 2022 оны 7 сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон. Уг хууль батлагдсантай холбогдуулан “Гадаадаас авах нарийн мэргэжлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох саналыг боловсруулж, ХНХЯ-нд хүргүүлсэн. Геологийн салбарын мэргэшсэн зөвлөх болон мэргэшсэн мэргэжилтний эрх сунгах, шинээр олгосон 109 хүнд гэрчилгээг УУХҮЯ-ны ТНБД-аар баталгаажуулан МГХНЗ-д гэрчилгээнүүдийг хүлээлгэн өгсөн.

3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

3.2.7.1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна.

Биелэлт: Засгийн газрын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Эдийн засаг хөгжлийн яам /хуучнаар/ болон “Кью Эс Си” ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан “Уул

уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг цуцалсан. Уг тогтоолын дагуу ТӨБЗГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн өмчит компанийн статустай болгож, бүтцийг баталж, удирдлагыг томилсон.

“Эрдэнэс Монгол” ХХК-аас “Монгол ган цогцолбор I” төслийн концепци, хүчин чадлыг өөрчлөн 1 сая тн бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэл өгсөн тул төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) хийлгэх ажлыг гүйцэтгэгч компанид мэдэгдэл хүргүүлж ажлыг зогсоосон.

Одоогийн төмөрлөгийн үйлдвэрийн шинэчлэлийн хүрээнд:

- “Мини шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төсөл хэрэгжүүлэх хүрээнд “Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв” болон “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу төслийн ТЭЗҮ-ийг боловсруулахад зориулж ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн “Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв”-өөр шууд ангижруулсан төмрийн технологийн туршилтыг хийлгэж эцсийн тайлан ирүүлсэн.
- Мини шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслийн хүрээнд жилд 100 мян.тн хүчин чадалтай “Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төслийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэс ҮТП” ХХК боловсруулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.11.28-ны өдрийн 01/1011 дугаар албан бичгээр төслийн шинжээч томилж, ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг УУХҮЯ-нд яаманд ирүүлсэн.

3.2.7.2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.

Биелэлт: “Бэрэн групп” ХХК нь 2014 оноос 200 мян.тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх домен зуух-хүчилтөрөгчийн конвертор-цахилгаан нуман зуух-шанаган зуух-тасралтгүй цутгах машин-цувих гэсэн тасралтгүй ажиллагаатай ган үйлдвэрлэлийн циклийг бий болгох зорилгоор Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж байгаа ба төслийн хэрэгжилт 70 орчим хувьтай байна.

Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар буюу нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Цаашид үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банканд гаргасан ба тус банкнаас боломжит хувилбарыг судалж байна.

“Бэрэн групп” ХХК болон түүний хамаарал бүхий компаниудын Хөгжлийн банкнаас авсан зээл, өрийн асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх хүсэлтийг Хөгжлийн Банкнаас 2022 оны 8 дугаар сард Хууль хяналтын байгууллагад хүргүүлсэн. Уг асуудлын хүрээнд шийдвэр гарч, барьцаа хөрөнгө өр, зээлийн асуудал шийдэгдэх хүртэл төслийн ажил зогсонги байдалд байна.

3.2.7.3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна.

Биелэлт: МДМУ ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил ковид-19 цар тахлын улмаас 2020 оноос 2021 оны 10 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн санхүүжилт толгой компани /“Монзол групп” ХХК/-ийн хөрөнгө оруулалтаар шийдэгдсэн. Цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж, 3.567 тэрбум төгрөгийн урьдчилгааг төхөөрөмж нийлүүлэгч компанид төлсөн боловч төлөвлөгөөний дагуу БНХАУ

/"Qianxi ADI Mechanical Casting" Co.Ltd компани/-д очиж газар дээр нь тоног төхөөрөмжийн сонголт хийн оруулж ирэх, мөн мэргэжилтэн оруулж ирэх асуудал хилийн хөл хорионы улмаас шийдэгдэхгүй байна. 2020 оноос хойш ковид-19 цар тахлын улмаас төслийн ажил зогссон. Цутгуурын цех, домен зуух, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмжийн захиалгын урьдчилгаа 3.567 тэрбум төгрөгийг үйлдвэрлэгч компанид төлж тоног төхөөрөмжийн татан авалтыг эхлүүлээд байна.

Үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмж (нийт 2.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий тус бүр нь 2 тн багтаамжтай 6 ш индукцийн зуух, дулаан боловсруулалтын 1 ш зуух дагалдах хэрэгслийн хамт)-ийн захиалга /БНХАУ "Qianxi ADI Mechanical Casting" Co.Ltd компанид/ хийгдсэн ба 2023 оны 10 дугаар сард татан авалт хийгдэж, угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэж байна. 2024 оны 3 дугаар сард угсралт дуусна.

Мөн 1.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 6 кВ-ын 1.2 км ЦДАШ-ыг барьж байгуулахаар бэлтгэл ажил /техникийн нөхцөл авсан/ хангагдсан ба 2024 оны 4 дүгээр сард угсралтын ажлыг дуусгахаар төлөвлөж байна.

3.2.7.4."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

Биелэлт: Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2020.12.15-ны өдөр, техник технологийн түвшний үнэлгээг 2020.09 сард, БОННУ-ий тайланг 2021.02.09-ний өдөр тус тус холбогдох мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021.07.01-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор тус паркийг байгуулах зорилгоор нийт 1,217.4 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжсэн. Үүний дагуу парк байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг УУХҮС-ын 2021.07.08-ны өдрийн 01/1764 дугаар албан бичгээр БХБЯ-нд хүргүүлээд байна. УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн боловсруулах үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу дэд бүтцийн нарийвчилсан зураг, төсөл боловсруулах, барьж байгуулах ажилд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт 136.0 тэрбум төгрөгийг төсөвлөснөөс 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 4.8 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд паркийн төмөр зам, авто зам, ус хангамж, ариутгах татуургын систем барих зураг төсөл боловсруулах, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах тендерийн сонгон шалгаруулалтыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас зохион байгуулан шалгарсан этгээдтэй гэрээ байгуулан ажлын эхлүүлээд байна.

3.2.7.5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.

Биелэлт: Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэрийн төслийг БНХАУ-ын China ENFI Engineering (ENFI) компанитай хамтран, үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэр барьж, туршилт хийх ажлыг БНХАУ-ын Шинжан Уйгарын өөртөө засах орны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн

“Xinxin Metals” компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил бүрэн дууссан, туршилтад ашиглах 500 тн. шигшсэн нүүрс бэлтгэн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр туршилтын үйлдвэрийн талбайд хүргүүлснээр үйлдвэрлэлийн туршилтын ажлыг эхлүүлсэн. Туршилтад ашиглаж байгаа нүүрсний физик шинж чанар болон цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалсан зарим нэг хүндрэл гарч байгаа хэдий ч туршилтын ажил үргэлжилж байна. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр (ЗБХБҮ)-ийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг шинэчлэн боловсруулж байгаа бөгөөд төсөвт өртөгт шаардлагатай өөрчлөлтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-өөр батлуулсан. ЗБХБҮ-ийн Байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. Техник, технологийн түвшний үнэлгээ хийх ажлын тендер зарлагдсан байна. Төслийн ажлын явцын зорилтот түвшинг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 2023 онд 7.6% байхаар төлөвлөсөн бөгөөд хүрсэн түвшин 4.7% байна.

ЗБХБҮ байгуулах төслийн нийт санхүүжилтийн гүйцэтгэл нийт дүнгээр 14,440.0 сая төгрөг буюу 0.89% байна. Үүнээс УХОХ-т тусгагдсан санхүүжилтийн 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэл 1.6% байна.

Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил болох автозам, төмөр зам барих, цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын ТЭЗҮ-ийг боловсруулж, тендер зарласан.

3.2.7.6. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.

Биелэлт: “SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээг “ЭҮ” ТӨҮГ болон “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-хооронд 2021.09.17-ны өдөр байгуулсан.

Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2023.04.04-ны өдөр хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын “Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай” 2023.04.21-ны өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авсан.

“SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-д гэрээний дагуу 2021.11.24-ний өдөр 30% буюу 732.38 сая төгрөг, ажлын хэсгийн хурлын шийдвэр болон тайлангийн явцын гүйцэтгэлээр 2023.05.31-ний өдөр 33.8% буюу 852.4 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд нийт 1,584.78 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд: байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажилд 142.5 сая төгрөг, техник технологийн түвшний үнэлгээ хийх ажилд 100 сая төгрөг, ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын үлдэгдэл төлбөрийг тус тус төлөвлөсөн.

Тус үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 63.8%, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын явц 30%. Тайланг 2024.04.26-ны хүлээн авахаар төлөвлөн гэрээ байгуулсан.

3.2.7.7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна.

Биелэлт: Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс алт ресурс” ХХК 2020-2021 онд олон улсын 20 гаруй компанитай холбоо тогтоож төсөл дээр санал авсан ба “түлхүүр гардуулах”

нөхцөлөөр 4 компани (Сымбат инженеринг, Шинхай групп, “Кронимет Майнинг, Зижин Майнинг) санал ирүүлсэн. “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий” ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн.

Дүгнэлтээр ТЭЗҮ нь Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн үндэслэлийг тооцоогүй, эдийн засгийн тооцоолол бүхэлдээ буруу хийгдэж алдаатай болсон, төслийг хэрэгжүүлэх эрсдэлтэй тул дахин шинээр хийх, “Сымбат инженеринг” ХХК-тай цаашид ажиллахгүй тохиолдолд төсөлд оролцохоор ирүүлсэн хамгийн сайнаар үнэлэгдэх санал болох БНХАУ-ын “Шинхай групп”-ийн саналтай дүйцэх саналыг хэрэгжүүлэх, Цэвэршүүлэх алт мөнгөний жилийн хүчин чадлыг Монголбанканд 1990 оноос хойш аж ахуй нэгж байгууллага, иргэдийн тушаасан алт мөнгөний хэмжээ, нөөц, уул уурхайн компаниудын хэтийн төлөв, ирээдүйд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөр, хэмжээ, нөөцийг харгалзан үзэж жилд 30 хүртэл тн алт, 50 хүртэл тн мөнгө цэвэршүүлэх, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтойгоор төлөвлөх, эдгээр хувилбаруудаас хамгийн боломжит хувилбар “Түлхүүр гардуулах” төсөл хэрэгжүүлэгчээр өөрөөр нь санхүүжих, 8-10 жилийн урт хугацааны гаднын банкны хөнгөлөлттэй зээлд хамрагдах хувилбарыг судлах зэрэг асуудал гарсан.

Бүгд Найрамдах Казахстан улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамнаас 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн Монголд алт цэвэршүүлэх үйлдвэр барихад Казахстаны болон гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулах асуудлын талаар Монголын талын байр суурийг ирүүлэхийг хүссэн 30-71 албан бичгийн хариуд УУХҮ-ийн Дэд сайдын 2023.02.17-ны өдрийн 02/475 албан бичгээр хариу хүргүүлсэн.

3.2.7.8. Үнэт металлын сорьцын хяналтын газрын сорьц тогтоох лаборатори байгуулж, үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл, ажиллагааг өргөжүүлж иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. /Салбар лаборатори байгуулна./

Биелэлт: Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 48 дугаар тушаалаар “Үнэт металлын сорьц тогтоох салбар лаборатори байгуулах” үүрэг бүхий ажлын хэсгийг СХЗГ, Монгол банк, УУХҮЯ, АМГТГ-ын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгээс салбар лабораторийг Зүүн бүсэд буюу Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэд байгуулахаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байранд тус лабораторийг байрлуулахаар 89.23 метр квадрат 3 өрөөг бэлтгэсэн.

Үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл, ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд дараах тоног төхөөрөмжийг холбогдох хуулийн дагуу худалдан авсан. Үүнд:

- Эрдэнийн чулууг тодорхойлох “Kern” брэндийн дижитал камер бүхий микроскоп, алмаз таних багаж;
- Алтны шинжилгээ хийх зориулалттай Купляцийн зуух 2 ширхэг, Сорьц дарах зориулалттай лазер төхөөрөмж 1 ширхэг;

Дээрх тоног төхөөрөмжийг ашигласнаар үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчид төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, ханшийн эрсдэлээс сэргийлж байна.

3.2.7.9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалын хамт УУХҮС-ын 2023.01.03-ны өдрийн 01/04 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023.01.11-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг татан буулгах, төслийн нэгжийн чиг үүрэг, холбогдох баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэхийг УУХҮС-д даалгасан. Уг тогтоолоор “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих” төслийн нэгжийг татан буулгасантай холбоотойгоор төслийн чиг үүрэг, баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэх Ажлын хэсгийг ТНБД-ын 2023.02.01-ний өдрийн А/08 дугаар тушаалаар байгуулж, зохион байгуулсан. Төсөлтэй холбоотой бүх баримт, материалыг 2023.03.30-ны өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-д хүлээлгэн өгсөн.

Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны зэсийн асуудал хариуцсан дэд хороо “Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр” байгуулах байршлын талаар хийсэн олон улсын судалгааны байгууллагуудын санал, дүгнэлт дээр үндэслэн анхны зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг Орхон аймгийн нутаг дэвсгэрт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах нь зүйтэй гэж үзсэн.

3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.

3.2.8.1.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө.

Биелэлт: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/36 тушаалаар Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайд орших Цэн тогоруу ордын газрын тосны нөөцийг баталгаат (1P) зэрэглэлээр 1,151,194.0 тонн (8.68 сая баррель), үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,932.0 тонн (1.04 сая баррель), баталгаат+магадлалтай (2P) зэрэглэлээр 3,051,724.0 тонн (23.01 сая баррель), баталгаат+магадлалтай+боломжтой (3P) зэрэглэлээр 5,385,942.0 тонн (40.61 сая баррель)-оор тус тус хүлээн авсан.

Цэн тогоруу ордыг газрын тосны ашиглалтын талбайд шилжүүлсэн. Зон Хэн Юу Тиан ХХК-ийн газрын тосны хайгуулын Галба XI талбайн Өлгий ордын нөөцийн тооцоо, баялгийн үнэлгээний тайланд дүгнэлт гаргуулахаар ЭБМЗ-өөс шинжээч томилон ажиллуулж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/294, 2023 оны А/43, А/198, А/247, А/248, А/249 дүгээр тушаалуудаар газрын тосны хайгуулын 15 талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Үүнээс 4 талбайд захиалгын материал ирүүлсэн. 3 талбайд ялагчийг тодруулан бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийн талаар хэлэлцээр хийн, эцэслэн тохиролцож Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

3.2.8.1.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно.

Биелэлт: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил гүйцэтгэх 9 (газрын тос 2, нүүрсний давхаргын метан хий 6, шатдаг занар 1) гэрээ хэрэгжиж байна. Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний үр дүнгээр 2020 оноос хойш 5 бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. 2 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах шатанд байна.

Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын ажил: 2020 онд Төхөм Х (урд) талбайд 625.9 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн. Номгон IX талбайд 105 тууш км 2 хэмжээст микросейсмийн судалгаа хийж, метан хийн хайгуулын 7 цооног өрөмдсөн. 2021 онд Номгон IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын

17 цооног 11,360.0 тууш.метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн. 2022 онд Газрын тосны хайгуулын 2 талбайд 1,050.9 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 6 талбайд нийт 527 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа, 37 цооног нийт 22,151.3 тууш.м өрөмдлөгийн ажил тус тус хийгдсэн. 2023 онд Газрын тосны хайгуулын 3 талбайд 3 цооног нийт 4,991 тууш.м өрөмдлөг, 547.5 км² талбайд нийт 2,436 км 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, 1 талбайд нөөц бодох ажил хийгдэж байна. Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 5 талбайд 28 цооног нийт 10,784.73 тууш.м өрөмдлөг, 260 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 3 талбайд туршилтын олборлолтын ажил хийгдэж байна.

3.2.8.1.3.Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 57 дугаар тогтоолоор нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Богд IV, Онги V, Т1 талбайд Петровис ресурс ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус 3 талбайд 10 жилийн хугацаанд 30 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 435 дугаар тогтоолын дагуу 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр газрын тосны хайгуулын Тариач XV талбайд Чайна голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайд 3 жилийн хугацаанд 12,4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн.

Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 143 дугаар тогтоолоор нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Тавантолгой ХХХIII талбайд Эрдэнэс метан ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайд 10 жилийн хугацаанд 25 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 203 дугаар тогтоолоор нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Гурвантэс ХХХV талбайд Тэлмэн ресурс ХХК-тай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайд 10 жилийн хугацаанд 8.9 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. 2020 оноос хойш Газрын тосны хайгуулын 1, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 5 талбайд нийт 6 бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Тус талбайнуудад нийт 76.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

3.2.8.1.4.Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Матад ХХ талбайн газрын тосны нөөцийг бүртгэж авснаар газрын тосны баталгаат нөөц 338.78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43.38 сая тн болсон. Баталгаат нөөц 1 сая тн-р нэмэгдсэн.

Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт орших “Петро Матад” ХХК-ийн газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Матад-ХХ талбайн 213.93 км² газрыг газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 265 тоот тогтоол гаргуулсан. Уг тогтоолын 2 дэх заалтыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд АМГТГ-ын даргын тушаалаар Улсын тусгай хэрэгцээний талбайтай давхцал бүхий иргэдийн газрыг чөлөөлөх, газрын нөхөх олговрыг тохиролцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан газар дээр 2 удаа очиж айл өрхтэй уулзалт зохион байгуулж газар чөлөөлөх гэрээ байгуулж, нөхөх олговрын хэмжээг тохиролцоод байна. Газрын тосны хайгуулын Галба XI талбайн Өлгий ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд дүгнэлт гарган ЭБМЗ-д хүргүүлсэн.

3.2.8.1.5.Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар энэ онд 812 мянган тонн газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт 183.2 тэрбум төгрөг төвлөрүүлэх даалгавартайгаас 2021.01.01-2021.12.01-ний хооронд нийт 628,854 тонн газрын тос олборлож, 590,878 тонн түүхий тос БНХАУ-д экспортлоод байна. Газрын тосны орлогоос 2021.11.30-ны өдрийн байдлаар 180.5 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.

Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022.05.24-ний өдрийн 03 тоот тогтоол гарсан. Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар Ерөнхий сайдын 2022.05.19-ний өдрийн 78 дугаар захирамж гарч Ажлын хэсгийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулан ажиллаж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2023.05.17-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж 21 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Монгол Улсын хэмжээнд 2023 онд 6,500,000 баррель буюу 883,796 тонн газрын тос олборлож экспортлохоос 2023 оны 12 дүгээр сарын 13-ний өдрийн байдлаар нийт 4,667,599 баррель буюу 633,751 тонн газрын тос олборлож, 4,505,930 баррель буюу 612,842 тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. 2023 онд газрын тосны экспортоос улсын төсөвт 424.9 тэрбум төгрөг оруулах төлөвлөгөөтэйгөөс 2023 оны 12 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар Газрын тосны экспортын орлогоос Улсын төсөвт 281.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

3.2.8.2.1.Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Биелэлт: Засгийн газрын 2020.01.06-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тэмдэглэлээр Монгол-газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. 2020.02.19-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, худалдан авалтыг зохион байгуулах, бүтээн байгуулалтыг зохион байгуулахыг Сангийн сайд, УУХҮС нарт тус тус даалгасан.

Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардагдах дотоодын түүхий тос дамжуулах 530 км хоолой барих төслийг санхүүжүүлэх, гүйцэтгэгчийг урьдчилан сонгон шалгаруулах урилгыг олон улсад нэр хүнд бүхий Pipeline and Gas Journal сэтгүүлд 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдөр нийтлүүлж, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдөр хүртэл хүлээн авсан.

Түүхий тос дамжуулах хоолой санхүүжилт шийдэгдэж, гүйцэтгэгчээр БНХАУ-ын Норико интернэйшнл кооперэйшн компани шалгарч зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажил эхлүүлсэн.

УУХҮЯ-ны ТНБД-ын 2021 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг олон улсын сонгон шалгаруулалтыг явуулж БНХАУ-ын Норинко интернейшнл компанийг шалгаруулсан. Шалгарсан компанитай гэрээ байгуулах талаар ЗГ-ын 2022.03.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл, 94 дүгээр тогтоолыг тус тус гаргуулж, хоолойн байгууламж барихад

шаардагдах санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу Төслийн захиалагч Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төслийн санхүүжүүлэгч “ЭТТ” ХК, төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит Норинко компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр Хамтран ажиллах гэрээг, “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.21-ний өдөр дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (ЕРС) гэрээ, “МГТБҮ” ТӨХХК болон “ЭТТ” ХК-ийн хооронд 2022.04.22-ны өдөр дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээг, “ЭТТ” ХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.22-ны өдөр нүүрс худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулсан.

3.2.8.2.2. Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Дорноговь аймгийн Алтанширээ сумд баригдаж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын нэг болох дамжуулах хоолойн барилгын ажил гүйцэтгэгчийг санхүүжилтийн асуудлаа давхар хариуцан, ажлын төлбөрийг дараа төлөх нөхцөлтэйгөөр олон улсын нээлттэй тендер шалгаруулалт зарлах саналыг Сангийн яамны зүгээс 2021 онд албан бичгийг УУХҮЯ-д хүргүүлсэн. Түүнчлэн төслийн санхүүжилтэд төслийн гүйцэтгэгч, хөрөнгө оруулагчдаас тавьж буй Засгийн газрын баталгааны төрөл, нөхцөл, шаардлагуудыг тодруулах талаар албан бичгийг мөн хүргүүлсэн. УУХҮЯ-ны зүгээс газрын тос дамжуулах хоолойн төслийн ажил гүйцэтгэгчийг санхүүжилтийн асуудлаа давхар хариуцан, ажлын төлбөрийг дараа төлөх нөхцөлтэйгөөр олон улсын нээлттэй тендер шалгаруулалт зарласан.

Трассын дагуух зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах зорилгоор холбогдох орон нутгийн төрийн байгууллагуудад албан бичиг хүргүүлж, дамжуулах хоолойн трассыг хээрийн судалгааны ажлын үр дүнд эцэслэн тодорхойлж, байршлын солбицлуудын мэдээллийг хүргүүлж, зурвасын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авахаар ажиллаж байна

Дамжуулах хоолойн трассын дагуух газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг 2023 оны 5-р сарын 24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахаар шаардлагатай саналыг боловсруулж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Төрийн нууцын “Маш нууц” зэрэглэлээр ирсэн материалын нууцын зэрэглэлийн талаарх тодруулгыг Тагнуулын ерөнхий газраас авч, дээрх нууцын зэрэглэл өөрчилсөн асуудлыг шийдвэрлэсний дараа дамжуулах хоолойн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлуулсан.

3.2.8.2.3. Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна.

Биелэлт: УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.25-ны өдрийн А/08 тушаалаар төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулж ажилласан ба 2021.10.23-ны өдөр тендерийг нээж техникийн болон санхүүгийн саналыг үнэлэн гүйцэтгэх компанийг шалгаруулж компанитай байгуулах гэрээний нөхцөл, гэрээний төслийг боловсруулсан. Шалгаруулалтыг ЕРС+F буюу санхүүжүүлж барьж байгуулах нөхцөлөөр явуулсан тул ТЭЗҮ боловсруулж хүлээн авах шаардлагагүй болсон.

Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан “Улсын тусгай хэрэгцээ”-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн

шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан.

Төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл 70.0 хувь, худалдан авалт 35.5 хувь, барилга угсралт 38.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил 100 хувь, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил 100 хувь, геотехникийн судалгааны ажил 95 хувь, Техникийн зураг төслийн ажил 90 хувь, БОННУ хийх ажил 100 хувь, төслийн талбайд нийт 19,220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15,250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй байна. Мөн Үндсэн түр кемп 100 хувь, Толгой станцын түр кемп 77 хувь, Халаах, өргөх станц 1 түр кемп 79 хувь, Халаах, өргөх станц 2 түр кемп 100 хувь, Халаах, өргөх станц 3 түр кемп 78 хувь, Халаах, өргөх станц 4 түр кемп 93 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

3.2.8.3.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.

Биелэлт: Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын ерөнхий гүйцэтгэгч Жэй Эм Си Прожектс лимитед компани 2020.01.15-ны өдөр үйлдвэрийн талбайн ажлыг эхлүүлсэн. Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98.6 хувьтай байна. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /EPC-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0.79 хувьтай байна. Үйлдвэрийн цахилгаан станц /EPC-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1.32 хувьтай байна. Лицензтэй технологийн байгууламж /EPC-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023.09.29-ний өдөр МГТБҮ ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11 хувьтай байна.

3.2.8.3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Мөн хуулийн 3.3 дахь хэсэгт заасан Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газрын 2021.08.11-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор батлуулсан.

3.2.8.3.3. Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэг бүхий Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2021 оны 122, 133 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Шадар сайдын 2021 оны 87 дугаар тушаалаар Ажлын хэсгийн төлөвлөгөө, Шадар сайдын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/21 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах

арга хэмжээг авч ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам, газрын тосны хайгуулын Давст ХХХИ талбайг үйлдвэрт олгох асуудлыг тус тус батлуулсан. БНХАУ-ын Тяньжин боомтод саатсан барилгын материалыг татан авах талаар ГХЯ, ЗТХЯ, БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, МГТБҮ ТӨХХК, Энэтхэгийн JMC компанитай хамтран ажиллав. Үйлдвэрийн технологийн бус барилгын ажил /EPC-1/-д шаардлагатай 4000 тонн бараа материал 2021.12.24-ний өдөр БНХАУ-ын Тяньжин боомтод ирж ачааг боомтын талбайд бүрэн буулгасан бөгөөд ачааг Эрээн боомт хүртэл тээвэрлэн авч ирэх ажлыг зохион байгуулж байна. Мөн бүтээн байгуулалтын явцын талаар УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021.10.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 04 дүгээр тогоол гарсан.

Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ний өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан.

3.2.8.3.4. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Монгол Улсын хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар оны эхнээс өссөн дүнгээр нийт 2.3 сая.тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэн бөгөөд үүнд 90-ээс доош октантай автобензин 21.0 мян.тонн, 90-ээс дээш октантай автобензин 677.8 мян.тонн, дизель түлш 1.2 сая тонн, шатдаг хий 42.5 мян.тонн, ТС-1 агаарын хөлгийн түлш 57.7 мян.тонн, бусад 244.5 мян.тонн байна. Өнгөрсөн үеийн мөн үетэй харьцуулбал нийт бүтээгдэхүүний импорт 400.0 мян.тонн буюу 17 хувиар нэмэгдэж, төлөвлөсөн хэмжээнд хүрсэн байна. Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд ОХУ-аас гадна БНХАУ-ын “Петрочайна Интернэйшнл” компанитай зарим аж ахуйн нэгж бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулсан бөгөөд Гашуунсухайт болон Шивээхүрэн, Ханги зэрэг боомтуудаар газрын тосны бүтээгдэхүүн импортлох бэлтгэл ажил зохих түвшинд хангагдаж, улмаар БНХАУ-аас импортолж буй бүтээгдэхүүний хэмжээ 7 хувь болж нэмэгдсэн. 2023.12.09-ний өдрийн байдлаар А-80 12 хоног, Аи-92 автобензин 19 хоног, Аи-95 автобензин 11 хоног, ДТ 18 хоног, ТС-1 агаарын хөлгийн түлш 24 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл нөөцтэй байна.

3.2.8.3.5. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: 2023 оны байдлаар нийт 2,187,065 тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,912,740 тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангиллын шатахуун 198,365 тонныг импортолсон байна.

3.2.8.3.6. Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний

үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0 га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Гадаад талд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч компани ТЭЗҮ-д шаардлагатай зарим тодотголыг хийж байна. Уг төслийн санхүүжилт тодорхойгүй шалтгаанаар саатсан ба төсөл хэрэгжүүлэгч компани мэдээ ирүүлээд байна.

3.2.8.3.7.Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна.

Биелэлт: ЗГХЭГ-ын дарга болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2021.02.26-ны өдрийн 16-А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэг ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит “Эрчис Ойл” ХХК, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, “Эрдэнэс метан” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Мөн Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2021 оны 03 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн.

3.2.9.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг Баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ.

3.2.9.1.Ирээдүйн санд орлого төвлөрүүлж, хуримтлалыг оновчтой удирдан арвижуулж, эрдэс баялгийн өгөөжийг өнөө ба хойч үеийн иргэдэд тэгш хүртээнэ.

Биелэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн байгалийн баялгийн үр өгөөжөөс иргэн бүрд тэгш хүртээх боломжийг олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнд ногдох хувь хэмжээг нэмэгдүүлж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 34 хувийг Монгол Улсын иргэн бүрд эзэмшүүлэх, 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн иргэд, ирээдүйд төрөх хүүхдүүд болон Монгол Улсын харьяатад орсон иргэдэд хэрхэн хувьцаа эзэмшүүлэх асуудлыг нэг мөр зохицуулах шаардлагын дагуу Улсын Их Хуралд 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат

компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхээр дэмжигдсэн.

3.2.9.2. Ирээдүйн өв сангийн тухай хуультай уялдуулан хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барина.

Биелэлт: Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан хуримтлалын сан бий болгох болон Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагын дагуу “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, түүнийг дагалдуулж боловсруулсан Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хүргүүлсэн. “Эрдэнэс Монгол” нэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолоор Үндэсний баялгийн сан байгуулах бэлтгэл хангах зорилгоор “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд охин, хараат компани, харьяа хуулийн этгээдийг нүүрс, эрчим хүчний болон зэс, металлын гэсэн үйл ажиллагааны чиглэлээр бүлэглэж, группийн зарчмаар ажиллуулахаар шийдвэрлэсний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар холбогдох талуудыг оролцуулсан Ажлын хэсэг байгуулж, “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн бүтэц, үйл ажиллагааг оновчтой болгох болон Үндэсний баялгийн сангийн тухай, Хөгжлийн сангийн тухай хуулийн төслүүдтэй уялдуулах асуудлыг нарийвчлан судалж, Засгийн газрын холбогдох гишүүдэд санал танилцуулж, шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд хүргүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр буцаан татан авч, дээрх хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 192 дугаар захирамжаар байгуулсан. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

3.3.1.1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, механикжилтын түвшинг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Бүгд найрамдах Беларусь улсын Засгийн газрын 4.5 сая еврогийн зээлээр ногоон тэжээлийн 60, төмсний 35, хүнсний ногооны 20 иж бүрдэл, нийт 534 нэгж техник нийлүүлж, Сангийн яамтай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. ХХААХҮС-ын 2021 оны А-238 дугаар тушаалаар тариаланчдад 30 хувийн урьдчилгаа төлбөртэй, жилийн 1.37% хүүтэй зээлээр олгох гэрээ байгуулан худалдан борлуулсан. Үр тарианы техник шинэчлэх

хүрээнд Хаан банк өөрийн хөрөнгөөс 30 тэрбум төгрөгийн лизингээр ОХУ-аас техник нийлүүлдэг 6 дилер аж ахуйтай хамтран ажиллаж, 54 комбайн, 35 хаман боогч тариаланчдад нийлүүлсэн. Архангай, Хөвсгөл аймагт Шинэ хөдөө төслөөр хадлан тэжээл бэлтгэх 20 иж бүрдэл техник нийлүүлсэн. ХААДС-аас Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, механикжилтын түвшинг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд ОХУ болон БНХАУ-аас нийлүүлэгдсэн хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг үлдэгдлээс нийт 86 ширхэг буюу 4.5 тэрбум төгрөгийн зүтгэх хүчний техник, тоног төхөөрөмжийг ААН, иргэдэд санхүүгийн түрээсийн гэрээ болон шууд худалдан авалтаар худалдан борлуулаад байна.

Газар тариалангийн трактор, комбайн, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлдэг дилер 12 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2022 онд 4.5 тэрбум төгрөгөөр 44 ш комбайн, 12ш трактор нийлүүлсэн. Тариалалтын үеийн парк ашиглалт 85 хувь, ургац хураалтын үеийн парк ашиглалт 80 хувьтайгаар ажлыг бүрэн зохион байгуулсан. “Агромаштех” ХХК, “МБМ инжиниринг” ХХК, “Агротрак” ХХК, Техник Хаус” ХХК зэрэг дилер аж ахуйн нэгжүүд дээрх техникүүдийг нийлүүлсэн. “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл Улсын хэмжээнд (ТШ-2022-УТ-01-улсын хэмжээнд тендер) Багц-3 Хүнсний ногооны иж бүрдэл нийлүүлэх 220708/05-383 дугаартай гэрээгээр “Мөнх ногоон тал” ХХК 35-40 морины хүчтэй трактор 4 ширхэг, 35-40 морины хүчтэй тракторт угсрах хүнсний ногооны үрлүүр 4 ширхэг, Роторт сийрүүлүүр 4 ширхгийг улсын төсвийн 195.3 сая төгрөгөөр нийлүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 143 дугаар тогтоолын дагуу импортын шинэ трактор, комбайн, техникийг НӨАТ-аас 2025.01.01 хүртэл чөлөөлөх хөнгөлөлтийн дагуу дилер аж ахуйн нэгжүүд 66 ш комбайн, 69 ш трактор, бусад техник 143 ш нийлүүлсэн. Хувийн хэвшил 30.0 тэрбум төгрөг, улсын төсөв 195 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үр тарианы техникийн шинэчлэлийг хийхэд Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр 110 ААН, иргэнд 37.2 тэрбум төгрөгийн зээл олгосон. 500.0 сая төгрөгөөс дээш зээл авсан 27 ААН, иргэнтэй хяналтын гэрээ байгуулсан. “Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлж 6.1 тэрбум төгрөгөөр трактор 55 ширхэг, төмс, хүнсний ногооны зориулалттай бусад техник, тоног төхөөрөмж 62 ширхгийг худалдан авсан 95 аж ахуйн нэгж, иргэнд 3.0 тэрбум төгрөгийн үнийн хөнгөлөлт олгосон. 880 га төмс, хүнсний ногооны ажлыг механикжуулах боломжийг бүрдүүлж, бүтээмжийг нэмэгдүүлсэн.

3.3.1.2.Баруун, зүүн бүсэд улаанбуудайн элеватор байгуулах замаар газар тариалангийн үр ашгийг сайжруулна.

Биелэлт: Увс аймгийн Баруунтуруун сум, Дорнод аймгийн Хэрлэн суманд тус бүр 10.0 мянган тонн хүчин чадалтай үр тариа хадгалах элеваторыг байгуулахаар төлөвлөж, 2021 оноос элеваторын зураг төсөл, төсөв, барилгын талбайн инженер геологийн судалгааны дүгнэлтийг хийлгэсэн. 2022 онд Тэмээн ХХК-тай (Увс аймгийн Баруунтуруун сум) 221108/05-653, (Дорнод аймгийн Хэрлэн сум) 220923/05-558 дугаар бүхий гэрээг байгуулан гэрээний ажлын иж бүрэн зураг төслийг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүрэн дуусгаж, Барилгын хөгжлийн төвөөр дүгнэлт гаргуулан хүлээлгэн өгсөн. Улмаар 2023 онд Тэмээн ХХК-тай (Увс аймгийн Баруунтуруун сум) 231208/05-810, (Дорнод аймгийн Хэрлэн сум) 231208/05-811 дугаар бүхий гэрээг байгуулан элеваторын барилгын суурийн ажлыг 2024 оны 10 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

3.3.1.3.Хөрсний үржил шимийг сайжруулах, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно.

Биелэлт: 2021 онд Монгол Улсад хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах бордооны тоо хэмжээг тооцож, БОАЖС, ЭМС, ХХААХҮС-ын хамтарсан тушаалаар батлуулсан. Мөн 2021 онд ХААДС-аар дамжуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох бордоо, бодисын нэр төрлийг гаргаж ХААДС-д хүргүүлсний дагуу батлагдсан 500.0 сая төгрөгийн төсөвт багтаан 2021 онд нийлмэл бордоо 215 тн, гумины бордоо 25 тн, уринш боловсруулах бодис 56 тн, тариалалтын үеийн хог ургамалтай тэмцэх бодис 8,860 тн, таримлын болц түргэтгэх буюу хог ургамалтай тэмцэх бодис 4,350 тн-ыг нийлүүлэх, тэдгээрийг тариаланчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлыг зохион байгуулсан. Ургамал хамгаалах бодис, бордоо авах хүсэлт гаргасан давхардсан тоогоор 149 тариаланч, аж ахуй нэгж, иргэнд 215 тонн бордоо, 75.2 мянган литр ургамал хамгаалах бодисыг хөнгөлөлттэй үнээр болон зээлээр олгосон. Мөн импортлогч аж ахуйн нэгжүүд өөрсдийн хөрөнгөөр 6,311 тн нийлмэл бордоо импортолсон бол дотоодын бордооны үйлдвэр 10,080 тн бордоо үйлдвэрлэсэн байна. Импортын болон дотоодын нийт 16,631 тн бордоогоор 126,964 га талбай буюу нийт талбайн 29.9 хувийг бордож, 2021 онд үр тариа өнгөрсөн оноос 173.4 мян.тн, тэжээл 130.0 мян.тн, тосны ургамал 132.3 мян.тн, хүнсний ногоо 3.6 мян.тн-оор тус тус нэмэгдсэн байна. Энэ нь 2020 оны ургацтай харьцуулахад 37.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2022 оны тариалалтад зориулан ХААДС-тай хамтран хөрсний үржил шимийг сайжруулах нийлмэл болон гумины бордоо худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү худалдан авах ажиллагааны хүрээнд 78 тн гумины бордоог "Бүтлийн ундарга" ХХК, "Хийрэв" ХХК-аас тус тус нийлүүлснийг салбараар дамжуулан тариаланчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.6.2, "Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 63 дугаар тогтоол, "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2023 оны 147 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны "Татаас олгох тухай" А/236 дугаар тушаалын дагуу "Хөрсний үржил шимийг сайжруулж, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо хэрэглэсэн иргэн, хуулийн этгээдэд татаас олгох баримт бичиг"-ийг баталж, Тариалан үйлдвэрлэлийн нэгдсэн plant.mofa.gov.mn цахим системийн дэмжлэг бордоо цэсээр 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл материалыг хүлээн авч, хяналт үнэлгээ хийсэн. Plant.mofa.gov.mn, Support.mofa.gov.mn uramshuulal.gov.mn цахим системүүдээр материалуудыг хянаж, ажлын хэсгийн 8, газрын 1 удаагийн хурлаар хэлэлцүүлж, үнийн хөнгөлөлт үзүүлэх хувийг тогтоолоо.

3.3.1.4.Энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

Биелэлт: БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд нийт 2,575 га талбайг услах хүчин чадал бүхий 27 усалгааны тоног төхөөрөмж, 12,154м усалгааны хоолойг 10 аж ахуйн нэгж, 4 иргэнд 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр 6 жилийн хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй зээлээр ХААДС-аар дамжуулан олгож 2,575 га талбайн усалгааны системийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хүрээнд инженерийн болон энгийн хийцтэй услалтын систем барьж 2023 онд усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 62.4 мянган га талбайд хүрээд байна. Мөн тариалангийн талбайн усан хангамжийг сайжруулах, зорилгоор АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд 4.7 мянган га талбайн услах хүчин чадал бүхий услалтын систем шинээр барих, шинэчлэн сэргээн засварлах барилгын ажил гүйцэтгүүлж

байна. “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд сэргээн засварлаж, шинэчлэх 10 услалтын системийг барьж байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллав. Ажлын гүйцэтгэл Боомын ам 79%, Хүрэн тал 45%, Дулааны тал 73%, Цахир 91%, Ёлтон 87.5%, Ногоон хашаа 42.5%, Цул улаан 79%, Улаандэл 83%, Ивэн гол 95%, Сөгнөгөр 91 хувьтай тус тус явагдаж байна. Мөн улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгөөр 600 га талбай услах хүчин чадал бүхий Увс аймгийн Улаангом сумын "Арсай услалтын систем", Улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгөөр 700 га талбай услах хүчин чадал бүхий Булган аймгийн Баяннуур сумын "Борбулан" услалтын системийн барилгын ажлыг тус тус гүйцэтгэж 2024 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Дээрх услалтын системүүд ашиглалт оруулснаар усалгаатай ашиглах тариалангийн талбайн 68.0 мянган га талбайд хүрэх боломж бүрдэнэ.

Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хүрээнд инженерийн болон энгийн хийцтэй услалтын систем барьж 2023 онд усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 62.4 мянган га талбайд хүрсэн байна.

3.3.1.5.Өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйнууд байгуулж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортыг бууруулна.

Биелэлт: Засгийн газрын 2023 оны “Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны “Жагсаалт батлах тухай” А/140 дүгээр тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, банкнууд хооронд байгуулсан “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын 230330/07-217 дугаар санхүүжилтийн гэрээ”, тус гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах 230502/07-280 дугаар гэрээний нэгдүгээр хавсралтын 3.5.2-д заасан хүлэмжийн аж ахуй байгуулах хөрөнгө оруулалтын жилийн 6 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай 50.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр бий болгож Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх, зээлийн хүүгийн татаас олгоход 18 иргэн аж ахуй нэгжид 10.9 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. XVIII.3.3 "Орон нутгийн хөгжлийг дэмжих шинэ хөдөө төсөл" /Баянхонгор, Булган, Говь-сүмбэр, Дархан-уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Ховд, хөвсгөл/ төслийн хүрээнд Сэлэнгэ, Орхон, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Улаанбаатар, Баянзүрх дүүрэгт нийт 2.69 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 645 иж бүрдэл 39024 м2 нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулж Төрийн нарийн бичгийн даргын 6 тушаал гарган хүлэмж нийлүүлэх 6 тусдаа гэрээ байгуулав. Дорноговь, Баянхонгор аймагт хүлэмжүүдийг нийлүүлж, гэрээг дүгнэж, жилийн гүйцэтгэлээр нийт 16.0 га талбайн хүлэмж шинээр байгуулагдаад байна.

3.3.1.6.Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулна

Биелэлт: Импортын үр 1512.32 тн үрийг 29 иргэн аж ахуй нэгжид 936.06 тн 1,404,090,000 төгрөгийн үнэ бүхий улаан буудайг 30% урьдчилгаа нөхцөлтэй 506,428,500 төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлэн нийт 897,661,500.00 төгрөгийн дэмжлэг олгоод байна. 2023 оны Хаврын тариалалтыг үр дүнтэй зохион байгуулах улаан буудайн үрийн шинэчлэл хийх зорилгоор ОХУ-ын Барнаул хотоос эрт, дундын болцтой 5 төрлийн сортын 5251,85 тонн элит үр импортоор оруулж ирэн 187 тариаланч иргэн, ААН-д зээлээр олгож үрийн шинэчлэл хийж ажилласан.

3.3.1.7. Тариалангийн талбайн хог ургамал, хортон шавж, ургамлын өвчин, мэрэгч гэх мэт хөнөөлт организмын тархалтын судалгаа хийх, Ургамал хамгааллын цогц арга хэмжээг

хэрэгжүүлнэ.

Биелэлт: "Тариалангийн талбайн хөнөөлт организмын тандалт тархалтын судалгаа хийх" зөвлөх үйлчилгээний ажил 8 сарын 30-нд дууссан талаар албан тоотоор мэдээллийг ирүүлсэн ба зөвлөх үйлчилгээний тайланг 2 удаагийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж, ажил хүлээлцэх, ажлын хэсгийн 2023/05, 2023/06 дугаар тэмдэглэл, тайланг хүлээж авах ХХААХҮЯ/ГТ/ХУХҮСХ/07 дугаар акт, Гэрээний Т-231128/05-524. 2. УХЭШХ-ээс 2014-2023 оны хооронд Ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн чиглэлээр 4 чиглэлийн 28 стандарт батлуулсаны 2021-2022 онд 10 стандартыг батлуулсан байна. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй "Хүнсний аюулгүй байдал, ургамлын эрүүл мэндийг хамгаалах системийг сайжруулах" TCP/MON/ 3902 техник хамтын ажиллагааны төсөлтэй хамтран Сэлэнгэ, Дорноговь, Ховд, Баян-өлгий, Увс аймгийн гаалийн газар, Хилийн боомтуудад томилолтоор ажиллаж Ургамал хамгааллын олон улсын конвенцийн хүрээнд мөрдөж байгаа 47 стандартаас Монгол оронд нэн шаардлагатай 15 стандартын жагсаалтыг гаргаж, нутагшуулах, орчуулгын ажил хийгдэв. 3. Ургамлын дисикаци хийх(болц түргэтгэх) туршилт судалгааны ажлыг Глифосат, Дикват зэрэг гербицид дээр хийж, зөвлөмж гаргасан.

3.3.1.8.Газар тариалангийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлнэ.

Биелэлт: НҮБХХААБ, Монгол ногоо төслийн багтай хамтран "Хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэнийг баталгаажуулах" талаар холбогдох байгууллагуудын хэлэлцүүлэг уулзалтыг 1 удаа, ХААЗД -ыг баталгаажуулах аудиторын сургалтыг зохион байгуулсан. Мөн АНУ-ын BEST хөтөлбөртэй хамтарч тариаланчидын холбоонуудыг мэргэжлийн чиглэлээр баталгаажуулалт хийх сургалтанд хамруулах тэдгээрт баталгаажуулах эрх авахад нь дэмжлэг үзүүлэхээр хамтран ажиллах төлөвлөгөө хөтөлбөр батлууллаа. 2023 онд баталгаажуулах эрх бүхий 2 байгууллагаар жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, хамгаалалттай хөрсний тариалан эрхэлдэг нийт 16 аж ахуйн нэгжид ХААЗД нэвтрүүлсэн баталгаажуулалт олгох 2019 оноос хойш зохистой дадал нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн мэдээллийг QR кодоор уншдаг болгосон. Зохистой дадлын гэрчилгээтэй аж ахуй нэгжийн тоо 2023 онд 1.5 дахин өсч, сургалтад хамрагдсан ногоочдын 8.0% орчимд зохистой дадал нэвтрүүлсэн.

3.3.1.9.Чацарганын өрсөлдөх чадварыг сайжруулан экспортыг нэмэгдүүлэх, бусад жимс, жимсгэнийн таримал, сортуудыг турших, нутагшуулах, тариалах арга технологи боловсруулах, суулгац үржүүлгийн газруудыг орон нутагт байгуулна.

Биелэлт: Говь-Алтай аймагт 2020 онд байгуулсан Бигэр сум дахь суулгац үржүүлгийн талбайд торниун алим, бэсрэг алим, бөөрөлзгөнө, үхрийн нүд, чацарганын 3,395 ширхэг суулгац шинээр тариалж, үржүүлгийн газрыг 1.8 га-гаар өргөжүүлэв. Тус аймаг "Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэж орон нутгийг хөгжүүлэх сангийн 541.5 сая төгрөгийн санхүүжилтээр 2,650 ш торниун алим, 4,450 ш бэсрэг алим, чавганы 3,650 ш, бөөрөлзгөнийн 2,100 ш, интоорын 100 ш, үхрийн нүдний 17,500 ш, чацарганын 17,500 ш нийт суулгацыг нийлүүлж тариалалтыг нэмэгдүүлээд байна.

Япон улсын Жайка ОУБ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах төслийн хүрээнд "Чацарганын нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх, гадаад зах зээл маркетингийг сайжруулах" туршилтын төслийг 2021 оноос хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол чацарганын шинж чанарыг судлуулахаар Увс хүнс ХХК, Хаан жимс ХХК, Шар доктор ХХК, Тэсо ХХК, Эко эрдэнэ ХХК гэсэн 5 боловсруулах үйлдвэрийн чацарганын цэвэр шүүс, өтгөрүүлсэн шүүс, чанамал, нунтаг зэрэг 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дээжийг Герман

улсад 10 сард явуулж нарийвчилсан шинжилгээ хийлгэсэн. Чацарганын кластерийн хамтын ажиллагааны хүрээнд 2021.10.1-нд Увсын чацарганыг Европын холбоонд “Газар зүйн заалт”-аар бүртгэсэн бөгөөд 2022.01.01-ээс албан ёсоор баталгаажуулах ба экспорт нэмэгдэх боломж бүрдэж байна. 2022 оны 04 сарын 14-ний өдөр “Жимс жимсгэнэ тариаланчдын улсын зөвлөгөөн”-ийг Улаанбаатар хотод зохион байгуулж нийт 22 аймаг, нийслэлийн 150 гаруй төлөөлөгчид оролцуулсан ба Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд жимс жимсгэнийн салбарын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож 16 зүйл заалт бүхий цаашид хэрэгжүүлэх ажлын зөвлөмж боловсруулж гаргав.

Мөн Япон улсын Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах” төслийн 60.0 сая төгрөгийн санхүүжилтээр Төв аймгийн Борнуур суманд жимс жимсгэнийн судалгаа, суулгац үржүүлгийн загвар төв байгуулав. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд суулгац үржүүлгийн төв байгуулах” ТШ/2022/суулгац төв тендер шалгаруулалт зохион байгуулж Төв аймгийн Борнуур сум дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв болон Говьсүмбэр аймгийн ХХААГ-т тус бүр 3 га талбай, ойн зурвас бүхий суулгац үржүүлгийн төв байгуулж 8 төрлийн жимсний 3000 гаруй ширхэг эх модны суулгац тариалж нутагшсан, чанарын баталгааны бүхий дотоодын суулгац үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв.

3.3.1.10.Тариалангийн талбайн хөрсний үржил шим, төлөв байдлын мониторинг хийх, хөрсний үржил шимийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхдээ хөрсний хэв шинжээс хамааруулж Баруун бүсийн (Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий) 6 аймгийн 45 суманд 108 цэг, Говийн бүсийн (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгууд) 4 аймгийн 13 суманд 42 цэг, нийт 150 цэгийг байгуулсан бөгөөд хөрсний төлөв байдал хэв шинж, талбайн байршил, ашиглалт, гадаргын хэлбэршил, цаг уурын нөхцөл зэргийг мэдээллийн үндэс болгон ажлыг гүйцэтгэсэн.

2023 онд үр тариаг 326.3 мянган га талбайгаас 456.4 мянган тн ургац хураан авч нэгжийн ургац 14.0 цн хүрсэн.

3.3.2.Газар тариалан, хөдөө аж ахуйн төв Дархан, Сэлэнгэ бүс нутагт агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

3.3.2.1.Сэлэнгэ аймгийн Сант суман дахь Хөдөө аж ахуйн сургалт үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн хөгжүүлж, газар тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх малчид, тариаланчдыг сургах, давтан сургах, залуу тариаланч, малчдыг бэлтгэх “Илгээлтийн эзэн” аяныг өрнүүлнэ.

Биелэлт: ХААИС, Сэлэнгэ аймгийн Сант суманд байрлах МСҮТ-ийн барилга байгууламжийг ашиглан “Хөдөө аж ахуйн инновац, технологийн парк байгуулах” ТЭЗҮ-ийг боловсруулсан. Тухайн ТЭЗҮ-ийг үндэслэн барилга байгууламжийг сэргээн засварлах шинээр барих зураг төсөл төсөв зохиох, батлуулах ажлыг ХААИС мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

“Илгээлтийн эзэн аян”-ыг Сэлэнгэ аймгийн Сант суман дахь Хөдөө аж ахуйн сургалт үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн хөгжүүлж, газар тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх малчид, тариаланчдыг сургах, давтан сургах, залуу тариаланч, малчдыг бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар ХААИС-тай хамтран сургалтын хөтөлбөр, ажлын төлөвлөгөө боловсруулаад байна.

3.3.3.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

3.3.3.1.Махны нөөц бүрдүүлнэ.

Биелэлт: 2020 онд: ЗГ-ын 2019 оны 478 дүгээр тогтоолын дагуу Нийслэлд 42.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр нийт 8,846.0 тн мах, Аймаг орон нутгийн түвшинд нийт 1,100.0 тн мах буюу Улсын хэмжээнд нийт 9946.0 тн махыг нөөцөлсөн (зээлийн хүүгийн хөнгөлөлт 10%). 2021 онд: ЗГ-ын 2020 оны 129, 2021 оны 72 дүгээр тогтоолын дагуу Нийслэлд 67.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон, нийт 10,350 тн мах, аймаг орон нутгийн түвшинд 1,350 тн мах буюу Улсын хэмжээнд нийт 11,700 тн махыг нөөцөлсөн (зээлийн хүүгийн хөнгөлөлт 11%). 2022 онд: ЗГ-ын 2021 оны 216, 2022 оны 145, 173 дугаар тогтоолын дагуу Нийслэлд 96.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон, нийт 12,773 мах, аймаг орон нутгийн түвшинд 1,190 тн мах буюу Улсын хэмжээнд нийт 13,963 тн мах нөөцөлсөн (зээлийн хүүгийн хөнгөлөлт 7.5%). 2023 онд: ЗГ-ын 2022 оны “Гурил, махны үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 174 дүгээр тогтоолын дагуу нийслэлд 53.3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 2 банкнаас 12 аж ахуйн нэгжид 7,900 тн үхэр, хонь, ямааны мах, аймаг орон нутгийн түвшинд 1,195 тн мах буюу Улсын хэмжээнд нийт 9,095 тн махыг хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн.

Нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх арга хэмжээний санхүүжилт нь арилжааны банкны эх үүсвэрээр хэрэгждэг тул тухайн оролцох хүсэлтэй аж ахуйн нэгж банкнаас тавьж буй зээлийн шаардлага, нөхцөлийг хангахгүйтэй холбоотойгоор бэлтгэх махны хэмжээ ихээхэн буурдаг.

3.3.3.2.Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: ХХААХҮС-ын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/294 дүгээр тушаалаар байгуулагдсан Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг судалж, экспортыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагааг цахимжуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. ГХАН, БНХАУ-ын эрх бүхий байгууллагатай хамтран 2022.10.27-ны өдөр зохион байгуулсан "GIZ-CIQA Хүйтэн хэлхээний менежмент ба Хятад Улсын мах, махан бүтээгдэхүүний импорт” сэдэвт сургалт, уулзалтад экспортлогч 19 аж ахуйн нэгжийг хамруулсан. Тус уулзалтаар БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлоход мөрдөгдөж буй дүрэм журам, тавигдах шаардлагын талаар танилцуулж, санал солилцсон. “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу Монгол Улсын 2022 оны 10 дугаар сараас 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд экспортлох, импортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээний саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Зөвлөмж гаргуулсан. ХХААХҮС-ын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/12 тоот тушаалын хүрээнд БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүн экспортыг сэргээх ажлыг эрчимжүүлж, ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан ажиллаж, БНХАУ-ын эрх бүхий байгууллагын импортын мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, баталгаажуулах талаар тавьсан шаардлагыг бүрэн хангаж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай “нэмэлт гэрчилгээ”-ний загварыг тохирсны үндсэн дээр 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс Эрээн боомтоор мах, махан бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн.

3.3.3.3.Хүнсний сүлжээнд зохистой дадал, угтвар нөхцөл, удирдлагын тогтолцооны стандартыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ

Биелэлт: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хүнсний салбарын үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх 7 зохистой дадлын зааврыг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Үүнд: Сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадлын зааврын төслийг боловсруулж батлуулахаар ажиллаж байна. Харин “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ыг боловсруулж, Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор баталсан. Стандарт хэмжил зүйн газраас бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажилтыг 2021 онд 4, 2022 онд 3, 2023 онд 9, нийт 16 байгууллага авч, үйл ажиллагаандаа олон улсын стандартыг нэвтрүүлсэн байна.

3.3.3.4. Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан, худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлнэ.

Биелэлт: Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn-аар дамжуулан өнөөдрийн байдлаар 19 баталгаажуулалтын байгууллага, нийт 708 га органик талбайд хүнс тарьж, дотоодын үйлдвэрийн мал, амьтны гаралтай 59 төрлийн 626 органик, шилжилтийн 126 бүтээгдэхүүн баталгаажуулж, импортын 50 бүтээгдэхүүн бүртгэж, нийтийн хэрэгцээнд гаргасан. СХЗГ-ын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар, "Сэлэнгэ органик өнөр булаг" хамтын баталгаажуулалтын байгууллага нь органик хүнсийг хөндлөнгийн үнэлгээгээр болон хамтран баталгаажуулахаар шинээр итгэмжлэгдэж, органик хүнсний бүртгэл мэдээллийн сангаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.

Органик хөдөө аж ахуйн судалгааны хүрээлэн (FiBL)-ийн "Дэлхийн органик хөдөө аж ахуйн 23 дахь судалгаа"-ны маягтын дагуу органик хүнсний бүртгэл мэдээллийн сангаас шууд гаргах тайлангийн загвар боловсруулж, Монгол улсын органик үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг хүргүүлж, хэвлүүлсэн.

3.3.3.5. Түүхий сүүний нийлүүлэлтийг сэрүүний улиралд нэмэгдүүлнэ.

Биелэлт: Сэрүүний улирлын шингэн сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталсан.

Улсын хэмжээнд сэрүүний улиралд 2021 онд 22532.4 мян.литр, 2022 онд 19488.5 мян.литр, 2023 онд 24,803.0 мян.литр (Эх үүсвэр: ҮСХ, 2021-2023 он) шингэн сүүг тус тус нийлүүлсэн бөгөөд 2020-2021 онд 8 үйлдвэрт 8400.0 мян.литр сүү нийлүүлсэн 2375 малчин, фермерт 4.2 тэрбум төгрөг, 2021-2022 онд 12 үйлдвэрт, 10600.0 мян.литр түүхий сүү нийлүүлсэн 8851 малчин, фермерт 5.3 тэрбум төгрөг, 2022-2023 онд 15 үйлдвэрт 12000.0 мян.литр түүхий сүү нийлүүлсэн 7878 малчин, фермерт 6.0 тэрбум төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.

Засгийн газрын 2023 оны 363 дугаар тогтоолоор 2020 оны 130 дугаар тогтоолд дараах өөрчлөлтийг оруулж зөвхөн үнээний сүү байсныг бүх төрлийн малын сүү нийлүүлсэн малчин, фермерт олгодог болсон. Мөн малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасан албан татварыг тухайн татварын жилд төлсөн малчин, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид, 1 л тутамд 500 төгрөг байсныг 1000 төгрөг болгож нэмэгдүүлсэн.

3.3.3.6. Хүнсний ногооны хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулна.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2023

оны “Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоол, 2023 оны “Гэрээ байгуулах эрх олгох тухай” А/199 тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, банкнууд хооронд байгуулсан “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн 230502/07-218 дугаар гэрээ байгуулан төмс хүнсний ногоо тариалагч 554 иргэн, аж ахуйн нэгжид 24.1 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтэй зээл олгосон, Улсын төсвийн 3,7 тэрбум төгрөгөөр төл сонгинын үр 186 тн, саримсны үр 33 тн, урт сонгинын үр 1 тн, байцайны үр 834 уут, хүрэн манжингийн үр 1.5 тн, шар манжингийн үр 0.35 тн, шар луувангийн үр 1,250 кг үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосны хүрээнд 2023 оны ургац хураалтын урьдчилсан дүнгээр 13.5 мянган га талбайгаас 170.1 мянган тонн хүнсний ногоо хураан аваад байна. Энэ нь хүнсний ногооны дотоодын хэрэгцээний 83 хувийг хангах үзүүлэлт юм. Ургац хураалтын урьдчилсан дүнгээр төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны 85.0 хувийг дотоодын ургацаас хангах боломж бүрдэж байгаа бөгөөд хүнсний ногооны үйлдвэрлэл 35.0 мянган тонн буюу 23.0 хувиар тус тус өсөөд байна.

3.3.3.7. Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулна.

Биелэлт: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлуулсан. Хуульд ургамлын тосны хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортлоход гаалийн албан татвараас чөлөөлүүлсэн. ЗГ-ын 2022 оны 144, 175 дугаар тогтоолын хүрээнд ургамлын тосны үйлдвэрт жилийн 3%-ийн хүүтэй эргэлтийн хөрөнгийн зээлийн дэмжлэг үзүүлэхээр тус тус шийдвэрлэсэн. Монгол Улс 2021 онд 102 мян.га талбайд тосны ургамал тариалж 53.7, 2022 онд 124 мян.га талбайд тосны ургамал тариалж 45.8 мян.тн, 2023 онд 113.3 мян.га талбайд тосны ургамал тариалж 50.6 мян.тн, нийт 150.1 мян.тн тосны ургамал хураан авсан байна. Хэдийгээр 2023 онд 113.3 мян.га талбайд тосны ургамал тариалсан боловч цаг уурын нөхцөлөөс шалтгаалан ургацын хэмжээ буурч, зорилтот түвшинд хүрээгүй байна.

3.3.4. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.4.1. Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулна.

Биелэлт: Улсын хэмжээнд 2020 онд 131 Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж үржил, бүртгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 2023 оны байдлаар Улсын хэмжээнд нийт 184 МҮТАҮ-ний нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь зорилтот түвшинг 22 нэгж буюу 13.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

3.3.4.2. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ.

Биелэлт: Бог малын хээлтүүлэгчийг хангамжийг нэмэгдүүлэх, үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилгоор улсын төсвийн 250.0 сая төгрөгийн санхүүжилтээр 16 аймагт 379 хуц, 328 ухна нийт 707 бог малын хээлтүүлэгч худалдан авч, Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид гэрээ түрээсээр ашиглуулан малчдад ашиглуулж байна. Мөн Баталгаажсан үүлдэр, омгийн ухна 151.0 мянга, хуц 174.0 мянга нийт 325.0 мянган бог

малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлт хийх ажлыг намрын технологит хугацаанд 22 аймаг нийслэлийн 330 сум дүүрэгт гүйцэтгэж байна.

Малын гений санд үр үйлдвэрлэх 2021-2023 оны төлөвлөгөөт ажлын хүрээнд ОХУ, Франц, Швейцар улсаас импортоор авч ашиглаж байгаа гойд ашиг шимт махны чиглэлийн Хар, Улаан ангус, Халимаг, Герефорд, мах сүүний хосолмол ашиг шимт Симменталь, Швицийн бор, сүүний чиглэлийн Хар тарлан зэрэг 7 үүлдрийн 16 бухаас нийт 12298 тун үр, Франц улсаас импортлон нутагшуулж ашиглаж байгаа ноосны чиглэлийн меронос, махны чиглэлийн суффолк, брешин, рамонов, эдьелбай үүлдрийн хуцанаас 2500 тун үр, Монгол улсад баталгаажсан 58 үүлдэр, омгийн малаас 8500 тун, нийт 23,298 тун стандартад тэнцсэн үр үйлдвэрлэн малын үндэсний гений санд баяжилт хийв.

АДРА Олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн нийт 136.3 сая төгрөгийн санхүүжилтээр нарийн ноост болон ноос-махны чиглэлийн 5 хуцаны нийт 6000 тун үр, Монтбилерд үүлдрийн гүн хөлдөөсөн 1000 тун үр импортоор авч малын гений санд баяжилт хийсэн.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд 2021-2023 онд нийт 46,551 тун стандарт, үржлийн шаардлагад тэнцсэн үр үйлдвэрлэн Монголын малын гений санд баяжилт хийсэн байна. Энэ ажлын үр дүнд Монгол улсад үржүүлж байгаа баталгаажсан нийт 59 үүлдэр, омгийн малын 50.8 хувийг Монгол улсын малын генийн үндэсний санд хөлдөөсөн үр байдлаар тусгай орчинд хадгалаад байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл арга хэмжээний хүрээнд Говь-Алтай аймагт 670 толгой сарлаг, Баянхонгор аймагт 6 толгой Сэлэнгэ үүлдрийн бух, 6 толгой сарлагийн бух, Баянгол омгийн 120 толгой хуц Төв аймагт Эдельбайев үүлдрийн 60 толгой өсвөр хуцыг авч малчдад гэрээгээр ашиглуулж байна. Малын удмын сангийн үндэсний төвийн орон нутагт дахь цөм сүргийн салбар нэгжүүдээс тухайн үүлдрийн болон, үржлийн стандарт, шаардлагад тэнцсэн 215 өсвөр хуц, ухна өсгөн бойжуулж Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Булган, Төв аймгийн малчид, иргэн, аж ахуй нэгжид үржилд зориулан худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэв. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд 2021-2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 1380 толгой үржлийн өсвөр хээлтүүлэгчийг бойжуулан иргэд, аж ахуй нэгжид худалдан борлуулах болон түрээсээр олгосон байна.

3.3.4.3. Орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийг шинээр бий болгох, хил заагийг баталгаажуулах, ашиглалт хамгаалалтыг сайжруулна.

Биелэлт: Орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагааг 2020-2023 онд олон улсын төсөл хөтөлбөр, аймаг, сумдын Засаг дарга, ИТХ-тай хамтран ажилласны үр дүнд нийт 740 мянган га бэлчээрийг шинээр орон нутгийн тусгай хэрэгцээнд авч отрын бэлчээрийн зориулалтаар ашиглахаар болов. Үүнд: Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/05 тоот тогтоолоор нийт 14 сум сум дундын отрын нөөц нутаг, түүний хилийн зааг тогтоох, Өмнөговь аймгийн 8, Хөвсгөл аймгийн 2, Дорноговь аймгийн 1, Баян-Өлгий аймгийн 1, Сүхбаатар аймгийн 5, Ховд аймгийн 6, Дундговь аймгийн 2 нийт 8 аймгийн 37 сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бэлчээрийн хил заагийг багийн нэр, газрын нэр, талбайн хэмжээ, отрын бүс нутгийн хилийн зааг, солбицол эргэлтийн цэгийг тогтоосон байна.

3.3.4.4. Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна.

Биелэлт: Улсын төсөв болон төсөл, хөтөлбөрийн 453.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд 8 аймгийн 74 сумын 382 бэлчээрийн газарт уст цэг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж шинээр өрөмдөх худгийн найдвартай цэгийг нэмэгдүүлэв. Шинэ бэлчээр, отрын нөөц нутгийг ашиглах чиглэлээр зун, намрын бэлчээр болон сум дундын отрын нөөц нутагт уст цэг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улсын төсөв болон гадаадын төсөл, хөтөлбөрийн 453.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ховд, Өмнөговь, Дундговь, Дорнод, Завхан, Сүхбаатар аймгийн 74 сумын 382 бэлчээрт шинэ уст цэг тогтоох хайгуулын ажлыг гүйцэтгэж инженерийн хийцтэй худгийн нөөц цэгийн тоог нэмэгдүүлэв.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2023 онд улсын төсвийн 6.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 222, гадаадын төсөл, хөтөлбөрийн 2.6 тэрбум төгрөгөөр 122, орон нутгийн төсвийн 23.9 тэрбум төгрөгөөр 1,192, малчдын өөрсдийн санаачилгаар 456 гар худаг, нийт 1,536 худгийг ашиглалтад оруулснаар 2.6 сая га бэлчээр, 8,592 малчин өрхийн 5.2 сая малыг усаар хангах боломжийг бүрдүүлсэн.

Шинэ бэлчээр, отрын нөөц нутгийг ашиглах чиглэлээр зун, намрын бэлчээр болон сум дундын отрын нөөц нутагт уст цэг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улсын төсөв болон гадаадын төсөл, хөтөлбөрийн 453.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ховд, Өмнөговь, Дундговь, Дорнод, Завхан, Сүхбаатар аймгийн 74 сумын 382 бэлчээрт шинэ уст цэг тогтоох хайгуулын ажлыг гүйцэтгэж инженерийн хийцтэй худгийн нөөц цэгийн тоог нэмэгдүүлэв.

3.3.4.5.Тариалангийн бүс нутгийг түшиглэн сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйг бий болгоно.

Биелэлт: УИХ-ын 2022 оны 36 дугаар, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ХХААХҮЯ, Арилжааны 10 банкттай "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгө"-ийн болон "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл"-ийн гэрээнүүдийг байгуулсан. Эдгээр гэрээний хүрээнд сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд 44,038.5 сая төгрөгийн зээл олгох ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд шингэн сүү үйлдвэрлэлийн хэмжээг 14.0 гаруй сая литрээр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна. Засгийн газрын дэмжлэг, хувийн хэвшлийн хүрээнд 14.0 сая литр сүү үйлдвэрлэх боломж бүрдүүлэв. Энэ нь импортын сүүний 46.6 хувийг бүрдүүлэхээр байна.

3.3.4.6.Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачилга, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжинэ.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, арилжааны банкнуудтай "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгө"-ийн 23330/07-218 дугаартай, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 230502/07-281 дугаартай, "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл"-ийн 230330/07/217 дугаартай, 230502/07-280 дугаартай гэрээнүүдийг 2023.03.30-ны өдөр, 2023.05.02-ны өдөр тус тус байгуулсан. УИХ-ын 36 тогтоолын хүрээнд 2022-2023 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 131 иргэн, аж ахуйн нэгжид 63.9 тэрбум төгрөгийн зээл олгох ажлыг зохион байгуулсан. Үүнээс сүүний чиглэлийн 46 иргэн, аж ахуйн нэгжид 5.2 тэрбум төгрөгийн, махны чиглэлийн 30 иргэн, аж ахуйн нэгжид 13.42 тэрбум төгрөгийн, 11 тахианы аж ахуй эрхлэгчид 19.3 тэрбум төгрөгийн зээл тус тус олгогдсон. Мөн Дэлхийн банкны "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг сайжруулах" төслийн (2021-2023 онд) "Мал аж ахуйн инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ" дэд төслийн хүрээнд 13.46 тэрбум төгрөгийн 26 төсөлтэй, Бүтээмжит түншлэлийн хамтын шийдэл" дэд төслийн хүрээнд 17.0

тэрбум төгрөгийн 10 төсөлтэй, малын тэжээлийн үйлдвэрлэлийн зангилаа төв байгуулах 4 дэд төсөлтэй 4.2 тэрбум төгрөгийн хэлцэл хийж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан. Зээлд 40 аж ахуйн нэгж хамрагдаж 34.66 тэрбум төгрөгийн зээлийн гэрээ байгуулагдсан зэрэг нь сүүний импортыг 46.6 хувиар бууруулах боломжийг бүрдүүлсэн.

3.3.4.7. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор бог малыг шахан бордох төвийг орон нутагт туршина.

Биелэлт: Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал, төслийн хүрээнд Дорнод аймгийн Хөлөнбуйр, Булган сум, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Мөнххаан, Түмэнцогт суманд Хурга бордох аж ахуйг бий болгох, дэмжлэг үзүүлэх чиглэлээр Төслөөс 60.0 тн ислэг багатай, хорголжин тэжээлийг хүргүүлэх ажлыг зохион байгуулж, "Хурганы мах үйлдвэрлэл" гарын авлага малчдад хүртээх ажлыг, мөн Мөнххаан сумын малчдад 60 тн тэжээлийг үнэгүй олгож, хавар нялх хургыг тэжээж, намар амьдын жинг дунджаар 43 кг хүргэж борлуулсны дараа тэжээлийн үнийг "Тэжээлийн эргэлтийн сан"-д төвлөрүүлэх ажлыг хамтран зохион байгуулав. Энэхүү тэжээлийн эргэлтийн санд төвлөрүүлсэн мөнгөөр ирэх хавар хургаа тэжээх зохицуулалтын ажил хийгдэнэ.

Мөн Дэлхийн банкны "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх" төслийн Бүтээмжит түншлэлийн зааврын дагуу төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн "Шинэлэг шийдэл" хөтөлбөрийн хүрээнд "Хаш хур" ХХК-ийн хамтран түншлэгч байгууллагуудын "Нялх бог мал шахан бордох" төслийн багтай хэлцэл хийж, төслийг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Баянгол, Бүрд, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Уянга, Хархорин, Хужирт сумын 320 өрхийн 32,000 хургыг бордох 8 аж ахуй байгуулаад байна. Төслийн үр дүнд хурга бордох жишиг 8 аж ахуй байгуулж, махыг "Монголиан лэмб" ХХК-аар дамжуулан олон улсад экспортлох ажлыг үе шаттай зохион байгуулав.

Түүнчлэн Төслийн бүтээмжит түншлэлийн хамтын шийдэл дэд төслийн хүрээнд "Түмэн шувуут" ХК-тай хэлцэл хийж "Монгол хонины махан ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үүлдэр хоорондын гетерозисийг ашиглаж үр дүнг нотлох" төсөлтэй хэлцэл хийж өсвөр хонь бордох ажлыг дэмжив. Мөн төслийн хүрээнд "Стандарт мах" ХХК-ийн "Үхрийн мах, мал бэлтгэх нэгдсэн тогтолцооны түншлэл" төслийн багтай хэлцэл хийж, төслийг Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд 6 бүлгийн 150 малчин өрхийг хамруулан, "Өсвөр үхрийг эрчимтэй шахан бордож" үхрийг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүхий эд бэлтгэлийн хэмжээг 30 хувь нэмэгдүүлэх боломж бүрдүүлэн ажилласан.

3.3.4.8. Бэлчээрийн ашиглалтыг сайжруулахын тулд гүний худаг болон ус хуримтлуулах бүтээцийг байгуулж, бэлчээрийн нөөц болон хадлангийн талбайг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Бэлчээрийн усан хангамжийн зориулалттай 456 гар худгийг малчид өөрсдийн санаачилгаар шинээр гаргаж, сэргээн засварласан. Инженерийн хийцтэй 1536 худгийг шинээр гаргаж ашиглалтад оруулснаар 5.2 сая мал сүргийг усаар хангах боломжийг бүрдүүлэв. НҮБ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" төслийн хүрээнд Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 онд 710 га талбайд татмын ойжуулалт, нөхөн сэргээлт хийх замаар усны нөөц, экосистемийн үйлчилгээг тэтгэх үйл ажиллагааг зохион байгуулж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшигт үзэгдлээс үүдэлтэй амьжиргааны тогтворгүй байдлыг багасгах зорилгоор 24 бүлгийн эхийг хашиж хамгаалж, 44 худаг гаргаж усны хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зорилтод 4 аймгийн 49 сумын 138 багт хийж хэрэгжүүлсний үр дүнд нийт 15,500 малчин өрх төслийн үр шимийг хүртэх боломжтой болсон. Булгийн эхийг

хашиж хамгаалснаар малын хөлд ихээр дарагддаг, хүн малын төвлөрөл ихтэй булгууд байсан бөгөөд малын хөлөөс эх ундарга бүрэн чөлөөлөгдсөн.

3.3.5.Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.

3.3.5.1.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтад, шавжтай байгаль орчинд сөрөг нөлөө багатай аргаар тэмцэнэ.

Биелэлт: Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг мэрэгч амьтад, шавжийн тархалт олшролтын судалгааг 2020-2023 онд нийт давхардсан байдлаар 91 сая га бэлчээрийн талбайд хийж дүгнэлт гаргасан. Энэхүү эрдэм шинжилгээний байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн улс, орон нутгийн төсвийн 8.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нийт 3.25 сая га бэлчээрийн 1.9 сая тонн ургамлыг мэрэгч амьтад, шавжийн хөнөөлөөс хамгаалсан. 2020-2023 онд хэрэгжүүлсэн бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээний үр дүнд Монгол Улсын 64.7 сая толгой малыг 30 хоногийн турш байран тэжээхүйц хэмжээний өвсийг мэрэгч амьтад, шавжийн хөнөөлөөс хамгаалсан. ЗГҮАХ хэрэгжих нийт хугацаанд 5.0 сая га бэлчээрийн талбайд ургамал хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан ч тухайн жилийн улсын төсөвт тусгагдсан санхүүжилтээс хамааран хүрэх үр дүнгээ 64.5 хувиар биелүүлсэн.

3.3.6.Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

3.3.6.1.Малчдын анхдугаар аяныг зохион байгуулна.

Биелэлт: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар “Малчдыг дэмжих анхдугаар аян өрнүүлэх тухай” шийдвэр гаргасан. Шийдвэрийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01/745 тоот албан бичгээр бүх аймаг, нийслэлийн Засаг дарга нарт ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хамтран ажиллах албан тоот хүргүүлж 21 аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж гарган аяныг зохион байгуулж ажилласан. Тус аяныг орон нутгийн онцлогт тохируулан 8 арга хэмжээтэйгээр батлан хэрэгжүүлсэн.

3.3.6.2."Монгол малчин" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар “Малчдыг дэмжих анхдугаар аян өрнүүлэх тухай” шийдвэр гарган улс даяар өрнүүлсэн.

3.3.6.3.Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Дэлхийн банкны санхүүжилттэй "Экспортыг дэмжих төсөл"-өөс жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг сайжруулах, санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор Түншлэлийн хөтөлбөр-ийг ЖДҮГ-тай хамтран хэрэгжүүлсэн. 2022.11.15-ны өдрөөр тус хөтөлбөрт хамрагдахаар нийт 43.1 тэрбум төгрөгийн 203 хүсэлт ирснээс 20.2 тэрбум төгрөгийн 100 өргөдөл төсөл судлагдан иж бүрдлийн шаардлагыг хангасан

төслүүдийг ЖДҮГ нарийвчилж судлан, гэрээ байгуулж ажиллан Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн “Түншлэлийн хөтөлбөр”-өөс 13.3 тэрбум төгрөгийн 63 төсөл санхүүгийн дэмжлэг авахаар гэрээ байгуулсан ба ЗТХ нь давхардсан тоогоор 78 албан хүсэлт бүхий 10.7 тэрбум төгрөгийн гэрээний ажлыг хянаж, ЭДТ-д хүргүүлэх ажлыг зохион байгуулснаас 9.6 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 54 аж ахуйн нэгжид олгосон. Дурдвал Сор кашемир ХХК нь 1998 онд байгуулагдсанаас хойш тасралтгүй 20 жил үйл ажиллагаа явуулж байгаа ба жилд 3000-4000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, гадаад, дотоодын зах зээлд нийлүүлж байна. Тус үйлдвэр нь жилд 100 тн ноос, ноолуурыг 70 гаруй хоршооноос бэлтгэн авч, угаахаас бусад боловсруулалтыг хийж байна. Тэдний зүгээс самнасан ноолуурыг экспортод гаргадаг болох нь хамгийн ашигтай гэж мэдэгдсэн ба илүү олон хоршоодтой хамтран ажиллах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Тус компани нь Экспортыг дэмжих төсөлтэй 300.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээнд заасан ажлуудаа амжилттай хэрэгжүүлэн санхүүгийн дэмжлэг бүрэн хамрагдсан. Мөн 2020-2023 онуудад Зээлийн батлан даалтын сангаас нийт 267 зээлдэгчдийн 91.4 тэрбум төгрөгийн зээлд 46.7 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна.

3.3.7. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.

3.3.7.1. Өвсний нөөц бүрдүүлэх, зориулалттай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.

Биелэлт: Сүүлийн 4 жилийн хугацаанд 6 аймгийн 14 сумын хэмжээнд 14 өвс тэжээлийн агуулах шинээр барьж, 4 агуулахыг засаж ашиглалтад оруулав. Орон нутгийн хөгжлийг дэмжих шинэ хөдөө төслийн хүрээнд Хөвсгөл, Булган, Төв аймагт 20 хадлангийн олгож орон нутгийн өмчид бүртгүүлэв. Мөн ХААДС-с өвс пресслэгч 3 ширхэг хадуур тармуур иж бүрдэл 6 ширхгийг хөнгөлөлттэй нөхцөлөөр малчдад олгов. БНХАУ-с жижиг оврын 150 гаруй тоног төхөөрөмжийг импортлон авч хадлан тэжээлийн техникийн шинэчлэл хийв.

Бүгд найрамдах Беларусь улсын ЗГ-ын зээлийн хүрээнд нийт 7 тэрбум төгрөгийн үнэ бүхий трактор, хадуур, тармуур, дөрвөлжин хаман боогч 62 иж бүрдэл хадлангийн тоног төхөөрөмжийг тариаланчдад 3 жилийн хугацаатай, 30 хувийн урьдчилгаатай, жилийн 1.37 хувийн хүүтэй олгосон. Бүгд найрамдах Беларусь улс 115 тоног төхөөрөмжийг 49 иргэн, ААН-д 60 ширхгийг 486,277 еврогийн үнэ төлбөртэй худалдан 212,891.7 урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэй 273,385.3 еврогийн үнэ бүхий техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж 52.2% гүйцэтгэлтэй худалдан борлууллаа. Мөн Бүгд найрамдах Беларусь улсын ЗГ-ын зээлийн хүрээнд нийт 7 тэрбум төгрөгийн үнэ бүхий трактор, хадуур, тармуур, дөрвөлжин хаман боогч 62 иж бүрдэл хадлангийн тоног төхөөрөмжийг тариаланчдад 3 жилийн хугацаатай, 30 хувийн урьдчилгаатай, жилийн 1.37 хувийн хүүтэй олгосон.

3.3.8. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.

3.3.8.1. Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологийг шинэчилнэ.

Биелэлт: Дэлхийн банкны нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ногоон, өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй” төслийн саналд “Био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх” хүрээнд 30.0 сая \$ хөрөнгө оруулалтын саналыг бэлтгэн Дэлхийн банканд хүргүүлсэн. Мөн Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Ногоон өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй” төслийн саналын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Эдийн засаг, хөгжлийн яамнаас “Ногоон

өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй төсөл"-ийн хүрээнд Биокомбинат ТӨХХК-ийг иж бүрэн шинэчилж, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох арга хэмжээг дэмжсэн болно. Одоогоор Дэлхийн банктэй хамтран "Ногоон өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй төсөл"-ийг боловсруулахаар ажиллаж байна. Шүлхийн 0 хэвшлээс сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакцин 50 литр буюу 50000 тун савласан. Дэлхийн банкны LCP болон GSAP төслүүдэд шугаман эсийн технологи нэвтрүүлэх, вирусийн гаралтай вакцины шинэ үйлдвэрийн төслийн танилцуулгыг хүргүүлсэн.

3.3.8.2. Малын эмч нарыг чадавхжуулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна.

Биелэлт: Мал эмнэлгийн ерөнхий газраас 2020 оноос эхлэн мал эмнэлгийн цахим гэрчилгээг нэвтрүүлж, урьдчилан сэргийлэх бүхий л үйл ажиллагааны бүртгэл мэдээллийг цахимжуулж, мал эмнэлгийн нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлснээр МЭҮН-р үйлчлүүлдэг малчин өрхийн тоо нэг МЭҮН-д улсын дунджаар 204 болж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх үед аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор жилд 500 мянга гаруй мал эмнэлэг, ариун цэврийн цахим гэрчилгээ олгож, тогтмол үйл ажиллагаа явуулж буй 1,023 МЭҮН зах зээлээс ойролцоогоор 2.5 тэрбум төгрөгийн орлого олж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг дэмжих ажил болоод байна. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэдээ судалгаагаар 2023 оны жилийн эцсийн байдлаар нэг малын эмчид 47.0 мян мал оногдож байна. хийх үйлчилгээний хөлсийг бог-800 төг, бод-1500 төгрөг байхаар нэмэгдүүлэх саналыг хүргүүлсэн. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Булган (2), Говь-Алтай (2), Дорноговь (1), Дорнод (1), Дундговь (2), Сүхбаатар (1), Увс (2), Өмнөговь (1), Улаанбаатар (1) буюу нийт 9 аймаг, нийслэлийн 13 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг Жижиг, дунд үйлдвэрийн газрын хөнгөлөлттэй зээлд хамруулж 1.1 тэрбум төгрөгийн зээл олгосон.

3.3.8.3. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ (Мал, амьтны гоц халдварт болон зооноз өвчнөөс бусад).

Биелэлт: Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021-2023 онд дархлаажуулалтын төлөвлөгөөг тархвар зүйн судалгаа болон лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн МЭЕГ-н дэргэдэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж гарсан зөвлөмжийн дагуу МЭЕГ-н даргын тушаалаар дархлаажуулалтын төлөвлөгөөг албажуулан аймаг нийслэлийн мал эмнэлгийн газарт хүргүүлдэг. Төлөвлөгөөний дагуу "Биокомбинат" ХХК-тай жил бүр вакцин худалдан авах гэрээг байгуулан орон нутагт захиалгын дагуу вакцинууд хүргэгдэж байна. 21 аймаг нийслэлийн мал эмнэлгийн газар нь "Биокомбинат" ХХК-тай мөн гэрээгээ байгуулж хамтран ажиллаж байна. Улсын хэмжээнд жил 17-20 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Мал эмнэлгийн нэгдсэн системээр сум, дүүрэг дэх МЭТ-ийн төлөвлөснөөр гүйцэтгэл давхардсан тоогоор 2021-2023 онд жил бүр 531,430 малчин, мал бүхий өрхийн 36,783,794 толгой үхэр, адуу, хонь, ямаа, гахай, тахиа, нохойг дархлаажуулалтад хамруулж төлөвлөгөөг 97.7 гүйцэтгэж 2022 оны халдварт өвчний гаралтаас 2023 онд 48.7 хувиар буурсан байна.

3.3.8.4. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

Биелэлт: Шүлхий 2020-3, 2021-301, 2022-462, 2023-1, бог малын мялзан 2020-0, 2021-36, 2022-99, 2023-102, хонины цэцэг 2020-0, 2021-4, 2022-15, 2023-75 голомт тус тус бүртгэгдэж тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Өвчний гаралт, тархалтын нөхцөл байдлаас шалтгаалан урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад

шүлхий 2020-24.7 сая, 2021-23.3 сая, 2022-15.0 сая, 2023-12.0 сая толгойг 92-98 хувийн гүйцэтгэлтэй, бог малын мялзан 2020-2.7 сая, 2021-1.9 сая, 2022-2.6 сая, 2023-19.4 сая толгойг 92-96 хувийн гүйцэтгэлтэй, хонины цэцэг 2020-2.7 сая, 2021-0.9 сая, 2022-2.3 сая, 2023-4.6 сая толгойг мэдрэмтгий мал сүргийг 90-96 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хамруулсан. Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг 2022 оноос УИХ-аар батлагдсан 2022 оны 36-р тогтоол болон холбогдох шийдвэрийн дагуу улсын хэмжээнд нэгдсэн аян хэлбэрээр зохин байгуулсны үр дүнд 2023 оны 12-р сарын байдлаар улсын хэмжээнд шүлхий, бог малын мялзан өвчний голомт байхгүй тайван байна.

3.3.8.5. Малын бруцеллёз, боом, галзуу зэрэг зооноз өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

Биелэлт: Бруцеллёзын дархлаажуулалтын төлөвлөгөөний дагуу 2023 онд 12.9 сая толгой охин төл хамруулахаас 12,3 сая төл хамрагдаж, 95.0 хувьтай гүйцэтгэсэн. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1.7 сая толгой мал хамруулахаас 1.6 сая толгойг хамруулж, 98.3 хувьтай гүйцэтгэсэн. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 3,1 сая толгой мал хамруулахаас 100.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн ба 2023 онд өмнөх оноос өвчний гаралт 48 хувиар буурсан байна. Малын бруцеллёз өвчинтэй тэмцэх шинэ стратеги төлөвлөгөөг Дэлхийн банкны МAAЭЗЭН төсөлтэй хамтран төслийг боловсруулсан. 2023 оны 12 дугаар сард сүүлийн хэлэлцүүлэг хийж стратеги төлөвлөгөөг батлуулахаар болоод байна. 2024 онд бруцеллёз өвчинтэй тэмцэх шинэ стратеги төлөвлөгөөний дагуу төлөвлөж ажиллана.

3.3.8.6. Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдлын лаборатори, чанарын дэд бүтцийг сайжруулах, чадавхжуулна.

Биелэлт: Олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар, АХБ-ны "Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах" төслөөр Сэлэнгэ, Дорноговь аймгийн мал эмнэлгийн лабораторийн барилгын ажлыг 2019 онд эхлүүлэн, 2022 оны 06 дугаар сард Дорноговь аймгийн барилга ашиглалтад оруулаад байна. Мөн Дэлхийн Банкны "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх" төслийн санхүүжилтээр Ховд, Хэнтий, Өвөрхангай аймгийн мал эмнэлгийн лаборатори болон УМЭАЦТЛ-ын БСЛ-3 дугаар зэрэглэлийн лаборатори, Мал эмнэлгийн эмийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторид нийтдээ 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байна. Харин улсын төсвөөр, 2023 оны 12 сарын байдлаар Итгэмжлэлийн үндэсний төвөөс Говь-Алтай, Дорнод, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Ховд, Увс аймгийн мал эмнэлгийн лабораториуд ISO MNS 17025:2018 стандартын итгэмжлэлд хамрагдаад байна.

3.3.8.7. Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархиагтах өвчингүй, тайван байдлыг ДМАЭМБ-аар баталгаажуулна.

Биелэлт: 2023 оны тандалт шинжилгээний ажлыг Мал эмнэлгийн хүрээлэнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, үхрийн цээж өвчнөөс тайван статусыг хадгалах стратегийг хэрэгжүүлэх тандалт, шинжилгээг 2000-аас доошгүй сорьц цуглуулах шинжилгээ хийж. Үхрийн цээж өвчнөөс эрүүл, тайван болохыг батлах 2022 оны тайланд нэмэлт тайлбар илгээж, баталгаажуулсан. 2023 оны тайлан, тандан шинжилгээний үр дүнг 11 дүгээр сарын 30-ны өдөр ДМАЭМБ-д илгээж тайлагнасан. Мөн Монгол улсыг ямааны годрон өвчнөөс эрүүл, тайван болох тайланг 2023 онд эхлүүлж 2024 онд эрүүл болох тайланг МЭЕГ-ийн дэргэдэх мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дотооддоо уг өвчнөөр эрүүл, тайвал байдлыг зарлахаар төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. 2024 онд тайланг мэргэжлийн зөвлөлөөр оруулж баталгаажуулна.

3.3.8.8. Шүлхий өвчингүй, тайван байдлыг баталгаажуулна.

Биелэлт: Шүлхий 2020-3, 2021-301, 2022-462, 2023-1 голомт тус тус бүртгэгдэж тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Өвчний гаралт, тархалтын нөхцөл байдлаас шалтгаалан шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2020 онд 24.7 сая, 2021 онд 23.3 сая, 2022 онд 15.0 сая, 2023 онд 12.0 сая толгой мэдрэмтгий мал сүргийг 90-96 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хамруулсан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг УИХ-аар батлагдсан 2022 оны 36-р тогтоол болон холбогдох шийдвэрийн дагуу улсын хэмжээнд нэгдсэн аян хэлбэрээр зохион байгуулсны үр дүнд 2023 оны 12-р сарын байдлаар улсын хэмжээнд шүлхий өвчний голомт байхгүй тайван байна. Монгол улсын баруун бүсийн аймгуудыг шүлхий өвчингүй, вакцин хэрэглэдэггүй болохыг ДМАЭМБ-аар баталгаажуулах доссиерыг боловсруулж, Баруун бүсийн Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий, Говь-алтай аймгийн шүлхий өвчинд мэдрэмтгий мал сүрэгт 2021 оны 05-р сард 7168 ийлдэсний сорьц цуглуулж хийсэн халдвар илрүүлэх тандалт шинжилгээгээр уг шүлхий өвчний халдвар байхгүй болохыг тогтоосон боловч 2021 оны 07-р сард Ховд аймагт шүлхий өвчний гаралт бүртгэгдэж эрүүл тайван байдлыг баталгаажуулах ажил тодорхойгүй хугацаагаар хойшилсон бөгөөд бүс, улсын хэмжээнд шүлхий өвчингүй байдлыг баталгаажуулах боломжгүй болохыг харуулсан. Цаашид мал, малын гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааг дэмжих зорилгоор бүс нутгийн түвшинд бус аж ахуйн түвшинд /хамгаалалттай аж ахуй/ өвчингүй тайван байдлыг хангах зорилгоор ХХААХҮС-ын тушаалаар ажлын хэсэг байгуулан дүрэм, журам боловсруулах, хууль эрхзүйн орчин бүрдүүлэхээр ажиллаж байна.

3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

3.3.9.1. Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхыг сайжруулна.

Биелэлт: Хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийг шинээр байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

3.3.9.2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2020 онд 44 аж ахуйн нэгжид 103.9 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг ноолуур бэлтгэлийн зориулалтаар олгосон. Гоёл кашемир ХХК нь АНУ-ын DFC банкнаас 5 сая ам. долларын зээлийн хөрөнгө оруулалтаар шинэ үйлдвэрийн байр ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн. 2021 онд 31 аж ахуйн нэгжид 94.9 тэрбум төгрөгийн зээл олгосон. Говь ХК 17.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Итали улсын 4 самнах машин шинээр суурилуулан, ээрэх хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж 1,080 тн-д хүргэн, 15 байнгын ажлын байрыг бий болгосон. 2022 онд 24 аж ахуйн нэгжид 121.95 тэрбум төгрөгийн зээл олгосон. Говь ХК 8.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Итали улсын иж бүрэн 2 самнах машин шинээр суурилуулж, байнгын 10 ажлын байрыг бий болгон ээрэх хүчин чадлыг 350 тонноор нэмэгдүүлснээр улсын хэмжээнд нийт ээрэх хүчин чадал 2,970 тн-д хүрсэн. "Баялаг Өлзий" ХХК нь 300 мянган ам.долларын үнэ бүхий хялгас ялгах 40 тоног төхөөрөмж суурилуулан хүчин чадлаа 40 тн-оор нэмэгдүүлж, 20 ажлын байр бий болгосон.

Итали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Итали-Монголын Текстил (нэхмэл)-ийн технологийн төв”-ийг байгуулж, төвийн үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр албан ёсоор нээсэн. 2023 онд 38 зээлдэгчид 168.9 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан 2022, 2023 онуудад нийт 15 үйлдвэрт 4,163 тонн хялгас ялгах хүчин чадал нэмж суурилагдсан байна. “Говь” ХК нь Хэнтий аймагт 80 ширхэг оёдлын кеттель машин суурилуулан салбар үйлдвэр байгуулан 100 гаруй ажлын байр шинээр бий болгосон.

3.3.10. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

3.3.10.1. “Дархан арьс ширний цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк (ҮТП)-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Биелэлт: ҮББХ-ны 2023.01.18-ны өдрийн хуралдаанд “Дархан арьс ширний цогцолбор төсөл”-ийн танилцуулгыг танилцуулан, хэлэлцүүлж “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 01 дүгээр тогтоолыг батлуулав. Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах замаар МУХБ-ны санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх, зээлийн чанарыг сайжруулах хүрээнд ХХААХҮЯ болон МУХБ хооронд салбарын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” ХХААХҮС болон МУХБ-ны гүйцэтгэх захирлын хамтарсан 2022.12.02-ны өдрийн А/374, А-96 дугаар тушаалаар байгуулагдаад байна. “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-аас Хөгжлийн банкны зээлийн төлбөрт тооцон шилжүүлэхээр санал болгосон дуусаагүй гүйцэтгэлтэй дэд бүтцийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бодит гүйцэтгэлийг батлагдсан зураг төсөл, төсөвтэй харьцуулж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий БХБС, ХХААХҮС, ЭХС-ын хамтарсан 2023.03.10-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 44, А/68, А75 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдаад байна.

3.3.10.2. Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Биелэлт: “Шинэ Ховд” ҮТП-ийн бүтээн байгуулалтын ажлыг 6 багц тендер зарлан, гүйцэтгэгчид шалгарч ажлаа гүйцэтгэж байна.

3.3.10.3. Түүхий эд бэлтгэлийн зориулалтаар хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн нэн хөнгөлөлттэй зээлийг Аж ахуй нэгжүүдэд олгоно.

Биелэлт: Ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлд зориулан 2020 онд 44 аж ахуйн нэгжид 103.9 тэрбум төгрөгийн, 2021 онд 31 аж ахуйн нэгжид 94.9 тэрбум, 2022 онд 24 аж ахуйн нэгжид 121.95 тэрбум, 2023 онд 38 зээлдэгчид 168.9 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Мөн импортын гаалийн татвараас чөлөөлөх “ноолуурын хялгас ялгахаас дээш түвшинд боловсруулалт хийх зориулалттай тоног төхөөрөмжийн /БТКУС-ийн код/ жагсаалт”-ыг Засгийн газрын 2023 оны 107 дугаар тогтоолоор баталсан.

3.3.11. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно.

3.3.11.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох татаас, мөнгөн урамшууллын тогтолцоог бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үр дүнтэй холбож боловсронгуй болгоно.

Биелэлт: Хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгож байгаа урамшууллыг цахимжуулж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн “Төсвийн урамшууллын систем”-ийн сайжруулалт, хөгжүүлэлтийн ажлыг хийж, Газар тариалангийн болон МАА системтэй холбон, малчид, тариаланчид урамшуулалд хамрагдах хүсэлтэй и-баримт, гарал үүслийн гэрчилгээг үндэслэн цахимаар хүсэлт гаргах нөхцөлийг бүрдүүлэн 2023 оноос нэвтрүүлж эхлээд байна. 2020-2023 онд үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад /давхардсан тоогоор/: ноосны урамшуулалд 53.2 мян.тн ноос тушаасан 229,462 малчинд 89,179.35 сая төгрөг, арьс, ширний урамшуулалд 5,800.5 мянган ширхэг арьс, шир тушаасан 85,427 малчинд 22,937.48 сая төгрөг, махны урамшуулалд 2020-2022 онд зээл авсан 55 ААН-ийн 25.70 тонн нөөцөлсөн маханд 15,872.16 сая төгрөг, ноолуурын урамшуулалд 2020 онд 203,641 малчинд 174,909.7 сая төгрөг, улаанбуудайн урамшуулалд 2020-2023 онд 163,604 мян.тн үрийн буудай тушаасан 2,952 тариалан эрхлэгчид 82,103.29 сая төгрөг, хүнсний ногооны урамшуулалд 2022-2023 онд 11,116.43 мян.тн ногоо тушаасан 690 тариалан эрхлэгчид 6,508.77 сая төгрөг, сүүний урамшуулалд 2020-2023 онд 31,261.33 мянган литр сүү бэлтгэн нийлүүлсэн 26,260 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид 15,872.16 сая төгрөг, 2023 онд Төмс хүнсний ногооны техник хэрэгсэл, бордоо худалдан авсан иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх 30-50 хувийн хөнгөлөлтөд 6,839.6 сая төгрөгийг, Ноолуур бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2020-2023 онд нийт 106 зээлдэгчийн хүүгийн төлбөрт 13,625.56 сая төгрөг, ХАА-г дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2021-2023 онд нийт 60,640 зээлдэгчийн хүүгийн төлбөрт 74,480.39 сая төгрөг, Хүнсний болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2023 онд 910 зээлдэгчийн хүүгийн төлбөрт 26,429.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

3.3.12.Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

3.3.12.1.Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төвүүдийг Улаанбаатар хот, бүсүүдэд байгуулна.

Биелэлт: Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” төлөвлөгөөнд” 2022-2024 онд төмс, хүнсний ногооны механикжсан агуулахыг 21 аймаг, нийслэлд 55.0 мянган тонноор нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Тус тогтоолын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд: Барилга хот байгуулалтын яамтай хамтран “Төмс, хүнсний ногооны 500, 1000, 2500 тонн багтаамжтай агуулахын цогцолбор”-ын нэг хэв маягийн зураг төсөл, төсөв, ТЭЗҮ-ийг 2022 онд боловсруулсан. Улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгөөр Хөвсгөл аймгийн Мөрөн суманд төмс, хүнсний ногооны механикжсан тус бүр нь 500 тонн багтаамжтай 2 агуулахыг Төрөлх мөрөн ХХК, Өсөх нум ХХК-тай байгуулж, агуулахын барилга угсралтыг улсын комисст 2023 оны 10 сард хүлээлгэн өгсөн.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил, нэмэлт санхүүжилт төслийн санхүүжилтээр Төв аймгийн Борнуур суманд 200 тонн багтаамжтай төмс, хүнсний ногооны механикжсан агуулахыг Буяннэмэх интер ХХК-тай гэрээ байгуулж, 2023 онд ашиглалтад оруулж, улсын комисст хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 497 сая төгрөгөөр Сэлэнгэ аймгийн Мандал суманд 200 тн багтаамжтай төмс, хүнсний ногооны агуулах барих гэрээг Хүйс нутаг ХХК-тай байгуулан хэрэгжүүлж, улсын комисст хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Орхон аймагт 500 тн багтаамжтай агуулах баригдаж 2024 онд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Мөн “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг

дэмжих эргэлтийн 230502/07-217 дугаар гэрээ байгуулан төмс, хүнсний ногооны зоорины аж ахуй байгуулах 40 аж ахуйн нэгж иргэн 28.1 тэрбум төгрөгийг 5 жилийн хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй хүүгийн хөнгөлөлтэй зээлийг олгоод байна.

3.3.12.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх, анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч малчин өрхийн үйлдвэрлэл буй түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: МАА-н үйлдвэрлэлд ХАА-н зохистой дадлыг нэвтрүүлэхээр “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага MNS 6891:2020 стандарт”-ын хүрээнд тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний мөшгөх тогтолцооны сургалт, малчид сургагч багш нарт зориулсан гарын авлагыг тус тус боловсруулсан. “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” ТББ-ын Баталгаажуулалтын алба нь MNS ISO 17065:2013 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага” стандартын шаардлагыг хангаж Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/112 тоот тушаалаар 2 жил хугацаатай анх удаа итгэмжлэгдлээ. ХХААХҮЯ, ЗГХЭГ-тай хамтран “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийг 2021-2023 онд хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангаж ажилласан. Үүний үр дүнд мал аж ахуйн үйлдвэрлэлд 2021, 2022 онд нийт 35.2 тэрбум төгрөгийг ОНХС-д төвлөрүүлж, МАА үйлдвэрлэлд томоохон хөрөнгө оруулалт хийгдсэн.

3.3.12.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг Хөдөө аж ахуйн бирж, хоршооны бүтцэд тулгуурлан боловсронгуй болгож, Загвар хоршоодыг байгуулна.

Биелэлт: Төв аймагт 5 загвар хоршоог байгуулан Зуунмод суманд ХАА, эдийн засгийн бүтэж бүхий ҮТП-г байгуулж, сумдад дундын хоршоо, орон нутгийн оролцоот агробизнесийн компани байгуулан дундын хоршооны гишүүн байхаар төлөвлөж “Аймаг хөгжүүлэх сан”-ийн нийт эх үүсвэрийн 30 хувийг хоршооны үйл ажиллагааг дэмжихээр шийдвэрлэж, эх үүсвэрийг жил бүр 600.0-1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж “Аймаг хөгжүүлэх сан”-с 11 хоршоонд 375.0 сая төгрөгийн зээл олгосон байна. “Хоршоонд суурилсан ХАА-н тогтвортой үйлдвэрлэл 53036-001 Монгол Улс” төслөөс Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум, Архангай аймгийн Өлзийт суманд “Малчдын хоршилт, хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээр, усны менежмент, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ, зах зээлтэй холбогдсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах” зорилгоор хэрэгжиж, төслөөс малчдын хоршооны сайжруулсан загвар бүхий хоршооны бүтэц, зохион байгуулалтын загварыг турших, МАА-н тогтвортой үйлдвэрлэл, менежмент, орон нутгийн хүний нөөцийн чадавхыг сайжруулах, махны экспортын бодлогыг судалж, үнэлэх ажлуудыг гүйцэтгэж байна.

2021 онд Сангийн яам, ХХААХҮЯ, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл” нэмэлт санхүүжилтийн 810 сая төгрөгийн зээлийн хөрөнгийг ЖДҮГ-аар дамжуулан олгох гэрээний дагуу 9 аймгийн 12 хоршоонд 810 сая төгрөгийн зээл олгосон. 2023 онд ЖДҮХС-аас загвар хоршоонд зориулж олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 308 хоршоо хүсэлт ирүүлснээс нийт 22 хоршоонд 1,790 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. УИХ-ын 36 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөгөөр Загвар хоршоо байгуулахад олгох хөнгөлөлттэй зээлд 590 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 4 загвар хоршоо буюу нийт Загвар хоршоо байгуулахаар 51 хоршоог хөнгөлөлттэй зээлд хамруулж дэмжсэн байна. Мөн ХХС-аас 2020-2023 онд нийт 5.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 162 хоршоонд олгосон.

3.3.12.4. Олон улсын жишигт нийцсэн тохирлын үнэлгээний мэргэшсэн байгууллагуудыг бий болгоно

Биелэлт: Экспортыг дэмжих төслийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар болон “Эс Эф Си Эс” ХХК хамтран IFOAM (Олон улсын органик хөдөө аж ахуй нүүдлийн холбоо)-ны итгэмжлэлийн байгууллага (IOAS)-аар итгэмжлүүлэх ажлыг эхлүүлсэн. “Эс Эф Си Эс” ХХК Органик газар тариалан, мал аж ахуй, зөгийн аж ахуй, хүнсийг боловсруулах үйлдвэрийн чиглэлээр итгэмжлэгдэн баталгаажуулах үйл ажиллагаагаа явуулж байна. Стандарт, хэмжил зүйн газарт 2023.10.02-2023.10.06-ны өдрүүдэд Олон Улсын Органик итгэмжлэлийн холбоо (IOAS)-ны үнэлгээний баг ирж айлчлан газар дээрх үнэлгээг хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний урьдчилсан тайлантай танилцаж, үл тохирлыг залруулах ажлын төлөвлөгөөг боловсруулан баталсан. Үл тохирлыг залруулах ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангуулан цахимаар хүргүүлсэн.

3.3.13. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ.

3.3.13.1. Экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд даатгалын үйлчилгээг нэвтрүүлнэ.

Биелэлт: Монгол банк, Сангийн яам, ХХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэрийн газар болон МҮХАҮТ-тай хамтран хууль, эрх зүйн орчин болон нөхцөл байдлын судалж, Үндэсний давхар даатгал ХК нь Скор групптэй экспортын худалдааны зээлийн хувь тэнцүүлсэн давхар даатгалын гэрээг байгуулж олон улсын давхар даатгагч гэрээний хариуцлага болон хураамжийн 80 хувийг хариуцах ба давхар даатгуулагч буюу Үндэсний Давхар Даатгал ХК 20 хувийг хариуцан ажиллаж байна.

Үндэсний давхар даатгал ХК нь Бодь даатгал ХК болон Миг даатгал ХХК-тай давхар даатгалын мастер гэрээг байгуулахдаа /Олон улсын зөвлөхүүдтэй хамтран боловсруулсан даатгалын гэрээ, бүтээгдэхүүний журам болон бүтээгдэхүүний үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бүх хавсралт бичиг баримтуудыг монгол хэл рүү орчуулан, монгол загвар, нөхцөл, стандартад хөрвүүлсэн/ хамтран ажиллагч даатгалын компаниудтай хамтран даатгалын гэрээнүүдийг байгуулан экспортын зээл болон даатгалын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээр бүтээгдэхүүнээ экспортод бүтээгдэхүүнээ гаргаж байгаа болон гаргах хүсэлтэй ААНБ-ыг даатгалд хамруулах боломжийг бүрдүүлсэн.

Мөн Экспортыг дэмжих төслийн хүрээнд гэрээ байгуулсан ААНБ-дад даатгалын үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр олон улсын даатгалын СКОР ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа ба экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд даатгалын үйлчилгээг үзүүлэх даатгалын тогтолцоо бий болсон.

2020-2023 онуудад ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 275 зээлдэгчдийг санхүүгийн даатгалд бүрэн хамруулав. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын дагуу хоршоонд олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаа ААНБ-дад даатгалын үйлчилгээг сурталчилж хамруулах ажлыг зохион байгуулав.

3.3.13.2. Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2020-2023 оны хооронд зээлийн эргэн төлөлт, орон нутгийн болон олон улсын санхүүжилттэй нийт 88.0 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, Төсөл сонгон шалгаруулах хороо болон дэд хорооны шийдвэрээр 687 төсөлд 78.9 тэрбум төгрөгийн

хөнгөлөлттэй зээлийг олгосон бөгөөд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт авсан иргэн, аж ахуй нэгжүүдийн 32% буюу 25.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Улаанбаатар хотын 162 иргэн, аж ахуй нэгжид, 68% буюу 53.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 525 орон нутгийн иргэн, аж ахуй нэгж хамрагдсан.Тэд 2020-2023 оны хооронд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт авсан иргэн, аж ахуй нэгжүүд Улаанбаатар хотод 1,811 шинээр нэмэгдүүлж, 920 ажлын байрыг хадгалсан бол орон нутагт 2,127 ажлын байрыг шинээр нэмэгдүүлж, 1,630 ажлын байр хадгалсан байна.

3.3.13.3.Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" аяныг зохион байгуулах тогтолцоог сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

Биелэлт: Улсын хэмжээнд 21 аймгийн нийт 207 ААН-ийн брэнд бүтээгдэхүүнийг судлан "Орон нутгийн-Онцлох бүтээгдэхүүн" нэрээр танилцуулгыг цувралаар бэлтгэн олон нийтийн цахим орчинд сурталчлан, ХХААХҮС-ын 2021 оны А-301 тушаалаар аймаг бүрд санхүүжилт хуваарилсны дагуу 21 аймгийн мэргэжилтнүүдэд аяныг зохион байгуулах удирдамж, мэдээллийг өгч ажиллав.

3.3.14.Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ.

3.3.14.1.Үндэсний бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөр, төрийн байгууллага, томоохон аж ахуйн нэгжүүдэд чанар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх тогтолцоог хөгжүүлэх, хэрэглэгч, үйлдвэрлэгчийг холбоно.

Биелэлт: “Оюу толгой” компани, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-т хөдөлмөр хамгааллын гутал ажлын арьсан бээлий, баяжмал савлах зориулалттай шуудай, бэлдэц материалыг нийлүүлсэн. Бүтээгдэхүүн үйлчилгээг стандартын тохирлын үнэлгээнд хамруулах, үнэлгээчин аудитор бэлтгэх сургалтыг 2020.11.25-12.04 өдөр зохион байгуулж 45 хүн албан ёсны эрхтэй тохирлын үнэлгээний шинжээчээр бэлтгэлээ. “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл 2021”, “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021”, “Улаанбаатар Түншлэл-2021”, “Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн-2021” үзэсгэлэн худалдаа зохион байгуулав. “Монгол хүнс-Монгол бараа 2022”, “Монголын худалдаа, хөрөнгө оруулалт, өв соёлын чуулган-2022”-ыг АНУ-ын Вашингтон ДС хотод, “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2022”, “Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн-2022”, Парис хотноо 2022.07.05-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хувцас загварын чиг хандлагыг тодорхойлогчдод зориулсан “Premiere Vision Paris 2022”, Канад Улсын Торонто хотноо 2022.11.07-09-ний өдөр сүлжмэл хувцасны “Apparel Textile Sourcing” ОУ-ын үзэсгэлэнд зохион байгуулах, үйлдвэрлэгчид оролцоход дэмжлэг үзүүлэн ажиллав. “Эх оронч худалдан авалт-үндэсний үйлдвэрлэл 2023” үзэсгэлэн, “Дэлхийн экспортыг дэмжих форум 2023”, Монгол гэр үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа, “Монгол-Хятадын Экспо” ӨМӨЗО-ны Хөх хотод, “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2023”, “Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн-2023”, “Монголын өдрүүд 2023” АНУ-ын Чикаго хотод зохион байгуулах, үйлдвэрлэгчид оролцоход дэмжлэг үзүүлэн ажиллав.

3.3.14.2.Хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн судалгааг явуулж, тэднийг хөгжүүлэх, чадавхжуулах "Үндэсний ханган нийлүүлэлт" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Биелэлт: "Үндэсний ханган нийлүүлэлт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хамтран

ажиллах саналыг 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/1425 дугаартай албан бичгээр Дэлхийн банк группийн суурин төлөөлөгч Руфат Алимардановт хүргүүлсэн. Мөн "Linkages" буюу ханган нийлүүлэлтийн холбоостой холбогдох судалгааны материалуудыг Дэлхийн банк группийн Олон улсын санхүүгийн корпорацын төлөөллүүдээс авч, хөтөлбөрийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллага болох Үндэсний хөгжлийн газрын Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн албан хаагчдад сургалт зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Уул уурхайн салбарын ханган нийлүүлэлтийн талаарх үндсэн ойлголтууд болон ханган нийлүүлэлтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, холбогдох цахим системийг ашиглалтад оруулсан улсуудын туршлагын талаар судалгаа хийсэн.

"Монголын ЖДҮ" төслийг Германы хамтын ажиллагааны нийгэм/GIZ/-тэй хамтран хэрэгжүүлсэн. Дэлхийн бусад орнуудын "Үндэсний ханган нийлүүлэлт" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн талаарх холбогдох судалгааг хийсэн. Улсын Их Хурлын түр хорооны Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолд санал өгч батлуулсан. Тус тогтоолын 4.1-т хөгжлийн бодлого, төлөвлөлт болон бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан бүс нутгийн онцлог, нөөц боломжид тулгуурлан кластерын зохион байгуулалттай, зах зээлд өрсөлдөх чадвартай, салбар хоорондын уялдааг хангасан хүнсний чиглэлийн үйлдвэрлэл, худалдааны нэгдсэн тогтолцоо, кластерын сүлжээг бүрдүүлэх; 4.3-т хүнс, хөдөө аж ахуйн салбарын цахим системүүдийг уялдуулан хүнсний хангамж, аюулгүй байдлыг хянах нэгдсэн цахим системийг бий болгох заалтууд тусгагдсан. Мөн 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Төрийн ордонд "Хүнс үйлдвэрлэгчдийг дэмжих санхүүжилт, кластерын бодлого"-ын талаар танилцуулсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар холбогдох 5 аймагт "Орон нутгийн нөөцөд тулгуурласан үйлдвэр үйлчилгээг хөгжүүлэх" чиглэлээр бодлогын санал танилцуулсан.

3.3.15.Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

3.3.15.1.Байгаль орчин, нийгэмд ээлтэй, ногоон төслүүдийн санхүүжилтийг дэмжих, ногоон санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэх судалгаа хийж, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх замын зураг, төлөвлөгөө боловсруулан, ногоон хөгжлийг дэмжих санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ.

Биелэлт: Ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх ажлын хүрээнд 2019-2023 онд нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс зарцуулж, 1,275 иргэн, аж ахуйн нэгжид ногоон зээл олгожээ.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын хамтарсан 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-82/157/68/А26 дугаар тушаалаар "Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг"-ийг баталсан бөгөөд БОАЖЯ-ны хамтран хэрэгжүүлэх 14 арга хэмжээ тусгагдсан байна. Хувийн хэвшлийн оролцоотой "Тэрбум мод" сангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд 2023 оны байдлаар санд 5 орчим тэрбум төгрөг төвлөрсөн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих хүрээнд байгаль хамгаалал, ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, агро-ойн аж ахуйн чиглэлээр нийт 34 төсөл шалгаруулж, 3 төслийг хэрэгжүүлсэн.

3.3.15.2.Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийг санхүүжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

Биелэлт: 2020-2023 онд Жайкагийн "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, Байгаль

орчныг хамгаалах Хоёр-үе шаттай зээлийн төсөл"-өөс 34.0 тэрбум 63 төсөлд дэмжлэг үзүүлснээс байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай 3.4 тэрбум төгрөгийн 7 төсөл дэмжигдсэн ба 124 ажлын байрыг /хадгалсан, нэмсэн/ нэмэгдүүлсэн байна. Мөн 2023 онд ЖДҮХС-ийн эх үүсвэрээс хүлэмж, тэрбум мод салбарт 4.4 тэрбум төгрөгийн 56 төсөл тэнцэж, 274 ажлын байрыг хадгалж, 197 шинэ ажлын байрыг нэмэгдүүлсэн.

Аялал жуулчлал

3.4. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.4.1. Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий, "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II"-ийг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Увс, Ховд зэрэг аймагт хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.

3.4.1.1. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-1"-ийг Хөвсгөл, Хэнтий аймагт хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2020 онд Хөвсгөл аймагт баригдах 37.9 км авто замын трасс, авто зогсоолуудын байршлыг баталгаажуулж, шийдвэр гаргасан. 2021 онд ХНБЦГ-т баригдах 37.9 км авто зам, 7 авто зогсоолын барилгын ажил гүйцэтгэгч Бээжин Юни-Констракшн Групп ХХК-тай 21/311 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. 2023 онд 3-н трасс дагуух 37.9 км авто замын ажлын хүрээнд нийт 8 км асфальт бетон хучилт болон 8.9 км буталсан чулуун суурийн ажил хийгдсэн. Нийт авто зам, зогсоолын ажил 63% гүйцэтгэлтэй байна. Тусгай зориулалтын завь, дагалдах хэрэгслийн хамт хүлээн авч, 2023 оны 08 сарын 20-нд завинуудыг албан ёсоор Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн. Хэнтий аймагт байгууламжийн ажлууд үргэлжилж байна.

3.4.1.2. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-2"-ийг Баян-Өлгий, Увс, Ховд аймагт хэрэгжүүлнэ /2021-2027/.

Биелэлт: Уг төслийг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хэрэгжүүлэхээр ЗГҮАХ-т тусгагдсан хэдий ч төсөл 1-ийн үр дүнг харах, зээлийн хэлэлцээр УИХ-аар соёрхон батлуулах ажил удаашралтай байна.

3.4.1.3. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл"-ийг Архангай, Өвөрхангай аймагт хэрэгжүүлнэ.

Биелэлт: Судалгааны ажлын шатанд ажиллаж байна. АХБ-аас 1 болон 2 дугаар төслүүд эхлэх, ажлын явцын байдлаас шалтгаалж 3 дугаар төслийг эхлүүлэх эсэхийг хэлэлцэх талаар мэдэгдсэн. Төсөв санхүүжилтээс шалтгаалж ажил удаашралтай байна.

3.4.2. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор"-ын ажлуудыг цогц байдлаар дуусгаж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.4.2.4. Хэнтий аймгийн Батноров суманд "Хүлэг Боорчи-Андлалын өргөө" цогцолбор байгуулна.

Биелэлт: Хэнтий аймгийн Батноров суманд "Хүлэг Боорчи-Андлалын өргөө" цогцолборын бүтээлийн зохиогч Д.Эрдэмбилэг агсны ар гэрээс "Бүтээл ашиглуулах гэрээ"-г цуцлах хүсэлт гаргасны дагуу цогцолборыг буулгасан.

Хэнтий аймгийн нутгийн зөвлөлийн санаачилгаар Андлалын өргөөний суурин дээр МУГЗ уран барималч А.Очирболдын загвараар Ядмын Мөнхчулуун сангийн санхүүжилтээр "Тэнгэрийн андгай" хөшөөт цогцолборын ажил бүрэн хийгдэж дууссан ба цогцолборыг түшиглэн жил бүр "Талын түмэн адуу" эвент арга хэмжээг зохион байгуулж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон ашиглалтад оруулаад байна.

3.4.2.5.Хэнтий аймгийн Норовлин суманд "Шихихутаг-Их засаг" цогцолбор байгуулна.

Биелэлт: Уг цогцолборын үндсэн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг БОАЖЯ ЭЛ СИ БИ ХХК-тай 2019.07.18-2022.11.30-ны хооронд 1,847.9 сая төгрөгөөр хийхээр байгуулсан. Нийт 1365.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Их засаг Шихихутаг цогцолборын гадна цахилгааны ажил гүйцэтгэх гэрээг Хэнтий аймаг Хөх өндөр уул ХХК-тай хийж 290.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, комисс хүлээн авсан. 5 багц ажлын гүйцэтгэл 70% байна.

3.4.2.6.Хэнтий аймгийн Биндэр суманд "Их хуралдай цогцолбор" байгуулна.

Биелэлт: Биндэр сумын "Их Хуралдай" цогцолборын хүрээнд тусдаа гэрээтэй Барилга угсралт, Гадна цахилгаан, Доторх уран бүтээлийн ажил, Зоорины давхрын ажил, Гадна тохижилт гэсэн 5 ажил бүрэн хийгдэж дууссан. Барилгыг ашиглагч талд хүлээлгэж өгөх ажил хүлээгдэж байна. Барилгын ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 04-06-ны хооронд Улсын комисс ажиллан дүгнэлт гарсан.

3.4.2.7.Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд "Монголын нууц товчоо" цогцолбор байгуулна.

Биелэлт: Дэлгэрхаан сумын "Монголын нууц товчоо" цогцолборын барилга угсралтын ажлын үүтгэл, гоёлын бичээс, гадна шат довжооны ажлаас бусад ажлууд дууссан Металл каркас бүрэн дууссан Дотор интерьер, дотор цахилгаан халаалтын монтаж, холбоо дохиолол, гэрэлтүүлгийн шугамын ажлууд хийгдэж дууссан комисс ажиллуулах хүсэлт өгөөд байна. байна. Гадна тохижилт, угтах үйлчилгээний барилгын А, Б блокийн каркас болон түшиц ханын цутгалт, дулаалга, дээвэр, газар шорооны ажил, холбоо дохиолол, цэвэр бохир усны шугам, гадна хашааны ажлууд дууссан, ногоон байгууламж, зам талбайн ажил дулааны улиралд хийгдэнэ. Тус цогцолборын барилгын интерьерийн ажлыг хэсэгчлэн 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улсын комисс хүлээн авсан.

3.4.3.Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ.

3.4.3.1.Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулалтыг хийж, шалгарсан "Пластик центр" компани хамгаалалт, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэхүү ажлын үр дүнд гадаад, дотоодын аялагч, жуулчдын ая тухтай нөхцөлийг хангасан хөрсөнд шингээлтгүй эко ариун цэврийн байгууламж, ахуйн болон бусад хог хаягдлын цэг, ангилсан бага оврын хогийн савнууд, 155 м явган хүний сайжруулсан зам, эко хавтан бүхий талбай, амрагчдын

сүүдрэвч, сандал, эрчим хүчний хэмнэлттэй гэрлүүд, үл хөдлөх дурсгалуудыг хамгаалсан мод, олсон хашлага, мэдээллийн самбар, Монголыг хамгийн том тогоог хүрээлсэн суурийг хийж гүйцэтгэн Төв аймгийн ажил хүлээлцэх комисст хүлээлгэн өгсөн.

3.4.4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.

3.4.4.1. НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

Биелэлт: НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэрээний төлбөр цар тахлаас үүдэлтэй хугацаандаа хийгээгүй тул ажлыг НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага хийхгүй болохоо илэрхийлсэн. Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан "Монгол Улсын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө"-г 8 зорилт 28 дэд зорилттойгоор боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор БНСУ-ын жуулчдыг визийн шаардлагаас чөлөөлсөн шийдвэрийг гарган, энэ оны хувьд аялал жуулчлалын голлох зах зээлийн орныг Азийн орон гэж тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласан. Зочлох жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ болон Аялал жуулчлалын салбарыг сэргээх стратегийг боловсруулан Засгийн газрын 2023 оны 6 сарын 07-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Монголд зочлох жилийн төлөвлөгөөг 2023 онд хэрэгжүүлж ажилласан бөгөөд үр дүнд нь Монгол Улсад ирсэн жуулчдын тоо 635 мянгад хүрсэн төдийгүй, цар тахлын дараа богино хугацаанд бүрэн сэргэсэн салбарын нэгд зүй ёсоор тооцогдож, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа эргэн хэвийн байдалдаа ороход чухал нөлөө үзүүлсэн.

3.4.4.2. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, батлуулна.

Биелэлт: Монголд зочлох жилийн хүрээнд нэн тэргүүнд хэрэгжүүлсэн арга хэмжээ нь эрх зүйн орчны шинэчлэл байсан бөгөөд 23 жилийн дараа Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн боловсруулж 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан. Хууль шинэчлэгдсэнтэй холбоотой дагалдан гарах дараах журмын төслүүдийг боловсруулаад байна. Үүнд:

1. Жуулчны хөтөч тайлбарлагчийн үнэмлэх олгох, ур чадварын зэрэглэл тогтоох
2. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэл тогтоох журам
3. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журам
4. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах журам
5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны ажиллах журам
6. Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журам
7. Аялал жуулчлалын байгууллагын хариуцлагын даатгалын журам.

3.4.5. Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ.

3.4.5.1. Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлнэ.

Биелэлт: Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлэх ажлын хүрээнд Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын дагуу Хөх сувд мөсний баяр, Мөнгөлөг шагшуурга цас мөсний баяр, Тэмээний баяр, Бүргэдийн баяр, Талын түмэн адуу, Торгоны зам-Хархорин, Айргийн баяр, Морин хуур уртын дууны их наадам, Айс фестиваль олон улсын мөсөнд авиралтын тэмцээн, Монгол туургатны Харвуул их наадам зэрэг 11 эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн ажилласнаас гадна бусад 58 эвент арга хэмжээтэй хамтран ажилласан болно.

Соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилго бүхий “Нүүдэлчин Монгол-2023” дэлхийн соёлын фестиваль Налайх дүүргийн Тайж хайрхны бэлд 2023 оны 08 дугаар сарын 18-20-нд зохион байгуулагдсан. Фестивальд 21 аймаг болон нийслэлийг хамруулсан 22 отог бүхий Монгол Улсын биет бус соёлын өвийн долоон ай савд хамаарах 362 өвийг танилцуулж байгаагаараа онцлог болсон. Фестиваль зохион байгуулагдах хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, харуул хамгаалалт, зохицуулалтад дэмжлэг үзүүлэх, эрүүл ахуйн хяналт тавих, хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ авч, ирсэн жуулчид, аялагчид, иргэдэд “Welcome to Mongolia” цогц арга хэмжээний талаар болон фестивалийн талаар мэдээлэл өгөхөөр Мэдээллийн төв ажиллуулсан.

3.4.6. Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.4.6.1. Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 200 км тутамд үйлчилгээний цогцолбор, 100 км тутамд амрах талбай байгуулах төслийг эхлүүлнэ.

Биелэлт: 2022 онд дараах байршлуудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто зам дагуух үйлчилгээний цогцолборыг байгуулж ашиглалтад оруулсан. Үүнд:

1. Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд “Инсун мод” ХХК
2. Завхан аймгийн Сонгино суманд “Титан Би” ХХК
3. Архангай аймгийн Цэнхэр суманд “Заяын өгөөж” ХХК
4. Булган аймгийн Хутаг өндөр суманд “Уньтын рашаан” ХХК
5. Төв аймгийн Баянцагаан суманд “Мандах бадрах булаг” ХХК

Дээрх цэгүүдийг БОАЖЯ болон “АТҮТ” ТӨҮГ хамтран хот хоорондын нийтийн тээврийн хуваарь, аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээ авах байгууллагуудын жагсаалтад оруулан ажиллаж байна.

3.4.6.2. Жуулчид голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэгүүдийг байгуулна.

Биелэлт: Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон бусад жуулчдын гол зорин очдог газруудад ариун цэврийн байгууламж бүхий отоглох хоноглох цэгийг үе шаттай 2021-2023 оны хооронд нийт 16 отоглох цэг байгуулагдсан байна. 2021 онд 5, 2022 онд 10, 2023 онд 1 отоглох цэгийг тус тус байгуулсан.

Жуулчдын гол зорин очдог байгалийн үзэсгэлэнт газруудад хүрээлэн буй орчныг хамгаалах, иргэд, жуулчдын тав тухтай аялах нөхцөлийг тодорхой хэмжээгээр бүрдүүлэх зорилгоор цаашид отоглох цэгүүдийг бий болгох шаардлага байгаа тул байгалийн нөхцөл, байдал, даацад нь тулгуурлан отоглох цэгүүдийг байгуулахад харгалзах зураг төсвийг 2022 онд боловсруулсан. Тухайлбал:

- Бага буюу 5 хүртэл майхантай иж бүрдэл бүхий отоглох цэгийн төсөв 149 сая;
- Дунд буюу 25 хүртэл майхантай иж бүрдэл бүхий отоглох цэгийн төсөв 374 сая;

- Том буюу 50 хүртэл майхантай иж бүрдэл бүхий отоглох цэг нь 419 сая төгрөгийн төсөвтэй байхаар батлагдсан байна.

3.4.6.3. Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад аялал жуулчлалын нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох цогц судалгааг хийнэ.

Биелэлт: Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021 онд Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад аялал жуулчлалын нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох цогц судалгааг “Монгол улсын аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн талаарх бодит мэдээ мэдээлэл, тоо баримтыг цуглуулж, нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэх судалгаа”-ны хүрээнд Японы ЖАЙКА-тай хамтран хийж гүйцэтгэсэн. Судалгааны хүрээнд аялал жуулчлалын 4 чиглэл ялангуяа Өмнөговь, Дорноговийн чиглэлд аялал жуулчлалын нөөц, хүний нөөцийн нөхцөл байдал, статистик болон хууль эрх зүйн орчны судалгаа хийгдэж аялал жуулчлалын хөгжлийн бодлого, зөвлөмжийг гаргасан.

3.4.6.4. Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх MARS-V төслийг хэрэгжүүлнэ. /Survival буюу даван туулж, тэсэж гарах чадвар олгох мэргэжлийнхэн болон сонирхогчдод зориулсан MARS-V академи байгуулах/

Биелэлт: Марс-Ви төслийн танилцуулгыг олон нийт болон гаднын хамтрагчдад 17 удаа, МУ-ын Ерөнхий сайдын АНУ хийсэн айлчлалын үеэр 2023.08.03-нд Марс-Ви төслийн Технологи хөгжүүлэлтийн багийн ахлагч НАСА-ийн удирдлагуудтай хийсэн уулзалтад Марс-Ви төслийг танилцуулсан.

Марс-Ви төслийн гишүүд Д.Батбилэг, Б.Эрдэнэбаяр нарын Марсын Арт “Be Ready” уран бүтээлийн үзэсгэлэн 2023 оны 05 дугаар сард гаргасан. Марс-Ви төслийн Марсын технологи хөгжүүлэлтийн паркт зориулж, Сонгинохайрхан дүүрэгт 8623.1мкв газрыг 60 жил эзэмших эрхтэйгээр авсан. МУ-ын Ерөнхий сайдын 2022 оны 119 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан МУ-ын Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийн 3 дахь удаагийн хурлыг 2023.10.13-ны өдөр зохион байгуулав. Монголын сансрын судалгаа хөгжүүлэлтийн төв ТББ нь хамтын ажиллагааны санамж бичгийг Марсын нийгэмлэгтэй 2023 оны 04 сард, АНУ-ын Колорадогийн их сургуультай 09 сард байгуулав. Марс-Ви төслийн “Сансрын хоол” хөгжүүлэлтийн баг 09 сард байгуулагдаж, ТЭСО групптэй хамтарч Альфа хөтөлбөрт туршигдах Марсын Аналог хоол хүнс бэлэн бүтээгдэхүүнийг хийсэн.

“Дэлхийн Сансрын 7 хоног Монголд” үйл ажиллагааг 10 дугаар сарын 4-10-ны өдөр хамтран зохион байгуулагчаар оролцож, тус үйл ажиллагааны үеэр “Space networking event”-г зохион байгуулсан. АНУ-ын Аризонагийн Их сургуульд 2023 оны 10 сард болсон Марс нийгэмлэгийн 26 дахь удаагийн чуулганд Марс-Ви төслийн үйл ажиллагааны талаар илтгэл тавьж оролцсон. Япон Улсын Токио хотноо 2023.11.07-09-нд зохион байгуулагдсан Олон Улсын Марс Судлалын ажлын хэсгийн хуралд 3 гишүүн оролцож, төслийн үйл ажиллагааг танилцуулж, 2024 онд Монголд энэхүү хурлын зохион байгуулах санал гаргасан.

3.4.7. Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.4.7.1. “Цайны зам” хил дамнасан аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын аялал жуулчлалын сайд нарын 7 дугаар уулзалт БНХАУ-ын Ухань хотноо хуралдаж Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, БНХАУ-ын Соёл, аялал жуулчлалын яам, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам хамтран “Түмэн газрын цайны зам”-ын хил дамнасан аялал жуулчлалын

маршрутыг байгуулах, сурталчлах хамтын ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Бээжин хотноо байгуулсан. Энэхүү хэлэлцээрээр хоёр улсын хоорондын аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор БНХАУ-ын бүлэг жуулчид Монгол улсын хил орчмын аялал жуулчлалын зорилгоор холбогдох боомтоор зорчих асуудлаар тохиролцоонд хүрсэн. 2023 оны 12 дугаар сарын байдлаар БНХАУ-с 126,000 жуулчин Монгол Улсад ирсэн байна

3.4.8."Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.

3.4.8.1.Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.

Биелэлт: Аялал жуулчлалын салбарын цахим номын сан бий болгох зорилгоор цахим номын сан байрших Вэбсайтын загвар боловсруулагдаж, домэйн холболт хийгдсэн. Ном сурах бичиг, материал, гарын авлага, судалгааны материалуудыг судалж, цуглуулан, www.mto.mn вэбсайтад байршуулсан.

Аялагчдыг нэгдсэн мэдээллээр хангах, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл авах, захиалга хийх боломжийг бүрдүүлсэн ""Feel Mongolia"" гар утасны аппликейшний хөгжүүлэлтийг хийсэн.

"ХЯМД АМАР" цахим үзэсгэлэнг 3 сарын турш зохион байгуулж, 100 орчим зочид буудал, жуулчны бааз, амралтын газар, сувиллууд нэгдэж 200 сая төгрөгийн, нийтдээ 1162 захиалга хийсэн байна.

"Манай аймгаар аялаарай" сэдэвт 21 аймгийн сурталчилгааны видео шторк 21 ширхэг хийн идэвхжүүлэлтэд ашигласан.

Дотоодын аялагчдад аяллын боловсрол олгох "Ээлтэй Аялал Энэ Зуны Тренд" цахим аян зохион байгуулсан.

Feel Mongolia аппликейшн идэвхжүүлэх зурагт самбар, постер, хаштаг, сурталчилгааны видео шторк, телевизийн нэвтрүүлэг зэргийг бэлтгэн гаргасан.

21 аймгийн алдартнуудтай хамтран сурталчилгааны шторк хийж, аялал жуулчлалын цахим үзэсгэлэнг зохион байгуулсан.

3.4.9.Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.

3.4.9.1.Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулж, аялал жуулчлалын үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулна.

Биелэлт: БНСУ-ын Аялал жуулчлалын төрийн өмчит байгууллага /КТО/-тай хамтран хэрэгжүүлж буй "Аялал жуулчлалын сургалтын төв байгуулах" төслийн барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай байгаа бөгөөд энэ ондоо багтаан дуусгаж, хүлээлгэж өгөхөөр төлөвлөсөн. Барилгын ажлын гүйцэтгэлтэй холбоотой Монгол Улсын талаас гадна дэд бүтцийн ажилд шаардагдах төсвийг шийдвэрлүүлэх эхний ажлыг хийгээд байна. Төсөв батлагдсантай холбоотойгоор Аялал жуулчлалын сургалтын төвийн барилгын цэвэр, бохир ус, дулааны шугам, цахилгаан, мэдээлэл холбооны сүлжээтэй холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/213 дугаар тушаалаар байгуулагдаж, ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг боловсруулан tender.gov.mn-д байршуулан худалдан авах ажиллагааг зарласан. БОАЖЯ/202307004 дугаартай тендерийн дагуу Рутан ХХК-тай гэрээ байгуулан

“Аялал жуулчлалын сургалтын төвийн барилгын цэвэр, бохир ус, дулааны шугам, цахилгаан, мэдээлэл холбооны шугам сүлжээтэй холбох ажил”-ыг гүйцэтгэхээр болсон ба гадна тендерийн ажил 80 хувьтай явагдаж байна.

Хүний нөөцийг чадавхжуулах дэмжих ажлын хүрээнд БОАЖС, БШУС нарын хамтарсан А/318, А/333 тушаалаар аялал жуулчлалын байгууллагад дадлага хийж буй их дээд сургуулийн оюутнуудын хичээлийн эхлэх хугацааг 10 дугаар сарын 15 болтол хойшлуулсан нь нэг талаас ажлын байранд дээр дадлагажих, нөгөө талаас байгууллагууд хүний нөөцөөр хангагдах боломжийг бүрдүүлсэн юм.

Эрчим хүч

3.5.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.

3.5.1.Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ:

3.5.1.1.Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар нэмэгдүүлэн шинэчилнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн 01 тоот тогтоолоор “ДЦС-4” ТӨХК-ийн турбоагрегат №1-4-ийг шинэчлэх төслийг ОХУ-ын зээлээр хэрэгжүүлэх шийдвэр гарч, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018.06.14-ний өдрийн 32/20 тоот зөвлөмжөөр дэмжсэн. Шийдвэрийн дагуу ОХУ-ын Екатеринбург хотын Уралын турбины заводтой 2018.06.19-нд “ДЦС-4” ТӨХК-ийн турбоагрегат №1-4-ийг шинэчлэх ажлын №79-16/215-2018/ Г/2018-07 тоот гэрээ байгуулсан. Гэрээний дагуу төслийг 3 үе шаттай хэрэгжүүлж, 2019 онд 1,2-р шатны ТАН№1, ТАН№4-ийн техникийн шинэчлэлтийг хийсэн. Төслийн 3-р шатны ТАН№2, ТАН№3-ын техникийн шинэчлэлийг 2020-2021 онд хэрэгжүүлж, 2021.01.11-ний өдөр дуусган туршилт хийсэн. Шинэчлэлийн төсөлд хамрагдсан дөрвөн турбоагрегатад техникийн комисс үе шаттайгаар ажиллаж, улмаар ТНБД-ын 2021 оны 12 дугаар сард Улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан.

Төсөл хэрэгжсэнээр Дулааны 4 дүгээр цахилгаан станцын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 89 МВт-аар, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл 75 Гкал/ц-аар тус тус нэмэгдэж эрчим хүчний нэгдсэн системд нийлүүлж байна.

3.5.1.2.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Төслийн БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2021 онд Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулсан.БНХАУ-ын ЭКСИМ банктай Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулахаар МУ-ын Засгийн газраас төлөөлөх эрх бүхий этгээдийг томилсон бөгөөд Монгол Улсын талаас хамаарах бэлтгэл ажил бүрэн хэрэгжиж, БНХАУ-ын талаас хүлээгдэж байна.

Засгийн газрын 2023.03.29-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор төсөлд шаардагдах дотоодын санхүүжилтийг 2024 оны улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.2023 онд төслийн нөлөөлөлд өртөж буй нийт айл өрхтэй эд хөрөнгийн нөхөн олговрын гэрээг 100% байгуулж нөхөн олговор олголт Увс, Ховд аймагт 100%, Баян-Өлгий аймагт 96.5% байна.Эд хөрөнгийн бус нэг удаагийн нөхөн олговор олгох асуудлыг ЗГ-ын 2023.06.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 246-р тогтоол гарсан. Улмаар нөлөөлөлд өртсөн иргэн бүрд нэг удаагийн нөхөн төлбөр олгох, тайлагнах түр журмыг Эрчим хүчний сайдын 2023.10.16-ны өдрийн А/228 дугаар тушаалаар баталж журмын дагуу нөхөн олговор олгох ажил Ховд аймаг 100% хийгдсэн бол Увс аймагт гэрээ байгуулах ажил

100% хийгдэж 80.5% олгогдсон, Баян-Өлгий аймагт гэрээ байгуулах ажил 80.5% хийгдэж 28.5 хувьд нь олгосон.

ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран төслийн барилгажих талбарт хамаарах археологийн 23 дурсгалыг авран хамгаалах ажлыг зохион байгуулсан. Гүйцэтгэгч компани геологи, геофизикийн судалгааны ажлыг хийсэн, зураг төсөл хийгдэж байна. ЦДАШ-ын ажил хийгдсэн. Ашиглалтын 40 км замын 10 км-т далангийн суурь тавьж, төслийн талбарт 6 км зам шинээр засаж, бараа материалын агуулах, гаалийн баталгаат агуулах, төмөр модон материал бэлдэх үйлдвэр, техник засварын цехийн талбайг бэлтгэж, үндсэн кемпийн 3 барилгыг барьж, голын түр гүүрний тулгууруудын суурийн цутгалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

3.5.1.3. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөнө.

Биелэлт: Засгийн газрын 2018.07.04-ний өдрийн 29 дүгээр тэмдэглэлээр Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийн хөрөнгө оруулалтыг Хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлэх шийдвэр гарсан. Хөгжлийн банкны шаардлага хангасан ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ерөнхий үнэлгээг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, шалгарсан БНХАУ-ын ТВЕА компанитай гэрээг байгуулсан.

Төслийн нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийг судлан 3.9 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүний алдагдал үүссэнийг 2023.06.26-ны өдөр гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гэрээний үнийн дүнг 2,421,751 ам.доллаар нэмэгдүүлэн 81,910,017 ам.доллар болгон өөрчилсөн. 2024 оны Улсын төсөвт үлдэгдэл төлбөр болох 30.9 тэрбум төгрөгийг (ханшийн зөрүүг тооцсон нэмэгдэл 11.3 тэрбум төгрөг багтсан) тусгасан.

Төслийн 2023 оны БУА-ыг 03-р сарын 24-өөс эхлүүлсэн. БУА-ын гүйцэтгэл 92%. 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 105,286.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон, үүнээс Улсын төсвөөс 28,822.3 сая төгрөг, БНХАУ-ын Хөгжлийн банкнаас 76,463.9 сая төгрөг тус тус санхүүжсэн.

БНХАУ-ын Хөгжлийн банкны санхүүжилт олгогдохгүй удааширснаас төслийн хэрэгжилтэд хүндрэл үүсгэж гэрээт хугацаанд ашиглалтад оруулах боломжгүй нөхцөл үүссэн ба 2024 оны 02 дугаар сард төслийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Төслийн хүрээнд баригдсан 110 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж, үйлдвэрийн бэлтгэл трансформатор, 0.4кВ, 6кВ хуваарилах байгууламжуудын БУА улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж 2023.12.06-ны өдөр техникийн комисс ажиллан туршилтын хүчдэлд залгасан.

3.5.1.4. Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

Биелэлт: ЗГ-ын 2020.11.11-ний өдрийн хуралдаанаар ТТДЦС ТӨХХК-ийн хувь эзэмшлийн асуудлыг шийдвэрлэж, ЭТТ ХК-д 30 хувийг эзэмшүүлэх замаар төслийн хөрөнгө оруулалтын 30% шийдвэрлэгдсэн. Төслийг эрчимжүүлэхийн тулд 300МВт+150МВт гэсэн 2 үе шатад хуваан эхний ээлжид 300МВт хүчин чадлаар ашиглалтад оруулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа “ЕРС+Financing” хэлбэрээр санхүүгийн нээлттэй нөхцөлтэйгөөр зохион байгуулах, “ЭТТ” ХК-д I үе шат 300 МВт-ын төслийн нийт хөрөнгө оруулалтын 30 хувийг санхүүжүүлэх асуудлыг ЗГ-ын 2023.04.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 132 дугаар тогтоол гарсан.

450 МВт-ын хүчин чадалтайгаар боловсрогдсон ТЭЗҮ-д тодотгол хийж “Тавантолгойн 300+150 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол”-ыг ЭХЯ-ны ШУТЗ-ийн 2023.05.15-ны өдрийн хурлаар

хэлэлцэн баталсан. “Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавантолгой 450МВт-ын дулааны цахилгаан станцын эхний ээлжийн 300МВт-ын гүйцэтгэгч болон санхүүжүүлэх эх үүсвэрийг сонгон шалгаруулах” тендерийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зарлаж 2023.07.27-ны өдөр нээсэн. Тендерийн хүчинтэй хугацаанд тендерт оролцогчоос 2 удаа гомдол гарсан тул үнэлгээний хорооны 2023.10.20-ны өдрийн шийдвэрээр тендер хүчингүй болсон. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд:

- “Усны нөөцийн зөвлөл”-ийн 2023.07.06-ны өдрийн хурлаар станцын усны эрэл хайгуулын судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлж, БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023.08.11-ний өдрийн А/248 дугаар тушаалаар Тавантолгой дулаан цахилгаан станцын усны нөөцийг 25 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн С зэргээр 13л/сек буюу 1,123.2 м3/хоногоор батлуулсан.
- Газрын тухай хуулийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах станцын нийт 90.2 га газарт Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраар батлуулсан.
- Тавантолгой ДЦС-Тавантолгой дэд станцтай холбогдох 21 км ЦДАШ-ын газар эзэмших гэрчилгээ авах асуудлыг Цогтцэций сумын ИТХ-ын (2023.12.14) хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн.

3.5.1.5. Төвийн, зүүн болон говийн бүсийн нүүрсний орд газруудыг түшиглэн 300-400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт 300 МВт-ын цахилгаан станцын төслийг хувийн хөрөнгө оруулалтаар "Цэцэнс майнинг энд энерги" ХХК хэрэгжүүлж байна. Хөрөнгө оруулалтын гэрээ 2018 онд байгуулагдсан. Барилга угсралтын ажлыг 2022 оны 7 дугаар сараас эхлүүлсэн. Эхний 150 МВт-ын блокыг 2024 онд, хоёр дахь блокыг 2025 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Компанид гаалийн баталгаат талбай ажиллуулах зөвшөөрлийг олгох хүсэлтийг Монгол банканд ЭХСайдын 2023 оны а/3854, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх хүсэлтийг ХНХЯ-д ЭХЯ-ны ТНБД-ын 2023 оны в/3813 тоотой тус тус хүргүүлсэн.

Станцын барилга угсралтын ажил 35%-тай, цахилгаан станцыг төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбох "Багануур" дэд станцын өргөтгөл, "Багануур Бөөрөлжүүт" чиглэлийн 71.5 км ЦДАШ барих барилга угсралтын ажлууд эхэлсэн.

3.5.1.6. 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барина.

Биелэлт: АХБ-ны зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур” төслийн хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Сонгино дэд станц”-ын дэргэд том чадлын хуримтлуурын байгууламжийг угсарч суурилуулан тус дэд станцад холбохоор АХБ-тай байгуулсан санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт 2020 оны 02 дугаар сард нэмэлт өөрчлөлт орж, УИХ-аас соёрхон баталснаар уг төслийн санхүүжилт шийдвэрлэгдсэн. АХБ-тай зээлийн тусгайлсан гэрээг 2020.05.14-ний өдөр байгуулсан.

Үндсэн тоноглолууд болох батарей, эрчим хүчний хувиргуур, трансформаторууд болон бусад тоноглолуудын угсралт суурилуулалтын ажил дуусаж техникийн комисс 2023.11.10-аас эхлэн үе шаттайгаар ажиллаж, эхний тоноглол болох Сонгино дэд станцын хуваарилах байгууламжийн өргөтгөлийг 2023.11.10-нд хүчдэлд залгасан. Батарей хуримтлуурын байгууламжийг 2023.12.08-нд хүчдэлд залган цэнэглэж, 2023.12.09-өөс эхлэн хуримтлуулсан эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлж эхлээд байна.

Туршилт тохируулгын ажил 14 хоног хийгдэх ба энэ хугацаанд сүлжээнд 70 МВт хүртэл чадлаар 207 МВт.ц хүртэл хэмжээний эрчим хүч нийлүүлсэн, удирдлагын системийн

туршилт тохируулга, сайжруулалт хийгдэж байна. Батарей хуримтлуурын байгууламжийг хүчдэлд залгахтай холбогдон ашиглалтын талаарх сургалтууд хийгдсэн. Төслийн нийт хэрэгжилт 93%.

3.5.1.7. Амгалангийн дулааны станцын хүчин чадлыг хосолмол 50МВт-аар нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2015 онд ашиглалтад орсон, хотын зүүн хэсгийг дулаанаар хангаж байгаа Амгалан дулааны станцын дэд бүтцийг түшиглэн 50 МВт-ын дулаан цахилгаан хослон үйлдвэрлэх блок нэмж, суурилагдсан чадлыг 50 МВт-аар нэмэх төслийн санхүүжилтийн эх үүсвэрийн талаар Хөгжлийн банкт хамтран ажиллаж, банкны шаардлагын дагуу ТЭЗҮ-д нэмэлт оруулсан. 2021 онд Хөгжлийн банканд зээлийн судалгаа эхэлсэн хэдий ч Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд Амгалан дулааны станцын төслийн хөрөнгө оруулалтын талаарх арга хэмжээ тусгагдаагүй тул Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрт хүндрэл үүссэн. Иймд тус дулааны станцын үйлчлэх хүрээнд буюу Улаанбаатар хотын зүүн бүсэд 232 Гкал/ц дулааны ачаалал хүлээгдэж, ойрын хугацаанд шийдвэрлэх нь эрчим хүчний салбарын болон нийслэлийн өмнө нэн тулгамдсан асуудал байгаа тул тус станцыг одоогийн ажиллаж байгаа зуухтай нь ижил 100 Гкал/ц үйлдвэрлэх хүчин чадалтай 1 зуухаар өргөтгөх нь богино хугацаанд хэрэгжих хамгийн боломжит хувилбар гэж үзсэн.

Амгалан дулааны станцыг 116 МВт (100 Гкал/ц) хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх төслийн БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2022 онд “Хунан индастриал экүйпмент инсталэйшн” ХХК-тай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулсан. 116 МВт-ын хүчин чадалтай зуух, дагалдах тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хамт хийгдэж станцын технологийн дамжлагуудад түлш дамжлагын системд вагон гэсгээгч, бутлуур суурилуулах, хими ус бэлтгэлийн хэсгийн ус зөөлрүүлэх төхөөрөмжийг 2 үе шаттай болгож техникийн ус хангамжийн чанарыг сайжруулна. Өргөтгөлийн ажил 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 82 хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн санхүүжилтийн 75 хувийг Хөгжлийн банкны охин компани “Ди би эм лизинг” ХХК-тай байгуулсан санхүүгийн түрээсийн гэрээний дагуу санхүүжүүлж байгаа бөгөөд 2023 онд 48,700.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Гэрээний дагуу 2023 оноос эхлэн зээлийн хүү, үндсэн төлбөрийг төлж эхэлсэн. Хэрэглэгчийн дулааны эрчим хүч тарифт өөрчлөлт ороогүй тохиолдолд “Амгалангийн ДС” ТӨХК-д хүндрэл үүсэхээр байна.

3.5.1.8. Дулааны хоёрдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын эрчим хүчний системд түргэн маневрлах чадвартай турбин генератортай болох зорилгын хүрээнд 50*2 МВт-ын хийн генератор бүхий 100 МВт-ын цахилгаан станцыг ДЦС-2-ыг түшиглэн барьж байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулан 2020 оны 02 дугаар сард ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр гадаадын хөрөнгө оруулагч хэд хэдэн байгууллагад хүсэлт хүргүүлсэн боловч сонирхсон хөрөнгө оруулагч байхгүй.

Төслийг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгаж концесс эзэмшигчийг сонгон шалгаруулж өгөх тухай хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт, мөн Төрийн өмчийн хорооны 2010 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Концессын зүйлийн зардал, үр ашгийн тооцоо хийх түр аргачлал”-ын дагуу суурь судалгааны тооцооллыг хийж ажилласан. Засгийн газрын 2022.08.17-ны өдрийн хуралдаанд “ДЦС-2” ТӨХК-ийн дэд бүтцийг түшиглэн барих 100 МВт-ын хийн цахилгаан станц төсөл”-ийг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д тусгуулах саналыг танилцуулсан ба Засгийн газрын 2022 оны 309 дүгээр тогтоолоор концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2023.12.31-ний өдрөөс мөрдөгдөж

эхлэхтэй холбогдуулан сонгон шалгаруулалтын ажил түр хойшилсон байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хуулийг хэрэгжүүлэх холбогдох дүрэм журмыг батлуулахаар ажиллаж байна.

3.5.1.9. Нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд дулааны станцын өргөтгөл шинэчлэлт хийх; эрчим хүчний шинэ эх үүсвэр, дэд станц шинээр бий болгоно.

Биелэлт: Нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих ТЭЗҮ боловсруулах саналыг Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар “ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төсөл арга хэмжээний жагсаалт”-д тусгуулахаар БХБЯ-нд хүргүүлж, БХБС-ын 2021.04.01-ний өдрийн 66 дугаар тушаалаар баталгаажин уг төслийн техник эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021.12.21-ний өдрийн VII дугаар хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Барилга угсралтын ажлын санхүүжилтийг 2022, 2023 2024 оны улсын төсвийн төсөлд Налайх дулааны станцын өргөтгөлийн төслийг хэрэгжүүлэх санал хүргүүлсэн, тусгагдаагүй. Дулааны станцуудыг барих хөрөнгө оруулалтын зардал улсын төсөвт тусгагдаагүйгээс барилга угсралтын ажлыг эхлүүлэх боломж бүрдээгүй байна.

3.5.1.10. Эрдэнэтийн Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөнө.

Биелэлт: Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 35 МВт-аар нэмэгдүүлэх төсөлд Засгийн газрын 2018 оны 160 дугаар тогтоолоор БНХАУ-ын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээс 51.8 сая ам долларыг зарцуулахаар шийдвэрлэсэн. БНХАУ-ын талтай байгуулсан зээлийн хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсны дагуу төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын Хунан Индустриал экюпмент инстолэйшн компани шалгарсан. Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахал, БНХАУ-ын дотоодын хөл хорио, хил гаалийн хорио цээрийн хүндрэлтэй нөхцөл байдлын үед төсөл хэрэгжсэн бөгөөд тухай бүрд холбогдох зохион байгуулалтыг авч төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Тухайлбал Монгол Улсын Засгийн газрын 2020.05.06-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор төслийн ажиллах хүчний квотыг баталж, Улсын Онцгой комиссын тогтоосон журмын дагуу үе шаттайгаар Монгол Улсын хилээр нэвтрүүлж, 21 хоног тусгаарлан төслийн талбайд угсралтын ажил 2020.10.01-ээс хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлсэн.

Барилга угсралтын ажил бүрэн дуусаж 2021.12.15-ны өдөр Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. Төсөл хэрэгжсэнээр Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадал 35 МВт-аар нэмэгдэж төвийн эрчим хүчний системд 71 МВт-ын чадлаар цахилгаан эрчим хүчийг нийлүүлэн ажиллаж байна.

3.5.1.11. Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 325 МВт-аар өргөтгөх ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: ЗГ-ын 2021.01.13-ны өдрийн 3-р тэмдэглэлээр төслийг ОХУ-ын ЗГ-ын экспортын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх талаар шийдвэрлэсэн. “ДЦС-3” ТӨХК болон Интер РАО Экспорт компанийн хооронд хамтран ажиллах санамж бичгийг 2021.07.09, 2021.12.16-ны өдөр тус тус байгуулж, Интер РАО Экспорт компаниас төслийн ТЭЗҮ-ийг 2022 онд “ДЦС-3” ТӨХК-д хүлээлгэн өгсөн. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГ хоорондын комиссын 24-р хуралдааны протоколын хүрээнд ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулахаар ОХУ-ын ЭХЯ-тай хамтран ажиллаж байна. ОХУ-ын талаас хэлэлцээрийн төслийг ирүүлсэн ба хариу санал боловсруулж ЗГ-т танилцуулах явцад ЗГ-ын саналыг боловсруулах Ажлын хэсэг байгуулахаар болсон.

Санхүүжилтийн асуудлаарх хоёр улсын СЯ хооронд харилцан албан бичгийг хүргүүлсэн ба санхүүжилтийн нөхцөлийн талаар харилцан зөвшилцөлд хүрээгүй байна. Төслийн талаар ОХУ-ын ЭХЯ, СЯ-тай МУ-ын ЭХЯ-ны зүгээс 2023.02.13, 2023.02.17, 2023.06.16-ны өдөр ОХУ-д уулзалт хийж, санал солилцсон. Мөн төслийн зураг төсөл боловсруулах, ЗГ-ын хэлэлцээрийн төсөл боловсруулах асуудлаар “Интер РАО-Экспорт” ХХК-тай цахим уулзалтуудыг хийсэн.

3.5.1.12.Эгийн голын 315 МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц төслийн байгаль орчинд үзүүлэх олон талт нөлөөллийн судалгааг хийж, дэлхийн өвийн хороонд тайлагнаж зохих шийдвэр гаргуулна.

Биелэлт: Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч Франц Улсын “БРЛ Инженер” компани, МУ-ын “Престиж Инженеринг” ХХК, “Санни Трейд” ХХК-ийн түншлэлийн гүйцэтгэсэн “Эгийн голын УЦС төслийн Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурт үзүүлэх биологийн олон янз байдлыг тодорхойлох нэмэлт судалгаа”-ны ажлын эцсийн тайланг БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөр 2022 оны 11-р сард, Усны зөвлөлөөр 12-р сард тус тус хэлэлцүүлсэн. Эгийн голын УЦС төслийн Биологийн олон янз байдлын үнэлгээний тайланг ДӨХ-нд хүргүүлэх асуудлаар ЭХЯ, ГХЯ, БОАЖЯ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын НБД болон “Эгийн голын УЦС” ТӨХХК зэрэг холбогдох албаны хүмүүс 2023.01.11-ний өдрөөс Дэлхийн өвийн төвтэй цахим хурал хийх, Дэлхийн өвийн үндэсний хорооны 2023.02.06-ны өдрийн хуралд судалгааны ажлын үр дүнг танилцуулах, ОХУ-ын талаас хүссэний дагуу төслийн судалгаа болон УЦС-ын дүүргэлт ба ашиглалт ажиллагааны үед Сэлэнгэ мөрөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй байгалийн горимын нөхцөлийг хангах техникийн арга хэмжээний судалгааны товч тайланг ОХУ-ын Эрчим хүчний сайдад ГХЯ-аар дамжуулан хүргүүлэх зэргээр харилцан хамтран ажиллаж, тайланг ЮНЕСКО-д хүргүүлсэн.

2023.09.10-25-ны өдрүүдэд Саудын Арабын Хаант Улсын Рияд хотноо зохион байгуулагдсан ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооны 45-р чуулганаар хэлэлцэн, МУ, ОХУ-ын талуудыг БНБОУ-ний дүгнэлтэд үндэслэн одоо байгаа болон ирээдүйд барихаар төлөвлөж буй бүх УЦС, усны менежментийн төслүүдийн Байгаль нуурын Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэт байдалд үзүүлэх Хуримтлалын нөлөөллийн үнэлгээг хамтран боловсруулах шийдвэр гарсан. ДӨХ-ноос гарсан шийдвэрийн хүрээнд “Эгийн голын УЦС” төслийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулж, яамдаас санал авч ЗГХЭГ-т 2023.12.04-ний а/3970 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

3.5.1.13.Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй дулаан цахилгааны хэрэгцээг хангах шинэ эх үүсвэр байгуулах ТЭЗҮ боловсруулна.

Биелэлт: “Улаанбаатар хотын шинэ дагуул хотуудыг түшиглэн баригдах дулаан, цахилгааны эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг БХБЯ-аас зохион байгуулан “Мон-Энержи консалт” ХХК 2021-2022 онд гүйцэтгэж, ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Мөн Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хангах зорилгоор төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлыг БХБЯ-нд 2021-2022 онд гүйцэтгүүлэн ТЭЗҮ-ийг ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг үндэслэн “ЗҮ-3: Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах эх үүсвэрийн зураг төсөл; /НС-10, Дүнжингарав орчимд 2 байршилд/” зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Каркас зураг” ХХК гүйцэтгэсэн. Төсөл хэрэгжүүлэх нэгжийг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д байгуулсан.

3.5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана.

3.5.2.1. Монгол улсын газар нутгаар дайруулан татах хийн хоолойн судалгааг хийнэ.

Биелэлт: Хийн хоолойн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-ийг тусгай зориулалтын компани “Газопровод Союз Восток” ХХК 2021.12.15-ны өдөр монголын талд хүлээлгэн өгсөн.

2022 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов нар Монгол Улсын Засгийн газар болон “Газпром” НХН-ийн Хамтарсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж тус төлөвлөгөөний дагуу 2022.02.28-ны өдөр инженерийн хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудын даалгаврыг баталж “Газопровод Союз Восток” ХХК блон “Газпром Проектирование” ХХН-ийн хооронд инженер хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг гүйцэтгэх Гэрээнд гарын үсэн зурсан. Үүний дагуу 2022.04.28-ны өдөр инженерийн хайгуул судалгааны ажил эхэлж, судалгааны ажил хэвийн явагдаж байна.

2023 онд тус төслийг гүйцэтгэхэд ОХУ-аас 30 ажилтан ажиллахаар төлөвлөсөн бөгөөд эдгээр хүмүүст Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгуулахаар НХХЯ-д дэмжлэг үзүүлэх тухай 2022.10.24-ний өдрийн 03/2779 албан бичгийг хүргүүлсэн.

3.5.2.2. ОХУ, БНХАУ-ыг холбосон хийн хоолой Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх трассын хувилбарыг боловсруулж, төслийн нэгжийг мэдээллээр хангана.

Биелэлт: Монгол Улсын Шадар сайдаас 2020.01.28-ны өдрийн ЗГ-2/58 дугаар албан бичгээр ирүүлсэн ОХУ, БНХАУ-ыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байр зүйн зургийг бэлтгэн холбогдох материалын хамт 2020.03.05-ны өдрийн 03/646, 2020.10.27-ны өдрийн 01/2497 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан. ОХУ-аас БНХАУ руу дамжуулан барих байгалийн хийн хоолой /трассын хувилбар нь/ нь манай улсын нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг хүн ам ихээр төвлөрсөн суурьшлын бүсүүдээр дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн

3.5.3. Төвлөрсөн хот, сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. /Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дундговь, Говьсүмбэр, Төв, Сүхбаатар, Хэнтий аймагт дулааны станц барина./

3.5.3.1. Арван аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барина, /Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв/

Биелэлт: Төслийн зөвлөх компаниар БНСУ-ын “KDHEC” компанийг шалгаруулан 2019 оны 07 дугаар сард гэрээ байгуулсан. Төслийн БУА-ын гүйцэтгэгчийг шалгаруулах ажлыг зохион байгуулж Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Төв, Дундговь аймгийн гүйцэтгэгчээр шалгарсан Бюксан Инженеринг компанитай 2021.12.27, 2022.08.25-ны өдрүүдэд гэрээ байгуулж, төслийг эхлүүлсэн.

2023 оны жилийн эцсийн байдлаар Багц-1 (Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан) зураг төсөл, худалдан авах ажиллагаа, барилга угсралтын ажлын дундаж 42,05%, Багц-2 (Төв, Дундговь) зураг төсөл, худалдан авах ажиллагаа, барилга угсралтын ажлын дундаж 40.27%, Багц-3 (Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар) аймгийн барилга угсралтын ажлын дундаж 41.77 хувьтай тус тус үргэлжилж байна.

Төслийн ерөнхий гүйцэтгэгч “Бьюксан Инженеринг” компаниас зах зээл дээрх бараа материалын үнэ өссөн мөн валютын ханшны хэлбэлзлээс шалтгаалан нийт 64 сая орчим ам.доллараар төсөв өсөх буюу гэрээний үнэд өөрчлөлт орох талаар тооцоолсон мэдэгдлийг ирүүлснийг төслийн зөвлөх “Кореа дистрикт хитинг инженеринг” компаниас хөндлөнгийн тооцоолол хийж нийт 19,462,724 ам.долларын нөлөөлөл гарч болзошгүй гэсэн дүгнэлт гаргасан.

Эрчим хүчний сайдын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/246 дугаар тушаалаар дээрх төсөлд тулгамдаж буй асуудлыг судалж шийдвэрлүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Төслийн нийт гүйцэтгэл 41.4 хувьтай, 2023 оны санхүүжилт 91.6%, нийт санхүүжилт 38.5% байна.

3.5.3.2. Нийслэл, орон нутгийн дулааны шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгөх, шинэчилнэ.

Биелэлт: Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сумын төвийн байгууллагуудын дулаан хангамжийн систем /Хэнтий, Баян-Овоо сум/ төсөл, арга хэмжээг 2022-2023 онд хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж 2023.12.13-ны өдөр Улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан.

Халаалтын зуухнуудын төвлөрсөн дулааны холболт /Улаанбаатар/ төсөл, арга хэмжээг 2018-2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж 2023.12.08-ны өдөр ашиглалтад оруулах техникийн комисс ажилласан. Комиссын үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж байна. Дулаан хангамжийн шугам сүлжээ, дулаан дамжуулах төв /Хэнтий, Батноров, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж ашиглалтад оруулах техникийн комисс ажилласан, комиссын акт баталгаажих шатанд байна.

3.5.3.3. Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2021-2025 онд хэрэгжиж буй тус төслийн хүрээнд 2023 онд дулааны 4а,б магистралийн 2Ф250/350 мм-ийн голчтой шугамыг 2Ф400 мм болгон өргөтгөж сувагт оруулах, 12г магистралийн 2Ф500мм-ийн голчтой шугамыг 2Ф700 мм-ийн голчтой болгон өргөтгөн шинэчлэх, 9а,б магистралийн Ф400/500 мм-ийн голчтой шугамыг 2Ф700 мм-ийн голчтой болгож өргөтгөх, 9ж магистралийн 2Ф250/300 мм-ийн голчтой шугамыг 2Ф400 мм-ийн голчтой болгож өргөтгөх, 5а магистралийн 800мм-ийн голчтой дулааны шугамыг 1000мм болгож өргөтгөн шинэчлэх /уурын шугамын хамт/ ажлыг тус тус дуусгаж техникийн болон улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан.

2024-2025 онд шинээр хийгдэх өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд дулааны 2а магистраль шугамын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээг байгуулсан бол 9г магистраль шугамын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг зохион байгуулж үнэлсэн. Төслийн хүрээнд 2021-2023 онд нийт 7 магистраль шугам, 2 насос станцын шинэчлэл, хийгдсэн. Шугамыг шинэчилж сольсноор нийт 403 Гкал/ц дулааны хэрэглээг нэмж хангах техникийн боломж бүрдсэн бөгөөд дулааны шугамын найдвартай ажиллагаа сайжирч гэмтэл доголдлын тоо байхгүй болж эцсийн хэрэглэгчдийн горим ажиллагаа сайжирсан. Мөн хуучин шугамын дулаалгаар алдах 16510.3 Гкал/жил, гэмтэл гарснаар алдах 7214.8 Гкал/жил дулааны эрчим хүчийг хэмнэсэн. Төслийн нийт хэрэгжилт 65 хувьтай байна.

3.5.3.4. Улаанбаатарын хотын дулаан хангамж төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2021-2024 онд хэрэгжиж буй уг төслийн хүрээнд дулааны сүлжээний 8а, б, в, г магистралийн 2х400/500мм голчтой 3.3 хос км шугамыг 2х600мм голчтой болгож өргөтгөх 4 багц ажил, 5в-12а магистралийн холбоос 2х600мм голчтой 0.5 хос.км шугам татах 1 багц ажил, Даралт өргөх Насос станц №2-ын хүчин чадлыг 1,250 тн/ц-аар нэмэгдүүлэх ажлуудын бүтээн байгуулалтыг дуусгаж байнгын ашиглалтад хүлээлгэн өгснөөр төслийн дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх багц ажил бүрэн хэрэгжсэн. Ингэснээр Баянгол дүүргийн 4,5,6 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 12,13,14,15,16,17 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөөний дагуух 70 орон сууцны 8,900 айл өрх, 30 гаруй аж ахуйн нэгжийн дулаан хангамжийн найдвартай байдал хангагдсанаас гадна дамжуулах сүлжээний хүчин чадал 600 тн/ц буюу 48 Гкал/ц-аар нэмэгдсэн.

Бичил хорооллыг дулаанаар хангах 1.3 км шугамын БУА 60 хувьтай байна. Алсын удирдлага, хяналтын системтэй цахилгаан активатор бүхий бөмбөлгөн хаалт суурилуулах, Амгалан орчмын дахин төлөвлөлтийг хангах дулааны шугам шинээр татах /2Ф400мм, 1.8 хос.км/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг тус тус зарласан, 2024 оны 1 дүгээр сард нээнэ.

Толгойт орчмын төлөвлөлтийг хангах дулааны шугам шинээр татах, Хэрэглэгчийн төлбөр тооцоонд ашиглах ухаалаг тоолуур суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороодыг тус тус байгуулсан, ажлын тоо хэмжээ, техникийн шаардлага боловсруулах, тодотгох зэрэг ажлууд хийгдэж байна. Төслийн нийт хэрэгжилт 60.5 хувьтай байна.

3.5.3.5. Арван аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчлэх, шинээр барина.

Биелэлт: 2023 оны байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2 аймгийн төвийн дулаан түгээх сүлжээний шинэчлэлтийн ажил он дамжин хэрэгжиж байна.

1. Хэнтий аймагт 2021-2023 оны Улсын төсвийн 5,970.2 сая.төг-ийн санхүүжилтээр “Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл-3 дугаар ээлж /Хэнтий, Хэрлэн сум/” арга хэмжээг хэрэгжүүлж, 2023.11.14-ний өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комисс ажилласан. Техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаж, акт баталгаажих шатанд байна.
2. Төв аймагт 2022-2023 оны Улсын төсвийн 11,632.5 сая.төг-ийн санхүүжилтээр “Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Төв, Зуунмод сум/” арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн. БУА-ын гүйцэтгэл 10%-тай. Дулааны станцын болон дулаан дамжуулах төвийн цахилгаан хангамжийн зураг бүрэн дууссан.

Мөн станц, дулаан дамжуулах төвүүдийн холбоо мэдээлэл, цэвэр бохир ус хангамжийн зургийг ихэнх аймгууд гүйцэтгээд байна. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжих Эрчим хүчний сайдын багцад цахилгаан хангамж, дэд бүтцийн БУА-д 1,602.0 сая.төгрөг тусгагдсан.

3.5.3.6. Орон нутгийн дулааны станцын өргөтгөл, шинэчлэл болон эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна /Багануур дүүрэг, Хөвсгөл аймаг Хатгал, Өвөрхангай аймаг Баянтээг/.

Биелэлт: Нийслэлийн Багануур дүүргийн дулаан хангамжийн эх үүсвэрийн ТЭЗҮ, Хөвсгөл аймгийн Хатгал сумын шинэ дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ, Өвөрхангай аймгийн Баянтээгийн уурхайг түшиглэн цахилгаан станц барих ТЭЗҮ-ийг 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр боловсруулж, ЭХЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцэн баталсан. Хөрөнгө оруулалтын асуудлаар гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй, нүүрсний станцуудад гадны хөрөнгө оруулалт татах боломжгүй байгаа тул улсын төсөвт тусгах саналыг хүргүүлсэн боловч төсвийн хязгаараас шалтгаалан шийдвэрлэгдээгүй.

3.5.4. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах инновац, шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.

3.5.4.1. Эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлж, тарифыг индексжүүлэн зах зээлийн зөв тогтолцоонд шилжих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх, бодит өртөгт шилжүүлэх гол зорилтыг Шинэ сэргэлтийн бодлогын зорилтод тусган батлуулснаар улсын хөгжлийн дунд хугацааны эдийн засгийн үндсэн зорилтуудын нэг болон батлагдсан. ЭХЗХ-ны 2022.10.28-ны өдрийн 504-523 дугаар тогтоолуудаар тарифыг валютын ханшийн өсөлт, эрчим хүчний зориулалттай нүүрс олборлолтын зардал, нүүрсний тээврийн тариф, эрчим хүч үйлдвэрлэгч компаниудын үйл ажиллагааны бодит зардлыг тооцон айл өрхийн цахилгаан, дулааны төлбөрт өөрчлөлт оруулахгүйгээр үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хувьд сарын эхний 5000 кВт.ц хүртэл хэрэглээний тарифыг 14 хувиар, 5000 кВт.ц-аас дээш хэрэглээний тарифыг 28 хувиар тус тус нэмэгдүүлсэн.

Дулааны тарифт өөрчлөлт оруулах тооцоолол, судалгаа хийгдсэн, оролцогч талуудын санал сонсох, хэлэлцүүлэг хийгдсэн. Өөрчлөлт оруулах шийдвэр гараагүй байна.

3.5.4.2. Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлнэ /Эрчим хүчний төсөл-2/

Биелэлт: Дэлхийн банкны зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй уг төслийн хүрээнд “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн хангах, түгээх үйл ажиллагаа явуулдаг Архангай, Өвөрхангай, Орхон, Булган, Хэнтий, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Багануур дүүрэг, Өвөрхангай аймгийн Хархорин, Дорноговь аймгийн Замын-Үүд, Хэнтийн аймгийн Бор-Өндөр сумын төвийн цахилгаан түгээх, дамжуулах шугам сүлжээг шинэчлэх, Багануур дүүрэг, Хэнтий аймаг, Говьсүмбэр аймгийн төвд хаалттай хуваарилах байгууламж барих, Ховд аймгийн Мянгад сумын дэд станцыг түшиглэн 10МВ-ын нарны ЦС барих, мөн сумын дэд станцыг шинэчлэх ажлууд тус тус хэрэгжүүлж байна. Төслийн хэмнэгдсэн хөрөнгөөр 20 сумын төвийн цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах барилга угсралтын ажлыг 2023 онд шинээр эхлүүлсэн. 2024 оны 04 дүгээр сард дуусгах төлөвлөгөөтэй байна.

Ховд аймгийн Мянгад суманд 10 МВт-ын хүчин чадалтай нарны эх үүсвэрийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтад хүлээн авсан. Ашиглалтад орсноос хойш 36.4 ГВт.ц ЦЭХ үйлдвэрлэж, Баруун бүсийн эрчим хүчний системд нийлүүлсэн.

Түгээх сүлжээний шинэчлэлийн ажлын хүрээнд 0.4-10кВ-ын 255.3 км цахилгаан дамжуулах шугам, 6,10/0.4кВ-ын 100-400 кВа чадалтай 11 дэд станц шинээр барьж, цахилгаан эрчим хүч түгээх чадлыг 8.53 МВА-аар нэмэгдүүлсэн. Дундговь аймгийн Сайнцагаан, Дорноговь аймгийн Сайншанд, Замын-үүд, Өвөрхангай аймгийн Хархорин сумын түгээх сүлжээний шинэчлэлтийн ажлуудыг дуусгаж Улсын комиссоор хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулсан. ЭБЦТС ТӨХК болон БЗӨБЦТС ТӨХК-ийн 53,098

хэрэглэгчийг ухаалаг тоолуур болон шинээр хийгдсэн чанар, стандартын шаардлага хангасан шугам сүлжээнд холбож, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангасан. Төслийн хэрэгжилт 93% байна.

3.5.4.3. Нүүрсний ордуудын метан хийн хангамжийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулна.

Биелэлт: Хийн түлшний хэрэглээг нэвтрүүлэх, хийн хангамжийн сүлжээг байгуулах зорилгоор АХБ-ны техникийн тусалцааны хүрээнд “Метан хийн хангамжийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г боловсруулах, төслийн цар хүрээг тодорхойлох ажлыг зохион байгуулсан.

АХБ-аас шалгаруулсан зөвлөх үйлчилгээний компани болох АНУ-ын HJI Group Corporation компаниас ирүүлсэн Урьдчилсан шатны тайлан, Дунд шатны тайлан, Хийн хангамжийн сүлжээг хөгжүүлэх 10 жилийн стратегийн баримт бичигт УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ, НЗДТГ-ын төлөөллийг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Эцсийн шатны тайлангийн төслийн хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос гаргасан санал, зөвлөмжийг тусган эцсийн байдлаар боловсруулж АХБ-аас шалгаруулсан зөвлөх үйлчилгээний компани болох АНУ-ын HJI Group Corporation компаниас ирүүлсэн Урьдчилсан шатны тайлан, Дунд шатны тайлан, Хийн хангамжийн сүлжээг хөгжүүлэх 10 жилийн стратегийн баримт бичгийг боловсруулан ажиллаж байна.

3.5.4.4. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 20.45 сая еврогийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих уг төслийн хүрээнд 220, 110 кВ-ын дэд станцуудад ашиглагдаж буй ашиглалтын хугацаа дууссан, насжилт болон элэгдэл ихтэй 110 кВ-ын тосон болон хуурай таслуурыг гүйдлийн трансформатор, реле хамгаалалт удирдлагын хамтын шинэчлэх, төвийн бүсийн эрчим хүчний системийн гол зангилаа 220 кВ-ын 4 дэд станцын реле хамгаалалт, автоматик, хяналт, удирдлагын системийг бүрэн шинэчилж өргөтгөх ажил хийгдэнэ. Төслийн зөвлөхөөр Герман Улсын Integration Umwelt & Energie компани шалгаран ажиллаж байна.

Барилга угсралтын гүйцэтгэгч сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2023.02.06-ны өдөр зарлаж 2023.03.31-нд нээсэн. Үнэлгээний хорооноос тендерт оролцогч компаниуд техникийн шаардлагыг хангаагүй тул бүх тендерээс татгалзах шийдвэр гарсан. Үнэлгээний тайланг KfW банкнаас хянаад "Үл татгалзах" зөвшөөрлийг 2023.06.13-ны өдөр ирүүлсэн. KfW банкны худалдан авах ажиллагааны журамд заасны дагуу тендер шалгаруулалт амжилтгүй болсон мэдэгдлийг ХБНГУ-ын Эдийн засаг хөгжлийн агентлаг (GTAI), ЭХЯ, "ЦДҮС" ТӨХК-ийн цахим хуудсаар нийтэд мэдээлсэн.

Үнэлгээний хороо, Зөвлөх компани тендер амжилтгүй болсон шалтгааныг судлан тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж KfW банкнаас "Үл татгалзах" зөвшөөрөл авсан. Олон улсын нээлттэй тендерийг 2023.08.21-ний өдөр зарлаж 2023.10.13-ны өдөр нээсэн. Тендерийн техникийн саналын үнэлгээний тайланд "Үл татгалзах" зөвшөөрөл авахаар 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр KfW банканд хүргүүлсэн. Банкнаас шалгах ажил хийгдэж байна. 2023 онд зээлийн хөрөнгөөс зөвлөх үйлчилгээний зардалд 876.3 сая төгрөг санхүүжигдсэн байна.

3.5.5. Бүс нутгийн эрчим хүчний сүлжээг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийн цахилгаан хангамжийг үе шаттайгаар шийдвэрлэж, ухаалаг систем бий болгоно. /Чойр-Сайншандын 230 км урттай

220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина./

3.5.5.1. Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд 300 сая ам.долларын санхүүгийн эх үүсвэрээс 56.6 сая ам.доллароор Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийг санхүүжүүлэхийг Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 356 дугаар тогтоолоор баталсан. Төсөвт өртөгт дутагдаж байсан санхүүжилт болох 13.8 сая ам.долларын 8 сая ам.долларыг нь Европын Сэргээн босголт, хөгжлийн банкнаас, 5 сая ам.долларыг Европын холбооны буцалтгүй тусламжаар шийдвэрлэхээр уг төслийн зээлийн гэрээний хэлцэл 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр амжилттай хийсэн.

Чойр-Сайншандын 220 кВ-ын 220.08 км ЦДАШ, дэд станц барихаар төлөвлөсөн шинэчилсэн трассыг Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээллийн санд бүртгүүлж, газрын гэрчилгээнүүдийг албажуулж, 2013 онд хийгдсэн зураг төслийг шинэчилсэн. Мөн төслийн ТЭЗҮ-ийг Mercados Aries International компани болон “Мон-Энержи консалт” ХХК, Байгаль орчин, нийгмийн судалгааны ажлыг Sustainability East Asia болон Atkins компаниуд, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Эко трейд” ХХК тус тус гүйцэтгэж, тайлангууд баталгаажсан. Төслийн зээлийн гэрээний хэлцэл амжилттай хийгдсэнтэй холбогдуулан “Төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг байгуулан ажиллаж байна.

3.5.5.2. Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

Биелэлт: Тус төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил 2021 онд хийгдэж, 2022 онд магадлал хийгдэж баталгаажсан. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор АХБ, Европын Сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран ажилласан ба Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 30-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр АХБ-ны санхүүжилт дэмжигдсэн.

Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 468.3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын “Мянгад”, “Улиастай” дэд станцуудыг барих төслийг Монгол Улсын эдийн засгийн хүндрэлтэй байдал, зээлийн хязгаараас шалтгаалан 2 үе шаттайгаар “Эрдэнэбүрэн-Мянгад”, “Мянгад-Улиастай” дарааллаар, эхний ээлжид Эрдэнэбүрэн-Мянгад цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төслийн хүрээнд “Эрдэнэбүрэн-Мянгад” 69 км урт ЦДАШ, “Мянгад” 220/110/35 кВ-ын дэд станцын төслийг “Цэвэр дулааны төсөл”-тэй багц болгон 50.6 сая ам долларын төсөвт өртөг бүхий зээлийн гэрээний санамж бичигт Эрчим хүчний яам, Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Монгол Улс болон АХБ хооронд байгуулах “2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Монгол Улсын Их хурал 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр соёрхон баталсан. Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн ЦДАШ барих төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/323 дугаар тогтоол гарсан. ЦДАШ-ын 468.3 км урт трассыг Ховд, Завхан аймгуудын ИТХ, Засаг дарга нартай хамтран ажиллаж баталгаажуулан орон нутгийн газрын албаны мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших гэрээг авсан.

3.5.5.3. Даланзадгад-Ноён чиглэлийн 220 км 110 кВ-ын ЦДАШ барина.

Биелэлт: ЦДАШ-ын зураг, төслийг 2019 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Баясалтөгс” ХХК хийж гүйцэтгэсэн. Төслийн ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яамны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Эрчим хүчний яамны зүгээс Сангийн яаманд тухай бүр улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн боловч “Төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр” гэсэн шалтгаанаар жил дараалан хасагдсаар ирсэн.

Энэхүү арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн Гурвантэс, Ноён, Сэврэй сумд болон тухайн бүс нутгийн уул уурхайн орд газруудыг дотоодын эрчим хүчээр хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд хамтран ажиллах талаар Өмнөговь аймгийн Засаг дарга, ИТХ-д жил дараалан хүргүүлсэн боловч 2020, 2021, 2022 онуудын улсын төсвөөс удаа дараалан хасагдсан байна. Өмнөговь аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Н.Наранбаатар болон тус аймгийн Засаг дарга нараас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Эрчим хүчний сайдын 2023 оны төсвийн багцын төсөлд тусгуулахаар хүргүүлсэн боловч санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдэхгүй байна. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдэхгүй байгаа тул барилга угсралтын ажил эхлээгүй.

3.5.5.4. Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгөөр 2021-2024 онд хэрэгжиж буй Тайширын УЦС-аас аймгийн төв уруу татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц (Говь-Алтай) төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Биндэгноров” ХХК-тай гэрээг байгуулж БУА-ыг 2022 онд эхлүүлсэн. 110/35/6 кВ-ын дэд станцын 10 МВА хүчний трансформатор, 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн тоноглолыг угсарч суурилуулсан. 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийг хүчдэлд залгасан. 110 кВ-ын ЦДАШ-ын төмөр бетон тулгуур, анкер тулгууруудыг босгож газардуулга, утас болон шилэн кабель татах ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 92 хувь байна. Гэрээний дагуу 2024 онд ашиглалтад оруулна.

3.5.5.5. Нийслэл, орон нутгийн цахилгааны шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгөх, шинэчилнэ.

Биелэлт: Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сумын төвийн байгууллагуудын дулаан хангамжийн систем (Хэнтий, Баян-Овоо сум) төсөл, арга хэмжээг 2022-2023 онд хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж 2023.12.13-ны өдөр Улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан. Халаалтын зуухнуудын төвлөрсөн дулааны холболт (Улаанбаатар) төсөл, арга хэмжээг 2018-2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж 2023.12.08-ны өдөр ашиглалтад оруулах техникийн комисс ажилласан. Комиссын үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж байна. Дулаан хангамжийн шугам сүлжээ, дулаан дамжуулах төв (Хэнтий, Батноров, Бэрх тосгон) төсөл, арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж ашиглалтад оруулах техникийн комисс ажилласан, комиссын акт баталгаажих шатанд байна.

3.5.5.6. Цахилгаан дамжуулах шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна. (Мандалговь-Арвайхээр, Багануур-Чойр, Багануур-Чингис-Чойбалсан, Багануур-Налайх-Сонгино, Сайншанд-Цагаансуварга, 220 кВ-ын Оюут дэд станц, Дархан-Сонгино, шинээр барих 110 кВ-ын дэд станцууд)

Биелэлт: Мандалговь-Арвайхээр, Сайншанд-Цагаансуваргын ЦДАШ, дэд станцын зураг төсөл боловсруулах ажлыг 2021 онд БХБЯ-нд захиалан гүйцэтгүүлж магадлал хийгдэж, баталгаажсан. 1.БН-Чойр, 2.БН-Чингис-Чойбалсан, 3.БН-Налайх-УБ, 4.Сонгино-Дарханы 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцуудын өргөтгөл, 5.Налайх дүүрэгт шинээр баригдах 220/110 кВ-ын транзит дэд станц, “Сэргэлэн” болон “Сонгино” дэд станцтай холбох, “Сэргэлэн” дэд станцын өргөтгөлийн зураг, төсөл боловсруулах ажлуудыг БХБЯ-нд 2022 онд захиалан гүйцэтгүүлж байна. Он дамжин хийгдэх бөгөөд 65-98 хувийн гүйцэтгэлтэй. Төслийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ДБ, ЕСБХБ-тай 2021-2022 онуудад хамтран ажиллаж, банкнуудын УЗ-өөр хэлэлцүүлж, санхүүжүүлэхээ илэрхийлсэн.

Хөшгийн хөндийд Сонгино-Сэргэлэн 220 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ, дэд станц, Сэргэлэн-Аэросити 110 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ, 220/110/35 кВ-ын “Сэргэлэн” дэд станц, 35 кВ-ын ЦДАШ, 35/10 кВ-ын Хөндий дэд станцын зураг төсөл БХБЯ-ны захиалгаар хийгдэж, магадлалаар баталгаажсан.

3.5.6.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах ногоон үйлдвэрлэлийн төслүүдийг хэрэгжүүлнэ. (Салхины цахилгаан станцын 15 МВт-ын хоёр, нарны цахилгаан станцын 35 МВт-ын дөрвөн төсөл хэрэгжүүлнэ.)

3.5.6.1.Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл (салхины цахилгаан станцын 2 төсөл 15 МВт, нарны цахилгаан станцын 4 төсөл 35 МВт)

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, АХБ хооронд “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зээл, буцалтгүй тусламжийн гэрээнүүд 2019 оны 02 дугаар сард байгуулагдсан. Төслийн хүрээнд:

- Говь-Алтай аймгийн Алтай сумын хосолсон системийн ажлыг дуусгаж 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан. Хэрэглэгчдийн 24 цагийн тасралтгүй эрчим хүчээр хангаж байна;
- Завхан аймгийн Улиастай сумын 5МВт-ын нарны цахилгаан станц, 3.6МВт*ц багтаамжтай цэнэг хуримтлуурын станцын ажлыг дуусгаж 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ашиглалтад хүлээн авсан. Нийт 9,920,644.4 кВт/цаг цахилгаан үйлдвэрлээд байна;
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 МВт нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусаж Улсын комисс 2023 оны 12 дугаар сард тус ажиллан ашиглалтад хүлээн авсан. Системд холбогдсоноос хойш 980,040 кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж 959,060 кВт.цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлсэн;
- Завхан аймгийн Тэлмэн сумын 10МВАр-ийн хуурмаг чадлын компенсацилах төхөөрөмж (SVG) суурилуулах ажил дуусаж Улсын комисс 2023.07.25-нд ажиллаж, ашиглалтад хүлээн авсан;
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10МВт нарны станцын барилга угсралтын ажил 79 хувьтай, гэрээний дагуу 2024 онд ашиглалтад орно;
- 15 МВт СЦС-ын төсөл хэрэгжүүлэх газрыг судлах, салхины эрчим хүчний хэмжилтийг хийх ажил дуусаж, Говь-Алтайд хэрэгжүүлэхээр АХБ-тай зөвшилцсөн. Салхины нарийвчилсан хэмжилтийг 2022 оны 06 дугаар сараас 2023 оны 05 дугаар сар хүртэл хийсэн. Хэмжилтийн үр дүн гарсан боловч ТЭЗҮ-ийг боловсруулах үе шатанд төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай зам болон бусад дэд бүтэц, тээврийн зардал өсөж төслийн хүчин чадлыг бууруулахад хүрсэн тул төлөвлөж буй эх үүсвэрийн анхны хүчин чадал, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг бууруулахгүй байх талаар хэлэлцэн 15 МВт-ын нарны цахилгаан

станц болгох саналыг Төслийн Удирдах хорооноос АХБ-нд 2023 оны 10-р сард хүргүүлсэн. АХБ-ны зөвлөхүүд үнэлгээ хийж байна.

3.5.6.2. Газрын гүний дулааны эх үүсвэрийг ашиглах загвар төслүүдийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: АХБ-ны зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд:

- Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын дулаан хангамжид 135 кВт хүчин чадал бүхий “Гүний дулааны халаалтын систем”-ийн угсралт суурилуулалтын ажлыг хэрэгжүүлж 2022 оны 01 дүгээр сарын 12-нд ашиглалтад хүлээн авсан;
- Завхан аймгийн Улиастай сумын Жаргалант цогцолбор сургуулийн барилгад 110 кВт-ын хөрсний дулааны насосын системийг суурилуулах барилга угсралтын ажил дуусаж, 2023.04.05-нд ашиглалтад хүлээн авсан;
- Говь-Алтай аймгийн Алтай сумын эмнэлэг, захиргааны барилгад 90 кВт-ын хөрсний дулааны насосын системийг суурилуулах ажил 15%, Увс аймгийн Улаангом сумын 5-р сургуулийн барилгад 130 кВт-ын хөрсний дулааны насосын системийг суурилуулах ажил 25%, Баянхонгор аймгийн Өлзийт сумын сургуулийн барилгад 75 кВт-ын хөрсний дулааны насосын системийг суурилуулах ажил 48 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 онд буцалтгүй тусламжаас 74.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн.

3.5.6.3. Нарны эрчим хүчийг дулаан хангамжийн эх үүсвэрт ашиглах технологийг судлах, нэвтрүүлэх загвар төслүүдийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Даян дэлхийн ногоон хөгжлийн институти (ДДНХИ)-тэй хамтран одоогийн дулаан хангамжийн системд нарны дулааны эх үүсвэрийг холбох төслийн саналыг НАМА фасилити байгууллагаас 2022 онд зарласан хүлэмжийн хийн ялгарал бууруулах төслийн сонгон шалгаруулалтад хүргүүлсэн нь 1, 2 дугаар шатанд амжилттай шалгарсан. Энэхүү “Эрчим хүчний шинэчлэлд хүрэх цэвэр дулааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” нэртэй Дорноговь аймгийн Сайншанд хотод хэрэгжүүлэх нарны хэсэгчилсэн дулаан хангамжийн төсөл, цэвэр дулааныг дэмжих төслийн бэлтгэл үе шатны ажлын талаар 2023 оны 2 дугаар сард ЭХЯ, ЭХЗХ, Дорноговь аймгийн Засаг дарга, ДДНХИ-ийн Монгол дахь төлөөлөгч нар санамж бичиг байгуулсан. Төслийн Зөвлөх сонгон шалгаруулах ажлын даалгавар, зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний хороонд оролцох төлөөллийн нэрийг ДДНХИ-д 2023 оны 4 дүгээр сарын 17-нд хүргүүлсэн. Зөвлөх үйлчилгээний санхүүжилтийн гэрээ 2024 оны 1-р сард зурагдахаар хүлээгдэж байна.

Мөн АХБ-ны техникийн тусалцааны хүрээнд Японы ядуурлыг бууруулах сангийн дэмжлэгээр цэвэр эрчим хүчийг дулаан хангамжид ашиглах төслийг хэрэгжүүлэхээр ирэх 4 жилийн стратегийн төлөвлөгөөнд тусгуулсан ба буцалтгүй тусламжийн гэрээний хэлцэл хийгдсэн. АХБ-ны зүгээс төслийг Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг өргөтгөн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. “Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилт” төслийн гадаад, дотоодын зөвлөхүүдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан тендерийг зарласан, үнэлгээ хийж байна.

Ховд аймгийн Жаргалант сумын цэцэрлэгийн барилгад 135 кВт-ын дулааны насос, 10 кВт-ын нарны коллектор суурилуулж, нарны эрчим хүчийг дулаан хангамжид ашиглах төслийг 2022 онд, Завханы Улиастай сумын 2-р сургуулийн өргөтгөлийн барилгын дулаан хангамжид 110 кВт-ын хөрсний дулааны насос, нарны коллектор бүхий халаалтын загвар төслийг 2023 оны I улиралд тус тус ашиглалтад оруулсан.

3.5.6.4.Төвийн бүсэд усан цэнэгт цахилгаан станц барих ТЭЗҮ, барилга угсралтын ажил эхлүүлнэ.

Биелэлт: Усны нөөцийг хуримтлуулж эрчим хүч үйлдвэрлэх чиглэлээр Байдрагийн голд УЦС барих, Төвийн бүсэд усан цэнэгт ЦС барих ТЭЗҮ боловсруулах зөвлөхийг 2022 онд сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. ТЭЗҮ боловсруулах ажлыг 2022-2023 онд дуусган хэлэлцүүлэгдэж байна. Эдгээр ажлыг бодлогын удирдамжаар ханган ажиллаж байна. Байдрагийн голд УЦС барих ТЭЗҮ боловсруулсан “Монхидро констракшн” ХХК 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр ТЭЗҮ-ийн эцсийн тайланг ирүүлсэн ба яамны ШУТЗ-өөр 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хэлэлцүүлж, дэмжигдсэн. Төвийн бүсэд усан цэнэгт ЦС барих ТЭЗҮ боловсруулсан “Престиж инженеринг” ХХК ТЭЗҮ-ийн явцын тайланг яаманд 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн ба яамны ШУТЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Төвийн бүсэд УЦЦС-ын төслийг хамтран хэрэгжүүлэх саналыг АХБ, ДБ, Жайка ОУ-ын байгууллагуудад хүргүүлснээс АХБ судлан үзэж хамтран ажиллахаар болсон.

“Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ажиллах усан цэнэгт цахилгаан станц”-ын ач холбогдол, ТЭЗҮ-ийн хүрээнд хийгдэж буй ажлын талаар 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хамтарсан хэлэлцүүлэг, семинарыг зохион байгуулсан. Улмаар АХБ-тай зөвшилцөн ирэх 3 жилийн хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулж, АХБ-ны холбогдох зөвлөхүүдтэй дээрх ТЭЗҮ-ийг судлан хамтран ажиллаж, банкны хүсэлтээр төслийн суурь судалгааны хураангуй тайланг хүргүүлсэн. Мөн ААН-дийн санаачилсан төвийн бүсэд УЦЦС-ын төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийлгэх саналыг дэмжиж Улаанбаатар усан цэнэгт ХХК-ийн 100 МВт, Эрдэнэс пауэр ХХК-ийн 45МВт, Эрдэнэт усан цэнэгт цахилгаан станц ХХК-ийн 50 МВт, Санхидро ХХК-ийн 75 МВт, Пи Эс Хайдропауэр Женерэйшн ХХК-ийн 30 МВт-ын төслүүдийг дэмжин яамны ШУТЗ-д танилцуулсан. Эдгээрээс Улаанбаатар усан цэнэгт ХХК нь төслийг концессоор, Эрдэнэс пауэр ХХК нь хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр холбогдох тусгай зөвшөөрөл, Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг байгуулсан. Эрдэнэс пауэр ХХК БУА-ын зураг төсөл боловсруулж байна.

3.5.6.5.Бага оврын сэргээгдэх эх хүчний эх үүсвэр бүхий айл өрх, байгууллагын үйлдвэрлэсэн цахилгааныг түгээх сүлжээнд нийлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, хэрэгжүүлнэ

Биелэлт: “Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам”-ыг боловсруулж, Эрчим хүчний сайдын 2020 оны 159 дүгээр тушаалаар баталснаар бага оврын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий айл өрх, байгууллагын үйлдвэрлэсэн цахилгааныг түгээх сүлжээнд нийлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. Эрчим хүчний зохицуулах хорооноос хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх үнэ, тарифыг баталснаар айл өрх, аж ахуйн нэгжүүд бага чадлын сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг ашиглаж цахилгааны хэрэглээгээ хангаад илүү гарсан цахилгаанаа түгээх компанид тогтоосон үнэ тарифын дагуу нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Энэ хүрээнд 2023 онд 39 иргэн, хуулийн этгээдийн 967 кВт-ын нарны эх үүсвэр шинээр түгээх сүлжээнд холбогдохоор техникийн нөхцөл авснаас 28 хэрэглэгч, 7 хуулийн этгээд нийт 438.4 кВт-ын нарны эх үүсвэр түгээх сүлжээнд холбогдсон байна. Иргэн байгууллага тус бүрд журмыг хэрэгжүүлэхэд үүсээд байгаа хүндрэлийг нарийвчлан судлах шаардлагаар Ажлын хэсэг байгуулагдан 2023 он 6 дугаар сарын 07-ны өдөр хуралдсан. Мөн 2023 оны 12 дугаар сард дахин хуралдаж хүндрэлтэй асуудлыг жагсаалт гарган, журамд өөрчлөлт орох шаардлага үүсээд буй саналуудыг нэгтгэж байна.Түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдээс журмыг сайжруулах санал авахад 3 иргэн тариф нэмэх санал

өгсөн бөгөөд бусад хэрэглэгчдээс журмыг хэрэгжүүлэхэд аливаа хүндрэл үүсээгүй талаар хариу саналуудыг ирүүлсэн.

3.5.7. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх иргэний болон үйлдвэрлэлийн барилга байгууламжийн томоохон төслийн эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хийнэ. (Хөшгийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ.)

3.5.7.1. Хөшгийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ.

Биелэлт: УИХ-ын 2022 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 143 дугаар “Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” тогтоол, 2022 оны 98 дугаар “Төрийн захиргааны зарим байгууллагыг Хөшгийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний тухай” тогтоолуудыг тус тус батлуулсан. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажлыг “Некст степ инженеринг” ХХК, “Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”, “Тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний ажлыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ, “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Нарт дизайн” ХХК, ИНЕГ-ын 600 айлын орон сууцны барилгын ажлын зураг төслийг /300 сая.төг/ “Кон-Консалтинг” ХХК боловсруулж, нийт 1,773.6 сая.төг-ийн ажил, “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ болон инженерийн шугам сүлжээний 2,173.3 сая төгрөгийн 6 багц ажлын зургийн ажлыг хийж гүйцэтгэн батлуулж хүлээлгэн өгсөн.

Барилга, хот байгуулалтын сайдын 2022-2023 оны төсвийн багцад он дамжин хэрэгжүүлж байгаа “Хөшгийн хөндийн шинэ суурьшлын бүс”-ийн инженерийн дэд бүтцийн эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын явц:

1. Ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/-ний гүйцэтгэгч “Эс Энд Эй Трейд” ХХК, гүйцэтгэл 10800м хоолойг бүрэн угсарч, угсралтын явц 60 хувийн гүйцэтгэлтэй байна.
2. Цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч “Билгүүн Од констракшн” ХХК, гүйцэтгэл 52 хувьд хүрч, утас таталтын ажил үргэлжилж байна.
3. Инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламж /4/-ийн гүйцэтгэгчээр “Хангилцаг” ХХК, “Эм Даблю Ти” ХХК-ийн түншлэл, гүйцэтгэл 35 ш хавтан үйлдвэрлэсэн.

3.5.7.2. Олон улсын нисэх онгоцны буудал, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлж, зураг төслийг хийнэ.

Биелэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 76 дугаар захирамжаар байгуулагдсан “Богдхан төмөр зам” төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, төсөл хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн “Төв аймгийн Хөшгийн хөндий дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлт (бүсийн хөгжлийн төсөл)-ийг боловсруулах ажил Зам, тээврийн хөгжлийн болон Барилга хот, байгуулалтын сайд нарын 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/64, 98 дугаар хамтарсан тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл

ажиллагааны хөтөлбөрт барилга, хот байгуулалт, зам, тээврийн дэд бүтэц байгуулах чиглэлээр тусгагдсан үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдааг хангаж хамтарч ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан хамтран ажиллаж байна.

Дээрх ажлын хүрээнд инженерийн дэд бүтцийн буюу дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний нарийвчилсан зураг төслүүд батлагдсан. Үүнд үндэслэн Монгол Улсын 2023 оны төсвийн хуулиар Эрчим хүчний сайдын хөрөнгө оруулалтын багцад 2023-2024 онд хэрэгжихээр тусгагдсан. “Хөшгийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” /Төв/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчидтэй гэрээг байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Дараах гүйцэтгэлтэй байна:

- “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн Сонгино-Сэргэлэн 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ /Төв, Сэргэлэн/ төсөл арга хэмжээг 5 багцын хүрээнд хэрэгжүүлж байгаа ба барилга угсралтын ажлын гүйцэтгэл 35-42 хувь, он дамжин хэрэгжинэ.
- “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн 220/110/35 кВ-ын 2*125 МВА чадалтай “Сэргэлэн” дэд станц, удирдлагын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 20 хувь, он дамжин хэрэгжинэ.
- “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн 110 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, 2-40 МВА дэд станцын ИХБ-ын тоноглолын суурь, удирдлагын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 33 хувь, он дамжин хэрэгжинэ.

Тээвэр логистик

3.6.Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

3.6.1.Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ.

3.6.1.1.1.Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барина.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 125 дугаар тушаалаар байгуулагдсан Улсын комисс 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан.

3.6.1.1.2.Өмнөговь аймгийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замыг барина.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар тушаалаар байгуулагдсан Комисс 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдөр ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан.

3.6.1.1.3.Дорноговь аймгийн Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлнэ

Биелэлт: "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах тухай" Засгийн газрын 2023 оны 300 дугаар тогтоолоор хөрөнгө оруулж хамтран ажиллах компанийг сонгон төслийг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хөрөнгө оруулагчийг сонгох ажлууд хийгдээгүй. Мөн Концессын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/276 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулан ажилласан бөгөөд Концессын тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 31-

ний өдрөөс хүчингүй болсон.

3.6.1.1.4.Дорнод аймгийн Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийг эхлүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-аас 2022 оны 5 дугаар сард Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдийг урьдчилсан сонголтод оролцох саналын урилгыг зарласан. Концессын зарлалын дагуу зүүн чиглэлийн төмөр замын төсөлд 8 санал ирсэн. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга төслийн төмөр замын суурь бүтэц барих ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, хил холболтын төмөр замын төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдөр, холболтын төмөр замын ТЭЗҮ-ийн ажлын даалгаврыг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр тус тус баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 30-ны 35 дугаар тэмдэглэлээр тус чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанитай концессын шууд гэрээ байгуулах талаар дүгнэлт гаргахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, дүгнэлтийг үндэслэн хэлэлцээр хийж, зохих журмын дагуу гэрээ байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан.

“Ийст корридор рэйлрүүд” ХХК, Хятадын Улсын “CRDC” ХХК-тай гэрээ байгуулж Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлж байна. Барилгын ажлыг 2024 онд багтаан эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

3.6.1.1.5.Дорнод аймгийн Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийг эхлүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-аас 2022 оны 05 дугаар сард Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдийг урьдчилсан сонголтод оролцох саналын урилгыг зарласан. Концессын зарлалын дагуу зүүн чиглэлийн төмөр замын төсөлд 8 санал ирсэн. “Урьдчилсан сонгон шалгаруулалтын үнэлгээний баримт бичиг”-ийн Ерөнхий шаардлага, Санхүүгийн чадавх, Техникийн чадавхын бүрдлийн дагуу материал хүлээн авсан. ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга төслийн төмөр замын суурь бүтэц барих ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг 2023.01.24-ний өдөр, хил холболтын төмөр замын төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг 2023.03.14-ний өдөр, холболтын төмөр замын ТЭЗҮ-ийн ажлын даалгаврыг 2023.02.07-ны өдөр тус тус баталсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хуралдаж Баруун чиглэлийн төмөр замын төсөлд 1 компанитай хэлцэл хийхийг даалгасны дагуу “Ийст корридор рэйлрүүд” ХХК-тай сонгож, гэрээний төслийг тохиролцсон. “Монголын төмөр зам” ТӨХК болон “Ийст корридор рэйлрүүд” ХХК нар “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-г 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. Тусгай зориулалтын компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээ 2023.07.03-нд авсан. Төрийн худалдан авах газарт 2023 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн “Концессын гэрээ байгуулах тухай” 01/1081 дугаар албан бичиг хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 30-ны 35 дугаар тэмдэглэлээр тус чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанитай концессын шууд гэрээ байгуулах талаар дүгнэлт гаргахыг ТХААГ-т, дүгнэлтийг үндэслэн хэлэлцээ хийж, зохих журмын дагуу гэрээ байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/261 дүгээр тушаалаар Концессын гэрээний

хэлэлцээ хийх, шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан "Ийст Корридор Рэйлрүүд" ХХК-тай хэлэлцээ хийгдэж байна.

3.6.1.1.6. Дорноговь аймгийн Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төслийг эхлүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 28 тогтоолоор уг төмөр замын төслийг концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт дахь зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх "Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам" төслийн концессын гэрээг "Монголиан транс лайн" ХХК болон "Монголиан транс ложистик" ХХК-ийн нэгдэлтэй байгуулах эрхийг 2022 оны 03 дугаар сарын Засгийн газрын хуралдаанаар олгосон. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын барилгын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн бөгөөд Улсын хилийн шугам хүртэлх 226.3 км төмөр замын дээд, доод бүтцийг барьж дууссан. Энэ нь нийт барилгын ажил 90 хувь болох бөгөөд үлдэх дохиолол холбоо, хил холболтын ажил үлдэх 10 орчим хувийг эзэлж байгаа талаар концесс эзэмшигчээс мэдээлээд байна. 2022 оны 11 дүгээр сарын 25-нд нээлтээ хийсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 11 дүгээр 18-ний өдрийн А/299 дүгээр тушаалаар байгуулагдсан Техникийн комисс үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан ажиллаж байна. Техникийн комиссын үүрэг даалгаврын биелэлт 32 хувьтай явагдаж байна. Тээвэрлэлт эхэлснээс хойш нийт 470,958 тонн ачаа тээвэрлээд байна. Төслийн нийт барилгын ажлын гүйцэтгэл 90.04 хувь байна.

3.6.1.2.1. Улаанбаатар төмөр замын гол замд техникийн шинэчлэл төслийг эхлүүлнэ.

Биелэлт: Замын-Үүд-Шаргын-Овоо чиглэлийн 14.3 км төмөр замыг хос болгох тухай ТЭЗҮ-ийг Зам, тээврийн хөгжлийн яамны ШУТЗ-ийн дэд зөвлөл болон ШУТЗ-өөр хэлэлцүүлэн, батлуулсан. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгааны ажлууд болон зураг төсөл бүрэн хийгдсэн, Байгаль орчны нөхцөл байдлын үнэлгээ боловсруулах, инженер-геологийн ажлын гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж мөн газар шорооны ажлыг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж төслийн талбайд барилгын ажлыг эхлүүлж, "Улаанбаатар төмөр зам" ХНН нь 2021 онд 80.7 км, 2022 онд 0 км, 2023 онд 13.3 км их засварын ажил хийсэн.

3.6.1.2.2. Улаанбаатар төмөр замын гол замд 200 км их засвар хийнэ.

Биелэлт: "Улаанбаатар төмөр зам" ХНН нь 2021 онд 80 км их засвар хийхээр төлөвлөсөн бөгөөд Оорцог-Энгэр-Наран-Элгэн-Агуйт хоорондын замд 56.9км, Толгойт-УБ-Амгалан 18.1км, Баян зөрлөг гол зам 1.1км, Цагаан хяр зөрлөг гол зам 1.4км, Замын-үүд-1 өртөө-Улсын хил хооронд 3.2км замд тус тус их засвар гүйцэтгэж 11 дүгээр сарын 15-ны өдөр 80.7км-ыг бүрэн дуусгасан.

"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн 2022 онд хийх өртөө зөрлөгийн сунгалт, их засварын ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу Эмээлт зөрлөгийн 2.3 км сунгалтын ажил, Цомог зөрлөгт 4.5 км сунгалтын ажил (2022 онд хийгдэх 30.7 км төмөр замын их засварын ажлыг өмнөх онд хийсэн)-ыг тус тус гүйцэтгэв.

ОХУ, Украйны хооронд үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалж зам, төмрийн татан авалт удаашралтай байснаас шалтгаалан 2023 онд 13.3 км замын их засвар хийгдсэн.

3.6.1.3.1. "Богдхан төмөр зам" төслийн ТЭЗҮ, судалгаа, зураг төслийг гүйцэтгэнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 230 дугаар тогтоолын хүрээнд "Тавантолгой төмөр зам" ХХК болон Зэвсэгт хүчний барилга инженерийн цэргийн удирдах газрууд хамтран "Богдхан" төмөр зам төслийн доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр байгуулан ажиллаж байтал Зам, тээврийн хөгжлийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу талуудын хооронд байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалтыг үндэслэн ПК105+ПК142+500 хоорондох 37.5 км-т хийгдэж байсан газар шорооны ажлыг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түр зогсоосон. Ийнхүү "Богдхан төмөр зам" төслийг Оросын талтай хамтран хэрэгжүүлэх зорилгоор ОХУ-ын Тээврийн яам, "Оросын төмөр замууд" НХН-тэй хамтран ажиллаж ирсэн хэдий ч өнөөдрийг хүртэл оросын талаас албан ёсны хариу ирүүлээгүй байна. "Богдхан" төмөр зам төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан 2023 оны 07 дугаар сард оросын талд хүргүүлсэн.

3.6.1.3.2. Баруун босоо чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, судалгаа, зураг төслийг гүйцэтгэнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 116 дугаар тогтоолоор Концессын "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр Хөөт-Бичигт-Чойбалсан чиглэлийн төмөр замын төслийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас сонгон, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн оролцоотой Төслийн тусгай зориулалтын компани байгуулж хамтран хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 35 дугаар тэмдэглэлээр тус чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанитай концессын шууд гэрээ байгуулах талаар дүгнэлт гаргахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, дүгнэлтийг үндэслэн хэлэлцээ хийж, зохих журмын дагуу гэрээ байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн Сайдад даалгасан.

Зам, тээврийн хөгжлийн Сайдын тушаалаар концессын хэлэлцээ хийх Ажлын хэсгийг байгуулан хэлэлцээр амжилттай хийгдэж, гэрээний төслийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Концессын тухай хуулиар концессын гэрээ байгуулах асуудлыг концессын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хариуцна.

3.6.1.3.3. Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төсөл.

Биелэлт: БНС-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын буцалтгүй тусламжаар ГТХЗНТ-ийн барилгыг барихаар КОЙКА, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам 2021 онд хэлэлцээр байгуулсан. Хэлэлцээрийн хүрээнд Төвийн барилгын зураг төслийг боловсруулах гэрээг 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр "Эм Эс Эл" ХХК-тай байгуулан, зураг төслийг гүйцэтгүүлж Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газраар барилгын эх загвар зургийг 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, барилгын ажлын зураг, төсвийг 2023 оны 7 дугаар сарын 18-ны өдөр магадлалаар батлуулсан.

Авто зам, гэрэлтүүлэг, гадна тохижилтын ажлын зураг төслийг магадлалаар баталгаажуулж санхүүжилтийг 2025-2026 оны төсвийн төсөөлөлд тусгуулан 2024 оны 1 дүгээр улиралд барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.

3.6.1.4.1. Азийн авто замын сүлжээний АН-3 дугаартай Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.2 км авто замын өргөтгөл шинэчлэлт.

Биелэлт: УБ-Дархан чиглэлийн зам барилгын ажлыг 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн. Нийт 5 багц хэсгийн барилгын ажил Багц 1-1 хэсэг 96.16 хувь, Багц 1-2 хэсэг 89 хувь, Багц 1-3 хэсэг 99.5 хувь, Багц 1-4 хэсэг 81.2 хувь, Багц 1-5 хэсэг 99.9

хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна. Нийт хэрэгжилт 90.5 хувь байна.

3.6.1.4.2. Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн 2 дугаар үе шатны барилгын ажлыг дуусгана.

Биелэлт: Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ 202.4 км авто замын багц 2023 оны жилийн эцсийн байдлаар барилгын ажлын талбай дээр 579 гаруй инженер техникийн ажилчин, 281 техник, тоног төхөөрөмж ажиллаж байна. Багц 1 хэсэг 84.47 хувь, Багц 2 хэсэг 81.55 хувь, Багц 3 хэсэг 85.23 хувь, Багц 4 хэсэг 80.63 хувь, Багц 5 хэсэг 83.97 хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна. Нийт 5 багц хэсгийн барилгын ажлын гүйцэтгэл 83.17 хувь хэрэгжсэн бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн.

3.6.1.4.3. Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

Биелэлт: Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төслийн зураг төслийг “Эм Си Пи Жи Ар” ХХК гүйцэтгэсэн. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 355 дугаар тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ажлын хэсэг байгуулан 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр концесс олгох уралдаанд шалгаруулалтын ажлыг зарлаад байна.

3.6.1.4.4. Налайх-Төв аймгийн Баян сум чиглэлийн 58 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

Биелэлт: Налайх-Төв аймгийн Баян сум чиглэлийн 58 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх, шинэчлэх авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг 2021 онд “Ростов” ХХК боловсруулсан. Тус төслийг нэгтгэн “Рашаант-Хөшгийн хөндий-Хоолт зөрлөг” чиглэлийн 4 эгнээ, “Налайх-Багахангай-Чойр-Сайншанд-Замын-Үүд” чиглэлийн 2 эгнээ тусгай зориулалтын авто зам барих төсөл” болгон концессын “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 355 дугаар тогтоолыг баталсан.

Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ажлын хэсэг байгуулан 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр концесс олгох уралдаанд шалгаруулалтын ажлыг зарлаад байна.

3.6.1.4.5. Азийн авто замын сүлжээний АН-4 дугаартай Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто зам, Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто зам, гүүрийг барина.

Биелэлт: “Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг 100 хувь гүйцэтгэж, улсын байнгын ашиглалтад 2022 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авсан.

Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто замын Багц 1 хэсгийн барилгын ажлыг 100 хувь гүйцэтгэж, улсын байнгын ашиглалтад 2022 оны 10 дугаар сарын 28-ний өдөр хүлээн авсан. Багц 2 болон Багц 3 хэсгийн ажлын гүйцэтгэгчээр “Эйч кэй би интернэйшнл холдинг” ХХК ажиллаж, 2023 оны 11 сард ашиглалтад хүлээлгэн өгсөн.

3.6.1.5.Орхон-Дашинчилэнгийн замаас үргэлжлэх Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгийн авто замуудыг үргэлжлүүлнэ.

Биелэлт: Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 136 км авто замын эхний ээлжийн буюу Орхон-Их тамир чиглэлийн 63км авто зам, Орхон голын 220 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажлыг “Хурдны зам” ХХК гүйцэтгэж байна. 4 дүгээр улирлын байдлаар талбайд ул хөрс, далангийн дүүргэлт, хөлдөлтөөс хамгаалах үе, суурийн доод үе, хиймэл байгууламж, гүүр, суурийн ажил 100 хувь, 40 км ЦБС, 18 км суурь хучилт, өнгө хучилт 3 км хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 86 хувь. 2023 онд төлөвлөсөн хөрөнгийг бүрэн ашигласан.

3.6.1.5.1.Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт)

Биелэлт: Концесс эзэмшигч автозамын ажлыг хийж дуусгаагүй ба Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт)-ийн эргэн төлөлт нь эхлээгүй бөгөөд ажил гүйцэтгэгч компани 2017 оноос төслийг эхлүүлэн явц 64 хувийн хэрэгжилттэй байна.

3.6.1.5.2.Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт)

Биелэлт: Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт) төсөл, арга хэмжээ 2019-2023 онд 26.6 тэрбум төгрөгийн төсөв өртөгтэй батлагдаж, 2016 онд 2.6 тэрбум, 2022 онд 9 тэрбум, 2023 онд 14.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус улсын төсвөөс олгосон.

3.6.1.5.3.Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт)

Биелэлт: Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөлд 2020 онд улсын төсвөөс 62.9 тэрбум төгрөг, 2021 онд 45.0 тэрбум төгрөг, 2022 онд 94.5 тэрбум төгрөг, 2023 онд 96.06 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

3.6.1.5.4.Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт)

Биелэлт: "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам" төслийн төсөвт өртөг 218.9 тэрбум төгрөг, 2021 онд санхүүжигдэх дүн 131.4 тэрбум төгрөг, 2022 онд 87.6 тэрбум төгрөг батлагдсанаас 75.7 тэрбум төгрөг олгосон.

3.6.1.5.5.Өмнөговь аймгийн төвийг Нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт)

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 102.3 тэрбум төгрөгөөр, 2022 онд санхүүжигдэх дүнг 22.9 тэрбум

төгрөгөөр, хэрэгжих хугацааг 2022-2023 он гэж баталсан.

Концессын "барих-шилжих" төрлөөр хэрэгжүүлсэн тус төсөлд 2022 онд 22.9 тэрбум төгрөг батлагдсанаас 11-р сарын 22-ны өдрийн байдлаар 22.9 тэрбум төгрөг олгож 2022 онд олгох санхүүжилтийг бүрэн олгосон.

3.6.1.5.6. Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл (Концессын эргэн төлөлт)

Биелэлт: "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам" төсөлд 2020 онд 130.0 тэрбум төгрөг, 2021 онд 45.0 тэрбум төгрөг олгосон.

3.6.1.6.1. Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдаж, 20.8 тэрбум төгрөг төлөвлөснийг 2.5 тэрбум төгрөг болгон баталсан. Төрийн худалдан авах ажиллагааны газар сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлаж, сүүлийн тендерийг 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр нээсэн боловч оролцогч оролцоогүй байна. Иймд тус ажлын төсөвт өртгийг дахин магадлалаар оруулж, 2023 оны улсын төсөвт санхүүжилтийг суулгасан.

Багц 2, 3, 4 дүгээр багцын гүйцэтгэгч шалгарч зам барилгын ажлыг эхлүүлсэн, Багц 1 дээр маргаан гарсан учир 4 дэх удаагаа дахин зарлаад байна. Зам барилгын ажил 10-25 хувийн гүйцэтгэлтэй буюу ажлын явц дунджаар 15 хувь байна. 2023 оны Улсын төсөвт нийт төсөвт өртгийн 10 хувь суусан ба 2023 онд тусгагдсан төсвийн хүрээнд ажил хийгдэж дууссан.

3.6.1.6.2. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Овоотын уурхайгаас Арцсуурь хилийн боомт хүртэлх авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна.

Биелэлт: "Нөмрөг Сонгино чиглэлийн 167 км авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам"-ын инженерийн нарийвчилсан зураг төслийг "Аварга зам" ХХК боловсруулан 229/2021 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулан тус яаманд хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн цахим системд дээрх төсөл арга хэмжээг тусгасан. "Аспайр Майнинг Лимитед" компани Овоотын коксжих нүүрсний ордыг 100 хувь эзэмшдэг бөгөөд уурхай эзэмшигчид ТЭЗҮ, зураг төслийн ажлын даалгаврыг хүргүүлсэн.

3.6.1.6.3. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барина.

Биелэлт: Засгийн газрын 2018 оны 330 дугаар тогтоолоор концессын гэрээг "Ундрах говь" ХХК-тай байгуулахыг Үндэсний хөгжлийн газарт зөвшөөрсний дагуу 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигчийн зүгээс гэрээний 1.26-д заасан нөхцөлүүдийг хангаж, 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр концессын гэрээ хүчин төгөлдөр болсон. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 137 дугаар тушаалаар авто замын чиглэлийг баталсан.

Гүйцэтгэгч компани зам барилгын ажлыг эхлүүлэхээр нүүлгэн шилжүүлэлтийн ажил эхэлсэн боловч нутгийн иргэд, малчдын эсэргүүцэлтэй тулгаран, тодорхойгүй нөхцөл

байдал үүсэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Хүрмэн сумын Жанжин багт ард иргэдтэй уулзалт хийсэн. Уулзалтаар хөндөгдсөн асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр авто замын бүтээн байгуулалтын бүсэд хамаарч буй орон нутгийн иргэдэд хөгжлийн төслийн бүтээн байгуулалт, ач холбогдлын талаар таниулах, нөхөн олговрын асуудлыг концесс эзэмшигч аж ахуйн нэгжтэй хамтран тохиролцож, шийдвэрлэхийг Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, ЗТХСС Л.Халтар нарт даалгасан. Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу ажлын хэсэг 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдөр малчидтай уулзалт хийж, тохиролцоонд хүрч чадаагүй.

Ерөнхий сайд 2022 оны 5 дугаар сарын 26-аас 27-ны өдрүүдэд Цагаандэл-Уул боомтод ажиллан Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолыг түдгэлзүүлэх асуудлыг Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 107 дугаар захирамж гарган Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нараас бүрдсэн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

3.6.1.6.4.Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замыг барина.

Биелэлт: Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам барилгын ажлыг 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлэн, далан, ухмал, дэд суурь, цементээр бэхжүүлсэн суурийн 1-р үе, хиймэл байгууламжийн ажлыг гүйцэтгэсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 69 хувь байна.

3.6.1.6.5.Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замыг барина.

Биелэлт: Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто зам барилгын талбайд үйлдвэр барих, далангийн дүүргэлт, материал бэлдэх, хучилтын ажил, карьерын материалын шинжилгээ, хиймэл байгууламжийн угсралт, хайрган хөвөөний ажлууд хийгдэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 93 хувь байна.

3.6.1.6.6.Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замыг барина.

Биелэлт: Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замын барилгын ажил дууссан тул улсын байнгын ашиглалтад хүлээн авах комисс томилон ажиллуулах хүсэлт өгөөд байна.

3.6.1.7.Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт:

3.6.1.8.1.Хэнтий аймгийн Жаргалтхаан сум-Өмнөдэлгэр сум-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр сум-Баян-Адарга сум-Дадал сум чиглэлийн 290 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Тус чиглэлийн эхлэлийн Улаанбаатар-Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлгэр сум хүртэлх 52.5 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар зам барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь байна.

3.6.1.8.2.Өвөрхангай аймгийн Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн 90.1 км хатуу хучилттай авто зам, Орхон голын 220 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Орхон голын 220 у/м төмөрбетон гүүрийг "Мотор сервис" ХХК 100 хувь барьж гүйцэтгэн 2021 онд улсын байнгын ашиглалтад оруулсан. Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай замын барилгын ажлыг "Мотор сервис" ХХК, "Өндөр сант хайрхан" ХХК-ийн түншлэл 67941.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. 2022 онд 1.3 тэрбум төгрөг, 2023 онд 11.2 тэрбум төгрөг тусгагдсан. Гэрээний хугацаа 2025 онд дуусна. 4-р улирлын байдлаар талбайд замын чиг сэргээх 100 хувь, ургамлын үе хуулах 96 хувь, ухмал 99 хувь, тохиромжгүй материал зайлуулах 92 хувь, зөөврөөр далан 90 хувь, хөлдөлтөөс хамгаалах үе 38.9 хувь, суурийн доод үе 32.5 хувь, хиймэл байгууламжийн ажил хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 51 хувь байна.

3.6.1.8.3.Баянхонгор аймгийн төвөөс Шаргалжуут чиглэлийн 54.17 км хатуу хучилттай авто замын төслийг эхлүүлнэ.

Биелэлт: "Гео зураглал" ХХК инженерийн нарийвчилсан зураг төслийг 2014 онд хийж гүйцэтгэсэн. 2024 оны Улсын төсөвт тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулж байна.

3.6.1.8.4.Завхан аймгийн Донойн нисэх буудлаас Улаагчины хар нуур хүртэлх 74 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: "Ар Си Эс Си" ХХК инженерийн нарийвчилсан зураг төслийг 2020 онд хийж гүйцэтгэсэн. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

3.6.1.8.5.Завхан аймгийн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Завхан аймгийн төвийг нийслэл хоттой холбох Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто замын төслийг БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500.0 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн бөгөөд энэхүү төслийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Чайна Коммуникэйшн Констракшн" ХХК шалгарч 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр тус яамтай 20.9 сая ам.долларын төсөвт өртөгтэй гэрээг байгуулсан ба хяналтын зөвлөх үйлчилгээний санхүүжилттэй холбоотойгоор барилга угсралтын ажлыг 2019 оны 06 дугаар сард эхлүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар барилгын ажил бүрэн дуусаж 06/12/22 дугаар дүгнэлтээр улсын комисс ажиллан хүлээлгэн өгсөн.

3.6.1.8.6.Говьсүмбэр аймгийн Даланжаргалан сумаас Хэнтий аймгийн Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Тус авто замын 2021 оны барилгын ажил 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр эхэлсэн. 2022 оны 4-р улиралд барилгын ажил бүрэн дуусаж, ашиглалтад 100 хувь оруулсан.

3.6.1.8.7.Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 136 км авто зам, Орхон голын төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Орхон гол-Батцэнгэл чиглэлийн 63км хатуу хучилттай авто замын барилгын ажлын талбайд далан хөлдөлтөөс хамгаалах үе, ухмал, 220 у/м гүүрийн ажил хийгдсэн. 2021 оны төлөвлөсөн хөрөнгө дууссан ба санхүүжилтийг 2022-24 онд улсын төсөвт хэсэгчлэн тусгахаар оруулсан байна. Барилгын ажлын гүйцэтгэл 86 хувь байна.

3.6.1.8.8.Багануур хотоос Төв аймгийн Мөнгөнморьт сум хүртэл 60 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдаж, 6.4 тэрбум төгрөг төлөвлөснийг 3.8 тэрбум төгрөг болгон баталсан. Бараа материал, түлшний үнэ батлагдсан төсвөөс 2-3 дахин өссөн тул барилгын ажил хийгдэх боломжгүй төсөвт дахин магадлал хийх шаардлагатай талаар гүйцэтгэгч хүсэлт ирүүлж барилгын ажлыг түр зогсоогоод байна. 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдөр Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд “Тотал инж” ХХК-аас гаргасан “Гэрээ цуцалсан тушаалыг хүчингүй болгох” тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Зам, тээврийн хөгжлийн яамнаас илүү санхүүжилтийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргасан, шүүхийн маргаан үргэлжилж байна.

3.6.1.8.9.Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлнэ.

Биелэлт: Зам барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.1.8.10.Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Зам барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.1.8.11.Булган аймгийн Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замыг барина.

Биелэлт: Булган аймгийн Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 31.08 км хатуу хучилттай авто замыг 29880.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэхээр "РЭС" ХХК шалгарсан. 2022 онд Улсын төсөвт 9.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 1.2 тэрбум төгрөг, 2023 онд 16.8 тэрбум төгрөг тусгагдсан. Уг авто замын үлдэгдэл хөрөнгө болон тус авто замын үргэлжлэл болох Гурванбулаг хүртэлх 67.8км авто замыг шинээр барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар талбайд замын чиг сэргээх 100 хувь, түр зам байгуулах 100 хувь, тохиромжгүй материал зайлуулах 90 хувь, ургамлын үе хуулах 100 хувь, зөөврөөр далан 93.8 хувь, тэсэлгээний ажил 85.6 хувь, ЦБС 33 хувь, хиймэл байгууламжийн ажил тус тус хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувь байна.

3.6.1.8.12.Булган аймгийн Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 53.6 км хатуу хучилттай авто замын төслийг эхлүүлнэ.

Биелэлт: Тус арга хэмжээг 2024 оноос хэрэгжүүлж эхэлнэ.

3.6.1.8.13. Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Арбулаг чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Арбулаг чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг “Ростов” ХХК 2022 онд хийж гүйцэтгэсэн. Санхүүжилтийг 2024 оны улсын төсөвт тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулж байна.

3.6.1.8.14. Хэнтий аймгийн Чингис-Норовлин-Дадал чиглэлийн 255 км хатуу хучилттай авто замыг барина.

Биелэлт: Тус чиглэлийн эхлэлийн Чингис хот-Бэрх чиглэлийн 70 км хатуу хучилттай авто замыг 2022 онд байнгын ашиглалтад оруулсан. Үргэлжлэл Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км хатуу хучилттай авто замын багц-1-ийн 68 км хатуу хучилттай авто замыг “Наранбулаг-Хан” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилга угсралтын ажил 89 хувь байна. Эхлэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажил дууссан. Багц 2-ийн 62 км хатуу хучилттай авто замыг “Мотор сервис” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд зам барилгын ажил 60.7 хувь байна. Нийт 130 км хатуу хучилттай авто замын ажлын хэрэгжилт 74.8 хувь байна. Гэрээний хэрэгжих хугацаа 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дуусна.

3.6.1.8.15. Баян-Өлгий аймгийн Өлгий хот-Улаанхус сум-Алтай таван богд уул чиглэлийн 118 км хатуу хучилттай авто замын төслийг эхлүүлнэ.

Биелэлт: Баян-Өлгий аймгийн Өлгий хот-Сагсай сум-Улаанхус сум-Цэнгэл сум чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын зураг төслийг “Эм Ай Эл” ХХК боловсруулсан. 2024 оны Улсын төсөвт Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дөрөвдүгээр хэсэг, 23.13 км /Баян-Өлгий/ тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг бүрэн хангуулсан.

3.6.1.8.16. Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн 474.2 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ хийнэ.

Биелэлт: Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн 487.7 км авто замын зураг төслийг 2022 онд “Эм Си Пи Си Жи Ар” ХХК боловсруулсан. 2024 оны Улсын төсөвт Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Арвайхээр-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат (Өвөрхангай), Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Мандалговь-Чойр чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат (Дундговь), Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Чойр-Их залаат овооны ар хүртэлх хатуу хучилттай авто замын эхний үе шат (Говьсүмбэр)-ыг тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг бүрэн хангуулсан.

3.6.1.8.17. Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барина (Ховд, Увс аймаг)

Биелэлт: Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замын "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл, III үе шат"-ны хүрээнд хэрэгжүүлэхээр АХБ-тай зээлийн хэлэлцээрийг хийж МУИХ-аар батлуулсан. Гүйцэтгэгчийг сонгон

шалгаруулах сонгон шалгаруулалтыг яаралтай эхлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч байна.

3.6.1.8.18.Эрдэнэт-Жаргалант чиглэлийн авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна.

Биелэлт: Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн А1001 авто замын Орхон сумын уулзвартай холбох 92.28 км авто замын зураг төслийг 2021 онд “Эм Си Пи Си Жи Ар” ХХК боловсруулсан. 2024 оны улсын төсөвт тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулж байна.

3.6.1.8.19.Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төсөл (Концессын эргэн төлөлт)

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тухайн төсөл, арга хэмжээнд зарцуулах 1762.0 сая төгрөг тусгагдаж, олгогдсон.

3.6.1.9.Эдийн засгийн үр ашигтай, хөдөө аж ахуйн тээвэрлэлтийг дэмжсэн "Нутгийн зам төсөл"-ийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Богд, Чигэстэйн голын 290.03 у/м төмөр бетон гүүрийн зураг төслийн “ГБЭТ” ХХК боловсруулсан. 2024 оны улсын төсөвт тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулж байна.

3.6.1.10.1. Хэнтий аймгийн Биндэр сумын Онон голын 209.0 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Онон голын 209 у/м төмөрбетон гүүр /Хэнтий, Биндэр сум/-ийн барилгын ажлыг 100% хийж гүйцэтгэн, 2021.08.24-нд улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулсан.

3.6.1.10.2.Завхан аймгийн Ургамал сумын Хүнгүйн голын 72 у/м төмөр бетон гүүрийг барина

Биелэлт: Завхан аймгийн Ургамал сумын Хүнгүйн голын 72 у/м төмөр бетон гүүрийг барих ажлын санхүүжилт Монгол Улсын 2023, 2024 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй.

3.6.1.10.3.Ховд аймгийн Дөргөн сумын Чоно харайхын голын 36.8 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Ховд аймгийн Дөргөн сумын Чоно харайхын голын 36.8 км урт/метр гүүрийг 06/15/22 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.

3.6.1.10.4.Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Онги голын 54.8 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Онги голын 54.8 у/м төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил 100 хувь дуусах, Улсын комисс 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдөр ажиллаж №06/01/21 дүгээр дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан.

3.6.1.10.5.Хөвсгөл аймгийн Ханх сумын Ханх-Монд чиглэлийн 23 км хатуу хучилттай авто замын Цагаан сайрын 72.85 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.1.10.6.Завхан аймгийн Улиастай сумын Богд Чигэстэйн голын 290.03 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Богд, Чигэстэйн голын 290.03 у/м төмөр бетон гүүрийн зураг төслийн "ГБЭТ" ХХК боловсруулсан. 2024 оны Улсын төсөвт тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулж байна.

3.6.1.10.7.Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэрийн голын 97 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: "Ар Си Эс Си" ХХК Идэрийн голын 97 у/м төмөрбетон гүүрийн зураг төслийг 2020 онд боловсруулсан. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.1.10.8.Говь-Алтай аймгийн Шарга сумын Эвийн голын 32 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Гүйцэтгэгчээр "Тоёо" ХХК шалгарч гэрээ байгуулан барилгын ажлыг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр эхэлсэн. Гүүрийн барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь, ашиглалтад хүлээн авсан.

3.6.1.10.9.Хэнтий аймгийн Батширээт сумын Бархын голын 121.36 у/м төмөр бетон гүүрийг барина.

Биелэлт: Улсын төсөвт 1.5 тэрбум төгрөг тусгагдсан. 2022 оны 3-р улиралд тендерийг зарлаж, "ЗЗБ" ХХК-тай гэрээ байгуулан Хэнтий аймгийн Батширээт сумын Бархын голын 121.36 у/м төмөрбетон гүүрийн барилга угсралтын ажил бүрэн дуусгасан.

3.6.1.10.10.Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Завхан голын төмөр бетон гүүр.

Биелэлт: Завхан голын 181.15 у/м төмөр бетон гүүрийн зураг төслийг "Ар Си Эс Си" ХХК 2021 онд боловсруулсан. 2024 оны улсын төсөвт тусгаж, 2024 онд барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулж байна.

3.6.2.Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналтын механизмыг бүрдүүлэх замаар авто замын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн авто замын санг бие даасан үйл ажиллагаанд шилжүүлнэ:

3.6.2.1.1.Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний нийт 579 км хатуу хучилттай авто замд их засвар шинэчлэлт хийнэ.

Биелэлт: 2023 оны улсын төсвийн тухай хуульд их засварын ажилд зориулан 35 тэрбум төгрөг батлагдсан. Тайлант хугацаанд хэрэгжиж байгаа их засвар, шинэчлэлтийн ажлаас дурдвал АХБ-ны хөрөнгө оруулалтаар Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил 85 хувь, Хүйтний Хөндийгөөс Арвайхээр

чиглэлийн 58 км авто замын их засварын ажил 98 хувь, Зам, тээврийн хөгжлийн сайдын багцаас Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 6 багц ажилд нийт 50.5 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэж, байнгын ашиглалтад хүлээн авсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/118 дугаар тушаалаар нийт 7 чиглэлд 35.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 56.2 км хатуу хучилттай авто зам засварлах ажил хийгдэж байна. Ажлын явц 93 хувь, Дэлхийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд олон улс, улсын чанартай нийт 361 км хатуу хучилттай авто зам, 1205 м урттай 8 төмөрбетон гүүрийг засварлахаар Засгийн газрын хуралдаан, байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжигдсэн. Зээлийн санхүүжилтийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

3.6.2.1.2. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний нийт 334 км хатуу хучилттай авто замд ээлжит засварын ажлыг хийнэ.

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар “Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалтын 2022 оны төлөвлөгөө”-ний дагуу нийт 46.3 км авто замд ээлжит засварын ажил гүйцэтгэсэн. 2023 оны улсын чанартай авто замын ээлжит засварын ажилд 15.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн ба уг хөрөнгөөр хийгдэх ээлжит засварын ажлын төрөл, байршил зарцуулах хөрөнгийн хэмжээг батлах тухай Сайдын А/167, А/181 дугаар тушаал батлагдаж, 73.9 км авто замд ээлжит засварын ажлыг гүйцэтгэсэн.

3.6.2.1.3. Олон улсын болон улсын чанартай 14,918.7 км авто замын сүлжээнд урсгал засвар арчлалт хийнэ.

Биелэлт: Олон улсын болон улсын чанартай 14,918.7 км авто замын урсгал засвар арчлалтын ажлын 2021, 2022, 2023 оны төлөвлөгөөг замын чиглэл бүрээр, хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчим, эвдрэлийн байдал зэргээс хамаарч зам хариуцагч бүрээр тооцон гаргаж Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар батлуулан зам хариуцагч 32 компанитай засвар арчлалтын гэрээг байгуулж, засвар, арчлалтын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгүүлэн, улсын чанартай авто замын сүлжээний бэлэн байдлыг хангуулан ажилласан.

3.6.2.1.4. Авто зам засвар арчлалтын байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дүгээр тушаалаар батлагдсан “Зам, тээврийн салбарын стратеги төлөвлөгөө”-ний хавсралтаар “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний арчлалт, засвар, ашиглалтыг сайжруулж, чадавхыг бэхжүүлэх дэд хөтөлбөр” батлагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

- Замын засвар арчлалтын шинэ технологи болох нөхөөсний засварыг хэрхэн хийх талаар Беларусь улсаас ирсэн мэргэжилтэн зам хариуцагч төрийн өмчит 20 компанийн ажилтнуудад үзүүлэх сургалтыг зохион байгуулж, чадавхыг бэхжүүлсэн;
- Беларусь улсын МАЗ үйлдвэрээс зам хариуцагч төрийн өмчийн компаниудад замын засвар арчлалтын тусгай зориулалтын 42 техникийг хүлээлгэн өгч чадавхыг бэхжүүлсэн;
- Лазераар авто замын хучилтын эвдрэл, хагарлыг хэмжигч буюу Romdas системийг нэвтрүүлснээр орчин үеийн дэвшилтэт аргаар замын хучилтын

эвдрэлийн хэмжээ, засвар арчлалтын хэрэгцээ, ажлын тоо хэмжээг нарийвчлалтайгаар тодорхойлох нөхцөлийг бүрдүүлсэн;

- Гадаргуун боловсруулалтын машин 2 /Chip sealer, Slurry sealer/ зэрэг шинэ орчин үеийн техник, төхөөрөмжийг АХБ-ны Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төслийн хүрээнд нийлүүлсэн ба тус техник, тоног төхөөрөмжийг ашиглах ээлжит засварыг гүйцэтгэх, замын ашиглалтын хугацааг уртасгах нөхцөлийг бүрдүүлсэн;
- Нийт давхардсан тоогоор засвар арчлалтын байгууллагуудын 48 инженерийг мэргэшсэн, дадлагажигч инженерийн болон төсөвчний анхан шатны сургалтад хамруулсан зэрэг байна;
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион байгуулах асуудлыг хэлэлцэж, "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК байгуулах тухай 220 дугаар тогтоол баталсан.

3.6.2.1.5. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 57.56 км хатуу хучилттай авто замын их засварын ажил.

Биелэлт: “Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын их засвар болон гүйцэтгэлд суурилсан засвар арчлалтын ажил”-ын “Гэрээний ерөнхий нөхцөл”-ийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу 2023 онд ашиглалтад оруулсан.

3.6.2.2.1. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Онгийн голын 166 у/м төмөр бетон гүүр

Биелэлт: АХБ-ны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Хүйтний Хөндийгөөс Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засварын ажлын хүрээнд тус гүүрийн засварыг хэрэгжүүлэхээр болсон. Гэвч Зураг зохиогч “Ар Си Эс Си” ХХК болон гүйцэтгэгч “Эйч Кэй Би” ХХК, орон нутаг, төсөл хэрэгжүүлэх нэгж, захиалагч, зөвлөх “Ай Си ТИ сайн консалтинг” ХХК нар хамтран гүүрэнд үзлэг хийж, үзлэгээр гүүрийг АХБ-аас тавигдсан хөрөнгөөр бүрэн засварлах боломжгүй болсон. Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тус гүүрэнд их засвар шинэчлэлт хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан. Зураг төслийг боловсруулж АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. 2024 онд барилгын ажлыг эхлүүлнэ.

3.6.2.2.2. Увс аймгийн Түргэн сумын Түргэний голын 160.8 у/м төмөр бетон гүүр

Биелэлт: Тус арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.2.2.3. Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Байдрагийн голын 108 у/м төмөр бетон гүүр

Биелэлт: Тус арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.2.2.4. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Усан хоолойн 36 у/м төмөр бетон гүүр

Биелэлт: Тус арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.2.2.5. Дорнод аймгийн Хэрлэн сумын Хэрлэн голын төмөр бетон гүүрийн их засвар, 264

у/м

Биелэлт: Зураг төслийг боловсруулсан. Дэлхийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд засварлахаар төлөвлөсөн. Төслийг Засгийн газрын хуралдаан, байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжигдсэн. Зээлийн санхүүжилтийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

3.6.2.2.6.Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөөгийн голын 192 у/м төмөр бетон гүүр

Биелэлт: Гүүрийн их засварын ажлын зураг төслийг боловсруулсан. Засварын ажилд 8.9 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан ба тус арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

3.6.2.2.7.Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны голын 290 у/м төмөр бетон гүүр

Биелэлт: Их засварын ажлын зураг төслийг боловсруулж хүлээлгэн өгсөн. Дэлхийн банкны "Монгол Улсын зам тээврийн холболт ба логистикийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд уг гүүрийг засварлахаар саналаа хүргүүлсэн. Зээлийн хэлэлцээрийг УИХ-аар дэмжиж баталсан тул барилгын ажлыг 2024 оны хавар эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

3.6.2.2.8.Архангай аймгийн Тариат сумын Гичгэнийн голын 90 у/м төмөр бетон гүүр

Биелэлт: Зураг төслийг боловсруулсан. Дэлхийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд засварлахаар төлөвлөсөн. Төслийг Засгийн газрын хуралдаан, байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжигдсэн. Зээлийн санхүүжилтийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

3.6.2.2.9.Олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах цэгийг цахимжуулах, Мөрөн, Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчимд төлбөр авах цэг байгуулна.

Биелэлт: Автотээврийн хөдөлгөөний эрчим бага, улсын төсөв, авто замын санд төвлөрүүлэх орлогын хэмжээ багатай, урсгал зардал их байгаа тул Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Увс аймгийн Хяргас нуур орчимд төлбөр авах цэг барих ажлыг түр хойшлуулаад байна. Дорнод аймгийн Хэрлэн, Хэнтий аймгийн Мөрөн, Улаанбаатар хотын Түргэний гүүр, Булган аймгийн Баяннуур, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Төв аймгийн Эрдэнэсант, Хөвсгөл аймгийн Мөрөн, Архангай аймгийн Тариат, Завхан аймгийн Их-Уул, Сонгино, Баян-Өлгий аймгийн Сагсай, Ховд аймгийн Манхан, Говь-Алтай аймгийн Есөн булаг суманд тус тус төлбөр авах цэг шинээр барьж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Мөн Налайх, Хоолт, Айраг, Гурт, Онги төлбөр авах цэгт засвар үйлчилгээ хийсэн байна. 2024 онд багтаан олон улс, улсын чанартай авто замд байрлах бүх төлбөр авах цэгт цахим систем нэвтрүүлнэ.

3.6.2.3.2.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын орчимд төлбөр хураах цэг байгуулна.

Биелэлт: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төлбөр авах цэгийн зам талбай, төлбөр авах саравч, төлбөр авах байр, ажилчдын ажиллах, амрах байр, бусад тохижилтын ажлуудыг бүрэн дуусгаж, төлбөр авах цэгийг 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн.

3.6.2.3.3.Олон улс, улсын чанартай авто зам дээр одоо байгаа төлбөр авах цэгт төлбөрийн

цахим систем нэвтрүүлнэ.

Биелэлт: Нийслэл хотыг тойрсон Эмээлт, Баруунтуруун, Налайх, Хоолт, Түргэний гүүр, Хөшгийн хөндийн төлбөр авах цэгт цахимаар төлбөр авах үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс нэвтрүүлсэн. Бусад орон нутагт байгаа 25 төлбөр авах цэгийг шилэн кабельд холбох ажил 75 хувь байна. Орон нутгийн төлбөр авах цэгийг цахимжуулж, 2024 онд багтаан олон улс, улсын чанартай авто замд байрлах бүх төлбөр авах цэгт цахим систем нэвтрүүлнэ.

3.6.2.3.4.Чойр, Даланзадгад, Түмэнцогт, Хяргас нуур орчинд төлбөр авах цэг байгуулна.

Биелэлт: Хөвсгөл аймгийн Мөрөн суманд төлбөр авах цэг барьж, 2022 оны 8 дугаар 17-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн. Улсын чанартай Даланзадгад-Гурвантэс-Шивээхүрэн чиглэлийн авто зам, Даланзадгад хотод орон нутгийн төсвийн хөрөнгөөр төлбөр авах цэг барьж, ашиглалтад оруулсан. Улсын төсөв, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Говьсүмбэр аймгийн Чойр хотод төлбөр авах цэг барихаар төлөвлөн ажиллаж байна. Автотээврийн хөдөлгөөний эрчим бага, улсын төсөв, авто замын санд төвлөрүүлэх орлогын хэмжээ багатай, урсгал зардал их байгаа тул Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Увс аймгийн Хяргас нуур орчимд төлбөр авах цэг барих ажлыг түр хойшлуулаад байна.

3.6.3.1.Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, парк шинэчлэлтийг хийнэ (900ш).

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/130 дугаар захирамжаар Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт (Нийтийн тээврийн парк шинэчлэлт) хийх санхүүжүүлэх 21,393.9 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг шилжүүлсэн. Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолд ЗГҮАХ-ийн 3.6.3.1 дэх арга хэмжээний 2022-2023 оны хүрэх түвшинг “270 автобус” гэж төлөвлөсөн.

2021 онд 35 автобус, 2022 онд 71 автобус, Узбекистан улсаас туршилтаар ирсэн 2 автобус, 2023 оны 1 дүгээр улиралд 224 автобус, нийтдээ 332 автобусаар парк шинэчлэлт хийгдсэн бөгөөд 224 автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нам шал, тавцан, гишгүүр, зориулалтын зорчих хэсэг болон дотор талын зорчих хэсгийн зарлан мэдээлэх, урсдаг лед дэлгэцийг суурилуулан ашиглаж байна. 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй (Skywell) автобус нийлүүлэгдсэн бөгөөд үйлчилгээнд гаргав.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Тэнүүн-Огоо” ХХК-тай 2023 оны Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001 дугаартай гэрээ, ННТГ23001-01 дугаартай нэмэлт гэрээг хэсэгчлэн цуцалсантай холбогдуулан Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобус худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 1 сарын хугацаатай зарласан олон улсын нээлттэй тендерт шалгарсан БНХАУ-ын Yutong Bus Co.,Ltd компани 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдөр эхний ээлжийн 35 автобусыг нийлүүллээ.

3.6.3.2.1.Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.

Биелэлт: Байгалийн хийн импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч “Юу Би Метан” ХХК нь 2021 онд 1000 тонн шахсан байгалийн хий импортлон, нийслэлийн нийтийн тээврийн 100 орчим хийн хөдөлгүүртэй автобусыг цэнэглэж, Баянзүрх дүүргийн Монелд тээврийн хэрэгслийг байгалийн хий, ШШХ, шатахуунаар цэнэглэх станц барьж байгуулахаар зураг, төслийг батлуулан, эхний хэсгийг Улсын онцгой комисст хүлээлгэн өгсөн. Мөн Сонгинохайрхан дүүргийн Рашаант өртөөнд байгалийн хийн агуулах, хий цэнэглэх станц барих төслийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 80 гаруй хувьтай явагдаж байна.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд 2022 онд Улаанбаатар хотод цахилгаанаар ажилладаг автомашин цэнэглэх станц 4, Хэнтий аймагт 3, Өмнөговь аймагт 7, нийт 14, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх станц орон нутагт 1, УБ хотод 4, нийт 5-ыг байгуулсан. Улсын хэмжээнд 20-60 квт-ийн хүчин чадалтай цахилгаан автомашин цэнэглэх 25, өндөр хүчин чадалтай их багтаамжийн цахилгаан автобус цэнэглэх 11, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх 21 аймагт 80, УБ хотод 54 станц ажиллаж байна.

3.6.3.2.2.Замын-Үүд, Сэлэнгэ, Булган, Орхон, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн авто буудал байгуулна.

Биелэлт: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зорчигч тээврийн авто буудал байгуулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна:

- “Зорчигч Тээврийн Ховд” ХХК нь Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт байрлах өөрийн эзэмшлийн 5000м2 талбай бүхий газарт 3.7 тэрбум төгрөг өртөг бүхий 20 автобусны дулаан зогсоол, 12 метрийн урт суваг бүхий оношилгооны төв, зориулалтын үйлчилгээний нэгдсэн төвтэй 6 давхар байгууламж бүхий авто буудлын барилга барьж байна. Ажлын явц 80 хувь.
- “Жем Интернэшнл” ХХК нь “Дорноговь аймгийн Замын-Үүд суманд зорчигч тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэхээр зураг төслийг хийж гүйцэтгээд байна.
- “Драгон Холдинг” ХХК нь Улаанбаатар хотын баруун талд өөрийн хөрөнгөөр зорчигч тээврийн авто буудал байгуулах хүсэлтээ ирүүлж, зураг төслийн ажил хийгдсэн бөгөөд барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.
- 2022 оны төсвийн тухай хуульд Орхон аймагт авто буудал байгуулах 5 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг тусгасан. Мөн тус авто буудлыг байгуулах 1.2 га газрын асуудлыг шийдвэрлэсэн.
- “Бүрд чандмань” ХХК Хэнтий аймгийн Хэрлэн сумд авто буудал, мөн “Гэээгт” ЗГБХН-ээс Говьсүмбэр аймгийн төвд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа байранд өргөтгөл хийж авто буудал байгуулах санал, ТЭЗҮ ирүүлснийг хэрэгжих боломжтой гэж үзэн хамтран ажиллах гэрээ байгуулсан.
- “Өв хангамж групп” ХХК нь авто буудал барих газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
- Улсын төсвийн 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд Орхон аймгийн төвд авто буудлын барилга барих тендерт “Шинжүү” ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 90 хувьтай 3,040.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.
- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутагт барьж буй олон улсын Зорчигч тээврийн авто буудлын барилгыг үргэлжлүүлэн барих боломжтой эсэхэд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, барих төсөвт өртгийг тооцох ажлуудыг “АТҮТ” ТӨҮГ хийлгэн төр, хувийн хэвлийн түншлэлээр хүрээнд 2024 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бариулах сонгон шалгаруулах ажил

хийж байна.

- Улсын төсвийн 2024 онд төсөвт Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн авто буудал барих хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн.

3.6.3.2.3. Улаанбаатар хотын баруун зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлнэ

Биелэлт: 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдааны 27 дугаар тэмдэглэлд: Томоохон зах, логистикийн төвийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазар нарт даалгасан.

Зүүн бүсийн тээвэр, логистикийн хувьд нийслэлийн зүгээс “Туушин” ХХК-тай 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хамтран ажиллах гэрээг байгуулсан.

2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Олон улсын худалдаа логистикийн төв ХК, БНХАУ-ын “Чайна Рэйлвэй Констракшн Корпорэйшн” ХХК хамтран Улаанбаатар хотын баруун бүсийн тээвэр логистикийн төв байгуулах төслийн ТЭЗҮ-ийг хамтран боловсруулах, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр Санамж бичигт гарын үсэг зурсан.

3.6.3.2.4. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, Гашуунсухайт боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулна.

Биелэлт: Зүүн бүсийн тээвэр, логистикийн хувьд нийслэлийн зүгээс 2022 онд “Туушин” ХХК-тай санамж бичиг байгуулсан. 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК, “Туушин” ХХК-тай хамтран Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурсан.

3.6.3.3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төвийн төслийг эхлүүлнэ.

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдаас 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 01/3763 дугаар албан бичгээр гэрээнд заасан хөрөнгө оруулах үүргээ биелүүлээгүй БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Өвөр Монголын уурхайн үйлдвэрийн эд хөрөнгийн хамааралтын” ХХК-тай 2018 онд байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн хамтран ажиллах гэрээг хууль тогтоомжийн хүрээнд цуцлах чиглэл “Монголын төмөр зам” ТӨХК-д хүргүүлсэн. “Монголын төмөр зам” ТӨХК нь төслийг бие даан хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

3.6.3.4. Төмөр замын сүлжээг түшиглэн олон улсын стандартад нийцсэн хуурай боомтыг барьж байгуулна. Нийслэлийн Налайх дүүрэгт Улаанбаатар төмөр замыг түшиглэн олон улсын стандартад нийцсэн ачаа тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.

Биелэлт: Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад 39 төсөл, түүний дотор уг төслийг багтаан батлуулахаар 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 17 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор тус концессын зүйлийн жагсаалтыг батлаагүй байна.

2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК,

“Туушин” ХХК-тай хамтран Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх Санамж бичигт гарын үсэг зуран тус төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

3.6.4.1.1. Агаарын харилцааны зохицуулалтыг сайжруулж, агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар Испанийн Вант Улсын Засгийн газар хооронд байгуулах Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр үзэглэсэн.

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газартай байгуулах “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохирсон, цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ноот бичиг солилцож үзэглэх, цахим арга хэмжээг зохион байгуулахаар тохиролцсон.

Азербайжан, Грек, Лавти, Унгар, Кувейт Улстай байгуулах “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурж албажуулахад Монголын талаас шалтгаалах зүйлгүй, нөгөө талын шийдвэрийг хүлээж байна.

Нислэгийн цэг, давтамж нэмэгдүүлэх чиглэлээр БНСУ-ын талтай Улаанбаатар-Сөүл чиглэлд 2022 оны зуны цагийн хуваариас эхлэн 6-9 дүгээр сард долоо хоногт тал тус бүр 5000 суудлын багтаамж буюу Монголын тал 20, Солонгосын тал 18 нислэг гүйцэтгэхээр, 5-10 дугаар сард долоо хоногт тал тус бүр 2500 суудлын багтаамж буюу Монголын тал 11, Солонгосын тал 9 нислэг гүйцэтгэх одоогийн тохиролцоог хэвээр хадгалахаар тохирч, 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдөр Санамж бичиг байгуулсан.

Улаанбаатар-Хонконг чиглэлийн нислэгийн давтамжийг долоо хоногийн 11 байсныг 15 болгож нэмэгдүүлсэн, ОХУ-тай Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Улаангом, ОХУ-ын нутаг дэвсгэр дээр Кызыл нислэгийн цэгийг нэмж тохирч, нислэг гүйцэтгэх зохицуулалт бүрдүүлсэн.

3.6.4.1.2. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон (“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт 78.8 хувь, “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн хэрэгжилт 68 хувь).

3.6.4.1.3. Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийг барьж, дуусган ашиглалтад оруулна.

Биелэлт: Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга нь нийт 5 блок барилгаас бүрдэнэ. Үүний Б блок буюу Улаанбаатар хотын бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн барилгын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.6.4.1.4. Агаарын навигацийн үйлчилгээний техник технологийг шинэчилнэ.

Биелэлт: Барилгын ажлын гэрээний гүйцэтгэгч нь үүргээ биелүүлээгүй тул гэрээний тусгай нөхцөлд заасан нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлж нэхэмжилсэн. Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн Б корпус ашиглалтад ороогүй тул агаарын навигацийн үйлчилгээний техник технологийг шинэчлэх боломжгүй байна.

3.6.4.2.1.Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2023 оны 253 дугаар тогтоолоор төслийг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулсан. Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 264, 265, 266, 267 дугаар тушаалаар төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, 11 дүгээр сарын 22-ны өдөр нээсэн ч амжилтгүй болсон тул 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр дахин зарлан, нээх хуулийн хугацааг хүлээж байна.

3.6.4.2.2.Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2023 оны 253 дугаар тогтоолоор төслийг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулсан. Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 264, 265, 266, 267 дугаар тушаалаар төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, 11 дүгээр сарын 22-ны өдөр нээсэн ч амжилтгүй болсон тул 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр дахин зарлан, нээх хуулийн хугацааг хүлээж байна.

3.6.4.2.3.Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Ховд аймгийн “Ховд”, Хөвсгөл аймгийн “Мөрөн”, Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлын хүчин чадлыг 4С, Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлын хүчин чадлыг 4D ангиллын болгон нэмэгдүүлэх төслийг Засгийн газрын 2022 оны хуралдааны 14 дүгээр тэмдэглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Засгийн газрын 2023 оны 253 дугаар тогтоолоор төслийг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэлтээр оруулсан. Уг тогтоолын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны газар нь даргын 2023 оны 264, 265, 266, 267 дугаар тушаалаар тус тус төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан, ажиллуулж уралдаант шалгаруулалтыг 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, мөн оны 11 дүгээр сарын 22-ны өдөр нээсэн боловч амжилтгүй болсон тул дахин зарлахаар ажиллаж байна.

3.6.4.2.4.Увс аймгийн "Дэглий цагаан" нисэх буудлын хөөрч буух зурвасын хүчин чадлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит хуралдаанаар төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн (XIV тэмдэглэл), Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 05-ны 253 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулсан.

3.6.4.2.5.Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромд их засвар хийнэ.

Биелэлт: Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны өөрийн орлогоос санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн баталсан уг жагсаалтад Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын зурвасын засварын ажил хасагдсан.

3.6.4.2.6. Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засвар.

Биелэлт: Оролцогч байгууллагуудын материал тендерийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй тул цуцлагдсан. Тус нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын их засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг 2023 онд 2 удаа зарласан боловч амжилтгүй болсон тул 2024 онд дахин тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар байна.

3.6.4.2.7. Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-ийг хэрэгжүүлж дуусгана.

Биелэлт: Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төслийн Багц 1 буюу зорчигч үйлчилгээний барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ЗТХЯ/202201070 дугаартай тендерийг 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдөр зарласан. Тендерт шалгарсан "Барилга эрч" ХХК-тай 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Ажил гүйцэтгэх 164 дугаартай гэрээг байгуулсан.

Төслийн хүрээнд 2023 онд Багц-1: Зорчигч үйлчилгээний барилга угсралтын ажлын гүйцэтгэл 48 хувь байна. Багц-2: Аэродромын барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад хүлээж авах шатанд байна. Багц-3: Нисэх буудлын тоног, төхөөрөмж холбогдох техник хэрэгслийг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, гүйцэтгэгч 2024 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээлгэн өгнө.

3.6.4.2.8. Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог нисэх буудлыг зорчигч үйлчилгээний цогцолбор шинээр барьж, дуусган ашиглалтад оруулна.

Биелэлт: Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборын барилгын гүйцэтгэгчээр "Биг Монголиа Билдинг" ХХК шалгарч, барилгын ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр эхлүүлсэн ба гүйцэтгэгч талаас төсөвт өртгийн зөрүүнээс шалтгаалж барилгын ажлаа зогсоосонтой холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/149 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулж, гэрээг дүгнэн тус нисэх буудлын барилгын ажлыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг Иргэний нисэхийн ерөнхий газарт шилжүүлсэн.

Ажлын хэсгээс гэрээний хугацааг 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл сунгаж, үлдэгдэл ажлыг гүйцэтгүүлэх санал гаргасны дагуу 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр 288 дугаар нэмэлт гэрээг байгуулж, гэрээний хугацааг сунгасан ба Гэрээ-1: Зорчигч үйлчилгээний барилга угсралтын ажлын гүйцэтгэл 83 хувь байна. Гэрээ-2: Зорчигч үйлчилгээний барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна.

3.6.4.3.1. Орон нутгийн зорчигч тээврийн авто буудал, нисэх буудал, төмөр замын буудлын үйл ажиллагааг уялдуулж үр ашгийг дээшлүүлнэ.

Биелэлт: Төмөр зам, автотээврийн зорчигч тээврийн буудлын үйл ажиллагааг уялдуулах, үр ашгийг дээшлүүлэх ажлын хүрээнд "Зорчигчийн нэгдсэн тасалбарын систем"-ийг Tatapir компанитай хамтран хөгжүүлж, тус аппликейшн ашиглан, нэг цонхоор бүхий л тээврийн хэрэгслийн тасалбараа нэгэн дор захиалах боломж бүрдсэн. Хөшгийн хөндийн нисэх буудлын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчдийг сонгон шалгаруулж, "Атибус" ХХК-ийн 12, "Эрдэмтранс" ХХК-ийн 22, "Улаанбаатар такси транспорт сервис" ХХК-ийн 54, "ВИП такси сервис" ХХК-ийн 24 тээврийн хэрэгсэл тухайн чиглэлд явахаар болсон. "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ"-ыг "Интерактив" ХХК-тай хамтран хөгжүүлж байгаа

ба тус платформоор зорчиж буй тоо, зорчигч эргэлтийн мэдээллийг холбогдох бусад системүүдээс веб сервисээр татан авч, нэгдсэн цахим хяналтын самбарт өдөр, сар, улирал, жилээр графикаар гарган, бодлого төлөвлөлтдөө ашиглах боломж бүрдсэн.

3.6.4.3.2. Томоохон сум, суурин газруудад ерөнхий зориулалтын агаарын хөлгийн байнгын болон түр ажиллагаатай хөөрч буух зурвас, вертодром барих ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Хэлипортод тавих Ерөнхий шаардлага MNS6784:2019 стандартын дагуу яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх боломжтой нисдэг тэрэгний тавцан, талбайд үзлэг шалгалт хийж координатыг баталгаажуулсан. 2021 онд нисдэг тэрэгний 21 хөөрч буух талбайг байгуулсан. 2022 онд 17 аймгийн 59 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч, буух зурвас сонгон баталгаажуулахаар төлөвлөснөөс 50 байршилд зурвас сонгоод байна. Мөн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Скай Резорт" ХХК-ийн цанын бааз, "Интермед" эмнэлэг, "River garden" хотхонд, 23 давхарт нисдэг тэрэг хөөрч, буух талбайн (вертодром) үзлэг шалгалт хийж мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан.

2023 онд "АПУ" ХК-ийн Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Яргайтын аманд байгуулсан нисдэг тэрэгний талбай, "Шунхлай" ХХК-ийн Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо Ээрмэлийн гудамжинд байгуулахаар төлөвлөж буй нисдэг тэрэгний өргөгдсөн тавцанд ИНД 157-ын дагуу тус тус үзлэг шалгалт хийж, холбогдох дүгнэлтийг 2023 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 01/260 дугаартай албан бичгээр тус компанид хүргүүлсэн. ИНД-157-ын дагуу Өвөрхангай аймгийн Хархорин сумын Онгоцон хөндий, Архангай аймгийн Өгийнуур сумын "Тоглохын тал", Архангай аймгийн Хашаат сумын "Үйцийн хоолой", Өгийнуур сумын "Элсэн тал Орхоны хөндийн арал", Их тэнгэрийн аманд 2 хэлипорт, мөн "Монгол Номадик" ХХК нь Төв аймаг дахь Баянчандмань суманд хэлипорт талбай байгуулахад дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажилласан.

3.6.4.3.3. Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг эхлүүлж, байнгын ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтворжуулсан байна.

Биелэлт: "Чингис хаан" олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан 4 бүлэг, нийт 143 ажил хэрэгжүүлэн үйл ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлсэн. Шинэ нисэх буудал ашиглалтад орсонтой холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн "Чингис хаан" олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах зарим арга хэмжээний тухай 06 дугаар албан даалгаврыг баталж, олон улс, орон нутгийн нислэгийг тогтворжуулах, аюулгүй ажиллагааны хангалтыг сайжруулах, нисэх буудлыг гамшиг, цаг уурын болзошгүй эрсдэлээс сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмийг баримтлан ажиллах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нисэх буудлын үйл ажиллагаа тогтворжсон.

Барилга, хот байгуулалт

3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.7.1. Газрын харилцаа, хот байгуулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтооно.

3.7.1.1. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж Улсын Их

Хуралд өргөн барина:

- Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Кадастрын зураглал ба газрын кадастрын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл;
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Биелэлт: Газрын багц хуулийн төслийг УИХ-д 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Газрын багц хуулийн төслийн ажлын хэсгийг шинэчлэн баталж, хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслүүдэд иргэд олон нийтээс ирүүлсэн зарчмын саналуудыг авч нэгтгэн шинэчлэн боловсруулж, батлуулсан.

3.7.1.2.Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барина.

Биелэлт: Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.

3.7.1.3.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барина.

Биелэлт: Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулан яамны Цахим хуудас <https://mcud.gov.mn/forum/21>-т хуулийн төслийг холбогдох материалуудыг хамт байршуулан санал авч нэгтгэн хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээд, холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлэх хэлэлцүүлгийг 2023 оны 8 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авах ажлыг 2023 оны 12 дугаар сард зохион байгуулсан.

3.7.1.4. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна.

Биелэлт: Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын ЭЗБХ-ны 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн, УИХ-ын нэгдсэн чуулганы 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн гишүүдийн 82 хувийн саналаар уг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, УИХ-ын ЭЗБХ-нд шилжүүлсэн. УИХ-ын ЭЗБХ-оос Хуулийн төслийг УИХ-ын 2021 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд оруулсан бөгөөд Газрын тухай багц хуулийг УИХ-д өргөн мэдүүлсний дараа хамт хэлэлцүүлэхээр төлөвлөсөн.

3.7.1.5.Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна.

Биелэлт: Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 онд Улсын Их Хуралд өргөн барьсан боловч дахин шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон. Засгийн газрын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй болон ХЗДХЯ-ны 2023 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн ирүүлсэн саналтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 245 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хуулийн төслийг шинэчлэн боловсруулж байна.

3.7.1.6. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барина.

Биелэлт: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 80 заалт хэрэгжсэн, 108 заалтын хэрэгжилт хангалтгүй гэсэн дүгнэлт гарч, тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулан, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 1 дүгээр сарын 11-ний хуралдаан, 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хуулийн төслийг хэлэлцэж, 2022 оны 12 сарын 09-ний өдөр батлагдан хэрэгжиж байна.

3.7.2. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно.

3.7.2.1. Улсын хэмжээнд хот суурины төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийн жагсаалтын төсөлд 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний зургийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын саналаа ЭЗХЯ-д 2023 оны 1 дүгээр 30-ны өдрийн 1/361 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Засгийн газрын 2022 оны "Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай" 267 дугаар тогтоолын дагуу солбицлын шинэ эрин ITRF2020 эринд геодезийн хэмжилт, боловсруулалтыг хийж гүйцэтгэх болон бусад холбогдох саналыг дараах ажлуудын ажлын болон техникийн даалгаварт өгч, хамтран ажилласан. Үүнд:

- Их тэнгэрийн амын 200 га талбайд хийгдэх 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажил;
- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн хүрээнд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Нүхтийн амны 210 га талбайд 1:500-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажил;
- Увс аймгийн тариалан сумын Хөх үхэртийн Гэрсэн /600 га/, Адаргана /40 га/, Зүүнхангай сумын Далантүрүү /...га/ гэдэг газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх, ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг зохиох ажил
- "Шинэ хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанаас боловсруулсан "Шинэ хархорум" хот байгуулах нутаг дэвсгэрт хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай байр зүйн зураг зохиох ажил
- Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих "Сэлбэ сэргэлт" төслийн техник эдийн

засгийн үндэслэл, ажлын зураг төсөл боловсруулах ажлын үр дүнг 2023.06.23-ны өдрийн ГЗЗХ-2023/19 дугаартай дүгнэлтээр хүлээж авсан.

3.7.2.2.Навигацийн хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц /GNSS/-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана.

Биелэлт: Тус арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна. 2017 онд батлагдсан GNSS-ийн сүлжээг өтгөрүүлэх ажлын ТЭЗҮ-ийг “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ” (БД 81-103-21) барилгын дүрмийн дагуу зах зээлийн үнийн судалгаа, байршлын судалгаа, суурин станцуудын үйл ажиллагааны судалгаа, танилцуулгыг дахин хийж шинэчилсэн. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах ажлын хүрээнд GNSS-ийн байнгын ажиллагаатай 10 суурин станц байгуулах ажлын танилцуулга, байршлын схем, төсвийн тооцоог валютын ханшийн өөрчлөлтийг тооцон шинэчлэн боловсруулж 2023 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр МН/42 дугаар албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. 2023/142 дугаартай Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр "GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын өгөгдлийг ITRF2020 солбицлын тогтолцоонд тэгшитгэн бодох, хурдны утгыг тооцоолох" зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн тайланг ГЗЗХ-2023/35 дугаар актаар АМХ-т хүлээлгэн өгөв.

3.7.2.3.Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна.

Биелэлт: Тус арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна. Дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэв:

- Дунд масштабтай байр зүйн зургийн технологийн дарааллыг геодези, зураг зүйн чиглэлийн барилгын 4 норм, нормативын барим бичгийг үндэслэн боловсруулж, холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2023 оны 5 дугаар сарын 22-ны хэлэлцүүлж, мөн оны 6 дугаар сарын 09-ний өдөр ГЗБГЗЗГ-ын даргаар батлуулсан;
- Сансрын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах төсөл арга хэмжээний жагсаалтад уг арга хэмжээг тусгах ажлыг зохион байгуулж “хиймэл дагуулын технологи ашиглан тухай масштабын байр зүйн зургийг зохиох судалгаа, шинжилгээ, тооцоог боловсруулах” арга хэмжээг тус зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгасан;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 123 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ” /БД 81-103-21/ барилгын дүрмийн дагуу өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, зах зээлийн үнийн судалгаа, 2019-оноос өнөөдрийг хүртэл хийгдэж байгаа ажлуудын судалгааг хийж 2017 онд батлагдсан тус ажлын ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж, 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр батлав;
- Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 23/187 дугаар албан бичиг ирүүлсний дагуу “1:25000-ны масштабтай байр зүйн зураглал” хийх ажлын танилцуулга, төсвийн тооцоо, байршлын схемийг 2023 оны 1/1662 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

3.7.2.4.Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.

Биелэлт: 2017 онд батлагдсан "Монгол орны өндрийн тулгуур сүлжээг шинэчлэх" ТЭЗҮ-ийг БХБС-ын 2021 оны 123 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ" /БД 11-113-21/ барилгын дүрэмд тусгагдсан үнэ, бүрдлийн дагуу дахин шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулсан. "Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн 1-р ангийн сүлжээтэй холбох, хэмжилт хийх" ажлыг ГЗБГЗЗГ-ын урсгал зардлаар хийхээр шийдвэрлэсэн тул гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаж, ГЗБГЗЗГ нь "Геосет" ХХК-тай гэрээ 2023/89 дугаартай гэрээг 2023 оны өдөр байгуулсан /нийт төсөв 20.6 сая төгрөг/.

Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн хооронд Эхлэл цэгтэй холбох өндрийн 1 дүгээр ангийн сүлжээний хэмжилт хийгдсэн. Гүйцэтгэгчээс 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 23/42 дугаар албан бичгээр нэгдсэн тайланг ирүүлсэн бөгөөд Захиалагчийн техник хяналт хийх 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу ГЗБГЗЗГ 2023 оны 10 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд захиалагчийн хяналтыг хийж, 10 дугаар сарын 27-ны өдрийн ГЗЗХ/29 дугаар дүгнэлтийг тус газрын Архив, мэдээллийн төв хүлээлгэн өгсөн.

3.7.2.5. Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 29 дүгээр тушаалаар дээрх төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт шилжүүлсэн. Үүний дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, "Геомастер" ХХК-тай 2020/85 тоот гэрээг байгуулан, гүйцэтгэлийн явцад "Топ сүрвэй" ХХК захиалагчийн техникийн хяналтыг хийсэн. "Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулах" зөвлөх үйлчилгээ /1-3 дугаар багц/-ний 2020/85 дугаартай гэрээт ажлын ажлыг ГЗБГЗЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 2020/85-04 тоот дүгнэлт, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг Архив мэдээллийн төвд хүлээн авсан тухай 2021/ГБЗЗ/48 дугаар актаар эцсийн шатны гүйцэтгэлийг хүлээн авч, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

Хаягийн мэдээллийн санд нийт 1,081,186 нэгж талбар, 689895 барилга байгууламж, 49826 гудамжны өгөгдлийг оруулсан. Эдгээр өгөгдөлд автоматаар хаяг олгох боломжтой "Хаягийн мэдээллийн систем"-ийг хөгжүүлж, улсын хэмжээнд хот суурин газрын 650489 нэгж талбар, 283995 барилгыг хаягжуулаад байна. Мөн нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 10071 гэр хорооллын гудамж, 280332 хашаа, 89188 байшинг Хаягжуулалтын тухай хууль, журмын дагуу дугаарлаж, хаяг нэр өгч, хаягийн зураг зохион, мэдээллийн санг үүсгэсэн. Мөн Монгол Улсын 1:100000 масштабтай газар усны нэрийн тоон зургийн 258650 газар, усны нэрийн өгөгдлийг хаягийн мэдээллийн санд бүртгэж, малчдын өвөлжөө, хаваржаа, газар тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа нийт 206511 нэгж талбарт газар усны нэрийн дагуу шинээр хаяг олгоод байна. /Нууцын зэрэглэлтэй тул файл хавсаргах боломжгүй./

3.7.2.6. Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын нийслэл, 21 аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2023 оны гэрээнд уг ажлыг орон нутгийн төсөвт тусгуулж нийт 12 аймгийн 53 сум, нийслэлийн 1 дүүрэг уг ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийхээр төсвөө баталсан. Сүхбаатар, Увс, Булган, Сэлэнгэ, Сүхбаатар, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Хайрхандулаан сумын газар зүйн нэрийн мэдээллийн санг 1:100000-ны масштабтай байр зүйн зурагт давхцуулан шалгаж цэг өгөгдөл 5,389, шугаман өгөгдөл 2,106,

талбайн өгөгдөл 531 нийт 8,026 өгөгдлийг газар зүйн нэрийн мэдээллийн санг засварлав.

3.7.3.Хиймэл оюун ухаан болон блокчейн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан технологид суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ.

3.7.3.1.Цахим үйл ажиллагаатай Газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан газрын биржийн үйл ажиллагааны тодорхой хувиар газар хөгжүүлэх санг бүрдүүлнэ.

Биелэлт:Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор "Газрын биржийн үйл ажиллагааны журам"-ыг баталж, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 238 дугаар тушаалаар Газрын биржийн удирдах зөвлөлийг шинэчлэн баталсан. Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг улсын хэмжээнд хэвийн ашиглаж байна. Системийн хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.5-д тусгагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх зураг төслийн жагсаалтыг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны "Жагсаалт батлах тухай" 37 дугаар тушаалаар баталсан. Энэхүү тушаалаар "Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газрын сан бүрдүүлэх, газар хөгжүүлэлт хийх ажлын техник эдийн засгийн үндэслэл" төсөл, арга хэмжээ батлагдсан бөгөөд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Ланд овнер" ХХК шалгарч тус яамтай 2022/283 тоот гэрээг байгуулан ажлыг эхлүүлж, сүүлийн шатны тайланг хүлээн авч, ГЗБГЗЗГ-аас захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл үр дүнг газрын биржийн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. ТЭЗҮ төслийг Барилга, хот байгуулалтын яамны ШУТТЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, ТЭЗҮ-ийг батлуулсан.

3.7.3.2.Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ.

Биелэлт: Улсын хэмжээнд 3D, 4D /хэмжээст/ кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх" ажлын техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах ажлын 2021/91 тоот даалгаврыг батаж, Төрийн нарийн бичгийн даргын 2021.12.14-ний өдрийн А/150 тоот тушаалаар байгуулагдсан "Улсын хэмжээнд 3D, 4D /хэмжээст/ кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх" ажлын техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Б.Галмандах ахлагчтай зөвлөх багийг шалгаруулж, эхлэлийн шатны тайланг 2022.04.18-ны өдөр, дунд шатны тайланг 2022.07.18-ны өдөр, сүүлийн шатны тайланг, ТЭЗҮ-ийг 2022.11.18-ны өдөр тус тус хүлээн авсан. ТЭЗҮ-ийн төслийг тус яамны шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2022.12.20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэнийг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тус ажлын хөрөнгө оруулалтын хэмжээг гаргаж Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар саналыг ЭЗХЯ-д хүргүүлсэн.

3.7.3.3.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

Биелэлт: БХБЯ, ГЗБГЗЗГ-аас байрлалд суурилсан орон зайн мэдээлэл дээр өгөгдөл бүртгэх www.urban.gov.mn цахим системийг байгуулан хэрэглээнд нэвтрүүлж, ашиглаж байна. 21 аймгийн хэмжээнд барилга байгууламж 204,226ш, 3,058 байршилд 4,266,436.5 м2 ногоон байгууламж, ус хангамжийн 432.9 км шугам сүлжээ, ариутгах татуургын 264.7 км шугам сүлжээ, дулаан хангамжийн 263.9 км шугам сүлжээ, 578 байршилд 460.2км2 авто зогсоол,19,383ш гэрэлтүүлэг, усан оргилуур 67ш, 425ш хөшөө дурсгал, 1,906,656м авто зам, зорчигч тээврийн төв 17ш, нисэх онгоцны буудал-15ш, 128 гүний худаг, 56 усан сан, 45 ус хангамжийн шахуурга станц, 22 цэвэрлэх байгууламж болон бусад 204,226ш барилга байгууламжийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн. “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн программ хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэлт хийх”, “Нийслэл, 21 аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн цахим системийг нэвтрүүлэх” арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, холбогдох дүрэм, журмын хүрээнд ажиллаж, тайланг хүлээн авч, Захиалагчийн техник хяналт хийсэн.

3.7.3.4.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

Биелэлт: Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээнд улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийг хамарсан мониторингийн сүлжээ бүхий “Газрын мониторингийн үндэсний цахим систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү цахим системд газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт буюу бэлчээрийн газрын 8,310 цэг, тариалангийн газрын 2,190 цэг, хадлангийн газрын 258, хот суурин газрын 1,556, ой, усан сангийн газрын 212, тусгай хэрэгцээний газрын 120 цэг болон тус тус нийт 12,646 цэгийн анхдагч мэдээллийг байгуулж мэдээллийн санг үүсгээд байна. Мөн 2020 онд Улсын хэмжээнд бэлчээр болон хот тосгон бусад суурин газрын мониторингийн 1,000 цэгийн ерөнхий мэдээлэл, ургамлын бичиглэл, мониторингийн цэгийн хянан баталгааны дүгнэлт зэрэг мэдээлэл бүхий хувийн хэрэг, хөрсний агрохими, хүнд металл, эрүүл ахуйн, дээжийн мэдээ, ургамлын бичиглэлийн ажлыг хийж нэгдсэн нэг мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна. /www.egaza.gov.mn/ Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг турших, хэрэглээнд нэвтрүүлэх 2021 онд ТЭЗҮ-ийг батлуулж, дараах шалгууруудыг тодорхойлон туршиж байна.

3.7.3.5.Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно.

Биелэлт: Газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулах ажлын газрын асуудал шийдэгдсэн. Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор “Газрын биржийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Дуудлага худалдааны үйл ажиллагаа бүрэн цахимжиж, 2022 оны байдлаар нийт 3786 газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг газрын биржийн mle.mn системээр зохион байгуулж, нийт 6458 иргэн, хуулийн этгээд оролцож, ойролцоогоор 26.5 тэрбум, 2023 оны эхний 3 сард нийт 600 газрын дуудлага худалдааг зохион байгуулахаар бүртгэгдсэн бөгөөд үүнээс 173 газрын дуудлага худалдаа зохион байгуулсан. Нийт зохион байгуулагдсан дуудлага худалдааны 166 нь цахим хэлбэрээр, 7 нь танхимаар зохион байгуулагдсан. Дуудлага худалдаанд нийт 439 иргэн, хуулийн этгээд оролцож, 55,494.0 сая төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлж, 441.5 га газрыг цахим дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн байна.

3.7.3.6. Геоорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлнэ.

Биелэлт: Геоорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар 2022.03.02-ны өдөр 2022/05 тоот дугаартай батлуулсан. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэж "Нэкс ЖИ Ай Эс" ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 2022/282 тоот дугаартай гэрээг байгуулан, техник, эдийн засгийн үндэслэлийн төслийг батлуулсан.

2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/129 дугаар тушаалаар "1:25000 масштабтай байр зүйн тоон зургийг нэгтгэх" ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, сонгон шалгаруулалтад Геосан ХХК шалгарч, 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 2023/164 дугаартай гэрээг байгуулан, эцсийн тайланг ГЗЗХ-2023/40 дугаартай дүгнэлтээр АМХ-т хүлээн авсан. Нэгтгэсэн 1:25000-ны масштабтай 7328 хуудас байр зүйн зургийг Геоорталд оруулах ажлыг Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс гүйцэтгэсэн байна.

3.7.3.7. Улсын хэмжээнд ашиглагдаж буй барилга, байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулна.

Биелэлт: Шадар сайдын 2021 оны 2 дугаар тушаалаар Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ыг шинэчлэн баталсан. 2021 онд орон сууцны 617, төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт олон нийтийн 163, нийт-780 барилгад буюу 42.5 хувьд нь хэмжилт, судалгаа хийж, дүгнэлт гаргаж, паспортжуулсан. 2022 онд Нийслэлийн 988 олон нийтийн барилга байгууламжийг паспортжуулахад 6.9 тэрбум төгрөг, аймаг орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн 2142 барилга байгууламжийг паспортжуулахад 14.9 тэрбум төгрөг тус тус шаардлагатай байгаа талаарх танилцуулгыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/378 дугаар захирамжийн хүрээнд он дамжин хэрэгжиж буй 73 барилгаас 50 барилгын дүгнэлтийг гаргасан. 2023 онд нийт 69 барилга байгууламжийг паспортжуулахаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

3.7.3.8. Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлын хийж дуусган, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

Биелэлт: Улсын хэмжээний бичил мужлалын зураглалыг 12 аймгийн төвд нийт 174 мянган га талбайд инженер-геологи, гидрогеологийн судалгаа болон 120 мянган га талбайд газар хөдлөлтийн судалгаа, зураглалыг хийж мэдээллийн санд оруулсан. Үлдсэн 9 аймгийн зураглал хийгдэж байна. Барилга, хот байгуулалтын яам нь Одон орон, геофизикийн хүрээлэнтэй 2018.08.21-ний өдөр 2018/175 дугаар гэрээг 1,901,485,148 төгрөгийн үнийн дүнтэйгээр байгуулж 9 аймгийн /Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл/ төвийн газар хөдлөлтийн бичил мужлалын болон инженер-геологийн

1:10,000 масштабтай зураг зохиох ажлыг гүйцэтгүүлж байна. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.5 дугаарт тусгагдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв” /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд “Өмнөговь, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал боловсруулах” зөвлөх үйлчилгээний 197 сая төгрөг тусгуулсан бөгөөд үүний дагуу Одон орон, геофизикийн хүрээлэнтэй нэмэлт гэрээг байгуулан ажиллаж санхүүжилтийг бүрэн олгосон. “Өмнөговь, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал боловсруулах” зөвлөх үйлчилгээний 197 сая төгрөгийн санхүүжилтийн дагуу Одон орон, геофизикийн хүрээлэнгээс тус 2 аймгийн тайланг 2023 онд багтаан тус яаманд ирүүлэхээр болсон бөгөөд хээрийн судалгаа бүрэн хийгдэж дууссан.

3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.

3.7.4.1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангана.

Биелэлт: ХАНСХЕТ-ийг боловсруулах 2018/199, 2020/249 дугаартай гэрээнүүдэд эхлэлийн, дундын, эцсийн нийт 7 тайлан ирүүлэхээр тусгаснаас эхлэлийн 2, дунд шатны 2, “Хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн дэд бүтэц”, “Аж үйлдвэр дэд бүтэц”, “Хүн амын нутагшилт, суурьшил” зэрэг 3 боть ХАНСХЕТ-ийн эцсийн тайланг боловсруулж дууссан. Засгийн газрын 2023 оны 295 дугаар тогтоолоор байгуулагдсан “Хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн Үндэсний хороо”-ны 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, үзэл баримтлалын төслийн саналын зөрүүтэй асуудлыг судалж танилцуулах, бүс, нутаг хот төлөвлөлт газар зохион байгуулалтын асуудлаар олон улсын байгууллага болон эрдэмтэн судлаачдын хийсэн судалгааг нэгтгэн танилцуулахыг үүрэг болгосны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын “Хот байгуулалт, зураг төслийн институт”-ийн хийж гүйцэтгэсэн “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн “Эцсийн тайлан-3”-ыг хүргүүлж, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүн амын нутагшилт, суурьшлын төлөвлөлтийг хамтатган Улсын Их Хурал болон Засгийн газраар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр 2023.10.23-ны өдрийн 1/3821 тоот албан бичгээр Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн.

3.7.4.2. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүсүүдийн хөгжлийн төслийг боловсруулна.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг харилцан уялдаатай боловсруулах чиглэл өгсөн.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд "Хүн амын нутагшилт, суурьшлын төсөл"-ийг нэгтгэн боловсруулахаар Эдийн засаг, хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 52 дугаар хамтарсан тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахдаа эдийн засгийн бүс нутгийн орон зайн хөгжлийн олон талт үзэл баримтлал, орон зайн тогтвортой хөгжлийн онол, газарзүйн болон эдийн засгийн орон зайд суурилсан холболтын

газарзүйн хандлага /connectography/ зэрэг арга зүйн шинжилгээнд тулгуурлан, шинжлэх ухааны түгээмэл хэрэглэгддэг индукц, дедукц, баримт бичгийн судалгаа, загварчлал хийсвэрлэлийн зэрэг аргуудыг мөн олон шинжүүрт шийдвэр гаргалтын матрицын аргыг ашиглан судалгаа хийсэн. ХАНСХЕТ-ийн үр дүнд орон нутгийн түвшний 108 хөгжлийн ирээдүйтэй сум суурин тодорхойлсон байсныг Эдийн засаг, хөгжлийн яам болон ХАНСХЕТ-ний төслийн багтай уулзалт хийж сум дундын түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн 69 төвийг тодорхойлсон. Төслийг боловсруулах хүрээнд танхим болон цахимаар 45 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

3.7.4.3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: 2021 оны улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр нийт 11 зорилт, 86 арга хэмжээ, 526 бүтээгдэхүүн байхаар төлөвлөж, уг төлөвлөгөөний хэрэгжилт 2020 оны байдлаар 58.3 хувьтай, 2022 оны улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр нийт 11 зорилт, 86 арга хэмжээ, 526 бүтээгдэхүүн төлөвлөж, хэрэгжилт 2021 оны байдлаар 46.5 хувьтай гарсан ба хэрэгжилтийн тайланг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж 16, 24 дүгээр тэмдэглэл гарсан.

3.7.4.4. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулна.

Биелэлт: Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09-р сарын 29-ний өдрийн 95 дугаар тогтоолоор Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Булган аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын IX хуралдаанд хэлэлцүүлж, 2022 оны IX/18 дугаар тогтоолоор батлуулсан. Тус төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах ажлыг гүйцэтгэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 онд аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй нийцүүлэн хөдөө аж ахуйн 514 нэгж талбарын 496.2 га газрыг эзэмшүүлж, 59 арга хэмжээний 98,454.49 га газрыг хамгаалах, сайжруулах, ашиглуулах, нөхөн сэргээсэн. Хот тосгон бусад суурин газарт 3364 нэгж талбарын 4,245.17 га газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, өмчлүүлж, ашиглуулсан. Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон сумын 11 байршлын 14,282.37 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.

3.7.4.5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.

Биелэлт: Тайлант хугацаанд Хэнтий, Хөвсгөл, Ховд, Увс, Төв, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь, Орхон Завхан, Дундговь, Дорнод, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Булган, Баянхонгор, Баян-Өлгий, Архангай аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах, төсөв хөрөнгийг орон нутгийн сан бусад эх үүсвэрээр шийдвэрлэх зэрэг ажлууд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шат дараалалтай явагдаж байна.

3.7.4.6. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавина.

Биелэлт: Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн цахим

системийн хөгжүүлэлтийг хийж, мониторингийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгаа хийсэн. “Газрын мониторингийн сүлжээний тариалан, хот тосгон газрын мониторингийн 350 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх” АД/2023-06 дугаартай ажлын даалгаврыг батлуулсан. ТЭЗҮ 2022 онд батлагдсан. Газрын мониторингийн цахим системд дундын мэдээллийн сан бүхий нэмэлт хөгжүүлэлтийг хийж бусад газрын мониторинг хийдэг байгууллагуудаас өгөгдөл, мэдээллийг авч, Газрын мониторингийн үндэсний сүлжээний бэлчээрийн 50, тариалангийн 50, хот, тосгон, бусад суурины газрын 200, тусгай хэрэгцээний газрын 50 цэг буюу зайлшгүй судалгаа шинжилгээ хийх шаардлагатай нийт 350 мониторингийн цэгийн байршлыг тогтоож газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг зохион байгуулсан.

3.7.4.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн бодлого, зорилт болон холбогдох шийдвэрийн хүрээнд 2020-2023 он дамжин хэрэгжүүлэхээр “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/-т 65.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ батлагдсан. Уг төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 264 ТЭЗҮ, зураг төслийн ажлын жагсаалтыг Барилга, хот байгуулалтын сайдын холбогдох тушаалуудаар батлан мэргэжлийн түвшинд нэгдсэн бодлогоор ханган, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан бөгөөд үүнээс 240 зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажил бүрэн дууссан, 80 хувиас дээш гүйцэтгэлтэй 14.4-80 хувийн гүйцэтгэлтэй 10 ажил тус тус байна. Дуусаагүй үлдэгдэлтэй 24 ажлыг Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 456 дугаар тогтоолын дагуу тус яамны барьцаа дансанд төвлөрүүлэн 2024 онд шилжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлээд байна. Нийт ажлын гүйцэтгэл 97.4 хувьтай хэрэгжиж байна.

3.7.5. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.

3.7.5.1. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

Биелэлт: Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын техник туслалцааны хүрээнд боловсруулж буй “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө” төслийн хүрээнд Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн судалгааг хийж, Орхоны хөндийд “Шинэ Хархорум хот байгуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын холбогдох байнгын хорооны хуралдаан, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж улмаар УИХ-ын 2023.01.19-ний өдрийн 07 дугаар тогтоол гарсан. “Үндэсний хорооны бүрэлдэхүүн батлах тухай” болон ““Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай” ЗГ-ын тогтоолын төслүүдийг боловсруулж “Үндэсний хорооны бүрэлдэхүүн батлах тухай” ЗГ-ын 2023.02.01-ний өдрийн 38 дугаар тогтоол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай” ЗГ-ын 2023.02.01-ний өдрийн 40 дугаар тогтоол тус тус гарсан.

3.7.6. Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.

3.7.6.1."Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын систем, хагас нэвтрэх сувагт төлөвлөх, шинээр барьж байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: УИХ-ын 2020 оны 55-р тогтоолоор "Шинэ Зуунмод" болон "Майдар" хотуудыг байгуулахдаа Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө холбогдох баримт бичигтэй уялдуулан үе шаттайгаар шийдвэрлэхийг даалгасан. УИХ-ын 2022 оны 10-р тогтоол, Засгийн газрын 2022 оны 143-р тогтоол "Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай", 2022 оны 98-р тогтоолыг "Төрийн захиргааны зарим байгууллагыг Хөшгийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний тухай" тогтоолуудыг тус тус батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд "Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ болон инженерийн шугам сүлжээний 6 төрлийн ажлын зураг төслийг 2,173.3 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж, 100 хувийн гүйцэтгэлтэй байна. "Хөшгийн хөндийн шинэ суурьшлын бүс"-ийн инженерийн дэд бүтцийн эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын явц:

1. Ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/-ний гүйцэтгэгч "Эс Энд Эй Трейд" ХХК 2023.08.30-ны өдрийн байдлаар шугам хоолойн татан авч, 10,800 м хоолойг бүрэн угсраад байна. угсралтын явц 52 хувийн гүйцэтгэлтэй байна.
2. Цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч "Билгүүн Од констракшн" ХХК 2023.08.10-ны өдрийн байдлаар 52 хувьд хүрч, утас таталтын ажил үргэлжилж байна.
3. Инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламж /4/-ийн гүйцэтгэгчээр "Хангилцаг" ХХК, "Эм Даблю Ти" ХХК-ийн түншлэл 2023.08.21-ний өдрийн байдлаар 35 ш хавтан үйлдвэрлэсэн бөгөөд, ажлын явц 25% байна.
4. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд Эрчим хүчний сайдын төсвийн багцад батлагдсан эхний ээлжийн ус, дулаан, цахилгаан хангамж, мэдээлэл холбооны болон инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн байгууламжийн ажлын үргэлжлэл 138.3 тэрбум төгрөгийн өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний ажлыг ЭХЯ хариуцан хэрэгжүүлж, ус хангамж, мэдээлэл холбоо болон үерийн байгууламжийн ажлын тендерийг зохион байгуулан 2023 оны 5 дугаар сарын 20-ны байдлаар 3 ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, 22.0 тэрбумын гэрээ байгуулж барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

3.7.7. "Шинэ Зуунмод", "Майдар" шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ.

3.7.7.1."Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох судалгаа хийж, шийдвэрлүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор Шинэ Зуунмод хотын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталсан. Ерөнхий төлөвлөгөөний хүрээнд "Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажил, "Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө", "Тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"-ний ажлын явц 90 хувь, "Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явц 90 хувьтай байна.

"Майдар" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэхэд шаардлагатай 8,767.9 тэрбум төгрөгийн

санхүүжилтийн эх үүсвэрийг УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан. “Майдар хот төсөл” хэрэгжүүлэх газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Инженер геодези” ХХК шалгарч, 2020/69 тоот гэрээ байгуулан ажиллаж байна.

Төв аймгийн Хөшгийн хөндий дэх бүтээн байгуулалтын ажлын хүрээнд салбар хоорондын ажлын уялдааг хангах, бүтээн байгуулалтад шаардлагатай их хэмжээний хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, менежментээр хангах, төслийн хэрэгжилтийн явцад хяналт, мониторинг хийх зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг цаг хугацаанд нь шийдвэрлүүлж ажиллах Төв аймгийн Хөшгийн хөндий дэх бүтээн байгуулалтын асуудлыг хариуцсан захиргаа байгуулах тухай асуудлыг Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэв.

3.7.7.2. "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: БХБЯ-аас "Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04-р сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор "Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө " батлагдсан бөгөөд төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлууд үе шаттайгаар хийгдэж байна.

3.7.7.3. "Майдар" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Майдар хот” төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах ажилд Барилга, хот байгуулалтын яам, усны эх үүсвэрийн судалгааны ажилд Байгаль орчин, аялал жуулчлалын яам захиалагчийн хяналт тавин ажиллаж, Майдар эко” хотыг байгуулах шийдвэрийг Улсын Их Хурлын 2020 оны 55 дугаар тогтоолоор гаргасан.

БНСУ-ын Эксим банкны техник туслалцааны хөрөнгөөр хэрэгжсэн урьдчилсан техник, эдийн засгийн судалгааг батлуулах явцад Монгол, Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 40.0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Майдар хотын ус хангамж” төслийн БНСУ-ын Эксим банк хүлээн авч, зээлийн төслийг бэлтгэх 719,400 воны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулахаар Эксим банк БНСУ-ын “CHEIL engineering consortium” консорциумыг сонгон шалгаруулсан.

3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.

3.7.8.1. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК болон “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж, төрийн өмч давамгайлсан (66 хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” ХХК байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 13 дугаар тэмдэглэл гаргасан.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний

бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлд ипотекийн хөтөлбөрийг 2023 оны эхний хагаст багтаан Засгийн газарт шилжүүлэхээр тусгасны хүрээнд “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийг “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” болгон зохион байгуулж, “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг Засгийн газрыг төлөөлж тус байгууллагад шилжүүлэхээр Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар 15-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 51 дүгээр Захирамж гарсан.

Тус ажлын хэсгийн хурлыг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Сангийн яам, 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Барилга, хот байгуулалтын яам, 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Монголын ипотекийн корпорац ОССК дээр тус тус зохион байгуулж, ипотекийн зээлийн хөтөлбөрийг шилжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, холбогдох журам, гэрээний төслийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран эцэслэн боловсруулж, танилцуулсан.

3.7.9.Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.

3.7.9.1.Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд тус төслийн хүрээнд байгуулагдсан гэрээ хэлэлцээрийн дагуу Ерөнхий гүйцэтгэгч БНХАУ-ын “Хоёр дахь Металлурги групп корпорац” ХХК-тай 2020 оны 12 дугаар сарын 11-нд гэрээ байгуулсан, Монгол улсын Засгийн газрын 2023.01.11-ны өдрийн 19 дүгээр тогтоолын дагуу БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төсөл дээр ажиллах 310 мэргэжилтэн, ажиллах хүчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, ГИХГ-аас оршин суух зөвшөөрлийг хагас жилийн байдлаар нийт 199 гадаад ажилтан байснаас өнөөдрийн 100 ажиллах хүч ажиллаж байна. Барилгын ажлын хүрээнд барилга угсралт 8 блок байрны 21 давхар 100% цутгалт авсан. Нийт төслийн хэрэгжилт 60 хувьтай байна. Гүйцэтгэлийн ажил “2023 оны график төлөвлөгөө”-ны дагуу хийгдсэн.

3.7.9.2."Солонго 1", "Солонго 2" төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжих "Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл"-ийн тендер зарлаж, Барилга, хот байгуулалтын Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 3/38, 3/39 дугаар бичгээр гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийн гүйцэтгэгчид хүргүүлж, гэрээг 2023 оны 08 дугаар сарын 28-ний өдөр байгуулаад байна. Гэрээний дагуу барилгын ажлыг эхлүүлэхэд төсөл хэрэгжих газрыг салгаж бүртгэн гэрчилгээжүүлэх шаардлагатай болсны дагуу 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 0000222145, 0000222146 дугаар гэрчилгээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар гаргуулсан. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-ын 3 дахь хэсгийг үндэслэн тус төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг Нийслэлийн Байгаль орчны газраар хийлгэж, 2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 03/57 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу урьдчилгаа төлбөрийн баталгааны 30 хувийн төлбөрийн санхүүжилт эрх нээлгэх тухай Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 3/3683, 3/3684 дугаар албан бичиг болон санхүүжилтийн эрх

нээлгэж, хянан шийдвэрлүүлэх тухай 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 3/4001 албан бичгийг тус тус Сангийн яаманд хүргүүлж, санхүүжилт олгогдсон. Мөн 2024 оны санхүүжилтийн төлөвлөгөөг боловсруулж, төсвийн мөнгөн урсгалд тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн.

Мөн төслийн чадавх бэхжүүлэх 2 дугаар үе шатны сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 12-21-ний өдрийн хооронд БНСУ-д зохион байгуулж, 13 албан хаагчийг хамруулсан. БНСУ-ын барилга, орон сууцны бодлого, талаар сурсан туршлага мэдлэгээ 2023 оны яамны удирдлагуудад танилцуулсан. 2024 оны Улсын төсвийн төсөлд санал хүргүүлж, Сангийн яамны багцад төслийн барилга угсралтын ажилд 126.8 тэрбум төгрөг, төслийн зөвлөх үйлчилгээнд 2.5 тэрбум төгрөгийг тусгууллаа.

3.7.9.3."Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Төслийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагч, зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын сонгон шалгаруулалтыг БНСУ-ын Экспорт-Импортын банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулж, 2021 оны 09 дүгээр сард "АУМ ба Лий" консорциумтай гэрээ байгуулагдсан. "Баянголын ам түрээсийн орон сууцны хороолол барих төсөл"-ийн Төслийн удирдах хороо Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны А/320 тоот захирамжаар байгуулагдсан.

Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулах тендерийг 2023 оны 06 сарын 21-нд зарлаж, үнэлгээний тайланг баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас БНСУ-ын Эксим банк руу хүргүүлсэн. 2023 оны 11 сарын 29-ны өдөр ЭКСИМ банкнаас үнэлгээний тайлан дээр тодруулга ирүүлэхийг хүссэн албан бичгийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, Үнэлгээний хорооны даргад тоот албан бичгээр 2023 оны 12 сарын 4-нд илгээсэн.

3.7.9.4.Орлогод нийцсэн 10,000 орон сууцны эко хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Төсөл нь 1-р үе шатны хүрээнд Баянхошуу болон Шархад дэд төвүүдэд нийт 750 айлын ногоон орон сууц бүхий эко хорооллуудын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг гүйцэтгэж байна.

- Баянхошуу дэд төвийн эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажлын явц тайлант хугацаанд 45 хувийн хэрэгжилттэй байна.
- Шархад дэд төвийн эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажлын явц тайлант хугацаанд 30 хувийн хэрэгжилттэй байна.
- Баянхошуу дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг явц 40 хувийн хэрэгжилттэй байна.
- Баянхошуу дэд төвийн Б-13-1 талбарт төлөвлөсөн 150 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажлын инженерийн нарийвчилсан зураг төслийн явц 90 хувь, тус талбарын гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг 50 хувь, туслах болон хороолол доторх зам болон гадна тохижилтын ажил 60 хувь, Б-13-2 талбарт төлөвлөсөн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажлын инженерийн нарийвчилсан зураг төслийн явц 90 хувь, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг 70 хувь, туслах болон хороолол доторх зам болон гадна тохижилтын ажлын зураг төсөл 60 хувийн хэрэгжилттэй байна.

3.7.9.5.Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар СХД-ийн 6 дугаар хороонд 712 айлын орон сууц барих төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг “Эм Эй Ди Урбан” ХХК-аар гүйцэтгүүлж, 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Төслийн хөрөнгө оруулалтыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг НИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Төслийн барилга угсралтын зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд төслийн барилга угсралтын архитектурын ажлын даалгавар, хуучин техникийн нөхцөлүүд болон бусад холбогдох бичиг баримт Зөвлөх үйлчилгээний компанид хүргүүлсэн бөгөөд одоогоор нэмэлт мэдээлэл цуглуулах, зарим бичиг баримт шинэчлэх талаар ажиллаж байна.

3.7.9.6. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хооронд 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан хэлэлцээрийн хөрөнгөөр “Улаанбаатар хотын гэр хорооллын инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийг сайжруулах” төслийн хүрээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд нийт 31 байршил 88 хэсэгчилсэн талбайд төсөл хэрэгжүүлэхээс 2023 оны жилийн эцсийн байдлаар төсөл хэрэгжүүлж буй 20 байршил 58 хэсэгчилсэн талбайд 45 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байна.

2023 онд 4,438 айлын орон сууц ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажилласан. Үүнээс тайлант хугацаанд Моннис Урбан девелопмент ХХК 1 блок 169 айлын орон сууц, Цагаан хуаран консалтинг ХХК 1 блок 152 айлын орон сууц, Зургаан талт ХХК 2 блок 360 айлын орон сууц, 240 хүүхдийн цэцэрлэг, Батхэрэйд ХХК 3 блок 320 айлын орон сууц, Пример инвестмент групп ХХК 1 блок 96 айлын орон сууц, И ПИ СИ ЭМ Монголиа ХХК 1 блок 45 айлын орон сууц, Баганат өргөө ХХК 1 блок 105 айлын орон сууц, Магма од ХХК 1 блок 66 айлын орон сууц, нийт 11 блок 1,313 айл, 240 хүүхдийн цэцэрлэг ашиглалтад орсон. 2023 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 167 блок орон сууцны барилга ашиглалтад оруулсан ба 17,984 өрх орон сууцны инженерийн шугам сүлжээнд холбогдсон.

3.7.9.7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30,000 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хооронд 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан хэлэлцээрийн хөрөнгөөр “Улаанбаатар хотын гэр хорооллын инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийг сайжруулах” төслийн хүрээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд нийт 31 байршил 88 хэсэгчилсэн талбайд төсөл хэрэгжүүлэхээс 2023 оны жилийн эцсийн байдлаар төсөл хэрэгжүүлж буй 20 байршил 58 хэсэгчилсэн талбайд 45 төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байна.

2023 онд 4438 айлын орон сууц ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажилласан. Үүнээс тайлант хугацаанд Моннис Урбан девелопмент ХХК 1 блок 169 айлын орон сууц, Цагаан хуаран консалтинг ХХК 1 блок 152 айлын орон сууц, Зургаан талт ХХК 2 блок 360 айлын орон сууц, 240 хүүхдийн цэцэрлэг, Батхэрэйд ХХК 3 блок 320 айлын орон сууц, Пример инвестмент групп ХХК 1 блок 96 айлын орон сууц, И ПИ СИ ЭМ Монголиа ХХК 1 блок 45 айлын орон сууц, Баганат өргөө ХХК 1 блок 105 айлын орон сууц, Магма од ХХК 1 блок 66 айлын орон сууц, нийт 11 блок 1,313 айл, 240 хүүхдийн цэцэрлэг ашиглалтад орсон.

2023 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 167 блок орон сууцны барилга ашиглалтад оруулсан ба 17,984 өрх орон сууцны инженерийн шугам сүлжээнд холбогдсон.

3.7.9.8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.

Биелэлт: Архангай орон сууцны корпорац нь Булганхангай хорооллын 1-р ээлжийн төлөвлөлтөд тусгагдсан 120 айлын орон сууцны газрыг Төрийн орон сууцны корпорацаас орон нутгийн өмчид шилжүүлэн авч 81 айлын 2 блок 10 давхар орон сууцны барилгын зураг төслийг боловсруулж гүйцэтгэгчийг шалгаруулах төсөл сонгон шалгаруулалт явуулж байна.

Баян-Өлгий нийтийн орон сууцны зориулалтаар төлөвлөгдсөн 15 га газарт баригдах 900 айлын орон сууцны хорооллын иж бүрэн зураг төсөл хийгдэж, магадлалаар орж батлагдан, орон сууц барих, төсөл хэрэгжүүлэх, зорилтот бүлгийн иргэдийг хамруулах нөхцөл бүрдэх боломжтой юм.

Баянхонгор 1124 айлын 27 нийтийн орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлж 288 айлын 8 орон сууцны барилгыг байнгын ашиглалтад хүлээн авсан. Булган аймгийн төвд 2021-2022 онд 2 байршилд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хуучин барилгыг засварлан 12 айлын, шинээр 10 айлын түрээсийн орон сууцыг ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байна.

Говь-Алтай Есөнбулаг сум Баянхайрхан багт 2788 айлын орон сууцны “Солонго хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны барилга барих газрыг “Алтай орон сууцны корпорац” ААТҮГ-ын өмчлөлд шилжүүлж, орон сууц барих иргэдэд газрыг үнэ төлбөргүй олгож, инженерийн шугам сүлжээг орон нутгийн төсвийн санхүүжилтээр шийдвэрлэж байна. Говьсүмбэр 2021 онд 315 болон 40 айлын орон сууц барих төсөлд сонгон шалгаруулалт зарлан гэрээ байгуулж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 40 айлын орон сууцны барилга 80 хувьтай, 315 айлын орон сууцны барилга 25 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн түрээсээр ашиглуулж байгаа 22 орон сууц байгаа бөгөөд нийт 178 айл түрээсийн орон сууцанд амьдарч, 2020-2023 онд орон нутгийн төсөвт 40.2 сая төгрөг хуримтлагдсан байна. 2020-2023 онуудад 14 байршилд 1247 айлын орон баригдаж ашиглалтад орж, 2023 оны байдлаар хүн амын 56.6% нь орон сууцанд амьдарч байна.

Дорноговь аймаг "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн 1 дүгээр ээлжид 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос хөгжлийн бэрхшээлтэй иргэн 7, ахмад настан 11, өрх толгойлсон эх, эцэг 2, олон хүүхэдтэй гэр бүл 6, залуу гэр бүл 10, эмч, сувилагч, асрагч 14, сургуулийн багш 16, цэцэрлэгийн багш 15, малчин 17 байна. Үүнээс 45 төрийн албан хаагч түрээсийн орон сууцанд хамрагдаж, аятай тухтай ажиллаж, амьдрах боломжтой болсон.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар багт шинээр төлөвлөж байгаа 1800 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээг улсын төсвийн 5.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр ашиглалтад оруулсан ба 2021-2022 онд 1800 айлын орон сууцны хорооллын дотор цахилгаан, дулаан хангамжийн зураг төсөв боловсруулах ажлыг “Гидродизайн инновац” ХХК, хорооллын цэвэр, бохир ус, мэдээлэл холбоо, үерийн ус зайлуулах шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажлыг “Их мянган инженерчлэл” ХХК тус тус гэрээ байгуулан ажиллаж, хүлээлгэн өгсөн.

Дундговь аймгийн хэмжээнд Сайнцагаан сумын 7 дугаар багт байршилтай “Түмний хороолол болон Хаус хороолол”-ын гадна 1.8 км ариутгах татуургын шугамын угсралтын ажлыг “Ашид бьюдинг” ХХК гүйцэтгэж, 2023 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. Мөн 9 дүгээр багт хувийн хөрөнгө оруулалтаар 6 айлын инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон түрээсийн байр баригдсан. Мөн Дэлгэрцогт сумын төрийн албан хаагчдын орон сууцны их засварын ажлыг “Турнинг” ХХК-тай 236.8 сая, Дэлгэрхангай сумын төрийн албан

хаагчдын орон сууцны барилгын гадна, дотор халаалтын засварын ажлын “Толгод” ХХК-тай 83.4 сая төгрөгийн гэрээ байгуулан тус ажлуудыг хүлээн авч нийт дээрх сумдад 32 өрх түрээсийн орон сууцаар хангагдлаа.

Завхан аймгийн Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 21-р зуун жишиг орон сууцны хороололд түрээсийн орон сууц барих газар болон, инженерийн шугам сүлжээний ажил бүрэн шийдэгдсэн. Бохир усны насос станцын барилгын гадна ЦДАШ, бохир усны даралттай шугам 800 м, бохир усны өөрийн урсгалтай 250 м шугам зураг төслийн дагуу хийгдэж технологийн зогсолт хийсэн.

Орхон аймаг иргэдэд түрээслүүлэх түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын захиалгаар Хөгжлийн банкны 18.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын Цагаанчулуут багийн нутагт баригдсан 315 айлын орон сууцны байрыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 106 дугаар тогтоолын дагуу түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэдэд олгосон. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 23 иргэн орон сууцны байрны төлбөрийг бүрэн төлж өмчлөх эрхийн гэрчилгээ авсан байна.

Өвөрхангай 2021-2023 оны байдлаар нийт 634 айлын 29 орон сууц ашиглалтад орж улсын комисс хүлээж авч 2100 орчим иргэд чанар, стандартын шаардлага хангасан орон сууцтай болоод байна.

Өмнөговь “Шинэ мянган айл” орон сууцны хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Овоо суманд 14 айл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 415 айл, хувийн хэвшлийн түншлэлээр шинээр 492 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, төвлөрсөн шугамд холбогдсон амины орон сууцыг 386 айлаар нэмэгдүүлсэн байна. 2020-2023 онд төмөр замын төслүүд болон хувийн хөрөнгө оруулалтаар 1278 айлын орон сууц баригдаж ашиглалтад орсноор нийт 2122 орон сууцаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, 29.4 хувь буюу 5992 орон сууц болж нэмэгдсэн.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 3-р багын нутаг дэвсгэрт баригдаж буй “Шинэ тэмүүлэл” түрээсийн орон сууцны хотхон зураг төсөл бэлэн болж барилга угсралт ажил эхэлсэн, 2024 оны 1 дүгээр улиралд ашиглалтад орохоор ажлын график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажил гүйцэтгэгдэж байна.

Сэлэнгэ аймагт улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн дэд бүтцийн ажил хийгдсэн, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой газруудыг “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын мэдэлд шилжүүлж, уг газарт 95 айлын 2 блок орон сууцны барилга барихаар төлөвлөн ТЭЗҮ боловсруулсан. Сүхбаатар сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт төрийн албан хаагчдад зориулсан “Очир шагай” ХХК 50 айлын орон сууц, “Шинэ бадрах констракшн хөгжил” ХХК-ийн 2 блок 12 давхар 126 айлын орон сууц, 600 айлын “Сэлэнгэ мөрөн” хотхон, “Арвин алтан бумба” ХХК-ийн 2 блок 9 давхар 80 айлын орон сууц, 2.1 га газарт орчин үеийн орон сууцны хотхоныг “Арвин Алтан бумба” ХХК барихаар барилгын төслийн хэрэгжүүлж, дэд бүтэц, барилга байгууламжийг байгуулахад шаардлагатай техникийн нөхцөлийг гаргуулж, барилгыг ажлыг эхлүүлсэн бөгөөд орон сууцны хороолол барих ажлын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттайгаар хэрэгжүүлэн ажилласан.

Төв аймагт 36 түрээсийн орон сууцны сан бүрдсэн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 42 айлын орон сууц барихаар 2022 онд 800.0, 2023 онд 800.0 сая төгрөг төлөвлөн гүйцэтгэгчээр Төв цогт өлзийт ХХК шалгаран барилга угсралтын ажил 90 хувьтай комисс ажиллах бэлтгэл хангаж байна.

Увс аймагт 2014-2015 онд Төрийн Орон Сууцны Корпорацын хөрөнгө оруулалтаар 135 айлын орон сууц баригдаж иргэдэд түрээслэх, түрээслүүлэн өмчлөх хэлбэрээр ашиглагдаж байна.

Ховд аймгийн хэмжээнд Төрийн орон сууцны корпорацын 120 айлын орон сууцнаас түрээсээр авсан иргэдийн 60 хувь нь төлөлтөө хийж хувийн өмчийн хэлбэрт шилжүүлээд

байна. Аймгийн хэмжээнд 2023 оны 10 дугаар сарын байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 155 айлын 7 орон сууцны барилга нэмж ашиглалтад орсон бөгөөд өссөн дүнгээр нийт 4008 айлын орон сууц байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт “Зүүн Мөрөн хороолол”-д 1041 айлын орон сууцны барилга байгууламжийг барих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гадна инженерийн шугам сүлжээний ажлыг шат дараатайгаар гүйцэтгэж байна. Үүний хүрээнд цэвэр усны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил хийгдэж ашиглалтад орсон байна.

Хэнтий аймаг Шинэ Өндөрхаан хороололд 2 блок 60 айлын, 4 дүгээр багт 1 блок 30 айлын, нийт 3 блок 90 айлын түрээсийн орон сууц барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Барилгын ажлыг эхлүүлэхээр ТОСК-той хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууцны барилгыг барьж ашиглалтад оруулах сонгон шалгаруулалтыг ТОСК-оос нээлттэй зарласан. ТОСК-оос БХБЯ-тай хамтран 60 айлын орон сууцны барилга барих бэлтгэл ажлын хүрээнд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах ажил хийгдэж байна.

3.7.9.9. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны төслийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.

Биелэлт: “Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 68 дугаар тогтоолоор Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануур, Багахангайд анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх хүрээнд Орхон /22.7%/, Дархан-Уул /13.7%/, Дорнод /9.9%/ аймгуудад олгогдоод байна. Нийт зээлд хамрагдсан 787 зээлдэгчийн 760 нь тухайн орон нутагтаа амьдардаг иргэд хамрагдсан бол 27 зээлдэгч Улаанбаатар хотоос орон нутагт шилжин зээлд хамрагдсан байна.

Дээрх бодлогын хүрээнд хөдөө, орон нутагт 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 10,364 айлын орон сууцны барилгын төсөл эхэлж, барилга барих зөвшөөрлөө аваад байна. Энэ нь 2022 оны хөдөө, орон нутагт ашиглалтад орсон 3585 айлын орон сууцны тооноос 2.9 дахин их үзүүлэлт юм. Жишээлбэл Баянхонгор аймагт 143, Дархан-Уул аймагт 108, Төв аймагт 90, Хөвсгөл аймагт 84, Орхон аймагт 78, Дорнод аймагт 72, Өмнөговь аймагт 68, Дорноговь аймагт 65, Баян-Өлгий аймагт 57 айлын орон сууцны томоохон төслүүд хэрэгжиж тус тус ашиглалтад ороод байна.

3.7.10. Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулна.

Биелэлт: “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд Тус үйл ажиллагааны хүрээнд 2021 онд 13,292 иргэн, 2022 онд 7,847 иргэн, 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 8,092 иргэн, нийт 29,231 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд нэмж хамруулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хоёрдугаар хавсралтаар баталсан ипотекийн зээлд хамрагдсан 6,476 иргэдийн суурь тоог, 28,804 иргэнээр нэмэгдүүлж 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 35,707 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.

3.7.11. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.

3.7.11.3. Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.

Биелэлт: Аймгийн төвийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох зураг төслийн ажлыг 8 аймгийн төвийн 8 сум, 2 аймгийн 2 суманд хийж гүйцэтгэсэн. Хот, суурины ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, шинээр барих, ухаалаг ус түгээх байр барих ажлын үе шаттайгаар хэрэгжүүлж дараах 4 багц ажлуудыг хийж байна. АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламжаар УБ хотын гэр хорооллын шугамд холбогдсон 180 орчим ус түгээх байрыг автоматжуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулах ажил эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан хоёр дахь Компакт гэрээний дагуу Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд Улаанбаатар хотын 7 дүүргийн гэр хорооллын нийт 172 ус түгээх байрыг автоматжуулах төслийг хэрэгжүүлж байна.

3.7.11.4. "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, цэвэр ус дамжуулах шугам, дагалдах тоног төхөөрөмж, ус цэвэршүүлэх станцыг барьж ашиглалтад оруулна.

Биелэлт: БНАУ-ын "Ти Ар Эм" ХХК болон "Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" мэргэжлийн төрийн бус байгууллага хамтран инженер, техникийн ажилтнуудад зориулсан ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг 2021.09.27-ноос 2021.12.05-ыг хүртэлх хугацаанд онолын болон дадлагын гэсэн 4 үе шаттайгаар зохион байгуулсан. Төслийн БУА-ыг 2021.11.30-нд багтаан дуусгах 2021/101 тоот нэмэлт гэрээг 2021.04.15-нд байгуулсан. Техникийн комисс 2021.10.05-нд, улсын комисс 2021.11.24-нд ажиллаж, 2021/01-06 дугаар комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Техникийн комисс 2021.10.05-нд, улсын комисс 2021.11.24-нд ажиллаж, 2021/01-06 дугаар комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан.

3.7.11.5. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. /58.5 сая ам.доллар/

Биелэлт: АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Дархан, Дорноговь, Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлууд 60-85%-ийн хэрэгжилттэй үргэлжлэн хэрэгжиж байна. Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудад хэрэгжсэн 10 цэвэрлэх байгууламжууд 100% ашиглалтад орсон. Дархан-Уул аймгийн Дархан сумын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 98 хувийн гүйцэтгэлтэй, техникийн комисс болон улсын комисс ажилласан.

3.7.11.6. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)-ын Засгийн газар хооронд 2017.05.09-нд байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн

хүрээнд Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл хэрэгжиж байна. 2021 онд Баян-Өлгий, Увс, Завхан, Дорнод, Говьсүмбэр, 2022 онд нэр бүхий 8 аймгийн цэвэрлэх байгууламжийг барих ажлын хүрээнд 7 аймгийн зураг төслийн ажил эхэлсэн, нэг аймгийн зураг төслийн ажлын даалгавар бэлэн болсон. 5 аймгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч шалгаран, барилга угсралтын ажлуудыг эхлүүлээд байна. Төслийн нийт гүйцэтгэл 90%-тай хийгдсэн. 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт Говьсүмбэр, Баян-Өлгий, Увс, Завхан, Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийг барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Улсын төсвийн 2024 оны санхүүжилтээр Говь-Алтай аймгийн төв, Сэлэнгэ аймгийн Баянгол суманд цэвэрлэх байгууламж барих, Ховд, Баянхонгор аймгийн төв, Дархан-Уул аймгийн Шарын гол суманд шинээр цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн.

3.7.11.7. Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Дархан арьс ширний цогцолборын цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах ажлын хүрээнд Италийн талтай хамтран цэвэрлэх байгууламжийн ерөнхий схемийг боловсруулан, шаардагдах тоног төхөөрөмжүүдийн тооцоо судалгааг гарган, ТЭЗҮ-д тусгасан. ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу "Цэвэрлэх байгууламжийн барилгын зураг төсөв боловсруулах" зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Чанарын түншлэл" ХХК шалгаран, 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн ДАШЦББТӨ ХХК/202206019 дугаартай гэрээг Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-тай байгуулан ажлыг эхлүүлсэн. Цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд усан сангийн барилгын бүтэц, барилгын архитектурын ажлын зураг хийгдэж дууссан бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын гэрээг дүгнэх ажлын хэсэг байгуулагдан эхлэлтийн тайланг 2023.04.26-ны өдөр хүлээн авсан. Гэрээг дүгнэсэнтэй холбогдуулан талууд харилцан тохиролцон зураг төсөл боловсруулах ажлын гэрээг 2023.07.10-ны өдөр хүртэл сунгасан. "Чанарын түншлэл" ХХК нь цэвэрлэх байгууламжийн загвар зураг төслийг 2023.06.24-ний өдөр баталгаажуулсан. Одоогоор санхүүжилтээс шалтгаалан ажлыг зогсоосон байна.

3.7.11.8. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.

Биелэлт: Налайхын "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн дэд станцын бүтээн байгуулалтын ажлыг "Виллвэст" ХХК гүйцэтгэж, тус паркийн өргөтгөл 130 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай санхүүжилтийг БХБЯ-аас шийдвэрлэж, ажлыг "Өрх" ХХК гүйцэтгэж, мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан.

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажил дууссан. Дэд станцын угсралтын ажил 95 хувьтай хэрэгжсэн. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын хүрээнд 110 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ-ын 128 ш бетон суурь хийх ажил бүрэн дууссан.

110/35/10 кВ-ын "Налайх", 110/10 кВ-ын "Налайх парк" дэд станцуудын өргөтгөл, 10 кВ-ын 4 ш хуваарилах байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажил хийгдэж байна. 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр "Таван толгой түлш" ХХК зүүн бүсийн үйлдвэрийн усан хангамж шийдвэрлэх ажлын хүрээнд хийсэн паркийн усан хангамжаас татсан 9.6 км шугам хоолойн угсралтын ажлыг улсын комисст хүлээлгэн өгөв.

3.7.12.Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.7.12.1.Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын далан, сувгийн өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулна.

Биелэлт: Сонгинохайрхан дүүрэг 14,454 га, Баянгол дүүрэг 2,506 га (баруун бүс), Хан-Уул дүүрэг 9,150 га (урд бүс) нийт 26,110 га талбайд зураг төсөл боловсруулах ажлын Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Инженер геодези” ХХК шалгарч, Барилга, хот байгуулалтын яамтай гэрээ байгуулан Захиалагчийн хяналтыг Барилга, хот байгуулалтын яам гүйцэтгэсэн. Тус зураг төслийг Барилгын хөгжлийн төвийн магадлал экспертийн дүгнэлтээр баталгаажуулсан.

Батлагдсан өндөржилтийн нэгдсэн зураглалын төлөвлөгөөтэй уялдуулан 2023 онд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 26 байршлын инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээний зөвшилцсөн 11 км үерийн хамгаалалтын сувгийн мэдээлэл, 2022 онд батлагдсан 3.2 км инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн сан ebarilga системд оруулсан.

3.7.12.2.Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулан батлуулна.

Биелэлт: БХБЯ-аас улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгөөр инженерийн бэлтгэл арга хэмжээний бодлогын баримт буюу мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг “Престиж” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 6.1.7.-д улсын төсвийн 10,000.0 сая төгрөг тусгагдаж, Барилга, хот байгуулалтын сайд үндсэн хариуцагчаар төлөвлөгдсөн байна.

Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний эхний тайланг НХБХГ-ын Мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 10 дугаар хурлаар, дундын тайланг 2022 оны 19 дүгээр хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаалаар томилогдсон Улсын 4 эксперт хянаж магадлалын нэгдсэн дүгнэлт хийгдсэн. Барилгын хөгжлийн төвийн 2022 оны ЭЗ-0001/2022 тоот магадлалын дүгнэлтээр баталгаажсан.

2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хуралдсан БХБЯ-ны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг хэлэлцүүлсэн бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 65 дугаар тогтоолоор “Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө” батлагдсан.

3.7.12.3.Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт: НҮБ-ын ХАБИТАТ-аас 4.3 сая ам.долларын санхүүжилтээр “Улаанбаатар хотын гэр хорооллын үерийг даван туулах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, хөрсний усны түвшин өндөр, үерт өртөж болзошгүй Баянзүрх дүүргийн 9, Сонгинохайрхан дүүргийн 7, 24, 25, 40, 41, 42, Сүхбаатар дүүргийн 12, 13, 16-р хороодын нутаг дэвсгэрт хийгдэх үерийн далан сувгийн трассыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулж, 10 байршилд 10.5км урт үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг бүрэн дуусгаж

ашиглалтад хүлээлгэн өгсөн. УБ хотын хэмжээнд 53 байршилд 150 км үерийн усны далан сувагтай. Үүнээс 2021 онд 5.4 км үерийн усны далан суваг шинээр ашиглалтад орсон.

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хэрэгжүүлж буй Сэлбэ дэд төвийн 2.1 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлыг улсын комисс 2020 оны 09 дүгээр сард хүлээн авсан.

3.7.12.4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

Биелэлт: Хэнтий Хөвсгөл, Ховд, Увс, Төв, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, Завхан, Дундговь, Дорнод, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Архангай, Хэнтий, Баянхонгор, Булган аймгууд, нэр бүхий зарим сумдад үерийн хамгаалалтын байгууламжуудыг үе шаттайгаар хийж гүйцэтгэж байна.

3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.7.13.1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.

Биелэлт: Бэрэн групп ХХК-ийн 2004 оноос эхлэн Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төсөл нь "Бэрэн групп" ХХК нь "Бэрэн майнинг" ХК, "Ар ган" ХХК, "Хөх ган" ХК-д нийт 59.5 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр, "Бэрэн металл" ХХК-д 143.4 тэрбум төгрөгийг өөрийн болон банк, санхүүгийн байгууллагын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн домен зуухаар гангийн үйлдвэрийн гол түүхий эд болох ширэм үйлдвэрлэж байна. Эцсийн бүтээгдэхүүн буюу арматур үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг шийдвэрлэхэд тус яамнаас дэмжлэг үзүүлэн Хөгжлийн банктай хамтран ажиллаж байна.

Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Дэлхийн банк, Хөгжлийн банканд 2020-2021 онд удаа дараа хүргүүлж, тухайн хөрөнгийн зээлийн асуудал нь хувь компанийн чадамжтай холбоотойгоор шийдэгдэхгүй хүлээлтийн байдалтай байна. Бэрэн групп" ХХК, түүний хамаарал бүхий компаниудын тус банкнаас авсан зээл, өрийн асуудал хууль, хяналтын байгууллага дээр шалгагдаж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдэгдэх хүртэл төслийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байна.

3.7.13.2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.

Биелэлт: "Эрдэс плазм" ХХК-ийн Багахангай дүүрэгт байгуулах шилний үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Дэлхийн банк, Хөгжлийн банканд 2020-2022 онд удаа дараа хүргүүлж, тухайн хөрөнгийн зээлийн асуудал нь хувь компанийн чадамжтай холбоотойгоор шийдэгдэхгүй хүлээлтийн байдалтай байна. "Эрдэс плазм" ХХК нь үйлдвэрийн үндсэн түүхий эдийн судалгааг хийж гүйцэтгэн Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутагт байрлах Баян-Уул судлын цахиурын ордын нөөцийн шинэчилсэн тооцооны ажлын үр дүнгийн тайланг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн 2023.04.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

3.7.13.3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.

Биелэлт: Жилдээ 300 мянган тонн цемент үйлдвэрлэж баруун бүсийн аймгуудын цементийн хэрэглээг бүрэн хангах “Ховд эко цементийн үйлдвэр” 2022.10.28-ны өдөр бүрэн ашиглалтад орсноор жилд 300.000 тонн цемент үйлдвэрлэж, баруун 5 аймгийн цементийн хэрэгцээг хангах, барилга, орон сууц бүтээн байгуулалтын өртөг зардал бууруулах, 3000 хүний байнгын ажлын байр бий болгох, утааг бууруулж янданг цөөлөх, баруун бүс нутгийн хөгжлийн зүтгүүр болох нөхцөл бүрдсэн.

“Ховд эко цемент” үйлдвэр нь хуурай аргын үйлдвэр бөгөөд түүхий эдээ олборлох, бутлах, нунтаглах, хоорондын найрлагыг жигд болгоход ус хэрэглэхгүй, хамгийн сүүлийн үеийн шилдэг технологи бүхий байгаль, экологид ээлтэй үйлдвэр юм. Хоногт 1200-1300 тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай ба үйлдвэрлэсэн цементээ задгай, 50кг, 1тн гэсэн 3 хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэж байгаа бөгөөд аймгийн төв буюу Жаргалант суманд бөөний үнээр худалдан борлуулж байгаа болно. Үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд 2023 оны 05 дугаар сард ХХААХҮЯ-аас ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, Үйлдвэрийн барилга байгууламжийг 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр албан ёсоор ашиглалтад хүлээж авсан ба үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Одоогийн байдлаар зах зээлд нийт 110 мян.тн цементийг 1 тн тус бүрийг 380 мянган төгрөгөөр зах зээлд нийлүүлсэн байна. Нийт 380 ажилтантай ба үүний 90 хувь буюу 288 хүн нь аймаг орон нутгаас ажиллаж байна.

3.7.13.4.Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт УУХҮЯ: Эрх зүйн тусгайлсан хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн бусад холбогдох хуулиудтай зөрчил, давхардал, хийдэл байгаа эсэхийг тогтоож, тодруулах судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. Энэхүү судалгааны үр дүнд Түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой харилцааг зохицуулах тусгайлсан хууль шаардлагагүй гэж тогтоогдсон байна.

Хуулийн төслийг дахин боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2020 оны А/332 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоол гарсан.

3.7.14.Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд оруулна.

3.7.14.1.Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.

Биелэлт: Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Замын-Үүд” чөлөөт бүсийн хөгжлийн Мастер төлөвлөгөөнд тодотгол оруулах, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зураг төлийн ТГТ ХХК-аар гүйцэтгүүлсэн. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай" хэлэлцээрийг соёрхон батлагдсантай холбогдуулан хэлэлцээрт тусгагдсан хамтарсан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ерөнхий төлөвлөгөөг уялдуулах шаардлага

үүссэн тул ТГТ ХХК-ийн хийсэн төлөвлөлт нь дээрх шаардлагыг хангаагүй тул Засгийн газрын хуралдаанд оруулж батлагдаагүй.

Харин "Монгол, Хятадын Эрээн, Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгавар"-ыг боловсруулж батлуулав. Мөн "Монгол, Хятадын Эрээн, Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулна.

3.7.14.1. “Замын-Үүд” чөлөөт бүсийг нээж байнгын ажиллагаанд оруулна.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 223 дугаар “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд шилжүүлэх тухай” тогтоолоор байнгын ажиллагаанд оруулсан.

3.7.14.2. Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулна.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 01 сарын 10-ны А/10 тоот тушаалаар “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар БХБСайдын багцаас 214,9 сая төгрөг төсөвлөгдсөн. “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж БХБЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 сарын 27-ний өдрийн А/36 дугаар тушаалаар “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо БХБЯаман дээр байгуулагдсан. Уг үнэлгээний хороо зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулан зөвлөхөөр “Идеал групп” ХХК 2022.05.30-ний өдөр шалгарч 2022.06.07-ны өдрийн 2022/304 тоот гэрээ байгуулсан. 2023 оны 4-р сарын 14 нд Ажил гүйцэтгэж буй компанийн удирдлага болон архитекторууд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр “Алтанбулаг чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын явцын талаар дэлгэрэнгүй танилцууллага хийсэн. Мөн 2023 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Эдийн засгийн хөгжлийн яаман дээр төлөвлөлтийн ажлын явц танилцуулагдахаар товлогдсон ч хойшлогдсон. “Идеал групп” ХХК, “Некст степ инженеринг” ХХКомпаниудын гаргаж өгсөн зураг төслийн гүйцэтгэлийн ажлын графикаар 2023 оны 12-р сард боловсруулж дуусахаар байсан боловч 2024 ондоо 80 гаран %тай ажил үргэлжилж байна.

3.7.14.3. Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулна.

Биелэлт: “Инженер геодези” ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан 2022/238 дугаартай Цагааннуур чөлөөт бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах гэрээг байгуулсан. Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжил аргазүйн зөвлөгөөгөөр хангах, эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дугаар А/27 тушаалаар байгуулсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын дагуу хот төлөвлөлтийн суурь судалгаа, байр зүйн зураглал, инженер-геологийн судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг боловсруулж дууссан. Төлөвлөлтийн үндсэн шийдлийг боловсруулсан. Үндсэн шийдлийн дагуу инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлтүүд боловсруулагдсан. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар Бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг оруулж 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцэгдэн дэмжигдсэн. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд

магадлал хийгдэж байна. Үүний дараа Засгийн газрын хуралдаанд орж батлагдана. ""Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаалын хавсралтаар баталсан Цагааннуур чөлөөт бүсийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах 250.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах ажлын даалгавар №Ц/01-ийг батлагдаж Төрийн худалдан авах ажиллагааны газраас тендер сонгон шалгаруулалт зарлаж, 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр гүйцэтгэгчээр "Хайдродизайн прожект" ХХК шалгарсан. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Цагааннуур чөлөөт бүсийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр "Хайдродизайн прожект" ХХК-тай байгуулсан. Чөлөөт бүсийн талбай дээр техникийн судалгаа хийгдсэн. Урьдчилсан трассын схем, барилга, байгууламжийн байршлыг боловсруулж зөвшилцөх ажил хийгдсэн. Инженер геодезийн судалгаа хийж зураглал гүйцэтгэх ажил, Инженер геологийн хайгуулын судалгаа, дүгнэлт боловсруулах ажил хийгдсэн. "Хайдродизайн прожект" ХХК нь гэрээнд заасны дагуу 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 399 тоот албан бичгээр эхлэлийн тайлан, загвар зураг баталгаажсанаар буюу захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагын баталгаажуулсан баримтад үндэслэн, баталгаажсан ажлын гүйцэтгэл 30%-д төлөх дүн 30% буюу 72.0 сая төгрөгийн санхүүжилтийг компанид олгосон.

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1."Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

4.1.1.Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, "Нэг иргэн-нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.

4.1.1.1.Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлдэг төрийн үйлчилгээг технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системээр дамжуулан иргэд байгууллагуудад цахимаар хүргэнэ.

Биелэлт: Мэргэжлийн хяналтын байгууллага 2021 оноос үйл ажиллагаандаа "Дижитал шилжилт-Хэрэглэгчтэй хамтарсан хяналт" төслийг хэрэгжүүлж, www.igov.mn системээр 10 гаруй төрлийн 40 орчим төрийн үйлчилгээг хүргэдэг болсон. "Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоол гарсантай холбоотой уг арга хэмжээний биелэлтийг гаргах боломжгүй болсон.

4.1.1.2.Эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа тодорхой төрлийн хэргийн материалыг цахимжуулна.

Биелэлт: Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/178, А/298 дугаар тушаалаар прокурор, цагдаагийн байгууллагын хэмжээнд эрүүгийн болон зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны цахим мэдээллийг харилцан солилцох, цахим гарын үсгээр баталгаажсан албан бичгийг үйл ажиллагаандаа ашиглах ажлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой эрх зүйн баримт бичиг боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажилласан. ЦХХХЯ-тай нэмэлт гэрээ байгуулж,

төрийн үйлчилгээний нэгдсэн системд “lavlagaa.e-mongolia.mn” системийг шинээр нэвтрүүлж, цагдаагийн эрх бүхий алба хаагч иргэн, хуулийн этгээдтэй холбоотой 90 төрлийн лавлагаа, мэдээллийг авч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд ашиглах боломжтой болж, тус системд нэвтрэх эрхийг цагдаа, дотоодын цэргийн 65 нэгжийн мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн нарт олгож, мөрдөгчийн тогтоолыг үндэслэн бүртгэл хөтөлж, лавлагааг гарган өгч байна. Мөн албан бичиг солилцооны дундын “docx.gov.mn” системд цагдаагийн “earchive.police.gov” программ хангамжийг холбосноор прокурорын байгууллагатай цахимаар албан бичиг солилцох боломжийг бүрдүүлсэн.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн яамны Ажлын хэсэгт цагдаагийн байгууллагыг төлөөлөн Хуулийн хэлтсийн дарга санал, дүгнэлт боловсруулан ажиллаж байна.

4.1.1.3.Хууль зүй, дотоод хэргийн салбарын цахим мэдээллийн төв байгуулна.

Биелэлт:Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу “Буянт-Ухаа спорт цогцолбор”-ын хойд талд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын нэгдсэн “Дата төв”, “Видео аналитик, платформ систем”, “Ханан дэлгэцийн систем”, “Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж” болон “Орон нутгийн хатуу хучилттай авто зам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэг /пост/-ийг камерын систем бүхий “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн барилгын зураг, төслийг хийж, Барилгын хөгжлийн төвөөс баталгаажуулан хүлээж авсан.

4.1.1.4.“Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл”-ийг хэрэгжүүлнэ.

Биелэлт:“АЕГ-ын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл”-ийн хүрээнд хөгжүүлэх “Архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем”-ийн бодлогын даалгавар боловсруулах, эрх зүйн баримт бичгийн болон хэрэглэгчийн судалгаа, шинжилгээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг АЕГ-ын даргын 2023.03.14-ний өдрийн А/27-р тушаалаар байгуулж, төлөвлөгөөт ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлэх үндсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хоёр дугуйт нэг үе шаттай тендерийн урилгыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зарласан. Тендерийн нээлтийг үнэлгээний хороо 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, техникийн саналын үнэлгээг эцэслэн үнэлгээний тайланг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр БНСУ-ын Эксим Банк руу илгээж, 12-ны өдөр баталж ирүүлсэн. Тендерийн үнийн саналын нээлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, эцсийн тайланг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр БНСУ-ын Эксим Банк руу илгээсэн бөгөөд үнэлгээний тайланг БНСУ-ын Эксим Банкнаас 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр баталж ирүүлсэн. Төслийн гуравдугаар үе шат: Төслийн үндсэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, төсөл хэрэгжиж эхлэх үе шат 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр үндсэн гүйцэтгэгч БНСУ-н Эл Жи Си Эн Эс Консорциумтай гэрээ байгуулсан. Тус гэрээг БНСУ-н Эксим банк 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр албан ёсоор баталж, гэрээ хүчин төгөлдөр болж төлөвлөгөөний дагуу АЕГ-т хэрэгжиж байна.

4.1.1.5.“Цахим архив албан хэрэг хөтлөлт” хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл” боловсруулж, удирдлагад танилцуулахаар хүргүүлсэн. Төрийн 37 архивд хадгалагдаж буй цаасан болон тусгай суурьтай баримтаас 2022 онд 727 хөмрөгийн 1,106 дансны 21,377 хадгаламжийн нэгжийн 1,260,542 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, үүссэн мэдээллийн сангаас архивын лавлагаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд шуурхай олгож байна.

ХЗДХС-ын 2023 оны А/13 дугаар тушаалаар "Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл" батлуулж, чиглэлд тусгагдсан зорилтын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх 5 зорилтын 18 арга хэмжээний хэрэгжилтийг 37 төрийн архив бүрэн хангаж ажилласан.

Төрийн архивын нэгдсэн www.e-document.gov.mn системд 2023 онд 21 аймгийн төрийн архивд хөмрөг үүсгэгч 645 байгууллагын 848 дансны 28,525 хадгаламжийн нэгжийн 450,098 баримтын 2,516,751 хүний нэрийн мэдээллийг системд бүртгэсэн. Үндэсний төв архив болон 21 аймгийн төрийн архиваас үзүүлж буй 9 төрлийн архивын лавлагаа, үйлчилгээний хүсэлтийг төрийн архивын лавлагаа, үйлчилгээний www.e-archives.gov.mn системээр иргэн, хуулийн этгээдийн 26,224 лавлагааны захиалга авч, үүнээс 26,119 лавлагааг шийдвэрлэж /99.6%/, 7547 зөвлөгөө мэдээлэл, системд бүртгэсэн.

4.1.1.6. Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

Биелэлт: Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Архив, үйлчилгээний цогцолбор төвийн барилга, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар Ховд, Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын барилга байгууламж, засвар үйлчилгээний асуудлыг шийдвэрлэсэн.

Үүнээс Засгийн газрын 2023.03.29-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор Завхан, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газарт бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг эдгээр аймгийн УБХ-т балансаар шилжүүлэх ажлыг зохион байгуулав. ТӨБЗГ-ын 2023.03.28-ны өдрийн 104 дүгээр тогтоол, Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2022.12.05-ны өдрийн 75 дугаар тогтоолоор тус аймгийн ЗДТГ-ын III байрны 580.2м.кв талбайтай хэсгийг УБХ-т эзэмшүүлж, хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэв.

ТӨБЗГ-ын шийдвэр болон Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2022.09.30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тус аймгийн цагдаагийн газрын 507.94 м.кв байрыг УБХ-т балансаар шилжүүлэв. Уг байрыг 49 сая төгрөгөөр засварлаж, 2023.02.13-ны өдрөөс ашиглаж эхлэв. Мөн Дорнод аймгийн УБХ нь ажлын байрны нөхцөл байдал, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг даргад санал хүргүүлснээр шинээр ашиглалтад орсон Нутгийн удирдлагын ордны зүүн жигүүр буюу Б корпус архивын 2 өрөө, үйлчилгээний 2 танхим, цахим 1 танхим, албан хаагчдын 5 өрөөг тус тус шийдвэрлүүлээ.

4.1.1.7. Иргэний улсын бүртгэлийн дугаар болон тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн, бүртгэлжүүлнэ.

Биелэлт: Төрийн мэдээлэл солилцооны (ХУР) систем дэх улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж буй бүх сервист өөрчлөлт оруулж, төрийн болон бусад байгууллага иргэний улсын бүртгэлийн дугаараар мэдээлэл авах боломжтой болсон. Мөн Монгол Улсад төрсөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын харьяат болсон иргэний улсын бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хөтөлж, тухай бүр мэдээллийн сангаас иргэний бүртгэлийн дугаарыг шууд олгож байна. Харин иргэний харьяаллыг сэргээн тогтоосны бүртгэл хөтөлсөн тохиолдолд тухайн

иргэний бүртгэлийн дугаарыг мэдээллийн сангаас сэргээж, ашиглах боломжтой болов. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэнд иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан цахим шуудангийн хаяг нээсэн. Ингэснээр хуулийн хэрэгжилтийг хангаж, хүний хувийн мэдээллийг хамгаалах боломж сайжрав.

“Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн төсөлд холбогдох саналыг 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1/1258 тоот албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн ба уг хуулийн төсөлд иргэний бүртгэлийн дугаарт үндэслэн цахим гарын үсгийг олгох, ашиглах асуудал тусгагдсан. Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг Монгол Улсын Засгийн газрын 2022.10.10-ны өдрийн “Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг шинэчлэн батлах тухай” 374 дүгээр тогтоолоор батлуулж, иргэний үнэмлэх дээр регистрийн дугаарын оронд иргэний бүртгэлийн 12 оронтой дугаарыг ил харагдах байдлаар бичих ажлыг 2022.12.13-ны өдрөөс эхлүүлэв. Энэ оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 273,410 иргэнд шинэ загварын иргэний үнэмлэх олгосон байна.

4.1.1.8. Иргэний үнэмлэхийн үйлдвэрийг өргөтгөн гадаад паспортын бэлдцэд бичилт хийх үйлдвэрийн бүтцийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт байгуулан үндэсний цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлнэ.

Биелэлт: “Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспортын бэлдцэд бичилт хийх үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/1145 дугаар тушаалаар баталсан. Орон нутаг дахь Улсын бүртгэлийн газар, хэлтсийн мэргэжил арга зүйгээр хангаж 2022 оны 9 дүгээр сарын 29-ний 1/8275 тоот албан бичгээр “Гадаад паспортын бүртгэл хөтлөх тухай” чиглэлийг хүргүүлсэн. Хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-ын бүртгэлийн ажилтныг арга зүйгээр хангаж, мөн өдрийн 1/8274 тоот албан бичгээр Гадаад харилцааны яаманд мэдээлэл хүргэсэн. Гадаад паспортын бүртгэлийн үнэ хураамжийн мэдээлэл бэлтгэж, байгууллагын веб сайт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэсэн. Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг цахимжуулж, өөрийн үйлдвэрт бичилт хийх үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх танилцуулгыг бэлтгэж, “Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспортын бэлдцэд бичилт хийх үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг УБЕГ-ын даргын 2022.09.15-ны өдрийн А/1145 дугаар тушаалаар батлав. Үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн байрыг олон улсын стандартын дагуу засварлаж, тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулан 2022.10.01-ний өдрөөс ажиллуулж эхлэв. Тайлант хугацаанд 585,634 иргэн гадаад паспорт авах хүсэлт гаргасан. Үүнээс энгийн гадаад паспорт авах 309,716, цахим гадаад паспорт авах 275,918 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүрэн шийдвэрлэсэн.

4.1.1.9. Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ.

Биелэлт: Бүртгэлийн байгууллагын үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр үзүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг хүртээмжтэй, хялбар хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал (E-Mongolia, “E-Business”)-д 105 төрлийн үйлчилгээ нэвтрүүлэхээс тайлант хугацаанд 107 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Мөн дээрх үйлчилгээнүүдээс төрсний бүртгэлийн, гэрлэлт, гэрлэлт цуцалсны, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхийн лавлагаануудыг англи хэл дээр авах боломжтой болов.

“E-Mongolia, E-Business” төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар 2020-2023 оны 12 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 10,959,863 лавлагаа, үйлчилгээг иргэн, хуулийн этгээд авчээ. Үүнээс: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 7,973,001, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2,558,097, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр

428,765 лавлагаа, үйлчилгээ, англи хэл дээр 407,787 лавлагаа тус тус олгожээ. Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ)-аас 2023.02.08-ны өдөр зохион байгуулсан И-Бизнесийг хөгжүүлэх, цахимаар хуулийн этгээдийг бүртгэхтэй холбоотой асуудлаар ЦХХХЯ, Голомт банкттай гурван талт уулзалт хийв. Улсын бүртгэлийн “ДӨТ” машинаар иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээний талаар "Нью компас" ХХК-ийн төлөөлөлтэй уулзаж, холбогдох саналыг хүргүүлэв. Энэ ажлын хүрээнд “ДӨТ” машинаар гадаад паспорт, иргэний үнэмлэх дахин авах болон шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийхээр хөгжүүлэлт хийв.

4.1.1.10. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болно.

Биелэлт: Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ)-ын дарга нарын 2023.05.15-ны өдрийн А/82, А/985 дугаар хамтарсан тушаалаар Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн санг байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. 2023 онд нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Төв аймгийн Баянчандмань сумын мэдээллийг кадастрын дугаар, хаягийн мэдээллээр тулгахад Чингэлтэй дүүрэгт 43.7%, Баянчандмань суманд 53.9 хувийн нийцэлтэй байна. Түүнчлэн тус ажлын хэсэг Дундговь аймгийн Сайнцагаан суманд ажилласан бөгөөд нэгж талбарын дугаартай 10,350 бүртгэлийн хаягийн мэдээллийг ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 11,675 хаягийн мэдээлэлтэй тулгахад 4,150 мэдээлэл нийцэж байв. Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2023.05.17-ны өдрийн 11/А/46 дугаартай тушаалаар шинэчлэн байгуулагдсан “Хаягийн мэдээллийн системийг нэвтрүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг судлан тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах, салбар хоорондын уялдааг ханган хамтран ажиллах” үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна.

Хаягийн нэгдсэн мэдээллийн санг газрын нэгж талбарын дугаарт суурилан, хуучин, шинэ хаягийг зэрэгцүүлсэн байдлаар үүсгэхээр УБЕГ, ГЗБГЗЗГ-т байгаа хаягийн мэдээллийг тулгах ажил үргэлжилж байна. Уг ажлын хүрээнд УБЕГ-аас орон нутгийн кадастрын дугаартай 566,822 бүртгэлийн жагсаалтыг, хоёр байгууллага хамтран мэдээллийн сан үүсгэж, улсын бүртгэлийн байгууллагаас, ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 540,364 мэдээллийг байрлуулсан бөгөөд Үндэсний Дата төв дээр виртуал сервер бүхий дундын мэдээллийн санг 19 багана бүхий хаягийн мэдээлэлтэйгээр үүсгэсэн. Энэ нь орон нутагт байгаа нийт хаягийн бичлэгийн 92.6 хувийг эзэлж байна.

4.1.1.11. Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар Улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглана.

Биелэлт: Газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаас автоматаар олгодог болсон бөгөөд 2023.12.08-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 64,708 дугаар дундын мэдээллийн сангаас олгосон байна. Монголын нотариатчидын танхимын 89 нотариатчтай мэдээлэл солилцох гэрээг байгуулсан. Монголын нотариатчидын танхим болон “Интерактив” ХХК нотариатын зуучлалын системийг хөгжүүлж байгаа ба УБЕГ-аас API болон орчны тохиргооны мэдээлэл, шаардлагатай сервисүүд, нэвтрэх нэр, нууц үгийг үүсгэж өгсний дагуу системийг ашиглахад бэлэн болоод байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо хуульд заасан хязгаартай мэдээллийг тухайн байгууллагын үндсэн чиглэл, үйл ажиллагаанд нийцүүлэн “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр

мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ийн дагуу төрийн 125, хувийн хэвшлийн 313 байгууллага нийт 438 байгууллагат 173 төрлийн сервис үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн яамны төрөлт, ГЗБГЗЗГ-ын Э, А дугаарын мэдээллийг солилцох сервисийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. 2023.12.10-ны өдрийг хүртэл 62,114 иргэнд регистрийн дугаар, газрын эзэмших гэрчилгээ 63,715 дугаар, ашиглах гэрчилгээ 993 дугаар тус тус олгосон байна

4.1.1.12. Ухаалаг эмнэлэг хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эмнэлгийн захирлын 2021 оны А/86 дугаар тушаалаар “Ухаалаг эмнэлэг 2021-2024 он” хөтөлбөрийг 4 зорилт 30 үйл ажиллагааг төлөвлөн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Сан тус хөтөлбөрийн хүрээнд эмнэлэгт ашиглаж буй эрүүл мэндийн программ болох “Medsoft” v.6.0 программыг “Medsoft” v.7.0 программд шилжүүлж, хөгжүүлэн ажиллаж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “CALL PRO” үйлчилгээг нэвтрүүлэн, UP-TO-DATE платформыг ашиглах эрхийг эмч бүрд нээн өгч ажилласан. “M health” аппликейшнийг ашиглан хөдөлгөөнт орчинд буюу гар утас, таблет төхөөрөмжөөс “Medsoft v.7.0” программын эмчилгээ үйлчилгээний харилцах цонхтой харьцаж ажиллах үйл явцын судалгааг хийсэн шинээр аппликейшн бичүүлэх ажил METIPS ХХК-тай гэрээ байгуулан ажиллах хүсэлт илгээсэн. Уг аппликейшнийг ажиллуулахад мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эмнэлгийн серверт гаднаас хандах боломжгүй байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ технологи болох “Алсын зайн эмчилгээ, оношилгооны 5G нүдний шил”-ийг нэвтрүүлж, тусламж үйлчилгээ үзүүлж байна. Мөн “Dell-r 970 gold” загварын өндөр хүчин чадал бүхий сервер тоноглолыг нэмэлтээр байршуулж, эмнэлгийн нэгдсэн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн.

4.1.1.13. Стандарт, хэмжил зүйн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно

Биелэлт: Стандарт, хэмжил зүйн салбараас үзүүлж буй зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 6,608 стандартыг нэг дороос үзэж танилцах, худалдан авах нөхцөлийг www.estandart.gov.mn цахим сан бүрдүүлсэн. Хэмжил зүйн мэдээллийн сан, Баталгаажуулалтын мэдээллийн сангийн бүртгэлийн программыг нэвтрүүлсэн. www.masm.gov.mn цахим хуудсыг хөгжүүлж байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангасан. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/197 тоот тушаалаар “Салбарын ажил, үйлчилгээ, мэдээллийн санг цахимжуулах ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулан салбарын нэгдсэн системийг бий болгох ажлын даалгаврыг боловсруулсан бөгөөд 2024 онд цахимжуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр 500 сая төгрөгийн төсвийг батлуулаад байна.

4.1.2. Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана.

4.1.2.1. Цахим засаглалын хөгжлийг дэмжсэн хуулийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

Биелэлт: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслүүд УИХ-аар

хэлэлцэгдэж батлагдсан. Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 14 журам батлагдсан байна.

4.1.3.Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.

4.1.3.1.Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлнэ.

Биелэлт: 2021 оны хэрэгжилт ЦХХХЯ: 1. Төрийн байгууллагууд хоорондох мэдээллийн урсгалыг цахимжуулах ажлын хүрээнд Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд төрийн 72 байгууллагыг холбогдсон. Албан бичиг солилцооны дундын DocX системийг хөгжүүлэн Аблесофт, erp.e-mongolia.mn, Digital office, Veritech erp, "e-doc", "Able" зэрэг 12 төрлийн албан бичиг солилцооны системтэй холболт хийн 4000 гаруй байгууллагатай албан бичиг солилцоо боломж бүрдсэн. 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 43,942 бичгийг 54,953 хуудас хавсралт илгээж, 57,196 албан бичиг хүлээн аваад байна.

4.1.3.2. Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлнэ.

Биелэлт: "E-Mongolia 3.0" хувилбарын шинэчлэлийн хүрээнд E-Mongolia системийн хэрэглэгчийн хандалт, сүлжээний урсгал, ачаалал зэргийг хянаж ачаалал ихтэй үед ухаалгаар өөрийгөө өргөтгөж, ачаалал буурсан үед буцаж багасгах чадвартай AI /хиймэл оюун ухаан/-д суурилсан функц бүхий динамик шийдэл нэвтрүүлсэн. Ингэснээр платформ үр ашигтайгаар ажиллаж, олон төрлийн хэмнэлт хийхээс гадна илүү хурдтайгаар нэг агшинд 2 сая хэрэглэгчийн ачааллыг тэнцвэржүүлэх боломжтой болсон. Мөн "Авлигатай тэмцэх газарт өргөдөл гомдол гаргах" цэсийг шинээр нэмж, E-Mongolia системээс 11-11 дугаарт дуудлага хийх нөхцөлийг бүрдүүлсэн.

Иргэдэд төрийн байгууллагаас олгодог баримт бичиг, гэрчилгээ, зөвшөөрөлтэй холбоотой төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдлийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia.mn)-ээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж, иргэдэд 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 26,310,835 мэдэгдлийг хүргэсэн. Үүнээс үндэсний цахим шуудан (65% буюу 17,102,676), хувийн цахим шуудангийн хаяг (1.2% буюу 299,995), Push Notification (33.8% буюу 8,908,164)-ээр дамжуулан хүргэсэн. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох Үндэсний цахим шуудангийн систем (www.mail.e-mongolia.mn)-ийг нэвтрүүлж, 1.7 сая хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д гадаадын иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах, төрийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд яаралтай тусламжийн үйлчилгээ авах, цахим орчинд хүүхэд өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлж, "E-kids" шийдлийг нэвтрүүлсэн бөгөөд Танилт нэвтрэлтийн Дан системээр 23,273 орчим хүүхэд бүртгүүлсэн байна.

4.1.3.3.Төрийн цахим үйлчилгээний E-Mongolia системийн ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

Биелэлт: Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia" платформыг ашиглан хүн, хуулийн этгээд төрийн цахим үйлчилгээг нийслэл, орон нутагт байрлах төрийн үйлчилгээний нэгдсэн төв, "E-Mongolia" цахим хуудас болон гар утасны "E-Mongolia" аппликейшнаар авах боломж бүрдсэн. 2020 онд 23 байгууллагын, 2021 онд 59 байгууллагын 606, 2022 онд 69 байгууллагын 897, 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 86 байгууллагын 1130 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж, нийт 39,995,205 (38,078,442 нь амжилттай) удаагийн хандалт бүртгэгдсэн байна. Тус системээс 2022 оны жилийн эцсийн байдлаар 1.4 сая хэрэглэгч үйлчилгээ авсан ба 2023 оны 12 дугаар сарын байдлаар 319 мянга орчим хэрэглэгч шинээр нэмэгдэж, 1,729,205 буюу насанд хүрсэн иргэдийн 77% нь бүртгүүлж, 240,730 хэрэглэгч идэвхтэй ашиглаж байна.

2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр "E-Mongolia 3.0" хувилбарыг нэвтрүүлсэн. Шинэчилсэн хувилбараар хурууны хээ болон царай таньж нэвтрэх, яаралтай тусламжийн тусгай дугаар, 11-11 шууд дуудлага хийх, хэрэглэгчийн хамгийн их ашигладаг үйлчилгээг хамгийн ойр харуулах, хандалт ихтэй үйлчилгээ санал болгох, хянах самбараас үйлчилгээний хүсэлт, шийдвэрлэлтийн явц, сонордуулга зэргийг хянах, өөрийн фейсбүүк хаяг, үндэсний и-мэйл, "push notification", хувийн и-мэйл хаягуудаас сонгон баримт бичгийн хугацаа дууссан сонордуулга, төлбөрийн нэхэмжлэх болон үйлчилгээний мэдэгдлийг хүлээн авах, төрийн 11 байгууллага дахь өөрийн 14 төрлийн мэдээллээ шалгаж, хяналт тавих, нотариатын үйлчилгээ, нийтийн тээврийн тасалбар захиалах, цахим ур чадвар олгох гарын авлага харах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ID-ийг нэмж, сул хараатай иргэдэд зориулан өнгөний контрастыг нэмэгдүүлэх, өөрчлөх, шөнийн горимд шилжих боломжтой дэлгэцийн шинэчлэлийг хийж, үсгийн фонтоо хэмжээг өөрийн хэрэгцээнд тааруулан ихэсгэж, багасгах боломжийг бүрдүүлсэн.

4.1.3.4. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилнэ.

Биелэлт: Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төсвийг Төсвийн тухай хуульд тусгагдаагүй. Иймээс Монгол Улсын суурь гэрчилгээжүүлэх байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үндэсний суурь гэрчилгээжүүлэх системийг шинэчлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцооллыг гаргаж, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад ""Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх"" төслийн хэрэгжүүлэхээр тогтсон. Уг төслийн хүрээнд "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх" төслийн ажлын даалгаврыг боловсруулан төсөл хэрэгжүүлэх нэгжид 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн. Ажлын даалгаварт тоон гарын үсгийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх, цагийн бүртгэлийн системийг шинээр байгуулахад шаардлагатай программ хангамж, тоног төхөөрөмж, хийгдэх ажлын жагсаалтыг тусгасан.

4.1.3.5. Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулна.

Биелэлт: Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үндэсний суурь гэрчилгээжүүлэх байгууллагын техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг шинэчлэхэд шаардлагатай техникийн шаардлагыг боловсруулсан. Улмаар нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төслийн саналыг Дэлхийн банк, АХБ-д хүргүүлсэн. Мөн Монгол Улсын 2023 оны улсын төсвийн тухай хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулахаар холбогдох саналыг боловсруулсан. Дэлхийн Банкны

Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд “Үндэсний нийтийн түлхүүрийн хэрэглээнд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх” төслийн ажлын даалгаврыг боловсруулан төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн. Ажлын даалгаварт шинээр байгуулагдах суурь систем, цагийн бүртгэлийн системд аудит хийх байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавигдах шаардлагыг тусгасан.

4.1.3.6. Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт:Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд тоон гарын үсэг олгох талаарх зохицуулалтыг тусгасан. Хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг тус яамны сайдын А/28, Нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх журмыг тус яамны сайдын А/30 тоот тушаалаар тус тус баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Улсын бүртгэлийн байгууллагаас 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 171 хорооны бүртгэлийн нэгжээр дамжуулан нийт 313,384 иргэнд, тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас нийт 82,242 хуулийн этгээдэд, “Үндэсний дата төв” УТҮГ-аас 14,288 төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгоод байна. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс иргэнийг цахим харилцаанд таньж баталгаажуулах, төрийн үйлчилгээний системд нэвтрэхэд тоон гарын үсэг ашиглах боломжийг бүрдүүлсэн. Иргэн, хуулийн этгээд тоон гарын үсэг ашиглан танилт, нэвтрэлтийн систем ашигладаг төрийн 89 байгууллага, хувийн хэвшлийн 111 байгууллагын системээр дамжуулан цахим хэлбэрээр үйлчилгээ авах боломжтой болсон.

4.1.3.7. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний хамрах хүрээг өргөтгөн аймгийн төвүүдийг төв (Улаанбаатар хот)-тэй холбосон дэд систем, сүлжээг зохион байгуулна.

Биелэлт: Орон нутгийн төрийн захиргааны байгууллагыг ТМНС-д холбох ажлын хүрээнд “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-тай хамтран 21 аймгийн төвийн Засаг даргын Тамгын газрыг ТМНС-д холбох холболтын зардлыг нарийвчлан гаргаж, сүлжээний архитектур, дизайнд үндэслэн сүлжээг өргөтгөхөд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтыг гүйцэтгэж, 2022 оны IV улиралд ТМНС-д холбосон.

4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.

4.1.4.1.Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний E-Mongolia системд холбоно.

Биелэлт: Энэ арга хэмжээг ТӨБЗГ-аас санал өгч тусгаагүй, алдаа үүссэн байх тул тус байгууллагаас хэрэгжилтийг хариуцан тайлагнах боломжгүй. Манай байгууллагын эрхлэн хариуцах ажил биш тул үнэлгээг хугацаа болоогүй гэж авч нийт үнэлгээнээс хасаж тусгасан болно.

4.1.4.2. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлсэн цахим систем бий болгоно.

Биелэлт: Засгийн газрын харьяа тусгай сангуудын үйл ажиллагааг олон нийтэд ил болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх, боловсруулах зорилгоор судалгааны асуулгыг боловсруулан үйл ажиллагаа явуулж буй 22 тусгай санд албан хүсэлт хүргүүлэн мэдээллийн системийн талаар судалгаа авч дүгнэлтийг боловсруулсан. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (www.shilen.gov.mn)-ийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулсан. Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нийт 24 тусгай сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг ил тод, нээлттэй байршуулсан.

4.1.4.3. Төрийн байгууллагуудыг холбосон дүрст хурлын нэгдсэн системийг бий болгоно.

Биелэлт: “Төрийн байгууллагуудыг холбосон дүрст хурлын нэгдсэн системийг бий болгох” төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэх техникийн шаардлага, судалгаа, шийдэл боловсруулж, 21 аймгийн Засаг даргын тамгын газрыг тусгай хэрэглээний сүлжээнд холбосон. Дүрст хурлын төхөөрөмжийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 онд 1,628,069,256 төгрөг зарцуулсан байна.

4.1.4.4. Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх программ хангамжтай болно.

Биелэлт: Хүсэлт ирүүлсэн 5 байгууллагын үнэлгээг цахимаар зохион байгуулсан. УИТ-ийн цахим хуудасны <https://www.mnas.gov.mn/accredited> хэсэгт Итгэмжлэгдсэн байгууллагуудыг мэдээллийг итгэмжлэгдсэн хүрээний хамт итгэмжлэлийн шийдвэр гарсан тухай бүр байршуулж байна.

4.1.4.5. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.

Биелэлт: Уг мэдээллийн системийг боловсронгуй болгоход шаардагдах нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөв МУ-ын 2022 оны төсвийн тухай хууль, МУ-ын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдан зарим тендер зарлагдсан байсан нь 2022 онд батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлтэй холбоотой цуцлагдсан.

Төсөл, арга хэмжээг “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгахаар холбогдох журам, аргачлалын дагуу санал, үндэслэл, тайлбарыг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ЭЗХЯ-нд ТӨБЗГ-ын 2023.01.12-ны өдрийн А-1/96 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Уг хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах үе шаттай ажлуудыг гүйцэтгэж, холбогдох байгууллагатай хамтран ажилласны үр дүнд УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд уг асуудал тусгагдсан. УИХ-ын 2023.11.10-ны өдрийн чуулганаар баталсан МУ-ын 2024 оны төсвийн тухай хуулиар улсын төсөвт уг арга хэмжээний зардалд 1,200.0 сая төгрөг тусгагдсан. Иймд холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах зэрэг ажлуудыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж эхлээд байна. ТӨБЗГ-ын 2023.11.30-ны өдрийн хуралдаанаар “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн болон эд хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайлангийн тухай”

асуудлыг хэлэлцээд "...Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн систем"-ийг бий болгох ажлыг 2024 онд эхлүүлж, 2025 онд багтаан дуусгах, Сангийн яам, УБЕГ, ГЗБГЗЗГ, АТҮТ зэрэг төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбох асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх нь зүйтэй" гэж 41 дүгээр тэмдэглэлд тусгасан.

4.1.5.1. Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбоно.

Биелэлт: Монгол Улсын хэмжээнд Хөвсгөл аймгийн Ханх, Дорнод аймгийн Дашбалбар, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Баянжаргалан зэрэг 5 сум шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл" -ийн хүрээнд дээрх 5 сум болон Увс аймгийн Тэс сумын Тэс боомт, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Зэлтэр боомт, Дорнод аймгийн Баян-Уул сумын Ульхан зэрэг 3 боомтыг шилэн кабелийн сүлжээнд холбох төсөл хэрэгжихээр баримт бичгийн шатандаа явж байна.

4.1.5.2. Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна.

Биелэлт: Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах мэдээллийн зангилаа төвийг Дархан-Уул аймагт байгуулахаар 2022 онд тус аймагт 2000 мкв талбай бүхий 2 давхар төвийг байгуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд газар шороо, суурийн цутгалт хийгдсэн. 2023 онд карказ, өрлөг, шавар, газардуулга, гадна шугам сүлжээ, дээвэр, шат довжоо, агаар сэлгэлт, гадна авто замын цутгалт, цонхны ажил хийгдэж дууссан. Одоогоор бодит гүйцэтгэл 80 хувьтай, дотор заслын ажил, дотор цахилгааны ажил, гадна заслын ажил, дотор холбооны ажил болон дулаан дамжуулах төвийн барилгын ажил хийгдэж байна. Төслийн гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болж байгаа тул сунгах, мөн тухайн оны санхүүжилтийг захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд авах, санхүүжилтийг 2024 онд ажлын гүйцэтгэлд үндэслэн олгохоор ажиллаж байна.

4.1.5.3. Үндэсний дата төвийн техник, хүчин чадлыг сайжруулна.

Биелэлт: Мэдээллийн технологийн дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг бууруулах, төрийн цахим системүүдийн хэвийн ажиллагааг хангах, цахим үйлчилгээний чанар, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх суурь дэд бүтцийг бий болгох чиглэлээр Төрийн үүлэн тооцоолол (Төрийн клауд)-ын дэд бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр Фибо глобал ХХК-тай хамтран "mCloud" системийг нэвтрүүлсэн. Үндэсний дата төв УТҮГ-ын өөрийн орлогын санхүүжилтийг улсын төсвийн санхүүжилтээр тооцон Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгаж, төрийн 960 гаруй байгууллагад үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

4.1.5.4. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлнэ.

Биелэлт: Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийг 2023 онд нэвтрүүлэхтэй холбогдуулан уг технологийн онцлог болох өндөр хурдны хөдөлгөөнт холбоо, машин хоорондын холбоо, юмсын интернетийн үйлчилгээний талаарх 8 салбарын зах зээлийн судалгааг хийж, Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай радио давтамжийн нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд анхны туршилтыг 2021 оны 09 дүгээр сарын 17-19-ний өдөр ХХМТГ-аас зохион байгуулсан "Digital Nation" арга хэмжээний үеэр амжилттай зохион байгуулсан ба туршилтад БНХАУ-ын Зэт Ти И

компанийн хөгжүүлсэн харилцаа холбоо, дэд бүтэц, автоматжуулалт, IoT-д тулгуурласан 8 бүтээгдэхүүнийг, үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнител ХХК-ийн 5G технологид тулгуурласан IoT бүтээгдэхүүн, Анд глобал ХХК автоматжуулалт болон интернэтийн үйлчилгээний Ондо брэнд бүтээгдэхүүнээ тус тус олон нийтэд танилцуулсан. 2022 онд Улаанбаатар хотын Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, Ай Эн Мобайл ХХК, Скайтел ХХК-иуд хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийн туршилтын бүсийг үүсгэж, туршилтыг амжилттай хэрэгжүүлсэн. 5G технологийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангахын тулд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалаар Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг баталсан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Тус хорооны даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурваст тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалтын баримт бичиг бэлтгэх ажлын хэсэг байгуулагдсан. Уг баримт бичиг бэлэн болоход сонгон шалгаруулалт зарлагдаж, 5G технологид ашиглах радио давтамжийн зурвасын олголт хийгдэнэ.

4.1.5.5. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна.

Биелэлт: Монгол Улсын хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөрийн төсөв шаардлагатай төслийн жагсаалтад оруулсан. Сангийн яаманд 2023 онд хэрэгжүүлэх төсөл болон төсвийн тооцооллыг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/956 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т заасны дагуу Улсын хэмжээнд нэгдсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд өргөн нэвтрүүлгийн аналогийн дэд бүтцийг тоон технологид шилжүүлэх нэн шаардлагатай байгааг тодорхойлж, холбогдох мэдээллийг боловсруулан 2017, 2019 онд Сангийн яаманд удаа дараа хүргүүлсэн ба тухайн онд хэрэгжүүлэх төсөв болон төслийн тооцооллын жагсаалтад багтаагүй. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцын 2023 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу Сангийн яам болон Улсын Их Хуралд хүргүүлсэн. 2021-2023 оны төсөвт уг төслийн санхүүжилт батлагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүй байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/76 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг "Хонхорын аналогийн радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцыг тоон технологид шилжүүлэх" техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулсан.

4.1.5.6. Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв байгуулна.

Биелэлт: Монгол шуудан ХК-ийн санхүүжилтээр Төв аймгийн Хөшгийн хөндийд 2 давхар бүхий Шуудангийн ялган боловсруулах төвийг барьж дууссан бөгөөд Улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Мөн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нээлт хийхээр бэлтгэл ажил хангагдсан.

4.1.5.7. Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулна

Биелэлт: Харилцаа холбооны худаг сувагчлалд ашиглалтгүй болсон 100 хосоос дээш физик болон шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах ажлыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Монголын цахилгаан

холбоо ХК хамтран хэрэгжүүлж байна. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь КШ-32 чиглэлд 7592.5м, КШ-34 чиглэлд 2374.5м, КШ-351 чиглэлд 4635.3м, КШ-36 чиглэлд 13924.7, КШ-45 чиглэлд 10133.6м, КШ-63 чиглэлд 1045.6м, КШ-68 чиглэлд 3525.4м, нийт 43231.6 м кабель чөлөөлсөн.

4.1.5.8. Харилцаа холбооны дэд бүтцийг эрчим хүч, зам, замын байгууламж, барилга байгууламж зэрэг бусад инженерийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөнө.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар “Барилгын мэдээлэл холбооны болон менежментийн системийн сүлжээний зураг төслийн төлөвлөлтийн норм ба дүрэм”-ийг хэлэлцүүлж, дэмжигдэв. Эрчим хүчний яамтай хамтран “Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн мэдээлэл холбооны ажил” төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-иас 07 дугаар сарын 07-ны өдөр Худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийг хамгаалах, шилжүүлэх, шинээр суурилуулах техникийн нөхцөлийг баталсан. Хот төлөвлөлтийн судалгааны институтээс 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан уулзалтад Барилгын хөгжлийн төвд “Сэлбэ сэргэлт” төслийн Багц-1 болон Багц-2 хэсэгт таарсан холбооны худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийг зөөж шилжүүлэх төсвийн тооцоо болон холбооны худаг сувагчлал, кабелийн байгууламжийг шилжүүлэх, хамгаалах техникийн болон ажлын зураг боловсруулах даалгавар батлуулсан.

4.1.5.9. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг зохион байгуулна.

Биелэлт: Шуудангийн тухай хуулийн 6.1.5-д заасан Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/87 дугаар тушаалаар байгуулсан. Уг ажлын хүрээнд журмын төслийг боловсруулж, 24 байгууллагаас санал авахаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/2168 дугаартай албан бичгийг хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

4.1.5.10. Шуудан, ложистик, цахим худалдааны дамжуулах чадварыг өргөтгөн, сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.

Биелэлт: Азийн хөгжлийн банктай 2021 оны 11 дүгээр сард байгуулсан Бүс нутгийн “Цахим эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх” санамж бичгийн хүрээнд Монгол Улс дахь цахим худалдааны хууль эрх зүй, зохицуулалтын саад бэрхшээлийг тодорхойлж, сайжруулах зөвлөмжийг боловсруулах судалгаа хийгдэж байна. Уг ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр ГХЯ, ХХЗХ, АХБ-тай хамтран төр, хувийн хэвшлийн 80 орчим төлөөллийг оролцуулсан “Цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал” хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүнг нэгтгээд байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Дижитал эдийн засаг, цахим арилжааны хөтөлбөрийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар, Европын сэргээн босголтын банк, Хөгжлийн банк хамтран Монгол Улсын цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээг хийх Гадаад харилцааны яамнаас байгуулсан ажлын хэсэгт ажиллаж байна. Уг ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан Үндэсний олон талт зөвлөлдөх уулзалтад оролцож, Монгол Улсын цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдлын талаар хийсэн эхний тайлантай танилцаж, судалгааны ажлын даалгаварт санал өгсөн.

4.1.5.11. Шуудангийн нэгдсэн кодыг олон нийтэд таниулж, хэрэглээг цахим худалдаанд нэвтрүүлнэ.

Биелэлт: Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан шуудангийн нэгдсэн кодыг бусад платформуудтай холбох API-г Shoppu.mn, zochil.mn-үүдэд оруулахаар тохиролцож холбох ажлыг хийж байна. Нэгдсэн кодын холболт хийх ажлыг Бодь электроникс ХХК хариуцаж байгаа бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хороо ажлыг хүлээн авч байна. Мөн нэгдсэн кодыг хэрэглээнд нэвтрүүлэх, олон нийтэд таниулах хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр цахим худалдааны 56 байгууллагуудын дунд зохион байгуулж, хэлэлцүүлгээс зөвлөмж гарган танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 180 дугаар тогтоолын дагуу 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам хамтран төрийн болон хувийн хэвшлийн 30-аад байгууллагыг хамруулан хаягжилтын асуудлыг шийдвэрлэх нэгдсэн системтэй болох зорилгын хүрээнд “Газар, үл хөдлөх хөрөнгийн хаягжуулалт-Орон зайн өгөгдлийн дэд бүтэц” сэдэвт уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Барилга, хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан тушаал гарч, ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу зип код, шуудангийн кодыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай тулгах, нэгтгэх ажил хийгдэж байна.

4.1.5.12. Үндэсний хиймэл дагуул хөөргөх хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийн төслийг боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/93 дугаар тушаалаар "Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл"-ийг баталсан. Сансрын тухай хууль, тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох 34 асуумжийг боловсруулж, 37 байгууллагад хүргүүлэн санал авч судалгааг хийсэн. Мөн 23 орны сансар судлалтай холбоотой хууль, бодлогын баримт бичгийг судалсан.

4.1.5.13. Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холболтын нэгдсэн төв байгуулна.

Биелэлт: Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холболтын нэгдсэн төв байгуулах төслийн судалгааг 2021 оны 4 дүгээр улиралд шинэчлэн хийсэн ба 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санал өгсөн. Тус судалгааг хийснээр төрөөс зайлшгүй дамжуулах телевизийн сувгуудыг нэг цэгт төвлөрүүлж, нягтруулж эфирт цацах, улмаар гамшгийн үеийн зарлан мэдээлэл, зөвлөмжийг нэг цэгээс олон нийтэд шуурхай дамжуулах боломж бүрдсэн. Мөн орон даяар дамжуулах телевизийн өргөн нэвтрүүлгийн чанарт хяналт тавих боломж бүрдэхээр төлөвлөгөөг хийсэн. Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий компаниуд өргөн нэвтрүүлгийн телевиз бүртэй тусдаа давхардсан холболт хийх шаардлагагүй байхаар төслийн техникийн төлөвлөгөөнд тусгасан. Хяналтын нэгдсэн төв байгуулснаар бүх өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, болон контент нэвтрүүлэлт нэг удирдлага дор орох эрсдэлтэй байх тул энэхүү төвийг байгуулахгүй байх дүгнэлт гарсан.

4.1.6. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.

4.1.6.1. Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын Цахим хөгжил, харилцаа, холбооны яамны дэргэд байгуулж, дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ыг 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, улсын бүртгэлийн 9068001076 дугаартай гэрчилгээ олгосон. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/48 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирлыг томилсон. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/122 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газрын зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын нэр, орон тоог баталсан. Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 3.4.8-д заасны дагуу захирлын 2023 оны 12 дугаар сарын тушаалаар нийтийн төвийн 8 ажилтныг томилж үйл ажиллагааг эхлүүлээд байна.

4.1.6.2. Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: ЦХХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтын 4 дэх (IPv4) хувилбараас 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг нь Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь /IPv6/ хувилбарт шилжих төлөвлөгөө боловсруулж, Ази, номхон далайн бүсийн сүлжээ мэдээллийн төв (APNIC)-тэй хамтран 2023 оны 02 дугаар сард салбарын инженер техникийн ажилтны чадавхжуулах сургалтад, мөн салбарын байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын хүрээнд "Монгол Улсын интернэтийн сүлжээг интернэт хаягжилтын IPv6 хувилбарт шилжих төлөвлөгөөний талаарх хэлэлцүүлэг"-т нээлттэй танилцуулж, хэлэлцүүлсэн.

“Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтын 4 дэх (IPv4) хувилбараас 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлыг Харилцаа холбооны зохицуулах хороо зохион байгуулж байна. Мөн Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтын 4 дэх (IPv4) хувилбараас 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх яамдын болон харьяа байгууллагуудын бэлэн байдлыг судалж, нийт 65 байгууллагаас судалгаа авч, судалгааны үр дүнг нэгтгэсэн. Үндэсний дата төв УТҮГ төрийн байгууллагуудын интернэт хаягжилтыг 6 дахь хувилбарт шилжүүлэх ажлыг эхлүүлж, тус газрын хариуцан ажилладаг Монголын интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн сүлжээ (MIX)-д IPv6 dual stack тохиргоогоор 9 интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллага холбогдсон байна. Монгол Улсын гадаад гарцаар олон улс руу IPv6 хаягжилтаар гарч байгаа траффикын хэмжээ 30%-д хүрсэн.

4.1.6.3. Үндэсний хэмжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгоно.

Биелэлт: Мэдээллийн аюулгүй байдлын сургалтын тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Японы улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Техникийн хамтын

ажиллагааны төслийн хүрээнд их дээд сургуулиуд, Удирдлагын академи, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын мэдээллийн аюулгүй байдлын сургагч багш нарыг чадавхжуулахаар тохиролцож, 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр кибер аюулгүй байдлын хүнийг нөөцийг хөгжүүлэх төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр танхим болон цахимаар 2023 онд нийт 15 сургалт зохион байгуулж, 872 төрийн албан хаагчийг хамруулсан. И-Монгол академи УТҮГ-ын захирлын 2022 оны А/42 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчдын мэдээллийн технологи ашиглах чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр” баталж, 2023 оны 11 дүгээр сарын байдлаар мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, нийслэлд 692, орон нутагт 763, нийт 1455 албан хаагчийг хамруулсан байна.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар танхим, цахимаар 2023 оны 12 дугаар сарын байдлаар мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр төрийн албан хаагчдыг чадавхжуулах I, II шатны сургалтыг зохион байгуулж, I шатны сургалтаар 20 аймгийн 13,666 төрийн албан хаагч, II шатны сургалтаар 4 аймгийн 1,262 төрийн албан хаагчийг хамруулж, нийт 14,928 төрийн албан хаагчийг хамруулсан. 2023 оны байдлаар Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 17,255 төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн байна.

4.1.6.4. Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 89 дүгээр, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 96 дугаар тушаалаар ЗГХЭГ, ХЗДХЯ, ЗХЖШ, ХХМТГ, ТЕГ-ын МАБГ, “MN CERT” ТББ-ын төлөөллийг оролцуулсан “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулж, хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн бөгөөд Улсын Их Хуралд өргөн барьж, хууль батлагдсан.

Эстониин Цахим Засаглалын академитай Харилцан ойлголцлын санамж бичгийг 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр шинэчлэн байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд цахим засаглалын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, цахим засаглалын шинэлэг шийдэл, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд харилцан туршлага солилцох, кибер аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах зэрэг ажлуудыг төлөвлөсөн. Мөн Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Европын улсууд, Дани, Швед, Норвег, Финлянд зэрэг орнууд руу аутсорсинг хийх боломжтой мэдээллийн технологийн компаниудыг холбож өгөх зорилгоор Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо, Дриймэрс нэгдэл, Хэрэглэгчдийн систем нийлүүлэгчдийн холбоо болон Веб хөгжүүлэгчдийн холбоо Төрийн бус байгууллагуудын талаарх судалгаа хийж, холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг боловсруулахад Америкийн Нэгдсэн Улсын MITRE байгууллагатай хамтран ажиллаж, санал солилцож байна.

Мөн Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран Кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж байна. 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг хөгжүүлэх төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурж баталгаажуулан сургалт зохион байгуулах лабораторийг бэлтгэж байна. Бүгд Найрамдах Израил Улстай Кибер аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах санамж бичгийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан.

4.1.6.5. Үндэсний CERT-ийн үйл ажиллагааг эхлүүлнэ.

Биелэлт: Ерөнхий сайдын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр баталсан “Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай” албан даалгаварт кибер халдлага зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэхээр үүрэг болгосны дагуу иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн систем, сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах нийтийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах санал боловсруулсан. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах асуудлаар 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулсан. Америкийн Нэгдсэн Улсын Карнеги Меллоны Их Сургуультай хамтын ажиллагааны хүрээнд Кибер аюулгүй байдлын боловсон хүчний чадавхыг дээшлүүлэхээр “Компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх баг байгуулах” сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 22-ноос 25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 20 байгууллагын 34 албан хаагч хамрагдсан. Санхүүжилтгүйн улмаас тоног төхөөрөмжийн худалдан авалт удаашралтай байна.

4.1.6.6.Цахим шинжилгээний лаборатори байгуулна.

Биелэлт: Цахим шинжилгээний лаборатори байгуулах 3-р ээлжийн худалдан авалтаар АНУ-ын “Digital Intelligence” компанитай тусгай техник, тоног төхөөрөмж худалдах, худалдан авах гэрээ байгуулсан. Улмаар тусгай зориулалтын цахим шинжилгээний лабораторийн шүүх шинжилгээний нотлох баримтыг цахимаар архивлах, сэргээх нэгдсэн системийг худалдан авч, ашиглалтад оруулсан. Мөн тус системийн үйлдвэрлэгч компаниас сургагч багш Монгол Улсад ирж систем дээр ажиллах шинжээч ажилтнуудад 3 хоногийн хугацаатай сургалт явуулсан нь шинжээчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн өндөр ач холбогдолтой ажил болсон.

4.1.6.7.Дипломат төлөөлөгчийн газруудыг холбосон тусгай хэрэглээний сүлжээнд 30 ДТГ-ыг шинээр холбоно.

Биелэлт: Төслийн 3-р үе шатыг хэрэгжүүлэх 1,011 тэрбум төгрөгийн зардал 2023 оны улсын төсөвт батлагдсан. Улмаар хилийн чанадад буй Монгол Улсын 10 ДТГ-ыг тусгай хэрэглээний сүлжээнд холбох шийдлийн дагуу тоног төхөөрөмжийн тооцоо, судалгааг боловсруулж, худалдан авалтын гэрээг байгуулж, холбогдох тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн. Тусгай хэрэглээний сүлжээнд холбогдох дараах 10 ДТГ байна. Үүнд:

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хот
2. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Нью Дели хот
3. Бүгд Найрамдах Франц улсын Парис хот
4. Бельгийн Хаант Улсын Брюссель хот
5. Кувейт Улсын Эль-Кувейт хот
6. АНУ-ын Нью Йорк хот
7. ИБУИНХУ-ын Лондон хот
8. ОХУ-ын Улаан-Үд хот
9. ОХУ-ын Эрхүү хот
10. Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул

4.1.7.Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

4.1.7.1.Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацын кластер байгуулна.

Биелэлт: Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацийн кластер байгуулах ажлын хүрээнд ХХМТГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/44 тоот тушаалаар байгуулсан ХХЗХ, Үндэсний дата төв УТҮГ, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК, Монгол шуудан ХК, Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ зэрэг 7 байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэр, Морингийн даваанд төлөвлөгдөж буй “Залуус-1” орон сууцны хорооллыг харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын кластер хэлбэрээр хөгжүүлэх төлөвлөлтөд салбарын онцлог болон хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, саналуудаа нэгтгэж БХБЯ-нд хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 59 дүгээр тушаалаар байгуулагдсан Залуус-1 цогцолбор хороолол барихад шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх хувилбарыг судлах ажлын хэсгийн хүрээнд уг хорооллыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын кластер хэлбэрээр хөгжүүлэхээр төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Залуус-1 хороололд харилцаа холбооны суурь сүлжээ, дэд бүтцийг бий болгохоор 4, 6 яндантай худаг сувагчлал байгуулах төсөл боловсруулж, холбогдох тооцоо судалгааг гаргасан.

Буянт-Ухаа нисэх буудлын байрны тодорхой хэсгийг түшиглэн, Мэдээлэл, технологийн үндэсний паркийн үйл ажиллагааг өргөжүүлж, Монголын цахиурын хөндий, мэдээлэл технологийн чөлөөт бүс бий болгох зорилготой “Буянт-Ухаа инновацийн төв”-ийг байгуулах саналыг боловсруулж, Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд оруулсан.

4.1.7.2.МХХТ-ийн хэрэглээний өрх болон хувь хүний судалгааг хийнэ.

Биелэлт: “Хувь хүн болон өрхийн мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээний судалгаа” хийх ажлын хэсгийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2021 оны А63/А41 тоот тушаалаар байгуулж, судалгааны үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх зааврыг Олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөмжийн дагуу боловсруулсан. Мөн судалгааны дүгнэлт, мэдээлэл боловсруулалтыг 2022 оны нэгдүгээр улиралд багтаан боловсруулан 400 ширхэг судалгааны ботийг хэвлүүлэн салбарын байгууллага болон олон нийтэд тараасан. “Хувь хүн болон өрхийн мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээний судалгаа”-г Үндэсний статистикийн хороотой хамтран Улсын хэмжээнд 13,000 өрхийг хамруулан хийсэн. Тус судалгааны үр дүнг цахим хэлбэрээр www.1212.mn, www.mddc.gov.mn цахим хуудаст нээлттэйгээр байршуулж, олон нийтэд хүргэсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төлөвлөгөөний дагуу дараагийн судалгааг 2024 онд хийнэ.

4.1.7.3.Инновац, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний институтийг бэхжүүлнэ.

Биелэлт: Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд Судалгаа, шинжилгээний хэлтэс, “И-Монгол академи” УТҮГ-ын бүтцэд Мэдээллийн технологийн инновац, судалгаа, сургалтын хэлтсийг тус тус байгуулав. Монгол Улсын дижитал эдийн засгийг хөгжүүлэх суурь боломжийг бүрдүүлэх чиглэлээр бодлогын судалгаа хийсэн. Цахим шилжилт, дижитал эдийн засгийг ХХМТ-ийн дэд бүтцээр дэмжих, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй баг, суурин газрын судалгаа, хөдөлгөөнт холбооны 2 болон 3 дахь үе (2G, 3G)-ийн нэвтрэлтийн өнөөгийн байдлын судалгаа, өргөн нэвтрүүлгийн талаарх бодлогын судалгааг БНСУ-ын судалгаа, хөгжлийн байгууллага KISDI-тэй хамтран хийж байна. Ухаалаг хот

концепц, ОУЦХБ болон Европын холбооны Хотын зөвлөлөөс гаргасан Ухаалаг хот болсныг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг орчуулж, “Цахим аймаг” зөвлөмжид тусгасан.

Оюуны өмч, зохиогчийн эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төв (ITT LDDC)-тэй хамтран “Оюуны өмч, зохиогчийн эрх эдийн засгийн эргэлтэд оруулах, шинэ бүтээлийг хамгаалах, үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх, урамшуулах системийг бий болгох” судалгаа, цахим-худалдаа, цахим арилжаанд Монгол Улсын бэлэн байдлын судалгааг тус тус хийсэн. Мөн хиймэл оюун ухааны талаар баримтлах төрийн бодлого, хууль эрх зүйн орчны талаар судалгаа хийгдсэн.

Түүнчлэн Монгол Улсад Үндэсний рүүмингийн үйлчилгээг нэвтрүүлэх боломж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх эрэлт хэрэгцээний судалгаа, шуудангийн салбарын хүний нөөцийн судалгааг хийж байна. И-бизнес, цахим эдийн засгийг хөгжүүлэх ажлын хүрээнд “Квант технологи”-ийн хэрэгцээ шаардлага, түүний эдийн засагт үзүүлэх нөлөө, олон улсын туршлага ба өнөөгийн байдлыг судлах ажлын хамрах хүрээг тодорхойлох ажлыг эхлүүлээд байна.

4.1.7.4. Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, контент боловсруулж, түгээнэ.

Биелэлт: Мэдээлэл технологийн ур чадвар шаардлагатай байгаа алслагдмал бүсэд оршин суугаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 8 сэдвийн 28 агуулгаар сургалт зохион байгуулсан. Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Архангай аймагт 10 удаагийн сургалтад 1,248 иргэн хамрагдсан. Мэдээлэл технологийн ур чадварыг дээшлүүлэх туршилтын сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 16-аас 23-ны өдрүүдэд Өмнөговь, Дундговь, Төв, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Архангай аймгийн нийт 622 албан хаагчдад цахим хэлбэрээр, “Төрийн албан хаагчдын мэдээллийн технологи ашиглах чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр”-ийн дагуу Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд аймгийн нийт 608 төрийн албан хаагчийг хамруулан танхимаар зохион байгуулсан.

Эрүүл мэндийн яам, Аюулгүй байдал судлалын хүрээлэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн 64 мэргэжилтэнд кибер аюулгүй байдлын чиглэлээр сургалтыг 2023 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. Төрийн албаны мэдээлэл технологийн албан хаагчдыг мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэдлэг, ур чадвар олгох зорилгоор цахим сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 13-аас 22-ны хооронд 21 аймаг, 8 дүүргийн төрийн байгууллагын 706 албан хаагчийг хамруулан нийт 6 агуулгаар онол практикийг хослуулан 12 цагийн багц сургалтыг орсон бөгөөд сургалтаар цахим хөгжлийн багц хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл болон төрийн мэдээлэл солилцох, өгөгдлийг хамтран ашиглах, өгөгдлийн баазад хандах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, чадвартай болсон. “Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэд болон ахмад настай иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт”-ын төлөвлөгөө батлан “И-Монгол академи” УТҮГ-ын Цахим ур чадвар хөгжүүлэлтийн албаны сургагч багш нартай хамтран Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх 14 цагийн сургалтад 35 иргэн, ахмад настай иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 105 иргэдийг хамруулав. Нийт 4,618 иргэнийг сургалтад хамруулсан байна.

4.1.7.5. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд ур чадвар олгох суурь сургалтуудыг зохион байгуулна.

Биелэлт: Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 2022 онд нийт 19,889 иргэнийг хамруулсан. 2023 онд 114 удаагийн сургалтад 5,402 иргэнийг хамрууллаа. Сургалтыг Цахим хөгжлийн багц хууль, тоон гарын үсэг, түүний хэрэглээ, цахим иргэн,

мэдээлэл өгөгдөлтэй ажиллах ур чадвар, мэдээллийн аюулгүй байдал, ухаалаг утасны хэрэглээ, төрийн нэгдсэн систем E-Mongolia аппликейшний хэрэглээ, мэргэжил сонголт гэсэн агуулгын хүрээнд зохион байгуулсан.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр И-Монгол академийн Цахим ур чадварын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэний цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг мэдээллийн аюулгүй байдал, асуудал шийдвэрлэх ур чадвар, ухаалаг утасны хэрэглээ зэрэг агуулгын хүрээнд сургалтад харааны бэрхшээлтэй 86, хэл, яриа, сонсголын бэрхшээлтэй 25, ахмад настай болон тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй 77 иргэн, харааны бэрхшээлтэй болон алслагдсан хорооны 115 сурагч хамрагдсан.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, И-Монгол академи УТҮГ хамтран 2022 онд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд харааны бэрхшээлтэй 5 иргэний мэдээллийн технологийн ур чадварыг сайжруулах сургалтыг 2023 онд зохион байгуулсан. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Насан туршийн боловсролын төв, Ерөнхий боловсролын сургуулийн болон бусад байгууллагуудын 1790 иргэн, 2,629 төрийн албан хаагчийг хамрууллаа.

“Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл болон орон нутгийн төрийн албан хаагчдад “Цахим ур чадвар олгох сургалт”-ыг 2023 оны 8-10 дугаар сард, номын санч, нийгмийн ажилтнуудыг цахим ур чадварын сургагч багшаар бэлтгэх сургалтыг 10 дугаар сард, цахим ур чадвар олгох сургалтыг 11 дүгээр сард тус тус зохион байгуулж, 2,711 иргэн, 250 албан хаагч хамрагдсан. 2023 онд нийт 13,090 иргэн сургалтад хамрагдсан байна.

4.1.7.6. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан албан хаагчдад мэргэжлийн ур чадвар олгох мэргэшүүлсэн сургалтуудыг зохион байгуулна.

Биелэлт: ХХМТ-ын салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд нийт 1194 инженер, техникийн ажилтныг холбогдох чиглэлийн сургалтуудад хамруулсан. Тухайлбал, мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох сургалтад нийт 120 инженер, техникийн ажилтан хамрагдсанаас 23 хүн зөвлөх инженерийн, 39 хүн мэргэшсэн инженерийн зэрэг авч, 58 хүний мэргэшсэн, зөвлөх инженерийн зэргийн сургалтыг хийсэн. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын жендерийн тэгш бус байдлыг бууруулах, мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлийн мэргэжилтэй эмэгтэй инженерүүдийн тоог нэмэгдүүлэх, хөдөө, орон нутагт амьдарч байгаа охид, эмэгтэйчүүдийн мэдээллийн технологийн ур чадварыг сайжруулах, чадавхжуулах зорилгоор “Код бичих охидын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, 21 аймаг, 9 дүүргээс 30 охидыг шалгаруулан, код бичих 2 сарын сургалтад хамруулсан.

Дамжуулах байгууламж, шилэн кабелийн угсралт суурилуулалтын чиглэлээр: а) “ICNC&Huawei Workshop” онлайн сургалтад 390 инженер, техникийн ажилтан, б) Зай тэжээл, цахилгаан хангамжийн сургалтад 159 инженер, техникийн ажилтан, в) “Холбооны сүүлийн үеийн шинэ техник технологи” сургалтад 87 инженер, техникийн ажилтан, г) “NetEMS орчны хяналтын системийн ашиглалт, хяналтыг сайжруулах нь” сургалтад 47 инженер, техникийн ажилтан, д) ZTE ХХК-аас зохион байгуулсан “Шинэ техник технологи, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт” сургалтад 320 инженер, техникийн ажилтан, кабельчны мэргэжил олгох сургалтад 18 ажилтныг тус тус хамруулсан байна.

АНУ-ын Карнеги Меллоны Их Сургуультай хамтран “Компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх баг (CSIRT) байгуулах нь” сэдэвт сургалтыг, АНУ-ын Төрийн Департамент болон тус улсын “MITRE” байгууллагатай хамтран “Үндэсний кибер аюулгүй байдлын боловсон хүчний хөгжил” сэдэвт сургалтыг зохион байгуулж, төрийн болон хувийн

хэвшлийн ажилтан, албан хаагчдыг хамруулж, кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг хөгжүүлэх нөхцөл боломжийн талаар туршлага солилцсон.

ЦХХХЯ-аас 2023 онд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан, албан хаагчдад мэргэжлийн ур чадвар олгох 16 удаагийн сургалтыг зохион байгуулж, 852 албан хаагчийг хамруулсан. И-Монгол академи УТҮГ-аас 2023 оны 11 дүгээр сарын байдлаар мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын нийт 808 ажилтан, албан хаагчийг хамруулж, нийт 1,660 албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

4.1.7.7. Бүх шатны төрийн байгууллагын албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх онлайн сургалтын платформ хөгжүүлж, сургалтын контент боловсруулж, сургалт зохион байгуулна.

Биелэлт: “Төрийн албан хаагчдын онлайн сургалтын платформ”-ын ажлын даалгавар, техникийн шаардлагыг боловсруулж, Дэлхийн банкны “Ухаалаг засаг” төслийн ТУХ-оор хэлэлцүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн.

Тэргүүн дэд даргын тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо тендер зохион байгуулалт, сонгон шалгаруулалтыг хийж “Go Smart” ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулан ажилласан. Төслийг амжилттай хэрэгжүүлж, платформыг (www.surgalt.gov.mn) нэвтрүүлсэн бөгөөд сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Системийн ажиллагааг шалгаж Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтын “Харилцааны ур чадвар” хичээл, ЗГХЭГ-ын ажилтнуудад зориулсан “Microsoft 365 программын хэрэглээ” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулж, шалгалт авч, оролцогчдод цахим гэрчилгээ олгосон. Хуульд заасан чиг үүргийн дагуу Удирдлагын академид платформ хүлээлгэн өгөх тухай ХЭГ/2772 тоот албан бичгийг хүргүүлж, системийг Удирдлагын академид хүлээлгэн өгсөн. Уг системийг ашиглан нийт 19 багц сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 3,884 албан хаагчийг сургасан бөгөөд 1,594 хэрэглэгчээс цахим шалгалт, 552 хэрэглэгчээс бие даалт, 1,540 судалгааг авсан байна.

4.1.8. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.

4.1.8.1. Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын шийдвэрийн цахим системийн ажлын даалгавар боловсруулах хуулийн болон мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдөр “Ухаалаг засаг” төслийн хүрээнд байгуулж, төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан.

Засгийн газрын шийдвэрийн цахим системийн ажлын даалгаврыг боловсруулсан. 2022-2027 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Ухаалаг Засаг-2” төслийн Санхүүгийн хэлэлцээрт албан ёсоор тусгаж төсөл хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлсон. Систем хөгжүүлж, нэвтрүүлэх санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны улсын төсөв болон “Ухаалаг засаг-2” төслийн эх үүсвэрээс хийгдэх боломжтой нөхцөлийг бүрдүүлсэн.

4.1.8.2. Засгийн газрын цахим архивын систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.

Биелэлт: Архивын ерөнхий газрын ашигладаг үндсэн системийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, техникийн шаардлагыг судалж, ажиллагааны тест хийсэн. Ижил төстэй бусад системүүдийн харьцуулсан судалгааг хийсэн.

2022-2027 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Ухаалаг Засаг-2” төслийн Санхүүгийн хэлэлцээрт албан ёсоор тусгаж төсөл хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлсон. 1956-1990 оны Засгийн газар, Сайд нарын Зөвлөлийн шийдвэр 233 боть, 53,065 хуудас баримт; 1991-2021 оны Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж 202 боть, 44,920 хуудас, нийт 425 боть, 97,985 хуудас баримтад; 2012-2021 оны Засгийн газрын хуралдааны 1,406 боть 316,824 хуудас баримтад тус тус нягтлан шалгалт хийж, цахим хувь үйлдэж, цахим сан үүсгэсэн болно. 2009-2021 он хүртэлх Тэргүүн шадар сайд, Шадар сайдын тушаал 37 боть 7,675 хуудас, “ЗГ-1” албан бичгийн 57 боть 12,801 хуудас, “ЗГ-2” албан бичгийн 115 боть 25,370 хуудас, “Х” албан бичгийн 124 боть 28,988 хуудас, гадаад албан бичгийн 9 боть 924 хуудас, нийт 1,121 боть 257,900 хуудас баримтад нягтлан шалгалт хийж, бүртгэлтэй нь тулган, цахим хувь үйлдэж, цахим сан үүсгэсэн. Цахим санд оруулсан баримтын эрэлт хайлтыг хялбар, боловсронгуй болгох программ хангамжийг хөгжүүлэх, архивын баримтын ашиглалтын үйл ажиллагаанд цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

4.1.8.3.Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн шийдвэр гаргалтад иргэдээс санал авах цахим хэлэлцүүлгийн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.

Биелэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд иргэдийн санал асуулгыг төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д нэгтгэж, гар утасны аппликейшн, веб портал, оператор ажилтнаар дамжуулан нийслэл болон орон нутгийн иргэдээс саналыг авч, төрийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах боломжийг бүрдүүлсэн. Систем хөгжүүлж, нэвтрүүлэх санхүүжилтийг “Ухаалаг засаг-2” төслийн эх үүсвэрээс хийгдэх боломжтой нөхцөлийг бүрдүүлсэн.

4.1.8.4.Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.

Биелэлт: 2022-2027 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Ухаалаг засаг-2” төслийн санхүүгийн хэлэлцээрт албан ёсоор тусгаж төсөл хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлсон.

4.1.8.5.Зөвшөөрлийн нэгдсэн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.

Биелэлт: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг дагаж Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 201 дүгээр тогтоолоор "Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам", 352 дугаар тогтоолоор "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам", 200 дугаар тогтоолоор "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглах нөхцөл, журам, нээлттэй өгөгдөлд тавигдах шаардлага болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам", 202 дугаар тогтоолоор "Нээлттэй өгөгдлийн жагсаалтад тусгагдаагүй нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал"-ыг тус тус боловсруулан Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоол “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”, 200 дугаар тогтоол “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын хүрээнд нийт 54 байгууллагын 31 бүлэг 455 нээлттэй өгөгдлийг байршуулаад байна.

4.1.8.6.Нээлттэй өгөгдлийн порталыг өргөтгөнө.

Биелэлт: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг дагаж Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 201 дүгээр тогтоолоор "Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам", 352 дугаар тогтоолоор "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам", 200 дугаар тогтоолоор "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглах нөхцөл, журам, нээлттэй өгөгдөлд тавигдах шаардлага болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам", 202 дугаар тогтоолоор "Нээлттэй өгөгдлийн жагсаалтад тусгагдаагүй нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал"-ыг тус тус боловсруулан Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоол "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоол "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын хүрээнд нийт 54 байгууллагын 31 бүлэг 455 нээлттэй өгөгдлийг байршуулаад байна.

4.1.9. Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

4.1.9.1. Үндэсний контент үйлдвэрлэлийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулна.

Биелэлт: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2021 онд "Үндэсний контент үйлдвэрлэлийн төв байгуулах" төслийн танилцуулга, урьдчилсан тооцооллыг боловсруулж бэлтгэсэн.

4.1.9.2. Төвийн бүсэд тоон контент үйлдвэрлэлийн инкубатор төв байгуулна.

Биелэлт: "Мэдээлэл технологийн үндэсний парк" ААТҮҮГ-ыг түшиглэн Мэдээлэл, хандалтын төвийг байгуулахаар шийдвэрлэж, БНСУ-ын талаас засвар үйлчилгээний ажил, холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлэн "Мэдээлэл хандалтын төв"-ийг байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийсэн. Уг төвд цахим ур чадвар чадамжийг дээшлүүлэх сургалтын 2 танхим, контент хөгжүүлэлтийн 2 танхим, конференцын 1 танхим, интернэт үйлчилгээний 1 танхим, нийт 6 танхимыг хүлээн авах хэсгийн хамт тохижуулж, тоноглогсон. Энэхүү төвийн контент хөгжүүлэлтийн танхимд үндэсний контент хөгжүүлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах, бүтээсэн контентыг олон нийтэд сурталчлах зэрэг үйл ажиллагааг явуулахаас гадна олон нийт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт хийх зориулалттай. Бүсчилсэн контент үйлдвэрлэлийн төв байгуулах төсөв тусгагдаагүй тул 4 төв байгуулах боломжгүй байна.

4.1.9.3. МХХТ-ийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

Биелэлт: Гарааны бизнесийг дэмжих зорилгоор Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй хамтран Стар Венчэр хөтөлбөрийн нээлтийг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Уг хөтөлбөр нь мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсад таниулах, ногоон стартап, инновацын төслүүд болон гарааны бизнесийн хурдасгуур компаниудыг дэмжих зорилготой юм.

Бүгд найрамдах Казакстан Улсын "Астана Хаб" технологийн парк болон Мэдээлэл технологийн үндэсний парктэй хамтран ажиллах санамж бичгийг 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, сайд Н.Учрал, БНКУ-ын Цахим хөгжил, инновац, агаар-сансрын

үйлдвэрлэлийн сайд Багдат Мусин, технологийн салбарын хөрөнгө оруулагч, Freedom Finance компанийн захирал Тимур Турлов нартай уулзаж, Монгол Улсын мэдээллийн технологийн салбарт хөрөнгө оруулах боломжийн талаар ярилцаж, мэдээллийн технологийн гарааны компаниудыг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон.

Японы Токио, Фүкүока хотод Монголын гарааны бизнес эрхлэгчдийн pitch арга хэмжээг зохион байгуулсан. Япон Улсын Олон улсын байгууллага (Жайка)-тай Мэдээлэл, технологийн үндэсний парк хамтран ажиллах санамж бичгийг 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, “Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжих талаар мэдээлэл цуглуулах, баталгаажуулах судалгаа”-г хамтран 2023-2025 онд хэрэгжүүлэх, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэхэд чиглэсэн хоёр байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилготой.

4.1.9.4. Оюуны өмч, зохиогчийн эрх, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах систем хөгжүүлнэ.

Биелэлт: Оюуны өмчийн бүтээлийн хүсэлтийг хүлээн авах, хянах, бүртгэх, зохиогчийн эрхийг олгох тэдгээрийг бүртгэлийн мэдээллийн санд оруулах, цахим мэдээллийн системийг бий болгох чиглэлээр Оюуны өмчийн газраас www.ipom.gov.mn системийг ашиглалтад оруулсан. Ингэснээр иргэд, хуулийн этгээд оюуны өмчийн мэдээлэлтэй бүрэн танилцах, эзэмшигчтэй холбогдох, хөрөнгө оруулах, мэдээллээр хангах боломжийг бүрэн бүрдүүлээд байна.

Мэдүүлэг, мэдэгдэл, нэмэлт өөрчлөлтийн хүсэлт хүлээн авах, аж үйлдвэрийн өмчийн мэдүүлгийг цахимжуулах, бүрдлийн шүүлт хийх, мэдэгдэл хүргүүлэх; чанарын шүүлт хийх, патент, гэрчилгээ олгох, олон нийтэд мэдээлэх зорилгоор Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын систем (IPAS), патент олгогдсон шинэ бүтээл, патент олгогдсон ашигтай загвар; патент олгогдсон бүтээгдэхүүний загвар, мэдүүлсэн барааны тэмдэг, газар зүйн заалт; мэдүүлсэн олон улсын барааны тэмдгийн Аж үйлдвэрийн өмчийн хайлтын систем [/https://publish.ipom.mn/](https://publish.ipom.mn/), шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлгээ цахимаар мэдүүлэх Цахим мэдүүлгийн систем [/https://efiling.ipom.mn/](https://efiling.ipom.mn/)-ийг тус тус ашиглаж байна.

Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia)-д оюуны өмчийн бүтээлийн хүсэлтийг хүлээн авах холболтыг хийж, зохиогчийн эрхийн гэрчилгээ дахин авах, зохиогчийн эрхийн гэрчилгээний хуулбар авах, зохиогчийн эрхийн эрх шилжүүлэх хүсэлт гаргах үйлчилгээг нэмсэн.

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төв (ITT LDDC)-тэй хамтран “Оюуны өмч, зохиогчийн эрх эдийн засгийн эргэлтэд оруулах судалгаа шинжилгээний үр дүнд бий болсон оюуны өмч, шинэ бүтээлийг хамгаалах, үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг урамшуулах системийг бий болгох” чиглэлээр судалгаа хийсэн. Монгол Улсын зохиогчийн эрхийн тухай хуульд зохиогчийн эрхээр хамгаалдаг бүтээлд программ хангамж, өгөгдлийн сан хамаардаг бөгөөд одоогийн байдлаар зохиогчийн эрхээр хамгаалж буй нийт 14600 бүтээгдэхүүний 1310 нь программ хангамжаар, 5 нь өгөгдлийн сангаар бүртгэлтэй байна.

4.1.10. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

4.1.10.1.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

Биелэлт: Төрийн албаны цалингийн нэгдсэн систем /ТАЦНС/-ийг хөгжүүлж, улсын хэмжээнд нэвтрүүлэн Төрийн албаны зөвлөлийн “ХНУМТ” системээс ТАЦНС-д мэдээлэл дамжуулах үйл явцыг тогтвортой хангаж, шаардлагатай өөрчлөлт, сайжруулалтыг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна. Тус ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын 163 тоот тогтоолыг баталж, хэрэгжилтийг хангаснаар 2023 онд төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад 4,358 байгууллагын 190.0 мянга гаруй албан хаагчийн цалин хөлсийг тогтмол тооцоолж, Монголбанкны багцын гүйлгээний системээр албан хаагчийн нэрийн дансанд шууд шилжүүлж хэвшлээ.

ТАЦНС-ийг бүрэн нэвтрүүлснээр үндсэн болон гэрээт ажилтны орон тоо, үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, нөхөн олговор, тэтгэмж зэрэг шаардлагатай бүх мэдээллийг бодит цагийн горимд улсын хэмжээнд салбараар, байгууллага тус бүрээр шуурхай гаргаж, бүх шатны төсвийн захирагчид, харьяа салбарын байгууллагуудад ажиллаж байгаа нийт албан хаагчдын талаар үнэн зөв, бодит тоон мэдээлэлтэй болж, орон тоо, цалин хөлсний мэдээлэлд нарийвчилсан дүн шинжилгээ хийх боломж бүрдлээ.

Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба.

4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.

4.2.1.Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.

4.2.1.1.Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоол баталсан. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-д заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийг www.opendata.burtgel.gov.mn сайтад байршуулж, нээлттэй харах боломжийг бүрдүүлсэн, иргэд, олон нийтийн хяналт сайжирсан. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасны дагуу төсвийн орлого, түүний зарцуулалтыг байгууллагын цахим хуудсанд заасан хугацаанд байршуулсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байршуулсан мэдээллийг хуулийн хугацаа, үнэн, зөв байршуулсан эсэхэд сар бүр хяналт тавьж ажиллаж байна. “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжилтийг хангуулж, байгууллагын авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт /индекс/-ийг бууруулах, алба хаагчдын авлигын хор хөнөөл эрсдэлийн талаар болон хууль тогтоомж, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, баталгаажуулах цахим шалгалтыг 5265 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан.

4.2.2.Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.

4.2.2.1. Үндэсний хөгжлийн хүрээлэн-Засгийн газрын тинктанк байгуулах ТЭЗҮ, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын барилга барина.

Биелэлт: Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн бүтэц, дүрмийн төслийг боловсруулж, төсвийг 2023 оны улсын төсөвт тусгаж батлуулсан. Цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлтэй холбоотой шинэ барилга барихгүйгээр шийдвэрлэсэн тул Засгийн газраас Засгийн газрын XI байранд Эдийн засаг, хөгжлийн яамыг оруулах асуудалтай хамт тус хүрээлэнгийн барилгын асуудал шийдэгдсэн. Засгийн газрын 2023 оны 161 дүгээр тогтоолоор Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн орон тоо Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжиж ирсэн.

4.2.2.2. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийнэ.

Биелэлт: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон тэдгээрийн харьяа нэгжүүд, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Засгийн даргын Тамгын газрын хэмжээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Сангийн яам, Шинэ сэргэлтийн бодлогын "Хурдасгуур" төв, Сэлэнгэ аймаг Засаг дарга болон холбогдох агентлагийн төлөөлөлтэйгөөр байгуулан ажиллууллаа. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Шинэ сэргэлтийн бодлогын "Хурдасгуур" төвөөс байгуулагдсан хамтарсан ажлын дэд хэсгийн 21 ажилтан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, тэдгээрийн харьяа орон нутгийн 16 газар, хэлтэс, нэгжид 2 сарын хугацаанд ажиллалаа. Түүнчлэн аймгуудад бүсчилсэн хэлбэрээр хэлэлцүүлэг болон процессын шинжилгээний ажлыг нийт 13 аймгийн 360 гаруй албан хаагчийг оролцуулан хийлээ. Эдгээр судалгаа, шинжилгээнд үндэслэн процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлэх саналыг гаргасан. Тухайлбал, нийт 211 төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дунджаар нэг үйлчилгээ 20 үйл явцыг дамждаг байсныг тус бүр 6-10 болгон цөөрүүлэх, үйлчилгээний хамтарсан төвийн зохион байгуулалтаар нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн үйлчилгээг үзүүлэх, яамны болон агентлагийн зохион байгуулалтын бүтцийг давхардалгүй, үр нөлөөтэй, үр ашигтай хэлбэрээр зохион байгуулах, нийслэлд салбар бүрээр Засгийн газрын агентлаг, нийслэлийн агентлаг, дүүргийн газар, хэлтэс давхардсан бүтэцтэйгээр үүрэг гүйцэтгэж байгааг өөрчилж, давхардлыг арилгах, нийт 211 үйлчилгээнд иргэний бүрдүүлдэг баримт бичгийн 70 хувь нь төрд байгаа буюу "Хур" системээс авах боломжтой мэдээлэл байгаа тул холбогдох 53 баримт бичгийг иргэдээс шаарддаггүй болох зэрэг болон бусад асуудлыг тусгасан болно.

4.2.2.3. Төрийн байгууллагад "цалингийн нэгдсэн систем"-ийг нэвтрүүлнэ.

Биелэлт: Төрийн албаны цалингийн нэгдсэн систем /ТАЦНС/-ийг төсвийн байгууллагад нэвтрүүлэх тухай Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 163 тоот тогтоолыг хэрэгжүүлэн, ТАЗ-ийн ХННС-ээс төсвийн байгууллагууд, төрийн албан хаагчдын мэдээллийг веб сервис холболтоор хүлээн авч, цалин хөлсийг тооцоолж байна. ТАЦНС-ийн хэвийн үйл ажиллагааг хангаж, төлбөр тооцоог гүйцэтгэх, системийн хэрэглэгчдэд олон сувгаар туслалцаа дэмжлэг үзүүлэх, хэрэглэгчийн бүртгэлийг хөтлөх,

системийг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэх, хэрэглэгчийн чадавхыг сайжруулах ажлыг гүйцэтгэлээ.

Бүх шатны төсвийн 4320 байгууллага ТАЦНС-ээр цалингаа тооцоолж, ЭБС системээр баталгаажуулан Монгол банкны багцын гүйлгээний системээр цалин хөлсийг цахимаар олгож хэвшсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 35 дугаар захирамжийн хүрээнд Төрийн албаны үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн бүтээмжийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих систем”-ийг хөгжүүлж, холбогдох бусад системтэй уялдуулан нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллалаа.

4.2.3. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд зөвшөөрлийн цахим бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрөөс олгох зөвшөөрлийн тоог цөөлж, олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.

4.2.3.1. Зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүлнэ.

Биелэлт: “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам”-ыг Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан. Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу нийт 249 тусгай зөвшөөрлийг цахимжуулахаас E-Mongolia системд 6, Licence.mn 16, өөрийн цахим системтэй 141, цахим хэлбэрт шилжүүлэх боломжгүй 18, уламжлалт хэлбэрээр олгож байгаа 68 тусгай зөвшөөрөл тус тус байгаагаас 66 тусгай зөвшөөрлийн бодлогын даалгаврыг боловсруулан ГТМТТ-д өгсөн. Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцсэн асуудлын хүрээнд "Тусгай зөвшөөрлийг олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг тухай бүр зөвшөөрлийн нэгдсэн санд тусгах, шаардлагатай тохиолдолд төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан зөвшөөрлийн нэгдсэн санд нэгтгэх талаар холбогдох арга хэмжээг эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд даалгасан.

4.2.4. Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.

4.2.4.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана.

Биелэлт: Монгол улсын Засгийн газрын 2021 оны 46 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалт "... Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг Төрийн өмчийн корпорац болгож өөрчлөн зохион байгуулах асуудлыг судалж, холбогдох саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах..." гэж заасныг үндэслэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газрын засаглал, ашигт ажиллагаа, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, өгөөжийг нэмэгдүүлэх, нэгдмэл удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох саналыг боловсруулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагын чадавх, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлыг боловсруулах хүрээнд төрийн өмчийн удирдлага, менежмент болон гадаадын улс орнуудын төрийн өмчийн талаарх бодлого, баримталж буй чиглэл, компанийн

засаглал, санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх OECD, PWC, ADB (АХБ), World Bank, IDB, IMF (ОУВС), EBRD зэрэг олон улсын байгууллагын туршлага, судалгааны үр дүн, тайланг судалж, холбогдох санал, загварыг боловсруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газраас, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус тус бусад холбогдох хуулийн төслийн хамт 2022 онд УИХ-д өргөн мэдүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангах зохицуулалтыг тусгасан байна. Хууль санаачлагчаас хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал их, Хууль зүй, дотоод хэргийн сайд хуулийн төсөл шинээр өргөн барих болсонтой холбогдуулан хуулийн төслийг эргүүлэн татсан.

Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ХААГ-ыг шинээр байгуулж, ОНӨГ-ын чиг үүргээс холбогдох чиг үүргийг салгасан. Үүнтэй холбоотойгоор ОНӨГ-ын бүтцийн жишиг загвар, албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт хамаарах чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх хуулийн шаардлагын талаар зөвлөмж боловсруулж, ТӨБЗГ-ын 2023 оны А-1/1819 дугаар албан бичгээр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн.

4.2.4.2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.

Биелэлт: Төрийн өмчийн хяналт шалгалтын 2021 онд төлөвлөгөөнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 27 хуулийн этгээд (төрийн өмчит компани, үйлдвэрийн газар)-д баримтын иж бүрэн хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна. Үүнээс төлөвлөгөөт 11, төлөвлөгөөт бус 6, гүйцэтгэлийн 10 хяналт шалгалт, нийт 27 хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.

Төрийн өмчит 11 хуулийн этгээдэд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаас 10 шалгалтын дүн, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулсан, 1 шалгалтын тайланг баталгаажуулахаар бэлтгэж байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтын тайлангийн баталгаажсан дүнгээр 12.490.74 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд зөрчил арилгах асуудалтай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх нийт 90 арга хэмжээ, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах 86 арга хэмжээ бүхий үүрэг даалгаврыг эрх бүхий албан хаагчдад хүргүүлэн, 69 ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.

Засгийн газар, Сангийн сайд, 2020 оны 48-р тэмдэглэл, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга, зарим салбарын сайд, ТӨБЗГ-ын даргын удирдамж, үүрэг даалгаврын дагуу нийт төрийн өмчит 6 хуулийн этгээдэд төлөвлөгөөт бус баримтын шалгалт хийж, дүн, тайланг тухайн ажлын хэсгийн нэгдсэн тайланд нэгтгүүлэн, холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан. Төлөвлөгөөт бус баримтын шалгалтад хамрагдсан төрийн өмчит 6 хуулийн этгээдэд нийт дүнгээр 290.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоол шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн хяналт шалгалтад төрийн өмчит 10 хуулийн этгээдийг хамруулав. Шалгалтын үр дүнгээр зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч байгаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал сайжирсан бөгөөд 2020-2021 онд улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн төрийн өмчийн түрээсийн орлого болох 189.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх хугацаатай үүрэг өгч, хэрэгжилтийг бүрэн хангуулсан.

ТӨБЗГ-аас 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит 6 үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 18 компанид баримтын, төрийн өмчит төсөвт 10 байгууллагад системийн, нийт 34 хуулийн этгээдэд төлөвлөгөөт (төлөвлөгөөнд өөрчлөлт орсон) хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 4, гүйцэтгэлийн 10 хяналт шалгалтын ажлыг төрийн өмчит хуулийн этгээдэд гүйцэтгэсэн бөгөөд нийт дүнгээр 48 хяналт шалгалт хийв. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 24 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалтыг хийж, 14 хуулийн этгээдийн дүн тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан. Нийт дүнгээр 11,677.58 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын тогтоолоор баталгаажуулсан байна. "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК-д хийх хяналт шалгалт (3)-ыг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хийж байна.

4.2.4.3. Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Төрийн өмчийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2021 онд 11 төсөвт байгууллагад системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтад хяналт тавьсан байна. Хяналт шалгалтын баталгаажсан дүнгээр төсөвт 9 хуулийн этгээдэд нийт 1,268.12 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, баталгаажуулсан дүнгийн мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх нийт 53 арга хэмжээ, 55 зөвлөмжийг шалгалтад хамрагдсан байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, 35 албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

ТӨБЗГ-ын даргын 2022 оны 22-02/01 дугаартай шалгалтын удирдамжийн дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа 10 салбар нэгжийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.

Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022 онд хийгдсэн Гаалийн ерөнхий газар, түүний харьяа 10 салбар нэгжийн өмчийн захиран зарцуулалтад хийсэн системийн хяналт шалгалтын дүн, тайланд тусгагдсан 113.7 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын 2023 оны 96 дугаар тогтоолоор баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авсан байна. 2021 онд эхэлж, он дамжин 2 хуулийн этгээдэд хийгдсэн системийн хяналт шалгалтын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, илрүүлсэн 245.9 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг баталгаажуулан шийдвэр гаргасан.

Шалгалтын мөрөөр авах 16 арга хэмжээг дээрх тогтоолд тусгаж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан. Хяналт шалгалтын дүнгээр гарсан тогтоол, тайланг мэдээллийн нэгдсэн санд оруулж, баяжуулалт хийсэн.

ТӨБЗГ-ын 2023 онд хэрэгжүүлэх төрийн өмчийн хяналт шалгалтын төлөвлөгөө, газрын даргын баталсан удирдамжийн дагуу төрийн өмчит төсөвт 10 хуулийн этгээдэд хяналт шалгалтыг хэрэгжүүлэв. Тэдгээрээс 8 хяналт шалгалтын ажлын дүн, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, нийт дүнгээр 679,241.1 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг тогтоолоор баталгаажуулсан.

4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

4.2.5.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмыг шинэчилнэ.

Биелэлт: Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг 8 бүлэг, 62 зүйлтэйгээр шинэчлэн баталсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай аргачлал, загварыг шинэчлэн баталсан.

4.2.5.2.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн систем хөгжүүлнэ.

Биелэлт: Төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд БНСУ-ын КОИСА-тай хамтран төслийн ажлыг эхлүүлж, Солонгосын төслийн багтай ажлын даалгаврыг нарийвчлан тодорхойлсон. Төсөл 2025 онд дуусна.

4.2.5.3.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Биелэлт: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд батлагдсан ба уг хуулиар төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль болон “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-д нийцүүлэн төрийн байгууллагууд “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулж, Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг баталж мөрдөн ажиллаж байна.

Төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг жил бүр баталж, албан хаагчдад ёс зүйн чиглэлээр болон Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаар сургалт зохион байгуулахаар тусгасан.

Төрийн албаны зөвлөлөөс байгууллагуудын дэргэд ёс зүйн зөвлөлүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулсан “Ёс зүйн зөвлөлүүдийг чадавхжуулах нь сэдэвт” сургалтыг зохион байгуулж төрийн байгууллагын Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг хамруулж, арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хоёр дахь шатанд хэрэгжүүлж буй “Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төслийн хүрээнд тус төслийн багаас хэрэгжүүлж буй уулзалт хэлэлцүүлэгт яамд, холбогдох бусад байгууллага хамтран оролцож, “Мэдлэг өвлүүлэх менторшип” зэрэг хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

4.2.6.Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.

4.2.6.1.Төрийн албан хаагчдад зориулсан сургалт судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлж, сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчилж, онлайн хэлбэрт шилжүүлнэ.

Биелэлт: 2022 онд шинээр томилогдсон төрийн албан хаагчийн сургалтад 421, давтан сургалтад 546, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 967, тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1,141 албан хаагчийг хамруулсан.

Богино хугацааны сургалтад нийт 4,340 албан хаагчийг сургахаар төлөвлөж, 9,125 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хэрэгжилт, төлөв байдалд хийсэн шинжилгээ, төрийн захиргааны албан хаагчийн цалин, урамшууллын тогтолцооны өнөөгийн байдал, түүнийг оновчтой болгох нь, Нийгмийн халамжийн бодлогын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөө, Урт хугацааны хөгжлийн бодлого, “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийн судалгаа сэдэвт 4 судалгааны төслийг хэрэгжүүлсэн. Төрийн байгууллагын захиалгаар 10 зөвлөх үйлчилгээг зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 312 дугаар тогтоолоор Удирдлагын академийн богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчилсэн. Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу сургасан албан хаагчдын тоо 90,119 /үүнээс танхимаар 13,537, цахимаар 76,582/, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу сургасан албан хаагчдын тоо 6,257, нийтдээ Удирдлагын академи 96,376 төрийн албан хаагчдыг сургасан. Удирдлагын академийн нийт 6 судалгаа хийж, 2 зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн нийтдээ 36 судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулсан. Сургалтын хөтөлбөрийн агуулгын шинэчлэл 85 хувьтай байна.

4.2.6.2. Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим-сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулна.

Биелэлт: “Төрийн албаны онлайн сургалтын платформ”-ыг хийж, 6 онлайн хичээл, 3 live хичээл бэлтгэн байршуулсан. “Алсын Хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 42 богино хугацааны видео хичээл, 8 сургалтын контент бэлтгэж, цахим сургалтад 5000 албан хаагч хамрагдсан. Анги танхимыг иж бүрэн тохижуулж олон улсын хурал, семинар зохион байгуулах боломж бүхий орчин үеийн сургалт, хурлын тоног төхөөрөмж суурилуулсан. Сүлжээ сервер, хамгаалалтын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, утасгүй интернэтийн сүлжээнд хичээлийн анги, танхим бүрийг холбосон. Харилцаа холбооны бүрэн шинэчлэл хийж IP технологид суурилсан холбоо системийг 2022 оны 02 дугаар сараас ашиглаж эхэлсэн. Нийт багш, ажилтнуудын компьютер тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 100 хувь хийсэн. Техникийн хүчин чадлын дундаж үзүүлэлт i7 доошгүй CPU, лицензтэй Windows үйлдлийн систем бүхий зөөврийн компьютероор багш нар 100 хувь, суурин компьютероор ажилтнууд 100 хувь хангагдсан.

4.2.6.3. Олон улсын стандартын шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сурах бололцоог хангасан Сонсогчийн байр барина.

Биелэлт: Олон улсын стандартын шаардлагад нийцсэн албан хаагчдын сурах бололцоог хангасан Сонсогчийн байр нь сургалт, мэдээллийн төвийн байр, сонсогчийн дотуур байр, спорт заал бүхий 3 корпустай байхаар зураг, төсөв хийлгэсэн. Нийт талбайн хэмжээ 11,621.1 м.кв, төсөвт өртөг нь 18,827.2 сая төгрөг. “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай” хуульд “V.1.1.22 Удирдлагын академи кампус, өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/” нэртэйгээр 500.0 сая төгрөг, 2022 оны Төсвийн тухай хуульд 2,498.2 сая төгрөг санхүүжүүлэхээр тусгагдсан ба уг санхүүжилтээр хуучин барилгыг буулгах, цахилгааны дэд өртөөний барилгын ажил хийгдэж дууссан. Сонсогчийн байр барихад улсын

төсөвт нийт 5.7 тэрбум төсөвлөснөөс 5.6 тэрбум шилжигдэж зарцуулагдсан. Ус, дулаан дамжуулах төв бүрэн ашиглалтад орсон, А блокийн суурь цутгагдсан, Б блокийн гүйцэтгэл 70 хувьтай байна.

4.2.7. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендерийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.

4.2.7.1. Төрийн албан хаагчдын жендерийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Жендерийн үндэсний хорооны ажлын албаны 2021 онд 31 танхимын болон цахим сургалтыг төлөвлөн хэрэгжүүлж 2370 төрийн албан хаагчдын /үүнээс 953 эрэгтэй, 1417 эмэгтэй/ жендерийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. Мөн тус ажлын алба нь 105 сургалт, семинарыг 10017 /6040 эмэгтэй, 3977 эрэгтэй/ төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдад мэдээлэл хүргэж үүнээс 60 төрийн байгууллагын албан хүсэлтээр захиалгат сургалтыг тус тус зохион байгуулсан. Удирдах ажилтны жендерийн цахим модулийн сургалтад 2023 оны байдлаар төрийн албаны 650 удирдах ажилтныг шинээр хамруулж гэрчилгээг олгов.

4.2.7.2. Жендерийн сургагч багш бэлтгэнэ.

Биелэлт: Жендерийн үндэсний сургагч багшаар 21 аймгийн нийт 184 (76, 108), Улаанбаатар хот дахь нийслэл дүүрэг, агентлагийн 21 /3 эрэгтэй, 18 эмэгтэй/ сургагч багш тус тус бэлтгэгдэж 2023 оны байдлаар жендерийн үндэсний сургагч багш 368 бэлтгэгдээд байна.

4.2.7.3. Яамдын жендерийн салбар зөвлөлийн жендерийн бодлогын хэрэгжилтийг хангана.

Биелэлт: 2021-2024 Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 605. Салбарын жендерийн бодлогууд нь салбарын хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээг жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээгээр дэмжихийн зэрэгцээ ЖЭТБХ хууль, үндэсний болон салбарын дундын бодлого төлөвлөлтийг дэмжихэд чиглэгддэг. Хэрэгжих хугацаа дууссан болон эхний үе шат дууссан 6 салбарын бодлогын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн болон дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ болон тухайн жилийн хэрэгжилтийн байдалд тус тус үнэлгээ өгөв.

Дээрх хөндлөнгийн болон дотоод хяналт шинжилгээ үнэлгээний үр дүнгээс харахад нийт салбарт хэрэгжиж байгаа бодлогын хэрэгжилтийн дундаж нь 46.3 орчим хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Сангийн яам түүний харьяа гааль татварын байгууллагын жендерийн бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээний ажлыг эхлүүлсэн. Эрүүл мэнд, цахим хөгжил, харилцаа холбооны салбар, соёл, эрчим хүчний салбарын жендерийн бодлогын хэрэгжилтийн эхний үе шат дуусаагүй. ГХЯ, ЗТХЯ салбарын жендерийн бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээг 2024 онд эхний хагас жилд багтаан гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

4.2.7.4. Аймаг, нийслэл, дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

Биелэлт: 2017 оноос хойш 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн 31 дэд хөтөлбөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаад байна. 2023 оны 12 сарын байдлаар 31-ний байдлаар дэд хөтөлбөрийн хэрэгжилт дундаж 73.2 хувийн хэрэгжилттэй байна. Нийт 12 дэд хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Түүнчлэн ЖЭТБХ тухай хуульд заасан чиг үүрэг болон бодлого, үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтын хүрээнд 4 бүлэг бүхий дэд

шалгуур үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд үүнд Ховд, Дундговь, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Булган, Төв, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод, Дархан-уул, Завхан, Архангай, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Говьсүмбэр зэрэг (нийт 18) аймаг, нийслэлийн Сүхбаатар, Хан-уул, Багахангай, Сонгинохайрхан, Налайх дүүрэг тус тус 55 хувиас дээш хэрэгжилттэй байна. Үүнээс үзвэл орон нутгийн хэмжээнд ЖЭТБХ хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт 63.3 хувийн хэрэгжилттэй байна.

4.2.7.5. Жендерийн салбар зөвлөл, салбар хороодын гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлох, баталгаажуулна.

Биелэлт: Жендерийн үндэсний хорооны ажлын албанаас Жендерийн салбар, орон нутгийн хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор салбар зөвлөл, хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварыг 2021 оны 9 сард боловсруулсан. Цаашид салбар зөвлөл, хороо нь бүрэлдэхүүн, ажиллах үйл ажиллагааны журмаа энэхүү үлгэрчилсэн загварт нийцүүлэн боловсруулж, батлуулан мөрдөнө. Цаашид салбар хороо, зөвлөлийн гишүүдийн бодлого, хөтөлбөр, төлөвлөлтөд жендерийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгах, үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих идэвх оролцоо нэмэгдэх юм. Тус жендерийн салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварын дагуу салбар хорооныхоо бүрэлдэхүүн, ажиллах журмаа шинэчлэн батлуулсан 4 салбар хороо буюу 2 дүүрэг, 2 аймаг байна. 2022 онд Архангай, Говь-алтай, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар аймаг болон нийслэлийн Багахангай, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг нийт 9 салбар хороо харин 2023 оны 5 сарын 31-ний байдлаар Нийслэл, Баянзүрх, Дархан-уул, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий аймгийн жендерийн салбар хороод гишүүдийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, баталгаажуулж нийт 15 салбар хороо (9 аймаг, нийслэл, нийслэлийн 5 дүүрэг) баталгаажуулсан байна.

4.2.7.6. Барилга, хот байгуулалтын салбарт Жендерийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: БХБЯ нь жендерийн бодлогын зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд 3 зорилтын хүрээнд арга хэмжээ төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд тухайн жилийн зорилтын хэрэгжилт 2021 онд 80 хувь, 2022 онд 29 арга хэмжээг төлөвлөн 90 хувь буюу тус тус “Амжилттай” хэрэгжсэн байна. Хот суурин, барилга байгууламжийг жендерийн мэдрэмжтэй төлөвлөх, бүтээн байгуулах үндэсний чадавхыг сайжруулах бодлогын зорилгыг хангах хүрээнд үйл ажиллагааны 4 чиглэлд 14 арга хэмжээг 70-100 хувь хэрэгжүүлсэн.

Соёлын олон янз байдал, ялгаатай байдлыг хүндэтгэсэн ажлын орчин, байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт явуулах, удирдамж боловсруулан салбарын байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээ “Амжилтгүй” хэрэгжсэн байна. Тус зорилт, арга хэмжээний хүрээнд зарим сургалтууд хийгдсэн боловч салбарын жендерийн бодлогод тусгагдсан ажлын орчин, байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр тусгайлсан сургалтыг зохион байгуулах “удирдамж” боловсруулж салбарын төр, хувийн хэвшлийн байгууллагуудад хүргүүлэх ажил хийгдээгүй байна.

4.2.8. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.

4.2.8.1. Холбогдох хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Жендерийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг дэмжих чиглэлээр салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-г боловсруулан батлуулсан бөгөөд тус бодлогын баримт бичигт “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх” зорилго тусгасан болно. Энэ хүрээнд Хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Зорилго 1-д Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх талаар тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хорооны 2023 оны ээлжит хуралдаанаар 2023 оныг “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, Авлигын эсрэг эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих” жил болгон зарлаж шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах юм. Дээрх хүрээнд УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан шийдвэр гаргах түвшинд жендерийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд хууль эрх зүйн орчны шинэчлэлт, хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан олон талт нөлөөллийн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн №А/17 байгуулж, Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Ажлын хэсэг ажиллаж байна.

Хороо нь улс төрийн хүрээн дэх жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан олон талт нөлөөллийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.

4.2.9. Үндэсний стандартуудыг олон улсын түвшинд нийцүүлж шинэчилнэ.

4.2.9.1. Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг бууруулахад олон улсын стандартыг нутагшуулна.

Биелэлт: Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 6608 стандартыг нэг дороос үзэж танилцах, худалдан авах нөхцөлийг www.standard.gov.mn цахим сан бүрдүүлсэн. Хэмжил зүйн мэдээллийн сан, Баталгаажуулалтын мэдээллийн сангийн бүртгэлийн программыг нэвтрүүлсэн.

4.2.9.2. Бүтээн байгуулалт, мега төсөл болон экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүний стандартыг бий болгоно.

Биелэлт: 2023 оны байдлаар бүтээн байгуулалт, мега төсөл болон экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүний чиглэлээр нийт 28 стандарт батлагдсан.

4.2.10. Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.10.1. Төр, хувийн хэвшлийн яриа хэлэлцээ, зөвшилцлийн иж бүрэн тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг нь тогтворжуулна.

Биелэлт: Хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийг хийх зорилтын хүрээнд, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Хувийн хэвшлийн санхүүжилтийн зөвлөх сүлжээ (Private Financing Advisory Network)-тэй Харилцан ойлголцлын Санамж бичгийг байгуулсан. Төр хувийн хэвшлийн яриа хэлэлцээрийн хүрээнд

АБНЕУ, ХБНАБУ, ИБНПУ, БНБАУ, БНФУ, БНМУ, МНУ, БННУ, БНАЛАУ, РБНУ, Өмнөд Африк, БНПУ, ОХУ, ХБНУ-ын сайн туршлагын судалгаа, кэйс судалгаа болон өнөөгийн нөхцөл байдлын анализ /Төр-хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар хэрэгжсэн төслүүдийн ерөнхий судалгаа/, Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төсөл хөтөлбөрийн Монгол Улсад үзүүлэх үр өгөөж салбар хоорондын судалгаа, Төсөл хөгжүүлэх хурдасгуурын талаарх ойлголт, оролцогч талууд ба тэдний үүрэг, олон улсын шилдэг туршлагын талаарх судалгааг тус тус хийсэн. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл нь татан буугдсан ба тус зөвлөлийн дэргэд байгуулагдсан "Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо" мөн татан буугдаж, үйл ажиллагаа явуулаагүй болно.

4.2.10.2.Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, Барилгын материал үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, Барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох зэрэг төрийн эрхлэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх болон барилгын салбарын 3 талт хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангана.

Биелэлт: Барилгын салбарын ажилтан болон архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтний давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхтэй холбогдуулан Ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 87 дугаар тушаалаар байгуулж, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-аар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр гэрээг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр шинэчлэн байгууллаа.

Барилгын салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээрийн биелэлтийг дүгнэн, 2023-2025 оны гурван талт хамтын хэлэлцээрт Барилга, хот байгуулалтын яамыг төлөөлөн хэлэлцээ хийх ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний 85 дугаар тушаалаар байгуулж, Талууд хэлэлцээрт гарын үсэг зурсан болно.

4.2.11.Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.11.1.Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хуулийн 20 дугаар зүйлд Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх заалтуудыг тусгасан. Тухайлбал, [20.1] Эх орондоо буцаж ирсэн монгол ажилтан ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, хөдөлмөр эрхлэхэд хууль тогтоомжид заасны дагуу дэмжих, төсөл, хөтөлбөрт хамруулах дэмжлэг үзүүлнэ, Энэ хуулийн 20.1-д заасан үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, холбогдох Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөр батлуулж, хэрэгжилтийг хангана гэж тус тус заасан.

Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.

Мөн 2024 оноос эхлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын холбогдох яамтай хамтран “Хөгжлийн албан ёсны буцалтгүй тусламж /Official Development Assistance-ODA”/-аар 2024-2025 онд санхүүжин хэрэгжих “Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжих нь” төслийг боловсруулан хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Амар тайван, аюулгүй нийгэм.

4.3.Амар тайван, аюулгүй нийгэм. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

4.3.1.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглана. Хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хүний нөөцийг нэмэгдүүлнэ. Хилийн анги, салбаруудын автомашины парк шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.

4.3.1.1.Улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог хангаж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улс, Олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хил хамгаалалтад орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн ололтыг нэвтрүүлнэ.

Биелэлт: Хил хамгаалалтын удирдлагын төвийг шинээр барих төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон УИХ-ын зарим гишүүдэд танилцуулж, техник технологийн шинэчлэлийн судалгааг "IT zone" компанитай хамтран ажиллаж байна.

Монгол Улсаас БНЭУ-д суугаа ЭСЯ-тай хамтран ажиллаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг хийсэн.

Хилийн 0131, 0108 дугаар анги хил хамгаалалтын удирдлагын төвийг шинэчлэн байгуулж хил хамгаалалтад ашиглаж байна.

ОХУ-д зохион байгуулсан “Нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах” сургалтад 4 алба хаагчийг хамруулж, техник хэрэгслийг хүлээн авч, улсын хил хамгаалалтад туршиж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/237 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ШШҮХ зэрэг байгууллагуудын радио холбоог шинэчлэх ажлын хүрээнд АНУ-ын “Моторола солюшин” компанитай хамтран төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан.

“Алтан долгио” ХХК-тай “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан Америкийн Нэгдсэн Улсад үйлдвэрлэсэн “LEOPOLD VX MCKENZIE HD” 8x42 загварын 214 ширхэг дуран харааны хэрэгслийг 149,800,000 төгрөг, “HOWARD IMPACT” буудлагын чихэвч 30 ширхгийг 8,550,000 төгрөг, FENIX TK26R тактикийн гар чийдэн 30 ширхгийг 7,170,000 төгрөгөөр худалдан авч, хилийн цэргийн 24 ангид хангалтаар олгосон;

“Монголын практик буудлагын холбоо”-ноос сум галт хэрэглэл, “Алтан долгио” ХХК-аас 15 нэгж дулаан мэдрэгчтэй шөнийн дуран харааны хэрэгсэл худалдан авч, хилийн цэргийн ангиудыг хангасан;

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “ЦЕССНА-208В” загварын нисэх онгоц худалдан авч, улсын хил хамгаалалтад ашиглаж эхэлсэн;

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 68 дугаар тогтоолын дагуу хилийн “Зам-Үүд” боомт дахь чингэлэг тээврийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх 30 нэгж “FAW JIEFANG CA4250P66K24T1A” загварын автомашиныг худалдан авч, ашиглаж байна;

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 385 нэгж “Мустанг-150” загварын 2 дугуйт мотоцикл, “Kubota RTV-X900 WJP HSDL” загварын 4 дугуйт мотоциклийг худалдан авч, хилийн цэргийн 8 ангид хангасан;

ХХЕГ болон “Моннис” ХХК хооронд 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр автомашин санхүүгийн түрээсээр ашиглах тухай н/36-мм-а-2022-101 дугаартай гэрээ байгуулж, “Nissan patrol V61” маркийн 18 нэгж автомашиныг хүлээн авч хилийн цэргийн ангиудад хангасан;

“Хоббизоон” ХХК-тай 55 ширхэг дрон “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулж, “MAVIC 2 EA” загварын 48, “MATRICE 300” загварын 7 ширхэг нийт 55 ширхэг дронныг хүлээн авч, хилийн цэргийн 23 ангид хангасан;

“Цахим хил хамгаалалт”-ын программ хангамжийн хөгжүүлэлтийг “ICT” ХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

Хилийн цэргийн радио холбоог шинэчлэх чиглэлээр 2023 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй боловч ХЗДХЯ-ны харьяа “Төрийн болон хууль сахиулах байгууллагуудын радио холбоог шинэчлэх” төслийн хүрээнд АНУ-ын Засгийн газар болон “Моторола” компанитай төслийн I шат (Улаанбаатар хүрээний радио холбооны дэд бүтцийг байгуулах)-ны гэрээг 2023 оны 12 дугаар сард байгуулах, суурилуулалтын ажлыг 2024 оны II улиралд багтаан хэрэгжүүлэхээр тохиролцоонд хүрсэн;

Бүгд Найрамдах Франц Улсын “Атермес” компанитай хилийн боомтыг дохиолол, хяналт хамгаалалтын нэгдсэн системд шилжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичгийг ХХЕГ-ын даргын түвшинд байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд хилийн цэргийн 0245 дугаар ангийн “Хүдэн”-гийн заставын хариуцсан хэсэг болон “Боршоо” боомтод дохиолол, хяналтын систем суурилуулахад шаардлагатай техник хэрэгслийг худалдан авах асуудлыг шийдвэрлүүлж, “Бодь-электроникс” ХХК-тай мэдрэгч бүхий шилэн кабелийн дохиолол, хяналтын техник хэрэгслийг нийлүүлэх, угсралт, үйлчилгээний гэрээг байгуулж, 52 км шилэн кабелийг татан, “Боршоо” боомтод 12 ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, ажиллагаанд оруулсан. Ажлын явц 100 хувьтай байна (Гэрээний дүн 698.3 сая, урсгал санхүүжилтээр урьдчилгаа 300.0 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 300.0 сая төгрөгийн тус тус шилжүүлсэн);

Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн хариуцсан хэсэгт тоон радио релейн шугам байгуулах ажлын хүрээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авах гэрээг байгуулан, худалдан авалтыг хийж, 13 цэгт цамхгийг угсарч суурилуулж, 1 цэгт тоон радио релейн антенныг суурилуулан туршсан. “Мобиком” ХХК-аас 26 ширхэг антенныг хүлээн авч, тохиргоо хийн бэлтгэсэн. Тэжээлийн системийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

4.3.1.2. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилнэ.

Биелэлт: Хууль зүй, дотоод хэргийн яам, Хил хамгаалах ерөнхий газраас хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчлэх ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Тухайлбал, 2021 онд хилийн 0275

дугаар ангийн 0207 дугаар салбар /Ульхан/-д 11.2 км, 2022 онд хилийн цэргийн 0245, 0275 дугаар ангийн хариуцсан хэсэгт нийт 59 км спираль торон саад тус тус байгуулсан. Мөн хилийн цэргийн 0311 дүгээр ангийн хариуцсан хэсэгт 28 км газар мөр хянах зурвасыг сэргээж, 0130 дугаар ангийн хариуцсан хэсэгт 19.2 км нүхэн саад байгуулах ажлыг зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 онд байгуулсан “Хамтран ажиллах” 01-н/27 дугаар гэрээний дагуу хил дамнасан ой, тал хээрийн түймрийн эрсдэл ихтэй хилийн цэргийн 0245, 0277, 0243, 0287, 0275 дугаар ангиудын хариуцсан 187.6 км газарт түймрээс хамгаалах шороон зурвас шинээр байгуулах, 782.2 км газрын шороон зурвасыг сэргээх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Хилийн цэргийн ангиудын хилийн зөрчил гарч болзошгүй хэсэгт торон саад байгуулах газар орныг тодотгож, Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2023 оны н/03 дугаар тушаалаар “Хилийн инженерийн ажлын төлөвлөгөө”-г батлан мөрдөж байна.

2023 онд Дорнод аймаг дахь хилийн цэргийн 0275, 0132, 0306, 0198, Сүхбаатар аймаг дахь хилийн цэргийн 0184, 0146, Дорноговь аймаг дахь хилийн 0168 дугаар ангиудын хариуцсан хэсэгт торон саад байгуулах ажлыг эхлүүлэн нийт 449.1 км торон саад шинэчлэхээс 431.7 км хэсэгт торон саад байгуулаад байна.

Дорнод аймгийн Матад суманд үйл ажиллагаа эрхэлдэг “Петро Чайна, Дачин Тамсаг” ХХК-аас дахин ашиглагдахгүй болсон 70 мм диаметртэй, 9.7 м урт 3,886 ш ган трубаг ашиглан Увс аймаг дахь хилийн цэргийн 0245 дугаар ангийн хариуцсан хэсэгт 17.2 км, Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгон дахь хилийн цэргийн 0285 дугаар ангид 2,027 ширхэг трубаг ашиглан 14.9 км төмөр саадын байгууламж байгуулсан. Эдгээр ажлыг гүйцэтгэхэд 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,514.3 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл 100 хувь байна.

4.3.1.3. Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж, барилга, дэд бүтцийн 50-аас доошгүй хувийг шинэчилнэ.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2.3 тэрбум төгрөгөөр 2021 онд Дорнод аймгийн Чулуунхороот сум дахь хилийн 0275 дугаар ангийн “Эрээнцав” шалган нэвтрүүлэх салбарыг өргөтгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Хилийн 5 ангийн төвд 40 айлын орон сууц, 4 ангийн 11 заставд 48 айлын орон сууц, 3 ангийн 4 салбарт албаны нэгдсэн байрыг ашиглалтад оруулсан. Дорнод аймаг дахь хилийн 0198 дугаар ангийн 0188 дугаар салбар /Задгайт/-ын барилга байгууламж, Хэнтий аймаг дахь хилийн 0287 дугаар ангийн 0279 дүгээр салбар /Онон/-ын барилга байгууламж, Хилийн 0245 дугаар ангийн алба хаагчдын 4 айлын орон сууцны барилгад их засвар, тус ангийн соёлын төвийн барилгын дотор засал, сантехник, салхивч цахилгааны монтажны ажил, Хэнтий аймаг дахь хилийн 0287 дугаар анги, Ононгийн заставын 8 айлын орон сууцны барилгын дотор засал, цахилгааны монтажны ажлыг тус тус хийж, ашиглалтад оруулсан.

Хил хамгаалах ерөнхий газрын өргөтгөл, Монгол Улсын хил хамгаалалтын удирдлагын төв, Хилийн цэргийн төв архивын барилгын ажлыг 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлүүлж үндсэн каркас угсралт, гадна фасад, дотор ханын өрлөгийн ажил хийгдсэн, дотор инженерийн шугам сүлжээ, заслын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хилийн цэргийн анги шинээр байгуулах барилга угсралтын ажлын хүрээнд Дорнод аймгийн Чулуунхороот сум дахь хилийн цэргийн 0275 дугаар ангийн Эрээнцавын шалган нэвтрүүлэх салбарын өргөтгөл, 5 барилгын угсралтын ажил, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суман дахь хилийн цэргийн ангийн штаб, соёлын төв, спорт заалны барилгын угсралтын ажил хийгдэж, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд хүчжүүлсэн застав барих барилгын ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулсан.

Хилийн цэргийн 0166, 0130, 0131, 0198, 0214, 0245, 0277, 0286, 0287, 0275, 0285, 0306, 0311 дүгээр анги, 0267 дугаар тусгай салбарын барилга, Дорнод аймгийн Чулуунхороот сум дахь хилийн цэргийн 0132 дугаар ангийн “Авдар хараат” салбарын орон сууц, мөн аймгийн Матад сум дахь хилийн цэргийн 0306 дугаар ангийн “Бага хүрээ”-гийн салбарын их засвар, Хэнтий аймгийн Дадал сум дахь хилийн цэргийн 0287 дугаар ангийн “Цагаанчулуут”-ын салбарын барилгын их засварын ажлуудыг гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.

Дорнод аймгийн Баян-Уул сум дахь хилийн цэргийн 0275 дугаарын ангийн Өвөртогтор, Ямлахын салбарын хариуцсан хэсгүүдэд гүүр барьж, хил хамгаалалтад шилжүүлсэн. Дорноговь аймаг дахь хилийн 0129 дүгээр ангид 1 хянах цамхаг, Завхан аймаг дахь хилийн цэргийн 0277 дугаар ангийн Арцсуурь боомтод камерын цамхаг, Увс аймаг дахь хилийн цэргийн 0311 дүгээр ангийн “Цагаан гатлага” хилийн харуулд 1 хянах цамхаг, Дорноговь аймаг дахь хилийн цэргийн 0129 ангид 1 хянах цамхгийг тус тус шинээр байгуулж, Дорнод аймаг дахь хилийн цэргийн 0275, 0198 дугаар ангиудад тус бүр 1 хянах цамхаг, 0198 дугаар ангийн хариуцсан хэсэгт ган татлагат гүүр 1, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум дахь хилийн цэргийн 0146 дугаар ангийн Бичигтийн салбарт 1 хянах цамхаг, хилийн 0184 дүгээр ангийн 2 хянах цамхгийг тус тус засварлаж, хил хамгаалалтад ашиглаж эхэлсэн.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд нийт 102 нэгжийг шинэ автомашинаар хангаснаар хилийн цэргийн салбаруудын автопарк шинэчлэл 100 хувьд хүрч, автопарк шинэчлэл 7.4 хувиар нэмэгдсэн.

4.3.1.4.Хилийн салбаруудыг байнгын цахилгааны эх үүсвэрт холбох ажлыг үргэлжлүүлнэ.

Биелэлт: Хилийн салбаруудыг байнгын цахилгааны эх үүсвэрт холбох ажлын явц 80.0 хувь байна.

- Баян-Өлгий аймаг дахь хилийн 0285 дугаар ангийн 0289 дүгээр салбар /Холбоо нуур/, Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн 0154 дүгээр салбар “Гашуунсухайт”-ыг эрчим хүчинд холбосон.
- Мөн Сүхбаатар аймаг дахь хилийн 0146 дугаар ангийн 0176 дугаар салбар (Холбоо залаа)-ын өндөр хүчдэлийн шугам, дэд станцыг Улсын комисст хүлээлгэн өгч, 0245 дугаар ангийн 0246 дугаар салбар (Давст)-ын 18 км өндөр хүчдэлийн шугамын тулгуурыг босгож, дэд станцыг угсарсан.
- Увс аймаг дахь хилийн цэргийн 0245 дугаар ангийн “Давст”-ын салбарыг төвлөрсөн эрчим хүчний системд холбохоор шугамын төмөр бетон тулгуурыг суурилуулж, өндөр хүчдэлийн шугамын угсралтын ажлыг хийж дуусгасан. Цахилгаан эрчим хүчинд холбоход шаардлагатай 500 ширхэг тусгаарлагч, хуурай залгуур 1 ширхгийг худалдан авч, бэлтгэл ажлыг хангасан.
- Булган аймгийн Тэшиг сум дахь Хилийн цэргийн 0286 дугаар ангийн “Төмрөн, Бургастай”, Хилийн цэргийн 0287 дугаар ангийн “Онон, Цагаанчулуут” салбаруудад 5кВт-ын нарны цахилгаан станц суурилуулж, хилийн цэргийн 0303 дугаар ангийн “Минж”-ийн хилийн салбарыг 5 кВт-ын сэргээгдэх эрчим хүчний системд холбосон.
- Дорнод аймаг дахь хилийн цэргийн 0198 дугаар ангийн “Дэгээ гол” салбарыг эрчим хүчинд холбох зураг төсвийг батлуулан, ажлын зураг хийгдэж, одоогийн байдлаар 310 шон татан авч суулган, цахилгаан шугам татах ажлууд хийгдэж байна.

4.3.1.5.Хилийн боомтуудыг "Дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем"-ээр төхөөрөмжилж, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлж, шалгалтын техник, хэрэгслээр хангах, цэргийн холбооны техник хэрэгсэл, хүн нэг бүрийн тусгай хэрэгслийг шинэчилнэ.

Биелэлт: Хилийн боомтуудыг дохиолол, хяналтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх ажилд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтад санхүүжилт тусгагдаагүй, урсгал төсвийн санхүүжилтээр хилийн 4 боомтод дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөхөөр төлөвлөсөн.

Шалган нэвтрүүлэх албанд хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан технологи нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд БСШУЯ-ны судалгаа, туршилтын “Шинжлэх ухаан технологийн төсөл”-өөс 56 төрлийн 4001 ширхэг техник хэрэгслийн зардалд нийт 5.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, хилийн боомтуудын шалгалтын кабин, шалгалтын техник хэрэгслийг шинэчилсэн.

Хилийн “Гашуунсухайт”, “Ханги”, “Хавирга”, “Замын-Үүд” боомтуудыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх тооцоо, судалгааг 2023 оны төсөвт тусгаж, “Мобинет” ОХУ-ын “Оргэнергострой” ХХК-уудтай хамтран ажиллаж, хилийн 17 боомт шилэн кабелд холбосон, “Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн систем”-ийн программын шинэчлэлийг хийж, хилийн боомтуудын шалгалтын техник, хэрэгслийг бүрэн шинэчилсэн.

Хилийн “Чингис хаан” боомтод боомтод орох, гарах чиглэлд нийт 8 ширхэг Герман улсад үйлдвэрлэсэн цахим гарц, зорчигч өөрийгөө бүртгүүлэх төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад оруулж, 2021 оны 07 дугаар сараас гадаадын иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийг бүртгэж эхэлсэн. Мөн “Чингис хаан”, Төмөр замын “Сүхбаатар”, “Замын-Үүд” боомтод гадаадын иргэнийг биометрик өгөгдлөөр бүртгэх (хурууны хээ унших, нүүрний зураг авах, паспорт унших) зориулалт бүхий 30 ширхэг таблетыг худалдан авч, албанд ашиглаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын APIS системээс аяллын дугаарын мэдээллийг авах программын хөгжүүлэлт болон сүлжээний холболтын ажлыг хийж, цахим гарцаар нэвтэрсэн иргэдийн аяллын дугаарыг 30 минутын дараа мэдээллийн санд татаж авах боломжийг бүрдүүлсэн.

4.3.2. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.

4.3.2.1. Хууль сахиулах байгууллагуудын холбоо, зэвсэглэл, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэн, дэд бүтцийг хөгжүүлнэ.

Биелэлт: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын богино болон хэт богино долгионы радио холбоог шинэчлэх төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр танилцуулсан бөгөөд сайдаас яамны харьяа агентлаг, тусгайлсан чиг үүргийн байгууллага /ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ/-уудын богино болон хэт богино долгионы радио холбоог нэгдсэн нэг системээр шинэчлэх төсөл, танилцуулгыг бэлтгэх үүрэг өгсний дагуу нэгдсэн төслийг тооцоо судалгааг гаргаж, энэ оны 03 дугаар сарын 11-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, технологийн газрын даргад цахимаар хүргүүлсэн. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын техник хэрэгслийг шинэчлэх ажлын хүрээнд улсын төсвийн урсгал зардлаас 700 сая төгрөгөөр сүүлийн үеийн технологи бүхий 365 суурин компьютер, 55 нөүтбүүк, 35 ширхэг хэвлэгч төхөөрөмжийг тус тус худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын ашиглаж байгаа сумны нөөцийг бага зардлаар бүрдүүлэх зорилгоор ашигласан сумны хонгиог дахин цэнэглэх “mark 7 evolution” сум угсрагч загварын бүрэн автомат төхөөрөмж, “hornady ammo plant”, “the

evolution” загварын сум угсрагч гар төхөөрөмжийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс санхүүжүүлсэн хөрөнгөөр худалдан авч, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Цагдаагийн байгууллагын автомашинуудыг иж бүрэн шинэчлэх ажлын хүрээнд “Киа Моторс Монгол” ХХК-тай 4 жилийн хугацаатай байгуулсан санхүүгийн түрээсийн гэрээний дагуу 350 автомашин худалдан авахаас өнөөдрийн байдлаар 289 автомашиныг хүлээн авч, тусгай дуут болон гэрэл дохио, хэт богино долгионы /Icom IC-2300/ маркийн станцуудыг угсарч суурилуулсан. Энэ ажлын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нийт автомашины 30 хувийг шинэчлээд байна.

Цагдаагийн ерөнхий газрын төсвийн хөрөнгийн 821.0 сая төгрөгөөр Checkpoint 6000 техник тоног төхөөрөмж /багц1/, Firewall лиценз, техник хэрэгсэл /багц2/, K2 платформ системийн лиценз /багц3/, сервер, сүлжээ, теле хяналтын камерын системийн техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, худалдан авч, суурилуулан, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Бүгд Найрамдах Чех Улсын “Ceska zbrojovka” галт зэвсэг үйлдвэрлэгч байгууллагаас шинэ загварын 6 ширхэг галт зэвсэг олгосныг хүлээн авсан. Автопарк шинэчлэх ажлын хүрээнд улсын төсвийн санхүүжилтээр 1, урсгал зардлаас 8, нийт 9 ширхэг автомашиныг 414.4 сая төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаанд ашиглаж байна. 2023 оны байдлаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/237 дугаар тушаалаар байгуулсан “Төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын хэт богино долгионы радио станцуудыг шинэчлэх чиг үүрэг бүхий Дэд ажлын хэсэг”-ээс өгсөн үүргийн дагуу шаардлагатай төсвийн тооцоо, судалгааг танилцуулсан ба “Моторола сольюшн” компанитай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж, АНУ-ын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сард 5.0, энэ оны 08 дугаар сард 7.0, нийт 12.0 сая ам.долларын санхүүжилт шийдвэрлэгдсэн.

АНУ-ын Засгийн газраас “Моторола сольюшн” компанитай гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд энэ оны 10 дугаар сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулагдсан Дэд сайдтай хийсэн цахим хурлын үеэр “Моторола сольюшн” компанийн төслийн зохицуулагч нар энэ онд багтааж гэрээг байгуулж, 2024 оны 01 дүгээр улиралд радио, станцын тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр төлөвлөж байгаа талаар мэдэгдсэн болно.

Засгийн газрын 2022 оны МН/453 дугаар тогтоолын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны МН-1а/02 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагад шаардлагатай тусгай хэрэгсэл, зэвсэглэл, техник тоног төхөөрөмж хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох ажлын хэсгийг байгуулсан бөгөөд нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгсэл, камержуулалт, тусгай зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг 4 багц техник хэрэгслийг худалдан авах тендерт 2 аж ахуйн нэгж шалгарч, гэрээ байгуулж, хяналтын камер, ухаалаг программ хангамж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

4.3.2.2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг криминологи дүн шинжилгээ судалгаанд суурилан явуулж гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах арга хэмжээ авна.

Биелэлт: Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар 12 удаа дүн шинжилгээ, судалгаа хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий, тусгай, соён гэгээрүүлэх ажлыг Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран үе шаттай зохион байгуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг болон цахим орчинд хүүхдийг аливаа зохисгүй агуулга бүхий сөрөг мэдээ, мэдээлэл, контентоос хамгаалах, хувийн мэдээллээ хамгаалж, аюулгүй зөв зохистой оролцоход төлөвшүүлэх, цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 61 удаа хэлэлцүүлэг, 947 цагийн сургалт зохион байгуулж, 103 удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион

байгуулж, 891 сурагч оролцуулж, давхардсан тоогоор ерөнхий боловсролын 544 сургуулийн 5,216 бүлгийн ахлах ангийн 177,096 сурагчид, 89,895 иргэн, 9,502 багш, нийгмийн ажилтан, 65,698 ерөнхий боловсролын сургуулийн сурагч, оюутнуудад мэдээлэл хийж, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гэмт хэрэг, зөрчил, гэм буруугийн ойлголт, мэдлэг эзэмшүүлэх талаар “Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр”-т хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага, хувь хүн ба нийгэм, хувь хүн ба хууль, шударга ёс, үл ялгаварлан гадуурхах, шударга ёс ба авлига, эрх зүй, иргэний эрх зүйн харилцаа, иргэн ба төрийн харилцаа, иргэний эрх зүйн харилцаа, эрх зүйн зөрчил ба хариуцлага эзэмшүүлэх чадварыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн тусган хэрэгжүүлж байна.

ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Нийслэлийн Прокурорын газартай хамтран боловсруулж, ерөнхий боловсролын сургуулиудад 200 ширхгийг хүргэж, уг зөвлөмжийн хялбаршуулсан постероор дамжуулан, Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсанд байршуулсныг 951 удаа хуваалцсан байна.

Боловсролын ерөнхий хуульд бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт "гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршиг, дэлгэцийн донгоос сэргийлэх талаарх агуулгыг заавал тусгаж, хэрэгжүүлэхээр хуульчилсан. Өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас татгалзах соёлд сургах, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 онд улсын хэмжээнд 21 аймаг, 17 суманд "Анзаар" арга хэмжээг 2023 оны II-X сард ЦЕГ, ГБХЗХГ-тай хамтран зохион байгуулсан.

Цахим орчин дахь гадуурхалт, дээрэлхэлтээс сэргийлэхэд суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хамтдаа” тэтгэлэгт төслийг хэрэгжүүлж, 602 сурагчдын зөвлөлийн гишүүдэд сургалт, арга хэмжээг зохион байгууллаа. Түүнчлэн "Үе тэнгийнхний дээрэлхэлтээс сэргийлэх" гарын авлага модулийг боловсруулж, “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ын цахим хичээлд байршуулав. БШУС-ын 2022 оны А/453 дугаар тушаалаар "Сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам" болон А/214 дүгээр тушаалаар “Сургууль, дотуур байрны орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг батлан, хэрэгжүүлж байна. Соён гэгээрүүлэх “Үйлдлээрээ үлгэрлээ”, “Харилцан хүндэтгэе” зэрэг аян, “Охидын эрхийн өдөр” өдөрлөг, “Нууцтай байх эрх”, “Уулзалдъя-Зөвлөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдал”, “Эерэг хандлага, Харилцан хүндэтгэе” гэх мэт арга хэмжээг зохион байгуулж дунд, ахлах ангийн 312,914 суралцагчийг хамруулсан байна.

4.3.2.3. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ.
/Улаанбаатар хот, орон нутгийн бүх камер/

Биелэлт: Олон улс, улсын чанартай авто замын 62 цэгт камерын хяналтын систем суурилуулахаар төлөвлөснөөс улсын төсөв болон орон нутгийн төсвийн 448 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь, Завхан, Баянхонгор аймгийн 9 сумдын 13 постод 68 ширхэг хяналтын камерыг суурилуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор 2022 онд “Ногоон бүс” төслийг Чингэлтэй дүүргийн 1-3 дугаар хорооны амжилттай хэрэгжүүлж, Уг төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр 3 дүүрэг, 9 аймагт зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, Чингэлтэй, Налайх дүүрэг, Хөвсгөл, Сүхбаатар аймагт теле

хяналтын төв байгуулагдаж, Баянгол дүүрэг, Дорнод, Сэлэнгэ аймагт хяналтын төв байгуулах өргөтгөл, суурилуулалтын ажил хийгдэж байна. Төв аймагт тендер зарласан боловч тендерийн маргаан гарч, Сангийн яаманд шалгагдаж байна. Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулахад шаардлагатай 721.2 тэрбум төгрөгийг 2023 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг хүргүүлсэн боловч Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэх үед хасагдсан.

4.3.2.4.Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох нэгдсэн санг бий болгоно.

Биелэлт: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/208 дугаар тушаалаар зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох зөрчлийн бүртгэл, мэдээллийн цахим сан бий болгох ажлыг судалж, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн цахим систем хөгжүүлэх ажлын даалгавар”-г баталсан бөгөөд даалгаврын дагуу “IT zone” ХХК шалгарч, ХЗДХЯ-аас тус компанитай 2022 оны № 83393416 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгээс гаргасан шийдвэрийн дагуу оны 03 дугаар сараас эхлэн Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын нэг, хоёрдугаар хэлтэст эхний хувилбарыг, 10 дугаар сарын 01-ний өдрөөс Нийслэлийн 6 дүүргийн цагдаагийн газар, хэлтэс болон замын цагдаагийн хэлтэст хоёрдугаар хувилбарыг туршилтын журмаар ашиглаж байна. Цахим санг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхтэй холбогдуулан Дотоод хэргийн их сургуультай хамтран зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 650 алба хаагчийг оролцуулсан сургалтыг зохион байгуулсан.

4.3.2.5.Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, стратегийн ач холбогдол бүхий орд, зарим аймгийн төв болон хүн амын суурьшилд, иргэдийн хөдөлгөөний нягтаршил ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг хамгаалалтад авч, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн “Тавантолгой нүүрсний уурхай”, “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн I-IV объект, “Тайширын усан цахилгаан станцыг тус тус Дотоодын цэргийн гэрээт тусгай салбарын хамгаалалтад авсан.

Улаанбаатар хотын ус хангамжийн Дамбадаржаагийн усан сан, Толгойтын усны эх үүсвэр, Яармагийн усны насос станц, Алтай хотын ус хангамжийн эх үүсвэр, Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Тайширын усан цахилгаан станц, Дарханы “Үндэсний дата төвийн нөөц төв” стратегийн орд, нийт 6 объектыг Дотоодын цэргийн хамгаалалтад авсан.

Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй 15 аймгийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, Дархан, Эрдэнэт, Дорнодын цахилгаан станц зэргийг хамгаалалтад авахад шаардагдах орон тоо, зардлын төсвийг 2023 оны орон нутгийн төсөвтөө тусгаж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах хүсэлтийг тухайн аймгуудын Засаг дарга нар болон цахилгаан станцын удирдлагуудад тус тус хүргүүлж, хувийг тухайн аймгуудын цагдаагийн газарт хүргүүлсэн. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дархан дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ” ТӨХК, Хэнтий аймгийн Чингис хотын ус хангамжийн эх үүсвэр, Баянхонгор аймгийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, Үнэт металлын сорьцын хяналтын газрын салбар лаборатори, Зоонозын өвчин судлалын лабораторийг дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг эхний ээлжид тухайн байгууллагын төсвөөс санхүүжүүлж, улмаар Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолд нэмэлт оруулан улсын төсөвт хамгаалалтад шилжүүлэх талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулгыг нууцлалыг ханган хүргүүлсэн. Засгийн газрын энэ оны 126 дугаар тогтоолоор Засгийн

газрын Хяналт хэрэгжүүлэх газрын байрыг энэ оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс, Засгийн газрын энэ оны 141 дүгээр тогтоолоор Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг энэ оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс хамгаалалтад хүлээн авч, аюулгүй байдлыг нь ханган ажиллаж байна. Монгол Улсын 2024 оны төсөвт 5 аймаг, 3 станцыг Дотоодын цэргийн хамгаалалтад авах орон тоо, цалингийн төсөв батлагдсантай холбогдуулан бэлтгэж ажлыг ханган ажиллаж байна.

4.3.2.6.Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлж үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээ авна.

Биелэлт: Монгол Улсын Төсвийн тухай хуулиар 2020 онд 320, 2021 онд 650, 2022 онд 958, 2023 онд 20, нийт 1948 алба хаагчийн орон тоо нэмэгдүүлснийг хуваарилж, алба хаагчийг томилолтын асуудлыг шийдвэрлэснээр нэг алба хаагчид оногдох ажлын ачаалал буурахад эерэг нөлөө үзүүлсэн.

Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх талаар хийсэн судалгааны дүнг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны мн/08 тушаалаар Дотоодын цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулсан. Мөн алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, үндсэн чиг үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг нэмэгдүүлэх зорилгоор 45 тушаалаар 45 бүтцэд өөрчлөлт оруулж, 47 мөрдөгчийг 16 удаа нэмэгдлээр болон сэлгэн ажиллуулснаар ачаалал ихтэй нэгжийн ачаалал 15-25 хувиар буурч бусад хэрэгт ажиллах боломж нэмэгдсэн үр дүн гарсан.

Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар 13 төрлийн лавлагааг Лавлагааны сан, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбар цэгүүд, 21 аймаг, 330 сумдын Засаг даргын Тамгын газрын “Нэг цэгийн үйлчилгээ”, <https://e-mongolia.mn/> цахим хуудсаар олгох боломжийг бүрдүүлснээр лавлагаа олгодог алба хаагчдын ажлын ачааллыг 10 дахин бууруулсан.

4.3.2.7.Улаанбаатар хотод төвлөрсөн, орон нутаг дахь эрүүлжүүлэх, цагдан хорих, баривчлах байр, албаны байрны нөхцөлийг стандартад нийцүүлнэ.

Биелэлт: Улсын хэмжээнд 1966-2016 оны хооронд ашиглалтад орсон 37 эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа явуулж байгаа ба “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, ерөнхий шаардлага” MNS5527:2019 стандарт хангаагүй Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Шарын гол, Замын-Үүд, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Мандал, Сайхан, Хэнтий зэрэг 15 аймаг, сумын эрүүлжүүлэх, саатуулах байрны стандарт шаардлага хангаагүй байруудад үйл ажиллагаа явуулж байна.

4.3.2.8.Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг хотхон хэлбэрээр хөгжих замаар нэмэгдүүлж, сургалтын үйл ажиллагаанд олон улсын чанарын удирдлагын ISO-9001:2015 стандартыг нэвтрүүлнэ.

Биелэлт: Байгууллагын үйл ажиллагаанд стандартын 5s зарчмыг нутагшуулах ажлын хүрээнд Дотоод хэргийн Их сургуулийн дотор, гадна хаяг, мэдээллийн самбар, танилцуулгуудыг шинээр хийх, сайжруулах, шинжлэх ухаан, технологийн мэдээллийн сан бий болгох, Их сургуулийн онцлог хэсэг /музей, үзэсгэлэн, танхим зэрэг/-ээр зорчих 360 виртуал хөтөч бий болгон цахим хуудаст байршуулах, шалган нэвтрүүлэх байршилд зорчих хөдөлгөөнд цахим бүртгэл, хяналтын систем нэвтрүүлэх, Их сургуулийн нийт 7900 м.кв талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, 5S бүтээмжийн аян өрнүүлэх,

хэвшил болгож Их сургуулийн хэмжээнд нутагшуулах, Их сургуулийн хэмжээнд “Кайзен саналын систем” нэвтрүүлэх талаар судалж, турших зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнг олон улсын баталгаажуулалтын “Монсертф” ХХК-ийн бүрэлдэхүүн Их сургуульд зочилж, баталгаажуулалтын аудитыг 2021 оны 06 дугаар сарын 21-ээс 24-ний өдрүүдэд хийж, 3 жилийн хугацаатайгаар баталгаажуулахаар шийдвэрлэсэн. 2021 онд Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагаанд олон улсын ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо, ISO 21001:2018 боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлсэн. Энэхүү олон улсын стандартын стандарт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж дүгнэх, нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилт, явц, сайжруулалтыг үнэлэх магадлах аудитыг Олон улсын баталгаажуулалтын эрхтэй “Монсертф” компаниар 2022 оны 10 дугаар сарын 19-өөс 21-ний өдрүүдэд хийлгүүлж, гэрчилгээг 1 жилийн хугацаатай сунгуулсан.

4.3.2.9. Дотоод хэргийн их сургуулийн бүтэц зохион байгуулалтыг салбарын хөгжилтэй уялдуулан алба хаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлж үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээ авна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/24 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Их сургуулийн төрийн тусгай албанд болон төрийн үйлчилгээний албанд ажилладаг нийт 500 гаруй хүний цалингийн зэрэглэл, удаан жилийг шинэчлэн тогтоож, цалин хөлс, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх шат дараатай арга хэмжээг авч ажилласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох зорилгоор тус Их сургуулиас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд хүсэлт илгээсний дагуу 2023 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд шуурхай жижүүр, багш, дамжааны захирагч-багш, усан спорт сургалтын төвийн дасгалжуулагч-багш, зэвсгийн мастер-түгээгч, архивч, номын санч, шалгах механик, тогооч, бэлтгэгч, үйлчлэгч, дэвтэрлэгч гэх мэт 20 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн Сайдын шийдвэрлэсний дагуу Их сургуульд шинээр мэргэжлийн анги нээгдэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан Хил хамгаалах ерөнхий газраас 6, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 3, Шүүхийн шинжилгээний ерөнхий газраас 1, нийт 10 орон тоог шилжүүлж авсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/236 дугаар тушаалаар баталсан “Дотоод хэргийн их сургуулийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийг шинэчлэн баталсантай холбогдуулан шинээр нэмэгдсэн, өөрчлөгдсөн 200 гаруй албан тушаалын болон ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан.

4.3.3. Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрын байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.

4.3.3.1. Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Биелэлт: Хөтөлбөрийн хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд хэрэгжүүлэх ажлын 6 зорилтын хүрээнд 33 ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Улсын хэмжээнд нийт 141 хамгаалалтын арга хэмжээ бүртгэгдсэнээс урьдчилан сануулах 125, тодорхой үйлдлийг хязгаарлах 1, биечилсэн хамгаалалт 6, нэг бүрийн тусгай хэрэгсэл, тусгай техник, харилцаа холбооны хэрэгслээр хангах 2, сэтгэл зүйн хамгаалалт 7, хамгаалуулагч 138 хүн бүртгэгдсэнээс гэрч 8, хохирогч

128, гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн 2 иргэн тус тус бүртгэгдсэн. Аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтны шийдвэр, тогтоол хүлээн аваагүй, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлээгүй.

4.3.3.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр байгуулна.

Биелэлт: Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяанд Ховд аймаг болон Баянгол дүүрэгт, Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар Түр хамгаалах байрыг 2021 ашиглалтад оруулсан. Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын харьяанд Түр хамгаалах байрыг Японы ядуурлыг бууруулах хөгжлийн сан, АХБ-ны 240 сая төгрөгийн санхүүжилтээр 170 м.кв, 7 өрөө бүхий 8 хүнийг хүлээж авах хүчин чадалтайгаар 2022 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хороо, Зүүнбаян-Уулын 22 дугаар гудамжинд Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын захиалгаар АХБ-ны санхүүжүүлэлтээр Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр шинээр байгуулж, 2023 оны 08 дугаар сарын 28-ний өдөр тус түр хамгаалах байрыг хүлээж авсан боловч түр хамгаалах байранд ажиллах ажилтны орон тоо батлагдаагүй, зардал шийдвэрлэгдээгүй тул ямар нэгэн үйл ажиллагаа явагдахгүй байна.

Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Түр хамгаалах байрны барилгын ажил 45 хувьтай явагдаж байна. Улсын хэмжээнд 35 Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгаа ба энэ оны байдлаар 2,918 хүүхэд, 98 эрэгтэй, 1,536 эмэгтэй, нийт 4,552 иргэн тус тус бүртгэгдсэн байна.

4.3.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.3.4.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчдийг албадан эмчлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Биелэлт: Согтуурах мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг бүсчлэн хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын бүсэд Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 150 га газар эзэмших эрхийн гэрчилгээг улсын бүртгэлд бүртгэж баталгаажууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн I үе шат 2017-2019 онд, II үе шат 2019-2021 онд хэрэгжиж дуусаж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 247 дугаар тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн баталсан ба Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээний талаар хэлэлцүүлэг зохион явуулахаар бэлтгэл ажлыг хангаж байгаа талаар Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас мэдэгдсэн. Мөн Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн барилгын зургийн ажлыг “Некстстеп Инженеринг” ХХК гүйцэтгэж байна. Зүүн бүсийн албадан эмчлэх эмнэлгийг байгуулан, ШШГЕГ-ын даргын 2023.02.01-ний өдрийн А/38 дугаар тушаалаар Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын

бүтэц, орон тоог шинэчлэн баталж, 17 алба хаагчийг томилж, албадан эмчилгээний төвийн үйл ажиллагааг 2023.04.07-ны өдөр эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 17 /эр 14, эм 3/ эмчлүүлэгчийн хүлээн авч, эмчилгээ үйлчилгээг үзүүлж байна.

4.3.4.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2017-2021 онд хэрэгжин дууссан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 онд баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нэгдүгээр шатны төлөвлөгөөний хэрэгжилт 96.0 хувь, хоёрдугаар шатны төлөвлөгөөний хэрэгжилт 98.6 хувь.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 247 дугаар тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн баталсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2023 оны төлөвлөгөөний хариуцсан 20 ажил, арга хэмжээний хэрэгжилтийг тооцож, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд 2/199 дугаар албан бичгээр хүргүүлж, үр дүнг тооцуулсан.

4.3.4.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдох, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирох эрсдэлтэй зорилтот бүлгийг тодорхойлоход чиглэсэн судалгаа, тандалтын ажлыг зохион байгуулж, судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэн ажиллана.

Биелэлт: Монгол Улсын 13-25 насны өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, үр дагаврын тухай ойлголт, мэдлэг, хандлага, хэрэглээний тархалтын талаарх судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх, шаардлагыг тодорхойлох зорилгоор “Хасах 25” төслийг хэрэгжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдох эрсдэлтэй зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудын дунд хэрэглээний тархалт, ойлголт, мэдлэг, хандлагыг тодорхойлох 10,000 респонденттой 6 модуль бүхий суурь судалгааны ажлыг 2020-2021 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Тус судалгааны ажлын гүйцэтгэгч “Максима Консалтинг” ХХК-аас энэ оны 09 дүгээр сарын 22-ны өдөр судалгааны ажлын нэгдсэн тайланг танилцуулсан ба судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх стандартыг боловсруулж байна.

Боловсролын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд, залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах чиглэлээр “Анзаар” арга хэмжээг зохион байгуулж, нийслэлийн төр, захиргааны 31 байгууллага, 3 дүүрэг, 21 аймгийн 1,066 төрийн болон төрийн бус байгууллагын 20,029 ажилтан, алба хаагч, 121 их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн 7,870 багш, нийгмийн ажилтан, 17,820 оюутан, сурагч, 14,476 эцэг, эх асран хамгаалагч нарт “Өсвөр насны хүүхдийг хорт зуршлаас ангид байлгах, хар тамхины ойлголт, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга” сэдвээр нийт 60,195 хүнд 790 удаагийн сургалтыг танхимаар зохион байгуулсан. Сургалт, мэдээллийн ажилд хамрагдсан иргэдэд 60.0 мянган ширхэг зөвлөмж, сэрэмжлүүлгийг хүргэж, 5 асуулт бүхий санал асуулга цаасаар авахад 98 орчим хувь нь “Эерэг” үнэлгээ өгч 4,240 хүн бичгээр талархал илэрхийлсэн байна. Дархан-Уул

аймгийн 8 их, дээд сургууль, коллежийн 680 оюутан, сурагчдад “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх,” Хорт зуршлаас татгалзах” сэдвээр сургалтыг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээллийг агуулсан QR-той 500 ширхэг түлхүүрийн оосрыг тараан ажилласан.

4.3.4.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийг шинэчлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт ургамлын тархац бүхий нутаг дэвсгэрт устгалын арга хэмжээг өргөн цар хүрээтэй зохион байгуулах, алба хаагчид, мэргэжилтнүүдийг мэргэшүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хүний шээснээс мансууруулах бодис илрүүлэгч 7,725 ширхэг тест, Hiace petrol AT, LC200 GX petrol v6 маркийн автомашин, гэмт этгээдийг дайчлан баривчлах болон хойшлуулшгүй ажиллагааны үед хэрэглэх хувцас, техник, тоног төхөөрөмж худалдаж авсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын энэ оны 05 дугаар сарын 03-ны өдрийн тушаалаар баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон 14 аймгийн нутаг дэвсгэрт зэрлэг байдлаар ургаж байгаа олсны ургамлыг устгах “Устгал” нэгдсэн арга хэмжээг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 07 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд тархац тогтоогдсон 14 аймгийн 51 сум 252 цэг, нутаг дэвсгэрт зохион байгуулсан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, эрэлт нийлүүлэлтийг хязгаарлах, борлуулалт нийлүүлэлтийн сүлжээг таслан зогсоох, сэжигтэй этгээд бүлэг бөөгнөрөл, тэдгээрийн хууль бус үйлдлийг илрүүлэх зорилгоор үе шаттай 10 тусгай арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон. Олон Улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполоос Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газарт 6 нэр төрлийн 53 багц хар тамхи, тэсэрч дэлбэрэх бодис тест хүлээлгэн өгсөн.

Олсны ургамлыг түүж бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх, худалдан борлуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор устгалын ажлыг жил бүр тасралтгүй зохион байгуулснаар 14 аймагт тархан ургадаг байсан ургамал Архангай, Ховд, Завхан аймгуудад бүрэн устаж 11 аймаг болж буурсан. Энэ оны хувьд нийслэл хотын 2 байршилд олсны ургамлын ургалт 90 гаруй хувиар багасаж, нийт тархац бүхий аймгуудын нутаг дэвсгэрт ургаж буй олсны ургамлын бүлгэмдэл нь сийрэгжиж, гарц багассан, 7 цэгт ургамал ургаагүй үр дүн гарч, арга хэмжээний хүрээнд 3 холбогдогчтой 3 хэргийг илрүүлэн шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

“Анзаар” нэгдсэн арга хэмжээний хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршгийн талаар сургалт, мэдээлэл хийж ажилласан нь тархац бүхий аймгуудын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас устгалын ажилд онцгой ач холбогдол өгч ажиллахад нөлөөлсөн байна.

4.3.4.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулна.

Биелэлт: Монгол Улсын 13-25 насны өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, үр дагаврын тухай ойлголт, мэдлэг, хандлага, хэрэглээний тархалтын талаарх судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, судалгааны үр дүн, нотолгоонд суурилсан үндэсний хэмжээний урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ /бодлого/, стратеги боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор “Хасах 25” төслийг хэрэгжүүлж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах чиглэлээр ажиллах 24 сургагч багшийн давтан сургалтыг зохион байгуулж, сертификат гардуулсан. Бэлтгэгдсэн сургагч багш нараас нийслэлийн 6 дүүрэгт эцэг эх, асран хамгаалагч 28,623, багш, ажилчид 10,874, оюутан 3,768, сурагч 4,691, нийт 47,958 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байх талаар сургалт, мэдээлэл хийж ажилласан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулснаар эрсдэлт бүлгийн 134 эцэг эхэд утсаар болон биечилсэн хэлбэрээр тусламж, зөвлөгөө өгч, 15 хүүхдийг бүртгэл хяналтад авч, Эрүүл мэндийн төв, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай холбон зуучилж ажилласан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 214 гэмт хэрэг, 200 яллагдагч цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 1 буюу 0.4 хувиар яллагдагч 34 буюу 14.5 хувиар буурсан байна. Энэ онд 5 гэмт хэрэгт 6 насанд хүрээгүй хүүхэд холбогдсоныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Зөрчлийн тухай хуулийн 5.1.3-т заасан 185 зөрчилд 215 хүн холбогдон шалгагдсаныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил 17 буюу 8.4 хувиар, холбогдогч 25 буюу 10.4 хувиар тус тус буурсан. Зөрчилд холбогдсон 215 хүнээс 22.3 хувь буюу 48 насанд хүрээгүй хүүхэд бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

4.3.5. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.

4.3.5.1. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаменттай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгаалал түншлэлийн компакт гэрээ”, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Эрүүгийн цагдаагийн албаны 1 дүгээр давхарт байрлах мэдүүлэг авах 2 өрөөг “Хүүхдэд ээлтэй өрөө” болгон тохижуулж, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт чадавхжуулах сургалтад 305 алба хаагчийг хамруулж, Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн Монголын мэдээ сувгийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт “Хүн худалдаалах гэмт хэрэг”-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 цуврал сурвалжилга бэлтгэж, олон нийтэд түгээсэн. Гадаад харилцааны яамны Консулын газар, Тагнуулын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагуудтай хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон нийт 10 иргэнд сэтгэл зүйн болон, эрүүл мэнд, хууль зүйн туслалцааг үзүүлж байна.

4.3.5.2. Эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Биелэлт: ХНХЯ-аас БНСУ-ын Жендерийн тэгш эрх, гэр бүлийн яамтай хамтран “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийг 5 жилийн хугацаатай амжилттай хэрэгжүүлж дууслаа. Энэхүү төсөл нь хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх замаар холбогдох бодлого, хөтөлбөрт нөлөөлөх, хэрэгжилтэд олон талт оролцоог нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд хэрэгжсэн. Төслийн гүйцэтгэгч байгууллагаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр 2000 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа Хүйсийн тэгш эрх төв ТББ ажиллалаа.

Төслийн хаалтын үйл ажиллагааг 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр олон салбарын төлөөллийг оролцуулсан бага хурал хэлбэрээр зохион байгуулж, мөн уран бүтээлчдийн дунд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зарласан уран бүтээлийг шалгаруулж, шалгарсан бүтээлээр үзэсгэлэн гаргаж, олон нийтийн хүртээл болголоо.

Тус бага хуралд Бүгд Найрамдах Солонгос Улсаас ирсэн төлөөлөл, Соёлын яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн байгууллага, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, болон дүүргүүдийн сургалтад хамрагдсан алба хаагчид, даван туулагчид, Олон Улсын байгууллага, төрийн бус байгууллагын нийт 60 гаруй төлөөлөл оролцлоо.

4.3.6. Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ.

4.3.6.1. Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх бодлогын хэрэгжилтийг хангана.

Биелэлт: Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр 2021 онд Засгийн газрын 2021.04.14-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”, ШШГЕГ-ын даргын 2021.05.19-ний өдрийн А/85 дугаар тушаалаар “Цахим хяналт, удирдлагын төвийн ажиллах журам”, “Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд нэвтрэх, ашиглах журам”, ШШГЕГ-ын даргын 2021.03.29-ний өдрийн А/47 дугаар тушаалаар зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэгдэх 16 маягтын загварыг тус тус шинээр батлуулж, ХЗДХС, УЕП-ын хамтарсан 2021.07.02-ны өдрийн А/158, А/76 дугаар тушаалаар “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 онд 1200 ширхэг иж бүрэн цахим гав, компьютер техник хэрэгслийг шинэчилсэн.

БНХАУ-ын “Shenzhen Hexum Technology Co.,LTD” компанийн үйлдвэрлэсэн шинэ төрлийн цахим бугуйвчийг зорчих эрхийг хязгаарлах ялын бүртгэл хяналтын системд холбох ажлыг “Сэтгэ ХХК”-аас ирүүлсэн “Зөвлөх үйлчилгээний санал”-ын дагуу ажил гүйцэтгүүлэхээр “Ажил гүйцэтгүүлэх тухай” гэрээг байгуулсан. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглах боломжтой дагалдах хэрэгсэл 40 ширхэг хөлийн цахим бугуйвчийн дагалдах хэрэгслийг /цэнэглэгч, оосор/ 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авсан.

БНХАУ-ын “Shenzhen Hexus Technology Co.,LTD” компанийн туршилтад ашиглагдах 2 ширхэг гарын цахим бугуйвч, 2 ширхэг хөлийн цахим бугуйвч, 2 ширхэг гэрийн хорионы суурин станц, 2 ширхэг зөөврийн цэнэглэгчийн үнэ болох 935 ам.долларын хяналтын тоног төхөөрөмжийг хүлээн авч, туршилтын журмаар ажиллуулж байна. БНХАУ-ын “Shenzhen Hexus Technology Co.,LTD”-тай компанитай 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр холбогдон DDX-04, DDX-14 загварын 400 ширхэг цахим бугуйвчийн тээвэрлэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн. “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг 2020 онд байгуулж, хяналтын дэлгэц, алба хаагчдын компьютер техник хэрэгсэл, серверийн нөөц тэжээлийг суурилуулан 1,317 ялтанд хяналт тавьж үйл ажиллагаа жигдэрсэн.

АХБ-ны санхүүжилтээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын II байранд Цахим хяналтын дэд төвийг байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, сервер, техник хэрэгслийг худалдан авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах “Нээлттэй тендер”-ийг зарлаж, тендерт “Ай Ти Зон” ХХК шалгарсан. Мөн Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй анги цахим хяналт, удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ойролцоох аймгуудыг багтаасан бүсийн хяналтын төвийг байгуулахаар төлөвлөн, “Гэмтэй ч гэртээ” төслийг санаачлан Дархан сумын Засаг даргын Тамгын газраас 18.4 сая төгрөгийн санхүүжилтээр зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд хяналт тавих өрөөг шинээр тохижуулж бэлэн болгосон бөгөөд шаардлагатай орон тооны судалгааг гарган, дээд байгууллагад хүргүүлсэн.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангах, программ хангамжийн ачааллыг бууруулах, цахим хяналтын системийг шинэчлэх зорилгоор АХБ-ны 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр цахим хяналтын системийн программ хангамж болон хоригдогсдын бүртгэл хяналтын нэгдсэн системийг шинэчилж, шинээр хийх тендерт “Ай Ти Зон” ХХК шалгарсан бөгөөд тендерт шалгарсан мэдээлэл технологийн “Ай Ти Зон” ХХК-д мэдээ, судалгааны загвар хүснэгтийг боловсруулж файлаар хүргүүлсэн. БНХАУ-ын “Shenzhen Hexus Technology Co.,LTD” компанитай хамтран ажиллаж, DDX-04 загварын 790 ширхэг гарын цахим бугуйвч, 10 ширхэг хөлийн бугуйвчийг зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглаж байна.

4.3.6.2.Хорих ял эдлүүлэх, цагдан хорих орчин нөхцөлийг хүний эрхийг хангасан түвшинд хүргэх,насанд хүрээгүй ялтныг сургаж хүмүүжүүлэх зориулалт бүхий "Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага"-ын цогцолбор барилга байгууламжийг сайжруулна.

Биелэлт: Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын сургуулийн шинэ барилгын санхүүжилтийг УИХ-ын 2023.05.30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгаж, барилга барихад шаардлагатай 6.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Сангийн яам хянаж, УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар баталж 2024 оны улсын төсөвт тусгахаар бүрэн шийдвэрлэсэн.

4.3.6.3.Хоригдлын биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ.

Биелэлт: 2021 оны хэрэгжилт ХЗДХЯ: Хоригдол, хоригдогч нарын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор телекамер үйлдвэрлэгч Финланд улсын “AXIS”, БНХАУ-ын “Megvi” брэндийн царай таних телехяналтын системүүдийн шийдлийг судалсан. Уг систем нь хүний нүүр царайны дахин давтагдашгүй мэдээллийг бүртгэн авч, өндөр түвшинд ялгах чадвартай, царайг таньж хаалгыг автоматаар онгойлгох, хөдөлгөөн дунд бүртгэл хийх, бүртгэлтэй хүний нүүр царай телекамерын дуранд тогтоосон хугацаанд илрээгүй тохиолдолд бүртгэлд хамрагдаагүй хүмүүсийн мэдээллийг

ялган харуулж анхааруулах дохио өгдөг зэрэг боломжууд нь хорих ангийн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглахад тохиромжтой байна. Тус хяналтын системийн шийдэл, тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийн тооцоо судалгааг гарган, хорих анги, байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлэх шаардлагатай байгааг удирдлагад танилцуулж, 2022 оны улсын төсөвт тусгуулах саналыг ХЗДХЯ-нд 2021.08.11-ний өдөр танилцуулсан.

Байгууллагын онцлогт тохирсон нүүр царай таних телекамер, телехяналтын системийн шийдлийг судалж, "ITZONE" ХХК-тай хамтран БНХАУ-ын MEGVII брэндийн нүүр царай таних Megeye-C3S-123 загварын телекамер, Megserver-S1C-L3-L1 загварын өгөгдөл боловсруулах сервер, Megbox-B1F-122 загварын дүрсний хайрцаг суурилуулж, програм хангамжийн систем хөгжүүлэлт /System installation and development/-ийг 421 дүгээр нээлттэй хорих ангийн байрлалд 60 хоригдлын нүүр царайг 14 хоногийн хугацаатайгаар таниулан туршилт хийхэд теле хяналтын систем, програм хангамж хэвийн ажиллаж ашиглалтын шаардлага хангасан. Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 23 хорих ангид тус системийг нэвтрүүлэхэд шаардлагатай 1.1 тэрбум төгрөгийн тооцоо судалгааг гаргасан.

407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, 421 дүгээр нээлттэй хорих ангиудад хоригдлын биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгийн асуудлын шийдвэрлүүлсэн. 407, 421 дүгээр нээлттэй хорих ангиуд болон Үйлдвэр, барилга аж ахуйн хэлтэст тус хүний нүүр царай танин бүртгэх телекамерыг суурилуулан туршиж, дүн шинжилгээ хийсэн. Хөрөнгийн асуудал шийдвэрлэгдвэл тус хорих ангиудад суурилуулахад бэлтгэж байна.

4.3.6.4. ШШГБ-ын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор шат дараатай арга хэмжээ авна.

Биелэлт: ШШГЕГ-ын даргын 2021 оны А/43 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх хөтөлбөр"-ийг баталж, жил бүр тусгайлсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаж байна. Тус хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд:

- Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа албан хаагчдад 5 жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал 336 албан хаагчид 6.6 тэрбум төгрөгийг олгосон.
- Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар алба хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлж, нийт цалинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад офицер бүрэлдэхүүний цалин 44 хувь, ахлагч бүрэлдэхүүний цалин 48 хувиар тус тус өссөн.
- Тэтгэвэрт гарсан 12 албан хаагчид 248 сая төгрөгийн урамшуулал олгосон.
- ШШГБ-ын хүүхэд асрах чөлөөтэй байгаа 210 эмэгтэй албан хаагчдад 222.3 сая төгрөгийн цолны цалинг 2023 оноос олгож эхэлсэн.
- Алба хаагчдыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан, яаралтай тусламж болон 3 дугаар шатлалын эмнэлгийн тусламж шаардлагатай тохиолдолд Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Бүгд Найрамдах Солонгос Улсын "Эль" эмнэлэгтэй хамтран ажиллаж байна.
- Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 269 алба хаагчид хөнгөлөлттэй үнээр орон сууц, 21 алба хаагч, ахмад ажилтнуудад гэр олгож, тусламж дэмжлэг үзүүллээ.
- Гадаад улсад суралцаж буй 22 албан хаагчдад үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны мөнгө, унааны зардал буюу 97.5 сая төгрөг олгосон.
- Ажлын ачааллыг тэнцвэржүүлж, бодит биелэлтийг өсгөх зорилгоор Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт орон нутгийн салбар нэгжээс 53 алба хаагч 3 сарын хугацаанд туршлага солилцон ажилласан.

- Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын зүүн бүсийн албадан эмчилгээний төвийг байгуулж 17 орон тоог харьяа бусад салбар нэгжийн орон тооноос шилжүүлэн авч, үйл ажиллагааг эхлүүлсэн зэрэг болно.

4.3.6.5.Хорих анги, байгууллагын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Баруун бүсэд Баянхонгор аймагт “Согтуурах мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төв”-ийг байгуулахад аймгийн Засаг даргын Тамгын газраас 6.4 га газрыг Баянхонгор сумын 9 дүгээр баг “Шинэ суурьшлын бүс”-д олгохоор шийдвэрлэсний дагуу баруун бүсийн наркологийн эмнэлгийн /100 ор бүхий/ үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд холбогдох судалгааг хамтран хийж, эмнэлгийн барилгын зураг төслийн даалгавар, шаардлагатай орон тоо, төсвийн төслийг боловсруулан удирдлагад танилцуулахаар хүргүүлсэн бөгөөд 39,247м.кв газрын эзэмших эрхийн гэрчилгээг улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн, биелэлтийг хангуулах, бүсийн нөхцөл байдлын талаар удирдлагыг мэдээллээр хангах, бүсчилсэн хэлбэрээр нэгтгэн зохион байгуулах зорилгоор ШШГЕГ-ын даргын 2023.05.03-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар хорих байгууллагын бүсчилсэн тогтолцоо, бүсийн дарга нарыг томилж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Хорих ангийн тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр суурьшлын бүсээс холдуулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүнсний хэрэглээний тодорхой хувийг дотоодоосоо хангахад чиглэсэн ажлын хүрээнд газар тариалан, хөдөө аж ахуйн чиглэлээр төрөлжсөн ангийг шинээр зохион байгуулахаар 421 дүгээр нээлттэй хорих ангийг Сэлэнгэ аймгийн Сайханд суманд нүүлгэн шилжүүлэх саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.

Баруун бүс: Ховд аймаг дахь ШШГГ-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн хамгаалалтын хашаа; Баянхонгор аймагт Согтуурах мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төвийг байгуулах ажлын газрын асуудал 2022 онд шийдвэрлэгдсэн боловч барилгын зураг төслийн даалгавар, шаардлагатай орон тоо, төсвийн төслийг боловсруулсан.

Зүүн бүс: Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ШШГЕГ-ын даргын 2023.02.01-ний өдрийн А/38 дугаар тушаалаар Зүүн бүсийн албадан эмчлэх эмнэлгийг байгуулсан, эмчилгээ үйлчилгээг хэвийн явагдаж байна. Хэнтий аймаг дахь ШШГГ-419 дүгээр нээлттэй хорих ангийн цагдан хорих байрны барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

4.3.6.6.Алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: ШШГЕГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/215 дугаар тушаалын хүрээнд ШШГЕГ-ын алба хаагчдыг чадавхжуулах давтан сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулсан ба Удирдлагын академийн Социологи, сэтгэл судлалын тэнхим, доктор /Ph.D/ профессор Б.Хэрлэн “Орчин үеийн төрийн албаны удирдах ажилтны ур чадвар”, “Бүлгээр ажиллах” сэдвийн хүрээнд 4 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Дотоод хэргийн их сургуультай хамтран ажиллаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилт” сэдэвт суурь судалгааг хийлгэж тайланг хүлээн авсан.Дотоод хэргийн их сургуультай хамтран “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилт” сэдэвт суурь судалгааг хийсэн. Тус судалгааны зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн өнөөгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, улмаар

боловсронгуй болгохтой холбоотой дүгнэлт, зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн. ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тэнхим 2023.03.24-ний өдөр “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахлагч бүрэлдэхүүнд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсанд хорих анги, байгууллагын алба хаагчдаас ирүүлсэн 22 илтгэл оролцсон байна.

Мэргэшүүлэх сургалтыг төвлөрсөн болон бүсчилсэн, цахим хэлбэрээр холбоо, мэдээлэл технологийн инженер, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, ахлах болон шийдвэр гүйцэтгэгч, хорихоос өөр төрлийн шийдвэр гүйцэтгэгч, хүний тоо бүртгэлийн байцаагч, харуул хамгаалалтын ажилтнууд зэрэг 9 төрөл мэргэжлийн давхардсан тоогоор нийт 2,043 алба хаагчийг хамруулсан.

4.3.6.7.Хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх тогтолцоог орчин үеийн чиг хандлагад нийцүүлнэ.

Биелэлт: Хоригдолд зохион байгуулах сургалтын жишиг хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуультай хамтран “Дахин гэм хэрэг үйлдсэн хоригдлуудын харилцааны түвшинг нийгэмшүүлэх үйл ажиллагаатай холбон судлах” судалгааны ажлыг зохион байгуулж, судалгаанаас гарсан үр дүнг үндэслэн “Хорих ял эдлэх үеийн сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулж, хөтөлбөрийн төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2021.11.30-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт ДХИС-ийн ШШГГ-ийн сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч доктор, профессор, хурандаа Б.Алтангэрэл, ШУТИС-ийн Бизнесийн Удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн ахлах багш доктор, профессор Н.Нямдорж болон хорих ангийн нийгмийн ажилтнууд оролцсон. Хэлэлцүүлгээс гаргасан саналыг хөтөлбөрт тусган боловсруулж, дахин санал авахаар 2021.12.06-ны өдөр аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, байгууллагад хүргүүлж, саналыг нэгтгэн, ШШГГ-ын даргын 2021.12.22-ны өдрийн А/207 дугаар тушаалаар хөтөлбөрийг батлуулсан. Хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгэмд гаргахад бэлтгэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суралцах, ажил хөдөлмөр эрхлэх дадал хэвшүүлэх, гэр бүлийн харилцаанд бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийг Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвтэй хамтран боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022.08.30-ны өдрийн А/167, А/233 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. НҮБ-ын /Ерөнхий ассамблейн/ 2021.12.16-ны өдөр баталсан “Нийгэмшүүлэх болон нийгэмд эргэн нэгтгэх замаар давтан гэмт хэргийг бууруулах” тогтоол, “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай үүргийг аймаг, нийслэл дэх ШШГГ, хэлтэс, хорих анги, байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хоригдлыг суллагдахад бэлтгэх зорилгоор 417, 419, 439 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиуд нь тусгайлсан нийгэмшүүлэх байр болон өрөөг бэлтгэн тохижуулж, нийгмийн харилцаа, амьдралд гарахад бэлтгэх, дадлага олгох сургалтыг 2022 оноос үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал суллагдахын өмнөх сургалтаар хууль эрх зүйн мэдлэг олгохоос гадна нийгэмд хэрэглэгдэж буй техник технологийг /АТМ, ТҮЦ, ухаалаг утас, автобусны картыг хэрхэн ашиглах, “Нэг цонхны үйлчилгээ”-ний талаар/ танилцуулах үзүүлэн, загвар, гарын авлага, товхимлыг байршуулан сургалтад ашигласан.

“Дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын харилцааны түвшинг нийгэмшүүлэх үйл ажиллагаатай холбон судлах” судалгааны ажлыг гарын авлагын эхийг бэлтгэсэн. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт хорих анги, байгууллагын хэмжээнд 4354 хоригдол ял эдэлж байгаагаас 769 хоригдлыг хорих ангийн үйлдвэрт, 1918 хоригдлыг аж ахуйн үйлчилгээнд,

648 хоригдлыг гэрээт хэсэгт, нийт хоригдлын 3335 буюу 76.5 хувийг ажлын байраар хангасан. Байгууллагын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 182 хоригдол хорих ял эдэлж байгаагаас 95 хоригдлыг тэдний эрүүл мэндийн байдалд тохирсон хөдөлмөрт хуваарилсан ба үүнээс 29 хоригдол цалинтай ажлын байранд хөдөлмөр эрхэлж 9.7 сая төгрөгийн цалин олгогдсон байна.

4.3.7. Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангана.

4.3.7.1. Криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна.

Биелэлт: БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хүрээлэнгийн лабораториудыг шинэчлэн тоноглож, шинжилгээний лабораториудыг шинээр байгуулж шинжээчдийг урт, богино хугацааны сургалтад хамруулж, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Уг төслийн Техник эдийн засгийн үзүүлэлтийг “КОЙКА”-ийн судалгааны баг бүрэн хийж дуусгасан болно.

Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2022 оны А/140 дүгээр тушаалаар Экологийн шинжилгээний лабораторийн статусыг шинжилгээний бие даасан нэгж болгож аймаг, орон нутаг бүсчлэн хариуцах 8 шинжээчийн орон тоог баталсан. “Киа Моторс” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр БНСУ-д үйлдвэрлэсэн “Киа Вонго 2700” маркийн арын чингэлэг хэсгийн загварыг өөрчилж туулах чадварт нийцүүлсэн, үзлэг шинжилгээнд шаардлагатай техник, хэрэгслээр бүрэн тоногдсон 167.0 сая төгрөгийн өртөг бүхий автомашиныг хүлээн авч үзлэг шинжилгээнд ашиглаж байна. Мөн экологи эдийн засгийн үзлэг шинжилгээ хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулан ажиллаж 216.2 сая төгрөгийн өртөг бүхий нийт 23 нэр төрлийн техник, тоног төхөөрөмж худалдан авсан.

Криминалистик, тусгай шинжилгээний чиглэлээр БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хими, цахим технологи, хэргийн газрыг сэргээн дүрслэх, бичиг баримт, ДНХ-ийн шинжилгээний лабораториудад олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийг суурилуулан, лабораторийг шинэчлэн, 19 алба хаагч гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтад хамрагдаж, хүний нөөцийг чадавхжуулсан. Төсөл хэрэгжсэн лабораториудын нээлтийн үйл ажиллагааг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх хэрэгсэл, мөр судлалын шинжилгээний лабораторид харьцуулалтын "ОРТО-EDU A18" микроскоп, гарын мөрийн шинжилгээний лабораторид мөр илрүүлж бэхжүүлэх "Crime lite-Auto" гэрэлтүүлэх хэрэгслийг, физикийн шинжилгээний лабораторид натригаас уран хүртэлх химийн элементийг тодорхойлдог "EDX-7200" маркийн рентген флуоресценцийн спектрометр тоног төхөөрөмжийг шийдвэрлэж шинжилгээнд ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд Биологийн шинжилгээний лабораторид ГХУСА33-ийн санхүүжилтээр "Olympus" DX-53 маркийн 3 ширхэг микроскоп мөн байгууллагын худалдан авах ажиллагаагаар 5 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авч, шинжилгээ хийж байна. Шүүх анагаах ухааны шинжилгээний чиглэлээр БНСУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх "Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл"-ийн хүрээнд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга зөвлөх үйлчилгээ

үзүүлэх гэрээг “AUM&LEE Architects & Associates” компанитай 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан.

4.3.7.2. Нийслэл, орон нутгийн Шүүхийн шинжилгээний албадын үйл ажиллагааг нэг жишигт /стандартад/ хүргэхийн тулд нэг загварын лаборатори, хүний нөөц, хэрэгцээт техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.

Биелэлт: Баян-Өлгий, Сэлэнгэ аймгийн шүүхийн шинжилгээний албанд байр барих төсвийг шийдвэрлүүллээ. Тайлангийн хугацаанд Говь-Алтай аймгийн Замын цагдаагийн байрыг тус албанд балансаас баланст шилжүүлэн авлаа. Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/216 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, орон тоо”-г 80 орон тоогоор нэмэгдүүлэн батлуулсан. Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2021 оны 67 дугаар тогтоолоор Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг байрлаж байсан 153.6 сая төгрөгийн өртөг бүхий байрыг тус аймгийн ШША-нд балансаас баланст шилжүүлэн авч 2022 оноос үйл ажиллагаагаа явуулж байна.

Баянхонгор аймгийн шүүхийн шинжилгээний алба нь аймгийн “Татварын хэлтэс”-ийн 2 давхар барилгыг 2022.10.13-ны өдөр шилжүүлж авсан. Завхан, Хөвсгөл аймгийн ШША албаны байрны асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад санал, хүсэлт уламжлан ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар “Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, орон тоо”-г шинэчлэн нийт 623 албан хаагчийн орон тоотой байхаар нэмэгдүүлж баталсан. “Киа моторс монгол” ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр 542.0 сая төгрөгийн цогцос тээвэрлэх тусгай зориулалтын 5 ширхэг автомашин нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж 2022 оны 09 дүгээр сарын 29-ний 2 ширхэг, 10 дугаар сарын 20-ны өдөр 3 ширхэг БНСУ-д үйлдвэрлэсэн “Киа Вонго 2700” маркийн автомашиныг хүлээн авч ашиглаж байна. Баян-Өлгий аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай, Сэлэнгэ аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын дагуу Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн мэргэжлийн хяналтын лабораторийн зориулалт бүхий байрыг балансаас баланст шилжүүлэн хүлээн авсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 182 дугаар тогтоолоор Дархан-Уул, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Дорнод аймгуудын Шүүх шинжилгээний хэлтсийг бүсийн Шүүх шинжилгээний төв болгон өөрчилж, 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Дорнод аймаг дахь бүсийн Шүүх шинжилгээний төвийн нээлтийг зохион байгуулсан.

4.3.7.3. Шүүх эмнэлгийн лабораторийн болон Цогцос хадгалах зориулалтын төвийг байгуулан, иммуногистохимийн зэрэг иж бүрэн шинжилгээний лабораториуд, үзлэг шинжилгээний орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

Биелэлт: Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын “Эд эсийн шинжилгээний лаборатори”-д иммуногистохимийн шинжилгээг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжийг 38.3 сая төгрөгөөр худалдан авч суурилуулсан. Мөн Дорнод, Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний албанд Эд эсийн шинжилгээний лабораторийг шинээр байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлээд байна.

БНСУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Шүүх эмнэлгийн шинжилгээний лабораторийн болон цогцос хадгалах барилгыг Нийслэлийн баруун талд барихаар Техник эдийн засгийн үзүүлэлтийг хийж дуусгасан. Барилга барих 1 га газрыг Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Архивын ерөнхий газрын баруун урд талд шийдвэрлүүлж,

холбогдох техникийн нөхцөл, зөвшөөрлүүдийг авсан байгаа бөгөөд барилгын зургийг “Зуун найм” ХХК-аар, барилга угсралтын төсвийг “Өрх” ХХК-аар хийлгүүлсэн болно. Мөн төслийн техник эдийн засгийн үзүүлэлт, урилга бүхий 150 хуудас материалд дүн шинжилгээ хийж санал хүргүүлсэн. Зураг төсөл, тендерийн баримт бичиг боловсруулах ажил 8 сарын хугацаанд хийгдэх бөгөөд 2023 оны 05 сард барилга байгууламж барьж, тоног төхөөрөмж суурилуулах ажил 18 сарын хугацаанд хийхээр төлөвлөсөн бөгөөд төслийг нийт 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж 2025 оны 5 дугаар сард бүрэн дуусгахаар төлөвлөгдсөн болно.

Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын “Эд эсийн шинжилгээний лаборатори”-д иммуногистохимийн шинжилгээг нэвтрүүлж, шинжилгээ хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийт 38.3 сая төгрөгөөр худалдан авч суурилуулсан. Тайлангийн хугацаанд шаардлагатай урвалж бодис, ариун тариур, бүрхүүл шил, будаг зэргийг хүлээн авч шинжилгээ хийж байна. Мөн Дорнод, Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний албанд Эд эсийн шинжилгээний лабораторийг шинээр байгуулж, холбогдох албан хаагчийг томилж, үйл ажиллагааг нь жигдрүүлээд байна.

Нийслэлийн зүүн талд Шүүх анагаах ухааны цогцос хадгалах барилга барих газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Баянзүрх дүүргийн Засаг даргад 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 02/1391 тоот албан бичиг, нийслэлийн хойд хэсэгт НШШГ-ын шарил түр хадгалах зориулалттай барилга барих 1 га газрыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн захирагчийн ажлын алба болон газрын албанд 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 03/1795, 03/1849 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн.

4.3.7.4.Эрэн сурвалжлах болон нууц далд аргаар үйлдсэн, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх зорилгоор ДНХ-ийн сан бий болгоно.

Биелэлт: ДНХ-ийн нэгдсэн санг бий шаардлагатай “ABI3500 генетик анализатор, тог баригч”, “NanoDrop-2000”, “7500 Real-Time PCR System for Human Identification with Dell Notebook 0520”, “ДНХ ялгах автомат машин”, “ДНХ-ийн дээжийг 860С хэмд хадгалах гүн хөлдөөгч”, цуглуулсан дээж материал буюу сорьцод шинжилгээ хийхэд шаардлагатай урвалж бодисын зардлыг байгууллагын 2022, 2023 оны төсвийн төсөлд тусгасан боловч батлагдаагүй. Иймд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр 01/6633 тоот албан бичгийг 2022 оны 11сарын 17-ны өдөр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга бөгөөд нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргад, 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 01/6515 тоот албан бичгийг Авлигатай тэмцэх газарт холбогдох судалгаа, танилцуулгыг саналын хамт хүргүүлэн ажилласан. Мөн 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд ДНХ-ийн шинжилгээний лабораторид 5 нэр төрлийн 400.3 сая төгрөгөөр тоног төхөөрөмжийг тусгах саналыг боловсруулсан. ДНХ-ийн шинжилгээгээр 2023 оны 11 сарын байдлаар 2 эзэнгүй хэргийг нотлон ажилласан. КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын тусламжаар хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 26 төрлийн 66 ширхэг тоног төхөөрөмж, 34 төрлийн урвалж бодис, 12 төрлийн туслах хэрэглэгдэхүүнийг суурилуулж, шинжилгээнд ашиглаж байна.

4.3.8.Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

4.3.8.1.Төрийн архивуудыг зориулалтын байртай болгоно.

Биелэлт: Аймгийн Архивын тасаг /төрийн архив/-ийн байр, хадгаламжийн сан, өрөө тасалгааны хэмжээ, зай талбайн хүрэлцээ, нөхцөл байдлын судалгааг шинэчлэн, Архивын барилгын зураг төсөл хийлгэх боломжтой аймгуудын судалгааг ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 6

аймагт /Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий/ Архивын байр барих газрын асуудлыг тухайн аймгуудын Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлсэн. Улсын бүртгэлийн архив, үйлчилгээний цогцолбор төвийн барилга Сүхбаатар дүүрэгт 2020-2021 онд баригдаж ашиглалтад орсон.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын төрөлжсөн архивын 5 давхар барилга баригдаж дууссан бөгөөд ус, дулаан, цахилгааны холболтууд бүрэн хийгдэж, энэ оны 12 дугаар сарын 30-нд түлхүүр гардуулахаар бэлтгэж байна. Увс аймгийн Төрийн архивын барилга угсралтын ажлыг “Ундарга Петролиум” ХХК гүйцэтгэж, 2023 оны 08 дугаар сарын 14-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвөөс 30 сая төгрөг шийдвэрлэж, архивын баримтыг нүүлгэн шилжүүлж дууссан. Барилгын нийт өртөг 2,8 тэрбум төгрөг болсон.

Говь-Алтай Аймгийн Төрийн архивын барилга угсралтын ажлыг “Вентана констракшн” ХХК гүйцэтгэж, 2023 оны 11 дүгээр сарын 15-нд улсын комисст хүлээлгэн өгч, архивын баримтыг нүүлгэн шилжүүлж дууссан. Барилгын нийт өртөг 2,5 тэрбум төгрөг болсон.

4.3.8.2. Монгол Улсын түүх, соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг нээн илрүүлж, худалдан авах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: 1913 онд Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн Орос улсын Петербург хотод хийсэн албан айлчлалд холбогдох 31 хуудас баримтыг ОХУ-ын Түүхийн архиваас цахим хэлбэрээр хүлээн авч, бүртгэл үйлдсэн. “Дэлхийд тархсан монгол өв: Архивын баримт, бичгийн дурсгал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын үеэр МУИС-ийн багш, доктор дэд профессор О.Оюунжаргалаас 114 хуудас бүхий дараах 2 баримтыг хүлээн авч, Үндэсний төв архивд шилжүүлсэн. Үүнд:

ТТ30.12.18: БНХАУ, Түүхийн Нэгдүгээр Архив, Цэргийн тухайн газар, манж эвхмэлийн хуулбар, 2171-025, 076-322. Тэнгэрийн тэтгэсний 30(1765) оны 12 дугаар сарын 5-ны өдөр улаан бийрээр цохолсон Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин Цэнгүнжав нарын, "Мянгадын ардын уг эхийг байцаагаад, хэвээр Ховдод суусан сайдад захируулж, алба хаах газрыг гуйн айлтгасан эвхмэл".

ТТ31.7.8: БНХАУ, Түүхийн Нэгдүгээр Архив, Цэргийн тухайн газар, манж эвхмэлийн хуулбар, 2195-005, 077-2475, "Мянгадын ардын сум зохиосон өрх амын тоо, олон эр, ламын тооны цэс". Тэнгэрийн тэтгэсний 31(1766) оны 7 сарын дугаар 8-ны өдрийн Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин Цэнгүнжав нарын өргөсөн 1766 онд Засагт хан аймгаас Ховдод нүүлгэсэн мянгад отгийн лам хар бүгд 411 өрхийн 1070 хүний бүртгэл болно.

“Чингис хаан”, язгууртнуудын музей байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж буй түүхийн баримт, дурсгалт зүйлсийг судлан тогтоох, эх хувь болон хуулбарлан авах ажлыг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж байна. Соёлын яамнаас 2020 оны 12 дугаар сард шинэчлэн ирүүлсэн “Гадаадын улс орнуудаас бүрдүүлэх, хуулбарлан авах үзмэрийн жагсаалт”-ын дагуу холбогдох ДТГ-тай харилцаж байна. 2020-2021 онд нийт 9 орноос 23 үзмэрийн “А” болон дижитал хуулбарыг хүлээн авч, Соёлын яам болон “Чингис хаан” музейн удирдлагад 2021 оны 6 болон 11 дүгээр сард албан ёсоор хүлээлгэн өгөв. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхээс 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн ЗГ-1/198 дугаар албан тоотоор гадаад улсад суугаа ДТГ-ын тэргүүн нарт чиглэл хүргүүлж, “Чингис хаан” хаад, язгууртнуудын музей байгуулах Засгийн газрын шийдвэр гарсантай холбогдуулан Монголын түүх, өв соёлд холбогдох түүхийн эх сурвалж, архивын баримт, эд өлгийн зүйлсийг судлан тогтоох, тэдгээрийг эх орондоо шилжүүлэн, эсхүл хуулбарлан авах боломжийг судлан мэдээлэл ирүүлэхийг үүрэг болгосон. 2022 онд ОХУ-ын Шинжлэх ухааны архиваас олон улсын сансрын нислэгийн түүхэнд холбогдох 147 хуудас бүхий 87 баримтыг хуулбараар авсан.

БШУЯ-ны Технологийн сангийн захиалгат төсөлд ХЗДХЯ-аар уламжлуулан Гадаадын 4 орноос баримтын хуулбар авах асуудлыг БШУЯ-ны дэргэдэх комисст 2022.03.31-ний өдөр хэлэлцүүлсэн. БНПУ-ын Шинжлэх ухааны архивд хадгалагдаж байгаа 1915 оны хүн амын тооллогын баримтын хуулбар авах, хэвлүүлэх тухай саналыг Архивын ерөнхий газрын 2022.06.02-ны өдрийн 01/375 дугаартай албан бичгээр Олон улсын монгол судлалын холбоонд хүргүүлсэн.

Оросын Шинжлэх ухааны академийн Санктпетербургийн салбар архиваас Д.Г.Мессершмидтийн баримт бичгийн өв дэх толь зүйн материал: “Монгол, төвд толь бичгийн тойм” 458 хуудас зохиолыг цахимаар авч хэвлэн товч оршил бичиж, Үндэсний төв архивын сан хөмрөгт авсан.

4.3.8.3. "Монгол төрийн баримтат аман өв төсөл"-ийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын баатар, ЗХУ-ын баатар, МУ-ын анхны сансрын нисэгч Ж.Гүррагчаа, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ц.Нямдорж нарт Архивын ерөнхий газрын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/478, 01/479 дугаартай албан бичгээр төсөлд оролцох урилга хүргүүлж, төслийг гүйцэтгүүлэхээр “Адме болон Ви Витекс” ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ХА/А/2021/07, 08 дугаартай гэрээ байгуулж, 2 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аман өв төслийн хүрээнд 150 гаруй хөдөлмөрийн баатрын судалгааг гаргаж, 2022.05.05-ны өдөр 25 хөдөлмөрийн баатрыг Архивын ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцуулж, “Монголын баримтат аман өв” төсөлд оролцуулах тухай хүсэлтийг “Хөдөлмөрийн баатруудын холбоо” ТББ-д хүргүүлж, 14 хөдөлмөрийн баатрын дурсамж яриаг 38 цагийн 1242 gb дүрс бичлэг, 159ш гэрэл зургаар Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулсан.

Монгол Улсын төрийн зүтгэлтэн, Ерөнхий сайд асан Д.Содномын хувийн хөмрөг үүсгэх арга хэмжээг 2022.06.09-ний өдөр зохион байгуулж, түүний амьдрал үйл ажиллагаанд холбогдох 1956-2022 оны 147 хадгаламжийн нэгж, хувийн гаралтай баримтаар, 2022.06.30-ны өдөр Төрийн шагналт Ардын уран зохиолч П.Бадарчийн 50 минутын дурсамж яриаг UHD 4k форматын 3840 pixel өргөн, 2160 pixel өндрийн хэмжээ, нягтралтай 1242 gb дүрс бичлэг, 467 ширхэг гэрэл зураг авч, түүний амьдрал үйл ажиллагаанд холбогдох баримт мэдээгээр Үндэсний төв архивын сан хөмрөгийг тус тус баяжуулсан.

Монгол Улсын урлаг, утга зохиолын өв соёл, төрөөс соёлын талаар баримталсан бодлого шийдвэр, ололт амжилт, сургамж, үр дүнгийн талаарх дуртгал яриа бичихэд зориулж 2023.11.17-нд Гандантэгчлэн хийдийн тэргүүн хамба номун хан гавж Ч.Чойжамцын тэргүүн хамбын албаа хүлээлгэн өгсөн ёслолын 115 минутын 41 gb хэмжээтэй дүрс бичлэг хийж баримтжуулсан.

4.3.9. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.

4.3.9.1. Хөшгийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна.

Биелэлт: Зорчигчийн мэдээллийн төв байгуулах зорилгоор үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК-ыг сонгон туршилтаар зорчигчийн урьдчилсан мэдээллийг авч, нислэг үйлдэж буй орнуудын зорчигчийн мэдээллийн төвүүдэд мэдээллийг өгөх ажлыг эхлүүлэх бэлтгэл хангасан;

НҮБ-ын “Go Travel” зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем (APP, PNR)-ийг Чингис хаан боомтод нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, “Зорчигчийн мэдээллийн төв”-ийн чиг үүрэг, бүтэц, орон тоог ХХЕГ-ын даргын 2022 оны н/20 дугаар тушаалаар батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам”, “Зорчигчийн мэдээллийн төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо”-г тус тус батлуулсан.

“Үндэсний дата төв”-тэй сервер, “Иргэний нисэхийн үндэсний төв”-тэй байр ашиглах гэрээ байгуулж, алба хаагчдын ажлын байрны тавилга хэрэгсэл болон албанд ашиглах компьютер, техник хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулсан. Зохиомол сервер ашиглах, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох дэд бүтцийг бий болгох зорилгоор зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, цуглуулах, дүн шинжилгээ хийх “Go travel” системийн туршилтын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай серверийн лиценз, компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Азийн сан, Хил хамгаалах ерөнхий газрын санхүүжилтээр худалдан авсан (Компьютер худалдан авахад урсгал санхүүжилтээр 14.9 сая төгрөг зарцуулсан);

4.3.9.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Биелэлт: “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” системийг нэвтрүүлэх арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэхээр төлөвлөн хөгжүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр 04 дүгээр сарын 12-ны өдөр гэрээ байгуулж, хөгжүүлэлтийг эхлүүлсэн боловч, гүйцэтгэлийн үр дүнгээр систем хөгжүүлэлт хангалтгүй үндэслэлээр 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/1391 дүгээр албан бичгээр “Гэрэгэ системс ХХК”-д мэдэгдэл хүргүүлж, гэрээг цуцаллаа. “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем” (ISM) (одоо ашиглаж байгаа хуучин систем) дэх визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний бүртгэл хэсгийн үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд 10 дугаар сарын 30-ны өдрөөс бүрэн нэвтрүүлж, хүсэлтийг хүлээн авч байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 11 дүгээр сарын 02-ны өдрөөс танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системтэй холболоо. Энэ онд хөгжүүлэлтэд төсөв зарцуулаагүй.

4.3.9.3. Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллийг бий болгож, виз, визийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг уг мэдээллийн сантай холбоно.

Биелэлт: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль 2020 оны 12 дугаар сард батлагдаж, 2021 оны 6 дугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөж эхлээд байна. Хуулийн дагуу Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системийг 2021.11.01-ний өдрөөс бүрэн нэвтрүүлж, 3 төрлийн визийг цахимаар олгож байна. Визийн мэдээллийн нэгдсэн сангийн эхний хувилбарыг 2021.11.01-ээс туршилтын журмаар нэвтрүүлж, 2022.05.01-ээс ГИХГ-т нэвтрүүлэн хөгжүүлэлтийг хийж байна. ХХЕГ-ын мэдээллийн сантай холбох, зарим нууцлалын асуудлыг шийдвэрлэх талаар ХЗДХЯ, ТЕГ, ХХЕГ, ГИХГ хамтран ажиллаж байгаа болно.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин сайдын яам болон Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газарт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллийг томилох асуудлыг Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны салбарын зөвлөлийн хурлаар 2021 оны 7 дугаар сард шийдвэрлэсэн. 2023 оны 1, 2, 4 дүгээр сард ГХЯ-ны Консулын газар, Дипломат ёслолын газар, Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газар болон ХЗДХЯ, ХХЕГ, ТЕГ, ГИХГ-ын хамтарсан уулзалтыг 5 удаа зохион байгуулж, бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх, ашиглах хамтарсан журмыг боловсруулж батлуулах, системийн явц, хөгжүүлэлтийн талаар санал солилцож ажиллав.

Монгол Улсын хилээр орохыг түдгэлзүүлсэн гадаадын иргэдийн жагсаалтыг тухай бүр шинэчилж, Хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад хүргүүлэв. ГХС, ХЗДХС-ын 2023 оны А/03, А/05 тушаалаар Цахим визийн системд 99 улсыг нэмж хамруулан, визийг түргэн шуурхай олгож байна. Дэлхийн 61 улсыг визээс чөлөөлж, 99 улсад цахимаар виз олгож байгаа тул одоогоор ДТГ-т ГИХГ-ын төлөөлөл бий болгох шаардлагагүй гэж үзэж байна. Дипломат, албан визээс бусад бүх төрлийн визийг Гадаадын иргэн, харьяатын газар олгож буй, цахим визийн систем болон мэдээллийн нэгдсэн сан, ДТГ-дад сүлжээ үүсгэж холбох, тоног төхөөрөмж худалдан авч суурилуулах асуудлыг ХЗДХЯ, ГИХГ хариуцаж байна.

4.3.10. Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл автомашины камертай байх стандартыг тогтоож, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг үе шаттайгаар хязгаарлах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.

4.3.10.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай, Автозамын тухай, Зөрчлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

Биелэлт: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2022.05.05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж шийдвэрлэсэн. Одоогоор дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээгүй байна. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Арван дөрөвдүгээр бүлэгт тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчлийг тусгасан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, мэдээлэл хүлээн авах, нийлүүлэх, боловсруулах тогтолцоог автоматжуулах, хүний оролцоогүйгээр зөрчлийн хэрэгт дугаар олгох, цахим хэлбэрээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах нөхцөл, боломж бүрдүүлэх, цахим нотлох баримт бүрдүүлэх замаар зөрчлийг шалган шийдвэрлэх, шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг цахим хэлбэрт шилжүүлэх, бэлэн бус хэлбэрээр торгуулийн шийдвэрийг биелүүлэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтийг тусгасан.

Мөн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан боловсруулсан Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан. Уг хуулийн төсөлд зорчих тээврийн автобусанд дүрс бичлэгийн төхөөрөмжтэй байх шаардлага тусгасан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулах үүднээс тус яамнаас боловсруулж буй Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагалдан гарах Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд замын хөдөлгөөний аюулгүй байдалд хийх аудитын тогтолцоог бүрдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх үйл ажиллагааны журам, аргачлалыг батлах, хөдөлгөөний аюулгүй байдлын аудитуудыг бэлтгэх, Монгол Улсын тээврийн хэрэгслийн ангиллыг олон улсын ангилалд шилжүүлэх, Монгол Улсад сүүлийн үед нэвтэрч буй шинэ тээврийн хэрэгсэл (цахилгаан автомашин, цахилгаан мотоцикл, скүүтэр), тэдгээрийг жолоодох жолоочийн насны хязгаарлалтыг тогтоох зэрэг зохицуулалтуудыг тусгаад байна.

4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлэх, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна.

4.3.11.1. "Монгол Улсад зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоо, гамшгийн бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл" хэрэгжүүлнэ.

Биелэлт: Гамшгийн аюулыг зарлан мэдээлэл нэгдсэн системийг улсын хэмжээнд байгуулах замаар гамшгаас хамгаалах, бэлэн байдлын чадавхыг бэхжүүлж, гамшгийн улмаас учрах хохирлыг бууруулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас АХБ-ны дэмжлэгтэйгээр 2020-2022 онд "Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлж, АХБ-ны 33 сая долларын зээлийн санхүүжилтээр хэрэгжих "Монгол Улсад гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" зээлийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн ерөнхий загвар, төслийн удирдлагын гарын авлага, техникийн тодорхойлолтууд болон холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулсан. Уг төслийн хүрээнд "Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх зээлийн төсөл"-ийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн ерөнхий загвар, төслийн удирдлагын гарын авлага, техникийн тодорхойлолтууд болон холбогдох бусад баримт бичгүүд боловсруулагдсан. Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх зээлийн төслийг Монгол Улсын Засгийн газар АХБ хоорондын 2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтад оруулж, Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 323/а дугаар тогтоолоор батлуулсан.

4.3.11.2. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.

Биелэлт: Цаг агаарын аюулт болон сэрэмжлүүлэг мэдээллийг сумдад албан тоотоор, цахим хуудсанд тухай бүр байршуулж урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажилласан нь гамшиг ослын дуудлагыг өмнөх онтой харьцуулахад 36.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хөдөө аж ахуйд цаг агаарын эрсдэлүүдийг тооцож мэдээллийг яаралтай малчдад цаг алдалгүй хүргэж, мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор "Масс мэдээ" үйлчилгээг орон нутагт нэвтрүүлсэн. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх Зарлан мэдээллийн дуут дохиог байршуулсан.

Гамшгаас хамгаалах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн тоног төхөөрөмжүүдэд хэт богино долгионы радио станцууд иридиум утас, нисдэг камер буюу дрон (MAVIC2), Онцгой байдлын ерөнхий газар болон бүс нутгийн хэмжээнд яаралтай шуурхай цахим хурал зохион байгуулах орчин үеийн дэлгэцийн өргөтгөл зэргийг хийсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар Цогцолборын ажлын зураг төсвийг гүйцэтгэж ЦУОШГ-т 9-р сард хүлээлгэн өгсөн. Орон нутгийн дэд цогцолборын бэлтгэл ажлыг хангах 17 цогцолборын зураг, төсөл боловсруулах ажлын зардал БХБС-ын багцад батлагдсан болно.

4.3.12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн системийг хөгжүүлнэ.

4.3.12.1. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой гаргасан санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зөрчигдөхөөс сэргийлэх чиглэлээр эрсдэлийн үнэлгээ боловсруулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажил, арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2023 оны 1 дүгээр улиралд НҮБ-ын 1540 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хороотой хамтарч "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний аргачлал"-ыг шинэчлэн боловсруулахаар тохиролцсон. Улмаар тус хорооноос 2023 оны 09 дүгээр сард Австрали улсын хэрэгжүүлж буй дээрх чиглэлийн "Эрсдэлийн үнэлгээний аргачлал"-ыг ирүүлсэн. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар тус эрсдэлийн үнэлгээний аргачлалтай нийцүүлэн өөрийн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулж байна, 2024 оны эхний хагас жилд терроризмыг санхүүжүүлэх, зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг холбогдох салбаруудад хийхээр төлөвлөн ажиллаж байна.

4.3.12.2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам, аргачлалд шаардлагатай өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам, аргачлал"-д шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанктай хамтран хэрэгжүүлж, 2023 оны 3 дугаар улиралд хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан. Журам, аргачлалд орсон нэмэлт өөрчлөлтийг сурталчлан таниулах зорилгоор өмгөөлөгчид, үл хөдлөх хөрөнгө зуучлагчид, крипто арилжаа эрхлэгчдэд нийт 3 удаа мэдээлэл хийсэн.

4.3.12.3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2023 оны Н/05 дугаар захирамжаар батлагдсан "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын 2023 онд хамтран ажиллах нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу 2023 оны 5 дугаар сард "Хаан шонхор-2023" нэгдсэн дадлага сургуулийг Чингис хаан олон улсын нисэх буудалд хийсэн. Улмаар Терроризмтой тэмцэх зөвлөлийн Баян-Өлгий, Говьсүмбэр, Өмнөговь аймаг дахь Салбар зөвлөлтэй хамтран тухайн орон нутгийн

онцлогийг харгалзан тус дадлага сургуулийг хэсэгчилсэн байдлаар зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудад Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийг сурталчлан таниулах ажлыг хийсэн.

4.3.13. Иргэдийн эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийг өндөр нарийвчлалтай тодорхойлж, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрсдэлд суурилсан хяналтаар чанд мөрдүүлнэ.

4.3.13.1. Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын ургамал, малын эрүүл ахуйн хяналтын тогтолцоог сайжруулж, хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүний худалдаа эргэлтийг хөнгөвчлөх зорилготой АХБ-ны 15.0 сая ам долларын санхүүжилттэй хэрэгжиж байгаа “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын чадавхыг дээшлүүлэх” төслийн хүрээнд лабораториудад 18 төрлийн өндөр хүчин чадал бүхий багаж тоног төхөөрөмж, 19 төрлийн 519 ширхэг лабораторийн тавилга эд хогшил, 52 төрлийн улсын байцаагчдын хяналт шалгалтын гар багажийг нийлүүлсэн хэдий ч лабораторийн барилга ашиглалтад ороогүйгээс өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүнийг эрт илрүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн байгууллагын лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд 2021 онд нийт 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, лабораторийн барилгыг барих, шаардлагатай шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг хэрэгжүүлсний 99.5% нь батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар, 0.5% нь орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийгдсэн байна. "Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоол гарсан.

4.3.13.2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлж Хүнсний аюулгүй байдлыг хангуулна.

Биелэлт: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Баяжуулсан хүнс болох гурил давсанд болон баяжуулагч хүнсний нэмэлтэд витамин В1, В2, В6, В9, витамин Д3, төмөр цайр тодорхойлох шинжилгээнүүдийг туршиж, судалгааны ажил гүйцэтгэн хүнсний бүтээгдэхүүнд төмөр болон цайр, давсанд иодын агууламж, баяжуулагч бэлдмэл болон баяжуулсан гурилд усанд уусдаг витамин В1, В2, В6, В9, витамин Д3 тодорхойлох шинжилгээний аргыг туршиж үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд бэлэн болгосон.

Шинжилгээний аргын стандартын төслүүдийг боловсруулж СХЗГ-т хүргүүлсэн. Энэхүү судалгааны ажлыг ШУТИС-ийн Хүнс судлалын эрдэм шинжилгээний төвтэй хамтран хэрэгжүүлсэн. АХБ-ны “Бүс нутгийн ургамлын хорио цээр, эрүүл ахуйг сайжруулах, худалдааг хөнгөвчлөх ЗЗӨЕТ МОН 46315 төсөл”-ийн хүрээнд нийлүүлэгдсэн Infromatic-9500 багажийн болон шинжилгээний аргын САЗ-ыг боловсруулж, шинээр нэмэгдсэн үзүүлэлтүүдийг шинжилгээнд нэвтрүүлэн шинжилгээ хийсэн. Засгийн газрын хуралдаанаар Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгах асуудал хэлэлцсэнтэй холбогдуулан нэмж багаж, тоног төхөөрөмж аваагүй байна.

4.3.14. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт,

хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна.

4.3.14.1. “2.0 мян.тонны багтаамжтай хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, 20.0 мян.тонн хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах” байгуулна.

Биелэлт: Улсын материаллаг нөөцийг бүрдүүлэх, гамшгийн аюул, байгаль цаг уурын бэрхшээл тохиолдоход түүний хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засгийн хүндрэл үүссэн үед хүн амын амьжиргаа, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор “Улаанбаатар хотод барих Улсын нөөцийн хүнсний бараа материал хадгалах механикжсан агуулахын төсөл”, “Улаанбаатар хотод газрын тосны бүтээгдэхүүний 20000 метр.куб-ын багтаамжтай терминал байгуулах төсөл”-ийг тус тус хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

“Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан улсын нөөцийн хүнсний болон газрын тосны бүтээгдэхүүний агуулахын төслийн танилцуулгыг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын зураг төслийн ажил бүрэн хийгдэж, ТЭЗҮ-ийг боловсруулах ажил бүрэн хийгдэж дууссан.

4.3.14.2. “20.0 мян.м3-ийн багтаамжтай газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор” байгуулна.

Биелэлт: Улсын материаллаг нөөцийг бүрдүүлэх, гамшгийн аюул, байгаль цаг уурын бэрхшээл тохиолдоход түүний хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засгийн хүндрэл үүссэн үед хүн амын амьжиргаа, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор “Улаанбаатар хотод 20.0 мянган тонн хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах барих төсөл”, “20.0 мянган м3-ийн багтаамжтай газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулах төсөл”-ийг Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Шадар сайдаас 2022 оны ЗГ-2/406 дугаар албан бичгээр Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яамны сайдад албан хүсэлт уламжилсан. Улсын нөөцийн хүнсний болон газрын тосны бүтээгдэхүүний агуулахын төслийн танилцуулгыг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын зураг төслийн ажил бүрэн хийгдэж, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил бүрэн хийгдэж дууссан.

4.3.15.Салбар дунд ашиглах "Агаарын аврах хүчин" байгуулна.

4.3.15.1.Агаараас эрэн хайх, аврах үйл ажиллагааг шуурхай удирдан зохион байгуулах болон техникийн засвар, үйлчилгээ, сургалт хийх чадвартай үндэсний мэргэжилтэй хүний нөөц бүхий нисэх нэгжийг Онцгой байдлын байгууллагын харьяанд байгуулж, хөгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн бүтэц, орон тоог баталсан бөгөөд 111 дүгээр анги 34 алба хаагч, ажилтантайгаар үүрэг гүйцэтгэж байна. Эхний ээлжид нийлүүлэгдсэн 2 нисдэг тэрэг нь угсралт, засварын үйлчилгээ хийгдэж 2022 оны 6 дугаар

сараас эрэн хайх, аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж, өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 15 аймаг, сумын нутаг дэвсгэрт 37 удаагийн ослын дуудлагаар нислэг үйлдэж, 50 хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж, тэдний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалаад байна. Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн гуравдахь ЕС-145 маркийн нисдэг тэрэг, сургалтын дадлагажуулагчийг хүлээн авах ажлын хэсэг шалгалтын ажлыг зохион байгуулж, 2023 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар өмчлөлд хүлээн авсан. Төслийн хүрээнд бэлтгэгдэх Инженер, техникийн алба хаагчид нислэгт инженерээр үүрэг гүйцэтгэх сургалтад хамрагдаж, нислэгийн урьдчилсан болон дараах бэлтгэлийг гүйцэтгэн, шалгалт 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс нислэгт үүрэг гүйцэтгэн дадлагажиж байна. Нисгэгч бэлтгэх хүрээнд нэгдүгээр ээлжийн 4 сурагч нисгэгч бүр ЕС-145 загварын агаарын хөлгөөр ажиллагааны сургалтад хамрагдсан. Туршлагатай нисгэгчид ЕС-145 загварын агаарын хөлгийн 72 цагийн онолын сургалтад хамрагдаж, нисдэг тэрэг дээрх дадлага сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс эхэлсэн. Төслийн төсвийн гүйцэтгэл 100 хувьтай байна.

4.3.16. Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүрээлэн байгаа орчны эрүүл, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хэмжил зүйн эталоныг хөгжүүлнэ.

4.3.16.1. Хэмжил зүйн чиглэлээр салбар лаборатори байгуулна.

Биелэлт: Герман Улсын Физик техникийн хүрээлэн /РТВ/-ээс “Даяаршлын чанарын дэд бүтцийн сан 95276-01-B58” төслийн хүрээнд Зайнаас хэмжих хэт улаан туяаны эмнэлгийн термометр шалгах эталон тоног төхөөрөмжийг авсан бөгөөд 2021 оны 12 дугаар сард Хүний биеийн халууныг зайнаас хэмжих хэт улаан туяаны термометрийг шалгаж тохируулах лабораторийн байрыг засварлан ашиглалтад оруулсан. 2021 оны 12 сард 20 хэт улаан туяаны термометрт шалгалт тохируулга хийсэн. Монгол Улсад хийн тоолуур шалгах ажлын эталон бий болгох болон уг төслийг хэрэгжүүлэх хүрээнд хийн бүтээгдэхүүн импортлодог, худалддаг, түгээдэг, ашигладаг ААНБ-ын төлөөллүүдтэй 2022 оны 3, 5 дугаар сард 2 удаа уулзалт зохион байгуулан, Олон Улсын болон Хууль эрхийн хэмжил зүйн Олон Улсын байгууллага (OIML)-ын холбогдох 3 стандартыг хамтран орчуулж, үндэсний стандартаар батлуулах ажлыг зохион байгуулсан. Стандарт, хэмжил зүйн газар нь “Хийн тоолуур шалгах ажлын эталон бий болгох төсөл”-ийг шинэчлэн боловсруулж, БНХАУ-ын Үндэсний хэмжил зүйн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 2024 онд Хийн тоолуур шалгах ажлын эталон бий болгох төслийг хэрэгжүүлэх 500.0 сая төгрөгийн төсөв батлагдсан.

4.3.16.2. Хэмжил зүйн салбарын эталон тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

Биелэлт: Монгол Улс болон БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн сангийн дэмжлэгээр тус газарт хамтран хэрэгжиж буй төслийн хүрээнд шингэний нягтын эталон болох аерометрүүд БНХАУ-ын хэмжил зүйн хүрээлэнгээс нийлүүлэгдэж нягтын эталоны чадавх, нарийвчлалыг нэмэгдүүллээ. Цахилгааны эталоны нарийвчлалыг дээшлүүлэх зорилтын хүрээнд ХБНГУ-ын Физик техникийн хүрээлэнгээс хэрэгжүүлж байгаа төслөөр Тогтмол гүйдлийн эсэргүүцлийн 6 эталон, өндөр нарийвчлалын жин, согтуурлын түвшин хэмжих эталон, ажлын эталон манометр СХЗГ-т нийлүүлэгдэхээр худалдан авалт хийгдэж байна. Стандарт, хэмжил зүйн газар нь өөрийн нэмэлт орлогын хөрөнгө оруулалтаар 268.8 сая төгрөгийн үнэ бүхий эталон муьтметр, гүйдэл хэмжигч ороомгийг худалдан авч нийлүүлэгдсэн. ХБНГУ-ын “Эрчим хүчний чанарын дэд бүтцийг дэмжих нь” төслийн хүрээнд бш улсын эталон ороомгууд нийлүүлсэн. Цахилгааны хэмжлийн дээрх эталон тоног төхөөрөмжүүд тус газарт 2022 онд нийлүүлэгдсэнээр нарийвчлалын түвшинг 10 хувиар

нэмэгдүүлж чадсан. СХЗГ-ын Хэмжил зүйн бодлогын газрын Уртын эталоны лабораторид 2022 онд суурилагдсан оптик коллиматор систем, индексэд ширээг ашиглан автомат нивелир, электрон тахеометр, электрон теодолит зэргийн өнцөг, зайг шалгаж 5 аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүлсэн байна. Хэмжил зүйн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр 2024 оны төсөвт 400.0 сая төгрөг батлуулсан.

4.3.17.Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.

4.3.17.1.Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.

Биелэлт: Монгол Улсын Их Хурал 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан.

Улсын онцгой комиссын 2020 оны 35 дугаар тэмдэглэлийн 3.6-д “уул уурхайн зориулалттай сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бараа материалын тээвэрлэлт, түгээлтийг халдвар хамгаалалтын дэглэмийг сайтар мөрдөж, ариутгал, халдваргүйжүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэл, орон нутагт саадгүй нэвтрүүлэх” заалтыг тусгуулж шийдвэрлүүлсэн.

Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98.6 хувьтай байна. ЕРС-2 буюу Анхдагч технологийн байгууламжийн 17 барилга байгууламжаас 4 барилгын ухмалын ажил хийгдэж байна. Эдгээрт төв удирдлага, хяналтын барилга-93 хувь, “Дэд станц 1”-94.1 хувь, “Дэд станц 3”-96 хувь, “Дэд станц6”-71 хувь. Мөн нийт 41 ширхэг сав, резервуар барихаас түүхий тосны 3 савны ул бетон цутгалтын ажил, арматурчлал, ус тусгаарлалт буюу хар тосон түрлэг, буцаан дүүргэлтийн нягтруулалтын ажлууд үргэлжлэн хийгдэж байна. ЕРС-3 буюу үйлдвэрийн цахилгаан дэд станц №5, хяналтын өрөө, үйлдвэрийн шугам хоолойн эстакад зэргийн ухмал, хэв хашмал ба арматурчлалын ажил үргэлжлэн хийгдэж байна.

4.3.18.Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлнэ. Архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.

4.3.18.1.Согтууруулах ундааны эргэлт болон хэрэглээ, архидан согтуурлаас үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 54-д Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах, биеэ удирдан жолоодох чадваргүй болтлоо согтсон хүнд согтууруулах ундаа худалдан борлуулсан, эсхүл үйлчилснээс үүдэн гарсан хохирол, хор уршиг учирсан тохиолдолд тухайн хуулийн этгээдэд хариуцлага тооцдог байх, согтуурах донтой хүнийг эмчлэх, албадан эрүүлжүүлэх, согтууруулах ундаанаас үүдэлтэй хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх харилцааг

зохицуулах зорилгоор Архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/-ын төслийг боловсруулж 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийг 2021 оны 03 дугаар сарын 19-нд Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн. Согтууруулан ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн хуралдаанаар эцэслэн баталсан. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан.

4.4.1. Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авна.

4.4.1.1. Шүүх эрх мэдлийн байгууллагатай холбоотой хуулиудыг нэгтгэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төслийг батлуулна.

Биелэлт: Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тус яамнаас боловсруулж, 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

4.4.1.2. Иргэн болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/71 дүгээр тушаалаар Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай харьцуулсан судалгаа хийж, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан.

4.4.2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно.

4.4.2.1. Монгол Улсын цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгүүлсэн бөгөөд гадаад улс, орнуудын харьцуулсан судалгаа болон хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн. Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Хуулийн төслийг УИХ-аас байгуулсан Ажлын хэсгээс боловсруулахаар болсонтой холбогдуулан хуулийн төслийг нэгтгэсэн. Хуулийн төслийн эхний хувилбар, үзэл баримтлалын төслийг ажлын дэд хэсэг боловсруулсан.

4.4.2.2. Үндсэн Хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгүүлсэн бөгөөд гадаад улс, орнуудын харьцуулсан судалгаа болон хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн. Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Хуулийн төслийг УИХ-аас байгуулсан Ажлын хэсгээс боловсруулахаар болсонтой холбогдуулан хуулийн төслийг нэгтгэсэн. Хуулийн төслийн эхний хувилбар, үзэл баримтлалын төслийг ажлын дэд хэсэг боловсруулсан.

4.4.3. Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэнэ.

4.4.3.1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 67-д Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар тус хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд бэлтгэл хангах, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэг 2022 оны 05 дугаар сарын 10 болон 05 дугаар сарын 30 болон 6 дугаар сарын 23-ны өдрүүдэд хуралдсан.

4.4.3.2. Эрх зүйч, хууль сахиулагч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах тухайлсан хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 74-д Эрх зүйч, хууль сахиулагч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын тухай хуулийн төслийг 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд тус хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа хийж, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Эрх зүйч, хууль сахиулагч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын тухай хуулийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авахаар 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/1707 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн ХЭГ/1574 дугаартай албан бичгээр хуулийн төслийг буцаасан. ХЗДХС-ийн өгсөн чиглэлийн дагуу Ажлын хэсэг Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар холбогдох судалгаануудыг гүйцэтгэсэн.

4.4.4. Эх газрын эрх зүйн бүлийн хэв шинж, философид суурилсан Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн урт хугацааны “Эрх зүйн шинэтгэл II” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.4.4.1.2050 он хүртэлх Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлж эхлүүлнэ.

Биелэлт: “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр II”-ийг боловсруулах ажлын хэсгийг ХЗДХС-ийн тушаалаар байгуулж, ажлын хэсгийн хуралдаан 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулагдсан. Уг хөтөлбөрийн эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан, хуулийн төслийн хамт ЗГХЭГ-т хүргүүлсэн ба “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хамт Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тул тусдаа бие даасан хөтөлбөр гаргах шаардлагагүй болсон.

4.4.5.Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.4.5.1.Хууль зүйн туслалцааны тухай хуулийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 55-д Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд тус хуулийн төсөлд Төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх, өмгөөллийн үйлчилгээг зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчаар хязгаарлахгүйгээр хамрах хүрээг өргөжүүлэх зохицуулалтыг тусгасан. Хуулийн төслийг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэж, 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар эцэслэн баталсан.

4.4.5.2.Улсын өмгөөлөгчийн орон тоог гурав дахин нэмэгдүүлнэ.

Биелэлт: Хууль зүйн туслалцааны төв нийт 48-н орон тоотойгоос 52 улсын өмгөөлөгч ажиллаж байгаа ба тайлант хугацаанд 2292 эрүүгийн хэргийн 2293 төлбөрийн чадваргүй холбогдогчид үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн. Нийт хүлээн авсан эрүүгийн хэргээс шүүхээр 1348, шүүхийн өмнөх шатанд 87 хэргийг шийдвэрлүүлж, 298 хэргийг үйлчлүүлэгч төлбөрийн чадвартай нь тогтоогдсон болон бусад шалтгааны улмаас хүлээн авахаас татгалзан шийдвэрлэсэн байна. Эцэслэн шийдвэрлэгдээгүй 559 хэрэгт өмгөөллийн үнэ төлбөргүй үйлчилгээг үзүүлсэн. Шүүхийн шатанд болон шүүхийн өмнөх шатанд эцэслэн шийдвэрлүүлсэн 1435 эрүүгийн хэргээс хүнд 548, хөнгөн 887 хэрэг байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт улсын өмгөөлөгчийн орон тоог 2022 онд 50, 2023 онд 25, 2024 онд 25, нийт 100-аар нэмэгдүүлэхээр заасныг үндэслэн 2022 онд улсын өмгөөлөгчийн орон тоог тавиар

нэмэгдүүлэх, 2023 оны улсын төсвийн төсөөлөлд 75-аар тус тус нэмэгдүүлэхээр санал хүргүүлсэн боловч дэмжигдээгүй.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 7.4.6-д “хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/378 дугаар тушаалаар Хууль зүйн туслалцааны төвийн бүтэц, орон тоо, байршлыг баталсан. 2023 оны улсын төсөвт шинэчилсэн бүтэц, орон тоогоор санхүүжилт тусгагдаагүй учир хуучин бүтэц, орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

4.4.6. Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулан цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

4.4.6.1. Баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжсэн Арилжааны багц хууль болох Арилжааны хууль, Хэрэглэгчийн гэрээний тухай, Компанийн тухай, Хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдлийн тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай, Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай зэрэг хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Түүнчлэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын санаачилгыг дэмжих тухай, Гадаад худалдааны тухай, Аж үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 53-т Дампуурлын /Төлбөрийн чадваргүйдлийн/ тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд яамдаас санал авч нэгтгэн, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хүргүүлж, 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар, Улсын Их Хурлын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжин шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн Байнгын хороонд шилжүүлсэн.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл, Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хууль боловсруулах ажлын хэсгийг байгуулан төслийг боловсруулан холбогдох байгууллагаас саналыг авч, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Арилжааны хууль боловсруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, Шүүхээр шийдвэрлэгдсэн арилжааны хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх арилжааны гэрээний судалгаа, гадаад улсын арилжааны хуулийн харьцуулсан судалгаа, Монгол Улсын бизнес эрхлэгчдийн дунд тогтсон бизнесийн практик зан заншлын хэм хэмжээний тухай зэрэг нэмэлт судалгааг тус тус хийсэн. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг боловсруулсан.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ХЗДХС-ийн 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/376 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

4.4.6.2. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Патентын тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг боловсронгуй болгох оюуны өмчийн багц хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Оюуны өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах бүтэц, хүний нөөцийг бүрдүүлнэ.

Биелэлт: Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлуулсан. Оюуны өмчийн газар нь тус хуулиудын хэрэгжилтийн ханган ажиллаж байгаа.

4.4.6.3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, хуулийн хэрэгжилттэй холбогдуулан учирч буй хүндрэл, бэрхшээлийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг хамруулан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

ИХШХШТХ-д заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, Нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалт, Давж заалдах шатны шүүхийн хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэх зохицуулалтад тус тус хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалан гэр бүл цуцлуулах нэхэмжлэл гаргасан хохирогчийг маргаан дуусах хүртэл хамгаалалтад авах зохицуулалтын хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа, ИХШХШТХ дахь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны талаарх судалгааг ГИЗ-д захиалан хийлгүүлсэн. 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн.

4.4.7. Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.

4.4.7.1. Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг чангатгана.

Биелэлт: Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох байнгын ажиллагаатай ажлын хэсгийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх явцад учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас 2021 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 1/3542, 1/3543 тоот албан бичиг хүргүүлж санал авсан ба саналуудад дүн шинжилгээ хийж, хуулийн төслийг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ба 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн. Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 194 дүгээр захирамжийн дагуу нэн яаралтай Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг Авлига, албан тушаалтны эсрэг гэмт хэргийн ял, хариуцлагын чангатгаж, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хүний

бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд заасан арван зургаан нас хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн үндсэн, хүндрүүлэх бүрэлдэхүүнд оноосон ял, хариуцлагыг чангатгаж тусгасан.

4.4.7.2.Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулах харилцааг зааглан оновчтой тогтоож, зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг уян хатан зохицуулах зорилгоор Зөрчлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийт 37 байгууллагаас санал авч, хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тус хуулийн төслүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэн 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн. Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар тогтоолоор хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд бэлтгэл хангах, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэг байгуулагдсан ба Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр 500 гаруй хүний оролцоотой олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан ерөнхий ангид өөрчлөлт оруулсан үзэл баримтлалын шинжтэй томоохон өөрчлөлтийг тусган нэмэлт өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр УИХ-ын чуулганы хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн баталсан.

4.4.7.3.Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөн шалгах чиг үүрэг бүхий Мөрдөх албаны тогтолцоог боловсронгуй болгох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 87-д Шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бие даасан бүтэц бүхий мөрдөх албыг байгуулах, тогтолцоо, чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хяналт тавих, алба хаагчдын эрх зүйн байдлыг тодорхойлох зохицуулалт бүхий Мөрдөх албаны тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Мөрдөх албаны тухай хуулийг төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагатай тооцоо, судалгааг гүйцэтгэж байна.

4.4.7.4.Шүүхийн шинжилгээ хийхтэй холбогдон үүсэж буй харилцааг цогц байдлаар шийдвэрлэх, байгууллагын удирдлага, зохион байгуулалт, бүтэц, статусыг тодорхойлох, байгууллага болон шинжээч мэргэжилтний бие даасан, хараат бус байдлыг хангах, гадны нөлөөнд автахгүй байх, албан хаагчдын нийгэм, эдийн засаг, эрх зүй, аюулгүй байдлын баталгааг хангах тогтолцоог бүрдүүлэх Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, төслийн үзэл баримтлалыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2020 оны 09 дүгээр

сарын 09-ний өдрийн А/147 дугаар тушаалаар байгуулсан. Хуулийн төсөл, үзэл баримтлал, дагах хуулийн төслийг боловсруулан ажлын хэсгээс саналыг авч, нийт 6 удаагийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хуулийн төслийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн. Шүүх шинжилгээний тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд албан хаагчдын нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн баталгаа дээшилж, хөрөнгийн үнэлгээнд хийх шинжилгээ, инженер-техникийн шинжилгээ, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирол тооцох шинжилгээ, сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоох зэрэг шинжилгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн.

Хууль батлагдсантай холбогдуулан Монгол улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар тогтоолоор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүх шинжилгээний ерөнхий газар болсон ба ХЗДХС-ын 2023 оны А/10 дугаар тушаалаар Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Мөн Монгол улсын Засгийн газрын 2023 оны 182 дугаар тогтоолоор Дархан-Уул, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Дорнод аймгуудад бүсийн Шүүх шинжилгээний төвийг байгуулсан бөгөөд ерөнхий газрын даргын 2023 оны А/56 дүгээр тушаалаар Нийслэлийн шүүх шинжилгээний газар, хэлтэс болон Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс, хэсгийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, цолны зэрэглэлийг шинэчлэн баталсан.

4.4.7.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ял хариуцлагыг нэмэгдүүлэх, мансуурах донтой этгээдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 63-т Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулж, 2021 оны IV улиралд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийн хуралдаанаас гарсан саналыг нэгтгэн, хуулийн төслийн анхны хувилбарт тусгасан бөгөөд Ажлын хэсгийн хуралдааныг 2021 оны 10 дугаар сарын 25-нд зохион байгуулж, холбогдох байгууллагаас санал авахаар хэлэлцэв. ХЗДХС-ын 2023 оны А/386 дугаар тушаалаар Ажлын хэсгийг 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр, холбогдох яам, агентлаг, бусад байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан шинэчлэн байгуулсан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлгэхээр Хууль зүйн үндэсний хүрээлэнд захиалан хүргүүлээд байна. Цагдаагийн ерөнхий газраас 2019-2023 оны байдлаарх шаардлагатай мэдээлэл авахаар албан тоот хүргүүлж, хуулийн төсөлтэй холбогдох асуудлын чиглэлээр ажилладаг судлаач, ТББ-ын төлөөлөлтэй уулзсан. Бодлогын баримт бичигт судалгаа хийж, бодлогын баримт бичиг тусгасан холбогдох зорилтуудыг хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд нэмж тусган боловсруулалт хийсэн. Холбогдох Олон улсын гэрээ, зөвлөмж, стандарт, гадаад улс орнуудын сайн туршлагыг судалсан.

4.4.8. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.

4.4.8.1. Малыг нэгдсэн бүртгэлд бүртгэх, ялган тэмдэглэх хэрэгсэлтэй болгох, мал, малын гаралтай бүтээгдэхүүний худалдааны эргэлтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 71-д Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулж, 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан. Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээг хийж, хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад шаардлагатай 3 судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ХЗДХС-ын 2022 оны А/30 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж ажиллаж байна.

4.4.9. Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

4.4.9.1. Хууль тогтоомжийн тухай хуулийг боловсронгуй болгоно.

Биелэлт: Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбарыг боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлэн, 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1/4220 дугаар албан бичгээр яамд болон холбогдох байгууллагуудаас саналыг авч тусгасан. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх Сангийн сайдын зөвшөөрлийг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1/3975 дугаар албан бичгээр авсан. Хуулийн төслийг 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 1/5332 дугаар албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, тус хууль 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан.

4.4.9.2. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, санхүүжилт, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэн бэхжүүлнэ.

Биелэлт: ХЗДХ сайдын 2020.09.10-ны өдрийн А/158 тоот тушаалаар ХЗҮХ-ийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Эрх зүйн байдлын хувьд тодорхой болж, үндэсний хэмжээнд тэргүүлэх хууль зүйн судалгааны хүрээлэн болох зорилгоор Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-г Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/150 тоот тушаалын 11 дугаар хавсралтаар батлуулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ХЗҮХ-ийн төлөөлөл орж ажиллаж байна. Байгууллагын эрх зүйн үндсийг уг хуулиар зохицуулна. 2021-2022 онд эрдэм шинжилгээний ажилтны орон тоог 9-өөр нэмэгдүүлсэн нь хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, судалгааны ажлын чанарт эерэг нөлөө үзүүлсэн төдийгүй 2023 оны 3 дугаар сард Менторшип-2023 хөтөлбөрийг боловсруулж, эхний хагас жилд нийт 5 ментортой болсон байна.

4.4.9.3.Хууль зүйн үндэсний хүрээлэн болон их, дээд сургуулиудыг түшиглэн хөрш орнуудын арилжаа, худалдааны эрх зүйн хууль тогтоомжийг судалж, бүс нутгийн хэмжээнд эдгээр улсуудтай байгуулах аливаа гэрээ хэлэлцээрийг Монгол Улсын эрх ашигт нийцүүлнэ.

Биелэлт: 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Япон улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Бүгд Найрамдах Казахстан Улсын Хууль зүйн яамны харьяа Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар ажиллаж байна. ХЗДХС-ын 2020 оны А/158 тоот тушаалаар бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. ХЗҮХ нь ОХУ, БНХАУ-ын арилжаа, худалдааны хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хэрэгжүүлж байгаа бөгөөд БНХАУ-ын тухайн хүрээлэнтэй төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг цахимаар судалж, зарим судлаач, багш, мэргэжилтнүүдтэй харилцан санал солилцох хэлбэрээр тандан судалгаа хийсэн. Түүнчлэн БНХАУ-ын “Өвөр Монголын Их Сургууль”-ийн Хууль зүйн сургуультай санамж бичиг байгуулах бэлтгэл ажил хийж байна.

4.4.9.4.Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулж хөрөнгө оруулалт, бизнесийн эрх зүйн хууль тогтоомжийн албан бус орчуулгыг хийж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

Биелэлт: 2023 оны 04 дүгээр сарын байдлаар 90 хууль эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсанд байршсан байна.

4.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.

4.4.10.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 52-д Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулж, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийж, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, эхний хувилбарыг боловсруулан олон нийтээс санал авахаар 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр яамны сайтад байршуулж, тус /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хариуцан боловсруулахаар ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн. Дэд Ажлын хэсгийн хүрээнд 2 удаа хуулийн төслийн хэлэлцүүлэг хийсэн. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ЭЗБХ-ны ажлын хэсэгт орж ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсэг 2023 оны 02 дугаар сарын 03, 03 дугаар сарын 04-ны өдөр хуралдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийн хуралд 2023 оны 09 дүгээр сарын 16, 22, 27, 29, 30-ны өдрүүдэд хийгдэж, 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 1/5664 дугаар

албан бичгээр хуулийн төсөлд санал авахаар Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагууд руу хүргүүлсэн.

4.4.10.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.

Биелэлт: УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 4.1.19-т Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьж батлуулах, дагалдан гарах 3 журмын төслийг боловсруулан баталж мөрдүүлэх тухай зорилт, арга хэмжээ тусгагдан батлагдсан. Тус хуулийг даган 13 дүрэм, журам батлагдана гэж төлөвлөж байгаа бөгөөд үүнээс 9-ийг нь Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас, 4-ийг Засгийн газраас тус тус батлахаар хуулийн төсөлд тусгасан ба дээр дурдсан холбогдох журам, дүрмийн төслийг бусад хууль дүрэм журамтай уялдуулан боловсруулж бэлтгэсэн. Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Автомашин дуудлагын үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний тариф, зардлын норм, норматив болон төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгслийн нийтлэг жишгийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна.

“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд суудлын автомашин ашиглах нийтлэг журам”-ын төслийг боловсруулж, байгаа ба хуулийн шинэчлэл батлагдаагүй байгаа боловч төрийн өмчийн харилцааны зарим асуудлыг бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд өөрчлөн шинэчлэх, боловсронгуй болгож, хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажилласан. Тухайлбал, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн чиг үүргийг тодорхой болгосон. Мөн Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, 86 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ыг тус тус баталсан. Түүнчлэн, ТӨБЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал”-ыг батлав.

2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3 дахь заалтад 2023 оны 467 дугаар тогтоолоор: 2019 оны “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолд 2023 оны 468 дугаар тогтоолоор (дуудлагын худалдааны үнэ хаялцах доод хязгаарыг нэмэгдүүлсэн, дуудлагын худалдааны тайланг ирүүлэх маягтыг 5 дугаар хавсралтаар баталсан) тус тус нэмэлт өөрчлөлт оруулан үйл ажиллагаандаа мөрдөв.

4.4.10.3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ.

Биелэлт: Компанийн засаглалын олон улсын туршлага, сайн жишгийг судлах чиглэлээр Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь төлөөлөгчтэй уулзалт хийж, зөвлөмж, арга зүйн зөвлөгөө авч, холбогдох судалгаа мэдээллийг хүргүүлж, Дэлхийн банкны техникийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд,

үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр, засаглалыг сайжруулах загвар төслийг боловсруулсан. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Санхүү, эдийн засгийн их сургууль, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллаж, “Монгол шуудан” ХК (73%), “Монголын цахилгаан холбоо” ХК (62%), “Монголын төмөр зам” ТӨХК (59%), “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (60.5%), “Амгалан дулааны станц” ТӨХК (52.6%), “Хөдөө аж ахуйн бирж” ХХК (61.9%), “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК (84.6%) гэсэн нэр бүхий төрийн өмчит 7 компанийн засаглалын үнэлгээг хийлгэсэн. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 53.9 хувь байсан бол 64.8 хувьд хүрсэн үр дүнтэй байна.

Төрийн өмчит компанийн хууль, эрх зүйн орчин, өмчлөл, засаглалын бүтцийг сайжруулах, цахим шилжилт хийж компаниудын мэдээллийг цахим платформын хүрээнд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх талаарх зөвлөмж боловсруулах, туслалцаа үзүүлэх чиглэлээр Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас 2 шатны 5 төрлийн техникийн туслалцааг буцалтгүй тусламжийн хүрээнд авахаар ажиллаж байна. Төрийн өмчит 9 компанид хийсэн компанийн засаглалын үнэлгээ дунджаар 69.0 хувь байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, сонгон шалгаруулах, түүнд тавих шаардлага, хэрэгжүүлэх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилгын хүрээнд “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, “Төрийн өмчит хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ыг боловсруулж, ЗГ-ын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолоор батлуулсан. ТӨБЗГ-ын 2023 оны 174 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал”-ыг баталж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан.

4.4.10.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

Биелэлт: ТӨБЗГ-ын 2022 оны 307 дугаар тогтоолоор тогтоосон хувь хэмжээ, хуваарилалтын дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 44 хуулийн этгээдээс төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байна. 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар төрийн өмчийн ногдол ашгийн нийт 156.1 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. ТӨБЗГ-аас Хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлж буй 43 хуулийн этгээдийн 2023 оны ЭЗ-ийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон ХО-ын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулав. ТӨБЗГ-ын даргын 2023 оны 12 дугаар 01-ний өдрийн А/97 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 5 компани, төрийн өмчит 15 үйлдвэрийн газрын 2024 оны ЭЗ-ийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон ХО-ын төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлт боловсруулсан. Нэгдсэн санал, дүгнэлтийг ТӨБЗГ-ын 2023 он 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тухайн компани, үйлдвэрийн газрын 2024 оны зорилтот түвшин, ХО-ын төлөвлөгөөг баталсан. Төрийн өмчит компаниудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс харьяа төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын 2024 оны санхүүгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, ХО-ын төлөвлөгөөг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах, үнэлэх үйл ажиллагааг боловсронгуй

болгох, шийдвэр гаргалтын үйл ажиллагааг дүн шинжилгээнд үндэслэн шуурхай болгон цахимжуулах ажлыг эхлүүлж байна.

4.4.10.5. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 4.4.1-д төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийх, хяналт тавих тухай асуудал тусгагдсан бөгөөд шаардлагатай нийт 301.0 сая төгрөгийн төсөв 2022 оны улсын төсөвт тусгагдсан. Үүнээс 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 268.0 сая төгрөгийг тоног төхөөрөмж, программ хангамж, түүний зөвшөөрөл, томилолтын зардал, хэвлэлийн үйл ажиллагааны зардалд зарцуулаад байна. Төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл 33.0 сая төгрөг байна. Улсын үзлэг, тооллогын мэдээллийн системийн техник болон программ хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд нийт 29.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж, бүртгэл, дүн мэдээг нэгтгэх боломжийг бүрдүүлснээр төрийн болон орон нутгийн өмчийн 6,813 хуулийн этгээдийн улсын үзлэг, тооллогын дүн мэдээг хянан баталгаажуулах ажлыг хийж дууссан.

ТӨБЗГ-ын даргын 2023 оны “Албан томилолтоор ажиллуулах тухай” А/42 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 06 дугаар сарын 05-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд орон нутагт ажиллаж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2022 оны биелэлтийг дүгнэх, татан буугдсан МХЕГ-ын эзэмшиж байсан хөрөнгийн асуудалтай холбоотой ЗГ-ын 2023 оны “Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг газар дээр нь зохион байгуулсан. Ажлын хэсэг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт ажиллаж, уг гэрээний 2022 оны биелэлтийг дүгнэж, өмч хөрөнгийн байдалтай танилцан ажлын хэсгийн хүлээсэн үүрэг чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээг аван ажилласан. Төрийн өмчит 1026 хуулийн этгээдийн гэрээг дүгнэхээс хамрагдалт 98.5 хувь, гэрээний биелэлтийн улсын дундаж үнэлгээ 93.05 хувь байна. Гэрээний дүнгийн талаарх дүгнэлт, зөвлөмж, зөрчлийн жагсаалтыг ТӨБЗГ-ын 2023 оны 613 дугаар тогтоолоор баталгаажуулав. Уг тогтоолыг төрийн өмчит нийт хуулийн этгээдэд хүргүүлж, тогтоолыг хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан байна.

4.4.11. Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна.

4.4.11.1. Төр сүмийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан бөгөөд Үндэсний аюулгүй байдлын ажлын албанд 2019 оны 04 сарын 03-ны өдрийн 1-1/1437 дугаар албан бичгээр хүргүүлж, хуулийн төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах албан хаагчийн нэрийг хүргүүлээд байна. Төр сүмийн харилцааны тухай хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

4.4.11.2. Төрийн бус байгууллагын тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, Холбооны тухай, Сангийн тухай, Нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээгүй бөгөөд Сан, Холбооны тухай хуулийн төсөл болгох чиглэлийн дагуу төслийг боловсруулсан. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, төслүүдийн үзэл баримтлалыг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хурлаар УИХ-ын чуулганы нэгдсэн хурлаар хэлэлцэх эсэхийг дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн боловч МАН-ын бүлгээс завсарлага авсан.

Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх зорилгоор төрийн бус байгууллагатай “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг гаргасны дараа дээрх хуулийн төслийг хэлэлцүүлэхээр тохирсон. Үүний хүрээнд Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал, “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, төслийн үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Эдийн засгийн хөгжлийн сайдаар батлуулахаар хүргүүлээд байна.

4.4.11.3. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Биелэлт: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийг 2020 оны 02 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд хуралдуулж, 02 дугаар сарын 18-ны өдөр хуулийн төсөлд санал авахаар ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн.

4.4.12. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

4.4.12.1. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

Биелэлт: Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ХЗДХС-ын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/321 дүгээр тушаалаар байгуулагдсан. Цагдаагийн ерөнхий газраас шаардлагатай зарим асуудлаар эхний байдлаар хуулийн төсөл боловсруулж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг судалж, нууцын зэрэглэлтэй журмаас бусад хуулийн төслийг боловсруулж байна.

4.5.Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого. Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.

4.5.1.Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулна. Зорчих болон гадаад улсын виз авах нөхцөлийг хөнгөвчлөх (цахим виз, хилийн боомтод виз мэдүүлэх, авах) чиглэлээр ажиллана.

4.5.1.1.Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Хилийн чанадад 90-ээс дээш хоног оршин суугаа иргэдийг бүртгэх программыг боловсруулж, 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс нэвтрүүлж эхэлсэн ба иргэд www.citizen.gov.mn цахим хуудсанд хандан сайн дурын үндсэн дээр бүртгүүлж байна. Бүртгэлийн хэсгийг ГХЯ-ны шинээр нэвтрүүлсэн цахим хуудасны <http://mfa.gov.mn/overseas-missions-2> хэсэгт давхар холбон, Үндэсний дата төв, Үндэсний Статистикийн хорооны бүртгэлийн системд холбогдож байна. Засгийн газраас 2021 оны 4 дүгээр сард олгосон 300 мянган төгрөгийн дэмжлэгийг авах хүсэлтэй, хилийн чанадад байгаа Монгол иргэдийг “E-Mongolia”, “E-barimt” порталаар дамжуулан эрхээ эдлэх боломжийг шуурхай бүрдүүлж, иргэдийг бүртгэн, 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар гадаадаас 88,857 иргэн И-баримт хаягаар шинээр бүртгэл үүсгэж, мөнгөн дэмжлэгийг өөрийн дансаар хүлээн авсан ба 25,880 иргэн citizen.gov.mn хуудаст хандан бүртгэл хийлгэсэн байна. Хилийн чанадад байгаа иргэдийн 16 мянга гаруй нь насанд хүрээгүй хүүхэд тул И-баримт бүртгэлд шинээр хамрагдаагүй, эцэг эхийн аль нэгийн бүртгэлд нэгтгэгдэж, мөнгөн тусламж хүлээн авсан байна.

4.5.1.2.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, ААН-ийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгоно. Консулын албыг бэхжүүлж, бүтэц, орон тоог оновчтой хуваарилах замаар консулын төлөөлөл, үйлчилгээний хүртээмж, мэргэшсэн байдлыг сайжруулна.

Биелэлт: Гадаадад амьдарч байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах зорилгоор консулын төлөөлөл шинээр байгуулах, консулын албыг бэхжүүлэх асуудлаар хийсэн судалгаа, статистикт тулгуурлан Манжуур хотод Консулын газар, 2022 оны 3 дугаар сард Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод, Монгол Улсаас Австралийн Холбооны Улс, Монгол Улсаас Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Чех Улсад суугаа ЭСЯ-ны бүтцэд, Узбекистан Улсын Ташкентад, БНФУ-д суугаа ЭСЯ-нд Консулын хэлтэс байгуулах саналыг боловсруулж, Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 198 дугаар тогтоолоор батлуулав. 2021 онд хилийн чанадад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалахад анхаарч ажиллав. Нэн ялангуяа цар тахлын улмаас гадаад улсад гацсан монгол иргэдийг эх оронд нь ирүүлэх, тухайн улсын эрх бүхий байгууллага, цагаачлалын албанд хандан визийн хугацааг нь сунгуулах, торгууль төлбөрөөс чөлөөлүүлэх талаар ДТГ-уудыг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангаж ажилласан. Цар тахлын хугацаанд манай иргэд, ААН-үүд цахим худалдааны залилан гэх мэт гэмт хэрэгт өртөх явдал нэмэгдсэнтэй холбогдуулан асуудлыг айлын талд уламжлан шийдвэрлүүлэх, иргэд, олон нийтэд хандан Консулын газраас сэрэмжлүүлэг нийтлэх ажлыг хэрэгжүүлэв. Засгийн газрын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хилийн чанад дахь 16 Дипломат төлөөлөгчийн газар тус бүр 1-2, нийт 22 орон тоог нэмэгдүүлэн батлуулав.

4.5.1.3.Хилийн чанадад зорчиж буй иргэд, ААН-д нэн шаардлагатай мэдээ, мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлгийг шуурхай хүргэх, хувийн хариуцлагыг нь нэмэгдүүлэх “Хариуцлагатай аялцагая” аяны цар хүрээг өргөжүүлж, сурталчилгаа, мэдээллийг эрчимжүүлнэ.

Биелэлт: Хилийн чанадад зорчих болон “Ковид-19” цар тахлын улмаас гадаадад гацсан, эх нутагтаа ирэх хүсэлтэй иргэдэд мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлэг хүргэх үүднээс www.consul.mn цахим хуудсыг тухай бүр баяжуулж, Монгол, Англи хэлээр нийт 55 хэсэгт 140 гаруй мэдээ байршуулав. 2022 оны эхний 11 сарын байдлаар монгол, англи хэлээр нийт 98 мэдээ байршуулав. 2023 оны байдлаар монгол, англи хэлээр нийт 85 мэдээ, зөвлөмжийг байршуулав. 2021 онд цахим хуудаст 28,900, 2022 онд 210,000 орчим хандалт бүртгэгдсэн. Гадаад улсад зорчиж яваад нутаг буцах боломжгүй болсон иргэдийн өргөдлийг хүлээн авах, заавар, зөвлөмж өгөх хүрээнд нийт ДТГ-ын Facebook хаяг, шуурхай утсыг нээлттэй байршуулсан. Иргэдийн зорчих хөдөлгөөнийг сэргээх хүрээнд “Ковид-19”-ийн вакцинд бүрэн хамрагдсан болон PCR, IgM шинжилгээний дүн бүхий лавлагааг харилцан хүлээн зөвшөөрөх тухай БНХАУ-ын саналын дагуу 2021 оны 4 дүгээр сард дотоодын байгууллагын Ажлын хэсгийг байгуулж, вакцинд хамрагдсаныг нотлох “Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ”-ний загварыг боловсруулсан. Иргэний овог нэр, регистрийн болон паспортын дугаар, PCR шинжилгээний хариу, вакцины нэр, тун, огноо зэрэг мэдээллийг агуулсан гэрчилгээг “E-Mongolia” цахим систем, “ТҮЦ” машинаас 3-5 минутад хэвлэн авах боломжтой болов. Гэрчилгээний загварыг дипломат шугамаар гадаад улсуудад мэдэгдэж, гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх ажлыг хэрэгжүүлэв. Иргэдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийг ЦЕГ, ОУШХБ-тай хамтран түгээж ажилласан.

4.5.1.4.Хилийн чанадад байгаа иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар үзүүлнэ. Үүнд: Нотариатын болон Апостиль гэрчилгээний үйлчилгээг цахимжуулах, бусад үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэх, www.consul.mn цахим хуудсыг өргөжүүлж гар утас, таблетад зориулсан хувилбар хөгжүүлнэ. Төрийн үйлчилгээний хураамжийг жигд, уян хатан, тодорхой болгох, чирэгдлийг багасгах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэн мөрдөж ажиллана.

Биелэлт: Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системийг нэвтрүүлж, Европын 32 улс болон Австрали, Шинэ Зеланд, БНСУ, БНХАУ гэсэн 36 улсын иргэнд цахим виз олгож байгаа бөгөөд цахим визийн загвар, тодорхойлолт, улсын жагсаалтыг Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталж, Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ICAO), гадаадын улс орнуудад дипломат шугамаар хүргүүлсэн. Цахим визээр анхны гадаад зорчигч 10 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсад зорчин ирсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус системээр гадаадын 94 иргэн цахим виз мэдүүлснээс 88 иргэнд зохих журмын дагуу виз олгосон. 2022 оны 1-11 дүгээр сард нийт 36 улсын 7281 иргэнд виз олгосон.

“E-Mongolia” платформын нүүр хуудаст “Гадаадад байгаа монгол иргэн” гэсэн хэсэгт шинэ цэс нэмж, 40 төрлийн үйлчилгээний холбоосыг 2021 оны 03 дугаар сарын 19-нд байршуулав. www.consul.mn цахим хуудасны хэрэглээг өргөжүүлэн, гар утас, таблетад зориулсан хувилбарыг нэвтрүүлэв. ДТГ-уудад цахим нотариатын үйлчилгээ нэвтрүүлэх тухай гэрээг ГХЯ, Монголын нотариатчидын танхим хооронд 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгуулж, 16 сая төгрөгийн зардлыг Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас санхүүжүүлэн, програмын хөгжүүлэлт туршилтыг хийж байна. ГХЯ-аас консулын үйлчилгээ авч буй иргэдийн төлбөрийг “Гэрэгэ” киоскоор дамжуулан авч, “Монгол шуудан”, KGB tegbe шуудан хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлж, иргэдийн ачаалал, бөөгнөрлийг бууруулан цар тахлын халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэв. “Цахим

Апостиль” санг 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлж, компьютер, өндөр хурдны сканерыг ашиглан цахим архивыг бүрдүүлэн ажиллаж байна.

“Цахим нотариат” системийг нийт ДТГ-т нэвтрүүлэх хүрээнд ГХЯ, Монголын нотариатчидын танхим, Интерактив ХХК-ийн хурлыг 8 удаа зохион байгуулсан. “Цахим нотариат” системийн ашиглалт, хөгжүүлэлтийн тухай ГХЯ, Монголын Нотариатчидын Танхим хоорондын гэрээг 2023 оны 05 дугаар 30-ны өдөр байгуулсан. Тус системд шууд холбогдох эрх бүхий 49 ДТГ-ын 92 ажилтны хувийн мэдээлэл, интернэт хаягийн IP бүртгэлийг нэгтгэж, Монголын нотариатчидын танхим, Гадаад улсад сурч, ажиллан амьдарч буй иргэдэд төрийн үйлчилгээг хурдан, шуурхай үзүүлэх хүрээнд хилийн чанадад суугаа ДТГ-уудад “Хур Дан” цэгийг байгуулж байгаа бөгөөд холбогдох төхөөрөмжүүдийг үе шаттайгаар хүргүүлж байна. Эхний ээлжид 19 ДТГ-т цэгийг байгуулсан, үлдсэн 27 ДТГ-т тоног төхөөрөмжийг үе шаттайгаар дипломат шуудангаар хүргүүлж байна. Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан, шуурхай үзүүлэх хүрээнд хилийн чанадад суугаа ДТГ-уудын ажилтнуудад “E-Mongolia” цахим системд оператор эрхээр нэвтрэх эрх олгож байгаа бөгөөд холбогдох төхөөрөмжүүдийг үе шаттайгаар хүргүүлж байна. Эхний ээлжид 10 газарт байгуулаад байна.

4.5.1.5. “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-гийн хөрөнгийг нэмэгдүүлж, гадаад улсад аюултай нөхцөл байдалд өртсөн иргэдэд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, монгол иргэдийн холбогдсон, үйлдсэн гэмт хэргийг бууруулах талаар гадаад, дотоодын хууль хяналтын байгууллагуудтай мэдээлэл солилцож, хамтран ажиллана.

Биелэлт: 2021 онд 5 удаагийн хурлаар 56 өргөдөл, хүсэлтэд нийт 188.8 сая төгрөгийн, 2022 онд 5 удаагийн хурлаар нийт 51 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 185.3 сая төгрөгийн, 2023 онд 4 удаа хуралдаж, хилийн чанадад нас барсан болон журмын дүрмийн заалтад нийцсэн 130 иргэний асуудлыг шийдвэрлэж 310.4 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. 2023 оны эхний 11 сарын байдлаар Хилийн чанадад 375 иргэн гэмт хэрэгт холбогдон саатуулагдаж, 109 иргэн нас барж, 155 иргэн ял эдэлж байна. Монгол Улс Эрүүгийн ял шийтгэлийг гадаад улсад эдлүүлэх тухай Америкийн улсууд хоорондын конвенц нь Монгол Улсын хувьд 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс, Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, БНКУ хоорондын 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай протокол 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс, Ханой хотноо 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гарын үсэг зурсан “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, БНВУ хоорондын гэрээ” 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс, Улаанбаатар хотноо 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, БНВУ хоорондын гэрээ” 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс, Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчин төгөлдөр үйлчилж эхлэв.

Зүүн Өмнөд Азийн орнууд, Европын зарим улсад хүн худалдаалах гэмт хэрэг, цахим залилан, хөдөлмөрийн мөлжлөгийн гэмт хэрэгт манай улсын иргэд олноор өртөж буй тул таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр ГХЯ, ХЗДХЯ, ТЕГ, ЦЕГ, “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-ын хамтарсан уулзалтыг 2023.06.06-ны өдөр зохион байгуулж, зарим асуудлыг шийдвэрлэв. Газын зурваст үүсээд буй нөхцөл байдалтай холбогдуулан 2023.10.09-ний Гадаад харилцааны сайдын тушаалаар ГХЯ-нд ажлын хэсэг байгуулагдан, “Израилд оршин суугаа Монгол иргэдийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө”-г баталсан.

4.5.1.6. Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулна. Зорчих болон гадаад улсын виз авах нөхцөлийг хөнгөвчлөх (цахим виз, хилийн боомтод виз мэдүүлэх, авах) чиглэлээр ажиллана.

Биелэлт: Бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжив. Мальдив, Доминикан, АНЭУ-тай бүх төрлийн паспортыг визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, уг хэлэлцээрийг байгуулах дотоодын процедураа эхлүүлээд байна. Монгол Улсын цахим визийн системийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс амжилттай нэвтрүүлсэн бөгөөд 2022 оны байдлаар 36 улсын 7284 иргэнд цахим виз олгов. БНСУ-ын иргэдийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлөх асуудлыг ЗГ-ын 2022 оны 5 дугаар сарын 178 дугаар тогтоолоор батлуулав. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар он гарснаас хойш Визийн шаардлагаас харилцан чөлөөлөх Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Мальдив, Португал, Вьетнам зэрэг улстай байгуулсан. Өдгөө Португал, Мальдив, Вьетнам зэрэг улстай байгуулсан хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгохоор шуурхайлан ажиллаж байна.

“Дипломат болон албан/тусгай паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Засгийн газар, Бүгд Найрамдах Мозамбик Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Мозамбикийн талтай эцэслэн тохиролцож хэлэлцээрийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны Засгийн газрын хуралдаанаар дэмжсэн. “Дипломат, албан паспорт бүхий иргэд харилцан визгүй зорчих тухай Засгийн газар, Чех, Словак Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Монгол, Чех Улсын албан /сервис/ паспорт эзэмшигч иргэдийн харилцан визгүй зорчих нөхцөлийг Чехийн талтай ноот бичиг солилцох замаар 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс сэргээв. 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Арабын Нэгдсэн Эмират Улсын Ерөнхийлөгчтэй хийсэн уулзалтын хүрээнд “Дипломат, албан/тусгай, сервис болон энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Засгийн газар, АНЭУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т талууд гарын үсэг зурав. “Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг манай талаас боловсруулж, Өмнөд Африк, Бутан, Тажикстаны талд хүргүүлсэн.

4.5.1.7. Аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг дэмжих ажлын хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын виз олгох журмыг шинэчлэн батлуулах зэргээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Монгол Улсын виз олгох үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан цахим визийн систем нэвтрүүлэх, мөн виз мэдүүлгийн төвийг хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах зэрэг шинэлэг арга хэлбэрийг бий болгоно.

Биелэлт: УИХ-аас Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-нд өөрчлөлт оруулан баталсан. Уг хуулиар Монгол Улсын цахим виз, хилийн боомтод олгох виз, виз мэдүүлгийн төвийг нээх зэрэг виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх эрх зүйн зохицуулалт тусгагдсан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгүүдийн төслийг боловсруулах, цахим визийн систем нэвтрүүлэх бэлтгэлийг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 63 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг “Монгол Улсын цахим визийн систем” нэвтрүүлэх ААН-ийг сонгон шалгаруулж, ГХЯ-нд эрх олгосны дагуу гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, идэвхтэй хамтран ажиллаж Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системийн бүрэн хувилбарыг 2021 оны 10 дугаар сарын

01-ний өдрөөс амжилттай нэвтрүүлсэн. Уг системээр нэн тэргүүнд Европын орнууд, Австрали, Шинэ Зеланд, БНСУ, БНХАУ зэрэг 36 улсын 7281 иргэнд цахим виз олгохоор шийдвэрлэж, 2023 оны эхний 11 сарын байдлаар нийт 74 улсын 28420 иргэн виз мэдүүлж зохих ангиллын виз аваад байна. Ажлын хэсэг Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар 4 журмыг шинээр баталж, Монгол Улсын цахим визийн системд голлох зорилтот улсууд хамрагдсаныг харгалзан, хилийн чанадад Монгол Улсын визийн төв байгуулах ажлыг түр хойшлуулсан болно. 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан гадаадын өндөр хөгжилтэй 34 улсыг визээс чөлөөлөх шийдвэрийг 2023 оны 1 дүгээр сард, 99 улсыг цахим визийн системд хамруулах шийдвэрийг 2 дугаар сард гаргасныг Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага, гадаад улсуудад дипломат шугамаар мэдэгдсэн.

4.5.2. Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.

4.5.2.1. Үйлдвэрлэл-худалдаа-хөрөнгө оруулалтын цогц бодлогыг дэмжихэд чиглэсэн “Төрөөс гадаад худалдааны талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг боловсруулж, батлуулна.

Биелэлт: Гадаад харилцааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын 2020 оны А/50, А/375 тоот хамтарсан тушаалаар Монгол Улсын Гадаад худалдааны бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоол, Засгийн газрын 314 дүгээр тогтоол, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 55 дугаар тэмдэглэлээр хүчин төгөлдөр мөрдөж байсан төрөөс баримтлах бодлогын 200 гаруй баримт, хөтөлбөрийг хүчингүй болгож, “Төрөөс гадаад худалдааны талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

4.5.2.2. “Монгол экспорт” арга хэмжээг /2019-2022/ хэрэгжүүлж дуусгана. Экспортыг дэмжих, төрөлжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын судалгаа, маркетингийг төрөөс дэмжинэ.

Биелэлт: Монголд үйлдвэрлэсэн экспортын бараа бүтээгдэхүүнийг Европын холбооны иргэд, бизнес эрхлэгчдэд сурталчлах зорилго бүхий МХДТ-ийн нээлт Берлин хотноо 2021 оны 8 дугаар сарын 07-ны өдөр болов. ЗГҮАХ, МУ-г хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх асуудал хариуцдаг Экспортыг дэмжих зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын тогтолцоог боловсронгуй болгож, “нэг цонх”-ны зарчмаар хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллав. Монголын ноос, ноолуурын холбооны санаачилгаар “Ноос, ноолуурын экспортыг нэмэгдүүлэх” талаар гадаадад суугаа зарим Дипломат төлөөлөгчдийн газартай санал солилцох цахим уулзалтыг 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулав. Түүнчлэн хурлаас гаргасан шийдвэр, илтгэх хуудас, “Монгол экспорт хөтөлбөр”-ийн II үе шатны төлөвлөгөө батлуулан ажиллав. 2021 оны 12 дугаар сарын гаалийн статистик мэдээгээр уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 1731.1 сая ам.долларт хүрч, нийт экспортын 18.7 хувийг эзэлж байгаа нь түүхэн дээд үзүүлэлт юм. “Монгол экспорт хөтөлбөр”-ийн II үе шатны төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилт 81.9 хувьтай байна.

4.5.2.3.Худалдаанд тулгарч байгаа хүндрэлийг багасгах зорилгоор гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан байгуулж, гадаад худалдаатай холбоотой бүх мэдээллийг түргэн шуурхай, нэг цэгээс авах боломжийг бүрдүүлнэ. Цаасгүй худалдаа, цахим худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажиллана.

Биелэлт: Дэлхийн банкны Олон улсын санхүүгийн корпорацын дэмжлэгтэйгээр “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” цахим хуудсыг 2020 оны 12 дугаар сард ашиглалтад оруулж, цахим хуудсыг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангасан. “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг УИХ 2022 оны 4 дүгээр сарын 28-нд баталж, батламж жуух бичгийг зохих журмын дагуу хэлэлцээрийн эх хадгалагчид хүргүүлж, улмаар тус хэлэлцээр 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улсын цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээний тайланг танилцуулах зорилготой “Хөгжлийн түншүүдтэй дугуй ширээний уулзалт” болон “Цахим худалдааны тайлангийн нээлт” арга хэмжээг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) хамтран 2023 оны 6 дугаар сарын 7-8-ны өдөр тус тус зохион байгуулж, олон улсын байгууллага болон гадаад улсаас Монгол Улсад суугаа ДТГ, монголын талын Ажлын хэсэг болон төр, хувийн хэвшлийн 100 гаруй төлөөлөл оролцов. Монгол Улс тус үнэлгээг хийлгэснээр Засгийн газрын “Цахим үндэстэн” болох бодлогыг хэрэгжүүлэх, дижитал эдийн засаг, цахим худалдааг хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой ба тайланг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-ын албан ёсны цахим хуудаснаа англи, монгол хэлээр нийтлүүлэв. <https://unctad.org/news/mountainous-mongolia-eyes-e-commerce-diversify-its-economy>

Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны ерөнхий хэлэлцээрийн Зөвлөл, Байнгын хорооны хоёрдугаар хуралдаанд Монгол Улсын төлөөлөл энэ оны 6 дугаар сард оролцож, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаярыг Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны ерөнхий хэлэлцээрийн Зөвлөлийн гишүүнээр сонгов. 2023 оны эхний 9 сарын дүнгээр МУ-ын гадаад худалдааны нийт бараа эргэлт 18 тэрбум ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 2.77 тэрбум ам.доллар буюу 18.2 хувиар өссөн байна. Экспортод 11.29 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.6 хувиар өссөн байна. Импортоор нийт 6.75 тэрбум ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2022 оны мөн үеэс 6.3 хувиар өссөн байна.

4.5.2.4.Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үр ашгийн судалгаа хийнэ. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /АПТА-2019 онд нэгдэн орсон/-ийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана. Хэлэлцээрийн гишүүн улс орнуудад Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрүүлэх, хөнгөлөлтийн жагсаалтад багтсан бараа бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчдэд сурталчлан таниулах, тухайн зах зээлд нийцүүлэн үйлдвэрлэх зэргээр зах зээлээ тэлж, экспортын барааны нэр төрлийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Монгол Улс, ЕАЭЗХ хооронд чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах боломжийн талаар санал солилцох уулзалт хийв. Экспортын гол нэрийн мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолууран бүтээгдэхүүн, арьс шир, савхин бүтээгдэхүүн зэрэг гурван нэр төрлийн барааг Дорнын эдийн засгийн VIII чуулга уулзалтад оролцох үеэрээ Засгийн газрын орлогч дарга А.Л.Оверчуктай 2023 оны 9 дүгээр сарын 11-нд хийсэн уулзалтын үеэр “ЕЭЗХ, Ираны хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад чиглэсэн түр хэлэлцээр”-тэй ижил төстэй түр хэлэлцээрийг Монгол Улс, ЕЭЗХ хооронд байгуулах боломжийг хамтран судлах тохиролцоонд хүрсэн. АНДХХ-ийг хэрэгжүүлж эхэлснээр нийт гэрчилгээний 89% нь БНХАУ-д, 11% нь БНСУ-д хийгдсэн экспорт эзэлж байна. Ази, Номхон

Далайн Худалдааны Хэлэлцээр (АПТА)-ийн хүрээнд хийсэн манай нийт худалдааны эргэлт 2021-2023 оны 9-р сарын байдлаар 205 сая.ам долларт хүрсэн. Үүний 191.2 сая ам доллар буюу 93.2% нь хөнгөлөлт эдэлсэн экспорт, 13.9 сая.ам доллар буюу 6.8% нь хөнгөлөлт олгосон импортод ногдож байна. АПТА гэрчилгээг авсан экспортлогчийн тоо 28, импортлогчийн тоо 1 болсон байна.

4.5.3.Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ.

4.5.3.1.Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах саналыг холбогдох улсуудад шат дараатай тавьж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2020 онд нэгдэж, 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой хэлэлцээрийн тав дахь нэмэлт өөрчлөлтөд Монголын талаас баримтлах байр суурийг тодорхойлсон. Дэлхийн худалдааг хөнгөвчлөх Үндэсний хорооны 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн VI хуралдаанд оролцож, Монгол Улсад Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр олон улсын донор байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн танилцуулга, тэдний уялдаа холбоог сайжруулах болон Монгол Улсын тээвэр зууч, логистикийн салбарынханд тулгарч буй асуудлуудын талаар санал өгч ажилласан. Дэлхийн худалдааны байгууллагаас 2021 оны 3 дугаар сарын 17-19-ний өдөр Монгол Улсын худалдааны бодлогыг хянан хэлэлцсэн хуралд оролцож, Монгол, Орос, Хятадын ЭЗ-ийн коридор байгуулах хөтөлбөрийн хүрээнд ТЗ-ын төв коридорыг шинэчлэх хамтарсан мэдэгдэл, ажлын төлөвлөгөөний төслийг тохиролцов. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд АНЗ замнал дагуух Алтанбулаг-УБ-Замын Үүд чиглэлийн хурдны автозамын ТЭЗҮ-ийг ОУ-ын хөрөнгө оруулагчдад танилцуулж, хөрөнгө оруулалт татах чиглэлээр уулзалтуудыг хийв.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр БНСУ-д айлчлах үеэр БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлэх талаар хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурж, “Монгол-Солонгосын бизнес форум”-ыг зохион байгуулав. Форумд монголын талаас 60 компанийн 80 гаруй төлөөлөгч, БНСУ-ын талаас 140 гаруй төлөөлөгч оролцов. Польш Улсын Ерөнхийлөгч Монголд хийсэн айлчлалын хүрээнд Монгол-Польшийн бизнес форумыг 2023 оны 4 дүгээр 25-нд зохион байгуулав. МҮХАҮТ, Бизнесийн зөвлөл, Польшийн Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулав. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-д хийсэн айлчлалын хүрээнд МҮХАҮТ, БНХАУ-ын Олон улсын худалдааг дэмжих хороо хамтран “Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа” форумыг Бээжин хотноо 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулав. Форумд манай талаас 90 гаруй компанийн 130 гаруй төлөөлөгч, Хятадын талаас 350 орчим бизнес эрхлэгч оролцож, нийт 2.2 тэрбум ам.долларын мөнгөн дүнтэй 25 гэрээ, санамж бичгийг үзэглэв.

“Монголын эдийн засгийн чуулга-2023” арга хэмжээгээр Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны талаар сурталчлан, хөрөнгө оруулагч нарыг татахаар төлөвлөн 2023 оны 07 дугаар сард зохион байгуулагдсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Улаанбаатар хотноо 2023 оны 06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд “Дэлхийн экспортыг дэмжих чуулга уулзалт”-ыг зохион байгуулж гадаад, дотоодын 500-600 гаруй төлөөлөгчдийг оролцуулсан.Хамтын ажиллагааны тухай МУ-ын Хөрөнгө оруулалт, худалдааны газар болон Киргиз Улсын Үндэсний хөрөнгө оруулалтын агентлаг хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг 2023.10.24-нд байгуулав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Франц Улсад 2023 оны 10 дугаар сарын 10-14-нд хийсэн айлчлалын үеэр “Засгийн газар

болон Франц Улсын Орано Майнинг хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээний протокол"-ыг байгуулсан. Энэ ажлын хүрээнд Гадаад харилцааны яамнаас 2023 онд БНСУ, БНЭУ, Вьетнам, Тайландын Хаант Улсуудтай байгуулах Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрт санал авах бичгийг ирүүлснийг судалж, хариу өгөх, эрчимжүүлэх ажлууд хийгдэж байна.

4.5.3.2. Санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй болон шинээр хэрэгжүүлэх МЕГА төслийг сурталчлах, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулагчид, гадаад улс, олон улсын банк санхүү, хөгжлийн байгууллагатай хамтран ажиллана.

Биелэлт: Монголд үйлдвэрлэсэн экспортын бараа бүтээгдэхүүнийг Европын холбооны иргэд, бизнес эрхлэгчдэд сурталчлах зорилго бүхий МХДТ-ийн нээлт Берлин хотноо 2021 оны 8 дугаар сарын 07-нд болов.

Монгол Улсын дунд хугацааны бодлогод тусгасан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх асуудал хариуцдаг Экспортыг дэмжих зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын тогтолцоог боловсронгуй болгож, “нэг цонх”-ны зарчмаар хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллав.

4.5.3.3. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх цогц механизмыг бүрдүүлнэ.

Биелэлт: Хөрөнгө оруулалтын тухай шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудал хариуцсан зөвлөлийн эрх үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон төрийн байгууллагуудаас хөрөнгө оруулагчдын гомдол, маргааныг шуурхай шийдвэрлэх талаар тусгах арга хэмжээний зохицуулалтыг шинээр тусгасан.

Засгийн газар 2022 оны 11 сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол баталсан. Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар уул уурхай, газрын тос, иргэний агаарын тээвэр болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай 5 аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдлыг танилцуулж 160 дугаар тогтоолоор судалж, хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхийг, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар уул уурхай, газрын тос, хүнс, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 6 аж ахуйн нэгжээс ирсэн гомдлыг танилцуулж 413 дугаар тогтоолоор хууль журмын дагуу судлан, арга хэмжээ авахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосон.

4.5.3.4. Дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, сурталчлах чиглэлээр арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

Биелэлт: 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр “Invest in Mongolia-Tokyo 2021” бизнес форум арга хэмжээг Японы Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага /JETRO/, Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ, Олон Улсын Санхүүгийн Корпорац (IFC), Ирбис Венчурс компанитай хамтран “Invest in Mongolia-Tokyo 2021” Монгол-Японы бизнес

форумыг цахимаар зохион байгуулж, Японы талаас 340 гаруй, Монголын талаас 50 гаруй нийт 400 гаруй төлөөлөгч оролцсон.

Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо “ЭКСПО Дубай-2020” арга хэмжээний хүрээнд “Монгол Улсын Үндэсний өдөрлөг”-т Монгол Улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх “Монгол-АНЭУ-ын бизнес форум”-д Үндэсний хөгжлийн газраас хөрөнгө оруулалтын орчны талаарх илтгэлийг хүргүүлэн танилцуулсан.

Засгийн газраас Европын сэргээн босголт, хөгжлийн банканд хүсэлт гаргасны дагуу “Ногоон хөрөнгө оруулалт”-ын төслүүдийг шинжлэн тодорхойлох, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах техникийн хамтын ажиллагааны (ТХА) төслийг 2022 оны 3 дугаар сараас, Монгол Улсын тогтвортой хөгжлийн өсөлтийг хангах хөрөнгө оруулагчийн зураглал боловсруулах судалгааг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран 2022 оны 5 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна.

Америкийн Нэгдсэн Улсад 2022 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 09 дүгээр сарын 05-ны өдрүүдэд “Монголын худалдаа, хөрөнгө оруулалт, өв соёлын чуулган”-нд оролцож, Шинэ сэргэлтийн бодлогын хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслүүдийг сурталчлах ажлыг хийсэн. Монгол дахь Америкийн худалдааны танхимаас 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдөр гишүүн байгууллагууд, хөрөнгө оруулагч нартай цаг үеийн асуудлаар хийсэн уулзалтад “Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт ба санхүүжилт” сэдвээр илтгэл танилцуулж, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн шатны 61 төсөл болон эх үүсвэр шаардлагатай 33 төслийн талаар мэдээлэл хүргэсэн.

БНСУ-ын Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг (KOTRA)-тай хамтран “Global Project Plaza 2022” ногоон, тогтвортой бизнесийг дэмжсэн 2022 оны 5 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулсан арга хэмжээнд Шинэ Сэргэлтийн Бодлогын төслүүдийг танилцуулсан.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Засгийн газар, Олон улсын худалдааны төвтэй хамтран “Дэлхийн экспортыг дэмжих чуулга уулзалт”-ыг 2023 оны 06 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Тус чуулга уулзалтад 70 орчим улс орноос 600 гаруй төлөөлөгчид оролцсон.

4.5.3.5. Гадаадын хөрөнгө оруулалтын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагааг бэхжүүлж, “Цахим нэг цонхны үйлчилгээ” нэвтрүүлж, хөгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газраас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг” төслийн хүрээнд “Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн систем www.e-invest.mn цахим системийг нэвтрүүлж, 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хөрөнгө оруулагчийн тодорхойлолтыг олгож эхэлсэн. Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “Цахим нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан гадаадын хөрөнгө оруулагчдад мэдээ, мэдээлэл өгөхөөс гадна, төрийн 7 байгууллага 17 үйлчилгээг үзүүлж байна.

4.5.4. Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, хүмүүнлэг зэрэг бүх салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.

4.5.4.1. ОХУ, БНХАУ-тай дээд, өндөр түвшний харилцан айлчлал, хамтын ажиллагааны механизмуудын уулзалтыг тогтмолжуулна.

Биелэлт: ОХУ, БНХАУ-тай дээд, өндөр түвшний харилцан айлчлал, хамтын ажиллагааг тогтмолжуулах хүрээнд санаачилга гарган ажилласан зарим онцлог ажлаас дурдвал:

- Монгол, Хятадын эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны зөвлөлийн III хуралдааныг 10 дугаар сард, Монгол-Хятадын ЗГХК-ын Ажлын хэсгийн хуралдаан болон Монгол, БНХАУ-ын ГХЯ-д хоорондын Стратегийн яриа хэлэлцээний ээлжит цахим уулзалтыг 12 дугаар сард тус тус зохион байгуулав;
- Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Дорнын эдийн засгийн VII уулзалтад оролцох үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтэй уулзаж, “Газпром”, “Роснефть”, “Оросын төмөр замууд”, “Газпромбанк”, “Роскосмос” компанийн тэргүүн нартай уулзав. Үүний дүнгээр АИ-92 бензинийг ОХУ-аас 2027 он хүртэл хөнгөлөлттэй үнээр авахаар тохиролцов;
- Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 2 дугаар сарын 03-08-нд БНХАУ-д айлчилж, БНХАУ-ын Дарга Ши Жиньпин, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчян, ХКН-ын Төв хорооны Гадаад харилцааны газрын дарга Сун Тао нартай уулзав. Айлчлалын хүрээнд эдийн засгийн чухал ач холбогдолтой 5 баримт бичигт гарын үсэг зурж, “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хоёр улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталсан тухай батламжлах жуух бичгийг солилцов.

4.5.4.2. ОХУ-тай худалдааны алдагдлыг бууруулж, БНХАУ-тай экспортын хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Монгол-Оросын худалдааны хэмжээ 2 тэрбум 31 сая ам.доллар, үүнээс импорт 1.9 тэрбум ам.доллар, экспорт 90 сая ам.доллар, худалдааны тэнцэл-1.85 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан. Сүүлийн 3 жилийн экспортын байдал сая ам.доллаар: 2019 онд 68.0, 2020 онд 57.3, 2021 онд 112.8, 2022 оны эхний 10 сарын байдлаар 2.1 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 46 хувиар өссөн.

Монгол-Хятадын худалдааны хэмжээ 14.37 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 11.32 тэрбум ам.доллар, импорт 3.05 тэрбум ам.доллар, худалдааны тэнцэл 8.27 тэрбум ам.долларын ашигтай байна.

4.5.4.3. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг урагшлуулна.

Биелэлт: “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т туссан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай ЗГ хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах гурван талын Хамтарсан хорооны хоёрдугаар хурал 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр хийв. Тус хурлаар Хамтарсан хорооны анхдугаар хурлаар тохиролцсон асуудлын хэрэгжилт, олон улсын авто тээвэрлэлтэд “Ковид-19” цар тахалтай холбоотой үүсч буй хүндрэл бэрхшээлийг арилгах чиглэлээр талуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, 2021, 2022 онд зөвшөөрлийн бичгийг хэрэглэх зохицуулалт, Азийн авто замын сүлжээний АН-4 коридорын дагуух тээврийн маршрутыг нээж, туршилтын тээвэрлэлт хийх боломжийн талаар хэлэлцэв.

“Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг урагшлуулах ажлын хэсгийн шинжээчдийн түвшний V хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, Монгол-Орос-Хятадын Аялал жуулчлалын сайд нарын VI дугаар хуралдааныг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр, БНХАУ-тай “Хятад, Оросын эрчим хүчний хамтын ажиллагаа” сэдэвтэй цахим хурлыг 2022 оны 1 дүгээр сарын 19-нд тус тус зохион байгуулав.

Самарканд хотноо 2022.09.15-16-нд болсон ШХАБ-ын дээд түвшний уулзалтын үеэр МУ, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын ээлжит VI уулзалт болж, тус уулзалтаар ЭЗ-ийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хэлэлцэж, “Монгол, Орос, Хятадын ЭЗ-ийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг 5 жилээр сунгасныг зарлав.

Коридорын ТЗ-ын “Төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-ийн ажлыг эхлүүлэх тухай” Хамтарсан мэдэгдэл болон “ТЭЗҮ-ийг судлах Ажлын төлөвлөгөө”-нд 3 тал гарын үсэг зурж баталгаажуулсан. МУ-ын ШУТИС, ОХУ-ын ЗТИС, Бээжингийн ЗТИС хоорондын Хамтын ажиллагааны санамж бичигт 3 тал гарын үсэг зурж баталгаажуулж, хамтарсан хөтөлбөр боловсруулахаар болж, шинжээчдийн түвшний VI уулзалт Москва хотноо 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр болж, 32 төслийн хэрэгжилтийг дүгнэж, цаашид шинэчлэх нь зүйтэй гэдэгт санал нэгдэж, хятадын тал эхний төслийг талуудад хүргүүлэхээр тогтов.

4.5.4.4. Монгол Улсын газар нутгаар дамжуулан ОХУ, БНХАУ-ыг холбосон байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийг хөрш хоёр оронтой хамтран хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.

Биелэлт: Монгол Улсын газар нутгаар дамжуулан ОХУ, БНХАУ-ыг холбосон байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн ажлыг судлах хамтарсан ажлын хэсгийн оросын талын дарга “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов 2021 оны 3 дугаар сард Монгол Улсад айлчилж, төсөл нь эдийн засгийн ашигтай гэж дүгнэснийг үндэслэн “Төслийн 2022-2024 оны хамтарсан ажлын төлөвлөгөө” болон “зураг төсөл, инженерийн ажлыг гүйцэтгэх гэрээ” зэрэг баримт бичигт 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан. ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах талаар гурван улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгаж, үүний дагуу ОХУ-ын “Газпром” компани монголын талын дэмжлэгтэйгээр ТЭЗҮ-ийг боловсруулж дуусган өдгөө зураг төсөл, судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Дорнын эдийн засгийн VII чуулга уулзалтын үеэр “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн дарга А.Б.Миллертэй уулзаж, төслийн хэрэгжилтийн талаар санал солилцов. Самарканд хотноо ШХАБ-ын дээд түвшний уулзалтын үеэр болсон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын VI уулзалтаар талууд хийн хоолойн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн уялдаа холбоог нэмэгдүүлэх чиглэлд хамтран ажиллах талаар онцолсон болно.

4.5.4.5. “Талын зам” хөтөлбөрийг “Бүс ба Зам” санаачилгатай уялдуулах хүрээнд төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын “Хөгжлийн зам” болон БНХАУ-ын “Бүс ба Зам”-ын бүтээн байгуулалтыг урагшлуулах тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөөг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. Төлөвлөгөөний хавсралтад 2019-2020 онд хэрэгжүүлэхээр тусгасан 15 арга хэмжээнээс 2020 оны байдлаар бүрэн хэрэгжсэн 2 арга хэмжээ, 50 хувиас дээш хэрэгжилттэй 8 арга хэмжээ, удаашралтай 4 арга хэмжээ, зогссон 1 арга хэмжээ байсан.

Энэхүү төлөвлөгөөг шинэчлэн байгуулж, хэрэгжүүлэх хүрээнд 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн E/07/22/262 тоот цахим шуудангаар Бээжин дэх ЭСЯ-аар дамжуулан хятадын талтай төлөвлөгөөний хэрэгжилт болон цаашдын чиглэлийн талаар санал солилцож, “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” хэлэлцээрийн дагуу байгуулсан Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн монголын талын бүрэлдэхүүнийг Гадаад харилцааны сайдын А/69 дугаар тушаалаар баталсан. Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн монголын талын бүрэлдэхүүний анхдугаар хуралдааныг 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр зохион байгуулав.

4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.

4.5.5.1.1. АНУ-тай Стратегийн түншлэлийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлж ажиллана.

Биелэлт: 2021 оны 1 дүгээр сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн АНУ-ын шинэ 117 дугаар Конгресст Америк, Монголын бүлэг байгуулагдсан. Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорацтай 2018 оны 7 дугаар сард байгуулсан Хоёр дахь компакт гэрээ 2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр хүчин төгөлдөр болж, компакт гэрээ хүчин төгөлдөр болсныг тэмдэглэх арга хэмжээг 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр зохион байгуулав.

АНУ-ын зүгээс Олон улсын хөгжлийн агентлагаар дамжуулан КОВИД-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд зориулж нийт 8.1 сая гаруй ам.долларын тусламж үзүүлсэн.

Монгол Улс, АНУ-ын дипломат харилцааны 35 жилийн ойг тохиолдуулан “Mongolia Today” сэтгүүлд Монгол, АНУ-ын харилцааны тухай нийтлэл гаргаж, “Америкийн өдрүүд 2022” соёл, боловсролын цуврал арга хэмжээг 2022 оны 6 дугаар сарын 15-30-ны өдөр зохион байгуулсан.

Монгол Улсын ГХЯ, АНУ-ын Төрийн департамент хоорондын XV Улс төрийн зөвлөлдөх уулзалт, анхдугаар Стратегийн яриа хэлэлцээ 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, “Агаарын харилцааны хэлэлцээр” байгуулах, Монголын соёлын өмчийг АНУ руу хууль бусаар гаргах явдлаас хамгаалах хамтарсан зохицуулалттай болох зэргийг тохиролцож, хамтарсан мэдэгдэл гаргасан.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг 2 сая ам.долларын санхүүжилтийг Монгол Улсад хэрэгжүүлж буй Жижиг, дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх (BEST) хөтөлбөрөөрөө дамжуулан олгохоор шийдвэрлэсэнээ 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр мэдэгдсэн.

Монгол Улс, АНУ-ын Эдийн засгийн бодлогын IV зөвлөлдөх уулзалт Вашингтонд 2023.02.02-нд болж, талууд 2 улсын Стратегийн түншлэлийг бэхжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.

Нэн чухал эрдэс баялгийн талаарх Монгол Улс, АНУ, БНСУ-ын 3 талт анхдугаар яриа хэлэлцээг Улаанбаатарт 2023.06.27-нд хийж, төр-хувийн хэвшлийн хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар санал солилцов.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2023.08.01-06-нд АНУ-д хийсэн айлчлалын дүнгээр “Монгол Улс, АНУ-ын Стратегийн гуравдагч хөршийн түншлэл”-ийн тухай хамтарсан мэдэгдэл гаргаж, “Стратегийн гуравдагч хөршийн түншлэлийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Замын зураглал”-д гарын үсэг зурав.

Монгол, АНУ хоорондын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан хорооны VII хуралдаан Улаанбаатарт 2023.08.29-нд болж, “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, АНУ хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд монгол боловсон хүчний чадавхыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар ярилцав.

Монгол Улс, АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд байгуулсан Монгол-Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын Хамтарсан хорооны хурлыг Улаанбаатарт 2023.08.29-нд хийж, 2 орны худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг хөгжүүлэх боломжийн талаар хэлэлцэв.

4.5.5.1.2. Дээд, өндөр түвшний харилцан айлчлал хэрэгжүүлнэ. Тухайлбал, Гадаад харилцааны сайд, УИХ-ын даргыг АНУ-д айлчлуулна. Зөвлөлдөх уулзалт зэрэг хоёр талын харилцааны механизмын арга хэмжээнүүд хэрэгжүүлнэ.

Биелэлт: Монгол Улс, АНУ-ын Эдийн засгийн бодлогын IV зөвлөлдөх уулзалт 2023 оны 2 дугаар сарын 02-ны өдөр Вашингтон хотод, Монгол Улс, АНУ, БНСУ-ын гурван талт анхдугаар уулзалт 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Улаанбаатар хотод, нэн чухал эрдэс баялгийн талаарх Монгол Улс, АНУ, БНСУ-ын гурван талт анхдугаар яриа хэлэлцээр 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав.

УИХ-ын дарга Г.Занданшатар 2021 оны 9 дүгээр сард АНУ-д хийсэн айлчлалаар Конгрессын Олон улсын байгаль хамгаалах бүлгийн гишүүдтэй уулзаж, “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, АНУ хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр авч буй багц арга хэмжээний талаар мэдээлэл өгч, цаашид хоёр талын эдийн засгийн харилцааг өргөжүүлэх хүрээнд Монгол, Америкийн хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлэх, түүнчлэн “Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль”-ийг АНУ-ын Конгрессоор батлуулах асуудлыг хөндөж, хоёр орны хооронд эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх талаар санал солилцов.

4.5.5.1.3. АНУ-тай тохиролцсон Эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглалыг хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол, АНУ хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд харилцан ойлголцлыг баталгаажуулах захидлыг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хоёр тал харилцан солилцсон.

“Стратегийн гуравдагч хөршийн түншлэлийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын Замын зураглал”-ыг Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2023 оны 8 дугаар сарын 01-06-ны өдрүүдэд АНУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр байгуулав. Замын зураглалд эдийн засгийн тодорхой салбаруудын хүрээнд хамтран ажиллах чиглэлийг дэлгэрэнгүй томъёолж тусгасан. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд байгуулсан Монгол-Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын Хамтарсан хороо 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо хуралдаж, хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх боломжийн талаар хэлэлцэв.

Монгол, АНУ-ын худалдааны эргэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 279 сая ам.долларт хүрч, үүнээс экспорт 34.4 сая ам.доллар, импорт 245.2 сая ам.доллар байна.

4.5.5.1.4. АНУ-ын Конгрессоор гуравдагч хөршийн худалдааны тухай хуулийг батлуулах боломжийг эрэлхийлэх, Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий систем (General System of Preferences) хөтөлбөрийг бүрэн ашиглах чиглэлээр ажиллана.

Биелэлт: АНУ-ын Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP)-ийн үйлчлэх хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дууссан. Монгол Улс ноос, ноолууран бүтээгдэхүүнийг тус хөнгөлөлтийн жагсаалтад оруулах хүсэлтийг удаа дараа гаргаж байсан боловч АНУ-ын Конгресс дотоодын нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийн зүгээс томоохон эсэргүүцэлтэй тулгарсны улмаас манай хүсэлтийг хэлэлцээгүй төдийгүй худалдааны хөнгөлөлтийн жагсаалтаас нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүнийг хасах шийдвэр гаргасан. Иймд Монголын ноос, ноолууран бэлэн

бүтээгдэхүүнийг АНУ-ын Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий системд хамруулах боломжгүй болсон.

4.5.5.2. Япон Улстай харилцааны түвшинг ахиулж “Иж бүрэн стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэнэ. Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны дараагийн хөтөлбөрийг шинэчлэн байгуулна.

Биелэлт: Япон Улсын ЭСЯ-тай хамтран 40 гаруй арга хэмжээг, Токио хотноо 30 гаруй арга хэмжээг 50 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан, тухайлбал:

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 7 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Япон Улсад ажлын айлчлал хийж, Олон улсын Олимпын хороо, “Токио-2020” Олимпын наадмыг зохион байгуулах хорооны урилгаар Токиогийн зуны XXXII Олимпын наадмын нээлтийн ажиллагаанд оролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Япон Улсад 2022 оны 11 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол, Японы Стратегийн түншлэлийг “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай Стратегийн түншлэл” болгож шат ахиулах тухай хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав. Мөн энэхүү төрийн айлчлалын үеэр Монгол Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн Монгол Японы “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай Стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийг 2022-2031 он хүртэл 10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд хоёр талын хамтын ажиллагаа, олон улс, бүс нутаг ялангуяа дэлхий нийтийн өмнө тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт зэрэг нийтлэг нийтлэг асуудлын хүрээнд хамтран ажиллахаар тусгасан болно.

Монгол, Японы Стратегийн түншлэлийн хүрээнд Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Чингис Хаан ОУНОБ баригдаж, үйл ажиллагааг эхлүүлсэн ба вакцины болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж, цар тахлын эсрэг арга хэмжээний яаралтай зээл”-ийг авсан.

Монгол Улс болон Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд Японы Гадаад харилцааны сайд Ё.Хаяши 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 02-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн.

Мөн Японы Парламентын төлөөлөгчид Монгол Улсад 8 дугаар сард айлчлав. “Монгол-Японы стратегийн түншлэлийг бизнес, эдийн засгийн талбарт өргөжүүлэн бэхжүүлэх нь” сэдэвт симпозиум, Монгол, Японы Стратегийн түншлэлийн харилцаа-50 жил” сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн болон 50 жилийн ойн шуудангийн марк гаргав. Түүхэн баримтат кино жилийн турш UBS телевизээр гаргуулж, “Алтан аргамж” ном хэвлэгдэн гарсан.

4.5.5.3. Европын Холбоотой байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана. Европын улсуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, санхүү, техник, технологи, ажиллах хүчний давуу тал дээр тулгуурлан улс тус бүрээр хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлно. Европын зарим улстай шинээр яриа хэлэлцээний механизм бүрдүүлэхийг зорино.

Биелэлт: Монгол Улс, Европын Холбоо хооронд 2013 онд байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн 27 дугаар зүйлд заасны дагуу “Монгол Улс, Европын Холбоо хооронд газар зүйн заалтын тухай” хэлэлцээр байгуулах хоёр дахь шатны яриа хэлэлцээг 2023 оны 1 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулав. Монгол Улс, Европын Холбоо хооронд “Газар зүйн заалтын тухай хэлэлцээр” байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тус газраас 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Европын Холбооны Ази,

Австралийн Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн ерөнхий газрын дэд дарга Раймондо Серра тэргүүтэй төлөөлөгчидтэй цахим уулзалт зохион байгуулав. Монгол Улс, Европын Холбоо (ЕХ)-ны Хамтарсан комиссын дэргэдэх Худалдаа, хөрөнгө оруулалтын дэд хорооны хуралдааныг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулав. Дэд хорооны хуралдаанаар талууд эдийн засгийн одоогийн нөхцөл байдал, худалдааны бодлого, хөрөнгө оруулалтын орчны талаар харилцан мэдээлэл солилцов. Хуралдааны үеэр ЕХ-оос сайн засаглал, тогтвортой хөгжлийн болзлыг хангасан хөгжиж буй орнуудад хэрэгжүүлдэг Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP+)-ийн дагуу Монгол Улсад олгодог тарифын хөнгөлөлтийг 2027 он хүртэл сунгахаар шийдвэрлэсэн тухай мэдэгдэв. Тус хөнгөлөлтийн ерөнхий системийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй 7200 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн европын зах зээл дээр гаалийн тарифын хөнгөлөлт эдэлдэг тул дээрх шийдвэр нь манай бизнес эрхлэгчид европын зах зээлд нэвтрэх, экспортын барааны төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, газар зүйн заалттай бүтээгдэхүүний дотоодын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой.

4.5.5.4.БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: 2023 оны байдлаар нийт 2,187,065 тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,912,740 тонн байна. Үүнээс K5 /Евро-5/ ангиллын шатахуун 198,365 тонн буюу нийт шатахууны 11 хувийг эзэлж байна. Зорилт 6. Нүүрсний уурхайн метан хийг ашиглах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар Засгийн газрын шийдвэрээр 2018 оноос хойш уламжлалт бус газрын тосны /Нүүрсний давхаргын метан хий/ зургаан Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан.Үүнд: Нүүрсний давхаргын метан хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээнд зургаан талбайд микросейсмийн 2 хэмжээст чичирхийллийн судалгаа нийт 1293 тууш.км, хайгуулын нийт 65 цооног өрөмдсөн. Өнөөдрийн байдлаар нүүрсний давхаргын метан хийн хайгуулын зургаан талбайд 2023 онд нийт 21.18 сая ам.долларын төлөвлөгөө, төсөвт өртөг бүхий геологи, хайгуулын ажлыг хийхээр батлуулсан.

4.5.5.5.БНСУ-тай харилцаагаа өргөжүүлж, “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэнэ.

Биелэлт: Монгол Улс, БНСУ-ын хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг эхлүүлэх тухай Ажлын даалгаврыг хоёр тал эцэслэн тохирч, 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав. Үүний дагуу эхний шатны хэлэлцээг 2023 оны 12 дугаар сард Сөүл хотноо зохион байгуулахаар тохиролцож, БНСУ-ын буцалтгүй тусламжийн 8 сая ам.долларын санхүүжилтээр 2023-2028 онд хэрэгжүүлэх “Монгол, Солонгосын газрын ховор металлын хамтарсан судалгааны төв” байгуулах төслийн үйл ажиллагааг 2023 оны 11 дүгээр 20-ны өдөр нээж, хоёр талын хамтарсан хорооны анхдугаар хурлыг зохион байгуулав.

БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамнаас 400-600 мянган ам.долларын техникийн туслалцааны санхүүжилтээр “К-Сити нетворк” хөтөлбөрийг 2022-2023 онд “Шинэ Зуунмод ухаалаг хот”-д хэрэгжүүлж байна. Манай улсын “Тэрбум мод” санаачилгыг БНСУ дэмжиж, БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Ногоон хэрэм” 3 дугаар шатны төслийн хүрээнд нийт 45 га талбайд мод тарих ажлыг өргөжүүлэхээр болов. БНСУ-ын хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд 2023-2026 онд “ХААИС-ийн сургалт, судалгаа аж үйлдвэрлэлийн уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төсөл (5 сая ам.доллар)”, 2023-2027 онд “Монгол Улсын авто тээврийн

хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн чадавхыг бэхжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах төсөл” зэрэг 2023 оны байдлаар нийт 15 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

4.5.5.6. Бүгд Найрамдах Турк Улстай худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тус улсаас хөнгөлөлттэй зээл, тусламж авахыг зорино.

Биелэлт: Гадаад харилцааны сайдын 2023 оны 3 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд Турк Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр талууд “Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, хамгаалах тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар хамтран ажиллах тухай” санамж бичиг зэргийг байгуулан хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, улмаар ирэх жилүүдэд худалдааны эргэлтийг 200 сая ам.доллар ба түүнээс илүү хэмжээнд хүргэх чиглэлээр эрчимтэй хамтран ажиллахаар тохиролцов. Талууд харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан хувийн хэвшил хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, чингэхдээ ялангуяа хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуй, түүх, соёл, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг түлхүү дэмжиж ажиллахаар өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн дээд, өндөр түвшний айлчлалын үеэр ярилцаж, тохиролцсон.

4.5.5.7. Зүүн өмнөд болон Төв Азийн бүс нутгийн орнуудтай харилцаагаа гүнзгийрүүлж, эдийн засгийн интеграцид орох боломжийг эрэлхийлэх, харилцан ашиг сонирхлыг бий болгоно. Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, нэр төрлийг нэмэгдүүлэх, хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээр дамжуулан Азийн болон “гуравдагч” бусад зах зээлд Монголын бараа бүтээгдэхүүнийг гаргах, бизнес эрхлэгчид шинэ зах зээлд нэвтрэхэд нь бодит дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2023 оны 11 дүгээр сарын 1-5-нд БНСВУ-д төрийн айлчлал хийж, Монгол, Вьетнамын харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн бодит агуулгаар баяжуулан хөгжүүлэх, хоёр улсын иргэдийг харилцан визийн шаардлагаас чөлөөлөх, уламжлалт найрсаг харилцааг шат ахиулан ирэх онд “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүргэх зэрэг чухал тохиролцоонд хүрэв. Мөн 11 дүгээр сарын 5-7-ны өдрүүдэд БНАЛАУ-д төрийн айлчлал хийх үеэр Агаарын харилцааны тухай болон Мал эмнэлэг, мал амьтны хорио цээрийн тухай хэлэлцээр зэрэг хоёр талын 8 баримт бичиг байгуулав. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2023.03.8-9-нд Узбекистанд айлчилж, Монголоос мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос, ноолуур нийлүүлж, Узбекистанаас жимс, жимсгэнэ, нарийн ногоо импортолж, харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхээр тохиролцов.

Монгол, Казахстаны ЗГХК-ын IX хуралдааныг 2023 оны 5 дугаар сарын 26-нд УБ хотноо хийж, тээвэр логистик, хөдөө аж ахуй, соёл, аялал жуулчлал, мэдээлэл технологи зэрэг салбарт харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэн бэхжүүлэхээр тохиров. Киргизийн Гадаад харилцааны сайд Ж.Кулубаев, Ерөнхийлөгч С.Жапаров нар Монгол Улсад тус тус айлчилж, Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн, арьс, шир, ноос ноолуур нийлүүлэх, Киргизээс жимс, жимсгэнэ, нарийн ногоо зэрэг бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, харилцан ашигтай, худалдааны тэнцвэрийг хадгалсан хамтын ажиллагааг өрнүүлэхээр тохиролцож, БНКиру-ын ЭСЯ-ыг албан ёсоор нээв.

Монгол, Тайландын ЗГХХА-ны зөвлөлийн II хуралдааныг 2023.06.02-нд Бангкок хийж, худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Тайландын тур-операторын төлөөлөгчдийг 2023 онд Монголд айлчлуулах, хамтын ажиллагааны замын зураглал байгуулахаар

тохиров. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Киргиз Улсад 2023.10.24-нд айлчлах үеэр Хамтын ажиллагааны тухай Хөрөнгө оруулалтын байгууллага хоорондын санамж бичгийг байгуулав.

4.5.5.8. Франц Улстай харилцааг Иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх замын зураглалыг баталж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: БНФУ-ын Ерөнхийлөгч Э.Макроны 2023 оны 5 дугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалаар талууд улс төр, батлан хамгаалах, иргэдийн аюулгүй байдал, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, эрчим хүч, хөдөө аж ахуй, харилцаа холбоо, сансар судлал, иргэний хамгаалал, аялал жуулчлал, аж үйлдвэржилт болон боловсрол, шинжлэх ухаан, соёлын түншлэлийг бэхжүүлэхээр тохиролцон хоёр улсын харилцааны түвшнийг ахиулж, иж бүрэн түншлэлд хүргэх эрмэлзлээ Монгол, Францын хамтарсан тунхаглал гарган мэдэгдсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн БНФУ-д хийх төрийн айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд талууд хоёр орны харилцааг Иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх замын зураглал баримт бичгийг Монгол, Францын Онцгой эрхт түншлэлийн харилцааг өргөжүүлж, стратегийн түншлэлд хүргэхэд чиглэсэн “Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улс хоорондын хамтын ажиллагааны үйл ажиллагааны төлөвлөгөө” болгон байгуулахаар тохиролцсон. Хүрсэн тохиролцооны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн БНФУ-д 2023 оны 10 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд хийсэн төрийн айлчлалын хүрээнд Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, БНФУ-ын Европ, Гадаад харилцааны сайд К.Колонна нар гарын үсэг зурав.

4.5.5.9. Канад Улстай явуулж буй хамтын ажиллагааг Иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэхийг зорьж ажиллана. Канад Улстай хоёр талын хамтын ажиллагааны замын зураглалыг байгуулж, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

Биелэлт: Монгол, Канадын Засгийн газар хоорондын Дугуй ширээний уулзалтын IX хуралдааныг 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, энэ үеэр талууд “Иж бүрэн түншлэлийн төлөөх Монгол, Канадын хамтын ажиллагааны Замын зураглал”-ыг тохиролцов. Монгол, Канадын Хөдөө аж ахуйн хамтарсан хорооны III хурал 2021 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр Оттава хотод зохион байгуулав. Монгол, Канадын Дугуй ширээний уулзалтын IX хуралдааныг 2021 оны 5 дугаар сарын 27-нд хийж, “Иж бүрэн түншлэлийн төлөөх Монгол, Канадын хамтын ажиллагааны Замын зураглал”-ыг тохиролцсон. Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга Жорж Ж.Фюри 2022 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал нь харилцааны түвшнийг “Иж бүрэн түншлэл”-д хүргэх зорилтыг урагшлуулахад түлхэц үзүүлсэн.

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2023 оны 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Канад Улсад албан ёсны айлчлал хийж, хоёр улсын харилцааны түвшинг ахиулан “Иж бүрэн түншлэл”-ийн харилцаанд хүргэв. Монгол, Канадын худалдааны эргэлт 2023 оны байдлаар 29.1 сая ам.доллар болж өсөв (2021 онд Монгол Улсаас Канадад 759.9 сая ам.долларын бараа экспортолж, 24.2 сая ам.долларын бараа импортолж, нийт худалдааны эргэлт 784.1 сая ам.доллар байсан)

4.5.5.10. Ойрх Дорнод, түүний дотор Булангийн орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Биелэлт: Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2023 оны 5 дугаар сарын 22-26-ын өдрүүдэд Саудын Арабын Хаант Улсад албан ёсны айлчлал хийж, хамтын ажиллагааны

асуудлуудаар санал солилцов. АНЭУ-ын Гадаад худалдаа хариуцсан Төрийн сайд Ахмад Аль-Зивиуди 2023 оны 7 дугаар сард Монгол Улсад айлчилж, холбогдох сайд, бизнесийн төлөөлөлтэй уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар ярилцсан. Үүний мөрөөр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 4 төслийн мэдээллийг айлын талд хүргүүлэв. Саудын Арабын Хаант Улсын Ханхүү Турки бин Мухаммед бин Аль-Сауд 2023 оны 9 дүгээр сард Монгол Улсад айлчилж, Монгол Улсын Ерөнхийлөгч, ЕТГ-ын дарга Я.Содбаатар, ГХС, БОАЖС нартай уулзаж, зэрлэг амьтан хамгаалах болон Тэрбум мод үндэсний хөдөлгөөнтэй холбоотой төслүүд дээр хамтран ажиллахаар тохиролцов. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2023.11.28-ны өдөр АНЭУ-ын Ерөнхийлөгч Мухаммед бин Заид Аль-Нахъян-тай уулзаж, хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлаар санал солилцов. Мөн энэ үеэр хоёр талын эрх зүйн орчин, эдийн засгийн хамтын ажиллагааг тэлэх баримт бичгүүдэд гарын үсэг зурав.

4.5.5.11. Латин Америкийн орнуудтай: Аргентин Улстай байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ. Чили, Колумби зэрэг улстай уул уурхай, ХАА-н салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.

Биелэлт: Аргентин: 2021 оны 12 дугаар сарын 09-нд болсон хоёр улсын ГХЯ-д хоорондын III зөвлөлдөх уулзалтын үеэр Аргентинтай байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд хөтөлбөрүүд хэрэгжүүлэх асуудлаар санал солилцож, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүднээс Хамтарсан ажлын хэсэг байгуулав.

Чили: Монгол, Чилийн анхдугаар бизнес уулзалт 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр, II зөвлөлдөх уулзалт 2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, талууд эдийн засгийн харилцаа, уул уурхайн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов. Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Уул уурхайн яамд хоорондын санамж бичигт 2022.06.14-нд гарын үсэг зурав.

Колумби: Бүгд Найрамдах Колумби Улсын Гадаад харилцааны сайд Альваро Лейва Дуран нар “Техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар болон Бүгд Найрамдах Колумби Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т 2023 оны 9 дүгээр 20-ны өдөр гарын үсэг зурав. Энэ үеэр Гадаад харилцааны сайд нар уул уурхай зэрэг салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцов.

Куба: Монгол, Кубын ГХЯ-д хоорондын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр болсон IV зөвлөлдөх уулзалтаар ХАА-н хамтын ажиллагааны асуудлыг хөндөж ярилцсан.

Бүгд Найрамдах Эль Сальвадор: Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд Алдонов Франкеко Альварезыг 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч уулзаж, хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийн талаар санал солилцов.

Холбооны Бүгд Найрамдах Бразил: Монгол, Бразилын Гадаад харилцааны яамд хоорондын улс төрийн VI зөвлөлдөх уулзалтыг энэ оны 12 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулж, хоёр улсын уул уурхай, ХАА, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, “Техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар хоорондын суурь хэлэлцээр”-ийг ойрын үед байгуулах талаар ярилцав.

4.5.6.1. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган, Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын чуулган болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Сайд нарын зөвлөлийн уулзалт, АСЕМын Дээд түвшний уулзалт, Гадаад харилцааны сайд нарын уулзалт зэрэг НҮБ, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн байгууллагаас зохион байгуулах хурал, арга хэмжээнд төлөөлөгчдийн үр дүнтэй, идэвхтэй

оролцоог хангаснаар өөрийн улсын эрх ашгаа хамгаалж, олон улсад нэр хүндээ улам бататгана.

Биелэлт: НҮБ-ын ЭЗНЗ-ийн Хөгжлийн санхүүжилтийн асуудлаарх чуулга уулзалт, Нийгмийн хөгжлийн комиссын 61 дүгээр чуулган, Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 67 дугаар чуулган, Залуучуудын 2023 оны чуулга уулзалт, Статистикийн комиссын 54 дүгээр чуулганд манай төлөөлөгчид оролцов. УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар Вена хотноо ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Өвлийн уулзалтад, Элчин сайд Д.Гэрэлмаа НҮБ-ын ХЭЗ-ийн 52, 53, 54 дүгээр чуулганд, Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр Нэн буурай хөгжилтэй орнуудын асуудлаарх НҮБ-ын V бага хуралд, Элчин сайд В.Энхболд ДГХБО-ын асуудлаарх Венийн хөтөлбөрийн 2014-2024 оны хэрэгжилтийг хэлэлцэх Ази-Европын уулзалтад оролцов. ТНБД Н.Анхбаяр 2023 оны 5 дугаар сард Бангкокт НҮБ-ын АНДЭЗНК-ын 79 дүгээр чуулганы дэд даргаар ажиллаж, манай улсын байр суурийг илэрхийлж үг хэлэв. Манай улсын төлөөлөгчид 11 дүгээр сард болсон ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 42 дугаар чуулган, ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөлийн 30 дугаар уулзалтад оролцов.

4.5.6.2.Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ зэрэг олон улсын бага хурал, олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран хурал, арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулж бүс нутгийн түвшинд байр сууриа бэхжүүлнэ.

Биелэлт: Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн санаачилгаар Гадаад харилцааны эмэгтэй сайд нарын уулзалтын 2023 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Уулзалтад Герман, Франц, Индонез, Лихтенштайн, Өмнөд Африк зэрэг улс Гадаад харилцааны сайдын түвшинд, Австрали, Мозамбик Улс Элчин сайдын түвшинд оролцсон бөгөөд Олон улсын худалдааны төвийн Гүйцэтгэх захирал, ЕАБХАБ-ын ЕНБД, Уур амьсгалын ногоон сангийн Гадаад харилцааны асуудал эрхэлсэн захирал нар биечлэн оролцов. Түүнчлэн Андорра, Перу, Люксембург, Нидерланд, Монако, Шинэ Зеланд, БНАСАУ, БНСУ болон Япон Улсын Гадаад харилцааны сайд нар, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Амина Ж. Мохаммед, НҮБ-ын Орлогч ЕНБД бөгөөд Нэн буурай хөгжилтэй, далайд гарцгүй хөгжиж буй болон арлын жижиг орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгч Рабаб Фатима зэрэг 10 гаруй төлөөлөгч цахимаар оролцов. Тус уулзалтаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцооны талаар 3 сэдэвчилсэн хэлэлцүүлэг өрнүүлж, Өндөр түвшний хуралдаанаар “Улаанбаатарын тунхаглал”-ыг баталж гаргав.

4.5.6.3.“Монгол Улсад НҮБ-аас үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” хөтөлбөр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сантай хэрэгжүүлж буй Орны хөтөлбөр зэрэг баримт бичгийн хэрэгжилтэд анхаарч, Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

Биелэлт: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн дэд захирал Кристоф Бауэ энэ оны 5 дугаар сард Монгол Улсад ажлын айлчлал хийж, ГХЯ-ны ТНБД Н.Анхбаяртай уулзав. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг энэ оны 4 дүгээр сард Баянхонгор аймагт ажиллаж, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн, амын сангийн үйл ажиллагаатай танилцав. ДЭМБ-ын Ерөнхий захирал манай улсад 2023 оны 7 дугаар сард албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нарт бараалхаж, Эрүүл мэндийн сайд С.Чинзоригтой хоёр талын уулзалт хийв. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд 2023 оны 7 дугаар сард танилцуулсан Тогтвортой

хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлаарх Үндэсний сайн дурын 2 дахь удаагийн илтгэлийг боловсруулахад НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллав. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн шинээр томилогдсон Суурин төлөөлөгч М.Димовска энэ оны 9 дүгээр сард Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт Итгэмжлэх захидлаа гардуулж, ГХЯ-ны ТНБД Н.Анхбаяртай уулзав.

4.5.6.4. НҮБ-ын мандаттай олон улсын Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлнэ. НҮБ болон олон улсын байгууллагуудын хүрээнд болох томоохон сонгуулиудад Монгол Улс хийгээд Монгол Улсын иргэнийг нэр дэвшүүлснээр олон улсад нэр хүндээ өсгөх, байр сууриа бэхжүүлэх боломж бүрдэнэ.

Биелэлт: 2023 онд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах 8 ажиллагаанд штабын ажилтнаар, цэргийн мэргэжилтэн болон Мотобуудлагын батальоны цэргийн багт нийт 900 орчим цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа нь энхийг сахиулах ажиллагаанд цэрэг хандивлагч дэлхийн 121 улс орнуудаас 24 дүгээрт, эмэгтэй цэргийн алба хаагчдын оролцоогоор 17 дугаарт, Зүүн хойд Азийн улс орнуудаас 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Цаашид Энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоогоо хадгалан, олсон амжилтаа бататгахад анхаарч ажиллаж байна.

4.5.6.5. Тогтвортой хөгжлийн асуудлаар зохион байгуулагдах хурал, арга хэмжээнд оролцож, тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтээр манай талаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулж, Тогтвортой хөгжлийн асуудлаарх манай талын Сайн дурын үндэсний илтгэлийг танилцуулах талаар дэмжлэг үзүүлж ажиллана.

Биелэлт: 2023 онд Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн асуудлаарх 8 дугаар уулзалтад Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг оролцоход дэмжлэг үзүүлэв. Мөн 7 дугаар сард 6-15-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо болсон Тогтвортой хөгжлийн асуудлаарх улс төрийн өндөр түвшний уулзалтад Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг, тус газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Сюзанна нар оролцоход дэмжлэг үзүүлэв. Энэ үеэр “Sustainable Pastoralism and Rangelands: Impacts of COVID, and how to leave them behind in the 2030 Agenda for Sustainable Development” сэдэвт тусгай арга хэмжээ зохион байгуулж, манай улсын дэвшүүлсэн “Бэлчээр болон нүүдлийн мал аж ахуйн олон улсын жил” санаачилгын талаар танилцуулав.

Мөн 2023 оны 4 дүгээр сард Болгар Улсын Софи хотноо Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний сайн дурын илтгэл танилцуулах улсуудын төлөөлөгчдөд зориулсан 2 дахь удаагийн семинарт Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга Б.Мөнгөнсүх оролцов. Үндэсний сайн дурын илтгэлийн “үндсэн санаа” (main message)-г 5 дугаар сард, бүрэн илтгэл, видео материалыг 6 дугаар сард НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд тус тус хүргүүлсэн.

4.5.6.6. Монгол Улс, ОХУ-ын хооронд 1958 болон 1976 онд байгуулсан хилийг гэрээг НҮБ-д бүртгүүлэх чиглэлээр ажиллана.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж, орон тоог баталсан. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу 1958, 1976 оны хилийн гэрээ, тэдгээрийн хавсралтууд болон 1987-2001 оны Монгол-Оросын хилийг хамтран анх удаа шалгасан баримт болон бусад баримт бичгийг төрийн нууцаас гаргах жагсаалтыг эцэслэв. Уг жагсаалтыг тулгалт хийлгэхээр ГХТА-д хүргүүлж, 34 нэгж баримт тус яамны архивд 28 нэгж бичиг баримт

хадгалагдаж буйг тодорхойлов. Мөн архивд байхгүй 6 нэгж архивын баримт хадгалагдаж буй эсэх талаар холбогдох байгууллагаас тодруулахаар бичиг хүргүүлэв. Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичгийг төрийн хамгаалалтаас гаргасан тухай нотолгоо /Маягт №22/-г боловсруулж байна.

4.5.6.7.Энэтхэг, Номхон далайн санаачилгыг эдийн засгийн хамтын ажиллагаа, үр өгөөж, ач холбогдол талаас нь судалж, хамтран ажиллах боломжийг эрэлхийлнэ.

Биелэлт: Монгол, АНУ, Японы гурван талт уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар дахь АНУ, Японы ЭСЯ-ны Элчин зөвлөхүүдтэй манай талын санаачилгаар уулзаж, “Энэтхэг-Номхон далайн үзэл санаа”-ны хүрээнд Монгол, АНУ, Японы гурван талт хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжүүлж болох төсөл хөтөлбөрүүдийн талаар санал солилцож, “Энэтхэг-Номхон далайн үзэл санаа”-ны хүрээнд АНУ, Япон Улстай кибер аюулгүй байдал, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах зарчмын тохиролцоонд хүрсэн. 2022 оны 10 дугаар сарын 28-нд Монгол, АНУ, Японы гурван талт уулзалт Токио хотноо болж уулзалтын дүнгээр хамтарсан мэдэгдэл гаргав. Талууд уулзалтаар бүс нутгийн асуудлууд, тухайлбал, Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хөгжлийн талаарх өөр өөрсдийн ирээдүйн төсөөллийг харилцан хуваалцаж, цэцэглэн хөгжсөн амар амгалан ирээдүйг бий болгоход чиглэсэн хамтын ажиллагааны талаар санал солилцов. “Энэтхэг, Номхон далайн бүс нутгийн V бизнес форум”-ыг “Оролцоог хангасан тогтвортой хөгжил” сэдвийн хүрээнд АНУ, Япон Улс хамтран 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Токио хотноо зохион байгуулав.

4.5.6.8.НҮБ-ын бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулна.

Биелэлт: НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө боловсруулах үйл явцыг урагшлуулах чиглэлээр ажиллав. НҮБХХ-ийн Бизнес ба хүний эрхийн төслийн багтай 2022.08.18-ны өдөр уулзалт хийж, төлөвлөгөөний төсөл боловсруулах Ажлын хэсгийн Гүйцэтгэх хороог 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хуралдуулж, төслийг 2 дугаар сард нэгтгэсэн. Бизнес ба хүний эрхийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлав.

4.5.7.1.Гадаад бодлогын тухай хуулийн төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлнэ.

Биелэлт: ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн А/68 дугаар тушаалаар “Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, төр засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдмэл байдлаар зохицуулах тухай” хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. “Монгол Улсын төрийн гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах тухай хууль” болон үзэл баримтлалын төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг боловсруулахтай холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн.

4.5.8.1. Дараах ДТГ-уудын байршил, бүтэц, орон тоог тогтооход эхний ээлжид анхаарч ажиллана. Үүнд: Арабын Нэгдсэн Эмират Улсад Монгол Улсын Элчин сайдын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур, Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Консулын газар нээнэ. Монгол Улсаас Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Элчин сайдын яамдын бүтэц орон тоог

оновчтой болгох, бэхжүүлэх хүрээнд Консулын хэлтэс байгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. ДТГ-уудын байршил бүтэц орон тооны асуудлыг ач холбогдлыг нь харгалзан тухай бүр шийдвэрлэнэ.

Биелэлт: 2019 оны 80 дугаар тогтоолоор Арабын Нэгдсэн Эмират Улсын нийслэл Абу Даби хотод Монгол Улсын Элчин сайдын яам, 2020 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур хотод, 2021 онд консулын техник ажилтан, ААЭЖ-ийг, Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух ЭСЯ-нд 2 дипломат, 1 үйлчилгээ техникийн ажилтан, Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод суух Консулын газрын 3 дипломат, 1 үйлчилгээ техникийн ажилтан,

2022 онд Монгол Улсаас Австралийн Холбооны Улс, Монгол Улсаас Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Чех Улсад суугаа ЭСЯ-нд, Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Элчин сайдын яамны бүтцэд Консулын хэлтэс байгуулах асуудлыг 2024 онд багтаан шийдвэрлэхээр төлөвлөж байна. Мөн гадаад улс оронтой хөгжүүлж буй улс төр, эдийн засаг болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэдэд консулын үйлчилгээг хүртээмжтэй түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хилийн чанад дахь 16 ДТГ тус бүр 1-2, нийт 22 орон тоог нэмэгдүүлж, батлуулав.

Монгол Улсаас БНФУ-д суугаа ЭСЯ-нд Консулын хэлтэс байгуулах саналыг боловсруулж, Засгийн газрын 2023.05.24-ний өдрийн 198 дугаар тогтоол Засгийн газрын 2022 оны 70 дугаар тогтоолоор Монгол Улсаас Австрали, Швед, Чех Улсад суугаа ЭСЯ-дын бүтцэд Консулын хэлтэс байгуулахаар шийдвэрлүүлэв. 2023.09.06-ны өдрийн Засгийн газрын хуралдаан, 2023.10.10-ны өдрийн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Узбекистаны Ташкент хотод Монгол Улсын ЭСЯ нээн ажиллуулах тухай асуудлыг тус тус хэлэлцүүлж, 2023.11.10-нд БНХАУ-д суугаа Узбекистан Улсын Элчин сайдад манай Элчин сайдын яам нээхэд холбогдох зөвшөөрөл өгөх, дэмжлэг үзүүлэх ноотыг гардуулав.

Бүгд найрамдах Индонез улсад Монгол Улсын Элчин сайдын яамыг сэргээн ажиллуулах хүсэлтийг 2023.10.10-ны өдөр Тайландын Хаант Улсад суугаа тус улсын Элчин сайдын яаманд ноот бичгээр хүргүүлэв. “Япон Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” улсын төсөвт байгууллагын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 442 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2023.10.19-ний өдрийн 08/5593 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, 2023 оны 11 дүгээр сарын 01-ний Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэв. Монгол Улсаас БНСВУ, БНЭУ-д суугаа Элчин сайдын яаманд цэргийн атташе суулгах хүсэлтийг 2023.10.10-нд талуудад хүргүүлэн зөвшөөрсөн хариу авав. Асуудлыг ойрын хугацаанд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

4.5.8.2. Дипломат албан хаагчдыг сонгон шалгаруулах, томилохдоо ил тод байдлыг хангаж, тухайн албан тушаалд тавигдах мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлага болон гадаад хэлний шаардлагыг чанд мөрдөж ажиллана.

Биелэлт: Төрийн албаны тухай, Дипломат албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм журмын хүрээнд тайлант хугацаанд хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт 47 албан хаагчийг дипломат албан тушаалд, 27 албан хаагчийг үйлчилгээ техникийн ажилтнаар тус тус томилох асуудлыг нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж ТА3-тай хамтран шалгалтыг зохион байгуулж шалгалтад тэнцсэн 32 албан хаагчийг томилон ажилласан.

Мөн тус яамны төв аппаратын гүйцэтгэх албан тушаалд сул орон тоо гарсантай холбогдуулан нээлттэй сонгон шалгаруулалт зарлан Хөрөнгө оруулалтын газар, Ази номхон далайн орнуудын газрын захирлуудын албан тушаалд тэнцсэн Сонгон шалгаруулалтад тэнцсэн албан хаагчдыг ТАЗ-ийн саналаар, шатлан дэвшүүлэх зарчмын хүрээнд томилон ажиллуулж байна.

Дипломат төлөөлөгчийн газруудад ажиллахаар шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан хууль эрх зүй, сахилга хариуцлага, дипломат ёслол болон бусад улс төр, эдийн засгийн сэдвээр, гадаад улсад суух 23 элчин сайдад зориулсан цуврал сургалтуудыг тусгай хөтөлбөрийн дагуу тус тус зохион байгуулсан.

4.5.9. Дипломат албанд сахилга, хариуцлагыг эрс нэмэгдүүлж, хар тамхи тээвэрлэх болон хууль бус бусад аливаа үйлдлийг таслан зогсооно.

4.5.9.1. Дипломат албаны ёс зүй, сахилга бат, үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан албан хаагчдад тухай бүр хариуцлага хүлээлгэнэ.

Биелэлт: “Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй албан хаагчдын үүрэг, хариуцлага” сэдвээр томилогдсон нийт 70 гаруй албан хаагчдад төрийн болон албаны нууц, дипломат шуудан, харилцаа холбоо, мэдээллийн аюулгүй байдал, тамхи, хар тамхи болон хууль бус наймаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт зохион байгуулав.

Хилийн чанад дахь 10 Дипломат төлөөлөгчийн газрын 46 тээврийн хэрэгсэлд байршил тогтоогч төхөөрөмж /GPS/-ийг суурилуулсан бөгөөд ашиглалтыг онлайнаар тогтмол хянан ажиллаж байна.

Гадаад харилцааны сайдын 2023 оны А/70 дугаар тушаалаар яамны Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, ёс зүйн холбогдолтой асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 2 албан хаагчид сануулах, 1 албан хаагчид 3 сарын хугацаагаар цалин 20 хувиар хасах, 1 албан хаагчид 1 сарын хугацаагаар цалин 20 хувиар хасах, 1 албан хаагчид халах сахилгын шийтгэл тус тус ногдуулж, хариуцлага хүлээлгэв.

4.5.9.2. Хар тамхи, хууль бус наймаанд оролцсон ажилтан, түүнийг хариуцан ажиллаж буй ДТГ-ын тэргүүнийг эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэн, мөрдөж ажиллана.

Биелэлт: Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-д ДТГ-т ажиллах хугацаандаа хууль бус наймаанд нэр холбогдсон, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис (хар тамхи)-ыг хууль бусаар олж авах, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, олон улсын хил, гаалиар нэвтрүүлэх буюу нэвтрүүлэхийг завдах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцсон нь тогтоогдсон болон суугаа улсын холбогдох байгууллагаас Дипломат төлөөлөгчийн газарт албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд тухайн албан хаагчийг дипломат албанаас халах, түүнчлэн тухайн ажилтныг удирдан ажиллаж буй тэргүүнд мөн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Шинээр томилогдсон Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүд Гадаад харилцааны сайдтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Дипломат төлөөлөгчийн газрын ажилтан суугаа болон хавсран суугаа орноосоо өөр улсад зорчих тохиолдолд 2022.01.01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн “Зорчих зөвшөөрөл хүсэх тухай мэдэгдэх хуудас”-ыг бөглөж ирүүлж байх үүрэг чиглэлийг 2023 оны Е/08/23/0228 дугаар цахим шуудангаар нийт Дипломат төлөөлөгчийн газарт хүргүүлэн ажиллаж байна.

Дипломат төлөөлөгчийн газруудад томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдад зориулсан ерөнхий багц сургалтын хөтөлбөрт хилийн чанадад хууль бус наймаа, гэмт хэрэг,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, яамны газар, нэгж болон АТГ, ТЕГ, ХНХЯ, ГИХГ, Монголын Нотариатчидын Танхим, УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газруудтай хамтран сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

4.5.9.3.Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолоор баталсан Дипломат ажилтны сахилгын тусгай дүрмийг чанд мөрдөж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

Биелэлт: Хилийн чанад дахь ажиллахаар шинээр томилогдсон албан хаагчдад болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд дипломат төлөөлөгчийн газар ажиллах хугацаандаа баримтлах сахилга хариуцлага, ёслол хүндэтгэл, санхүү төсөв болон салбарын хөдөлмөрийн дотоод журам, сахилгын тусгай дүрэм зэрэг сэдвүүдээр дэлгэрэнгүй багц сургалт, томилогдсон 63 албан хаагчдыг “Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй албан хаагчдын эрх үүрэг, хариуцлагын тухай” ТАЗ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд Ёс зүйн зөвлөлүүдийг чадавхжуулах нь” сэдэвт танхимын сургалтад тус тус хамруулав.

Гадаад орнуудын дипломат албаны мэргэшил дээшлүүлэх цахим (20)-ын болон танхимын сургалтад (9) албан хаагчийг сургалтад хамруулав. Түүнчлэн Удирдлагын академиас жил бүр зохион байгуулдаг төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 9, ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалт 5, төрийн албанд шинээр томилогдон ажиллаж буй албан хаагчдад зориулсан сургалтад 9 нийт 23 албан хаагчийн тус тус сургаж мэргэшүүлэв.

4.5.10.Монгол Улсын түүх, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ олон улсад сурталчлах, таниулах “Монгол Үндэстний үнэлэмж” арга хэмжээ, хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх “Дэлхийн Монголчууд II” арга хэмжээг төлөвлөн боловсруулж хэрэгжүүлнэ.

4.5.10.1.Монгол Улсын эерэг имижийг бүрдүүлэх, нэр хүндийг өсгөх замаар улс орныхоо язгуур эрх ашгийг хамгаалах, байр суурийг бэхжүүлэхэд зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх зорилготой “Монгол Үндэстний үнэлэмж” арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.1.3-ын дагуу боловсруулж, баримт бичгүүдийн уялдаа, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дүнгийн үзүүлэлт, төсвийн тооцоо зэрэг 5 цогц судалгаа хийсэн бөгөөд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн жагсаалтад “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээг тусгуулан ажиллаж байна. “Монгол Үндэстний үнэлэмж” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Зөвлөлөөр батлуулав. Түүх, хэл бичиг, өв уламжлал, соёл урлаг, спорт, оюуны хөгжлийн ололт амжилтыг хилийн чанадад сурталчлах чиглэлээр 34, дипломат харилцааны тэгш ойн хүрээнд 6, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 7, монгол судлалын чиглэлээр 16, хэвлэл мэдээллийн чиглэлээр 5, нийт 70 орчим арга хэмжээг зохион байгуулав. “Монголын нууц товчоо”-г болгар, румын, грек, вьетнам хэл дээр хэвлүүлж, Чехийн Карлын ИС-тай хамтран “Mongolica Pragensia” сэтгүүлийн 2 дугаар эрхлэн гаргаж, ЮНЕСКО-ийн “World Heritage Review” сэтгүүлд монголын тухай нийтлэл хэвлүүлсний зэрэгцээ “Google Arts and Culture Platform”-д 5 өвийн газар нутгийг сурталчлах болон 210 орчим монгол судлалын ном, бүтээлийг Монгол судлалын 12 төвд хүргүүлсэн. Бээжинд “Монголын соёл, мэдээллийн төв”-ийн барилгыг 2022 онд хүлээн авч, төвийн нээлтийн үеэр Монголын соёлын өдрүүдийг зохион байгуулав. “Чингис хааны ертөнц ба Монгол судлал” ОУ-ын эрдэм шинжилгээний бага хурлын

“Монголчууд ба гадаад ертөнц” салбар хуралдааныг зохион байгуулж Их зохиолч Д.Нацагдоржийн цээж баримлыг Болгарын Плиска хотын “Двор на Кириллицата” цогцолборт байрлуулав. Соёлын яам хамтран HBO, Netflix, Discovery, Warner Bros, MTV зэрэг продакшны продюсер нарт улс орноо танилцуулах “FAM TOUR-2022” арга хэмжээг зохион байгуулав. ЮНЕСКО-ийн төв байранд Үндэсний урлагийн их театр Нүүдэлчдийн домог тоглолтоо толилуулав. Морин хуурын чуулга Японы NHK ТВ-ийн төв танхимд болон 12 хотод тоглолт хийлээ.

4.5.10.2.Хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх “Дэлхийн Монголчууд II” арга хэмжээ /хөтөлбөр/ боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг Гадаад харилцааны сайдын 2021 оны А/51 дугаар тушаалаар баталсан. Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй 11 улсын 25 хотод нийт 44 монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвийн судалгааг гаргаж танилцуулсан. Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран багшийн мэргэжил, заах арга зүйн 16 сургалт, ШУА-тай хамтран 44 сургуульд Хүүхдийн эх хэлний боловсролд эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Мал аж ахуйн соёл, Би Монгол хүн, Монгол ярианы сурах бичиг, Монгол хэлний дүрмийн заах арга зүйн эмхэтгэл зэрэг 350 гаруй номыг Дипломат төлөөлөгчийн газруудад хүргүүлэв. Цогц арга хэмжээний “2.3.6. үндэслэн “Монголын бүх ард түмний XV наадам”, “Монгол Үндэсний спортын VII наадам”-ын бүсийн тэмцээнийг АНУ, БНФУ, БНСУ-д зохион байгуулав. ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн “Монгол үндэсний баяр наадам”-ыг сурталчлах зорилгоор хилийн чанад дахь монголчуудын дунд “Миний Монгол наадам-2022” уралдааныг НЗДТГ-тай хамтран зохион байгуулж, амжилттай зохион байгуулсан. “Хилийн чанад дахь Монголчуудын нэгдсэн чуулга уулзалт”, “Хилийн чанад дахь Монголчуудын Зөвлөл” НҮТББ-ын IV чуулга уулзалтыг тус тус зохион байгуулав.

4.6.1.Хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

4.6.1.1.Монгол Улсын хууль, тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр туссан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулж, батлуулна.

Биелэлт: Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлуулсан бөгөөд хууль батлагдсанаар “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г тусгай хуулиар зохицуулах эрх зүйн үндэслэл бүрдэж, сангийн хөрөнгөөр энхийг дэмжих ажиллагаа болон улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтуудыг боловсронгуй болгосон. Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиудыг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн тус тус батлуулсан. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдээр хамтран батлуулж, төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг 2 удаа авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдсан болно.

4.6.1.2. Хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох талаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд “Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална” гэсэн эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгасан нь хугацаат цэргийн алба хаагч алба хаах хугацаандаа сайн дурын үндсэн дээр мэргэжил үйлдвэрлэлийн сургалтын төвөөр дамжуулан нарийн мэргэжил эзэмшиж, улмаар улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож тодорхой мөнгөн хуримтлалтайгаар цэргийн албанаас халагдах эрх зүйн орчин бүрдсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/70, А/58 дугаар хамтарсан тушаалаар “Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах тухай” журмыг мөрдөн ажиллаж байна.

“Цэргийн албаны тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэн хугацаат цэргийн албыг хаах хугацааг 24 сар болгох, цэргийн албыг сайн дурын алба болгон хөгжүүлэх, иргэнийг хугацаат цэргийн албанаас түр чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хугацаат цэргийн албыг хаасан иргэнийг “эрүүл мэндийн даатгал”-аас алба хаасны дараах жилд нэг удаа чөлөөлөх, хугацаат цэргийн алба хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц төгрөгийн цалин олгох зэрэг зохицуулалтыг шинээр тусгахаар санал боловсруулсан. Мөн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд хугацаат цэргийн алба хаасан 1 жилийг 1 жил 4 сараар тооцож, ажилласан жилд тооцох зохицуулалтыг тусгах, цэрэг татлагын төв байр /дамжин/-ыг хуульчлан баталгаажуулах, иргэдийн цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлогын үзэл санааг тусгасан.

4.6.1.3.Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны стратеги, хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн Зэвсэгт хүчний стратегийн удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор Цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хангах, хадгалах журам, мөн яамны сайдын тушаалаар Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө (2021-2024), Батлан хамгаалах яамны стратеги төлөвлөгөөг (2021-2024) Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийг баталсан. Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.2.Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг зэвсэгт хүчнийг бэхжүүлнэ.

4.6.2.1.Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн, чадварлаг болон хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлж, зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх зорилгыг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ бүхий дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, Зэвсэгт хүчний

байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Батлан хамгаалахын сайдын 2021 оны нууц тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилтэд 2023 оны 03 дугаар улирлын байдлаар явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 74.1 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн хэрэгжилттэй байна.

4.6.2.2. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийг 4 жилийн цэргийн сургалтын тогтолцоонд шилжүүлнэ.

Биелэлт: Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалаар батлагдсан “Бакалаврын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын дагуу 4 жилийн Цэргийн мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрт 45-50 орчим хичээлийг тусгуулж ерөнхий суурь, цэргийн мэргэжлийн заавал үзэх гэсэн агуулгаар тусган батлуулан мөрдөж байна. Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/190 дүгээр тушаалаар Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийг 4 жилийн цэргийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулж байна. Уг тогтолцоонд шилжүүлснээр Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвартай, бие бялдрын тэсвэр хатуужилтай офицер, мэргэжлийн боловсон хүчний нөөц бүрдэж, цэргийн сургалтын агуулга, хэлбэр, чанарт шинэчлэлт хийгдсэн байна.

4.6.2.3. Зэвсэгт хүчний удирдлагын төв, Зэвсэгт хүчний жанжин штабын барилгыг шинээр барина.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ЗХЖШ-ын төв байрны барилгын ажлын зураг төслийг Барилга хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулсан. ЗХЖШ-ын төв байрны барилгын ажлын зураг Барилгыг шинээр барихад шаардагдах 21.4 тэрбум төгрөгийг тусгуулахаар холбогдох газарт саналаа хүргүүлсэн ч төсвийн хүндрэлээс шалтгаалан тайлант онуудын төсөвт тусгагдаагүй байна.

4.6.2.4. Зэвсэгт хүчний цэргийн орон зайн тандалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.

Биелэлт: Зэвсэгт хүчинд орон зайн тандалт, судалгааг 2030 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/170 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.2.5. Цэргийн II шатны эмнэлэг байгуулах бүтээн байгуулалтын ажил

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.2.6. Баруун бүсэд галт хэрэглэлийн нөөцийн агуулахыг ашиглалтад оруулж, галт хэрэглэлийн нөөцийг шилжүүлэн байрлуулна.

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.2.7. "Налайх" аэродромын үндсэн зурвасыг сэргээн засварлана.

Биелэлт: Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.1.2-т болон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасны дагуу тайлантай танилцаж, ХШҮ хийсэн.

4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.

4.6.3.1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина.

Биелэлт: Батлан хамгаалахын сайд 21 аймаг, нийслэлийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г 2019 онд, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 331 сум, 9 дүүргийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г 2020 онд баталснаар орон нутгийн хамгаалалтыг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулах эрх зүйн орчин бүрдсэн. Улсын хэмжээнд 330 сум, нийслэлийн 9 дүүргийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-нд 2023 оны 05 дугаар сард тодотгол хийх талаар яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 1в/97 дугаар албан бичгээр аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабуудад хүргүүлэн удирдлагаар ханган ажилласан. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу аймаг, нийслэл, сум дүүргийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-д 2023 онд 04 дүгээр сарын 20-ноос 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нар тодотгол хийсэн. Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.3.2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.

Биелэлт: Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/69 дүгээр тушаалаар аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга нартай 2022 оны 03 дугаар сарын 22-28-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон Дорнод аймагт “Батлан хамгаалах бодлогын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх зарим асуудал” сэдвийн хүрээнд онол, дадлагын сургалтыг зохион байгуулсан. Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь аймгийн 19 сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 1237 томилгоот бүрэлдэхүүнийг хамруулан явуулсан. Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/246 дугаар тушаалын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нартай “Цэрэг-стратегийн бэлтгэл” сургалтыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд 08 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Өвөрхангай аймгийн Хужирт суманд “Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн болон удирдах бүрэлдэхүүний сургалт”-ыг 2022 оны 09 дүгээр сарын 12-15-ний өдрүүдэд баруун бүсийн, 2022 оны 09 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд говийн бүсийн аймгуудын сумын Засаг даргын Тамгын газрын дарга нартай явуулах “Цэргийн бэлтгэл” сургалтыг Ховд,

Говьсүмбэр аймагт тус тус зохион байгуулсан. Баруун бүсийн 91 сумын Тамгын газрын даргаас 86, говийн бүсийн 67 сумын Тамгын газрын даргаас 59 албан тушаалтан оролцож, хамрагдалт 88 хувьтай байлаа. Батлан хамгаалахын сайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга нартай 2023 оны 01 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод “Монгол Улсын аюулгүй байдал ба Батлан хамгаалах нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх бодлогын шинэчлэл” сэдвийн хүрээнд онол, дадлагын сургалтыг зохион байгуулсан. Говь-Алтай аймгийн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд “Орон нутгийн хамгаалалтад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үүрэг оролцоо” сэдвээр зохион байгуулж, нийт 1200 гаруй бүрэлдэхүүнийг хамруулсан.

Өмнөговь аймагт Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд “Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүд хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх нь” сэдвээр Орон нутгийн хамгаалалтын томилгоот 7 нэгжийн 135 томилгоот бүрэлдэхүүнийг хамруулан зохион байгуулсан. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалт Баян-Өлгий, Увс, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудад тус тус зохион байгуулсан.

4.6.3.3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчилнэ.

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.3.4. Цэргийн дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгоно.

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.3.5. Бүсийн сургалтын төвийг байгуулна.

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.3.6. Батлан хамгаалах материаллаг нөөцийг нөхөн бүрдүүлнэ.

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.4. Зэвсэгт хүчний бүтцэд барилга-инженерийн, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргийг байгуулна.

4.6.4.1.Барилга-инженерийн цэргийн удирдах газар, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргийн командлалыг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.4.2.Барилга-инженерийн цэргийн ангийг байгуулах бүтээн байгуулалтын ажил.

Биелэлт: Засгийн газрын 2015 он, Батлан хамгаалахын сайдын 2015 оны тушаалаар Зэвсэгт хүчний 341, 342 дугаар ангийг байгуулж, ЗХЖШ-ын даргын 2022 оны А/330 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийг Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт, мөн даргын 2022 оны А/331 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний 342 дугаар ангийг Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт шилжүүлэн байршуулж, бие бүрэлдэхүүн ангийн байрлал дахь цэргийн объектыг барьж байгуулах, улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд оролцсон.

Барилга инженерийн цэрэг нь улс орны бүтээн байгуулалтын дараах ажлуудыг гүйцэтгэсэн. 2022 онд: Богдхан төмөр замын 40 км доод бүтцийн ажил, “Газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхон”-ы II шатны 287 айлын орон сууцны ажил, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн. Таван толгой-Зүүнбаян чиглэлийн 416 км төмөр замын дээд, доод бүтцийн барилга угсралтын ажлыг 2019-2022 онд, Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км төмөр замын 58.9 км-ын доод бүтэц, 33 км дээд бүтцийн угсралтын ажлыг 2022 оны 01 дүгээр сараас 2022 оны 11 дүгээр сард, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 15 км газар, шорооны ажил, 30 цэгт ус өнгөрүүлэх хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. 2023 онд: Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Гашуун сухайт боомтод хэрэгжиж буй “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах төсөл”-ийн бүтээн байгуулалтын ажилд 124 албан хаагч, 61 нэгж техниктэйгээр 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн үүрэг гүйцэтгүүлж байна. Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн Говь-Алтай аймагт хийгдэж буй авто замын засварын ажилд үүрэг гүйцэтгэж байна. Бусад тайланг 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн нууцын зэрэглэлтэй албан бичгээр хүргүүлсэн.

4.6.4.3.Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор /UBM/-ыг ашиглалтад оруулж, үйлдвэрлэлийг эхлүүлнэ.

Биелэлт: Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM) нь Батлан хамгаалах яамны баланст данс бүртгэлээр шилжин ирээгүй. Тус цогцолбортой холбоотой 33,177.4 сая төгрөгийн төлбөр үүссэн байна. ТОСК ТӨХХК-ыг ТУЗ-ын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар Хөгжлийн банкны нэхэмжилсэн дүн 25,649.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зээлийг БХЯ-нд шилжүүлэхээр хуралдсан боловч өр зээлийн асуудлаас шалтгаалан шийдэлд хүрч чадаагүй байна.

Батлан хамгаалах яамнаас 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолборыг цаашид ашиглах боломжтой эсэх талаар мэдээлэл ирүүлэх тухай” 05/381 дүгээр албан бичгийг Улаанбаатар хот дахь Гаалийн газарт хүргүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөгжлийн банкны хамтарсан ажлын хэсгээс хүсэлт ирүүлсний дагуу “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор иж бүрэн тоног төхөөрөмж”-ийн зээлд авах арга хэмжээний тухай засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Батлан хамгаалахын сайдын 2023 оны 1а/1662 дугаар албан бичгээр

яамдаас санал авахаар хүргүүлэхэд Хууль зүй, дотоод хэргийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам дэмжээгүй хариу ирүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 1в/3809 дугаар албан бичгээр Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар санал ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн. Мөн Барилга, хот байгуулалтын яаманд тус цогцолбор нь Батлан хамгаалах яамны өмч биш тул Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын 1.3 дахь заалтын хэрэгжилтийг ханган ажиллах хууль эрх зүйн боломжгүй бөгөөд цаашид Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг хүчингүй болгуулах саналтай байгаа талаар албан бичиг хүргүүлсэн.

4.6.4.4. Кибер аюулгүй байдлын Зэвсэгт хүчний Дата төвийг байгуулж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.

Биелэлт: “Кибер аюулгүй байдлын тухай” хуулийн төсөлд кибер аюулгүй байдлыг хангах зорилтыг олон улсын эрх зүйн жишиг хэм хэмжээ болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, практик хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх 16 саналыг тусган 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1а/1553 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

УИХ-ын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Н.Учралаар ахлуулсан ажлын хэсэг тус хуулийн эцсийн хэлэлцүүлгийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.

Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.4.5. Зэвсэгт хүчний тусгай хүчний цэргийг бэхжүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, тусгай хэрэгслээр хангах ажлыг эхлүүлж, тусгай хүчний анги байгуулна.

Биелэлт: Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.5. Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангах бодлогыг дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.

4.6.5.1. “Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах арга хэмжээ”-г батлуулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг боловсруулан сайдын 2021 оны А/250 дугаар тушаалаар батлуулсан. Тайлан нь Төрийн болон албаны нууцад хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсний дагуу тайлагнасан байна.

4.6.5.2-4.6.5.9. Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.1.2-т болон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасны дагуу тайлантай танилцаж, ХШҮ хийсэн.

4.6.6. Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, зэвсэгт хүчний олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

4.6.6.1. Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлнэ.

Биелэлт: Батлан хамгаалахын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Бүгд Найрамдах Филиппин Улсын Үндэсний батлан хамгаалах яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт хоёр улсын Батлан хамгаалахын сайд нар Сингапур Улсад 2022 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 19 дэх удаагийн “Шангри-Ла яриа хэлэлцээ” дээд хэмжээний уулзалтын үеэр гарын үсэг зурж баталгаажуулсан. Мөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын Арабын Нэгдсэн Эмират Улсад 2023 оны 02 дугаар сарын 16-26-ны өдрүүдэд хийсэн ажлын айлчлалын үеэр тус улсын Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Төрийн сайд Мохаммед Ахмед Аль-Буардитай яриа хэлэлцээ хийж, хоёр улсын сайд нар “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах болон айлчлал солилцооны тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНЭУ-ын Үндэсний Батлан хамгаалах яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурж баталгаажуулснаар гадаад хамтын ажиллагаатай орны тоо 39 болсон.

Саудын Арабын Хаант Улс, Тайландын Хаант Улсын батлан хамгаалах яамдад батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн төслүүдийг 2023 оны 09 дүгээр сард хүргүүлээд байна.

Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг боловсруулан Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/250 дугаар тушаалаар батлан, хэрэгжүүлж байна.

4.6.6.2. Олон улсын болон 2 талын хамтарсан сургалт, дадлага, хээрийн сургуулийн тоог нэмэгдүүлнэ.

Биелэлт: Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг, цэргийн алба хаагчийг оролцуулах болон олон улсын хамтарсан дараах сургалт, дадлага зохион байгуулсан. Тухайлбал; НҮБ-ын “UNMISS” ЭСА-нд Зэвсэгт хүчний 13 дугаар ээлжийн МББ-ны цэргийн баг, НҮБ-ын ЭСА-нд штабын ажилтан, цэргийн мэргэжилтэн, эмнэлгийн мэргэжилтэн, бүгд 39 албан хаагч, “Хааны эрэлд-2023” олон улсын сургууль, “Баланс мэжик-2023” тусгай хүчний хамтарсан сургууль, “Энхийн улирал-2023” хоёр талын сургууль, “Зам-2023” хоёр талын сургууль, “Зэв-2023” хоёр талын сургууль, ХБНГУ-тай хамтарсан “Уулын явган цэргийн сургууль”, АНУ-тай хамтарсан “Кибер аюулгүй байдлын сургалт” хоёр талын сургалт, НҮБ-ын ЭСА-ны сургагч багшийн дамжаа, “НҮБ-ын цэргийн ажиглагч офицерын дамжаа”, “НҮБ-ын штабын ажилтны дамжаа”, БНЭУ-тай хамтарсан “Нүүдэлчин заан” сургалт, дадлага, Гадаад Улсад: “ANATOLIAN-2023” олон улсын тусгай хүчний сургууль, ХЗЦ-ийн командлагч нарын хурал, зөвлөлдөх уулзалт, Энэтхэг номхон далайн бүсийн АЦ-ийн командлагч нарын зөвлөлдөх уулзалт, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний ХЗЦ-ийн Инженерийн сургуулийн сургалтын багтай хамтарсан “Зам-2023” сургалт дадлагад тус тус оролцож бие бүрэлдэхүүнийхээ мэдлэг, чадварыг нэмэгдүүлсэн.

Нэмэлтээр: Катар Улстай хамтарсан хээрийн дадлага, сургалт, “Олон нийттэй харилцах сургалт” хоёр талын сургалт, “Энхийн элч-2023” барилга-инженер, хүмүүнлэгийн хамтарсан сургууль, “Хүйтний улирлын сургалт” ЗХ-ний Хуурай замын командлал, АНУ-ын Аюулгүй байдлын 05 дугаар бригадтай хамтарсан сургууль, “Шийдэмгий шийдвэр-2023” Монгол Улсын Зэвсэгт хүчин, Катар Улсын Зэвсэгт хүчний хамтарсан сургалт, ХБНГУ-д

Баваар мужийн Миттэнволд дахь сургалтын төвд уулын явган цэргийн дунд шатны сургалт, дадлага

4.6.6.3-4.6.6.4. Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.1.2-т болон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасны дагуу тайлантай танилцаж, ХШҮ хийсэн.

4.6.7.Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.

4.6.7.1.Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, шинэ технологи, инновацыг нэвтрүүлнэ.

Биелэлт: Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/257 дугаар тушаалаар "Батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологи, инновацыг 2030 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г батлуулсан. Мөн 2021 оны А/351 дүгээр тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг 2030 он хүртэл хөгжүүлэх бодлого”-ын баримт бичгийн хүрээнд туршилт, судалгааны төвийг байгуулан судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг явуулж байна. Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/174 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний хөгжилд наалдацтай, хөгжлийн бодлогод нийцсэн, инновацад суурилсан, бүтээлч 8 эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг 70,991,510.00 төгрөгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Тухайлбал; “Батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааны хөгжүүлэх эрх зүйн орчны судалгаа”, Батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үндэстний бичигт хөрвүүлэх “Монгол бичгийн хөрвүүлэг-2022”, Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож буй талаарх нийгмийн сэтгэл зүй, чиг хандлага. Шифр: “ЭДА-Төрх”, Монгол Улсын аюулгүй байдалд био аюулын үзүүлэх нөлөөлөл. Шифр: Био аюул, Цэргийн зориулалттай богино долгионы дунд чадлын радио станцын шинэчлэл “Монрадио-1000А”.

4.6.7.2.Үндэсний батлан хамгаалахын их сургуульд нэгдсэн лаборатори байгуулна.

Биелэлт: Үндэсний батлан хамгаалахын их сургуульд Нэгдсэн лаборатори байгуулахаар холбогдох тооцоо судалгааг гаргасан бөгөөд төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж санхүүжилтийн асуудал түр хойшлогдсон.

4.6.7.3.Зэвсэгт хүчний нэгдсэн лабораторийг MNS/ISO олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн, чадавхыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн шалгалт тохируулга, сорилтын лабораториудад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO IEC 17025-2018 олон улсын стандартын дагуу 4 жилээр хугацаатай итгэмжлэлийн эрхийг авсан. Стандарт, хэмжил зүйн газрын улсын шалгагчийн аттестатчилалд радиотехникийн хэмжүүр, эзлэхүүн багтаамж, механик даралт, массын хэмжүүрийн төрлөөр улсын шалгагч шалгагчийн эрхээ 5 жилээр сунгуулсан. Мал эмнэлэг, бактери шинжилгээний лаборатори нь СХЗГ-аас MNS 5348-40:2010 Боом өвчний оношилгоо эмчилгээ, тандалт стандарт, сорилт шинжилгээнд шинэчлэгдэх шаардлагатай 16 стандарт, нийт 17 стандартыг худалдан авч үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

4.6.7.4-4.6.7.5. Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.1.2-т болон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасны дагуу тайлантай танилцаж, ХШҮ хийсэн.

4.6.8. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ”-г хэрэгжүүлж, “Оюутан-цэрэг” сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.

4.6.8.1. Бүх шатны боловсролын байгууллагын хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамтай хамтран хөдөлмөрийн насны 2387 иргэнийг сургалтад хамруулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабууд I шатыг 2022 оны 03 дугаар сарын 05-аас 05 дугаар сарын 12-ны өдрүүдэд 1,346 тасгийн 16,750, II шатыг 04 дүгээр сарын 16-аас 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд 285 тасгийн 3,871, III шатыг Батлан хамгаалах яам 08 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд 377 хүүхдийг хамруулан Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан.

“Бидний бахархал” төслийн нээлтийг 2022 оны 11 дүгээр сарын 09,10,11-ний өдрүүдэд нийслэлийн Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг Ерөнхий боловсролын 25 сургууль, 15 их, дээд сургуулийн 2,000 гаруй сурагч, оюутнуудыг хамруулж, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Тэмүүжин-Өрлөг дунд сургуулийг түшиглэн зохион байгуулсан. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит, Улсын аварга шалгаруулах 2023 оны Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд 15 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 3,600 гаруй хүүхдийг хамруулсан. Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын “Төсөл батлах тухай” 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 152 дугаар захирамжаар хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий “Бидний бахархал” төслийг улс орон даяар хэрэгжүүллээ.

4.6.8.2. Их, дээд сургуулиудад “Цэргийн эрдмийн тэнхим” байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Монголын Үндэсний их сургууль, Их засаг их сургууль, Орхон их сургуулиудад “Цэргийн эрдмийн тэнхим” байгуулагдан сургалт зохион байгуулж байгаа бөгөөд цэргийн анхан шатны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Боловсрол шинжлэх ухааны яаманд ҮБХИС-ийн материаллаг баазыг түшиглэн цэргийн мэргэжлийн багш нарын сургалтын хөдөлгөөнт бүлгээр их, дээд сургуулиудад цэрэгжлийн хичээлийг зохион байгуулж оюутан, суралцагчдад эх оронч, үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх ажлын хүрээнд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт цэрэгжилтийн хичээлийн багц цагийг тусгаж 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн зохион байгуулах талаар албан бичгийг сургалтын хөтөлбөрийн хамт 2023 оны 04 дүгээр сард хүргүүлсэн. 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын багц хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан дагалдан гарах дүрэм, журмууд шинэчлэгдэж байгаа тул шийдвэр хүлээгдэж байна.

4.6.8.3. “Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах их, дээд сургуулийн оюутан, МСҮТ-ийн суралцагчдын тоог шат дараатай нэмэгдүүлнэ.

Биелэлт: “Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтыг улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд нийслэл дэх их, дээд сургууль коллеж, мэргэжлийн сургалт

үйлдвэрлэлийн 400 гаруй суралцагчдыг хамруулан 11 бага мэргэжлийг эзэмшүүлсэн. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдах оюутан, суралцагчийн тоог энэ жил 1500-д хүргэхээр шийдвэрлэсний дагуу улсын төсөв, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн зохион байгуулсан. Онолын сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 06 дугаар 04-ний өдрүүдэд, Цэргийн мэргэжлийн бэлтгэл шатны сургалтыг 2023 оны 06 дугаар 19-ны өдрөөс 08 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулж, 1400 гаруй оюутан, сурагчийг Цэргийн тангараг өргүүлсэн.

4.6.9.Цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулна.

4.6.9.1.Зэвсэгт хүчний анги, байгууллагын мэдлийн тусгай хэрэгцээний газарт албан тушаалын орон сууц барина.

Биелэлт: Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/27, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/16, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны А/82 дугаар тушаалын дагуу Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 300.2 сая төгрөгийн санхүүжилтээр Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305, 321, 328 дугаар салбаруудад 8 айл, нийт 24 айлын орон сууцны барилга угсралтыг гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан.

4.6.9.2.Зэвсэгт хүчний ангиудад цэргийн байр шинээр барьж, одоо ашиглагдаж байгаа байруудыг засварлаж шинэчилнэ.

Биелэлт: Цэргийн алба хаагчдын ажиллаж, амьдрах ая тухтай орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 2021 онд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд: Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн ангорын барилга, цэргийн албан хаагч болон тусгай чиг үүргийн албан хаагчдын хүүхдийн цэцэрлэгийн барилга /150 ортой/ угсралт. Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн ЭДАСТ-ийн хурлын заал, эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, цэргийн байруудын дээврийн засвар, ангийн халаалтын тогооны засварын Зэвсэгт хүчний барилга инженерийн ангиуд болон аж ахуйн нэгж байгууллагуудаар гүйцэтгүүлсэн. 2022 онд: Зэвсэгт хүчний 110, 310 дугаар ангиуд тус нэгтгэлийн 2 цэргийн байрны барилгын дээвэр, гадна дулааны шугамын хэсэгчилсэн засвар, зарим барилгын дотор халаалтын шугамыг сольж, шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 327, 338, 339 дүгээр ангийн цэргийн гал тогооны барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

4.6.9.3.Зэвсэгт хүчний төв цэнгэлдэх хүрээлэнг Хужирбулан дахь сургалтын төвийн районд байгуулна. /биеийн тамир спортын төв/

Биелэлт: Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.1.2-т болон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасны дагуу тайлантай танилцаж, ХШҮ хийсэн.

4.6.9.4.Цэргийн хотхоны стандартыг шинэчилж, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагад шаардлагатай тохижилт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж амьдрах орчныг сайжруулна.

Биелэлт: Зэвсэгт хүчний 011 дүгээр анги, 016 дугаар нэгтгэлийг Эко-ногоон хотхон болгох төлөвлөлтийн дагуу Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023

оны А/44 дүгээр тушаалаар төсвийг шийдвэрлүүлж, төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн санхүүжилтээр анги, байгууллагууд тохижилтын ажлыг гүйцэтгэж байна. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2023 оны А/131 дүгээр тушаалаар Цэргийн алба зохион байгуулах зааврыг шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан цэргийн хотхон, барилга байгууламж, тавилга хэрэгслийн стандартыг шинэчлэн боловсруулж байна.

4.6.9.5. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн БХУА, Номын сангийн барилгын бүтээн байгуулалтын ажлыг дуусгах, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангана.

Биелэлт: Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн “Батлан хамгаалах удирдлагын академи”-ийг 2021 онд, “Ном мэдээллийн төв”-ийн барилгын ажлыг 2023 онд бүрэн дуусган улсын комисс хүлээн авч байнгын ашиглалтад оруулсан.

4.6.9.6. Цэргийн төв эмнэлгийг орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үргэлжлүүлэн дуусгана.

Биелэлт: Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа “Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл-II” төслийг хэрэгжүүлж, 41 нэр төрлийн 7,893,100.0 евро буюу 26.4 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийг хүлээн авч, суурилуулсан.

ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Ногоон хөгжил

5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

5.1.1.1. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авна.

Биелэлт: Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2023 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

1. “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн эрчим хүчний нүүрсийг баяжуулах туршилт хийсэн.
2. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хяналт шалгалт хийж 30 ажилтны ажлын хөлсөнд дэмжлэг үзүүлэв.
3. 5012 айл өрхийг 4 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах, техникийн боломж бүрдүүлэх 12 багц ажлыг хийсэн.
4. Хас, Хаан банкны ногоон зээлийг шийдвэрлэсэн.
5. Уур болон усан халаалтын зуухны судалгааг эрчим хүчний салбарын мэргэшсэн зөвлөх инженерүүдээр хийлгэсэн.
6. Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоо ойлголтыг баталгаат мэдээллээр хангах нөлөөллийн ажил хийсэн.

7. 30 сая мод хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймгийн ойн ангиудын техник хэрэгслийн чадавхыг бүрдүүлсэн.

Улаанбаатар хотын 2023 оны 11 дүгээр сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 10 мкг/м3 буюу 30 хувиар бага, PM10 тоосонцор 15 мкг/м3 буюу 16 хувиар их байна.

5.1.1.2. Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт: Орон нутагт агаарын чанарыг хянах 2 иж бүрэн автомат ажиллагаатай станцыг байгуулах, хяналт-шинжилгээний сүлжээг бэхжүүлэх зорилгоор Дархан-Уул, Дорнод аймагт 2 ширхэг агаарын чанарын автомат харуулыг суурилуулахаар 1.8 тэрбум төгрөг төсөвт өртөгтэй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын дүнгээр Интерсайнс ХХК-д 1.6 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлэхээр ажиллаж байна.

Дэлхийн банкны санхүүжилттэй Улаанбаатар цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төслийн хүрээнд Улаанбаатар хотын Налайх, Баянзүрх дүүрэгт 2 ширхэг агаарын чанарын автомат суурин харуул суурилуулж, тус 2 дүүрэгт орчны агаарын чанарын 6 үзүүлэлт бүхий агаарын чанарын мэдээллийг агаарын чанарын хяналтын үндэсний сүлжээ, www.agaar.mn цахим хуудаст шуурхай дамжуулах боломж бүрдүүлэх ажил хийгдэж байна.

БОАЖЯ, БНСУ-ын БОЯ хоорондын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд БНСУ-ын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгээр Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, БОАЖЯ-ны хашаанд агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах автомат суурин харуул шинээр байгуулан улсын нэгдсэн сүлжээнд холбосон.

5.1.1.3. Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн барилгыг шинэчилж, шинэ дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангана.

Биелэлт: “Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн Байгаль орчны төв лабораторийн барилгын зураг төсөл, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, төслийн явцын тайлан боловсруулах, захиалагчийн хүсэлтийн дагуу ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр сонгон шалгарсан БНСУ-ын “AUM & LEE Architects & Associates Co., Ltd, Korea Environment Corporation” нарын түншлэлтэй 23/119 дугаартай гэрээг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр байгуулж, гэрээний дагуу барилгын зураг төслийг боловсруулж байна.

5.1.1.4. Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон гадаадын зээл тусламж, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн хөрөнгө оруулалтаар 8552 м дулааны гол шугам сүлжээг өргөтгөх, шинээр татах томоохон ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд:

1. Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр VII Бичил хороолол, Амгалан орчмын халаалтын зуухтай барилгуудыг дулаанаар хангах 3 км хос дулааны шугам шинээр хийх ажлын худалдан авах ажиллагааг Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК зохион байгуулсан.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7.4 км хос дулааны шугам шинээр татах, 3.4 км хос шугамыг өргөтгөн шинэчлэх барилгын ажил хийгдэж байна.
3. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК 750 м хос шугамыг хэсэгчлэн солих ажил хийгдлээ.

4. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр ашиглалтын хугацаа дууссан дулааны гол шугам буюу 3г магистралыг бүрэн дуусгаж, 5а, 4а, 4б, 9аб, 12г, 9ж магистрал шугамуудын өргөтгөл шинэчлэлтийн ажил он дамжин хэрэгжинэ. Дээрх дулааны шугам сүлжээний ажил шинээр хийгдсэнээр Сонгинохайрхан дүүргийн 1-р хорооллын арын дэнж, Баянгол дүүргийн VII Бичил хороолол, Баянзүрх дүүргийн 10, 12-р хороо, Амгалан орчмын хэрэглэгчид төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломж бүрдэнэ.

2020-2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 4,882 ажлын зураг төсөл зөвшилцсөн байна.

5.1.2.Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

5.1.2.1.Хөвсгөл нуурын ёроолын судалгаа хийж, бохирдлын эрсдэлийг бууруулна.

Биелэлт: БОАЖЯ, ОБЕГ, ЗХЖШ, ШУТИС-ийн эрдэмтэн багш, цэргийн зөвлөх инженерийн бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний 186, 234 дүгээр ангийн алба, Онцгой байдлын газрын аврагчид 2020-2023 онд Хөвсгөл нуураас татан гаргасан “Сүхбаатар” хөлөг онгоц, 7 нэгж техник хэрэгслээс 34.7 тн бохир шатахуун, тос тосолгооны материал, Сүхбаатар хөлөг онгоцны ёроол хэсгээс 13 тн бохир, нийт 47.7 тн бохир шатахуун, тос тосолгооны материалыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны захирагчийн ажлын албатай хамтран нотломж үйлдэж, зориулалтын газарт холбогдох дүрэм, зааврын дагуу устгах ажлыг зохион байгуулсан. Нуурт живсэн тээврийн хэрэгслийг татан гаргах ажиллагааг зохион байгуулах хүрээнд хайгуул, судалгааны ажилд 9.7 тэрбум төгрөг, татан гаргах ажиллагаанд 2.3 тэрбум төгрөгийг Улсын төсвөөс санхүүжүүлсэн.

5.1.3.Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, нийслэлийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

5.1.3.1.Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийнэ.

Биелэлт: Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ус хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны хайгуулын ажлыг гүйцэтгэхээр 2022.04.20-ны өдөр БОАЖЯ/202211021 дугаартай гэрээг "Таширын хүрээ" ХХК-тай байгуулан ажлыг эхлүүлж, тус сумын ус хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны хайгуулын ажлын тайланг 2022 оны 10 дугаар сард хүлээн авч, усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Усны нөөцийн зөвлөл улсын төсвийн хөрөнгө болон аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр тогтоосон газрын доорх 9 орд газруудын нөөцийг баталсан. Үүнд:

1. Өмнөговь аймаг Манлай сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэр;
2. Өмнөговь аймаг Цогтцэций сумын нутагт барихаар төлөвлөсөн дулааны цахилгаан станцын ус хангамжийн эх үүсвэр;
3. Говь-Алтай аймаг Халиун сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэр;
4. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутагт барихаар төлөвлөсөн дулааны цахилгаан станцын ус хангамжийн эх үүсвэр;
5. Төв аймгийн Борнуур сумын нутагт барихаар төлөвлөсөн хий дамжуулах хоолойн ус хангамжийн эх үүсвэр;

6. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт барихаар төлөвлөсөн хий дамжуулах хоолойн ус хангамжийн эх үүсвэр;
7. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт баригдах нүүрс баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэр;
8. Булган аймаг Дашинчилэн сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэр;
9. Дорнод аймаг Чойбалсан хотод баригдах дулааны цахилгаан станцын ус хангамжийн эх үүсвэр;

5.1.3.2. Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтооно.

Биелэлт: 2022 онд Гидрогеологийн дунд масштаб зураглал хийсэн газар нутгийн хэмжээг 0.5 хувиар нэмэгдүүлж, (14.8% байсныг) 15.3 хувьд хүргэх зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Дэлгэрэх, Өргөн сум, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр Уулбаян, Халзан, Түвшинширээ, Асгат, Онгон, Баруун-Урт сумдын нутагт зураглалын ажлыг хийж гүйцэтгэн ерөнхий тайланг 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авсан. БОАЖС-ын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Төсвийн зардлын хуваарийг шинэчлэн батлах тухай” А/567 дугаар тушаалаар зардлыг баталсан. “Дунар-Од” ХХК-тай 2023.05.18-ны өдөр УГ/202301008 дугаар гэрээг байгуулсан. “Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлэх” зорилтын хүрээнд Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Мандах сумын нутагт (L-48-XXXV, L-48-XXXVI) 1:200000 масштабтай зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийсэн. Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн газар нутгийн хэмжээг 17.3%-д хүргэсэн.

5.1.3.3. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбоно.

Биелэлт: Монгол орны усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт хийх, газрын доорх усны хяналт шинжилгээний 319 цэгийг 6-аар нэмэгдүүлж 325 цэгийн мэдээллийг www.groundwater.mn нэгдсэн сүлжээнд холбосон. Улсын усны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх ажилд төсөв батлагдаагүй бөгөөд ус ашиглагч байгууллагуудын дотоодын хяналтын 4-өөс доошгүй цэгээр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Тус ажлын хүрээнд ус ашиглагч 10 аж ахуйн нэгж байгууллагад дотоодын хяналтын цэг байгуулж, сүлжээнд холбох тухай зөвлөмж хүргүүлсэн. Үүнээс Эрдэнэт ТӨҮГ-2 цэг, Саус Гоби Сэндс ХХК-2 цэг, Баянхонгор аймгийн Галуут сумын “Монгол болгар гео” ХХК-ийн алтны уурхай-1 цэг, Өвөрхангай аймгийн Хужирт сумын “Хужирт” ХХК-1 цэг, нийт 6 цэгийг шинээр холбож, улсын хэмжээнд 325 цэг сүлжээнд холбогдсон байна.

5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.

5.1.4.1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.

Биелэлт: Нүхэн жорлонгийн нэг маягийн СЛД-35/2022 СЛД-30/2022, ИД-18/2022, ХО-21/16, 09/2022 дугаартай зураг төсөл батлагдсан. УБ хот, Орхон аймгийн төвийн гэр хорооллын айл өрхөд 2022 онд 1620 өрхийн жорлонг ашиглалтад оруулсан. 2023 онд дараах байршилд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: ЧД-ийн “Эко хороо”, “Шинэ хороо төсөл”, “Ногоон хороо” төслийн хүрээнд 410 айлд; ЧД-ийн 7, 10, 12, 13, 14, 15-р хорооны 330 айлд; СХД-ийн 23, 39-р хороонд “Шинэ хороо” төслөөр 40 айлд эко жорлон суурилуулсан; ЧД-ийн 7, 10, 12, 13, 14, 15, 16, 17, 19-р хороонд “Эко жорлон”

төслөөр 450 өрхөд эко жорлон суурилуулахаас 250 айлын нүхэн жорлон шинэчлэгдсэн; Орхон аймагт 500, Ховд аймагт 450, СБД, ЧД, БЗД-т 300 айлын нүхэн жорлон шинэчлэгдсэн. 2023 онд нийт 2050 айлын нүхэн жорлон шинэчлэгдсэн байна.

5.1.4.2. Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулна.

Биелэлт: 2023 онд 1061 аялал жуулчлалын бааз, ШТС-дад хяналт шалгалт хийж, стандартын шаардлага хангаагүй 516 нүхэн жорлонг буулгуулж, 1815 м² талбайд мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгүүлсэн байна.

Аймаг, нийслэл, Улсын тусгай хамгаалалттай газар, Сав газрын захиргаадад “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын гаргасан албан даалгаврын хүрээнд аялал жуулчлалын бүсэд байгаа стандартын бус нийт 2,477 жорлонг буулгаж, шинээр 1,945 эко ариун цэврийн байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Европын Холбооны санхүүжилтээр Монгол Улсад "Бохирдлыг бууруулах замаар эрүүл мэнд, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг сайжруулах нь" төслийн хүрээнд “Орчны бохирдлыг бууруулъя” аян зохион байгуулж, стандартын бус нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлоос сэргийлэх чиглэлээр 5 төрлийн инфографик, 1 баримтат видео боловсруулан олон нийтэд түгээсэн байна.

5.1.4.3. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах (стратеги) төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. АНУ-ын МССК-ын буцалтгүй тусламжаар УБ хотын гэр хорооллын ус түгээх байрыг ухаалаг системд холбох төсөл хэрэгжүүлж УБ хотын Баянзүрх, Багануур, Налайх дүүрэг, Ховд, Дорноговь, Увс аймгийн төвд ухаалаг ус түгээх байрыг шинээр барьж ашиглалтад оруулсан.
2. АХБ-ны техник туслалцааны төслийн хүрээнд салбарын хэмжээнд инженер техникийн ажилтнуудыг сургах сургалтын 14 загварын хөтөлбөр боловсруулах төслүүдийг хэрхэн боловсруулах талаар ажлын хэсгийн 2022.10.12-ны хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн.
3. Увс, Говь-Алтай аймгийн хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтооход дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.

5.1.5. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

5.1.5.1. Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажлын үр дүн, чанарыг сайжруулж, мод тарьж ургуулахад мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Улсын хэмжээнд 80 га талбайд ойжуулалт, 802 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил, 75 га талбайд хамгаалалтын ойн зурвас буюу нийт 973 га талбайд ойжуулалт, ой нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлсэн бөгөөд үрийн байнгын болон түр талбай тусгаарлах, арчлах ажлын хүрээнд 140 га талбайд тусгаарлалт, арчилгааны ажлыг хэрэгжүүлсэн.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 41.5 сая мод тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хувийн хэвшил, төрийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор 26.9 сая навчит болон шилмүүст төрлийн мод тарьж ургуулан арчилж байна. Тарьсан нийт модны тоо хэмжээг 1 га талбайд тарих модны дундаж тоо буюу 2500 ширхэгт харьцуулахад 10.7 мянган га талбайд мод, сөөг тарьсан.

Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний 1 га талбайн норматив зардлын хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/172, 116 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Хөвсгөл, Өмнөговь, Говьсүмбэр, Дорнод зэрэг аймаг мод тарьж ургуулах ажилд идэвхтэй оролцсон 151 иргэн, 11 аж ахуйн нэгж, байгууллагыг 114.8 сая төгрөгөөр урамшуулсан байна.

5.1.5.2. Ойн хөнөөлт шавжийн голомттой ойн санд тэмцлийн ажил явуулж, ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж хомсдол, доройтлыг бууруулж, ойн төлөв байдлыг тогтмол үнэлнэ.

Биелэлт: Ойн хөнөөлт шавжийн голомт үүссэн 82.0 мянган га талбайд тэмцлийн ажлыг агаарын хөлөг, үүргийн шүршигч багаж ашиглан микробиологи, хими, гэрлэн урхи, дэлгэц байрлуулах аргуудаар орон нутгийн болон улсын төсвийн санхүүжилтээр 80-аас дээш хувийн техникийн үр дүнтэйгээр зохион байгуулсан. Хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох судалгааны ажлыг 16 аймаг, 109 сум, Улаанбаатар хотын ногоон бүс, Богдхан уулын ДЦГ-ын ойн сангийн 2.2 сая га талбайг хамруулан гүйцэтгэж навч, шилмүүсний 5 зүйлийн хөнөөлт шавжийн голомт 737.1 мян.га талбайд үүсээд байгааг тогтоосон. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээг "2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай" БОАЖС-ын 2022 оны А/327 дугаар тушаалаар баталж, ойн арчилгаа, ойн цэвэрлэгээний огтлолт, ойн цэвэрлэгээний ажлыг хүлээгдэж буй гүйцэтгэлээр 15 аймаг, нийслэлийн хэмжээнд 20.3 мянган га талбайд хийж гүйцэтгэсэн. 5 аймгийн хилийн бүс зурваст нийт 187.6 км урт түймрээс хамгаалах шороон зурвас байгуулж, 782.2 км шороон зурвасыг сэргээсэн байна.

5.1.5.3. Ойн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, ойн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: "2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай" БОАЖС-ын 2022 оны А/327 дугаар тушаалаар ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээг баталж, ойн арчилгаа, ойн цэвэрлэгээний огтлолт, ойн цэвэрлэгээний ажлыг хүлээгдэж буй гүйцэтгэлээр 15 аймаг, нийслэлийн хэмжээнд 20.3 мянган га талбайд хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр ойн 9 ангитай гэрээ байгуулан ойн арчилгааны гэрэлжүүлэх, тохируулах хэлбэрийн огтлолтыг 195 га талбайд хийлгэж, актаар хүлээн авсан байна.

Мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээний олголт, зарцуулалтад хяналт тавих зорилгоор веб суурьтай интернэт орчинд ажилладаг цахим санг үүсгэн өгөгдлийн санг Үндэсний Дата төвд байршуулсан. Улмаар Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын мэдээллийн технологи, холбооны төвтэй хамтран мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээний цахим хяналтын санг Е-Патрол системд холбож, гарал үүслийн гэрчилгээнд хөдөлгөөнт төхөөрөмжөөр хяналт тавих боломжийг судалж байна.

5.1.5.4. Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Биелэлт: Цөлжилтөд хүчтэй өртсөн 5 аймагт газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн зардлаар орон нутагт эрх шилжүүлэн 50 га талбайд цөлжилт бууруулах арга хэмжээ, ойжуулалтын хөтөлбөрийн зардлаар 40 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил хийсэн. Орон нутгийн төсвөөр 100 га талбайд хамгаалалтын зурвас байгуулахаар аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээнд тусган биелэлтийг хүлээн авч тайланг нэгтгэсэн. Ногоон ази, Ногоон хэрэм, Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслийн хүрээнд нийт 30 орчим га талбайд хамгаалалтын зурвас байгуулж, нийт 210 га талбайд цөлжилтийг сааруулах, хамгааллын арга хэмжээ зохион байгуулсан.

5.1.6.Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна.

5.1.6.1.Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж, өргөжүүлнэ.

Биелэлт: “Зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд хууль тогтоомжийн хуульд заасны дагуу судалгаа хийж, үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлан, Газрын харилцаа геодези зураг зүйн газраар дүгнэлт гаргуулсан. 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр үндэслэл боловсруулсан судалгааны баг талуудын оролцоотой хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох санал, зөвлөмжийг тусгав. Нийт 6 аймгийн 25 сумдын нутаг дэвсгэрийг хамарсан 2.1 сая га талбай бүхий 14 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахаар “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан, санал авч байна.

5.1.6.2.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дэд бүтэц, материаллаг баазыг сайжруулна.

Биелэлт: Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын нутгийг дамнан орших Гутайн даваа-Хөмүүл голын эхийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааг Хэнтий аймгийн Биндэр сумын төвд байгуулах шийдвэр 2022 онд гарч, 2023 оноос албан хаагчдыг томилж үйл ажиллагааг жигдрүүлсэн.

Япон Улсын Засгийн газрын “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих, материаллаг баазыг бэхжүүлэх сайжруулах зорилгоор богино долгионы холбоогоор тоноглогдсон, туулах чадвар сайтай Ниссан Патрол (Y-61) маркийн 30 автомашиныг 21 Сав газрын захиргаад, 2 улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад, 2 аймгийн Цаг уур, орчны шинжилгээний газар болон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын харьяа байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна. ХБНГУ-ын Сэргээн босголтын банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслийн хүрээнд “Хилийн цэргийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-тай гэрээ байгуулж, 2.3 тэрбум төгрөгийн төсөвтэй нийт 919 байгаль хамгаалагчийн 11995 ширхэг 4 улирлын иж бүрэн дүрэмт хувцсаар хангасан. Гэрээний дагуу 10 нэр төрлийн 7358 ширхэг хувцас хэрэглэлийг ажлын хэсгийн хурлын тэмдэглэл үйлдэж, актаар хүлээн авсан. “Үндсэн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нийлүүлэх” MONNCB-02/321, 23/02 дугаар гэрээний дагуу 11 нэр төрлийн 208 ширхэг

оффисын тавилга, IT тоног төхөөрөмжийг БОАЖЯ, Дарьгангын БЦГ, Ачит нуур-Дэвэл арлын БЦГ, Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ, Тэсийн гол-Булнайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн байна.

5.1.7. Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно.

5.1.7.1. Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, хадгалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Архангай, Говь-Алтай, Дорнод, Орхон, Төв, Сүхбаатар, Завхан Хөвсгөл, Хэнтий аймгуудад 930 монгол тарвага (9 аймагт) сэргээн нутагшуулах ажлыг зохион байгуулсан. Эдгээр тарваганы 620 толгойг зөвхөн Хустайн байгалийн цогцолборт газраас барьж, 6 аймгийн 14 суманд сэргээн нутагшууллаа. Тарвага сэргээн нутагшуулаад орхих биш тухайн нутгийн удирдлага, нөхөрлөлд хүлээлгэн өгч хариуцуулж, хүний шууд ба дам нөлөө, хууль бус агнуураас сэргийлэх улмаар тоо толгойг өсгөх боломжийг бүрдүүлж байна.

Орхон, Төв, Хэнтий, Архангай аймагт 40 халиун буга нутагшуулах ажил хийгдсэн. Халиун бугыг сэргээн нутагшуулах нь тухайн газрын бугын цус сэлбэх, тоо толгойг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Архангай аймгийн Бөхөн шарын нуруунд 10 толгой Баданга хүдэр сэргээн нутагшуулж, 4 Баданга хүдэрт сансрын дохиололтой хүзүүвч зүүх ажлыг хэрэгжүүллээ. Сансрын дохиололтой хүзүүвч зүүснээр уг нутагшуулсан амьтны шилжилт хөдөлгөөн, тархац нутгийн мониторинг судалгааг хийхэд чухал ач холбогдолтой юм.

Архангай аймагт 10 янгир, Хөвсгөл аймгийн Жаргалант суманд 11 янгир сэргээн нутагшуулах ажлыг ШУА-ийн Биологийн хүрээлэн, Газарзүй, гео-экологийн хүрээлэн, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүллээ. Ургамлын нөөц хамгаалах чиглэлээр: Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь "ENSURE төслийн санхүүжилтээр Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн нутагт улаан гоёо, чонон хармагийн байгалийн сэргээн ургалтыг дэмжих, эх ургамлын плантаци байгуулах, 6 га талбайд Тоорой модыг шилжүүлэн суулгаж байгалийн сэргэн ургалтыг дэмжин хашиж хамгаалах ажлыг хийсэн. Нийт 20 орчим ААНБ 16 зүйл ашигт ургамлыг 2000 орчим га талбайд тарималжуулан генетик нөөцийг нэмэгдүүлээд байна.

5.1.7.2. Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг үе шаттайгаар тогтооно.

Биелэлт: 2019-2023 онуудад ургамал газарзүйн 5 тойргийн ургамалжил тархац нөөцийн судалгааг хийсэн. Энэ нь нийт газар нутгийн 35 хувийн хамаарч байна. Монгол Алтайн өндөр уулсын Ховдын цөлөрхөг хээрийн тойрогт 74 овгийн 344 төрлийн 1015 зүйл, Монгол Алтайн уулын хээрийн тойрогт 80 овгийн 435 төрлийн 1625 зүйл гуурст дээд ургамал тус тус тархан ургаж байгааг илрүүллээ.

Улаан дансны (IUCN) үнэлгээгээр 2012, 2019, 2020, 2022 онуудад Монгол орны 6,456 зүйл ургамлыг үнэлэхэд Устаж байгаа (CR) 122, Устаж болзошгүй (EN) 321, Эмзэг (VU) 510, Ховордож болзошгүй (NT) 582, Анхааралд өртөхөөргүй (LC) 2,807, Мэдээлэл дутмаг (DD) 1,755, Үнэлэх боломжгүй (NA) 359 зэрэглэлд хамруулж, нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг шинэчлээд байна.

Хар сүүлт, Монгол бөхөн, Хулан гэсэн 3 амьтны нөөцийн судалгааг хийх ажлын хүрээнд Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас Хар сүүлт, Хулангийн судалгааг Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт нийт 116.0 мян.км2 талбайд хийхэд тус бүс нутагт 94,000 хар сүүлт, 85,000 гаруй Хулан байгаа нь тогтоосон ба нийт тархцын хэмжээнд 92,000 гаруй толгой хулан байна гэж тооцсон байна.

Монгол орны Халиун бугын судалгааны үр дүнд манай орны 15 аймгийн нутагт нийтдээ 192,150.7 км², голомт нутгийн хэмжээ 77,596.7 км² талбайд тархсан бугын нийт тоо толгойг 55,215 гэж тогтоож, ойн туруутны үнэлгээг хамгийн сүүлд хийсэн 2010 оны үзүүлэлттэй харьцуулахад халиун бугын ерөнхий тархац нутаг 70,000 орчим км²-ээр, тоо толгой 3 дахин өссөн байна.

Монгол орны загас бүхий томоохон гол, нууруудад тархаад байгаа Тураг гогойн судалгааг БОАЖЯ-ны захиалгаар Агнуур судлалын нийгэмлэг ТББ гүйцэтгэж, тоо толгойн ерөнхий судалгааг гаргаж, судалгаанд үндэслэн Тураг гогойг хянах, бууруулах төлөвлөгөөг боловсруулсан.

5.1.7.3. Генетик нөөцийг хамгаалах эрхзүйн зохицуулалтыг бүрдүүлж, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэнэ.

Биелэлт: Генетик нөөцийн тухай хуулийг УИХ-ын чуулганы 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

"Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийг тогтоох, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах урьдчилсан зөвшөөрөл авах журам"-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/324 дугаар, "Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, ашиглах, хадгалах, хамгаалах журам"-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/325 дугаар, "Генийн сан байгуулах, сан хөмрөгийг баяжуулж бүртгэх, хадгалж хамгаалах, түгээх, солилцох журам"-ыг БОАЖ болон БШУС-ын хамтарсан 2023 оны А/574, 537 дугаар тушаалаар тус тус батлуулсан. Журмуудыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний 5940, 5941, 6041 дүгээр актад бүртгүүлсэн. Генетик нөөцийн тухай хуулийг сурталчлан таниулах, дагалдан гарсан журмуудыг танилцуулах сургалт, "Биологийн олон янз байдал-Генетик нөөц ба био аюулгүй байдал" салбар дөрөвдүгээр хуралдааны үеэр генетик нөөцийн тухай хууль эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаарх хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан.

5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.

5.1.8.1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.

Биелэлт: Монгол Улсын Шадар сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 167, А/698, А/336, А/242 тоот "Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай" хамтарсан тушаалыг батлуулж "Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах салбар дундын ажлын хэсгийг байгуулж, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэн ажиллаж эхэлсэн. Нөхөн сэргээлтийг эрчимжүүлж ажилласны дүнд 2020, 2021, 2022 онд нийт 6285 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2086 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн. 2023 онд Монгол Улсын хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт нийт 3503,1 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 463,7 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд хийсэн. Үүнээс эвдэрч орхигдсон 2059 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн.

5.1.9. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулна.

5.1.9.1. Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулна.

Биелэлт: Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар 20 га газрыг “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 377-р тогтоолоор батлуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/52 дугаар тушаалаар “Төв аймгийн Сэргэлэн суманд Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих төслийн концессын уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгах” ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс концессын уралдаант шалгаруулалтын ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын 2023 оны 379 дүгээр тогтоолоор Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийн төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгасан.

5.1.9.2. Химийн хорт болон аюултай бодисын цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгоно.

Биелэлт: Химийн хорт болон аюултай бодисын цахим бүртгэл, мэдээллийн <https://chemical.met.gov.mn/> цахим системийн хөгжүүлэлтийг хийж ашиглалтад оруулсан. Химийн хорт болон аюултай бодисын цахим бүртгэлийн системийг ашиглаж эхэлснээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгож байгаа химийн бодисын тусгай зөвшөөрлийг мэдээллийн систем ашиглаж байгаа Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар болон бусад мэдээллийг авах эрхтэй төрийн захиргааны байгууллагууд шууд харах боломжтой болсон. 2023 онд Химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрлийг 196 аж ахуйн нэгж, байгууллагад E-Mongolia системээр дамжуулан олгосон.

5.1.10. Туул голын сав газраас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохыг таслан зогсоож, нөхөн сэргээлт хийж, усны түвшинг нэмэгдүүлнэ.

5.1.10.1. Туул голын хамгаалалтын бүсэд хяналт тавьж, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, аж ахуйн нэгжээр нөхөн сэргээлт хийлгэнэ.

Биелэлт: Төв аймгийн мэргэжлийн хяналтын газрын даргын 2021 оны 279 тоот, 345 тоот албан бичгээр ашигт малтмалын ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан нийт 37.1 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учруулсан зөрчлийг шалгуулахаар Төв аймаг дахь Цагдаагийн газарт шилжүүлсэн. МХЕГ-ын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 01/126 дугаар удирдамжийн дагуу Хан-Уул дүүрэг болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 62 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар 8 аж ахуйн нэгжид улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, Зөрчлийн тухай хуулийн дагуу 29.3 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, техникийн нөхөн сэргээлтийг 39.3 га, биологийн нөхөн сэргээлтийг 5.3 га талбайд хийж гүйцэтгүүлсэн.

“Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газрыг нөхөн сэргээх аргачлал”-ыг Азийн сан болон “Ногоон титэм” ХХК-тай хамтран боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/328 тоот тушаалаар батлуулсан.

5.1.11."Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.

5.1.11.1.1.Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

Биелэлт:Хэрлэн-Тооно төслийн ТЭЗҮ тодотгох ажлын даалгаврыг боловсруулж 2023.01.18-ны өдрийн 01/49 тоот албан бичгээр "Эрдэнэс Оюутолгой" ХХК-д хүргүүлсэн. ТЭЗҮ-ийн тодотгол хийх санхүүжилтийг "Оюутолгой" ХХК шийдвэрлэсэн. Нийт төсөвт өртөг 3 сая ам.доллар. Усны газар, "Эрдэнэс Оюутолгой" ХХК, Оюутолгой ХХК-тай хамтарсан хурлыг 3 удаа хийж, ТЭЗҮ тодотгох ажил болон судалгааны ажлын талаар нарийвчлан хэлэлцэж санал авсан. "Хэрлэн-тооно" төслийн ТЭЗҮ-ийн судалгааг шинэчлэх, тодотгол хийж боловсруулах ажлын даалгаварт дээрх саналуудыг тусган Усны газраар ажлын даалгаврыг дахин батлуулж, хүргүүлсэн. Тендерийн баримт бичгийг боловсруулан, тендер зарлахаар үнэлгээний хороо байгуулсан.

5.1.11.1.2.Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

Биелэлт:Онги Цагаан бургастайн төслийн хүрээнд Говийн бүсийн 4 аймгийн 11 сумын 40 гаруй мянган хүн амын унд, ахуйн хэрэгцээний усаар найдвартай хангах, Улаан нуурын усны түвшинг нэмэгдүүлэх, уул уурхайн ус хангамжийг сайжруулах зорилгоор Онги-Улаан нуур-Тавантолгой ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ, техникийн зураг төслийг 2022-2023 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар "Гидродизайн инноваци" ХХК хийж гүйцэтгэсэн. "Эгийн гол, Шүрэн, Чаргайтын УЦС, Орхон усан цогцолбор" бүс нутгийн байгаль орчны үнэлгээний ажлын 3.9 тэрбум төгрөгийг ЭЗХЯ-нд батлуулсан.

5.1.11.2.Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.

Биелэлт:Орон нутгийн санхүүжилт болон ААНБ-ын өөрийн хөрөнгө, Байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр улсын хэмжээнд нийт 578 булгийг хашиж, хамгаалан, 18 хөв цөөрөм шинээр гаргаж, 678.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Орхон голоос эх авч Онги голын урсцыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурины хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой "Орхон-Онги" эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Улаан нуур-Даланзадгад-Таван толгой" чиглэлийн ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг "Гидродизайн инноваци" ХХК хийж гүйцэтгэн ажлын явц 80 хувьтай явагдаж байна. Ус дамжуулах байгууламжийн трассын урт 358 км Онгийн хийд орчимд 2 гадаргын ус хуримтлуулах сантай. Тус усан сангаас Улаан нуур хүртэл өөрийн урсгалаар ус дамжуулах 110 км хоолой, Улаан нуураас Таван толгой хүртэл 248 км ус дамжуулах байгууламжтай, засварын усан сан бүхий 4 өргөлтийн насос станцтайгаар төлөвлөгдөн хийгдэж байна.

5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.

5.1.12.1. Уур амьсгалын өөрчлөлтийн харилцааг зохицуулах эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Биелэлт: Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн техник туслалцааны хүрээнд хэрэгжүүлж байгаа “Уур амьсгалын бодлогын чадавх бэхжүүлэх” төслийн дэмжлэгтэйгээр БОАЖ-ны сайдын 2022 оны А/77 дугаар тушаалаар байгуулагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг болон хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий олон улсын зөвлөх, үндэсний зөвлөх нар хамтран уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгааг хийж, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулсан.

5.1.12.2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана.

Биелэлт: “Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Бүгд Найрамдах Сингапур Улсын Тогтвортой хөгжил, байгаль орчны яам хоорондын санамж бичиг” 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан.

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд засан зохицох үйл ажиллагааны хүрээнд БОАЖЯ, ХХААХҮЯ болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран ENSURE төслөөс “Түншлэлийн форум-2023” арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд, Монгол Улсын төрийн байгууллагуудад нүүрстөрөгчийг үнэлэх механизм үүнд нүүрстөрөгчийн татвар зэрэг эдийн засгийн хэрэгслүүдийн талаарх мэдлэг, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд, “Цэвэр агаар-Дээд түвшний чуулга уулзалт”-ыг 2023 оны 03 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд, Байгаль орчны хамтын ажиллагааны Зүүн хойд Азийн дэд бүсийн хөтөлбөр (NEASPEC)-тэй хамтран “Цөлжилт, газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх шинжээчдийн бүлгийн хурал”-ыг 06 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд тус тус амжилттай зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар болон Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (UNFCCC)-ын Ази, номхон далайн бүсийн хамтын ажиллагааны төвөөс хамтран 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Парисын хэлэлцээрийн 6-р бүлэг ба нүүрстөрөгчийг үнэлэх механизм” зөвлөлдөх уулзалтад оролцож, нүүрстөрөгчийн зах зээл, механизмын талаар БОАЖЯ-ны зүгээс баримталж буй бодлого, стратегийн талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран “Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тодорхойлох аргачлал боловсруулах” судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд хүлэмжийн хийн ялгарлын итгэлцүүрийг БОАЖЯ-ны дэргэдэх “Уур амьсгалын үндэсний хороогоор хэлэлцүүлж батлуулах, олон улсын мэдээллийн сан /IPCC Emission Factor Database (EFDB)/-д Монгол Улсын “Үндэсний онцлогт тохирсон ялгарлын коэффициент”-оор бүртгүүлэх бэлтгэлийг хангасан.

5.1.12.3. Уур амьсгалын ногоон сан, Азийн хөгжлийн банк, Тогтвортой санхүүжилтийн холбоо, Монголын банкны холбоо, банкууд хамтран Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Байгаль орчны хөтөлбөр, Олон улсны хөдөлмөрийн байгууллага, Хүүхдийн сан, UNHABITAT, АХБ, ДБ, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, Азийн сан, Дэ Нэйче, USAID зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр 2023 оны байдлаар нийт 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнээс буцалтгүй тусламжаар 35 сая ам.доллар, техникийн туслалцаа хэлбэрээр 32 сая ам.долларын санхүүжилт хийгдсэн.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Байгаль орчны хөтөлбөр, Олон улсны хөдөлмөрийн байгууллага, Хүүхдийн сан, UNHABITAT, АХБ, ДБ, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, Азийн сан, Дэ Нэйче, USAID зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр 2023 оны байдлаар нийт 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнээс буцалтгүй тусламжаар 35 сая ам.доллар, техникийн туслалцаа хэлбэрээр 32 сая ам.долларын санхүүжилт байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслийн хүрээнд байгаль орчны бичил зээл, “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслийн хүрээнд орчны бүсийн эргэлтийн сангийн зээл олгох ажлын бодлогын удирдамжаар ханган ажиллаж, 2020-2022 онд нийт 400 орчим иргэн, аж ахуйн нэгж ногоон зээл, хөнгөлөлттэй санхүүжилтэд хамрагдсан бол 2023 онд 291 иргэн, ААН хамрагдсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж байгаа ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх ажил болон салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2019-2023 онд нийт 2000 гаруй иргэн аж ахуйн нэгж ногоон зээл, хөнгөлөлттэй санхүүжилтэд шууд хамрагдаж, 6000-аас доошгүй иргэн, ААНБ үр өгөөжийг хүртээд байна.

5.1.12.4. Ус, цаг агаарын урьдчилан сэргийлэх дунд, урт хугацааны мэдээ боловсруулах супер компьютерыг шинэчилнэ.

Биелэлт: “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн санхүүжилтээр шинэ үеийн супер компьютерыг худалдан авч суурилуулах олон улсын тендер зарлахад шаардлагатай тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтууд, ажлын даалгаврыг боловсруулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс супер компьютер худалдан авч суурилуулах олон улсын нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, үнэлгээг хийж байна. Мөн супер компьютерыг суурилуулах бэлтгэл ажлын хүрээнд “ЦУОШГ-ын барилгын цахилгаан, агааржуулалтын системийн хүчин чадлыг нэмэгдүүлэх” МОХИУАӨДЗЧНЭМСНТ/202209059 тоот худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан “Хурд монтаж” ХХК-тай гэрээ байгуулан, супер компьютерыг суурилуулах өрөөнд агааржуулалтын нөөц систем угсрах, цахилгааны кабелиг шинэчлэх, шилэн хоргыг зөөж байрлуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. Супер компьютерын хэрэгцээ шаардлага, ажиллах зааварчилгаа, цаг агаар, уур амьсгал, усны загварчлалын талаар Хирошима их сургуулийн зөвлөх мэргэжлийн баг 2023 онд ЦУОШГ-ын 20 албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Тоног төхөөрөмжийн эхний үе шатны бэлтгэл ажлын суурилуулалтыг зохион байгуулсан. 2 дахь үе шатны тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс зохион байгуулж байна.

5.1.12.5. Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Доплерын Радарын станц байгуулна.

Биелэлт: Монгол Улсын төсөвт Хөвсгөл аймагт радарын станц байгуулахад шаардлагатай 5.9 тэрбум төгрөгийн зардал тусгагдаагүйн улмаас хэрэгжээгүй.

5.1.12.6.Барилгын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө”-ний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, нотлохтой холбоотой үндэсний үйл ажиллагааны хийдлийн үнэлгээ” хийх зөвлөх үйлчилгээ авч, ажлын даалгаврын дагуу боловсруулсан Хийдлийн тайланг акт үйлдэн хүлээж авсан.
- a. “Хүлэмжийн хийн ялгарал багатай хот болон барилга байгууламжийн төлөвлөлт” сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын даалгаврын дагуу боловсруулсан сургалтын хөтөлбөрийг акт үйлдэн хүлээж авсан. Дээд боловсролын тухай хуульд нийцүүлэн ШУТИС-ийн Хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай саналыг 2023.06.22-ны өдрийн 1/2293 тоот албан бичгээр ШУТИС-д хүргүүлсэн.
- b. “Ногоон барилгыг үнэлэх аргачлал”, “Ногоон барилгыг гэрчилгээжүүлэх журам”-ыг боловсруулах Зөвлөх үйлчилгээний болон “Ногоон барилгын тогтолцоог бүрдүүлэх судалгаа”-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан “Монголын Ногоон барилгын хүрээлэн” ТББ-аас эхний шатны тайланг хүлээн авсан.

5.1.12.7.Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийг нэвтрүүлнэ.

Биелэлт: Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг (ҮТХН/NDC) хэрэгжүүлэх зорилгоор Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын онлайн платформ (<http://ghgconstruction.gov.mn>) буюу тооллогын мэдээллийн сангийн үйл ажиллагааг дэмжих, нээлттэй танилцуулахад ашиглах дэлгэц болон иж бүрэн суурин компьютерыг БХБЯ-д хүлээлгэн өгч дэмжлэг үзүүллээ.

Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын онлайн платформ буюу тооллогын мэдээллийн санд “Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдоогүй ердийн галлагаатай барилга байгууламжийг тооллогод хамруулах аргачлал”-ын дагуу тооцоолол хийх, системийг ашиглах талаарх сургалтыг хийсэн.

Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын онлайн платформын гүйцэтгэгч “Софт мастер” ХХК-ийн ажлыг 2023.12.01-ний өдөр акт хүлээж авсан.

5.1.12.8.Ус, цаг уурын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлнэ.

Биелэлт:ХБНГУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа KfW төслийн санхүүжилтээр 4 ш цаг уурын автомат станцыг Баян-Өлгий аймгийн Өлгий өртөө, Говь-Алтай аймгийн Эрдэнэ харуул, Баянхонгор аймгийн Баянхонгор өртөө, Увс аймгийн Хөхтолгой өртөөнд суурилуулж, шинжилгээний ажилд ашиглаж эхэлсэн.

БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Монгол Улсад цаг агаарын ажиглалтын нэгдсэн системийг суурилуулах” төслийг БОАЖЯ-ны яамны харьяа Цаг уур, орчны шинжилгээний газар тус улсын Цаг уурын газартай хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд Дундговь, Өвөрхангай аймгууд, Улаанбаатар хотод нийт 20ш автомат станц суурилуулах бэлтгэл ажлыг хангасан. БНСУ-ын Цаг уурын байгууллагаас тус төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан БНСУ-ын NOAA SNC компанийн мэргэжилтнүүд 2023 оны 08 дугаар сард Монгол Улсад ирж суурилуулах газрын урьдчилсан судалгааг хийсэн.

БНСУ-ын буцалтгүй тусламжаар “Монгол Улсын 21 аймгийн төвд агаарын чанарын хяналтын автомат харуул суурилуулах, улсын нэгдсэн сүлжээний чадавхыг бэхжүүлэх төсөл” хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны корпорац хооронд байгуулах хэлэлцээрийн протоколд гарын үсэг зурах бэлтгэл ажлыг хангасан.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 4-р хороо, Арцатын аманд агаарын чанар, цаг уур, орчны шинжилгээний хяналт, мониторингийн иж бүрэн автомат суурин харуулыг 2023 оны 09 дүгээр сард суурилуулж, нэгдсэн сүлжээнд холбосон.

Завхан аймгийн Отгон сумын цаг уурын өртөөнд суурилуулах 1ш цаг уурын автомат станц худалдан авах нээлттэй тендерийг 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулж, 12 дугаар сарын 15-ны өдөр автомат станцыг хүлээн авсан.

ЗУРГАА.НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Улаанбаатар хот

6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.

6.1.1.Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн 20 жилээр төлөвлөнө.

6.1.1.1.Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 94/А/443 тоот тушаал, захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгээс “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичигт “Сонсголонт хот”, “Сэлбэ сэргэлт” төслийг уялдуулан, баяжилт хийж боловсруулах үүрэг даалгавар өгсөн.

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барих ажлын хүрээнд “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулганаар батлуулахаар шийдвэрлэсэн.

6.1.2.Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад, Дарь-Эх дэд төвүүдийг шинээр байгуулна.

6.1.2.1."Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шар хад дэд төвүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэн дуусгана.

Биелэлт: Төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу Ханын материалын эцэст 9 давхар, 2 блок 126 айлын орон сууцыг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр ашиглалтад орууллаа. Төслийн 2 дугаар үе шатны хүрээнд Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдийн нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд зураг төсөл боловсруулалтын ажлын явц 93.2%, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 98.3%, худалдан авах ажиллагааны явц 88.3%, дэд төвүүдийн нийт барилга угсралтын ажлын явц 42.2% байна. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 64.3%-тай байна. Төслийн 3 дугаар үе шатны хүрээнд Шархад, Толгойт дэд төвүүдийн газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 74.27%, худалдан авах ажиллагааны явц 70.24%, зураг төсөл боловсруулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд зураг төсөл боловсруулалтын ажлын явц 87.7%, барилга угсралтын ажлын явц 15.91%. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 34.67%-тай байна.

6.1.2.2. Дарь-Эх олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл боловсруулна. /10 га газар/

Биелэлт: "Дарь-Эх" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төслийн ажлын тайланг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр БХБЯ-ны Шинжлэх ухаан техник, технологийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд төслийн гүйцэтгэлд нэмэлт судалгаа хийх шаардлага гарсан тул дахин хэлэлцүүлэхээр хойшлогдсон.

6.1.3. Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

6.1.3.1. Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. /Гадна инженерийн шугам сүлжээ/

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/75 дугаар захирамжаар 2022 онд гэрээ байгуулагдсан гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний 7 төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд АШҮН 26 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажил, Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны 6, 7, 8 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны 72 дугаар хотхон орчмын ашиглалтын шаардлага хангахгүй 5, 16, 24 дүгээр байруудыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил, Налайх дүүргийн 2 дугаар хороонд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгуудыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын гадна инженерийн шугам сүлжээний ажил, Баянгол дүүргийн 4 дүгээр хороонд Давхарын 9, 10 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төслийн Дулаан хангамжийн ажил, Дэнжийн мянган цагаан байрыг буулган дахин барилгажуулах төслийн Дулаан хангамж, ус хангамжийн ажил, Арьс ширний 26 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төслийн Цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэсэн.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны 51, 52 дугаар орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна цахилгаан, холбоо хангамжийн шугам сүлжээний угсралтын ажил, Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны 200,

201, 202 дугаар орон 2 сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж байна.

6.1.3.2. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2019 онд 100 айлын 4 орон сууцыг буулган 234 айлын 2 орон сууц (16 давхар), 2022 онд 12 айлын 1 орон сууцыг буулган 48 айлын 1 орон сууц, нийт 282 айл өрхийн 3 орон сууц ашиглалтад орсон. Үүнд:

- Баянгол дүүргийн 4 хороо, 82 айлын 2 давхар орон сууцыг буулган 143 айл өрхийн 16 давхар орон сууц, Хан-Уул дүүргийн 2 хороо, 18 айлын 2 давхар орон сууцыг буулган 91 айл өрхийн 16 давхар орон сууц, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 12 айлын 2 давхар орон сууцыг буулган 48 айл өрхийн 10 давхар орон сууц.
- Налайх дүүргийн 2 дугаар хороо, 26, 27 дугаар байрыг буулгаж, 9 давхар 2 блок, нийт 126 айлын орон сууцыг байнгын ашиглалтад орууллаа. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж, барилгажуулах төслийн хүрээнд нийт 25 багцын 72 барилгад дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулснаар 5 хуулийн этгээдэд төсөл хэрэгжүүлэх эрх олгож, 2 болон 3 талт гэрээ байгуулах эрх олгосон.

2020-2023 онд онд 13 орон сууцны 1665 айлын орон сууц ашиглалтад орсон.

6.1.3.3. Улаанбаатар хотын гэр хорооллын 6 дэд төвд 10,000 өрхийн орлогод нийцсэн ногоон орон сууцны бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Төслийн 1-р бүрэлдэхүүний хүрээнд Баянхошуу болон Шархад дэд төвүүдэд нийт 750 айлын ногоон орон сууц бүхий эко хорооллуудын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд:

1. Шархад болон Баянхошуу дэд төвүүдийн 110 айлын ногоон орон сууц, Баянхошуу дэд төвийн 110 айлын ногоон орон сууцны барилгын ажил мөн Шархад дэд төвийн 110 айлын ногоон орон сууцны барилгын ажлын явц 37.5 хувийн дундаж хэрэгжилттэй.
2. Баянхошуу дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн барилга угсралтын ажлын явц 40 хувийн хэрэгжилттэй.
3. Баянхошуу дэд төвийн Б-13-1 талбарт төлөвлөсөн 150 айлын ногоон орон сууцны барилга, Б-13-2 талбарт төлөвлөсөн 110 айлын ногоон орон сууцны барилгын ажлын зураг төсвүүдэд магадлал хийлгэж байна.
4. Шархад дэд төвийн S27-2 талбарын эко хорооллын загвар зургийг нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжлийн зөвлөлийн 35-р хурлаар хэлэлцүүлж батлагдсан, нарийвчилсан зураг төслийн явц 10 хувийн хэрэгжилттэй байна.
5. Төслийн санхүүжүүлэгч АХБ-аас жил бүр төслийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилгоор хийдэг хяналтын хурлыг зохион байгуулж, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг хэлэлцүүлж, тус хурлын санамж бичигт тусгуулсан.

6.1.3.4. Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. /Гадна инженерийн шугам сүлжээ болон орон сууц/

Биелэлт: Европын Хөрөнгө оруулалтын банкны 3,5 сая евро буюу 11 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийгдэж байна. Эхний ээлжийн 34.4га талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд АХБ-ны санхүүжилтээр УБХГХХХОДТН-ийн захиалан

хэрэгжүүлж буй 114 га талбайд 5325 айлын орон сууцны дэд бүтцийн ажил буюу иж бүрэн инженерийн шугам сүлжээний ажил бүрэн хийгдэж, Улсын комисст хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж байна. Хэрэгжилт 95.4 хувьтай байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн дулааны эх үүсвэрийн эхний ээлжийн ажлын гэрээг Рино инженеринг ХХК-тай байгуулж, ажлыг гүйцэтгэсэн.

Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Баянголын амны 10 га газарт 1764 айлын орон сууцны барилгын төслийн хэрэгжүүлэгчээр “Сайхан төмөрт” ХХК-ийг батламжилсан.

Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, Баруунсалаа орчимд байрлах 6.25 га газарт хэрэгжүүлэх орон сууцны төслийн гадна дулаан, ус хангамж ариутгах татуургын ерөнхий гүйцэтгэгчээр “Есөн талст оргил констракшн” ХХК болон зураг төсөл гүйцэтгэгчээр “Бум асар” ХХК шалгарсан ба ажлын зургийг Барилга хөгжлийн төвийн магадлалаар батлуулахаар хүргүүллээ.

6.1.3.5. Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд гэр хорооллын газрын дахин төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж, төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Улаанбаатар хотын гэр хорооллын газрын дахин зохион байгуулах ажлын хүрээнд 16 хэсэгчилсэн талбайд барилгажилтын төслийг хянан баталгаажуулсан.

“Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх Дэд бүтцийн төвийн ажлын зураг төсөв”, “Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх Дэд бүтцийн төвийн ажлын зураг төсөв”, “Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх Дэд бүтцийн төвийн ажлын зураг төсөв” гэсэн 3 зураг төслийг Барилга хөгжлийн төв хянаж, 2023 оны 1516/2023, 1380/2023, 1364/2023 магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан.

Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд дэд бүтцийн төвийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлагдсан. Тухайлбал,

1. Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1707 м² газарт Дэд бүтцийн төвийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, 437.2 м² талбайд 2 давхар 188 айлыг тэтгэх хүчин чадал бүхий барилгын загвар зураг;
2. Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1317 м² газарт Дэд бүтцийн төвийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, 437.3 м² талбайд 2 давхар 185 айлыг тэтгэх хүчин чадал бүхий барилгын загвар зураг;
3. Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1497 м² газарт Дэд бүтцийн төвийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, 496 м² талбайд 2 давхар 315 айлыг тэтгэх хүчин чадал бүхий барилгын загвар зураг;
4. Баянзүрх дүүргийн 2, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр “Мамба дацан” орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн “В” хэсэгчилсэн талбайд Кон консалтинг ХХК, 828 өрхтэй 5 блок 200 хүүхдийн цэцэрлэг бүхий үйлчилгээтэй орон сууцны барилгын загвар зураг.

6.1.4. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлогын арга хэмжээний хүрээнд сайжруулсан түлшний 2 дахь үйлдвэрийг байгуулна.

6.1.4.1. Нийслэлийн зүүн бүсэд сайжруулсан түлшний үйлдвэрийг барьж байгуулна.

Биелэлт: Нийслэлийн зүүн бүсэд баригдах сайжруулсан шахмал түлш үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 2020 оны 05 дугаар сард эхлүүлсэн бөгөөд Эрчим хүчний сайдын 2020 оны А/141 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг үйлдвэрийн барилга угсралтын ажилд хяналт тавих, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэх зорилгоор үйлдвэрийн газар дээр тогтмол ажиллаж барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажилд байнгын хяналт тавин үйлдвэрийг 2020.12.08-ны өдөр ашиглалтад оруулсан.

6.1.4.2. Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангахад тээвэрлэлт, борлуулалтын үйл ажиллагааг жигдрүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2021-2023 онд 29 тээврийн компани зүүн болон баруун бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, агуулахад нийт 544404 тонн сайжруулсан шахмал түлшээр, 203,683 айл өрхийг хангасан.

6.1.5. Нийтийн тээврийн үйлчилгээнд зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан ухаалаг, эко, цахилгаан хөдөлгүүрт дан болон давхар автобус, цахилгаан соронзон болон дүүжин замын тээврийн хэрэгслийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлнэ.

6.1.5.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглолтой тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд 2021-2023 онд 332 автобусаар парк шинэчлэлт хийгдсэн бөгөөд 224 автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нам шал, тавцан, гишгүүр, зориулалтын зорчих хэсэг болон дотор талын зорчих хэсгийн зарлан мэдээлэх, урсдаг лед дэлгэцийг суурилуулан ашиглаж байна.

- 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй (Skywell) автобус нийлүүлэгдсэн бөгөөд үйлчилгээнд гаргалаа.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Тэнүүн-Огоо” ХХК-тай 2023 оны Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001 дугаартай гэрээ, ННТГ23001-01 дугаартай нэмэлт гэрээг хэсэгчлэн цуцалсантай холбогдуулан Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобус худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 1 сарын хугацаатай зарласан олон улсын нээлттэй тендерт шалгарсан БНХАУ-ын Yutong Bus Co.,Ltd компани 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдөр эхний ээлжийн 35 автобусыг нийлүүллээ.

6.1.5.2. Цахилгаан соронзон тээврийн төслийг хэрэгжүүлж эхэлнэ.

Биелэлт: Метро барих төсөл: Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос авто замын түгжрэлийг бууруулах, олон төрөлт, нийтийн тээвэр нэвтрүүлэх зорилгын хүрээнд их багтаамж нийтийн тээврийн хэрэгсэл буюу метро байгуулах урьдчилсан тооцоолол, танилцуулгыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас Нийслэл Улаанбаатар хотод 2024-2028 онд багтаан Энхтайваны өргөн чөлөөг

хамруулсан хөндлөн чиглэлд 17.7 км урт метро барьж байгуулахыг дэмжиж, 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 46 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/1336 дугаар захирамжаар их багтаамж нийтийн тээврийн хэрэгсэл буюу метроны техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлан, боловсруулалтыг ажлыг эхлүүлээд байна. Уг ажлыг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч ахлуулсан Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам зэрэг яамдын болон Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 12 байгууллагын төлөөлөл гүйцэтгэж байна.

Баганан тулгуурт галт тэрэг төсөл: Хөдлөх бүрэлдэхүүний вагон депо, удирдлагын төв, засвар үйлчилгээний барилга байгууламжийн зориулалтаар 110.06 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршлын координатыг НИТХ-ын 2022 оны 39 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох ашиглах журам"-ын дагуу "110.06 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах" тухай дүгнэлтийг БХБЯ-нд хүргүүлээд байна.

6.1.5.3. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийн хоёр дахь шугамын Барилгын ажил гүйцэтгэх (ЕРС) гэрээг БНФУ-ын Пома групптэй 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан. Төслийн 2 дугаар шугам болох Наадамчдын өргөн чөлөөг Энхтайваны өргөн чөлөөтэй холбох Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбороос Хархорин автобусны буудал (4.2 км) чиглэлийг төлөвлөж, Техник эдийн засгийн үндэслэлийг 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр эцэслэн батлуулсан ба гүйцэтгэгч талаас нарийвчилсан зураг төсөл боловсруулж байна.

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Стандарт, хэмжил зүйн газрын ТХ15 Авто тээврийн стандартчиллын техникийн хороогоор "Хүн тээвэрлэх зориулалттай дүүжин тээврийн байгууламжийн аюулгүй байдлын шаардлага"-тай холбоотой 6 стандарт батлагдсан.

Монгол Улсын Засгийн газар болон БНФУ-ын Засгийн газар хооронд 2020 онд байгуулсан Санхүүгийн хэлэлцээр нь 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр дууссан бөгөөд хоёр улсын Сангийн яамд харилцан зөвшилцөж, 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр уг санхүүгийн хэлэлцээрийг 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан тухай БНФУ-ын Санхүү, эдийн засгийн яамнаас 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр албан бичиг ирүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/1083 дугаар захирамжаар "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийн нэгдүгээр шугам буюу "Баянхошуу-Ханын материал-Гэмтлийн эмнэлэг" чиглэлийн төлөвлөлтийг судалж, өөрчлөх талаар санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгээс тусгайлсан мэргэжлийн багийн судалгаагүй трассын өөрчлөлт хийх санал гаргах боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан. Уг трассын ЕРС гэрээг цуцлах, шинээр санал болгож буй трассын талаар урьдчилсан харьцуулсан судалгаа хийхийг гүйцэтгэгч талтай зөвшилцөөд байна.

6.1.6. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулна.

6.1.6.1. Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх дунд, урт хугацааны мастер төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2020-2023 онд нийт 73.7 км авто зам, 468 м гүүрийг шинээр ашиглалтад оруулсан.

6.1.7. Олон улсын стандартад нийцсэн явган хүний болон унадаг дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж барьж байгуулан, тоосжилтыг 50 хувь бууруулна.

6.1.7.1. Дугуйн замыг хөгжүүлнэ.

Биелэлт: 2023 онд авто замын байгууламжийн 5 зураг төсөлд 20.6 км дугуйн замыг тусган баталсан. Нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто зам дагуух тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган хүний замын ажлын хүрээнд 2023 онд шинээр 9 байршилд нийт 9.8 км дугуйн замыг шинээр барьсан байна. 2020-2023 онд нийт 59.455 км дугуйн зам ашиглалтад орж, 25.72 км дугуйн зам он дамжин хэрэгжиж байна.

6.1.7.2. Сул шороон хөрс бүхий талбайд явган зам, гүйлтийн зам хийнэ.

Биелэлт: Нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто зам дагуух тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган хүний замын ажлын хүрээнд 2023 онд шинээр 13 байршилд нийт 23771 кв.м явган замын ажлыг гүйцэтгэсэн. 8 дүүрэгт 95187.95 кв.м явган хүний зам байгуулахаас 62454.32 кв.м явган хүний зам байгуулсан. 2021-2023 онд нийт 351502.45 кв.м явган зам тавигдсан.

6.1.8. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулна. Туул, Сэлбэ, Дунд голын урсцын тохируулга хийж, голуудын орчинд олон нийтийн соёл, амралтын тохилог орчныг бүрдүүлнэ.

6.1.8.1. Туул, Сэлбэ, Дунд голын урсцыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд Туул голын эргийн дагуух тохижилтын ажил /Асем Вилла хотхоны баруун хойд талд 2 дугаар ээлж/ ажил бүрэн дууссан. Баянзүрх дүүрэг 11 дүгээр хороо, Бага тэнгэрийн ам, Туул гол дагуух амралт зугаалгын цогцолборын тохижилтын ажил үргэлжилж байна.

Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 2022-2031 онд 5 үе шаттайгаар 149 га талбайд хэрэгжих гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн /Family Garden/-гийн зураг төслийг боловсруулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Эв нэгдлийн цэцэрлэгт хүрээлэн” байгуулах тухай А/701 тоот захирамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Хар усан тохойд байрлах 32 га мод үржүүлгийн үйл ажиллагааг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд мэргэжлийн 15 ААНБ-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тус мод үржүүлгийн

эхний үе шатны төлөвлөлт болох 32 га талбайн зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба үүний 6 га талбайд дэд бүтэц бүрэн шийдвэрлэж 30 сая мод үрээр тарих ажил хийгдсэн.

Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд Туул голын эрэг дагуу үерийн эрсдэлтэй бүсэд байрлаж байсан 28 айлыг нүүлгэн шилжүүлсэн талбайд иргэд, олон нийтэд зориулсан цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай санамж бичиг байгуулж, дүүргийн төсвийн хөрөнгөөр зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулж байна. Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Туул голын эрэг дагуу тохижилт бүхий экстрем талбай, Баянзүрх дүүргийн 23, 28 дугаар хороонд “Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн”, Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Туул гол дагуу 50 га талбайд “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” байгуулах ажил хийгдэж байна.

6.1.8.2. Дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

Биелэлт: Гэр хорооллын 16 байршил /СХД-5, БЗД-5, БГД-2, ХУД-3/-д бичил цэцэрлэгт хүрээлэн байгууллаа. Нийслэлийн хэмжээнд 9 дүүрэгт 12 цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил он дамжин хэрэгжиж байна. Тухайлбал, Налайх дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт 68 га газарт “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнгийн явц 70%, Багануур дүүрэгт Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн 2-р ээлжийн тохижилтын ажил бүрэн хийгдсэн, ХУД-ийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 35 га талбайд 15 байгууламж бүхий “Олон улсын соёлын цэцэрлэгт хүрээлэн” буюу “IC PARK”, ХУД-ийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 2022-2031 онд 5 үе шаттайгаар 149 га талбайд хэрэгжих Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн /Family Garden/ төсөл, Багахангай дүүрэгт баригдаж буй цэцэрлэгт хүрээлэнгийн явц 80%-тай, СБД-т цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолборын ажлын явц 50%, ЧД-ийн Тахилтын аманд байгуулах Цэцэрлэгт хүрээлэн 70%, СХД-ийн Баянхошууны Хайрханы цэцэрлэгт хүрээлэн 95%, СХД-ийн 30 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэн 30%, БЗД-ийн Туул голын эрэг дагуу тохижилт бүхий экстрем талбай, 23, 28 дугаар хороонд “Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнгийн ажил 45%, БГД-ийн 20-р хороо Туул гол дагуу 50 га талбайд байгуулах “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-ийн ажлын явц 80%, БГД-ийн 22 дугаар хороонд байрлах Зүүн Нарангийн гудамжны цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын явц 30 хувийн явцтай байна.

6.1.9. Хог хаягдлын менежментийг сайжруулж, гэр хорооллын айл өрхийг үнс хадгалах зориулалтын савтай болгож, дахин боловсруулах бүх төрлийн үйлдвэрийг байгуулна.

6.1.9.1. Хог хаягдлын менежментийг сайжруулж, гэр хорооллын айл өрхийг үнс хадгалах зориулалтын савтай болгож, дахин боловсруулах бүх төрлийн үйлдвэрийг байгуулах судалгаа хийнэ.

Биелэлт: Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлсэн “Хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент төсөл”-ийн хүрээнд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт ангилан ялгах прэслэх төвийн Барилгын ажлыг хүлээн авах улсын комиссын дүгнэлт гарч барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан.

Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар 2020 онд Улсын төсвийн 8.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт хоногт 300 тонн хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн барилгын ажил бүрэн дууссан.

Нийт гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон авто замын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг 886 га газар цэвэрлэж, нийт 2,037 тонн хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөх ажлыг зохин байгуулсан.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3-р баг 100 гаруй өрхөд үнс хадгалах зориулалтын савыг хийж байршуулсан. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын хэмжээнд 1,383 өрх өөрсдийн нөхцөл бололцоонд суурилан ангилан ялгах хогийн савтай болсон бөгөөд аймгийн хэмжээнд нийт айл өрхийн 80 хувь нь үнс хадгалах зориулалтын савтай болсон.

Нийслэлийн хэмжээнд 826 орон сууц, 165 байгууллага, 25 ерөнхий боловсролын сургууль, 26 цэцэрлэг, бусад 83 цэгт давхардсан тоогоор 524,808 хүн хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ялгаж байна.

6.1.9.2. Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хот хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.

Биелэлт: Төслийг бүрэн дуусгаж, төгсгөлийн тайланг БХБЯ-ны 2023.04.07-ны өдрийн 3/1200 тоот албан бичгээр Сангийн яам, АХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газарт тус тус хүргүүлсэн.

6.1.10. Улаанбаатар хотын цэвэр усны шинэ эх үүсвэрийг бий болгож, “Төв цэвэрлэх байгууламж”-ийг шинээр барьж ашиглалтад оруулан, тус цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг дулааны III, IV цахилгаан станцын технологийн хэрэгцээнд ашиглана. Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартад нийцсэн бие даасан цэвэрлэх байгууламж бүхий ноолуурын үйлдвэрүүдээс бусдыг хотоос гаргаж, Ус сувгийн удирдах газрын харьяа урьдчилсан цэвэрлэх байгууламж Харгиаг татан буулгана.

6.1.10.1. АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барьж, ашиглалтад оруулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар болон Мянганы сорилтын сан хооронд байгуулсан II компакт гэрээний хүрээнд 3 төсөл хэрэгжиж байна. Үүнд: 1. Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа төсөл; 2. Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа төсөл; 3. Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа төсөл.

Нийслэлийн хэмжээнд гэр хорооллын оршин суугчдад ус хангамжийн үйлчилгээг хүргэх зардлыг бууруулах зорилгоор шугамд холбогдсон ачилтын 17 болон айл өрхөд үйлчилдэг 165, нийт 182 ус түгээх байрыг автоматжуулах тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, “Эйч Ти Эл” ХХК шалгарч, 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр гэрээг үзэглэсэн. Төслийн хүрээнд ус түгээх 180 байрыг автоматжуулах ажлын хэрэгжилт 70 хувьд хүрч, цахилгаан, сантехник, автоматжуулалт, барилгын ажлууд хийгдсэн.

6.1.10.2. Улаанбаатар хотын шинэ цэвэрлэх байгууламжийг барьж, ашиглалтад оруулна.

Биелэлт: Төслийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл 100 хувь, бараа материалын татан авалт 80 хувь, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт 70 хувь, төслийн технологийн 55 барилга байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85 хувийн явцтай хэрэгжиж байна.

6.1.10.3. Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “М-Си-Эс Проперти” ХХК, туслан гүйцэтгэгчээр Францын Egis болон Veolia Water Technologies компаниуд шалгарч, гэрээг 2022.05.10-нд байгуулж төслийн барилгын ажил эхэлсэн. УДБҮ-ийн суурийн бетон цутгалтын болон хэв хашмал, арматурын татан авалт хийгдэж, ажлын гүйцэтгэл 35 хувьтай байна.

Хаягдал ус дахин боловсруулах төслийн ТЭЦ-3, 4-ийн даралттай шугамын ажлын зураг төслийг боловсруулж, ТЭЦ-3, 4-т тоног төхөөрөмж угсрах ажлууд эхэлсэн.

6.1.11. Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

6.1.11.1. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/876, А/1098, 2023 оны А/317 дугаар захирамжаар Эмээлт эко паркийн газрыг 539 га болгон нэмэгдүүлж, Паркийн хамгаалалтын бүсийн бүтээн байгуулалтын ажил дууссан. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус XII хуралдаанаар батлуулсан. Тус аж үйлдвэрийн паркийн хуулийн этгээдийн хэлбэрийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуульд нийцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус XII хуралдаанаар өөрчлөн байгуулж хувьцаат компани болгон дүрмийг баталсан. “Улаанбаатар хотын өрсөлдөх чадвар, нөхөн сэргээлтийг дэмжих төсөл”-ийн техник туслалцааны томилолтын баг ажиллаж, төслийн ТЭЗҮ-ийг Олон Улсын Санхүүгийн корпорац IFC хийж гүйцэтгэх гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна. Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хүрээнд тус паркаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2023 оны сар бүрээр болон 2024 оны байдлаар нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, БХБЯ-нд хүргүүлэн хянуулж байна.

НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага /UNIDO/-тай олон улсын стандарт шаардлагыг нэвтрүүлэх, цэвэрлэх байгууламж болон паркийн бусад бүтээн байгуулалтуудыг эхлүүлэхэд мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх, Вьетнам, Этиоп, Энэтхэг зэрэг орнууд дахь паркуудын туршлага судлах зэргээр цаашид хөгжүүлэх техникийн туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай төсөв санхүүжилтийн эх үүсвэрүүдийг хамтран тодорхойлох чиглэлээр хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.

6.1.11.2. “Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна.

Биелэлт: 2023 оны байдлаар нийт 16 аж ахуйн нэгж паркт байрших хүсэлт ирүүлээд байгаа бөгөөд хүсэлтүүдийг судлан 14 аж ахуйн нэгжтэй нь үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээ байгуулсан 5 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд барилга угсралтын ажил 40 хувьтай явагдаж байна.

6.1.11.3. “Багануур үйлдвэрлэл технологийн парк”-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна. байгуулна.

Биелэлт:Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн ажилд 400.0 сая төгрөг тусгаж, гүйцэтгэгч “Энх-Өглөө” ХХК болон Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар хооронд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Төлөвлөгөөний дагуу Энх-Өглөө ХХК нь өөрийн үйлдвэртээ дэд станцын өргөтгөлийн тоноглолын суурь БС-2 маягийн суурь төмөр тулгуурыг үйлдвэрлэж дууссан ба шугамын трассын дагуу 14 анкерын угсралт болон суурилуулалтын ажлыг батлагдсан төсвийн хүрээнд 100% гүйцэтгэсэн.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу паркийг компани болгон өөрчлөн байгуулах зорилгоор дүрмийн төслийг шинээр боловсруулан санал авч байна. Цаашид нийслэлийн төсвөөс гаргах шаардлагатай 1,100.0 сая төгрөгийн санхүүжилтээс 800.0 сая төгрөгийг “Энх-Өглөө” ХХК нь өөрийн хөрөнгөөс нэмэлтээр гарган бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна.

6.1.11.4."Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна. байгуулна.

Биелэлт: 2022 онд паркийн эзэмшил 56 га газрыг 45.9 га-аар нэмэгдүүлж, 101.9 га болгосон бөгөөд Багахангай дүүргийн Засаг даргын 2023 оны А/78 дугаар захирамжаар паркийн газрыг 21 га газраар нэмэгдүүлсэн.

Багахангай дүүргийн 2023 оны төсвийн 25 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар паркийн “Хөгжлийн төлөвлөгөө”-ний зураг төслийн ажлыг “ШУҮП холбоо” ТББ гүйцэтгэн, 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Эл эс рэйлвэйс” ХХК нь 2023 онд 5 сая төгрөгийн төсөв бүхий паркийн хашаажуулалтын зураг төслийн ажлыг хийж хүлээлгэн өгсөн.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу паркийг компани болгон өөрчлөн байгуулах зорилгоор дүрмийн төслийг шинээр боловсруулан нийслэлийн удирдлагуудаас санал авч байна. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/961 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 4 зураг төслийн ажлын санхүүжилт батлагдсан. Уг ажлын хүрээнд дүүргийн Худалдан авах ажиллагааны алба зураг төслийн 4 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна.

6.1.12.Богдхан төмөр замын төслийг түшиглэн “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

Биелэлт: Богдхан төмөр замын төслийг түшиглэн "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас боловсруулж дууссан.

6.1.13.Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих “Сургуулийн автобус” төслийг үргэлжлүүлнэ.

Биелэлт: Сургуулийн автобусны парк шинэчлэлтийн хүрээнд 2020-2023 онд нийтдээ 75 автобус шинээр нийлүүлэгдсэн. 2022-2023 оны хичээлийн жилд 96 сургуулийг хамруулан хүүхдийн 72 автобусаар өдөрт 12,859, давхардсан тоогоор 742,736 сурагчийг тээвэрлэсэн.

2023-2024 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлуудын хүрээнд сурагчдыг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан автобусаар тав тухтай, аюул осолгүй тээвэрлэх зорилтын хүрээнд “Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014

стандартад тавигдсан шаардлагуудын хүрээнд ажиллаж байна. Мөн 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчит 56 сургуулийг хамруулан 58 чиглэлд хүүхдийн 58 автобусаар давхардсан тоогоор өдөрт 10,386 хүүхэд тээвэрлэж байна.

6.2. Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

6.2.1.Төвлөрлийг сааруулах бодлогыг Улаанбаатар хотын удирдлагатай хамтарч үндэсний хэмжээнд цогц байдлаар хэрэгжүүлнэ.

6.2.1.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон түүний удирдлагын шинэчлэлийг түргэтгэх замаар төсвийн төвлөрсөн байдлыг багасгана.

Биелэлт: Монгол Улсын Их хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн чуулганаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын баталсан. Тус хуулийн гуравдугаар бүлэгт, Нийслэл хотын эдийн засгийн үндэс нийслэлийн өмч, түүний харилцаа, нийслэлийн үнэт цаас гаргах, концесс олгох, нийслэл хотын албан татвар, түүнчлэн нийслэлийг хөгжүүлэх сантай байж болохоор, сангийн хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулах үйл ажиллагааны болон нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажил, үйлчилгээг нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлдэг байх нийслэл дэх хөрөнгө оруулалтыг тусгайлан дэмжих зохицуулалтыг нарийвчлан оруулсан.

6.2.2.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

6.2.2.1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулна.

Биелэлт:Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 52-р захирамж, Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 65 дугаар тушаалаар “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-г боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Тус бодлогын баримт бичгийн “Бүс, орон нутгийн хөгжил” буюу 8 дугаар бүлэгт бүсчилсэн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тусгасан. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичгийг төслийг 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Ерөнхий сайдад өргөн барьсан ба 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.

“Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын төслийн зарим арга хэмжээг 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” батлагдахад “Бүс, орон нутгийн хөгжил” буюу 8 дугаар бүлэг болгон баталсан. Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А-20 дугаар тушаалаар “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг, яамд, орон нутгаас ирүүлсэн төслийн саналыг ArcGIS программ дээр боловсруулан орон зайн төлөвлөлт, байршлын зураглалыг хийж гүйцэтгэсэн.

6.2.2.2.Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангана.

Биелэлт: АХБ-ны “Сумын хөгжил-инженерийн дэд бүтцийн хангамж төсөл”-ийн хүрээнд буцалтгүй тусламжаар 21 аймгийн тоног төхөөрөмж болон барилга байгууламжийн төслийг хүргүүлсэн бөгөөд АХБ-аас судалгааны ажил хийгдэж байна.

Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/ /2024 онд 17,217.1 тэрбум төгрөг/, "Алтанбулаг хилийн боомтын Будгийн болон Химийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/" /2024 онд 6,471.0 тэрбум төгрөг/, Дархан-Уул аймаг Барилгын материалын лабораторийн барилга /2024 онд 2,000.0 тэрбум төгрөг/ тус тус 2024 оны улсын төсөвт тусгуулахаар саналаа Сангийн яаманд хүргүүлсний дагуу тусгагдсан. Мөн Ховд ГХБХБГ нь аймаг 2022 онд орон нутгийн удирдлагын хүрээнд санал тавьж “Металл эдлэхүүний лаборатори”-ийг 150.0 сая төгрөгийг тусгуулсан. Металлын урсалт, бат бэхийн хязгаар тодорхойлох пресс, Металлын урсалт, бат бэхийн хязгаар тодорхойлох пресс, Металлын маталтын пресс, Арматурын хэмжээ тавигч, Хуванцар турших багаж, Штангенциркуль гэх мэт нийт 6 төрлийн 146,680,000 төгрөг үнэ бүхий тоног төхөөрөмжөө 2023 онд хүлээн авсан. Орхон аймаг 19.0 сая төгрөгөөр шцмидтийн алх, Өвөрхангай аймаг нь 780 мянга бүхий үнэтэй Плунжерийн багаж, Бетоны температур хэмжигч гэсэн нийт 176.8 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжөөр хангаад байна. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн боомтод баригдах барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн барилгын ажил 2023.12.15-ны өдөр улсын комисс ажилласан.

6.2.2.3. Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийг өргөх машин механизм, цахилгаан утасны лаборатори, барилгын физикийн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангана.

Биелэлт: Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагаанд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүдийг худалдан авах үнэлгээний хороог байгуулж, шинжилгээнд шаардлагатай 25 нэр төрлийн 106 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авах үйл ажиллагааг 3 багц болгож, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн бэлтгэл ажил хангаж байна.

БХБЯ-ны дэргэд байгуулагдсан ажлын хэсгээс Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн дэргэд баригдаж буй газар хөдлөлтийн лабораторийн барилгыг цаашид газар хөдлөлтийн лабораториос гадна өөр ямар лабораториор ашиглах боломжтой талаар санал солилцож, барилгын физик, өргөх машин механизм, цахилгаан утасны лабораторийн зориулалтаар ашиглах боломжтой гэж үзсэн ба тус лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах саналыг Монгол Улсын Засгийн газар болон АХБ-ны 2024-2027 оны хамтын ажиллагааны түншлэлийн стратегийн төсөлд тусгуулахаар харилцан тохиролцсон.

"Улаанбаатар хот дахь Будгийн болон Химийн лабораторийн тоног төхөөрөмж" (6,471.0 тэрбум төгрөг), "Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийн шаардлагатай иж бүрэн тоног төхөөрөмжүүд (барилгын физикийн лаборатори, өргөх машин механизм, цахилгаан утасны лаборатори)" (2,855.0 тэрбум төгрөг) тус тус 2024 оны улсын төсөвт тусгагдсан.

6.2.3. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу аймгийн төвийн статусын асуудлыг тодорхой болгоно.

6.2.3.1. Хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа, тооцоог боловсруулна.

Биелэлт: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлыг УИХ-ын Төсвийн байгуулалтын Байнгын хороотой хамтран хуульч, доктор А.Бямбажаргалаар гүйцэтгүүлж, тус хуулийн төсөлд "орон нутгийн зэрэглэлтэй хот" гэсэн бүлэг оруулан аймгийн төвийн сумдыг хот болгох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

6.2.4. Дархан, Эрдэнэт зэрэг улсын зэрэглэлтэй хот байгуулах болон аймгийн төвүүдийг хот болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6.2.4.1. Дархан, Эрдэнэт зэрэг улсын зэрэглэлтэй хот байгуулах болон аймгийн төвүүдийг хот болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай судалгаа, тооцоог боловсруулна.

Биелэлт: Дархан-Уул, Орхон аймагт Улсын зэрэглэлтэй Дархан, Эрдэнэт хотын статус тогтоох асуудлаар 4 хувилбар боловсруулж, бодлогын эерэг болон сөрөг талыг хэлэлцэн дүгнэснээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн статусыг алдагдуулахгүй байх хувилбарыг баримтлах зарчмыг сонгоод байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 95 дугаар захирамжаар "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангах" үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаар ахлуулан байгуулаад байна. 2023 оны 6 дугаар сарын 22-нд Дархан хотод "Хотуудын форум" зохион байгуулж боловсруулсан хуулийн төслийг танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулав.

6.2.5. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.

6.2.5.1. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.

Биелэлт: УИХ-ын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн чуулганаар хэлэлцэгдэн батлагдсан Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль гэсэн татварын 3 гол хууль шинэчлэгдэн батлагдсан байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д орсон зохицуулалтаар Монгол улсын алслагдсан бүс, сум суурин газар байнгын байрлаж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих, тухайн орон нутагт үйл ажиллагаа цаашид урт хугацаанд тогтвортой явуулахад дараах дэмжлэгийг үзүүлж байна. Тухайлбал, Өмнө мөрдөгдөж байсан хуулийн дагуу татвар төлөгч хуулийн этгээд нь борлуулалтын орлого, үйл ажиллагааны чиглэл зэргээс хамаарахгүйгээр татвар ногдуулах орлогоосоо 10 хувиар тооцож орлогын албан татвар төлдөг байсан бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д орсон зохицуулалтаар татвар төлөгчийг борлуулалтын орлогоос нь хамааруулан ангилалд оруулж, өмнөх жилийн борлуулалтын орлого нь 50 сая төгрөг хүртэл орлоготой аж ахуйн нэгжүүд нийт борлуулалтын орлогоосоо 1 хувиар тооцож орлогын албан татвар төлөх, жилийн борлуулалтын орлого нь 300 сая төгрөг хүртэл орлоготой аж ахуйн нэгжүүд татвар ногдуулах орлогоосоо 1 хувиар тооцож орлогын албан татвар төлөх боломжийг бүрдүүлсэн.

Үүнтэй холбоотойгоор Хөвсгөл, Увс, Төв Сэлэнгэ, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, Завхан Дундговь, Дорнод, Говьсүмбэр, Говь-Алтай, Булган Баянхонгор, Баян-Өлгий,

Архангай, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар аймгуудад 3 хувийн хүүтэй зээл олгох, аж ахуйн нэгж, иргэд өндөр хүүтэй зээлээ хүү багатай зээл рүү шилжүүлэх боломжийг бий болгосон.

6.2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тус сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ.

6.2.6.1. Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, болзол хангасан сумдад өнгөрсөн оны ОНХС-ийн санхүүжилтийн 25%-тай тэнцэх хэмжээний "урамшуулал" олгоно. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийг боловсруулж, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг сайжруулна.

Биелэлт: Сангийн яамнаас "Тогтвортой амьжиргаа-3" төслийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сан(цаашид ОНХС гэх)-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг хийж болзол хангасан сумдад өнгөрсөн оны санхүүжилтийн 25%-тай тэнцэх хэмжээний "урамшуулал" олгон ажиллаж байгаа ба тус сангийн хөрөнгийг зарцуулахдаа хууль, журамд заасны дагуу иргэдийн саналыг авч буй эсэх асуудалд хяналт тавих, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг бий болгох зорилгоор ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системийг ашиглалтад оруулсан. Тус систем ашиглалтад орсноор иргэд ОНХС-ийн санхүүжилт, тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө, тайлан зэрэг мэдээллийг бүрэн авах боломж бүрдэж байна.

Мөн Нийслэлийн ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор НЗДТГ-тай хамтран ОНХС-ийн гар утасны аппликейшнийг нэвтрүүлж, иргэдийн саналыг цахимаар авах, иргэдэд мэдээлэл түгээх ажлыг хэрэгжүүлж байна.

ОНХС-ийн үр дүнг үнэлэх зорилготой жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, үйл ажиллагааны хувьд болзол хангасан 218 суманд нийт 15.9 тэрбум төгрөгийн "урамшуулал"-ыг Тогтвортой амьжиргаа-3 төслийн санхүүжилтээр олгосон. ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг дээшлүүлэх зорилгоор ОНХС-ийн удирдлага мэдээллийн систем (www.onhs.mof.gov.mn)-д шаардлагатай шинэчлэл, хөгжүүлэлтийг хийсэн ба тус мэдээллийн системээс иргэд ОНХС-ийн төсөв, иргэдээс гарсан саналаас батлагдах хүртэлх үе шат бүрийн мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тоон болон зураг, файл, текст байдлаар авах боломжтой. Мөн ОНХС-ийн www.tusuv-oronnutag.mof.gov.mn цахим хуудас, "Орон нутгийн хөгжлийн сан" гар утасны аппликейшн, www.facebook.com/LDFMongolia, twitter.com/LDF, www.youtube.com/ОронНутгийнХөгжлийнСан нийгмийн сүлжээний хуудас, Фейсбүүк дээрх "Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн бүлэг" зэрэг мэдээллийн сувгуудыг ажиллуулж, иргэдэд мэдээлэл түгээж байна.

6.2.7. Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.7.1. Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Дархан-Уул, Дархан сумын цэвэр усны ф89-ф600 мм-ийн голчтой 10.7 км шугам сүлжээг шинэчлэх ажлыг "Өгөөмөр баян булаг" ХХК гүйцэтгэж байгаа ажлын төсөвт өртөг 5.6 тэрбум төгрөг, үүнээс 300.0 сая.төг санхүүжилт хийгдсэн, гүйцэтгэл 75%, Говь-

Алтай, Есөнбулаг сум, Индэрт багийн “Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн шугам сүлжээний холболт”-ын ажил, төсөвт өртөг 940.3 сая.төг, үүнээс 100.0 сая.төг санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл 80%, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4, 8-р баг гадна дулаан, цэвэр усны 756м шугам сүлжээг шинэчлэх ажил, төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөг, гүйцэтгэл 50%, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын 2-р багийн 1-13-р цэвэр усны худаг, цэвэр усны 500м шугам сүлжээний угсралтын ажил, төсөвт өртөг 14.6 тэрбум төг, үүнээс 3.9 тэрбум төг санхүүжилт хийгдсэн.

Ус хангамжийн шугам хоолойн угсралтын ажил 55%, Хөвсгөл, Мөрөн сум, "Зүүн Мөрөн" хорооллын цэвэр усны эх үүсвэрийн шугам сүлжээний 2-р ээлжийн ажлын цэвэр усны нийт 15 км ф 150-200 мм голчтой шугам сүлжээний угсралтын гүйцэтгэл 45%, Говь-Алтай, Есөнбулаг сумын цэвэр усны 1.5 км шугам сүлжээг шинэчлэх ажил, төсөвт өртөг 5.6 тэрбум төг, үүнээс 200.0 сая.төг санхүүжилт хийгдсэн. Гүйцэтгэл 40%, Түүхий эдийн захын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ /Булган, Орхон/ тухайн жилийн санхүүжилтийн 99.1%, зураг хийгдсэн, шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл/ ашиглалтад оруулах дүгнэлт гарсан. Гүйцэтгэл 100%, Өвөрхангай, Арвайхээр сум, Хуучин орон сууцны дахин төлөвлөлт, дэд бүтэц, хотын инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэлийн ажлаар ф125-219мм 385м хос шугам угсарсан, тухайн жилийн төлөвлөлтөөр 100 хувийн гүйцэтгэлтэй, 1.0 тэрбум төгрөг зарцуулсан, Хэнтий, Хэрлэн сум, Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станцын ажлын гүйцэтгэл 10 хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна.

6.2.7.2. Сумын хөгжил арга хэмжээг хэрэгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.

Биелэлт: Тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн сумын инженерийн дэд бүтцийн зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх, зураг төслийг боловсруулж баталгаажуулах, төсөл хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ашиглалтад оруулах зэрэг ажлууд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шат дарааллын дагуу явагдаж байна.

6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

6.2.8.1. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрд гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулна.

Биелэлт: Аймаг бүрд гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулах чиглэлээр хэрэглэгчдийг бохир усны нэгдсэн системд холбох, хөрсний болон агаарын бохирдлыг бууруулах өндөр ач холбогдолтой, дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх, гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд бүрэн холбож эрүүл аюулгүй аятай тухтай орчинд нөхцөлд амьдрах боломжийг бүрдүүлэх, гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл болон барилгажуулах ажлыг тодорхой үе, шат, дарааллын дагуу холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байна.

6.2.9. Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна. Аймгийн төвүүдийн гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна.

6.2.9.1.Бүс нутгийн томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлнэ. /5 газар/

Биелэлт: “Бүс нутгийн нүүрсний томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэл /5 газар/” ажлыг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн гэрээ дүгнэсэн актаар ЭХЯ-нд холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн. Бүс нутгийн томоохон уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлэх /5 газар/ ажлын хүрээнд “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-аас 7 байршилд ТЭЗҮ боловсруулж, ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан. ТЭЗҮ батлагдсантай холбогдуулан орон нутагт сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж байгуулах санхүүжилтийг шийдвэрлэх талаар Увс, Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Дорнод, Дорноговь аймаг, Багануур дүүргийн Засаг дарга нарт албан бичиг хүргүүлсэн.

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-аас боловсруулж ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэгдэн дэмжигдсэн Хөшөөтийн чулуун нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ-ийн дагуу Монгол Улсын 2021-2024 оны төсвийн хөрөнгөөр “Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах /Ховд/” төсөл арга хэмжээнд 2023 оны улсын төсөвт 4,361.0 сая төгрөг батлагдсан. Төсөл арга хэмжээг 2 багц болгон хэрэгжүүлж байгаа бөгөөд Багц 1-ийн хүрээнд бутлуур барилга, үйлдвэрийн барилга, оффис болон цэвэр усны барилгын ажил дуусаж техникийн комисс ажиллаж байна. Багц 2-ын БУА 90 хувьтай байна.

6.2.10.Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.

6.2.10.1.Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.

Биелэлт: Хэнтий, Ховд Увс, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, Завхан, Дундговь, Дорнод, Дорноговь, Дархан-Уул, Булган, Баян-Өлгий, Архангай, Баянхонгор зэрэг аймгуудад хог хаягдлыг ангилан ялгах, нягтаршуулах үйлдвэр, дахин боловсруулах хог хаягдал авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

6.2.11.Хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих замаар сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулна.

6.2.11.1.Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулна.

Биелэлт:Тус ажлын хүрээнд Булган, Увс, Хөвсгөл, Ховд, Өмнөговь, Завхан, Сэлэнгэ, Ховд, Хэнтий нэр бүхий сумдад улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн халуун усны барилга угсралтын ажил гүйцэтгэж, ашиглалтад оруулаад байна.

6.2.12.Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.

6.2.12.1.Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын

ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулах, орон сууцны байрыг ашиглалтад оруулах, хуучин байрыг орон сууцны зориулалтаар засварлан тохижуулах, урамшуулал олгох зэргээр тодорхой арга хэмжээг орон нутгийн хэмжээнд авч ажилласнаар алслагдсан сумдад амьдрах таатай нөхцөл бүрдэх нөхцөлийг бий болгож байна.

6.2.13.Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

6.2.13.1.Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

Биелэлт: "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө"-нд тусгагдсан хөнгөлөлттэй зээлийн хүрээнд ноос, ноолуур, арьс шир, мах, сүү, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, барилгын материалын үйлдвэр байгуулах, байгалийн баялаг болох жимс жимсгэнийн бүтээгдэхүүн, үр тариа, мод суулгац зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, эмийн ургамал ашиглан төрөл бүрийн цай үйлдвэрлэх, аялал жуулчлалын салбарын бэлэг дурсгалын бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрүүд олноор бий болсноор шинэ ажлын байр бий болж, үйлдвэрлэлийн борлуулалт нэмэгдэж эдийн засгийн өсөлтийг дэмжин, тодорхой хувь нэмрээ оруулж байна.

6.2.14.Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.

6.2.14.1. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөрөнгө оруулагч нарт сурталчлах, мэдээ, мэдээлэл түгээх, бүтээгдэхүүнийг сурталчлах, гадаад худалдаа, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээнд оруулна.

Биелэлт: "Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн систем"-ийг хөгжүүлэх ажлын хүрээнд боловсруулах үйлдвэрүүд болон жижиг дунд үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээ, мөшгөх тогтолцоог бий болгохоор хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлж байна. Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах цахим систем"-ийг хийсэн. Туршилтыг мах, махан бүтээгдэхүүн дээр хийхээр бэлтгэл ажлыг хангасан.

ЭЗХЯ-аас 2022 оны 09 дүгээр сарын 31-ний өдөр Солонгос Инчон хотноо БНСУ-ын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн яамны харьяа Инчоны үндэсний их сургуультай хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд аж үйлдвэрийн хөгжил, инновац кластерын менежментийн чиглэлээр туршлага солилцох, аж үйлдвэрийн хөгжил, инновац кластерын менежментийн чиглэлээр богино хугацааны сэдэвчилсэн судалгаа хийх, хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хөтөлбөрийг зохион байгуулах, туршилтын төсөл боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар болсон.

ЮНКТАД-ын төлөөллүүдтэй цахим уулзалт хийж Монгол Улсад үйлдвэрлэлийн чадавхыг бэхжүүлэх нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай саналыг тавьсан. Төслийн саналыг хэлэлцсэний үр дүнд Монгол Улсад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах тухай албан бичгийг (ЮНКТАД)-ын Африкийн буурай хөгжилтэй орнууд ба тусгай хөтөлбөрүүдийн хэлтсийн захирал (Пол Акивуми)-д хүргүүлсэн.

АХБ-ны “Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын хүрээнд Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр дээр Сангийн яамны Өрийн удирдлагын газартай хамтран ажиллаж, Засгийн газарт танилцуулах танилцуулгыг боловсруулан хүргүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Засгийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

6.2.14.2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.

Биелэлт: Хэнтий, Хөвсгөл, Ховд, Увс, Төв, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь, Орхон, Завхан, Дундговь, Дорнод, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр Говь-Алтай, Булган, Баянхонгор, Баян-Өлгий зэрэг аймгуудад тухайн аймаг орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгох зорилгоор үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, улсын чанартай авто зам дагуу орон нутгийн бүтээгдэхүүний худалдааны цэгийг байгуулах, аялал жуулчлалын улиралд эрэлт нийлүүлэлтийн төвлөрсөн цэг болж, орон нутгийн иргэд түр ажлын байраар хангах, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын тогтвортой үйл ажиллагааг хангах, ажлын байрыг хадгалж үлдэх, санхүүгийн эрсдэлээс сэргийлэхэд төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх, тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр борлуулах, сурталчлан таниулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, хөнгөлөлттэй зээл олгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна.